

Л.Түдэв

ОРОЙГҮЙ СҮМ

<u>АРГАГҮЙН ЭРХЭНД ДАЯАНЧ БУЮУ ЭХЛЭЛ</u>	4
<u>НЭГ. ГЭЦЭЛИЙН САХИЛ ХҮРТСЭН НЬ</u>	10
<u>ХОЁР. ЭРЭЛД ГАРСАН МӨРГӨЛЧИД</u>	22
<u>ГУРАВ. ЗАМЫН МЯНГАН БАРЦАА</u>	33
<u>ДӨРӨВ. БУРХНЫ ХОТЫН ҮЙМЭЭН ДУНД</u>	45
<u>ТАВ. ДАЛАЙ ЛАМД МӨРГӨСӨН НЬ</u>	57
<u>ЗУРГАА. БЭРЭЭВЭН ХИЙДИЙН ШАВЬ</u>	68
<u>ДОЛОО. НАС ЮУЛЖ ЗУУРДААР ОДОВ</u>	78
<u>НАЙМ. ХОРИН МЯНГАТЫН ЕРӨӨЛ</u>	90
<u>ЕС. ЗОЛИОСОНД ГАРСАН СҮЖИГТЭН</u>	101
<u>АРАВ. НҮГЭЛ БУЯНГИЙН ЯЛГАА</u>	112
<u>АРВАН НЭГ. ЕСӨН МЭНГЭ ГОЛЛОСОН НЬ</u>	122
<u>АРВАН ХОЁР. ДОЛООН ТАМИР СУЛЬДЖЭЭ</u>	133
<u>АРВАН ГУРАВ. ЖОРГҮЙ ЛАМААС ЗОВСОН ЧАВГАНЦ</u>	145
<u>АРВАН ДӨРӨВ. НОМЫН ХҮРД ЭРГҮҮЛЭГЧ</u>	156
<u>АРВАН ТАВ. ЗОВЛОНГИЙН ХҮРД ЭРГҮҮЛЭГЧ</u>	167
<u>АРВАН ЗУРГАА. ГАНЛИНГИЙН ГАСЛАХ ДУУН</u>	178
<u>АРВАН ДОЛОО. ОЮУНЫ САВ ГЭНЭТ ДҮҮРЭВ</u>	189
<u>АРВАН НАЙМ. ЕРТӨНЦ ӨНГӨРСӨН БА ҮЛ ӨНГӨРСӨН ЗАЙД</u>	200
<u>АРВАН ЕС. ОЛОН ХААЛГАТ СУВАРГА</u>	210

<u>ХОРЬ. СЭТГЭЛИЙГ БИЕЭР ИЛЧИЛНЭ</u>	221
<u>ХОРИН НЭГ. БУРХНЫ ОРОН ДАХЬ ТАМ</u>	231
<u>ХОРИН ХОЁР. ЗУРГААН ЗҮЙЛ ХАМАГ АМЬТАН</u>	241
<u>ХОРИН ГУРАВ. НОМ ХАЯЛЦАН ЦООРСОН НЬ</u>	251
<u>ХОРИН ДӨРӨВ. ТУЛАМТАЙ ГУРИЛААР БИЕЭ СОЛИВ</u>	261
<u>ХОРИН ТАВ. ТӨРӨЛ АРИЛЖСАН МӨРГӨЛЧИД</u>	270
<u>ХОРИН ЗУРГАА. АМЬ НААНА, ТАМ ЦААНА</u>	279
<u>ХОРИН ДОЛОО. ХАМБЫН ШИРЭЭНЭЭ ӨРГӨМЖЛӨВ</u>	292
<u>ХОРИН НАЙМ. ОРОН ХИЙДИЙН СУУРЬ ТАВИВ</u>	300
<u>ХОРИН ЕС. НҮГЭЛ НҮГЛЭЭС ЧИГ АЙСАНГҮЙ</u>	309
<u>ГУЧ. БУРУУ ДАВААГААР ОРСОН ХҮН</u>	320
<u>ГУЧИН НЭГ. ШАР ШУВТЛАХААР ШИЙДСЭН НЬ</u>	330
<u>ОРОЙГҮЙ СҮМ БУЮУ ТӨГСГӨЛ</u>	341

Аргагүйн эрхэнд даяанч буюу эхлэл

Урьдын баян хожим үгүйрвэл хөөрхий
Урьдын ноён хожим буурвал хөөрхий
Урин тэнэгүүдийн дунд ганц цэцэн хөөрхий

Дээрээс нар, доороос элс төөнөж Ингэнэ усны говьд жин үдийн халуун боллоо. Амьтан бүхэн сүүдэр хайж тарчилна. Халуун элсэнд амьдрах заяатай хонин гүрвэл хүртэл тэсч ядан, амаа ангайн, бөөрөө түнхэлзүүлэн, загийн хожуул доогуур сүүдэр даган аахилж байлаа. Их говийн зэлүүд хязгаарт торойх бараагүй, анир чимээгүй дүнсгэр ажээ. Гагцхүү царцаа, голионы часхийх дуунаас өөр юу ч үл сонсогдох дүлий шар элсэн дунд гэв гэнэт нэгэн хар юм бүртэлзэн үзэгдлээ. Гэвч түүнийг сонирхох эсвэл түүнээс цочин бишүүрхэх нэгээхэн ч амьтан энэхүү илчилгүй их цөлийн дунд огтхон ч байсангүй. Бүртэлзэн шовсхийсэн тэр нэгэн нь загийн үжир үндсээр таяг хийж тулсан, хижээл насны сохор хүн байлаа. Нүд нь шаравтар бөгөөд цэлдэн мэт өнгөтэй, хараагүй болсон ажээ. Зүс царай нь төдий л доройтоогүй мөртлөө сэтгэлийн их зовиуртай нь илэрхий үзэгдэнэ. Залуудаа цэвэр, цэмцгэр явсан хүний шинжийг хадгалсан хэвээр аж.

Жин үдийн халуунд духан дээгүүрх гурван гүн атирааны нь дагуу үл мэдэг хөлс чийхран гарч байх боловч уруул нь хатаж ундаассан нь илэрхий. Элсэн довцог дундуур гав ганцаар тэмтчин яваа тэр хүн өгөршиж муруйсан заг модны бахим урт үндсэн таягаа урдаа барьж түүгээрээ үе үе газар хатган үзэж нүдтэй хүнээс бараг дутахгүйгээр саад бэрхшээлийг мэдэрч тойрон явж байлаа.

Нүдэн балай болсон тэр хүн үе үе зог тусч, хараатай хүн шиг алсыг өлийн ширтэж, урт амьсгаа авна. Уруул дээгүүр нь энд тэнд ганц хоёр шөрвөгөр сахал ургажээ. Үс нь их ургаж, мөрөн дээрээ эвхрэн гогцоорчээ. Гогцоорсон хар үсэнд нь цайж бууралтсан хяруу адил

өнгө нэгэнт суужээ. Даяанч эр юм уу гэж таамаглаж болох боловч даяанчийн хэрэглэл түүнд байсангүй. Элсэн довын хоорондуур харгана, заг, хармаг холилдон ургасан говийн энэхэн хотгорт ганц хүн хүн болно гэж итгэхэд бэрхтэй билээ. Аглаг зэлүүдийн туйл болчихсон энэ хонхорт чухам ямар хэргээр, юуны төлөө ганц бие сохор хүн, таягаар морь хийж тэнүүчлэн явааг харахад хэний ч гайхаш төрнө. Ойр хавьд нь хэдэн арван бээрийн газарт айл амьтан байхгүй, тэр ч байтугай амны ус ч бараг үгүй. Ингэнэ усны цөлд явган, сохор ганц хүн байтугай морь, тэмээтэй хүн ч дан биеэр зүрхлэн явах учиргүй билээ. Гагцхүү өөрийн эрхгүй хувь тавилангийн хүчинд л ийм байдалд хүн орж болох юм.

Сохор эр үе үе зогтусаж тэргүүнээ дээш өргөж эргэн тойрон хязгаар хярхаггүй цэлийн шаргалтах говь нутгийг нүдтэй хүн ажин харах мэт дөрвөн зүг найман зовхист нүүрийг хандуулан удтал дуугүй зогсон чимээ чагнаж байлаа. Түүний дэлдгэр боловч омог нь доошоогоо урсан замхарсан юм шиг нарийсч эрүүний углуургаас хоёр хуруу дээхнэ газарт хацартайгаа нийлсэн хоёр чих ертөнцийн түмэн аялгуу, мянган авиаг алгаар тосохын адилаар шуналтайгаар эрэн хайж хүлээн авч цугларуулан нөөцөлж байх шиг харагдана.

Монхордуу хавчиг хөхөлбий хамрын хоёр нүх мөн л хорвоогийн сайн муу үнэр танарыг ховдгоор сорон татах адил байн байн сарталзаж үзэгдэнэ.

- Ашгүй өнөөдөр миний хэдэн хавтгай өглөгөө наддаа хүртээхээр шийдэж дээ. Буянтангууд, айдаа, буянтангууд минь! гэж сохор эр хэн нэгэн хүнд хандах мэт гэв гэнэт чангаар ярив. Хэчнээн өндөр дуугаар юу гэж хэлэвч түүний үгийг сонсож, ойлгох амьтан Ингэнэ усны говьд байсангүй. Гэвч сохор эр өөрөө өөртэйгөө ярьж заншсан байжээ.

Сохор эрийн царайд баярлах шинж илхэн тодорч, магнайны нь үрчлээс дэлгэгдэн, уруул нь үл мэдэг чичгэнэв. Гэвч хүний сэтгэлийн баяр баясгаланг илэрхийлэх толь болсон нүд нь нэгэнт гэгээгүйн

улмаас түүний баярласны шинж тэмдэг тун үл мэдэг ажээ.

- За үүлэн бор минь, жолоогоо сунгая. Найман шаргындаа очъё. Тэд чи бид хоёрт идээгээ зэхсэн байна. Хурдан очихгүй бол гомдчихно. Дунд Шаргын буян дэлгэрэг! гэж сохор эр таягандаа хандан бас л чанга дуугаар хэлэв.

Таягаа үүлэн бор морьтой зүйрлэн нэрлэсэн бололтой. Гэтэл бас найман шаргынх гэж юуг хэлж байгаа юм болдоо! Нэгэн бодоход энэ хүн сохор төдийгүй бас ухаан гажсан мэт ажээ.

Сохор эр тийнхүү таягийнхаа тусламжаар саад бүхнийг чадамгай тойрч явсаар ногоон хөвөөтэй бяцхан булгийн дэргэд ирэв. Энэ нь тэрхэн хавьдаа байдаг цорын ганц булаг юм. Ингэнэ ус гэдэг нэртэй билээ. Жилийн дөрвөн улиралд хатдаггүй юм.

- Найман шарга маань өнөөдөр өглөө эрт ирж дээ. Аргагүй их халуун өдөр болохыг тэд мэдээд рашаандаа эртлэн иржээ гэж сохор эр бас л хэн нэгэнд хандаж байгаа юм шиг хэллээ. Тэгснээ булгийн зүүн урд талд эмжээрлэн шаргалтах элсэн дундах бутнууд руу хүрч очлоо. Зог тусч хамраар шиншлэх мэт үнэр хөөж бөгтгөнөснөө сохор эр таягаа газар орхиж, элсэн дунд сөхрөн суулаа. Сөхөрсөн тэр газар нь элсэн дээр эзгийг шиг шаргал өнгөтэй юм тунаран байх ажээ. Сохор эр тэрхүү эзгийрэн тунарч шавар адил хагаран хатаж байгаа юмнаас авч наалдсан элсийг нь гараар тэмтрэн арилгаад амтархан идэж эхлэв. Өглөө үүрээр энд ирж ус уугаад булгийн захад амран хэвтэж байхдаа хавтгайн ингэ дэлэн нь чинэрэн элсэн дээр сүүгээ гоожуулсан нь өдрийн халуун наранд тийнхүү хатаж байжээ. Аажмаар эзгийг болон хувирдаг. - Ээ дээ, энэ хавтгай сүү ихтэй буянтай амьтан юм даа. Ботго нь хөхөөд байхад л барагдахгүй чинэрээд хэвтсэн газар болгонд аяндаа сүү нь тунаран гоожсон байдаг мөн ч шим сайтай буян төгс амьтан шүү. Миний муу үүлэн хөх моринд ийм шим яаж байх вэ? Гэхдээ хөлийн оронд хөл, нүдний оронд нүд болж наддаа их тусалдаг бас л буянтай мод доо гэж сохор эр газар хаясан таягаа зүүн гараар тэмтрэн олж авах зуур ярьжээ.

Зэрлэг тэмээ сүү ихтэй учир хөхүүл байх үедээ хэвтсэн газраар нь илүүдэл сүү нь гоожиж тунаран үлдээд говийн халуун наранд эззгий болон хатдагийг сохор эр бүр бага залуудаа мөргөлчний урт зам туулж гурван их говийг гаталж явах цагт олж мэдсэн юм байжээ. Сохор эр хавтгайн үлдээсэн сүүнээс цадталаа идээд,

- Амт чанар сайтай, аргагүй л нэг их говийн хүчит ургамал бүрийг түүж иддэг амьтны сүү юм даа. Хуруун чинээг амсаад орхиход л хамаг бие тавирч, тэнхээ орох шиг болох юм. Айдаа ийм сүү байдгийг тэртээ дөчөөд жилийн өмнө банди байхдаа олж мэдээгүй сэн бол ч би энэ цөллөгийн газар нэг хоног ч амьд явахгүй байхаа. Хөөрхий, хавтгай чиний буяныг би юугаар хариулах вэ дээ. Хоосон маань уншилтай биш дээ гэж ганцаараа ярьж хэсэг суулаа.

Говийн тэртээ алс хаяанд шаргал хөхөмдөг зүсмийн таван хавтгай гурван ботгоны хамт бэлчин яваа нь зэрэглээ униарын дунд нэг нам, нэг өндөр болж, даллан дуудах адил үзэсгэлэнтэй сайхан харагдаж байлаа. Гэвч тэднийг сохор эр яахин олж харах билээ.

- Үнэр нь бараг мэдэгдэхгүй болтлоо замхарсныг бодвол найман шарга маань өнөө өглөө тун эртэлж усанд ирж дээ. Одоо лав долоо хоног эргэж ирэхгүй байхаа. Хайрлаж үлдээсэн хишиг буяны нь хамж хормойлж авъяа гэж сохор эр хэлээд мөлхөн урагшилж хамраараа газар шинжлэн үнэр татаж хавтгайн хэвтшийг тэмтэрч эхлэв.

- Нэг бууртай юм даг. Тэр гайхал энд хэвтсэн байна. Шээг, заар нь хамар сэтэлчих гээд яг л мөн дөө. Буур энд хэвтсэн бол тэрнээс цааш ингэ байгаагүй биз гэж сохор эр амандаа бувтнан ярьж нөгөө тийш эргэн мөлхөх зуур мөн л газар шинжлэн тэмтэрч, хоёрдох ингэний хэвтшийг удаж төдөлгуй олжээ. Түүний илүүдэл сүү бас л элсэн дээр гоожиж захаасаа хатаад гол хэсэгт нь бүрэн хатаж амжаагүй зөөлнөөрөө үлджээ. Сохор эр түүнийг үнэрч болжээ. Хүнд заяасан таван аншай буюу сэрэхүйн эрхтнээс хамгийн эрхэм болох мэлмийгээсээ салсан ч гэсэн түүнийг орлох юмтай үлдсэндээ сохор эр

баяртай байлаа. Цанидын буюу билгэ чанарын ухааны лхаарамба болтлоо энэ хүний туулж өнгөрүүлсэн зам урт бөгөөд сургамжтай юмсанжээ.

- Үнэмлэхүйн мөрөөр явагч болох уу? гэж тэртээ дөчин жилийн өмнө багшийг асуухад нь сагардагамын зам хөөнө гэчихсэн минь сэтгэлийн гэм болоогүй л байх. Гэвч би эцэстээ үнэмлэхүйн мөрөөр орж даяанчийн зэрэгт хүрлээ. Уул нь би хүнээс дайжихгүй сэн гэж хүссэн юмсан. Насны эцэст хүнээс дайжих байсан бол анхнаасаа л даяанчийн мөр хөөх байж. Одоо хөгшин толгой би даяанчийн найман сахилыг сахиж яваагаас ялгаа юу байна? гэж сохор эр амандаа бөвтнөж бусад хэнд ч дуулдуулахгүй гэсэн юм шиг бүдэгхэн ярьж явлаа. Ингэнэ уснаас ганцхан саахалтын зайтай газар түүний орц байдаг ажээ. Үнэмлэхүйн мөрөөр явагч буюу даяанч болох хүн юуны урьд хад чулуугаар гэр хийх ёстой байлаа. Үүнд сохор эрийн байдал одоо тохирч байна. Тэрээр асар том хармагийн бут шавааралдан ургасан товцог доогуур нүхэлж гаргасан орцонд амьдарч байна. Даяанч хүн хөх чулуугаар дэр хийж, хүйтэн газраар дэвсгэр хийх учиртай. Би ханан гэрт орохгүй байх ёстой. Унаагүй сохор өвгөнд энэ их цөлд хад чулуунаас өөр ямар өмч байх вэ? Ханан гэрт хүрэх ямар тэнхээ байх вэ? Даяанч хүн өнгө, дуу, үнэр, амт, хүрэлцэхгүйн таван хүслээ хазаарлаж, зэрлэг араатан амаа ангайн дайрлаа ч, хорт могой өсгий рүү нь хатгаж байсан ч бясалгалаа хийж, сахил сахиж байх учиртай. Сохор эр үүнийг сахихыг хүсэхгүй байвч өөр ажил түүнд олдохгүй билээ. Даяанч хүн номт хувцаснаас өөр хувцас өмсөх ёсгүй. Тэгэвч сохор эрийн номт хувцсыг нэгэнт шалдлан хурааж аваад хар хүний дээл өмсгөн цөлсөн болохоор энэ сахил алдагджээ. Сохор эр номт хувцсыг дахин өмсөхийг ч өөрөө хүсэхгүй байлаа. Даяанчийн бас нэг сахил сохор эрийн сэтгэлд одоо их нийцэх болжээ.

- Хортон дайснаар нөхөр хийх гэдгийг чинь л би дагая гэж сохор эр нэг биш удаа өөртөө хэлжээ. Даяанч хүн хамгийн заналт дайснаа байлаа ч нөхөр гэж тооцох тийм бодь сэтгэлтэй байх учиртай ажээ. Сохор эрд өнөөдөр дайсан олон болжээ. Тэд сохор эрийг Ингэнэ усны говьд цөлсөн. Цөлөхдөө хэнд ч мэдэгдэлгүй нууцаар авчирч

ганцаарангий нь идэх хоол, уух унд өмсөх хувцасгүйгээр орхисон.

Тэгэхдээ төрсөн өдрийг нь, тохиосон одыг нь тааруулан авчирч цөлд хаяжээ. “Нэг бодоход цоо шинэ амьдрал эхэлж үүсгэхийг сануулсан юм шиг. Нэг бодоход ийм хүн төрөөгүй нь дээр гэж хэлсэн мэт. Гэвч би төрсөн, амьдарсан, хийсэн, бүтээсэн. Хэдийгээр насны үд хэвийж залуу нас алсад өнгөрсөн ч шинэ зам эхлэхэд юу нь хождох билээ. Гайгүй миний энэ замаар би ганцаараа олон жил явахгүй биз. Миний араас заавал хүмүүс ирнэ” гэж хаврын эхэн сарын тэр нэг өдөр, цөллөгийн анхны өдөр сохор эр ганцаараа бясалган боджээ.

Чухам яагаад ингэж итгэлтэй болсон юм бэ? Чухам яагаад энэ хүнийг эзгүй говьд ямар хүмүүс, яах санаатайгаар ганцаарангий нь цөлсөн юм бэ?

- Сагардагамын буюу үнэнч, шударга ёсны мөр хөөсөн минь намайг анд хүргэж дээ, хөө. Одоо энэ замын төгсгөл хүртэл чи бид хоёр яваад байнаа гэж сохор ар газар урцныхаа үүдэнд очихдоо таягтайгаа ярилаа. Олон жилийн өмнө түүний сагардагамын буюу нэгэнт харин ирэгчийн мөр яаж эхэлснийг дараах бүлгүүдэд өгүүлсүгэй.

Нэг. Гэцэлийн сахил хүртсэн нь

Нумгүй анчин ав дээр гэмшил

Номгүй лам хурал дээр гэмшил

Үйлгүй хүүхэн хурим дээр гэмшил

Буянзалбирах хийдийн гол сүмд нам гүм, бүрий барай, хүж, гүгэлийн нялуувтар үнэр сэнгэнэж байлаа. Шүтээний өмнөх зандан ширээн дээр хэдэн эгнээгээр ёс горимоор нь өрсөн тахилын юмс зулын бүдэг гэрэлд сүүтгэнэн хөдлөх шиг эрээлжлэн ярайна. Хамгийн урд нүүрэнд долоон цөгч эгнүүлсний зүүн хоёр нь устай, гурав дахь нь цэцэгтэй, дөрөв дэх нь хүжтэй, тав дахь нь шар тосон зултай, зургаа дахь нь ус, долоо дахь нь цагаан идээтэй ажээ. Бурхны өлмийн сэрүүцүүлэг буюу түвдээр шабсэл, нүүрийн сэрүүцүүлэг буюу түвдээр шалсэл, газар шорооны бэлэг буюу түвдээр мэхох цэцэг, утах хүж буюу түвдээр дугбойзул буюу түвдээр мармэй, үнэрт ус буюу түвдээр дигаб, гэгээний зоог буюу түвдээр шалсайг төлөөлж ийм долоон тахилыг аливаа сүмийн байтугай, гэрийн шүтээний өмнө өрж тавьдаг заншил түгээмлийн учир хаа ч ийм л байдаг бүлгээ. Долоон цөгцнөөс цааш өлзийт найман тэмдэг буюу найман тахил ярайж байна. Нисваанисын халууныг буюу элдэв нүгэлт хүслийн шуналыг дарах билэгдэл болсон цагаан шүхэр, цэвэр алтаар цутгаж хийсэн бодь гөрөөсний дүрс, тус жаргалангийн голд амьдрах загасны дүрс, яруу дуугаа арван зүгт түгээгч цагаан лавай гэгч дунгар, бохир муухайгаас хагацсан цагаан бадамлянхуа, хүслийн эрдэнээр төгс дүүрэн бумба, аз жаргалын төгсгөлгүй билэгдэл өлзий утас, балбэ, ялгуусны чимэг болох жалцан, мянган хигээст номын хорол энэ наймыг өлзийт тэмдэг болгон шүтээнийг чимэглэжээ. Мөн эдгээртэй зэрэгцээд Хүрд эргүүлэгч Чакаравартийн долоон эрдэнэ ярайж байна. Мянган хигээстэй наран мэт хүрд, найман булангаас таван өнгийн гэрэл цацруулж халуунд сэрүү татуулж, хүйтэнд халуу оргиулдаг увдистай гэгддэг чандмань эрдэнэ, хамаг зовлонг арилган чадах,

хүрэлцэхийн төдийхнөөр амгаланг өгөх эрдэмтэй хатан эрдэнэ, хамаг амьтныг хүү мэт тэтгэх учиртай түшмэл эрдэнэ, бурхны 84 мянган номыг нуруунаа үүрэгч заан эрдэнэ, салхи мэт хурдан ба нуруунаа чандмань тээгч морин эрдэнэ, ялахын хүчин бүрдсэн цэргийн ноён эрдэнэ эдгээр долоог билэгдэл болгон өржээ.

Тахилын ширээний баруун талд найман тахил, долоон цөгцний дунд дэлхийг дүрсэлсэн мандал байна. Хүрлээр хийсэн дүгрэг хэлбэртэй тэрхүү мандлын гол дунд нь сүмбэр уулыг зүүн гарыг мөнгөөр, өмнө талыг номин, барууныг бадмаараг, умрыг алтаар чимэглэн дүрсэлж тивүүдийг дугуйруулсан хүрээгээр томьёолж арвайгаар дүүргэжээ. Түүний эсрэг талд тогосын өдөн чимэгтэй цацал бүхий рашааны зэс гүц дэргэд нь хүрлээр хийсэн толь байна. Мандлын дэргэд гавал аяга хүрэл суурин дээр тавиастай. Зүсэн бүрийн тахил, өргөлийн ийм зүйлсийн цаад талд бурхан багшийн алтадмал дүрс хүж, зулын цэнхэр униарын дундаас гялтганан харагдана. Дээд тайзнаас унжуулан зүүсэн таван өнгийн бадан сүм дахь агаарын нөөлөгний аясаар үл мэдэг чичрэгнэн хөдөлж, арван нэгэн гошгор уутанд арц, хүж, гүргэм зэрэг үнэрт ургамал чихээд хооронд нь нийлүүлэн оёж хийсэн бөөрөнхий хэлбэртэй чима- пурмаа гэдэг чимэглэлтэй хавсран бурхдын өмнүүр сонин чамин унжлага болон алаглаж байлаа. Тахилын ширээнд бас бурхдын таван хүслийг хангах билэгдэл болгож сонсголыг нь дун, харааг нь толь, үнэртэхүйг нь задь, амтлахыг нь жимс, хүрэлцэхүйг нь хив торгоор хоргомчлох учиртайгаар дээрх зүйлсийг өрсөн ажээ.

Шүтээний ширээнээс урагш хоёр талаар лам нарын суудал, жавдан эгнэж байлаа. Хамгийн эхэнд зүүн гар талд долоон давхар олбогтой, түшлэгтэй суудал, түүний эсрэг талд есөн давхар олбогтой түшлэгтэй суудал байлаа. Есөн олбогт суудал эзгүй, долоон олбогт суудалд нэг ч үсгүй гуулин шанага шиг толгойтой тарган улаан лам заларчээ. Бурхан багш шавь нартаа нэг олбогийг зургаан жил хэрэглэхээс нааш сольж болохгүй гэж захисан ёсоор зургаан жил тутам олбог нэмэхдээ хуучнаас нэгэн алга дарам хуулбар авч шинийнхээ гол дунд оёдог, түүний нь төөтэй олбог гэж нэрлэж заншжээ. Долоон төөтэй, долоон давхар олбог дээр залрагч тэрхүү ламбугай зургаан долоо дөчин хоёр

дахь жилдээ энд сууж байгаа бололтой. Жавдангийн зүүн мөрний хоёр дахь суудал таван олбогтой бусад нь жирийн жавдангууд байлаа. Бурхан багш шавь нарынхаа суух дэвсгэрийг өргөнөөрөө хоёр тохой, уртаараа нэг тохой хагасаас хэтрүүлэхгүй хийж байх хэмжээ тогтоожээ. Гэвч сүмд шавилан сууж, олон жил хөдөлгөөн багатайгаар аж төрсөн лам нарын нэлээд нь бурхан багшийнхаа заасан хэмжээнээс хэтрэн халихаар махлаг болдог тул олбогтоо багтахгүй гэвддэг байжээ. Тийм үед олбогтоо зөвхөн эмжээр хийж болох тул зарим тариалаг лам нар эмжээртэй олбог дээр сууна. Буянзалбирах хийдэд тийм олбог цөөнгүй байлаа. Лам нар суудлаа эзэлж дуусахад үүдний хоёр хатавчинд хоёр гэвхүй буюу гэсгүй бэрээгээ барин түр зогслоо.

Гаднаас нэгэн хижээл насны гэлэн цовоолог гялалзсан нүдтэй бандийг дагуулан орж ирлээ.

- Олныг сонсож, винайг сахисан гэлэн Чоймчиг би шавь болсон банди Санждаа гэцлийн сахиус хүртээж өгөхийн соёрхлыг гуйя гэж хижээл насны гэлэн багшийгаа төв даруу боловч хүнгэнэсэн бүдүүн дуугаар хэлэхийг сонсоод банди Санж балмагдан айж зүрх нь түг түг цохилло.

- Энэ банди Санж сэтгэлийн түйтгэрээс бүрмөсөн ангижирсан уу? гэж долоон олбогт ширээт лам сөөнгөдүү паржигнасан дуугаар хариу асуулаа.

- Бүрмөсөн ангижирсаан! гэж багш лам нь өчөөд шавь бандийгаа хөтлөн сүмийн гол дунд аваачиж Бурхан шүтээний зүг харуулан гурвантаа сөгдүүлэн мөргүүлэв. Дараа нь ширээт ламд мөн тэрчлэн мөргүүллээ. Тэгээд ширээт ламын өмнө хоёр гараа элгэндээ зөрүүлэн сөгдөн суужээ. Тэр мэт суудаг гэж багш нь түрүүн зааж өгчээ. Банди Санж өөрөө ч урьд нь убаш, банди сахил хүртэж байсан тул юу болохыг гадарлажээ. Дөрөвхөн настайд нь убаш сахил хүртээсэн болохоор тэр үед яаж байсныг бүдэг бадаг санана. Гэвч долоотойдоо банди болсноо огт мартаагүй байлаа. Тэгэхэд хачин гайхмаар дөчин асуулт асууж билээ. Заримд нь юу гэж хариулахаа мэдэхгүй, заримд нь уур хүрч, заримд нь гайхаж байсан. Хэдий тэгэвч багшийнхаа

үгээр хариулж, бандийн сахил хүртсэн. “Хэрээ үргээж чадах уу?” гэж асуухад нь уур хүрч “нэгэн хумст тэргүүтэн биш биз?” гэхэд нь гайхаж, “доройтуулагч дөрвөн уналд орсон буюу чи?” гэхэд нь хариулах үг олохгүй байж билээ. Гагцхүү багш гэлэн Чоймчигийн үгээр тэр асуултад хариу өчсөнийгөө одоо дахин дурсан бодоод бандийн сэтгэл тавгүй болжээ.

Ширээт лам сөөнгө дуугаараа,

- Гэцэл болох хэрэгт чамд энэ хорвоог бүрэн огоорох хатуу итгэл хэрэгтэй. Бүхэл орчлонд амгалан тайван гэж оггхон ч үгүйг санахтун. Тамынхан галд шатан зовно. Бирдүүд өлсч, цанган зовно. Адгууснууд бие биенээ идэж зовно. Хүн богино насалдагтаа зовно. Тэнгэр нар оюунаа сэрээх гэж зовно. Төрмөгц зовлон эхэлмой. Төрмөгц хөгширч эхэлмой. Амьдрах нь өндөр уулнаас үсрэн буухын адил. Тэр хооронд жаргал хэмээ нь үгүй. Ийм болохоор хамаг амьтны тусын тулд бүхнийг нийгүүлсэгч, бүхнийг чадагч бурхан багшийн ариун хутгийг олж бүхнээс хамаг зовлонгоос ангижрахаар гэцэл сахил хүртэж есөн гэрээслэлийг хаа хэзээ ч болов сахих ёсон буй! гэж айлдав.

Багшийнхаа заасан ёсоор банди Санж номхон дуугаар,

- Банди Санж би энэ цагаас эхлээд эцэслэх насаа хүртэл хоёр хөлтний дээд бурханд, эгээрэлгүйн дээд номд бишрэн шүтэж явна. Намайг гэцэл болгон авна уу, Тойн бугай! гэв.

- Дахин өчигтүн! гэж ширээт лам зарлиг болгов? Банди дахин өчив. Түүнд бас л сэтгэл ханадаггүй бололтой.

- Дахин гурав дахь удаа өчигтүн! гэж ширээт лам зарлиг болгов. Банди дахин өчиж,

- ...гэцэл болгон авна уу? гэтэл - Ха! гэж ширээт лам чанга хашгиран гурван хуруугаар агаарт хий инчдэж часхийх дуу гаргалаа.

- Гэцэл сахиусыг зөв хүртлээ! гэж сүмд суугаа бүх лам тэр эгшинд

нэгэн дуугаар зэрэг хэлцгээлээ.

Банди Санж цочих шиг болсон ч гэсэн биеэ барилаа. Долоон настайдаа банди болж, үсээ үргээлгэсэнээ дурсан санав. Багш лам баруун гартаа хайчаа барьж, зүүн гараар үснээс нь нэг тугийг хайчлан аваад,

- Санж убаш чи үсээ үргээлгэсэнд баярлаж байна уу? үгүй юу? гэж асууж билээ.

- Баярлаж байна гэж арай чамай хариулахад багш лам дагзнаас нь бас нэгэн туг үс хайчлан авч сахил хүртээгч ламд өгсөн юмсан.

- Цагаан зүгийн тэнгэр минь өршөөн соёрхож хайрла гэж тэр хэлээд туг үсийг бурхны өмнө тавьж билээ.

Тэгээд аршаанаар нүүрийг нь угааж угаал үйлдсэний дараа,

- Номт дээлээ ав! Харчууд болоод тэрсүүдээс номт дээл чамайг ялгаруулж, халуун хүйтэн, салхи бороо, өт хорхойноос хамгаална гэж сахил хүртээгч хэлээд баруун мөрөн дээр нь номт хувцас тавьж,

- Энэ шамтав гэдэг хормогч доод биеийг хорон нүднээс халхална. Энэ номт дэвсгэр амьтан хүний алаг эрээн дэвсгэрээс аварна. Энэ бадар аяга, усны шүүр хоёр чамайг амны хор, усны нүглээс аварна. Уух буюу ам зайлах усныхаа дээр тогтсон амьтныг устай хамт залгихгүйн тулд усны шүүрээр зайлуулж бай гэж сурган зааж бандийн хэрэглэлүүдийг бүрэн өгч билээ.

Тэр цагаас өнөөг хүртэл номт хувцас халаагүй өмсөж явсаар одоо нэгэнт дасал болжээ. Бурхны шавь болох гурав дахь даваан дээр энэ банди өнөөдөр гарлаа.

Эцэг Сайнцогтын ерөөлийг үр нь ийнхүү алхам алхмаар биелүүлж яваа ажээ. Банди Санжийг үүнээс хойш гэцэл гэж хэн хүнгүй дууддаг

болно. Буянзалбирах хийдэд хамгийн залуу буюу арван таван настайдаа гэцлийн сахил хүртсэн банди болсондоо хөвүүн Санжийн сэтгэл өнөөдөр баяртай байлаа. Хийдийн гориломоос гадна харчуулын бор гэрүүд дотор садангийнхаа айлд эцэг Сайнцогт хүлээж суугаа. Ууган хүүгээ гэцлийн сахил хүртэхийг тэсч ядан хүлээж суугаа. Банди Санжийг Буянзалбирах хийдэд долоон настай байхад нь эцэг Сайнцогт дагуулан ирж гэлэн Чоймчиг гуайд шавиар өгсөн. Тэр хүртэл гэрийн газраа хонь мал хариулан, аргал гүлээ түүж байлаа. Дөрвөн настайд нь Чоймчиг гэлэн тэднийд залагдан очиж убаш сахил хүртээснээс хойш орон хийдэд шавилан суух бүхий л бэлтгэлийг хөвүүн Санж гүйцээж билээ.

Эцэг Сайнцогт цөөн малтай ядуу хар хүн. Багадаа Буянзалбирах хийдийн олон сүм дуганы хаялага, балин, шалсайг түүж идсээр хүн болжээ.

- Муу аавыг чинь хар багад минь харангадаж үхэхээс Буянзалбирах хийд аварсан юм. Хийдийн хаягдмал балин шалсайг түүж идсээр яваад хүний зэрэгт хүрсэн. Тэр цагт би хувь тавилангийн эрхээр үртэй болдог юм бол түүнийгээ Буянзалбирах хийдэд шавь болгон суулгана. Сайн лам болгоно гэж Буянзалбирах хийдийн босгоор алхах бүрдээ өчиг тангараг өргөж байсан юм. Ашгүй хувь тавилан минь надад хүү чамайг заяалаа. Багадаа өгсөн өчиг ёсоор хүү чамайгаа би хийдэд шавилуулан суулгаж лам болгоно гэж санаж байна. Намайг үгэндээ хүрнэ гэж итгэсэн юм шиг балин, шалсай элбэг л олддог байлаа, хөөрхий гэж мэдээ орсон цагаас нь хойш бараг л өдөр бүр хайрт эцгээс хөвүүн Санждаа ярьдаг байлаа. Энэ ярианд бас л эх нь нэмэр өгдөгсөн. Хийдийн гориломоос дотогш эмэгтэй хүн оруулдаггүй болохоор эцэг Сайнцогт очиж балин, шалсай хормойлон ирж эх Цэндээтэй олзоо хуваадаг байжээ. Долоо, найман настайгаас эхлэн энэ хоёр арван дөрөв тав хүртлээ балин, шалсай хуваан идэж хамтран өлсөж амьдарсаар эцэстээ хайр сэтгэлтэй болж хоёулаа айл гэр үүсгэсэн юм байжээ.

- Аав, ээж хоёртоо балинтай ирээрэй. Багадаа идэж явсан болохоор

хааяа амсахад сайхан байдаг юм гэж Санж хөвүүндээ аав ээж нь хийдээс гомбоо чөлөөгөөр харих бүрийд захидаг байлаа. Тийнхүү балин аваачиж өгөхөд аав ээж хоёр нь түүнийг хоёр гардан ихэд хүндэтгэн эхлээд духан дээрээ хүргэн адис аваад дараа нь амтархан идэхдээ хоёулангий нь нүднээ нулимс гялтганан гарч үзэгддэгсэн. Тэр хоёр балингаа идэж дуустал хэнтэй ч дуугардаггүй байлаа.

- Бурхдад өргөдөг идээ болохоор хамгийн сайхан юмаар хийдэг, тэжээлтэй зоог доо хөөрхий. Даанч хүртдэг хүн нь бурхан биш өнөө муу гуйрамч Сайнцогт шүү дээ! гэж эцэг нь шимийн архинд халах үедээ байн байн дурсан хэлдэг юмсанжээ.

- Замбативийн шалсайнаас эхлээд шатаг марж балинг хүртэл бишгүйдээ л нэг зооглосон. Аль аль нь ивгээлтэй л өнгөрсөн гэж эх Цэндээ үе үе дурсан ярина. Энэ бүхэн хөвүүн Санжийн сэтгэлд хадаатай үлджээ.

Замбативийн шалсайг газрын эзэнд зориулан хийдгийг одоо Санж андахгүй бас ч тийм шалсайг өөрөө урлан хийж чаддаг болжээ. Догшидын хурал хурах бүрийд гурван янзын балин шалсайг балинч, шалсайч нар бэлтгэдэг, тэд гарын ур дүйтэй барималч хүмүүс байдаг тул сониучхан банди Санж тэдэнтэй нөхөрлөж балин шалсайг их уран гоё хийдэг болжээ.

Замбативийн шалсайг гурвалжин босоо цац хэлбэртэйгээр хийж, нар, сар, чандмань эрдэнийн дүрсээр дээд талыг чимэглэнэ. Чимгийг шар тосоор, их биеийг замбайгаар хийнэ. Будагтай хольсон шар тосоор улаан нар, шар сар, таван өнгөөр чандмань эрдэнийг дүрслэн хийж замбайн гурилан шалсайн эргэн тойронд наалдуулан чимэглэнэ. Хамгийн амттай шалсай энэ бөгөөд үүнийг цөөн тоогоор хийх тул ховор олддог байлаа.

Замбативийн шалсайн дараагаар догшид нарт зориулсан гарын авлага гэж нэртэй, зүрхэн таринын үсэг бичээстэй шулуун гурвалжин цац мэт хэлбэртэй балин орно. Ийм балин нэг томыг хийх боловч эргэн

тойронд нь нөхөр гэж олон жижиг балин суулгадаг юм. Тоо нь адилгүй. Махгал бурханд зориулсан балин жаран хоёр нөхөртэй. Гомбод зориулсан нь далан таван нөхөртэй гэх мэтээр тогтоосон байна. Ийм балин элбэг олох тул Санжийн аав Сайнцогт голчлон түүгээр хооллодог байжээ.

Мах цусны балин буюу шатаг маржийг хүний биеийн гол гол эрхтэнгүүд бөөр, зүрх, сарвуу, тавхайг дүрслэн хүрэн өнгөөр будаж хивэг шиг бүдүүн ширхэгтэй гурилаар хийнэ. Ийм балинг хурал хурж дуусах үеэр шатаах буюу гаргаж хаяна. Мөргөлчид түүнийг гай, золигт гаргасан зүйл гэж үзээд хэзээ ч иддэггүй байлаа.

- Өлсөх цагт шатаг маржийг зөндөө л идэж явлаа. Уул нь муу ёрын идээ гэгддэг юм. Бидэнд хэзээ ч муу юм болж байгаагүй. Их идэхлээр таргалах гээд байдаг л даа гэж аав нь хааяа шогтойгоор инээмсэглэн ярьдаг гул Санж тэрхүү шатаг марж балингаас цэрвэж цээрлэхээ больжээ.

“Аавдаа гэцэл болсноо дуулгахаар очихдоо балин аваачих юм шүү!” гэж Санж дотроо бодож байтал багш лам нь,

- Улаан гал барс жилийн зуны эхэн сарын шинийн наймны өдрийн тахиа цагт долоон арт, гурван хулийн сүүдэрт банди Санж чи гэцэл сахиус хүртлээ. Чи энэ өдрөөс өмнө гэлэн, гэцэл болсон ахмад сүжигтэн бүрийг дээдэлж, өөрөөсөө дээш суулгаж, өргөл мөргөл үйлдэж, тэдний өмнө зогсоо байж хүндэтгэх ёстой. Тэгж чадвал чи бусдын сахилд итгэсний буян эдлэнэ. Энэ өдрөөс хойш гэцэл банди, убаш, убсанц сахил хүртсэн бүхэн чамаас насаар ах, дүү ялгаагүй чамд хүндэтгэл үзүүлэх ёстой. Чингэснээрээ чи өөрийн сахилд итгэл хүлээж буян эдлэнэ.

Сахил хүртээд түүнээ сахих ёстой. Үүний тул арван тэвчлэгийг бие, хэл, сэтгэлээр үйлд гэж ширээт лам пйлдав. Үүнийг гэцэл Санж анхааралтай сонсож тогтоож авахыг хичээж байлаа.

- Гэцэл сонс! Арван тэвчлэг, үүнд өргөн бариагүйг авахыг тэвч, завхай самууныг тэвч. Худал ярихыг тэвч. Согтуурах ундааг тэвч. Дуу бүжгийг тэвч. Хөгжим зугааг тэвч. Үнэртнээр гоёж, чимэг сэлт зүүхийг тэвч. Өндөр өргөн суудалд суухыг тэвч. Цаггүй хооллохыг тэвч. Мөнгө авахыг тэвч! гэж ширээт зарлигдахад гэцэл Санж тэвчлэг болгоныг “тэвчье” гэж хариу өчлөө.

Гэцлийн сахиус хүртэх зан үйл ийнхүү дуусахад багш лам Чоймчиг нь шинэ гэцлийнхээ гараас хөтлөөд суудал заахаар явлаа.

- Асуулгаа хэзээ хийх юм бэ? гэж Санж багш ламаасаа сэмхэн асуулаа. Олон асуулга асуух нь гэж айж байжээ.

- Гэцэл хүртэхэд өөр юм асуудаггүй. Харин гэлэн болох цагтаа л хичээ. Гучин долоон асуулт тэр цагт тулгарна гэж Чоймчиг гэлэн ууртай шивэгнэв.

...Лам нар гадаалахад гэцэл Санж хоёр ширхэг замбативийн шалсайг орхимжиндоо нууж аваад хийдийн гориломоос гарахаар явлаа. Садангийнхаа хар гэрийн гадаа эцэг нь харуулдан шээзгий сандайлан сууж байхыг Санж холоос хараад өрөвдөх шиг болов.

“Хөөрхий муу аав минь, намайг сайн лам болоосой гэж өдрийн бодолдхөтлөөстэй шөнийн зүүдэнд уяастай байх юм. Яаж ийгээд ч гэсэн олигтойхон шиг л лам болох юмсан. Өнөөдөр хүү нь гэцэл боллоо. Дахиад хэдэн жил өнгөрөхөд гэлэн болно. Амны уншлагаас хэтрэхгүй гэлэн болоод ч яахав. Таван ухаанд мэргэжих юмсандаа” гэж Санж дотроо бодлоо.

Эцэг нь гэж баяр дүүрэн царайтай, итгэл төгөлдөр нүдтэй хүн араг дээрээс ухасхийн босч угтан гүйж ирлээ.

- Яав? Сахил хүртэв үү? гэж явуут дундаа эцэг нь асуусаар хүүгээ тэврэн авлаа. Санж арьс элдсээр байгаад хөмний үнэр нэвт шингэчихсэн эцгийнхээ цээжинд наалдаж,

- Гэцэл сахил хүртлээ, аав аа! гэж аяархан хэллээ. Эцгий нь зүрх түг түг цохилж байхыг хүү тодхон сонслоо.

Ашгүй дээ, хүү минь. Муу эцгийнхээ хүслэнг хөсөр орхисонгүй гэж аав нь хэлээд хүүгийнхээ саяхан үсий нь хуссан гөлчгөр толгой дээр үнсэв.

- Би танд шалсай авчирсан. Ээжид ч бас! гэж Санж хэлээд орхимжны нугалаасанд далдалж сугандаа хавчиж авчирсан хоёр шалсайгаа гаргаж ирэв. Эцэг Сайнцогтын дөлгөөн нүдэнд нулимс цайлалзав. Түүний сэтгэл уян зөөлөн нь зүйргүй билээ.

- Гялайлаа хүү минь! гэж тэр хэлэхдээ хоолой нь үл мэдэг чичрэгнэж байв.

Аав нь баярлаж, сэтгэл догдолжээ. Зовлонт хэцүү амьдрал туулсан болохоор сэтгэл нь амархан уярдаг хүн юмсанжээ.

- Хоёр хөлтний дээд нь лам багш гэдэг юм даа хүү минь. Одоо тэдний зиндаанд хүрч байгаа болохоор Миний хүү эрдэм номоо сайн сурахад л чармайвал таарна. Номгүй лам хурал дээр гэмшил гэдэг үгтэй юм гэж аав нь сургамжлав.

- Сурахыг хичээнээ, аав минь. Хийдэд номоос өөр ямар ажил байх билээ. Бурхны ном л шагайж хамаг цагаа бардаг шүү гэж Санж ярив. Тэрнээс өөр ч ажил юухан байх вэ?

- Сайн номтой лам болох учиртай. Манайд одоо чамаас өөр хэн лам болох билээ дээ. Хоёр дүү чинь хоёулаа охин. Тэгээд ч эм хүн хэзээ лам байлаа. Харин багш ламтан чинь хэдүүн манайд очихдоо отгон дүүгий нь увсанц сахил хүртээсэн гэж аавыгаа хэлэхэд Санж гайхаж,

- Увсанц болгож яах нь вэ дээ? гэв.

- Яахав ариун журамтай яваг гэж ээж нь ятгаад тэгсэн юм. Ээжий нь санааг бас дагалгүй яахав гэж эцэг нь хүүг ээ ятган толгойг нь илж тайвшруулав. Санж эхээс гурвуулаа буюу хоёр охин дүү хойноосоо дагуулжээ.

Эр усан гахай жилийн хаврын эхэн сарын 15- ны өдөр Санж Ривади одноо тохион төрсөн тул лам багш Чоймчиг Сайнцогтын далагдан очиж ном нээж, шоо орхиж, хамаг л тохиолы нь шинжиж, зурхайн сударт үзжээ.

- Сайн заяатай хүүхэд төржээ. Эрдэмт их лам болох ч юун магад. Иймээс Ривади одны тохиолоор Хаянхирваа бурхан шүтэж яваг. Цэн хүлцэлд тохиосон ёсоор хувий нь амны уншлага “Ом нама шад суухаа!” болно. Хөх бор зүсмийн морийг голчлон хөлөглөж бай! гэж Чоймчиг гэлэн айлдан заажээ.

Түүнээс хойш хөвүүн Санжийн хэлдэг үг нь “Ом нама шад суухаа!” гэх залбирал болж аав нь хүүдээ зориулан морь бэлтгэх бинчингүйгээс арга буюу эр ганц хөх ямааг зүслэн зааж сэтэрлээд хүүгийнхээ унаа болгожээ. Гурваас долоон нас хүртлээ тэр ямааг Санж унадаг байлаа. Царигтай ямаа байсан болохоор туранхай жаалыг даадагсан.

Эцэг Сайнцогт бусдад арьс хөм элдэх, сур дээс тохих, чөдөр ногт зангидах, айл нүүлгэх, мал нядлах, ноослох, түлээ бэлтгэх зэргээр хар бор ажил хийж амь зууна. Эх Цэндээ ширдэг ширэх, гутал уллах, шөрмөс тохих, дээл эсгэж оёх, ноос савах, тариа татах, хуурах зэрэг ажлыг айлуудаар хэсэн хийж өгч хөлсөөр нь гэр орныхоо амьдрал ахуйд нэмэр болдог байлаа. Гурван хүүхэд төрүүлсний хоёр нь охин, нэг нь эр. Тэгээд ганц хүүгээ хийдэд өгсөн нь өнөөдөр гэцэл болжээ. Эцэг эхийн сэтгэлд нар гийж, буяны үйлсийн сайн замд ганц хүүгээ оруулж, бурханд түүгээр өргөл мандал болгосонд тэдний эгэл жирийн сэтгэл дээд баяраар дүүрчээ.

Хоёр. Эрэлд гарсан мөргөлчид

Тэнгэр баганагүй нэг дутуу
Уул бүслүүргүй нэг дутуу
Далай бүлүүргүй нэг дутуу

Алсад сүрлэг өндөр уулс хөхөмдөг манан дундаас сүндэрлэн шоволзож харагдлаа. Их зам дагасан мөргөлчдийн урт цувааны магнайн тэмээг хөтөлж явсан баргар царайтай хүн зогтусаж эргэн харснаа,

- Алшаа яаман харагдаж байна. Юмаа цэгцтэй явцгаа! гэж хэлэв.

Мөргөлчид цөмөөрөө ам амандаа бувтнан шуугилдаж турлиахын сүрэг цочин нисэхдээ гуаглалдахын адил бөөн шуугиан боллоо.

- Шуугилдан сониучилж байхыг нь хараач. Ер ихэнх нь анх удаа л энэ замд гарсан улс бололтой гэж Чоймчиг гэлэн шавьдаа хэлэв.

- Над шиг үү? гэж Санж гэцэл асуухад Чоймчиг толгой дохисноо,

- Би чамд зам зуурын бүхий л сонинг ярьж өгнө. Харин миний дутуу орхих юм уу, ажиглаагүй зүйл гарвал асууж авч байгаарай. Над дахиад чамд тэгж ярьж өгөх боломж байхгүй болно шүү гэж хэлэв. Тэр сэжигтэй үгэнд Санж цочирдлоо.

- Яагаад боломжгүй гэж? Бид чинь хамт буцна биз дээ? гэж Санж гэцэл гайхан асуужээ. Багш нь тэр асуултыг сонсоод царай нь үл мэдэг хувьсхийснээ биеэ барьж,

- Яах вэ. Хорвоогийн амьдрал эрээнтэй бараантай. Хожмын явдлыг таахад бэрх. Багш нь чам шиг залуусан бол маргааш юу болохоо

бодож л байхсан гэж хэлээд санаа алдсанаа,

- За за, хэрэгт дуртай гэдэг нь! Одоо мөдхөн Алшаа яаманд бууна, Өргөл, барьц, гааль төлөөсөө л бод гэв.

Санж гэцэл багшийнхаа үгэнд сэжиг төрсөн боловч аяны замын үзүүрт Алшаагийн сүрлэг уулсын энгэр түшсэн орог саарал хотын барааг хараад тэр зүг анхаарлаа чиглүүлэв.

Мөргөлчдийн энэ урт цуваа Халхын Засагт хааны нутгаас гарсаар хоёр сар гаруй явж байгаа ажээ. Гэлэн Чоймчиг шавь Санжаа дагуулан бас бус хэдэн мөргөлчний хамт нэгэн гал болж Буянзалбирах хийдээс гараад Цонжийн замд энэхүү урт цуваатай нэгдэн нийлсэн ажээ. Хэтийн хэрэг зориг нь гэвэл шашны ариун дээд орон Лхас зуу орж өргөл, мөргөлийн явдлаа гүйцээхийг хүссэн улс юм. Гэцэл Санж бол бурхны ном гүнзгийрүүлэн үзэх шашны сургуульд орохоор Лхас зууг зорьжээ.

- Цовоо сэргэлэн, ухаан тунгалаг, ааш эелдэг, санаа ариун, зураг тавилан буянтай, зүс царай намбалаг тул энэ хөвгүүнийг Лхас зууд явуулж номд мэргэн болговол шашин төрд хэрэгтэй биз. Эцэг Сайнцогт чи юу гэж бодно билээ? хэмээн нэгэн өдөр Буянзалбирах хийдийн хамба лам Санж гэцлийг Сайнцогт эцэгтэй нь нүүрэлдүүлэн асуужээ. Эцэг нь үнэмшихээргүй ихээр баярлан сэтгэл догдолж хэлэх үгээ олж ядан, амьсгаадаж,

- Лам гурван эрдэнэ минь! Лам гурван... гэж байсныг Санж гэцэл одоо ч сэтгэлдээ тод санаж, нүдэндээ хөөрхий эцгийнхээ баярласан царайг харах шиг болж байлаа.

- Эцэг Сайнцогт чи ганц хүүгээ бурхны шавь нарын тоонд оруулж, Лхасын оронд илгээхэд цааргалахгүй юм шиг вэ дээ? гэж хамбыг дахин лавлахад,

- Лам гурван эрдэнэ минь! Ганц хүү минь ариун шашны үйлэнд хэрэг

болбол эцэг миний энэ яваа нас болоод өмнө, хойнын хувь тавилангийн бүхий л хэрэг бүгнэ. Тэнгэр хүртэл баганаар дутдаг юм. Өршөөж соёрх! гэж эцэг нь хамбын өмнө өвдөг сөхрөн газар хүртэл бөхөсхийж наманчлан залбирчээ.

Ингэж Санж гэцлийн хувь заяанд шинэ зам эхэлжээ. Одоо тэр замаар хоёр дахь сардаа явж байна. Гэцлийн ухаан сэргэлэн, авьяаслагийг Буянзалбирах хийдийн лам нар ажиж мэдээд Түвдэд суулгаж ном үзүүлж өөрсдийн халааг бэлтгэхээр шийдсэн нь иймд хүргэжээ. Гэцэл Санжийг багш гэлэн Чоймчогт нь даалгаж, Лхас хотод хүргүүлж, шашны сургуульд оруулахаар болсон ажээ. Нөгөөтэйгүүр Чоймчиг гэлэн ч бас Лхас орох тусгай зорилготой байлаа.

Алшаагийн сүрлэг уулнаас буусан түргэн урсгалт голын хөвөөн дээр Алшаа Яаман гэдэг гаалийн хот байрлажээ. Арван дэлэм өндөр, зузаанаас зузаан шавар хэрэмний цаана сүм дуган, орд харш, мухлаг дэлгүүрүүд байрлажээ. Хэрэмнээс дотогш мөргөлчин, ядуус энгийн иргэдийн навсгар шавар тагз, жайжиг муруй хашаанууд нэвсийтэл шавааралдсан борчуулын хороолол байна. Андуу, Түвдийн орноо хүрэх замын хамгийн хөлтэй хотын нэг нь болох тул Алшаа Яаманд монголчууд бууж татвар төлж, хоол хүнс сэлбэж, наймаа хийдэг заншилтай болой. Учир нь Алшаагийн оршин суугчид ихэнхдээ өөлдүүд юм. Өөлдийн хошууг тэнд анх чин ван Лувсандорж гэгч зуу гаруй жилийн өмнө байгуулан захирчээ. Чин улсын хааны гүнжтэй сууж, хүргэн нь болсны учир хошуу захирах чин вангийн зэрэг хүртжээ. Түүнээс хойш Алшаагийн өөлд ноёд эзэн хааны хуурамч хүргэн болж, авсан эхнэр болгоныгоо хааны өргөмөл охин гэж зарладаг уламжлал тогтжээ.

- Миний таних нэг өөлд айл энд бий. Хоёулаа тэдний хашаанд хононо. Тэгээд маргааш цааш явна гэж Чоймчиг гэлэн шавьдаа хэлэхэд Санж дуугүй толгой дохив. Багшийнхаа үгэнд итгэж байлаа. Учир нь Чоймчиг гэлэн бага залуугаасаа Түвдэд олон дахин аялж явсан хүн тул зам болоод хүн танихдаа сайн ажээ. Чоймчиг гэлэн шавьдаа зам зуур тохиолдох сонин хачин юм болгоныг эрүү хамхихгүй ярьж өгдөг

ёсоороо,

- Энэ Алшаа Яаманд сарлагийн хялгасаар өрмөг таар нэхдэг юм. Өрмөгөөр шуудай, гөлөм хийдэг болохоор монгол хүн авах дуртай байдаг. Бас зах дээр нь сайхан хивс элбэг зардаг. Энэ Алшаагийн уулын наад бэлд Хатны голын хөвөөнд байдаг Яргай хотоос хивсчингүүд ирж энд панз хийдэг. Яагаав, манай Буянзалбирах хийдийн цогчин дуганы баганыг ороож бүрсэн хивс чинь энэ Яргай хотод захиж хийлгэсэн юм шүү гэж гэлэн Чоймчиг сонин болгон шавьдаа ярив. Нээрээ ч ярьж өгөөгүй бол мэдэхээргүй зүйл.

Буянзалбирах хийдийн цогчин дуганы гол дөрвөн баганыг эрээн хивсээр ороосныг банди байх цагаас Санж их л сонирхон гайхаж гараараа илж үздэгсэн. Нэг удаа тийнхүү сониучилж байгаад цорж ламд чихээ мушгиулснаа саналаа.

- Алшаагийн уул сүрд дарагдмаар гурван өндөр оргилтой. Тэр урагшаа харагдаж байгааг Баянсүмбэр уул гэдэг юм. Түүний баруун суганд Баруун хийд гэж алдартай газар бий хэмээн гэлэн Чоймчиг тайлбарлахад Санж гэцэл гайхаж,

- Эндхийн чинь уул ус ихэнхдээ монгол нэртэй юм гэж үү? гэхэд,

- Тэгэлгүй яахав. Манай өөлдүүдийн л нутаг юм. Дээр цагт энд хятад хүн их ховор байсан. Харин одоо л олшроод байгаа санагдах юм. Хятадууд ч бас эндхийн зарим уул усыг өөрийнхөөрөө нэрлээд байдаг. Энэ Алшаа Яаманг хятадууд Дэнянфу гээд л байдаг юм. Яргай хотыг ч гэсэн Нинсийфу гэдэг л дээ. Монгол нэр байхад тэр нэг фу му гээд л шулганаад юугаа хийнэ гэж Чоймчиг гэлэн дургүйцсэнээ,

- Баруун хийдийн тухай би ярьж байсан аа. Тэнд их нандин шүтээн бий. Зургаадугаар далай лам Цаньянжамцын бурхан байдаг. За чи бид хоёр түүгээр заавал очиж адис авах юм шүү гэж ярив.

Монгол нутгаас гарсан мөргөлчид ихэвчлэн энэхүү Алшаа Яаман гэж тэдний дунд алдаршсан хотод замын хүзүү нийлж, эндээс цааш хамтрах юм уу эсвэл хань бараандаа явцгааж заншжээ. Зам тоссон түвд, хятад түмэн хэлийн амьтад алс баруун хойноос мөргөлийн мөр хөөж ирдэг монголчуудыг олон арван жилийн турш ажиглан тандаж нарийн судалжээ. Тийнхүү тал бүрээс нь хавсран тоносоор байгаад Лхас ортол замдаа монголчууд бараг л нүцгэрээд очдог байжээ.

- Хүн бүрээс 100 юмуу хоёр зуун чох зоос гаалийн түрээсэнд авч байж л энэ Алшаа Яамны гараас мултарна шүү дээ, гэцэл минь! гэж багш нь амандаа бувтнаад зоостой хуурцгаа тэмтэрч үзэв. Санж гэцэл гайхаж, - Ганцхан хотод тийм их мөнгө төлөх хэрэг үү? гэв. Чоймчиг гэцэл хөхөөр инээмсэглээд намхан дуугаар, - Тэр юу ч биш. Хамгийн амархан аргаар олны нүдэн дээр дээрэмдүүлж байгаа нь тэр. Цаашлах тусам юу болно гээч? Ер нь тангадууд их танхай, дээрэмчин улс шүү. Мэдээтэй явах учиртай. Өнөө шөнө Алшаа хотод заавал айлын хашаа бараадаж хонохгүй бол хоёр зуун зоос байтугай хоёр гуталгүй ч болж мэднэ. Аваад цаддаггүй улс. Уул бүслүүргүй нэг дутуу гэдэг юм. Уул нь би чамд ийм муу юм ярих ёсгүй. Гэхдээ аян замын сайн муу алин ч чамд багш болно гэж би бодоод ярьж байна. Хүнд хэлж болдоггүй юм шүү дээ гэв.

Мөргөлчдийн цуваа их урт, бас тэгээд алаг эрээн байлаа. Бурхны орон үзэх гэсэн сониуч ноёд, хатдаас эхлээд шашны мяндаг цол эрэлхийлсэн лам нарыг хүртэл нүглээ наманчилж, хилэнцээ нимгэлэх гэсэн элдэв явдалтангаас эхлээд хол явж, юм үзэж, нүд тайлах гэсэн бадарчин, шавриачингууд, аяныхныг дагаж гэдсээ тэжээгч ядуу гуйлгачингууд, бусдад зарагдан явагч барлагууд, мөргөлчний дүрээр хувцасласан хулгайч дээрэмчин хүртэл тэр цуваанд нэгдэн нийлжээ.

Гэлэн Чоймчигийн баг зургаан хүнээс бүрдэж байлаа. Чоймчиг өөрөө тавь гаруй насны боловч хөнгөн шалмаг хүн, чухам ямар хэргээр явдгаа хэнд ч хэлээгүй. Хүмүүс бодохдоо гэцэл Санжийг Лхас зуу оруулж ном эрдмийн мөр хөөлгөхөөр яваа гэж үзсэн. Гол хэрэг зориг нь үнэхээр ч тийм бололтой. Гэцэл Санжийн тухайд бол илүү дутуу

бодол байсангүй. Лхас хотод шашны сургуульд орж их эрдэм сурч эцэг, эхийн захиа, лам багш нарынхаа найдварыг биелүүлж сайн лам болохыг зорьжээ. Багийн гурав дахь хүн нь Улиастайн шоронгоос оргосон нутгийн сайн эр Бөхмагнай байлаа. Түүнд онцгой хэрэг зориг байсангүй. Гагцхүү есөн эрүү шүүгдэхээс зайлж алс замд гарч эрх дураараа аялж юм үзэхийг хүсчээ. Бөхмагнай бол бяр чадал ихтэй, зоригтой сэргэлэн хүн тул Чоймчиг гэлэн түүнийг өөрийн галд дуртайяа нийлүүлж авчээ. Ер нь Утай Гүмбүм, Лхас зууг зорьсон монгол мөргөлчдийн гал, отог бүрийд нэг хоёр сайн эр явдаг байлаа. Тэр нь бие хамгаалагчийн үүрэгтэй билээ. Чоймчиг гэлэн Лхас хотод олон удаа аялсан туршлагатай хүн болохоороо зам зуурын бүхий л барцдыг мэддэг, түүнээс яаж мултарч гарахаа тооцоолдог ажээ. Бөхмагнай бас Чоймчиг гэлэнгийн холын садан юм.

Багийн дөрөв дэх тав дахь хүн нь эхнэр, нөхөр хоёр, нэр нь Хархүү, Отгон. Хоёул дунд зэргийн чинээлэг айлаас тасарч гэр бүл болсон. Гэвч эхнэр Отгонд үр заяахгүй уджээ. Лам багшаасаа асуухад Түвд орж Балдан Бэрээвэн буюу Төгсцогт үр жимсний овоолго гэдэг хийдэд мөргөл хийх хэрэгтэй гэж зөвлөв. Тэр ёсоор эхнэр нөхөр хоёр замд гарчээ.

Багийн зургаа дахь хүн нь бие муутай ядуу хар хүн. Хатингар цээжтэй, цоохор нүүртэй. Мөн л лам багшийнхаа сурган зааснаар Лхас зуу орж буян үйлдэж өвчнөөс салахыг зорьжээ. Нэр нь Өлзий гэнэ. Дунд хэрийн насны. Багадаа лам болох гэж сахил хүртэхэд нь багш лам нь,

- Хүзүүний шарх, хамуу, хатги, сэвх, үлд, хулгана яр, усны өвчин, ханиалга, хөхүүлэг, унах, хэнхэглэх гэхчилэн өвчин чамд буй буюу. Гагцхүү үнэнийг хэл гэж дөчөөд өвчний нэр тоочин асуухад нь Өлзий,

- Үлд, ханиалга, усны өвчин надад бий гээд үнэнээ хэлж орхижээ. Тэгтэл сахил хүртээх нь бүү хэл хийдийн гориломд оруулахгүйгээр түүнийг хөөн зайлуулсан билээ. Түүнээс хойш Өлзий сүм дуганд ч бараг орохгүй тэнүүчлэн явдаг болсон юм. Нас ахих тусам өвчин нь

нэмэгдэх тул бурхны орныг зорихоос аргагүй болсон юмсанжээ.

Ийм зургаан хүн нэг гал болж хамтран гараад одоо сар гаруй нэг замаар явж байгаа нь энэ.

"Дөрөө нийлмээр зураг төөрөгтэй улс хамт гарчээ, ашгүй. Аливаа гай түйтгэр тохиолдохгүй л явна, ум нам суухаа" гэж Чоймчиг гэлэн нэг бус удаа замын зуур амандаа шивнэжээ.

- Ярилцаж тохирсон ёсоороо Алшаа Яамны харчуулын хороонд бууж хоноглоод өглөө морин цагт нийлэн цааш хөдөлнө шүү! гэж цувааны даамал баргар царайт хүн нийтэд зарлан хашгирлаа.

Мөргөлчдийн цуваа хотын харчуулын хорооны зах руу орлоо. Тэгтэл өмнөөс нь худалдаачин, жуулчид, олз эрэгсэд, дууч эмс, сониуч хүүхдүүд бас золбин ноход тэргүүтэн угтлаа.

- Хэнд нь ч битгий нүүр өгөөрэй! Нүгэл болно гэж Чоймчиг гэлэн шавьдаа захилаа. Сарлагийн хялгасаар сүлжиж хийсэн хар өрмөгнүүдийг нэвсийтэл давхарлан үүрсэн наймаачид хоёр гурван талд нь харагдав.

- Өлмуг авуубаа! гэж хашгирахыг бодвол хятад худалдаачингууд бололтой. Бас монголоор хальтчуулаад байгаа.

Дулдуй мэт зэс савтай юм урт ишнээс нь барьж шаржигнуулан яваа хэдэн хүнийг гэцэл Санж олж харав.

- Дэн буудалд очих уу? гэж цэвэрхэн монгол хэлээр тэд асууна. Өөлдүүд бололтой. Тэгтэл бас алаг эрээн Туушингаар үс гэзгээ чимж, хоргой саагаар ханцуйгаа ороон, оёж гоёсон хүүхнүүд нударгаараа хамар амаа нэг таглаж, нэг больж, жуумалзан инээцгээж, нүдээ ирмэн мөргөлчдийн энд тэнд гарч үзэгдэв. Тэднээс хоёр залуувтархан нь ялгарч гэцэл Санжийг чиглэн, мурилзан мушилзан айсуй байхыг Чоймчиг гэлэн хармагц,

- Дууч эмс ирж явна! За чи тэдэн рүү харж ч болохгүй. Нүдээ аниад ямандагаас уншаад яваад бай. Замаа харах хэрэггүй. Би замчилна. Энэ нүгэл, чивэлт эмс рүү харахад л алдас болно гэж шивгэнэн тушаалаа.

Гэцэл Санж сахил хүртсэнээ бат санаж, тэр даруй хоёр нүдээ тас аниад амандаа ямандагаас уншиж эхэллээ.

- Замаас зайл, бузар эмс! гэж нэгэн удаа багш лам нь чанга зандрахыг залуу гэцэл сонсов. Нэлээд хугацаа өнгөрсний дараа хүүхнүүдийн “хи хи” гэж жиг жуг инээн дагалдах нь өнгөрөв бололтой. Тэдний харцыг Санж мэдэрч байлаа.

- Сохор банди байна, явъя гэж монголоор хүүхний нэг нь хэлэхийг бас залуу гэцэл сонслоо. Гэвч нүдээ нээсэнгүй.

Ямандаг уншиж дуусах яагаа ч үгүй байна. Хүүхнүүдийн дуу аажмаар замхрав. Алсад тас тас инээлдэх нь бүдэгхэн сонсогдлоо.

- Чивэлт эмсүүд ашгүй холдлоо. За нүдээ нээ нээ гэж багш ламыгаа дуугарахад Санж гэцэл сая л санаа амарч хорвоог харав. Намхан шавар хашааны хаалгаар орж байжээ.

Дөрвөлжин оройтой шавар тагзнуудтай том хашаанд тэд хоноглохоор буужээ. Өөлд авгайтай түвд хүн тэр хашааны эзэн юмсанж. Чоймчиг гэлэн шавийнхаа хамт цонхгүй шахам харанхуй хавчиг өрөөнд оров. Модон ханзан дээр сарлагийн савгаар нэхсэн өрмөгнүүд дэлгэн хаяжээ. Дэвсгэр хийдэг бололтой байлаа.

- Энд багш нь олон удаа хоног төөрүүлсэн юм. Хашаа нь бат хаалгатай найдвартай газар. Гэрийн эзэн ч сайн хүн байгаа юм. Тухтай унтаад маргааш эртлэн явна гэж гэлэн Чоймчиг шавьдаа яриад ханзан дээр шууд л ороо засч эхлэв.

Нэгэнт нар жаргасан болохоор байшин ч харуй бүрий байлаа. Ис

тортог болсон ханатай нэгэн өнцөгт нь гуутай бурхан зүүлттэй, түүний доорхи тавиур дээр ганц зул сүүмэлзэж байлаа.

- Ингэсгээд бидэнд буцалсан хар цай авчирч өгөх байх. Түүнд хатсан боорцог дэвтээж идээд унтъя. Өөр юм горьдолтгүй гэж гэлэн хэлэв.

Үнэхээр удсан ч үгүй, үүд чахран нээгдэж гуулин данхтай цай барьсаар ширэлдсэн хар үсээ сагсайлгасан, баргар царайтай авгай орж ирээд үг дуугарахгүйгээр түр зогссоноо данхыг орхиод буцаж эргэв. Өглөг нь үүгээр л дуусчээ.

Багш шавь хоёр боорцогтой хар цай ууж, ханаад унтахаар хажуулдав. Гэвч гэлэнгийн нойр тийм амархан хүрсэнгүй.

- Маргааш Баруун хийдээр дайрч зургаадугаар Далай ламын шарилаас адис аваад цааш явна. Урьд нь би түүнээс адис авдаггүй байсан юм. Одоо заавал адис авна гэж гэлэн аяархан шивнэн ярихад гэцэл гайхан эргэлзэж,

- Та урьд нь яагаад адис авдаггүй байсан, одоо юунд авах болов? гэж мөн л шивнэн асуулаа.

- Урьд би зургаадугаар Далай ламыг сахилаа сахиж чадалгүй алдас хийсэн гэж мэдэх болохоор нэг их сүжиглэдэггүй байлаа. Одоо бол бид хоёрын ялгаа үгүй болж... гэж гэлэн санаа алдав.

- Та сахилаа сахисаар л байгаа шүү дээ, багш минь! гэж гэцэл сануулав. Чоймчиг гэлэн хэсэг зуур юу ч хэлсэнгүй дуугүй хэвтсээр байхад Санж түүнийг нойрсож эхлэв гэж бодоод мөн өөрөө зүүрмэглэн байлаа. Тэгтэл багш нь аяар дуугаар,

- Зургаадугаар Далай лам Цанъянжамцтан их уян сэтгэлтэй хүн байсан юм гэдэг. Нэг бүсгүйтэй үерхэж байгаад тэр нь бие давхар болсон юм гэдэг. Тэгтэл хятад зурхайч нар тэр хүүхэд төрвөл замбуутивийн эзэн суух хувь ерөөлтэй юм байна гээд яриа

тараачихаж л дээ. Түүний нь Бээжинд сонсчихжээ. Тэгээд эзэн хаан зарлиг буулгаж Далай ламыг өөрий нь Бээжинд яаралтай дуудаж, тэр бүсгүйг нь даруйхан егүүтгэж хөнөөхийг тушаажээ.

Бээжин орохоор явж байтал одоо энэ бидний хоноглохоор ирсэн Алшаа Яаманд Далай ламын нэг дагуул нь өөд болчихож л дээ. Тэгээд Далай лам тэр үхсэн зарцдаа өөрийнхөө хувцас баринтгийг өмсүүлээд өөрөө түүний хувцсыг өмсч тэнүүлчин болоод Халх монгол руу оргочихсон юм гэдэг. Бас овоо сэхээ гаргасан хэрэг л дээ гэж Чоймчиг гэлэн ярьж байснаа дуугүй болов. Шавийгаа унтаад өгч гэж боджээ.

- Тэгээд яасан юм бэ, багш аа, гэж Санж гэцэл гэнэт асуусанд,

- Өө чи унтаагүй байна уу? гэж багш нь лавлаад цааш үргэлжлүүлэн,

- Халх монголоор баахан тэнүүчилж яваад буцаад Түвд газраа ирээд тэндээсээ Энэтхэг оронд одож олон оныг өнгөрөөсөн юм гэдэг. Тэгээд амь насанд нь ивээлтэй болсон энэ Алшаа нутагт эргэн ирж суурьшаад янз бүрийн ид шид үзүүлсэн юм гэдэг. Тэрний нь Алшаа вангийн эзэгтэй сэжиглэн тагнаад далай лам мөн гэж таньсан гэдэг. Тэр эзэгтэй Далай ламыг шүтдэг болсон юм билээ. Энэ Алшаа Яаманд Далай лам хэд хэдэн сүм дуган байгуулсан юмсанж... гэж өгүүлтэл шавь гэцэл нь нойрондоо дарагдаад үл мэдэг хурхирч эхлэв.

- Хөөрхий залуу юм болохоороо нойр ихтэй юм даа, зайлуул гэж гэлэн Чоймчиг амандаа бувтнаад буруу харан хэвтэв.

Чоймчиг гэлэнгийн нойр нь хүрэхгүй байлаа. Нүдний өмнүүр өөрий нь сэтгэлийг шаналгасан дүр зураг бүрэлзэн үзэгдэх шиг болж гэлэн удтал шаналан зовов.

Тавдугаар Далай ламын уянгын шүлэгний мөр бадгууд санаанд нь урган орж ирэхэд Чоймчиг гэлэн өөрийн эрхгүй нулимсаа бөмбөрүүлэн уярч хэвтлээ. Үзэсгэлэнт бүсгүй хүнд зориулан бичсэн

тэрхүү шүлгүүд хожим дуу болон олны дунд түгж билээ. Чоймчиг
гэлэн залуудаа тэрийг дуулах дуртайсан...

Гурав. Замын мянган барцаа

Өндөр тэнгэр үүлэн давхаргатай
Өвсөн дэлхий цасан давхаргатай
Өргөн далай мөсөн давхаргатай

Алтан Цоргын давааны ар шил дээрх овоог тойроод тангадууд гороо хийж байлаа. Овооны дөрвөн талд нь түүдэг гал асаажээ. Үсээ хэзээ ч тайрч самнадаггүй болохоор тэднийг малгайгүй байхад нь харахад айдас хүрмээр саглагар хар юмнууд, уулын хүйтэн салхи, хурц наранд бараантаж холцруутсан хөх царайд цагаан шүд, улбар өнгөтэй нүд нь зохилдохгүй зэрлэгээр гялалзан явах тул монголчууд жихүүцэн айдгаар барахгүй тангадууд гэхээсээ сэгсгэрүүд хэмээн нэрлэж сурчээ. Тэр нэгэн орой Алтан Цоргын даваа орчим сэгсгэрүүдийн хэд хэдэн бүлэг нуугдаж отлогод гараад зарим нь “агнуурт” явах бэлтгэл болгон гороо хийж байлаа.

“Монгол мөргөлчдийн цуваа ирж явна” гэдэг мэдээг тэд аль эрт авсан байжээ. Ер нь Монголоос мөргөлчид ирж явааг тангадууд ганцхан өдрийн дотор бараг бүх Түвд орон даяар зарлан мэдээлж, нэгнээсээ нэгэнд дамжуулж сурсан ажээ. Ийм мэдээг Алшаагийн чин вангийн нутгаас эхлээд Хөх нуур, Цайдамын уудам хөндий, уул нуруудаар, Зонхов бурхны төрсөн нутаг ариун Гүмбумд хүртэл түгээн тараахдаа алс холын гэнэн, аймтгай, шүтлэгтэй монголчуудыг түвдүүд хүндэтгэн угтах гэсэндээ биш харин өөр өөрсдийн арга хэрэгсэл, заль мэхээр тэднийг нүцгэлэн тонохын хүслээр тэгдэг байжээ.

Өнөөдөр Алтан Цоргын даваанд шивээлээд гороо хийж байгаа тангад дээрэмчдийн тэр бүлгийн санаархал бол монголоос ирж яваа мөргөлчдийг угтан тосч мулзлахад л чиглэсэн байхаас гарцаагүй.

- Тэнгэр Элс, Тэнгэр даваа гэхчилэн тэнгэрийн нэр барьсан газар ус

бидний замд олон дайралдана. Тэр бүхнийг давах, туулахад их хэцүү л дээ. Гэвч тэнгэрийн нэр барьсан тангад дээрэмчингүүдийн давааг давахад л тун бэрх. Тийм даваа алхам тутамд тохиолддог юм гэж тэр нэг өглөө Алшаа Яамны борчуулын хорооноос ачаалан хөдлөхдөө Чоймчиг гэлэн шавьдаа ярьжээ.

Одоо эдний цуваа Тэнгэр Элс, Тэнгэр даваа хоёрыг туулаад Хөх нуур орох замын хамгийн өндөр даваа болох Алтан Цоргыг өгсөж яваа ажээ.

Алтан Цоргын даваанд овоо тойрон гороо хийж байгаа тангадууд балбын дархчуулын хийцтэй болд хутгануудаа хуйнаас нь дутуу сугалаад түүдэг галаа тойрон паривалзан цовхорч бүжиглэх маягтай хэсэг зуур гүйлдэж байснаа шугпа гэдэг арцны үнэр гарахад сая зогтусаж цөмөөрөө хутгаа сугалан цэнхэр утаа нь залхуутайгаар эргэн хурган баагьж байгаа сангийн зүг шавааралдлаа. Сангийн утаан дээгүүр хутгаа нар зөв эргүүлэн ариутгал үйлдэцгээв. Тэгснээ болхи хийцтэй цахиур буу хоёрыг ахлагч нь бололтой хөхөөс хөх царайтай сэгсгэр үстэй эр хоёр мөрнөө зөрүүлэн зүүсэн байсныгаа мултлан авч сангийн утаан дээгүүр эргүүлэн ариутгаж эхлэв. Тэгтэл бодь гөрөөс буюу оронгын эврээр хийсэн бууны шийр нь доошоо санжганаад сангийн арцтай чулууг хажуулдуулж орхив. Тангадууд муу ёр гэж түүнийг цээрлэж ярвайснаа,

- Лхаржялоо! Лхаржялоо! гэж ахлагчийгаа чанга хашгирахад нь дууриаж “Лхаржялоо!” гэж олон чоно улих мэт хахир муухай дуугаар хашгиралдав.

“Тэнгэр бурхан дийллээ!” гэсэн энэ үг нь дээрэмчдийн сэтгэлийг сэргээдэг уухай нь юмсанжээ. Алтан Цоргын сүрлэг уулс дундуур “Лхаржялоо... оо...оо!” гэсэн дуу цуурайтан замхарлаа.

- Алтан Цоргын ууланд хүний дуу гарах шиг боллоо. Энд ч бид лавтай дээрэмдүүлэх байхаа гэж Чоймчиг гэлэн сэтгэл зовнин хэллээ.

- Бөхмагнай гуайг байхад гайгүй дээ, багштан минь! гэж гэцэл Санж багшийнхаа сэтгэлийг засахыг оролдов.

Алшаа нутгаас гарснаас хойш тохиолдсон хачин сонин явдлуудыг гэцэл Санж эргэж дурсан бодлоо.

Эхний зовлон Тэнгэр элсний хормойд очих үед тохиолдсон. Тэнгэр гэж өргөмжлөгдсөн их элсний баруун зах руу ойртож явтал бага шиг овоо босгосонтой тааралджээ. Мөргөлчид тэр овооны дэргэд саатан зогсоцгоож, сан, хүж унгатгаж зоос мөнгө, идээ хадаг тэргүүтнийг өргөж маань уншицгааж сунаж мөргөн хүндлэв. Гэцэл Санж сониучлан,

- Энэ юуны учиртай овоо вэ? гэж багшаасаа асуусанд Чоймчиг гэлэн,

- Хэдхэн жилийн өмнө үүгээр Банчин Богд Балданиш явж өнгөрөхдөө энэ овоог босгосон юм гэнэ лээ. Тэрнээс хойш мөргөчид тахидаг болжээ. Ер нь энэ Тэнгэр элсийг явган туулж гарсан хүн бол найман мянган хигээст их хөлгөн судар Жадамбыг уншсантай тэнцэх тийм буяны үйл бүтээсэн гэж тооцдог үгтэй юм. Залуудаа би нэг удаа явган туулсан юмдаг гэж ярьжээ.

Тэд яриандаа халж эхлээд байтал муухай хашгирах чимээ гарчээ. Лавлан харвал овооны дэргэд бөөн зодоон эхэлжээ. Мөргөлчид овоонд чох гэдэг хятад зоос, самбай хадаг өргөөд өнгөрөн явж байтал сондуулын цаанаас сангасваа үстэй гуйлгачин тангад гарч ирээд нөгөөх өргөлийг нь хуурайлан авчээ. Тэрнээс болж бөөн зодоон гарсан юмсанжээ. Ухаан жолоогүй зодолдоцгоож байгаад нэгнийхээ баруун шууг мулталж орхижээ.

“Банчин Богдын босгосон овооны дэргэд ийм муухай юм болох гэж дээ! Ядаж овоонд өргөсөн юмаа булаацалдаж зодоон үүсгэдэг нь ч юу билээ? Энэ муусайн тангадууд бурхны орны нэрийг ч бүр гутааж гүйцжээ” гэж гэлэн Чоймчиг аман дотроо ууртайяа бувтнаж байхыг Санж гэцэл тод сонсчээ.

Хар багаасаа сахил хүртсэн Санж гэгцэлд бол ийм юм үзээгүй болохоор аягүй муу ёрын явдал мэт санагдлаа. Урт цуваанд яваа хүмүүс ч бас ийм юм бодоцгоожээ.

- Удахгүй Алшаан чинвангийн нутгийн захад гарна. Иймд улаан эргийн хөшөө чулууны хавьд бууж уншлага хийж сан тавьцгаая гэж аяны даамал хар царайт эр хүмүүст сануулжээ. Тэд цөм зөвшөөрчээ. Тийнхүү Улаан эргийн хөшөө чулууны хавьд тэд бууцгааж, цуваанд яваа лам тоотой бүгд нь нийлэн цугларч сан тавьж баахан уншлага үйлдсэн ажээ.

- За гайгүй, Гүмбум ороод л нүгэл барцдаасаа ариусч болно биз! гэж гэлэн Чоймчиг шавьдаа хэлжээ.

Гүмбум гэсэн үгийг сонсмогц гэгцэл Санжийн сэтгэлд ямар нэгэн гайхамшигтай үлгэрийн орны тухай бодогдлоо. Бараг л мэдээ орсон цагаасаа хойш лам багш нараасаа ч гэсэн, эгэл жирийн хүмүүсээс ч гэсэн Утай, Гүмбумын тухай хачин гайхмаар яриа сонссоор өдийг хүрсэн билээ. Бурхан зонхов багш төрсөн нутаг болсон тэр ариун орныг үзнэ гэхээс гэгцлийн сэтгэл догдолж байсан юм.

- Гүмбум ортол бас хэд хэдэн даваа бий шүү. Тэнгэр даваа баС бий. Түүгээр л өлзийтэй шиг давж үзээсэй билээ гэж багш гэлэн нь ярьж байлаа.

Тэнгэр давааг давах гэж явтал Чоймчиг гэлэнгийн галынхнаас Отгон хүүхний толгой нь өвдөж, амьсгал нь давхцаж, амаа аналзан ойчжээ. Өндийн сэргээхээр оролдох зуур,

- Газрын сүрд дарагдаж байгаа нь энэ! гэж Чоймчиг гэлэн туршлагатай хүн тул мэдэмхийрлээ. Отгоны нөхөр Хархүү яах ч учраа олохгүй, тэвдэн сандчиж, нулимсаа дуслуулан Тэнгэр даваа өөд наманчлан залбирч, енгинэн уйлаад өвдөг сөхрөн суулаа.

Чоймчиг гэлэн тэр даруй манхгаа уудлан жижигхэн лонх гаргаж ирээд Отгоны ам руу ямар нэгэн юм тэр лонхноосоо цутгав.

- Усгүй хар архи байгаа юм! гэж Гэлэн, Отгоны нөхрийг тайтгаруулаад,

- Одоо чи наадхынхаа тохойгий нь ил гаргаад орхиоч гэв. Хархүү сандчин тэвдэн эхнэрийнхээ баруун гарыг сугалдаргалан тохойг нь ил гаргав.

Чоймчиг гэлэн манхагныхаа уутнаас бяцхан чичлүүр гаргаж ирээд Отгоны тохойн дотор талыг гараар тэмтчиж байснаа гэв гэнэт чичлүүрээр огцом хатгажээ. Отгон хүүхний цагаан тохойноос ягаан цус хол олгойдон гарав. Хүмүүс цочин балмагджээ.

- Зүгээр, зүгээр. Битгий ай. Газрын сүрд дарагдсан хүнийг ингэж хануурдахад зүгээр болдог юм гэж Чоймчиг гэлэн тайвшрууллаа. Үнэхээр хэдэн мөчийн дараа Отгоны бие сайжирч өндийн суужээ.

- Одоо зүгээр ээ! Явцгаая гэж Чоймчиг гэлэн хэлэхэд цөмөөрөө босч аянаа үргэлжлүүлжээ. Үнэхээр Отгоны бие Тэнгэр давааг давтал тэсч өнгөрөв.

- Тэнгэр даваанд ингэж байгаа юм. Хөх тоонын даваанд яанадаа гэж гэлэн амандаа шивнэхийг Санж гэцэл сонссон тул Отгоны төлөө санаа зовж байлаа. “Хөх тоонын даваа гэж бас энэнээс өндөр даваа байдаг байх нь? Хөөрхий энэ Отгон яана даа” гэж Санж гэцэл бодлоо. Гэвч юм бүхэнд эрдэмтэй гэлэн багшдаа гэцэл найдаж санаагаа амрааж билээ.

Тэнгэр даваанаас нэлээд яваад Андунуу Түвдийн нутагт оржээ. Гэлэн Чоймчиг сэтгэл ихээр хөддөн,

- Удахгүй Гүмбумын бараа харагдана. Бурхан багш Зонховын нандин шүтээний газар! гэж шавьдаа ярив.

Буман мянган бурхдын дүртэй жаргалангийн ертөнц гэж Гүмбум Жамбалин гэдэг тэр хийдийг нэрлэдэг, зандан модон дээр нь номын үсэг өөрөө тодрон ургадаг, түүний навчисуудад нь хоншим бодьсад, Манжшир, Махагал зэрэг бурхдын дүр үзэгддэг гэж Санж гэгцэл бага наснаасаа олонтаа сонсчээ.

Одоо тэр домогт орныг нүдээр үзэхээр болж байгаадаа залуу гэгцлийн сэтгэл их хөөрчээ. Хойш чиглэн гарсан гүн жалгын өндөр мөрөгцөг дээр Гүмбум буюу Буман дүрт гэдэг тэр хийд байрлажээ. Буддын шашныг түвд маягаар шинэчлэгч их лам Зонхов энэ сууринд төрж өссөн юмсанжээ. Зэрлэг сонгиноор бүрхэгдсэн гүн жалганы хөвөөгөөр байрласан тэр сууринд Зонховын мэндэлж хүйгий нь булсан газар гурав дахь жилийнхээ нүүрэн дээр зандан мод ургаж, тэрний нь навч, зодгон дээр Арслан дуут буюу хоншим бодьсад бурхны дүр тодрон гарч үзэгдсэн гэдэг домогтой ажээ.

- Тэр алтан оройтой Сэрдэнчөнмо суварга харагдаж байна. Наманчлан залбир! гэж гэнэт багшийгаа хэлэхэд гэгцэл Санж,

- Ай яасан гоё гялалзаж харагдах юм бэ? Сэрдэнчөнмо чинь их алтан мод гэсэн үг байх аа, багш аа? гэв.

- Тийм. Зонхов багшийн хүй булсан газраас ургасан зандан модыг тэгж нэрлэдэг юм. Одоо тэр модыг Сэрдэнчөнмо суварган дотор оруулан барьсан. Дээр цагт ил байсан юм гэдэг. За хоёулаа тэр суварганд зул өргөөд цаашаа явна гэж багш нь хэлжээ. Мөргөлчдийн цуваа Гүмбум орж шууд л Сэрдэнчөнмо суварга руу чиглэхийг хүсчээ. Гэвч ариун орны нандин шүтээнд унаатай ойртуулсангүй. Гүмбумын хаяанд буудаллаад мөргөлчид явгалж хотын төв оржээ.

Хоёр давхар алтадсан оройтой, ногоон паалантай туйпуугаар уран гоё барьсан жижигхэн дуган дотор төвлөрүүлэн босгосон давтамал мөнгөн чимэгтэй, шар торгон өнгөлөгтэй суваргын өмнө хэдэн зуун зул ярайж байлаа. Суваргын оройн бумбан дотор Зонхов бурхны алтан

хөргийг байрлуулжээ. Суваргын суурь талаар Гүмбумын үе улирсан олон ихэс лам нарын баримал шуумал дүрсүүд жижиг суварга, цацнууд эгнэн байна.

Суваргын эгц өмнөх сэнтий мэт ширээнээ нэг алт, хоёр мөнгө, нэг чулуун цөгцтэй том зул, гуулин цөгцтэй жижиг зулнууд тэрнээс цааш мөргөлчдийн тавьсан тоо томшгүй олон зул байна.

Гэлэн Чоймчиг тус бүр нь таван чох зоосны үнэтэй жижигхэн зул гурвыг хажуугийн мухлагаас худалдан авч ирээд нэгийг гэцэл Санжид өгч нөгөө хоёрыг өөрөө асааж суваргын өмнө өргөв.

- За одоо санаа амарлаа! гэж Чоймчиг гэлэн шавийнхаа чихэнд шивэгнээд гарахаар үүд зүглэв. “Багш ламтан Баруун хийдэд Далай лам Зургаадугаарын шарилд зул өргөхдөө “За одоо санаа амарлаа!” гэж байсан. Энд бас л тэгж хэлэх юм. Санаа нь нэг л юманд зовоод яваа юм уу даа? Юунд зовдог билээ?. Төрөл садан юу ч үгүй, эр ганц хүн шүү дээ. Эсвэл ер нь тэгж хэлдэг заншилтай юм уу? гэж гэцэл бодов? Багшийгаа огт барцадгүй хүн гэж тэр итгэдэг юм.

Гүмбүмээс гарч явахдаа лам багш нь гэцэл Санжид хандаж,

- Барцад нэлээд нимгэрсэн байх аа. Гэхдээ одоо Гансаа Равдангийн сэгсгэр толгойтонгуудаас зүгээр салахгүй ээ гэжээ.

“Гансаа Равдангийн сэгсгэр толгойтонгууд гэж юу хэлж байгаа юм болоо? Номонд огт гардаггүй, багшийн ер заагаагүй юм байх чив?” гэж гэцэл бодоод

- Тэр юун улс юм бэ, багшаа? гэв.

- Аа энэ Хөх нуурын монголчууд дотор нэрд гарсан хүн байгаа юм. Гансаа лам Равдан гэж Гүмбумд багадаа шавилан сууж байсан юм. Тэнхээ чадалтай, зориг сөс ихтэйдээ эрдээд хийдийг огоорон орхиж, дээрэмчдийн сүрэгт нийлээд зэгц тэргүүн нь болж сүүлдээ үүгээр

өнгөрч Лхас зуу руу явдаг мөргөлчдийг тонодогоороо зард гарсан. Тээр жил үүгээр манай Богд гэгээн заларч Лхас ороод буцаж явж л дээ. Тэгтэл Гансаа Равдангийн дээрэмчид Богдын жингийн цувааг бүсэлж аваад олз нэхсэн юм гэдэг. Цөөхөн тооны бие хамгаалагчтай болохоороо Богд гэгээнтэн яаж ч чадалгүй баахан бэлэг сэлт өгөөд үүнээс хойш үүгээр өнгөрөх монгол хүн бүрийг өршөөлдөө авагтун гэж Гансаа Равданд лүндэн зарлиг буулгаж байж салжээ. Тэрнийг Гансаа Равдан ухасхийн ашиглаж эзэмшил нутаг дээгүүрээ өнгөрөх монгол хүн бүрээс хоёр цэн мөнгө татварладаг болчихсон юм гэнэлээ. Тэгж их баяжиж байгаа хүн. Ракуу гол дээр тэр татвараа авдаг юм. Гансаа Равдан харин үгэндээ хүрч өөрийнхөө нутаг дээгүүр өнгөрөх үед нь монгол хүнийг өөрөөсөө бусад дээрэмчдийн гар хүргэдэггүй юм гэнэлээ. Гансаа гүнийхэн чинь ихэнх нь тангаджисан монголчууд буюу жахорууд байдаг. Эдний сэгсгэр толгойтонгуудад монгол хүн хоёр цэн мөнгөө илэрхий идүүлээд л явдаг нь ёс болсон хэрэг ээ гэж Чоймчиг гэлэн шавьдаа ярьжээ. Санж гэцэл,

- Тэгвэл бид Хөх нуур өнгөртөл юунаас ч айхгүй явж болох нь ээ? гэж асуухад,

- Аа тэгж битгий бод. Цайдамын таван хошуу, Хүхээт бэйл, Хүрлэг бэйл, Баруун, Зүүн засаг, Тайж нар уу? Энд ер нь тун айхтар улс суудаг газар. Алтан Цоргын даваанд их шивээлдэг юм гэж Чоймчиг гэлэн хариулаад гараа саравчлан шингэх наран зүг харж "Алтан Цорго ч тэр л байна" гэж амандаа шивнэсэн билээ. Одоо тэгээд дээрэмчин шивээлсэн Алтан Цорго ууландаа хүрээд иржээ. Арсгар хадтай сүрлэг сайхан уул ажээ.

Гэлэн Чоймчигийн баг мөргөлчдийн цувааны дунд хэрд явж байлаа. Аливаад сэжиглэсэн янзгүй тайван байв.

- Лхаржялоо! гэсэн зэрлэг дуу гэнэт цууриатаж, буу дуугарлаа. Мөргөлчид айн сандарч бужигналдав.

- Битгий сандарцгаа. Сэгсгэр дээрэмчид довтолж байна. Бяр чадалтай

нь тэдэнтэй үзэлц. Хүүхэд хөгшид унаанаасаа бууж эргэнд хоргод!
гэж жингийн цувааны ахлагч чанга дуунаар тушаалаа.

Буу, шийдэм барьсан дээрэмчид үнэхээр дайран орж ирлээ. Нэг хэсэг нь цувааны эх өөд, нэг хэсэг нь дундуурх, нөгөө нь сүүл рүү дайрцгаав. Дундуур дайрагсад Чоймчиг гэлэнгийн галынханд таарчээ. Чоймчиг гэлэн рүү сангалдай үстэй залуу дээрэмчин ухасхийн дайрахад хашир гэлэн өмнөөс нь урьдаас бэлтгэн авч явсан нунтаг азуйгаа цацаж орхисонд нүд рүү нь орж тэр юу ч үзэхгүй, нүдээ дараад зогтусав. Бас нэг саглагар хар хүн Бөхмагнай өөд дайрахад түүний цахиур бууны аман дээрээс мань эр атгаж аваад угз татан алдуулав. Дээрэмчин буугаа алдаад өөрөө газар шургаж унаснаа өндийн босч ирэхэд нь Бөхмагнай түүнийг цахиур буугаар нь эргүүлэн цохиход тар нярхийх дуун гарч буу нь хуйгаараа хугаран ойчлоо. Буугаа хугарахыг мэдмэгц дээрэмчин толгойгоо даран зугтаав. Гэтэл өөр нэг сэгсгэр хар амьтан Бөхмагнайн зүг уулгалан дайрчээ. Түүний гарт аймаар балт сүх шиг юм харагдахад Отгон айж муухай чарлав. Бөхмагнай тэр дээрэмчингийн гарыг хумхин барьж толгой дээрээ бүх биеэр нь өргөөд сарвалзуулан шидсэнд тэрээр том үхэр чулуу мөргөн унаж тэрийн хэвтлээ. Тэрнээс цаахна байсан бас нэг дээрэмчин улайран дайрахад Бөхмагнай түүнийг биедээ хүргэлгүй шүүрэн барьж аваад түүгээр бусдыг нь дүүгүүрдэн эргүүллээ. Хэд хэдэн дээрэмчин тэр махан дүүгүүрт цохигдон хөсөр ойчлоо. Дүүгүүр болсон эрийн өрөөсөн гутал сугарч жалга руу хийслээ.

Дүүгүүрдүүлж байгаа дээрэмчин муухай дуугаар чарлаж ямар нэгэн юм хашгирчээ. “Зугтаацгаа, намайг алах нь” гэж хэлж байгааг гэцэл Санж бүрэг бараг ойлгов. Тэр эгшинд дээрэмчид зугтааж уулын жалга руу тоос манаруулан чулуу өнхрүүлэн, ёолон гаслах дуугаа хадуулсаар далд орцгоолоо.

Дээрэмчдийн гар хөлд хохирсон хүнгүй. Гагцхүү цувааны даамлын шанаа нь халц цохиулж, бас нэг ламын эрх тасартлаа зулгаалгуулж, Отгон хүүхэн сахиусаа гээснээр энэ удаа тэд аврагджээ. Цөмөөрөө

үнгэлцгээ хагартал айжээ.

Бөхмагнай байгаагүй бол тэр цувааныхан нүцгэртлээ тонуулах нь мэдээж болжээ. Цөмөөрөө л Бөхмагнайд баярлаж байлаа.

- Намайгаа сайн л цатгаж байвал би энэ сэгсгэр тангуудад та нарыг дээрэлхүүлэхгүй байхыг хичээнэ гэж Бөхмагнай амлажээ.

Алтан Цоргын давааг давахад тэртээ хөндийг дүүрэн цэлэлзэн хөхөлзөгч том нуурын барааг тэд харлаа. Дунд нь нэг арал бүртийн харагдаж байлаа.

- Багшийн ярьдаг арал тэр үү? гэж гэцэл Санж саяхан болсон зодооныг мартахын тулд гэлэн Чоймчигоос асуужээ.

- Мөн, мөн. Хөх нуур дундах арал дээр тав зургаан ламтай жижигхэн сүм байдаг юм. Тэд нар өвөл мөс хөлдөх үед идэш хүнсээ аваад зунжингаа даяанчлан сууцгаадаг юм. Гадны саад түйтгэргүй зүгээр байдаг биз дээ гэж Чоймчиг гэлэн хэлэв.

Нэгэнт орой болсон тул мөргөлчид Хөх нуураас холгүйхэн газар хоноглов. Нуурын чийг ханхалж аятайхан байлаа.

- Одоо олон даваа бий юу? гэж Санж гэцэл шөнө орондоо ороод байхдаа асуужээ. Багш нь яарамгүй зугуун ярина.

- Олон бий. Тэр дундаас Хөх тоонын даваа л яггүй дээ. Осолтой даваа. За тэрүүгээр эсэн мэнд давчихвал ч Лхас зууд орлоо гэсэн үгээ гэж гэлэн хэлэв. Тэр шөнө аливаа зовлонгүй тайван өнгөрчээ. Ер нь Хөх тоонын даваа хүртэл тэд алзахгүй сайхан аялав. Найчжийн голын хөвөөн дээр хэдэн хар банаг байхад мөргөлчдийн цуваа ирж буулаа. Чоймчиг гэлэн шавьдаа Түвд орох замд тохиолдох юм болгоны учрыг ярьж өгнө гэж амласан ёсоороо учиртай бүхнийг учирлан ярьж өгдөг байв. Тэр л заншлаараа,

- Энэ банагийн гадаа хэдэн тэмээгээ орхихоос аргагүй. Мориор явахгүй бол Хөх тоонын давааг тэмээ давдаггүй юм гэв.

Маргааш нь мөргөлчид Хөх тоонын давааг давахаар эртлэн явцгаалаа. Нэг талаас хадтай уул, нөгөө талаас асар өндөр цавчим эрэг дундуур Найчжийн гол шуугин урсч байлаа. Гол тэртээ дор гүн ангалд шуугьж байхад мөргөлчдийн зам хадан хясааны нарийхан хэжим дээгүүр цувран алхам алхмаар урагшилж болгоомжтой явна. Цөмөөрөө л газрын сүрд дарагдан амандаа маань, мэгзэм уншицгааж байлаа. Гол руу харах хэрэггүй гэсэн ёсоор доошоо өнгийхийг хэн ч бодохгүй байв. Ачаатай морь дөнгөж багтаж байх тул тэр нарийхан хянга дээрээс халин хийсэхийн тулд өчүүхэн төдий эвгүй хөдлөхөд л хангалттай ажээ. Хүн бүр зүрх түгшиж болгоомжилж байлаа. Гэтэл дошгивтор зантай морь унаж явсан Хархүү гэнэт чанга найтаалгаж орхив. Морь нь түүнээс цочиж дальдгас хиймэгц өндөр халилын энгэрээс хийсэн нисэж ногоорон эргэлдэх голд морь хүн хоёр салж палхийн унаж далд орлоо. Дэргэд нь явсан Отгон хүүхэн айн цочиж ухасхийхэд Чоймчиг гэлэн түүний цулбуураас угз татан зогсоолоо. Отгон цурхиран уйлж, нөхрийнхөө хойноос тэмүүлэхэд Чоймчиг гэлэн ихээхэн тэвдэж,

- Биеэ барь! Биеэ барь! Одоо нэгэнт өнгөрсөн. Хойноос нь өчүүхэн хөдөлбөл бас л өнгөрнө. Өнгөрснийг тэнд нь орхиж өөрсдийгөө бодъё! гэж хүүхнийг аргадан цулбуурнаас нь хөтлөн болгоомжлов. Отгон нөхрийн хойноос дэгэлзэн мориноос ойччихмоор болоход Чоймчиг гэлэн,

- Санжаа, хүү минь, тэр нэг тохойрсон хонгорт зогсоод орхи. Тэгээд эмээлийнхээ араар сууж, урдуураа энэ Отгоныг авч сундалдаад энэ давааг давъя. Чи арай бие хөнгөнтэй байх. Морь чинь ч номхон юм. Эс тэгвэл энэ хөөрхий сүйд болж мэднэ. Талийгчийн хойноос тэмүүлээд байна гэв. Санж тэр ёсоор эмээлийн хойгуур суугаад хүлээж байтал Чоймчиг гэлэн Отгон хүүхнийг эмээл дээрээс нь тэврэн өргөж Санжийн урдуур суулгав.

- Наадхыгаа сайн тэврээд болгоомжтой яваарай. Ойчивзой! гэж багш нь тушаалаа. Эхэр татан уйлж, ухаангүй шахам яваа тэр хүүхнийг Санж морин дээрээ сундлаад бүсэлхийгээр нь тэвэрч даваа өөд мацууллаа. Дал мөр нь чичрэн, сүлжмэл хар үснээс нь гүргэмийн үнэр ханхалж байлаа. Хүүхэн тэврээд ийнхүү явж байх нь муугүй ч юм шиг түүнд бодогдов. Нүгэл байгаа даа!

Дөрөв. Бурхны хотын үймээн дунд

Алгандаа хөхтэй байдаг арслан нэг хачин
Амаа байтал шилээрээ дуугардаг голио нэг хачин
Ам нь хэнхдэгэндээ байдаг заан нэг хачин

Тэр өглөө мөргөлчид эрт босжээ. Уул нь шөнөдөө оройтож ирсэн боловч Бурхны хотод анхныхаа өглөө тайван унтаж аажим босох дуртай хүн үгүй байжээ. Засагт хаан аймгаас гарсан мөргөлчид хэд хэдэн гал болон хуваагдаад Лхас хотын Бэрээвэн хийдийн Халх Мицаан гэдэг монголчуудын хэргийг захиран шийтгэх газрын хуваарилснаар зарим нь айлуудад, зарим нь нийтийн дян буюу тайны газарт бууцгаажээ. Харин Чоймчиг гэлэн бол Бэрээвэн хийдэд багадаа ном үзэж, хожим олон дахин ирж байсан болохоор танил ихтэй, бас ч нэг зиндааныхан элбэгтэй байлаа. Тэгээд өөрийнхөө дагуулж ирсэн нэг галын хүмүүсийг эндээс буцтал нь өөрөө даана гэж амласан ёсоороо орогнох газар олж өгчээ. Тэр нь хоёр өрөөтэй намхан шавар тагз байлаа. Хуучин танилы нь хашаанд байдаг тэр тагзыг хожим шавь Санж гэцэлдээ худалдаж авч өгөх санаатай юмсанжээ.

Тагзанд өөр хүнгүй байлаа. Нэг өрөө нь утаа исэнд харлаж муухай үнэртэй болжээ. Нөгөө нь түүнээсээ арай том бөгөөд хоймор талдаа бурхантай, ханзан ортой, орон дээрээ буйдантай (дэр) арай тохилог юм.

- Симханд (унтлагын өрөө) шавь бид хоёр орно. Та нар түр зуурын улс рунханд (гал зуух) л сууж байхаас биш дээ гэж Чоймчиг гэлэнг хэлэхэд,

- Өө тэгье тэгье. Толгой хоргодох л юм олдож байвал хаана ч хамаа алга гэж Өлзий биеийн шаналгаандаа ярвайн хэлэв. Бусад нь түүний үгийг зөвшөөрчээ.

- Сарлагийн манхнаас өөр юм алга! гэж гаднаас нэг лам орж ирээд хэлэхэд,

- Яахав, яахав. Аваад ир! гэж Чоймчиг гэлэн хэлэв. Энэ лам тэднийг өчигдөр Лхас хотын захад угтан тосч очжээ. Монгол газраас мөргөлчид ирэхэд Бэрээвэн хийдийн Халх Мицан гэдгээс тусгай хүн явуулан угтаж авдаг байжээ. Бас Лхас хот руу морь тэмээ оруулдаггүй хуультай тул замд нь угтсан түвд панзчингууд шууд үнэ хаялцан худалдан авч оронд нь сарлаг хөлслөн өгдөг байжээ. Энэ тухай багш лам нь урьдаас тайлбарлаж хэлээгүй бол гайхмаар юм болох байлаа. Мөргөлчдийг янз бүрийн хувцастай, хутга, буу хүртэл зүүж, баруун гарыг сугалдаргалан ханцуйг унжуулсан зоримог, догшин царайтай тангад, түвд хүмүүс угтан ирж шууд л морины нь жолоо тэмээний нь бурантгаас атган барьж,

- Жушээ, Жушээ! гэж хашгиралдсан билээ. “Бурхан мэдэж байгаа” гэсэн үг тул гэцэл Санж гайхаж багшаасаа,

- Юуг бурхан мэднэ гээд байгаа юм бэ? гэж асуувал Чоймчиг гэлэн,

- Үнэ хаялцаж морь мал худалдан авах гэж байгаа юм. Тэгээд “Бурхан мэднэ, би нүгэл хийхгүй” гэж тангараглаж байгаа нь тэр л дээ. Бурхны нэр их барьдаг улс гэв.

Мөргөлчдийн унааг худалдаачид үнэ хаялцан хувааж аваад юу ч үгүй явгалжээ. Гагцхүү хашир зарим нэг нь урьдаас хэл явуулж тохиролцсон ёсоороо нутагшин сууж байгаа монголчуудад морь унаагаа тушаагаад, оронд нь сарлаг авч морио юүлэв. Гэтэл Бөхмагнай морио хэнд ч өгөх хүнгүй, бас худалдах дургүй тул золтой л зодоон гаргачихсангүй. Гэлэн Чоймчиг угтаж ирсэн ламтайгаа ярилцаж тохироод Бөхмагнайн морийг нэг хүнд маллан адгуулж байхаар өгчээ.

Мөргөлчдийн энэ цувааны сүүлчийн хэсэг нь Хөх тоонын даваагаар

давахаас зүрхшээж буцаж хэсэг яваад Бурхан буудайн даваагаар давсан тул хэдэн тэмээтэй иржээ. Гэвч дээрэмчинд тонуулж бараг нүцгэн ирцгээжээ. “Дээрэмчнээс айлгүй л тэр замаар явдаг байж. Тэгвэл эдийн хохирол үзэхээс хүний гарзгүй байх сан” гэж Чоймчиг гэлэн харамсан бодож Хөх тоонын давааны ханан халилаас хөл алдаж Найчжуу мөрөнд үйж үрэгдсэн Хархүүгийн тухай дурсан гасалж,

- Энэ хөөрхий бүсгүй Отгоныг санаагий нь засч, бурхны оронд юу үзэх гэсний нь үзүүлээд буцаая гэж шавьдаа хэлсэн байжээ. Энэ үгийг санасаар бурхны хотын анхны өглөөтэй Санж гэцэл золгов.

- Сарлагийн махнаас өөр юм алга! гэж өглөө бас л дахиад нөгөө лам зэс таваг дээр хэдэн хэрчим хорчийсон хар мах тавьсаар орж ирлээ.

Хөгшин сарлагийн мах байсан тул шүдэнд байтугай хутганд даагдахгүй байв. Борц маягтай болж урь иджээ.

- За би ч бухширэг зулгаасан хөгшин сарлаг шиг юм болох нь ээ. Энүүн дорвол замбай зуурая гэж гэлэн Чоймчиг шоглох аястай хэлэхэд цөмөөрөө инээлдэв. Юу гэвэл: Түвдийн өндөр уулсын энгэр хормойд ихээхэн хатуу иштэй ургамал ургадаг тул түүнийг бухширэг буюу бухширэг гэдэг юм. Бухширгийг хөгшин сарлаг даахгүй тул идэх гэж их сандардаг ажээ. Хөх тоонын даваанд тийм нэг хөгшин сарлагтай тэд дайралдсан билээ. Өлсгөлөн сарлаг, даахгүй ширэг хоёр уулзаж их л хөгтэй юм болж байсныг гэлэн ийнхүү дурсан санажээ.

- Бухширэг зулгаасан сарлаг гэхээс өчигдөр биднийг мөн баллах шахав аа? Би угаасаа сарлаг унах дургүй.

Гэтэл бас дүүгүүрдүүлэхэд мөн л аягүй байдаг шүү гэж Бөхмагнай ярив.

- Харин тийм ээ! гэж Өлзий залбирав.

Өчигдөр тэдний унаа унашийг үнэ хаялцан хувааж аваад түвдүүд

оронд нь сэлмэн эвэртэй сарлагнуудад ачаагий нь ачиж, өөрсдий нь суулгаад, дөрийг нь сарлагийнхаа толгойд эвхэж сул тавиад хамтруулан хөөж Лхас оруулжээ. Тэгэхдээ муухай хашгиралдан, суран дүүгүүр толгой дээгүүрээ эргүүлж, гонзгой хөх чулуугаар галзуурсан мэт дүүгүүрдэн, сарлагууд ч түүнээс айж ухаан жолоогүй гүйлдэв.

Дүүгүүрийн чулуу нь аймшигтай муухай улин шунгиналдаж, монголчуудын унаж яваа сарлагийн шарнуудын зүг бороо мөндөр шиг олноор эрчлэн ирж монголчууд түүнээс айж уулга алдан толгойгоо гараар дарцгааж байлаа.

- Битгий айцгаа! Түвдүүдийн ганц чаддаг юм нь дүүгүүр байдаг. Сарлагийнхаа эврийг ямар ч мэргэн буучаас дутахгүй ононо. Хүний биед огт хүргэхгүй. Битгий сандар! Тайван явцгаа! гэж гэлэн Чоймчиг тэдэнд захив.

Үнэхээр Түвдүүд дүүгүүрдэхдээ мэргэн ажээ. Дүүгүүрийн чулуу нь өөр юуг ч биш гагцхүү сарлагийн эвэр дээр мэргэн тусч байлаа. Эвэр дээр нь дүүгүүрийн чулуу буухад сарлагийн шарнууд сүнс сүүдэргүй айж хар хурдаараа гүйж байлаа. Ингэж тэд дүүгүүрийн чулуу, сарлагийн шарын нуруунд, түвдүүдийн хашгиралдаан дунд Бурхны орон Лхас зуугийн гориллом руу орж ирсэн билээ.

- За явцгаая. Юуны урьд Их зуу орцгооё. Тэгээд бусад ариун шүтээнүүдийг өдөр дараалан үзнэ. Цөмийг үзэхэд их цаг хэрэгтэй. Гол гол шүтээндээ эхлээд мөргөцгөө! гэж Чоймчиг гэлэн сануулав.

Мөргөлчид хамаг байдгаараа гоёжээ.

- Хамт явъя. Шавилан суучихвал зав олдохгүй. Эдэнтэй хамт явж, би чамд энэ газрын байдлыг мэдүүлье гэж гэлэн Чоймчиг шавь Санждаа хэллээ.

...Униар манан, тоосонд умбасан Лхас хотын гудамжинд монгол

мөргөлчид гарлаа. Уйчүү буюу дунд гол урдуур туналзан урсч, Марбори толгой.дээр Будаалын аварга ордон тэнгэр баганадсан суварга мэт зосон өнгөөр алаглан алтан ганжир, жанцангаа гялалзуулан сүндэрлэж харагдлаа.

Их зуу хүртэл мөргөлчид явган явлаа. Гудамжаар хачин янзын хувцастай тангад, түвд, монгол, балба, жагар, таван хэлийн хүн амьтан нааш цааш хөлхөж байлаа. Үсээ толгойн орой дээрээ гозойлгон овоолж, алт мөнгөн чимэгтэй гуунуудаар хашиж гоёсон дээдсүүд, үсээ сүлжиж ар нуруу руу унжуулсан чинээлэг хүмүүс, үсээ огт үл самнах саглагар сангасваа мэт ядуус өмнө хойноо орж нааш цааш явна. Улаан цацаг эргэн тойронд нь унжуулж хийсэн дугуй хүрээтэй орой нь цагаан бөгөөд дундаа улаан загалмай чимэгтэй нугалуур шиг хачин малгай өмссөн барлагууд олноор явна. Гэм л хийвэл толгойгүй болно гэсний тэмдэг болгож тийм малгайг ноёдууд зарц нартаа өмсүүлдэг ажээ. Хүзүүгээ тас цавчуулаад цус нь доош гоожиж байгааг улаан загалмай тэмдэг, доошоо унжсан улаан цацаг нь үг дуугүй өгүүлж байгаагийн билэгдэл болсон тэр малгайг гэлэн Чоймчиг тайлбарлаж өгөхөд Бөхмагнай маш их гайхжээ.

Хүүхнүүд баруун бугуйндаа дунгаар чимэглэсэн цул мөнгөн бугуйвч зүүсэн нь олонхи байх бөгөөд нүүр нь бараг цөмөөрөө ижил хар хүрэн өнгөтэй байлаа.

- Бугуйвч нь багадчихсан мөртөө амгүй шиг байх юм. Бас тэгээд цөмөөрөө хар хүрэн элэг шиг зүс царайтай улс юмаа гэж Отгон хүүхэн гэнэт гэлэнгээс асуухад түүний сэтгэлийг юугаар засах тухай бодож явсан Чоймчиг, - Түвд хүүхэн заавал битүү бугуйвч зүүх учиртай. Арваад настай байхад нь охид цул бугуйвч зүүж өгдөг. Насанд хүрэх үедээ тэр бугуйвчийг дүүртэл мяраалж салгаж авах аргагүй болдог юм. Түвд хүүхнүүд нүүрээ хар цайны өтгөн хандаар буддаг журамтай. Гудманд нүүрийн түрхлэггүй гарч явах нь муу явдалтны шинж гэж ярив. Отгон түүнд их гайхлаа.

Тэд Их зуугийн хэрэмний гол хаалган дээр ирэв. Хаалганы хачивч,

ханын дагуу сууж байсан ядуу түвдүүд бараг зэрэг шахам ухасхийн босоод хэлээ гарган, хоёр гарынхаа сарвууг зангидан зөвхөн эрхий хуруунуудаа гозойлгож зогсоцгоогоод

- Гүшүү, гүшүү! гэцгээхэд Отгон цочиж,

- Паах яанаа! Яах гэж байгаа юм болоо? гэхэд Чоймчиг гэлэн хажуугаас нь ёворч,

- Зүгээр, зүгээр. Түвд хүн ингэж хэлээ гаргаж эрхийгээ гозойлгож мэндэлдэг юм. Амандаа хорт үг агуулаагүй, гартаа ирт зэвсэг бариагүй гэсэн дохио гэв.

- Гүшүү гэдэг нь "дээдэс" хэмээн хүндэлж байгаа үг гэж Санж гэцэл Отгонд тайлбарлав. Гэцэл бол номын мөр хөөж долоон жил хийдэд сууж түвд хэлийг нэгэнт сайтар сурсан эрдмээ одоо амьдралд шалгаж байгаа нь энэ.

Мөргөлчид Их зууд орохын тулд хэдэн зоос хаяж өгсөнд түвдүүд,

- Лагсоо, лагсоо! гэж баярласнаа илэрхийлэн шилээ маажиж зарим нь хоёр гараа ар өгзгөндөө алгадав.

- Лагсоо гэж сайн сайн гэсэн үг. Шилээ маажих нь эсвэл өгзгөө алгадах нь хүндэтгэж байгаа хэрэг гэж Санж Отгонд тайлбарлав.

Их зуугийн давхар хашааны гонхон дотор дөрвөн их Махаранзын дүрс хос хосоороо байхыг босгоор алхангуут хараад Санж гэцэл Буянзалбирах хийдийг дурсан саналаа. Бараг адилхан ажээ. Богдын хаалга гэж ийм дөрвөн сахиустай гонх Буянзалбирах хийдэд байдаг юм. Сүмбэр уулын дөрвөн зүгийн амгаланг сахиулагч гэж энэ дөрвийг үздэг бөгөөд хөх царайтай, баруун мутарт сэлэм, зүүндээ дун барьсан сүрлэг баатрыг Барутахи Махаранз, улаан зүстэй, мутарт эрчилсэн могой барьсныг Виуракиш Махаранз, шар өнгөтэй, баруун мутарт жогвоо зүүндээ хулгана барьсныг Дритри раштра Махаранз,

хүрэн зүстэй пийпаа хөгжим дарж байгааг Вайсраавани махаранз гэдгийг Санж андахгүй мэдэж байлаа.

Богдын хаалгыг өнгөрч Чимраа гэдэг хашаанд мөргөлчид оржээ. Тэнд хурал, мөргөл болдог ажээ. Эсрэг талын хананд их сахалтай баатар эр, эхнэр хүүхдийн хамт зогсож байгаа зураг харагдав.

- Сөгдөн залбирахтун! гэж гэлэн Чоймчиг шивэгнээд газар сөгдөн залбирав. Бусад мөргөлчид мөн л дууриан үйлдэв.

- Энэ Далай ламын зураг бус уу? гэж Өлзий асуусанд гэлэн Чоймчиг,

- Энэ бол манай монголын Гүүш хааны дүр болно. Түвдэд их буян хийж өгсөн хаан юмдаг гэж хэлэхэд Бөхмагнай,

- Монгол хаантай байсан юм гэж үү, Түвд? гэж маш гайхан асуув.

Гэлэн Чоймчиг дуугарсангүй. Ханан дээрх их сахалт баатар, түүнтэй ярилцаж байгаа Банчөн-ринбочейн зураг өөд биширсэн нүдээр ширтэж амандаа юм уншиж түр сууснаа гэлэн Чоймчиг,

- Монгол хааныг гурван удаа залж ширээндээ өргөмжилсөн айл даа! гэж хэлээд босч ханан дээрх зураг өөд алхлав.

Үнэхээр Чимраа ордны энэхэн ханан дээр Монголын Гүүш хааны хөрөг зураастай байжээ. Гурван зуу гаруй жилийн тэртээ болсон явдал. Тавдугаар Далай лам Агваанлуvsанжамц Хошоотын Гүүш хаанд элч заран илгээж Түвд оронд цэрэг зэвсэг агсаж хүрэлцэн очихыг залж гуйжээ. Гэвч Гүүш хаан цэрэг, зэвсэг агсаж түвдэд очсонгүй. Харин ерийн мөргөлчин болж явжээ. Тийнхүү далай ламтай уулзаж сэмхэн хэлэлцэн тохирчээ. Гурван жилийн дараа Гүүш хаан их цэргээ толгойлон ирж, Шихаац хотыг долоон сарын турш бүслэн байлдаж Далай ламын эсрэг талынхныг дийлээд Зонховын шашныг мандуулж шашин төрийн эрхийг Далай ламд шилжүүлжээ. Гэвч өөрөө төр барьж суужээ. Тэгээд хүү Даяандаа Очиртхаан цол өгч

Түвдийн төрийн эрхийг шилжүүлж тэр нь хорь гаруй жил Түвдийг захираад нас юулж, хүү Пунцаг нь Далай хаан цол хүртээд мөн хорь гаруй он өнгөрмөгц түүний хүү Лхавсан хэргэмий нь залгамжилж монголын сүүлчийн хаан болон отголж, Зүүн гарын цэрэгт дийлэгдэн Будалын ордонд амь алджээ.

Түүхийн дурангаар цааш сунган харвал Гүүш хаанаас өмнө дөрвөн зуун жилийн тэртээ Чингисийн жанжин Мухур гэгч Хатны гол буюу Шар мөрнийг гатлан гарч Тангадыг байлдан дагуулж хойноос нь Чингис хаан өөрөө цэрэг хөдөлгөн ирж Тангадын улсыг үндсээр нь мөхөөжээ.

Түүхийн дурангаар дахин цааш сунган харвал манай тооллын өмнөх гурван зуун арванхоёрдугаар онд Монгол Тогоон жанжин Хөх нуурын уудам нутгийг эзэлсэн хаанчлал тогтоосон нь гурван зуун тавин нэгэн жилийн нүүр үзсэн билээ. Тогоон хааныг дүү Жолоогүй нь хавчин зайлуулж, сүүлд нь түүндээ гэмшин гуниж “Ах дүүсээ” гэдэг дуу зохиосон ажээ.

Энэ бүхнийг Чоймчиг гэлэн ном судраас уншиж мэдсэн байлаа. Гэвч мөргөлчдөд үүнийг ярих зав байсангүй.

- Бөхмагнай сонирхоод байвал орой хариад банагандаа чамд ярьж өгье! гэж Чоймчиг гэлэн амлав. Тэгснээ гэцэл Санжид хандаж гэлэн багш нь,

- Гүүш хааны зураг энд анх ганцаараа байсан юм. Тэгтэл нэг удаа зураг амь орж “Ганцаараа уйтгарлаж байна. Үг солилцох хань өгөөч” гэж дуугарсан юм гэдэг. Тэгэхээр нь Банченгийн хөрөг нэмж зуржээ. Тэгтэл нэлээд байж байгаад Гүүш хааны хөрөг бас дуугарч дээ. “Далай ламыг залрах болгонд байн байн босох юм даа” гэж тэр хэлсэн гэдэг. Түүнээс хойш Далай лам гол хаалгаар биш харин баруун хацрын хоёр дахь хаалгаар орж Чимраа ордныг Шинра ордонтой холбосон хонгилоор явдаг болсон юм гэнэлээ.

Энэ үгийг мөргөлчид сонсоод Гүүш хааны хөргийн өмнө чох зоос, хадаг тэргүүтэн өргөв. Тэндээсээ мөргөлчид Их зууд шилжин оржээ. Их зуу бол хааш хаашаа хорин алдын дөрвөлжин сүм юм. Тэнд ирэх галвын бурхан Майдар, их нигүүлсэнгүй бурхан Арьяабал, бүхнийг үзэгч бурхан Жанрайсэг, Зонховын дүр болон шашны амарлингуй догшин дүрт бурхдын хөрөг тус тусын дүрэм жаягаар байрлагджээ. Тэр бүхний дотроос онц эрхэмлэх нь Бурхан Шахьяамунийн хөрөг юм. Мөргөлчид тэнд орж мөргөхийг ихэд хүснэ. Иймд Чоймчиг гэлэн өөрийн багийг дагуулан юуны урьд Шахьяамуни бурханд мөргүүлэхийг зорьжээ.

- Тэр жижигхэн хонхыг дэргэдүүр нь очихдоо дуугаргадаг юм. Хүн ирж явааг мэдэгдэх, бас Бурхан багшийг хөгжмийн эгшгээр баясуулах буяны тэмдэг гэж гэлэн Чоймчиг сурган хэлэв.

Жижиг талбай дээр хоёр гуулин хонх дүүжлүүрт зүүсэн байлаа. Хонхны хэл нь мод ажээ. Гэцэл Санж эхлээд тэр хонхны хэлийг хөдөлгөв. Мод учраас битүүвтэр зөөлхөн чимээ гарч аажмаар замхарлаа. Мөргөлчид амьсгаа даран аяархан алхалсаар Будда Шахьяамунийн шүтээний газар орцгоолоо. Гурван талаасаа онгорхой гоёмсог сэхээвчин лавир дотор суугаагаар нь шууж хийсэн Будда бурхны алт түрхмэл дүрийг мөргөлчид хармагц цөм л наманчлан залбирцгаав. Лавир нь луу ороож гоёмсгоор сийлсэн баганан дээр тогтоосон, алтан дог бүхий үзэсгэлэнтэй байдалтай бөгөөд хоёр эгнээ тавиур дээр алтадсан сэргөөн буюу алт, тахилын цөгц өрөөстэй ажээ. Мөргөлчид Будда бурхны шүтээнийг нар зөв эргэн гороо хийж өргөл барьцаа орхиод ихэд сүсэглэн бурхны зүг бөгсөө харуулахгүйг хичээж арагшаа ухран гарцгаалаа.

- Хамаг нүгэл минь ариудсан байхаа! гэж шүтээний өрөөнөөс гарахдаа Өлзийг хэлэхэд Чоймчиг гэлэн дургүйцэж,

- Нүгэл нь ариудах хүн гэж бараг үгүй биз дээ! гэж хэлэв.

- Их зуугийн өглөөний мөргөл өндөрлөх цаг болж байна. Түргэлцгээ!

гэж мөргөлчдийг зохицуулагч Жахар хүн хэлэв.

Их зуу өглөө эрт, үд дунд, үдэш гурван удаа мөргөлчдөд зориулан нээгддэг байлаа. Чоймчиг гэлэн багийнхныгаа дагуулан Балданлхам бурхны өрөөгөөр дамжин гадагш гарахаар яаравчлав.

Балданлхам бурхны өрөөнд дөнгөж ортол Отгон хүүхэн золтой л хашгирчихсангүй. Ханцуйгаар амаа таглан айж бишүүрхсэнээ нууж явлаа. Юун гэвэл: Балданлхам бурхны өрөөгөөр ам цагаан хулгана шал дээгүүр нааш цааш гүйлдэж байлаа. Бурхан шүтээний газар хулгана гүйж явна гэж санаагүй тул Отгон байтугай Санж гэгцэл гайхан эргэлзэв. Хөлд өртөөд гишгэгдчихмээр олон ажээ.

- Багшаа, хулганыг яанаа? гэж Санж шивэгнэв. Тэгэхэд Чоймчиг гэлэн сая л ухаа орсон мэт эргэн харж

- Би хэлэхээ мартчихжээ. Их зуугийн Балданлхам бурхны өрөөнд ам цагаан хулгана гүйлдэж байдаг юм. Өлзийтэй амьтан гэж шүтдэг. Шүтлэгтэнгүүд худалдаж авдаг. Та нараас хулгана авах хүн байвал ав ав. Нэг нь арван чох байдаг гэж хэлэв.

Мөргөлчид мэлтийн гайхацгаажээ.

- Нэг хулгана авья байз! гэж Өлзий өврөө уудлав.

- Өлзий чи авмаар байна уу? За тэгвэл би авч өгье гэж Чоймчиг гэлэн хэлээд арван чох зоос гоцого хүүд авч өгөхөд тэр хүү өврөөсөө нэг хулгана гаргаж гэлэнгийн алган дээр тавив.

- Май! гэж Чоймчиг тэр хулганыг Өлзийд дамжууллаа. Өвчинд нэрвэгдсэн Өлзий их л бэлэгшээн баярлаж, нүдэн дээгүүр нь нулимс гүйлгэнэн, толгой дохин нахилзаж “гялайлаа, гялайлаа” гэсээр тэд Балданлхамын өрөөнөөс гарлаа.

Их зуугийн газар орсон мөргөлчид найман янзаар мөргөл үйлдэж

болдог ажээ. Бурхдын шуумал дүрсний баруун өвдөгт духаа хүргэн бөхөлзөж мөргөнө. Энэ нь хамгийн түгээмэл болохоор Их зуугийн Бурхдын баруун өвдөг нь гөлийтөл зүлгэгдээд заримы нь гууль нь цухуйчихсан байдаг ажээ. Гууль нь цухуйсан бурхдыг үе үе алт түрхэж сэргээдэг боловч олон түмэн мөргөлчдийн дух юутай ч зүйрлэшгүй ширүүн өрөвтөл ажээ. Гэвч бас бурхдын зүүн өвдөг мөн л халцарсан үзэгдэнэ. Яагаад гэвэл мөргөлчид бурхдын зүүн өвдгөөс адис авбал хүсэл мөрөөдлөө сэмхэн шивнэн ярьдаг байлаа. Хүний хүсэлд төгсгөл байхгүй болохоор гуйлан бурхдын зүүн өвдөг бас л амсхийхийх заяагүй байлаа. Хүсэхгүй юм гэж хүнд хаа байх вэ?

Чинээлэгдүүхэн мөргөлчид зул ба шар тос авчирч бурхдад өргөх, зарим нь Их зуугийн олон зуун зулны ширгэн дунд орж байгаа тосыг дүүргэн сэргээж буян үйлдэнэ. Энэ ёсыг дагаж Отгон нэг данх буцалсан шар тостой ирсэн билээ. Гэвч тэр данх шар тос Их зуугийн олон зулыг дүүргэн сэргээхэд хаана ч хүрээгүй. Үүндээ Отгоны сэтгэл дундуур байлаа. Түүнийг Чоймчиг гэлэн ажиглаад,

- Жажодын өргөл бэлтгэж өгөмц. Зуун зул, зуун балин ордог юм. Яахав би бэлтгүүлж өгнө. Над хэдэн зоос бий гэж түүний чихэнд шивнэжээ. Отгон түүнд тун их баярлав. Тэр нь нүдэн дээрээ тодхон байлаа. Чоймчиг гэлэн бас,

- Дончод буюу мянган зул, мянган балингийн өргөл байдаг юм. Түүнээс их өргөл үгүй. Гэвч түүнд түрийвч багадах байх гэж ярьжээ. Тэднийг буцахаар явахад л мөргөлчид хасагдсан шинжгүй.

Их зуугийн хашаанд мөргөлчид сунаж мөргөн, нэг босч, нэг хэвтэж хэдэн зуун цэрэг байлдааны сургууль хийж байх шиг харагдлаа. Хувь тавиландаа сайн сайхны буян өлзий горьдсон тэр олон мөргөлчид газар газраас цугларан ирсэн аж. Тэдний дунд баян чинээлэг хүн нэгээхэн ч үгүй байгааг ажиглан хараад Санж “Баян хүн энэ насны жаргал, чинээлэг амьдралдаа цадвал эргэл мөргөл хийх нь ховор байдаг юм уу даа! Гэтэл хойт нас гэж юмны тухай санаа зовдоггүй

хэрэг үү? Нэг бодоход зөв ч юм уу? Энэ л яваа насандаа жаргалтай байх нь эрхэм юмсан уу даа!” гэж бодож явлаа.

Тав. Далай ламд мөргөсөн нь

Чулуун дээр ногоо ургуулах нэг бэрх
Усан дээр гал тулэх нэг бэрх
Үхрийн эвэр дээр цас тогтоох нэг бэрх

Мөргөлчид тэр өглөө бөөн хөл хөөрцөг, баяр хөөр болж байлаа. Далай ламд мөргөх боломж, хувь хишиг хүртсэн нь мөргөлчдийн эцсийн хүсэл биелж байгаа гэсэн үг юм. Мөргөлчид хамаг байдгаараа гоёцгоожээ. Мөргөлчид хамаг байдгаараа чимэцгээжээ. Орой Чоймчиг гэлэн Далай ламд мөргөх бүхий л журам ёсыг ярьж өгчээ. Нэг бодоход хялбар мэт нөгөө бодоход ер бусын явдал шиг тэдэнд санагджээ. Үнэхээр бурхан шашны оройн дээд лам, биелсэн бурхан лугаа учран адис авна гэгч нь ерийн нэг мөргөлчингүүдэд ер бусын явдал байлаа.

Өглөө эртлэн боссон мөргөлчид явган явцгаалаа. Хотын баруун урьд талд Марбори толгойг эзлэн сүндэрлэгч Дүзин нийвийповран Будалин гэдэг өндрөөс өндөр ордон өглөөний наранд алт шармал орой нь гялтганаж үзэсгэлэнтэй сайхан харагдаж байлаа.

Дүзнинийвий повран Будалин гэдэг бол хоёрдугаар залуурчийн ордон Будала гэсэн утгатай үг байжээ. Долдугаар зууны үеэс эхэлсэн тэр ордон арван долдугаар зууны дундуур тавдугаар далай лам Агваанлуvsсанжамцын уед дуусах ёстой байтал тэр дуусгаж чадалгүй нас юулжээ. Гэвч талийгаач Далай ламын зүгээс монгол Гүүш хаантай хамсан тогтоосон ноёлог байдал, шашин төрийн эрхийг алдахгүйн тул Далай ламтангийн төрөл арилжиж насан үйл төгссөн тэр өдөр их лам нар хэлэлцэн үгсээд түүний нас барсныг нуужээ. Далай ламын насан өөд болсныг тийнхүү тас нууж 16 жилийн турш түүний нэрийг зээлдэн элдэв хэргийг шийтгэн явуулж, эцэст нь өөрсдөө мөн л насны явдал дуусдагийн даваан дээр дэлхийд анхны олон давхар барилга Будалинг босгож түүний 9- 13 давхарт нийтдээ

есөн зуун ерэн есөн өрөө засчээ. Мянгад нэг дутуу өрөөтэй асар том тэр ордон голоороо арван гурав, захаараа есөн давхар тул ямар нэгэн сүрлэг өндөр уулыг санагдуулахаар болжээ. Буддагийн шашны тэргүүн ламд зориулж барьсан тэр ордноос өндөр барилгыг буддагийн ертөнцөд барьж болохгүй гэж хууль зарлиг гаргажээ.

Нэгэнт насан эцэслэж мөнх бусын явдалд орчихоод байсан ч гэсэн Будалингийн гайхамшигт ордонг нэр сүрээрээ гүйцээлгэн бариулсан тавдугаар далай ламын шарилыг асар их ёслолоор мөнхүү ордонд суваргалжээ. Тэр суваргыг давтмал алтаар бүрж, эрдэнийн чулуугаар чимжээ. Алт, эрдэнийн суваргыг босгоход Түвдийн тэр үеийн сангийн бүх алт, эрдэнийн чулуу ёроолдоо хүрч хоосорсон ажээ.

Анхнаасаа Соронзонгомбо хааны босгосон цайзан дээр дулдуйдан сүндэрлэсэн Будалын ордон нэг харахад бурхны шилтгээн, нөгөө харахад цэргийн цайзыг ямагт санагдуулна. Голын хөндийд ганцаараа ялгаран тогтсон толгойн орой дээр байгуулсан Будалын ордон алс холоос харагдахын гадна дэргэд нь очиход өчүүхэн шүтлэгтэнгүүдийг сүр бараагаараа дарж, өөрийн эрхгүй шүүрс алдан наманчлахад хүргэнэ. Дэлхийд анхны олон давхар сүм аргагүй л мөн аж.

Гэлэн Чоймчигийн цөөн мөргөлчид мөн л тийнхүү сүрд дарагдаж Будалын ордны анхны довжоон гишгүүр дээр сунан мөргөж духаараа адис авцгаалаа. Будалын ордон өөд авиран очиход зориулж Марбори толгойг өгсүүлэн гурван талаас нь тавьсан чулуун шатнууд хөрөөний ир шиг ярайж байв. Зүүнээс баруунаа тахиралдуулан зассан шатны олон зуун гишгүүр өөд мөргөлчид сүжигтэйгээр наманчлан өгсөж эхлэв.

Хоёр тийш далавчилж гол өөд тэмүүлсэн хэлбэртэй асар том ордны төв хэсэг нь улаан хүрэн зосын өнгөөр будагдсан ажээ. “Улаан ордон буюу побранмарпо гэдэг нь энэ юм байж. Хоёр жигүүрийн цагаан барилгууд цагаан ордон буюу побран Карбо гэдэг нь байх. Яасан асар сүрлэг том орд харш вэ? Толгой эргэм сүртэй юм” гэж гэцэл Санж бодлоо. Буянзалбирах хийдээс өөр юу ч үзэж, нүд тайлаагүй залуу

гэцэлд Будалын ордон үнэхээр үнэмшигдмээргүй сүрлэг гайхамшигтай харагдлаа. Нутгий нь нэг өвгөн “Ай тэр Лхас зуугийн Будаалин өргөө юу, мөн ч сүрлэг том хайрхан шүү. Манай Бурхан буудай уулнаас багагүй байх. Дотор нь морьтой хүн явж байдаг юм. Байшин дотроо нуруу нь нэг нам, нэг өндөр болохоор үелүүлэн хийсэн байдаг юм. Хорин мянган лам хуралдаад гарч байхыг харсан. Айдаа мөн л уужим сав билээ” гэж ярьсныг гэцэл Санж гэнэт санах. “Худлаа байлгүй. Яаж Бурхан Буудай уул шиг дуган байх юм бэ?” гэж тэгэхэд өвгөнтэй маргахад тэр асар их уурлан гомдож “Чи буянтай хүн бол өөрөө очоод л мэднэ дээ. Буянгүй бол ингээд л хүнд итгэхгүй өнгөрнө” гэж хэлжээ. Санж гэцэл Будалын ордны босгон дээр зогсож байхдаа “Өвгөний хэлдэг ч аргагүй л юм байж. Уул шиг л харагддаг ордон байна” гэж бодлоо. Тэр бодлы нь Бөхмагнай тасалж,

- Хөх тоонын давааны сүрд дарагдаагүй байтал энэ Будалын ордны чинь сүрд аргагүй л дарагдах нь дээ. Оройгий нь харах гэхээр малгай ар тийш ойчих гээд байна. Мөн л асар сүрлэг, өндөр юмаа гэв.

Мөргөлчид алхам бүрээ Будда бурхны бие төлөөлөгч болон заяаж, орчлон дээр ариун үйлсийг нь залуурдаж байгаа Далай ламд зориулсан мөргөлийн алхаа гэж үзэж сүжигтэй, намбатай, басхүү хүндэтгэлтэйгээр элдэв үг яриагүйгээр өгсөн өгссөөр Будалингийн хаалган дээр хүрч ирлээ. Бурхны өргөөнд нэвтрэн орох хаалганы босгон дээгүүр алхан орсон эгэл жирийн хүнийг өчиггүй баривчлан авч тусгай өрөөнд оруулан дөчин есөн удаа торлогдож жанчаад дараа нь хэрэг зоригийг нь асуудаг тийм хуультай ажээ. Гэвч харь газрын мөргөлчдийг тэр хуульд хамааруулсангүй. Бас ч тэд урьдаар Далай ламд бараалхан мөргөх зөвшөөрөл авсан байлаа.

...Хаалга онгорхой байлаа. Мөргөлчид тэр хаалган дээр ирээд өөрийн эрхгүй зогтуслаа. Учир нь гэвэл хаалганы эгц харалдаа хойморт алд дэлэм өндөр өргөгдсөн зандан модон хээ угалзтай дөрвөлжин суудалд Далай лам арван гуравдугаар заларч байхтай мөргөлчдийн харц шууд тулгарчээ. Өмнөд этгээд рүү нь шар торгон унжлага унжуулжээ. Түүн дээр нацагдорж тэмдэг буюу зөрүүлсэн хос очир зуржээ. Ар этгээдэд

мөн л луун хээтэй шар торгон бүрхээстэй түшлэг их ламын тэргүүн дээгүүр үл ялих илүү гарч харагдлаа. Далай лам шар жанч нөмрөөд, завилан суужээ. Тэргүүндээ Зонховын өмсгөл шар овоодой малгайг залжээ. Зүс царай тун залуувтар бүр хүүхдээрээ боловч юм бясалган бодох мэт амирлангуй гунигтай ажээ. Буддын шашны оройн дээд ламтай гэнэт нүүр учран харц тулгаран уулзсандаа мөргөлчид сүрд дарагдан тэвдэн бапмагдаж түр ухрасхийн зогтусчээ.

“Далай лам гэдэг хэнсэн билээ? Арван нэгэн тэргүүнт бүхнийг айлдагч Хоншим бодьсад Авалокитешвары бурхны хувилгаан гэгддэг билээ. Хорвоод ийм хувилгаан зөвхөн арван гурав төрсний нэг нь ийнхүү өндөр суудалдаа залран байгаа биш үү? Сүслэн мөргөх хэрэгтэй” гэж гэцэл Санж бодлоо.

Арван гуравдугаар Далай ламын алдар нь Агваан лувсантүвдэнжагваралванчигчоглойнамжил юм. Нас бие гүйцээгүй тул шашны их хэргийг түүний эрдэнэт багш гэгддэг Ёнзонринбучи Лувсанчүлтэмжамбажамц гэгч шийтгэн явуулна. Ер нь ч түүний өмнөх арван хоёр Далай ламаас нас бие гүйцэж аж төрсөн хүн цөөн билээ. Ялангуяа эдүгээ тодорсон арван гуравдугаар далай ламаас өмнөх дөрөв таван далай лам хорин насыг насалж чадапгүй, мөнх бусыг үзүүлсэн ажээ. Дөрөвдүгээр Далай лам Ёндонжамц монгол хүн байлаа. Ламын шашныг Монголд дэлгэрүүлэх эрмэлзэлдээ хөтлөгдөж Далай ламын дүрийг Түвдүүд Монголоос тодруулжээ. Гэвч нэлээд хугацаа өнгөрөхөд монгол Далай ламд Түвдүүд хорсол төрж хуйвалдаан зохиогоод түүнийг монголчууд хонь яаж өрлөн төхөөрдөг тэр аргаар хорлон алсан юм гэдэг. Гэтэл түүний дараа тодорсон Далай лам Агваанлуvsанжамц нь монголчуудын тусламжаар шашин төрийн эрхийг бататгаж аваад түүнийгээ тавь шахам жил гартаа бат барьж хорин таван боть зохиол бичиж өөд болжээ. Түүний насан эцэс болсныг бараа бологсод нь нууж, монгол хятад, зүүнгарын хааныг хооронд нь хямралдуулах бодлого явуулснаар Түвдийн түүхэнд цаг төрийн үймээн эхэлжээ. Тэр үймээний хөлд түүнийг санаачлан үүсгэсэн Санжайжамц гэдэг дэбаа өөрөө эхлэн үрэгдээд дараа нь зургаа, долдугаар Далай ламыг бөөн хэрүүл дунд өргөмжилж улмаар

хэлмэгдүүлжээ. Ес, арав, арван нэг, арван хоёрдугаар Далай ламтангууд мөн л насаа зуурдаар төгсгөжээ.

Түвдүүд Далай ламын амь насыг хамгаалж байгаа мэтээр шашны зан үйл олон янзаар хийдэг боловч тэр бүхэн тус болох нь ховор байлаа. Ихэнх Далай лам цэл залуугаараа өөд болжээ.

Жил бүрийн хоёрдугаар сарын арван есөнд бага Монлам гэдэг хурал арав хоногийн турш хурж Далай ламын шавданг бататгах, өргөл, мөргөл хийнэ. Мөн сарын хорин есний өдөр нэг хүнийг золигт гаргаж Далай ламын амины солио болгоно. Тэр бүрий Далай ламын шавданг бататгаж чаддаггүй байлаа. Олны нүгэл асар зузаанаас тиймд хүрдэг гэлцдэг байв.

Арвангуравдугаар Далай ламд мөргөж, адис зангиа хүртэхийн тулд хүн бүр найман лан мөнгө хадгийн хамт Далай ламын санд өргөсөн болохоор гэлэн Чоймчигийн багийнхан санаа амар нүүр бардам байлаа. Хадаг өргөсөн мөргөлчин адис авч зангиа хүртдэг. Таван лан мөнгө өргөсөн хүн адис, зангианаас гадна ном, бурхан, эсвэл мандал, суварга зэргийн аль нэгийг Далай ламаар адислуулж буцааж авна. Далай ламын адисласан тэр юмч хаа ч хэзээ ч асар их үнэтэй шүтээний зүйл болдог байлаа. Найман лан мөнгө өргөсөн хүн бол дээрх зүйлийн эрхийг олж авахаас гадна Далай ламын ойролцоо сууж цай будаа хүртэх завшаантай болдог ажээ.

Хамгийн том өргөл нь Цогбул гэдэг бөгөөд Лхас Монлам хурах үеэр цуглардаг хорин мянган ламд хүн тус бүрд өргөл хүртээж, манз цав барихыг хэлнэ. Ийм өргөлийг асар баян хүн л дааж дийлдэг учир ховор өргөдөг байжээ.

“Цогбул өргөж чадсангүй. Даанч их мөнгө хэрэгтэй юм. Цогбул өргөсөн бол их л хэрэг бүтэх байсан юм” гэж Чоймчиг гэлэн Далай ламын барааг харангуут боджээ.

Мөргөлчид Далай ламын залран сууж байгаа шавдангаас таван

алхмын зайнд ирмэгц Чоймчиг гэлэнг дууриаж гурав дахин сунаж мөргөлөө. Дараа нь тус бүр хадгаа гаргаж аман талыг Далай ламын зүг харуулж, хоёр гарын алган дээр дэлгэн бариад урагш алхацгаав. Далай ламын дэргэд очиход бараа бологч лам тэдний хадаг дээр мандал, ном, бурхан тэргүүтнийг тавьлаа. Далай лам булцгар гараараа тэр бүхэнд хүрч, дараа нь мөргөлчдийн зулай дээр адис буулгав. Тэр мөчид Далай ламын бараа бологч нь торгомсог туушинг зангидаад Далай ламаар үлээлгэж мөргөлчдийн хүзүүнд зүүж өглөө. Гэлэн Чоймчиг тийнхүү долоо дахь зангиагаа гурав дахь Далай ламаас авч байгаа нь энэ ажээ. Бусад мөргөлчид цөмөөрөө анх удаа Далай ламын шившин таринадсан зангиа хүртэж байгаа нь энэ.

Мөргөлчдийг Далай ламын өмнөөс харуулж хивсэн дээр суулгалаа. Манзач гуулин домботой цай авч орж ирэв. Тэгээд Далай ламын өмнөхөн очиж зогсоход нь эхлээд Чоймчиг гэлэн өврөөсөө бадар аягаа гаргаж хоёр гардан тосоор манзачийн өмнө очиход тэрээр домбоноос нэг балга цай хийж өглөө. Бусад мөргөлчид дэс дэсээр босч тус тусын аяганд нэг нэг балга цай авч зэрэг балгаад гурав дахин наминчлан залбирлаа. Тэр даруй мөн цайнаас Далай ламын аяганд мөн нэг балга хийж өгчээ. Далай лам түүнийг балгав. Тэгтэл мөргөлчдийг буцааж хивсэн дээр нь сөгтгөн суулгалаа. Манзач домбоо бариад тэдний дэргэд ирж тус бүрийн аяганд гурав гурван дусал цай хийж өглөө. Тэгтэл Далай ламын ам нь хөдөлж юм хэлэх шиг болжээ.

- Замдаа сайн явж ирэв үү? Нутаг оронд чинь өлзийтэй байна уу? гэж байна хэмээн хэлмэрч дамжуулав.

Түүнд хариу хэлэхгүйгээр зөвхөн нахисхийн бөхийх ёстой гэсэн Чоймчиг гэлэнгийн заасан ёсоор мөргөлчид суудал дээрээ өндөсхийгээд нахилзан ёслов. Хэлмэрч мөн л Далай ламын зүг бөхөсхийн ёслов. Ийм ёс журам нэгэнт уламжлал болжээ.

Мөргөлчдөд цагаан будаа түгээж өгөхөөр цавчин хувин дүүрэн идээтэй орж ирлээ. Эхлээд Далай ламын аяганд хийж өгөхөд тэр амсах төдий зооглоод мөнгөн чавирнаас ус балган амаа зайлав.

Мөргөлчдөд аягы нь амаараа халин асгартал будаа хийж өглөө.
Будаанаас нэг амстал бэрээ барьсан гээгнүүд хаа нэгтэйгээс гарч
ирээд,

- Гарцгаа! Мөргөлийн цаг дууслаа! гэж зэрэг дуугаар хашгирлаа.

Бөхмагнай гайхан уурлаж,

- Өгсөн хишгийг нь идүүлэхгүй хөөх нь үү, эд нар чинь! гэхэд
хажуугаас Чоймчиг гэлэн ёворч,

- Дуугүй гар. Алдас болно! гэв. Тэгэхээр нь Бөхмагнай уурандаа
хүрэн эрээн царайтай болж бадар аягатай будаагаа том ангайж ам
руугаа хөнтөрч орхиод жавжаараа савируулан идсээр үүд чиглэв.

“Далай ламыг харсаар байтал өөрт нь сүжиглэсэн мөргөлчдийг ингэж
хөөн гаргах гэж дээ” хэмээн Бөхмагнай бас амандаа шивнэн бувтнаж
байлаа.

- Гарцгаа, түргэлцгээ! гэж бэрээ барьсан гээгнүүд зэрлэгээр дахин
шаардав. Бөхмагнай шанааныхаа судсыг гүрэлзүүлэн хилэгнэж нэг
бэрээчийг цохиод авах гэсэн шиг муухай харахад цаадах нь
тоосонгүй, харин ч бэрээгээ далайж цохихыг завдлаа.

Чоймчиг гэлэн дундуур нь орж хоёр этгээдийг зохицуулав.

Мөргөлчид тийнхүү найрсаг орж ирсэн газраасаа хүйтнээр үдүүлж,
төмөрлөсөн бэрээний далайлтан дор гадагш гарцгаалаа. Гэвч
Бөхмагнайгаас бусад нь цөм л амьд бурхнаас адис зангиа хүртсэндээ
хязгааргүй баярлаж, үлгэр домгийн орчлонд ороод гарсан мэт
хөөрүүн сэтгэлтэй байлаа. Залуу гэцэл Санжид бол энд үзсэн, сонссон
бүхэн нь ер бусын гайхам сонин, давтагдашгүй явдал байлаа. Тэр
саяын болж өнгөрсөн мөргөлийг хэзээ ч мартахааргүй тогтоож авчээ.

Далай ламын ордны үүдэн дээр гарч ирэхэд ядуу мөргөлчин түвдүүд

газарт эгнэн сууцгааж байлаа. Тэд хадаг самбай, мөнгөгүй болохоороо дотогш орж чадахгүй үүд сахин суугаа нь тэр байлаа. Саглагар үсэн дотроосоо юм маажин тэмтэрч байсан нэг түвд хүн бөөс олж аваад амандаа хийж зажпав. Цаана нь суугаа түвд эмэгтэй суганаасаа бөөс олж мөн л адил амандаа хийж үүдэн шүдээрээ хазлаа. Түүнийг харсан Отгон хүүхэн цочин гайхаж,

- Хүүш яанаа! Бөөсөө иддэг юм уу даа гэж дуу алдлаа. Чоймчиг гэлэн түүнийг дургүйцэн хажуугаас нь ёворч,

- Дуугүй яв! Идэж байгаа юм биш! Би чамд сүүлд учры нь хэлж өгнө гэв. Гайхан огиудас хүрмээр юм шиг байв.

Будалын ордны шат руу бууж явтал бас л хоёр түвд хүүхэн шатны гишгүүр чулуун дээр сандайлан суугаад бие биеийн сэгсгэр үснээс бөөс түүж байлаа. Нэг нь бөөс олж аваад нөгөөдөө өгөхөд тэр даруй амандаа хийж зажлав. Отгоны дотор муухай болох шиг эвгүйрхлээ. “Манайхан ч бөөстэй л дээ. Гэхдээ эдэн шиг арай л бөөсөө иддэггүй дээ” гэж тэр хүүхэн бодож явлаа.

- Идэж байгаа юм биш! гэж Чоймчиг гэлэнгийн хэлсэн үнэн байжээ. Түвдүүд бөөсөө үүдэн шүдээрээ хазаж алдаг заншилтай юм байжээ. Сармагчны ягчисаас гаралтай гэж Түвдүүд өөрсдийгөө үздэг юмсанжээ. Сармагчны ягчисаас үүсэлтэй тул түвдийн хаад цөм л сармагчинтай төстэй байхыг эрмэлзэж иржээ. Нэгэнт ийм болохоор түвд хүн бөөсөө шүдээрээ егүүтгэхийг огтхон ч зэвүүцдэггүй харин ч өндөр дээд гарал үүсэлтэйгээ цохон тодруулж байгаа хэрэг гэж итгэн заншчээ. Сармагчин биеийн бөөсийг шүдээрээ эрэн хайж олсноо хазаж устгадгийн адил түүнээс гаралтай түвд хүн бөөсөө шүдээр нядаахад юундаа ичиж зовох билээ!

Мөргөлчид Лхас зуугийн сүрлэг өндөр Будалин ордны өвөр тал руух өндөр шат руу бишрэн дээдэлсэн, болгоомжтой алхаагаар бууцгаалаа. Цөмөөрөнгийнх нь хүзүүнд Далай ламын адислан таринадсан зангиа зүүлттэй тул тэд одоо урам зоригтой, юунаас ч айхгүй, ирээдүйдээ бат

итгэлтэй явж байлаа.

“Одоо би ч үртэй болох байхаа! гэвч...” гэж Отгон баяр гуниг хослон бодож зүрх нь нэг шимшрэн, үе үе мартагнаж байлаа. Отгонд үрийн хутгийг Далай ламын адис заяалаа гэж бодоход нөхөргүй яах билээ. Хөөрхий нөхөр Хархүү Хөх Тоонын даваанд үрэгдсэн. Одоо хэнтэй суух билээ? Хорь гаруйхан насандаа бэлэвсрэх гэж үү? “Миний заяагүй толгойноос болж хөөрхий тэр минь хүний газар гүний нутагт ясаа тавилаа. Юутай заяагүй хүн билээ би!” гэж Отгон үе үе зовинон санаа алдана. “Гэвч бас байз. Бид хоёрын замын төөрөг таараагүй юм байлгүй. Уул нь лам багш Чоймчиг гэлэн гуай Уйшааз судраа нээж, шоогоо орхин их л нарийн үзэж байж бидний жил судрыг тааруулсан биш билүү? Миний л азгүйгээс болсон байх. Одоо тэгээд би үрийн хутаг олоод ямар сайн байх вэ?” гэж Отгон эргэн бодлоо. Хүзүүн дэх зангиа нь сэвэлүүүр салхинд үл мэдэг намилзан хийсч итгэл төрүүлж байв. Ямар ч атугай Их зуугийн нандин шүтээн бүрийн зүүн өвдгөнөөс адис авч тус бүрийд нь хандаж “Намайг үртэй болгож өгөөрэй”, “Надад үрийн хутаг хайрлаач дээ” гэж шивнэн гуйсан билээ. Одоо Далай ламд мөргөхдөө үйлдэл бүрийдээ энэ хүслээ толгойд бясалган хүсч байлаа. Нялх балчир Далай ламаас насанд хүрсэн эмэгтэй үрийн хутаг гуйх нь эвгүй юм шиг боловч сүжгийн үйлс тул тэр талаасаа Отгон бат итгэлтэй байлаа. Бурхан Будда Шахьяамунийн ертөнцөд түүнийг төлөөлөн сууж байгаа оройн дээд Далай ламаас адис хүртсэн тул хүсэл санаа нь заавал бүтэж үртэй болно гэдэгт Отгон бат итгэжээ.

Тэртээд Лхасын их захын хөл шуугиан нэмэгдэж мөргөлчид оройн гороондоо гарч байгаа нь илт харагдлаа. Захын тэндээс балба (непал) хачээ (кашмир), жанагуудын (хятад) бараагаа магтан хашгиралдах чимээ тод сонсогдож байлаа.

“Зах дээр очиж хүүхдийн угж, өлгий олж авах юмсан. Өнөөдөр л ийм өлзий буян бүрдсэн өдөр л тийм юм олж авбал зүгээрсэн” гэж Отгон бодсон боловч Чоймчиг гэлэнд хэлж чадсангүй.

- Одоо ч би архаг өвчнөөс салж ёолох ажлаас ангижрах байхаа! гэж Өлзий гэв гэнэт ам нээж хэлээд хоёр гарын алгыг хавсарч наманчлан залбирав. Сүсэглэн итгэсэн байдал царайд нь тунажээ.

- Өө, салалгүй яахав! гэж Чоймчиг гэлэн бувтнав.

- Далай ламтан миний зулайд гараа хүргэх үед л бие минь халуу оргиод их хөнгөрөөд л ямар нэг том хүнд чулуунаас салах шиг болсон. Архаг өвчин минь тонилоод өгөх шиг санагдсан. Одоо ч би илааршиж эхлэв бололтой! гэж Өлзий урам зоригтой ярьж байтал баруун бөөрөөр нь зүү шивэх шиг хатгуулж бүх биений хөлс хүйт даан чийхрав. Гэвч Өлзий түүнийг мэдэгдэхгүйг хичээж биеэ барилаа.

Алс тэртээ уулын оройгоор Лхасын цагаан таснууд эргэлдэн нисч байхыг Өлзий хараад Хар азаргын сүрлэг уулсаа дурсан бодлоо. Эндээс түргэн буцаж төрсөн нутгийнхаа уулсаар хэрэн тэнэж янгир намнан, гүзээнд нь хорхог хийж идэхсэн гэж бодов.

Залуу гэгцэл Санж Далай ламд мөргөн бараалхсан үйл явдлын сонин ертөнцөөс сэтгэлээрээ хагацаж чадахгүй бодлын шувуунд хөтлөгдөн энэ ертөнцийг хэдий нь мартсан тул хажуудаа яваа хүмүүсийн тухай огтхон ч хайхрахгүй байлаа. Хар багаасаа номын мөр хөөж хийдэд шавилан сууж гэгцлийн сахил хүртэх хүртлээ түүний сонсож мэдсэн зүйлийн оргил нь Бурхан шашны ариун голомт Лхас зуу, тэнд залран бурхны хэргийг явуулагч Далай лам, Лхасын нандин шүтээнүүдийн тухай яриа байлаа. Түүний бага насны гайхамшигтай үлгэр нь энэхүү Бурхны орны тухай байлаа. Одоо ийнхүү нүдээр үзэх завшаан тохиолджээ. Үүндээ баясч ядав.

Мөргөлчдийн дотроос гагцхүү Бөхмагнай Далай ламд бараалхсан нь төдийлөн таалагдсангүй. "Далай лам гээд байсан, нялх хүүхэд юм шиг вэ дээ! Бас тэгээд будаагаа

ч идүүлж дуусгасангүй! гэж тэр халаглан бодож явлаа. Уул нь тэрний

бодлоор бол Далай лам гэж ер бусын сүрлэг дээдэс байх ёстой билээ.
Гэвч хүний л адил хүн байсанд нь итгэл дундуур болжээ.

Зургаа. Бэрээвэн хийдийн шавь

Эрдэнэд алт нэг шар
Эдэнд жанч нэг шар
Идээнд уураг нэг шар

Түвдэд номын мөр хөөж очсон монголчууд Бэрээвэн юм уу Сэрээ хийдэд сууж ном үздэг заншил олон оныг дамжин тоггжээ. Тэр ёсоор гэцэл Санжийг Бэрээвэн хийдэд суулгахаар болов.

- Бэрээвэн хийдэд суух нь дээр биз дээ. Богд гэгээний маань хувилгаан анх аравнайлсан хийд юм. Тэгээд миний багадаа сууж байсан газар! гэж Чоймчиг гэлэн шавьдаа зөвлөж хэлжээ. Багшийн үг түүнд хууль болохоор Санж гэцэл дуугүй зөвшөөрчээ. Мөргөлчид ч Бэрээвэн хийд орж тэндхийн нандин шүтээнүүдэд мөргөх цаг болсон тул цөмөөрөө хамт явах болжээ.

Бэрээвэн хийд Лхасаас нэлээд хэдэн саахалтын хол зайтай Гэнпэл уулын өвөрт оршдог байлаа. Тэр хийдийн Гоман дацанд гол төлөв богдын шавь нар сууна. Халхаас ирсэн хүмүүс Самло Камцанд (жасаа) хамаардаг байжээ. Тэд бас Халх мицан болно. Бусад монголчууд тус тусдаа өөр өөр мицанд хуваагддаг тул торгуудууд торгууд, өөлдүүд цохаан, өвөр монголчууд журчүд мицан гэхчилэн хуваарилагддаг байжээ.

Бэрээвэн хийдэд мөргөлчид өглөө эртлэн очив. Жинхэнэ нэр нь Балдан Бэрээвэн буюу үр жимсийн гялалзсан овоо гэдэг энэ хийдэд жимс мод их л олноор ургадаг байлаа. Гэнпэл уулын өвөрт дугуйран орших Бэрээвэн хийдийн баруун урд руу алтан оройтой цогчин дуган, Далай ламын залардаг Галдан Повран хийд бүхнээс өндөрт сүрлэг сайхан харагдана. Зүүн урд руу ухаан тэжээгч орчлон буюу Лосаллин дацан тэрнээс холгүй Дэян, Гоман дацангууд шил шилээ харан

оршдог ажээ.

- Тэр шаргал байшин Богд гэгээний морилон ирэхдээ залардаг газар, Хутагт маань шар хайс, шар өргөөтэй байх учиртай болохоор Бэрээвэн хийдэд түүнд зориулсан өргөөг шар өнгөөр будсан юм гэж Чоймчиг гэлэн шавьдаа хэлээд намхан шар байшинг заалаа. Гэцэл Санж тэр бүхнийг гоц сониуч нүдээр ажиглан харж тогтоож авч байлаа. Онцгой сонин, үнэмшмээргүй хачин аж.

Мөргөлчдийг Бэрээвэн хийдийнхэн их л найрсаг угтлаа. Халх жасааны сангаас хонины гулууз мах нэг, арваад ширхэг бэлээ буюу мантуу, нэг домбо тараг мөргөлчдөд хадгийн хамт өргөн бариад,

- Халх жасаан мөргөлчид та бүхнийг аян замдаа сайн явж ирснийг бэлэгдэж энэ хишгийг өргөн барьж байна. Хүлээн авч соёрхоно уу? гэж бөхөлзөн ёслов. Чоймчиг гэлэн мөргөлчдийн багийн ахлагчийн хувьд тэр бэлгийг хоёр гардан авлаа. Тэр бэлгийг гардан авсан бол Халх жасааныханд хариу өргөл барина гэсэн дохио юм. Үүнийг гэцэл Санжид багш нь өчигдөр орой ярьж өгчээ. Хэрэв тэр бэлгийг авахгүй бол нярав нар нь хэнэг ч үгүй буцаагаад авч явдаг ажээ. Чоймчиг гэлэн нутгаасаа гарахдаа нэлээд бинчинтэй бэлтгэл сайтай байжээ. Хүн бүрд нэгээс доошгүй зоос түгээн өгөхөд түүний түрийвч хотойхгүй гэдгийг сайн мэдэж байсан тул Чоймчиг гэлэн сэтгэл өөг, бардан ажээ. “Өөр юунд зарах вэ” гэж тэр боджээ.

Халх жасааныхан шинэ мөргөлчдөд манз барьж агшаасан будаа, тараг, элсэн чихэр, тосоор дайлжээ. Мөргөлчин Бэрээвэн хийдийн нандин шүтээнүүдэд толгой дараалан мөргөж өдөржин явцгааж эцэж ядарчээ. Гэвч сэтгэл санаа өөдрөг болсон байв.

Орой Чоймчиг гэлэн шавь Санжийн хамт Бэрээвэнд үлдэж бусад нь Лхас өөд явцгаав. Танил ламындаа Чоймчиг шавийн хамт хоноглов. Маргааш өглөө нь түүнийг шавилуулах Гоман дацанд аваачихаар болжээ. Санжийн нойр хүрэхгүй их удтал хөрвөж сэрүүн байлаа. Бэрээвэн хийдийн өлсгөлөн ноход шөнө дүл болтол улин

боргож үе үе хоорондоо агсран архиралдах нь тодхон сонсогдож байлаа. Санжийн сэтгэлд ер бусын бодол эргэлдэнэ. Тэртээ холын мянганы газрыг туулж Бурхны орон гэгдсэн Түвд газар ирэхдээ янз бүрийн юм үзжээ. Алтан оройт сүм дуганууд, мяндаг тушаалт ихэс лам нар, бөөсөө иддэг гуйлгачингууд цөмийг тэр харлаа. Бүх юм Бурхан шашны төлөө зориулагдсаныг ч мөн харжээ. Ихэнх нь үл мэдэхийн мананд хучаастай энэ орчлонгийн мөн чанарыг нэвт ойлгохыг Санж гэгцэл хүсч байлаа. Түүний үзсэн, сонссонд ойлгон ухаарах аргагүй битүүлэг зүйл асар их байв. Үүний цаана гарахын тулд гагцхүү их эрдэмтэй хүн болох, номын мөрийг хоёргүй нэгээр хөөхийг тэр өөртөө андгайлжээ.

...Өглөө боллоо. Бэрээвэн хийдийн цогчин дуганы орой дээрх тавцангаас

- Пээб, пээб, пээб! гэж цангинасан дуутай жаал хүү уянгалан хашгирч эхэллээ. Өглөөний уншлаганд лам нарыг дуудаж байгаа нь энэ юм. Пээб гэдэг бол “морилогтун” гэсэн утгатай.

- Пээб, пээб, пээб...! гэсэн бүдүүн хүний дуун Сэрээ хийдийн цогчин дээрээс мөн л уянгалж байлаа. Хоёр дацан хоорондоо хол боловч бие биеийн цуурайг бүдэг бадаг сонсохоор билээ. Эдгээр хийдийн дацангууд хүүхэд, үүхэд хоёроор дуудлагаа явуулдаг бол Галдан хийдийнх цогчингийнхоо орой дээрх бүрээн шатанд зоосон том хэнгэрэгийг түн түн түнхийлгэн дэлдэж лам нараа хуралд урина.

Тэр дуудлагаар лам нар гэр, хашаанаасаа гарч зүг зүгээс цугларна. Өнөөдөр ч мөн тийнхүү лам нар цугларч эхлэхэд тэдний дунд гэгцэл Санж багш ламыгаа дагаад явж байлаа. Багш лам Чоймчиг нь түүнд бүхий л замыг нь зааж, номын ширээнд нь суулгаж өгөх учиртай байлаа.

Хүрэн улаан орхимж, шар дээлтэй лам нар өнгө хослон аажим зугуунаар намбатай алхалцгааж эрхээ гартаа эмрэн явцгаана. Цогчин дуганы үүдэнд очиж, цөмөөрөө жигдрэн зогслоо. Дуганы орой дээрх

тавцан дээрээс нэг лам Зонховын мэгзэмийг гурвантаа уншлаа. Үүдэнд цугларсан лам нар мөн л түүнийг давтан уншицгааж байлаа. Тэгтэл тарган лухгар биетэй зэсэн хүрэн царайтай цогчин унзад хоёр шамогийн хамт хүрэлцэн ирэв. Үүгээр цөм бүрдэл болсон тул Цогчин дуганы хаалга цэлсхийн нээгдэж лам нар дотогш оржээ.

Гэцэл Санж Буянзалбирах хийдэд арав гаруй жил сууж гэцлийн сахил хүртсэн тул цогчин хуралд суух эрхтэй болсон байлаа. Гэвч бурхны номыг нарийн бясалгаж бүрэн эрдэм төгс лам болохыг тэр л хүсчээ. Зарим зүйлийг давтан сурахад ч муугүй гэж гэлэн Чоймчиг шавьдаа сургажээ. Ер нь ч эхнээс нь эхэлдэг жамтай ажээ.

Цанидын ном үзэж төгсгөн гаарамба болохын тулд арван гурван жил хэрэгтэй байжээ. Санж арван хэдэн наснаас номын мөр хөөж цанидын анхны мэдлэг нэгэнт олж аваад байгаа боловч цанидын номыг дахин эхэлж арван гурван жил үзээд гарахад төдий л өндөр настай болчихмооргүй байх тул юмны захад хүрснийх эхнээс нь тухтай үзэхийг боджээ. Сурвал сурсан юм шиг оролдохыг урьдал болгов.

Цанидын ном таван аймаг саваас бүрддэг. Намдэл буюу самгарьдаар парамана вартика судалж зөв сэтгэхүйн ухаан сууна. Парчин буюу самгарьдаар парамита судалж ёс суртахууны ухаан сууна. Умаа буюу самгарьдаар мадьямика судалж гүн ухаантай болно. Зод буюу самгарьдаар абидарма судалж орчлонгийн мэдлэгтэй болно. Дульбаа буюу самгарьдаар винай судалж ламын сургаальд нэвтэрхий болно. Цанидын энэхүү таван аймаг сав ухааныг судалж өөрийн оюуны саванд багтааж авахын тул арван гурван жилийг зарцуулж хэдэн түмэн мөр шүлэг цээжилнэ. Эдгээр номлол цөмөөрөө шүлэглэн бичсэн зүйл тул цээжлэхээс өөр аргагүй. Бас цээжлэвч утга санааг ухаарахад амаргүй. Иймд цанидын ёгчаа буюу тайлбарыг судална.

Таван ухааны номлол бүрийг судлахад намдэлд дөрвөн зиндаа, парчинд таван зиндаа, умаад хоёр зиндаа, зодод хоёр зиндаа дүүргэх учиртай ажээ. Санж гэцэл намдэлийн хадаг, жумбрай, шидув зиндааг нэгэнт нутагтаа дүүргэсэн байлаа. Хэрвээ хүсвэл эдгээрийг

шалгуулаад шууд юлчан зиндаанд орж болох юм. Гэвч тэгэхийг Санж гэцэл хүссэнгүй. Тэр нь ч зөв болжээ.

Гэцэл Санжийн зиндаанд арван дөрвөн гэцэл оржээ. Ганцхан монгол, Хөх нуурын өөлд нэг, Ховог сайрын торгууд нэг, бусад нь түвдүүд байлаа. Тэгэхдээ бодпа буюу Лхасын Түвдүүд дийлэнх ажээ. Хэдэн амдоба камба, зонба нар байв. Энэ нь бас л түвд хүмүүс бөгөөд гагцхүү амдо (андуу) зон, кам нутгийнх гэдгээ ялгахын тулд тийнхүү өөрсдийгөө нэрлэдэг байжээ. Нэг хачээ гэцэл байв. Хачээ гэдэг нь их амт хэмээн кашмир хүмүүсийг түвдүүд хочилдог үг болой. Өөр дацанд харин хачээ нар олон байв.

Цанидын намдэл үзэх жумбрай зиндаанд ихэнх нь монголчууд байхыг Санж олж мэдээд тэнд ордог байж уу гэж эргэлзсэн боловч түвд хэлээ сайн сурахад дөхөм хэмээн уул сонгосон зиндаандаа сурахаар хатуу шийджээ.

Цогчин дуганд хорин таван тохой өндөр Майдар бурханг балбын дархан урлан бүтээжээ. Мөн Зонховын өөрөө аравнайлсан гэдэг ямандаг бурхны хөрөг байлаа. Гэцэл Санж чойнцам буюу завсарлага болоход Цогчин дуганы тэрхүү нандин шүтээнийг сонирхон үзлээ.

- Энэ ямандагийн дотор нь эвэрт хэлмэрч Ролооцавын шарил байдаг юм. Энэ Ролооцав хэлмэрч нямба хийж олон жилийн намбандаа ямандаг шүглэж толгойд нь эвэр ургатал суусан юм хэмээн гэлэн Чоймчиг шавьдаа сэмхэн тайлбарлав.

“Ролооцав шиг нямбалан хичээнгүйлж суралц” гэсэн захиас болгон түүнийг гэцэл Санж ухаарчээ.

Цогчинд нийтийн хурал өндөрлөмөгц гэцэл Санж сонгож авсан цанид номоо үзэхээр Гоман дацанд очив. Гоман дацангийн үүдэн дээр гурван шон байлаа. Тэдний нэг нь хоосон, хоёрт нь нэг нэг бандийг барьж хүлээд бөгсийг нь гарган гувруутгал нь торлогдож байгаатай гэцэл тохиолдож сүрдэн айв. Хурлын үеэр сахилга алдсан банди

нарыг тэгж, цээрлэл үзүүлдэг ажээ. Тэвэр шахам бүдүүн шонгууд шаргал өнгөөр гялтганатлаа зүлгэгдсэнийг бодвол Гоман дацангийн хуврагууд олон оныг дамжсан уламжлалтай нь илэрхий. Бас тэгээд эдгээр шонгуудыг тэвэрч бархирсан нь тооловч баршгүй болсон бололтой. Шонгийн ёроолд газар нь хүртэл хонхойжээ.

- Сахилаа бат сахиж байвал ийм юм хүртэхгүй л дээ. Шонд уяулж торлогдуулах ч гайгүй зүйл. Харин Гоман дацангийн дигваранзтай - шоронд орвол уу тэр л аюултай гэж гэлэн Чоймчиг шавьдаа захилаа. Дигваранзтай шорон түвд газар цөөн биш юмсанжээ. “Ариун их хутагт бурхад, тэдний оройн дээд нь болсон Далай ламын залран сууж, бурхны үйл бүтээдэг Будалингийн их ордны зүүн доод давхарт хүртэл дигваранзтай нүхэн харанхуй шорон байдаг гэдгийг шавьдаа хэлье байз” гэж Чоймчиг гэлэн бодоод хэлэн дээр нь тэр үг гарч ирснийг түр түдгэлзэн дуугаа хураажээ.

Будалингийн ордны тэрхүү шоронгийн хамгийн аймшигтай нь ямааны ууц, дигваранз хорхойгоор дүүрсэн харанхуй хар нүх юм. Тэрүүн рүү ялтан хүнийг нүцгэлээд шидэж орхидог. Өлсгөлөн хорхойнууд тэр дороо нөгөөх нүцгэн хүнийг тал талаас нь шавж аваад идэж, зулгааж гардаг. Хүн тийнхүү дигваранзанд шавуулаад тун ч их удалгүй амаар нь хөөс цахран амьсгал хураадаг ажээ. Тэр бол үхлийн муу үхэл байдаг болой. Гэлэн Чоймчиг мэддэг бүхнээ шавьдаа ярьж өгч байгаа боловч энэ тухай ярихаас төвөгшөөжээ.

Гоман дацанд гэцэл Санжийн анхны чойдог эхлэв. Намдэлийн хадаг зиндааны чойдог буюу хичээлий нь цаг өдөрт дөрвөн удаа юм. Дундаа хоёр удаагийн чойнцамтай (завсарлага) Өглөөгүүр шогаа чойр, дараа үд дундын үед гүнциг чойр, орой гүрэм чойр болно. Зиндааныхан нь цөм нэгэн ижил хувцастай байлаа. Лхамгой гэдэг тавшгар гутал, мадьяаг гэдэг дотуур банзал, додгой гэдэг цээживч, шамтав гэдэг гадуур банзал, дагам гэдэг хүрэн улаан орхимж, танба эрих чавир тэргүүтэн шасэр малгай, сэнх гэдэг нөмрөг эдгээрийг цөмийг цоо шинээр хийлгэн өмссөн арван хэдэн насны залуухан гэцэл нар жавданд эгнэн сууцгаажээ. Эхний эгнээнд Санж суулаа. Одоо эд

нарыг гэцэл биш харин ловнэрбаа нар гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл сурагчид гэсэн үг. Хэрвээ олигтой юм сурахгүй мангар хүн болох нь мэдэгдвэл тийм гэцлийг довдага болгоно. Довдага бол номгүй, мангуу толгойтонгууд учир хар ажилд голчлон зарагдана. Гэхдээ ламын хувцсаар хувцаслаж явна.

- Миний шавь ч арай нэг лобдага болох хүн биш гэж гэлэн Чоймчиг Санжийг Жавданд нь суулгахдаа чихэнд нь шивнэхэд мань эрийн сэтгэл хөөрч зориг оржээ.

Бэрээвэн хийд бол ирээдүйд шинжигч төрдгөөрөө алдаршсан ажээ. Бас энэ хийдийн гэсгүй нар их баян юм. Учир нь Лхас монлам гэдэг ерөөл унших лам нарын дээд чуулганыг жил бүрийн тэргүүн сарын гуравнаас хорин гурван хүртэл хуруулахад Бэрээвэн хийдийн гэсгүй нар журам сахиулдаг. Тэр олон мянган лам нарын цугларах үед зөрчил, алдас их гардаг тул гэсгүй нар идэвхтэй ажиллаж бүхий л торгууль шийтгэлийн хураамжийг авдаг юмсанжээ. Лхас монламын гэсгүй болохын тулд Бэрээвэн хийдийн лам нар арван гурван мэхээ гаргадаг. Заримдаа гэсгүйн тушаалыг дөрвөн мянган лан мөнгөөр ч худалдаж авдаг байжээ. Гэвч орлого хавьгүй илүү болдог нь лавтай. Хорин мянган лам тус бүрээс ганц лан мөнгө авахад л зарлагаа орлого нь тав дахин давна. Ялангуяа гэлэн сахилгүй лам нар үүнд их дурлана. Учир нь гэлэн сахилгүй гэсгүй бол ял шийтгэл оноох эрхтэй. Гэлэн сахилтай гэсгүй шийтгэл оноож болдоггүй ажээ. Яагаад гэвэл зарим тохиолдолд цаазаар авах ял оноож болно. Тэгвэл гэлэн сахил зөрчиж амьтны амь бусниулж болохгүй гэдэг ажээ. Залуудаа Чоймчиг гэлэн Бэрээвэн хийдэд сурч байхдаа сэргэлэн зан гаргаж нэг удаа Лхасын бага монламд гэсгүйгээр томилогдож овоо баяжсан билээ. Энэ тухайгаа ч шавь Санждаа бас ярьсангүй.

Гоман дацангийн тэргүүн тив лам нь буюу ширээт лам нь шинэ ирсэн шавь нараа айхтар ноцтой шинжин хардаг тийм заншилтай хүн байжээ. Тэр ёсоор бүх л шавь нараа өрөмдөн цоргих мэт харцаар дараалан ажиж байв. Түүний харцнаас дальтирсан хүнд тэр их дургүй ажээ. Тэр тухай Санж гэцэл багшаасаа сонсож мэдсэн тул тив ламтай

харц мөргөлдөхгүйг хичээж байв. Гэвч арга буюу нэг удаа харц тулгарав. Санж нүд цавчихгүйг хичээж тив ламын сормуусны үсийг тоолох гэж оролдов. Нэг бүрчлэн тоолохоор тод харахгүй байсан боловч тоолохыг оролдон нүд рүү нь ширтэж байтал тив лам өөрөө тэссэнгүй харцаа буруулан өөр хүн рүү харжээ.

“Ямар ч гэсэн харцаа дальтируулсангүй. Миний тухай муу юм лав санахгүй байх!” гэж Санж гэгцэл бодов.

Арслант тавцан дээрээ тив лам сүрлэг ихэмсэг суух нь үнэхээр айдас хүрмээр. Цагаан үстэй, улбар шар зогдортой дөрвөн цагаан арслан баруун урд хөлөө дээш өргөсөн бусад хөл нь доошоо тулж байгаагийн дээрх дөрвөлжин тавцан нь гурван саглагар яндартай сэнтий, банримаар чимэглэгджээ. Түүн дээр тив лам алтадсан шовоодой малгайгаа өмсч, ихэмсгээр завилан сууна. Цастын цагаан арслан газар, тэнгэрийн завсарт шашны аливаа дайсныг сүрдүүлэн, унгийг нь үхүүлж, лал болон шулмас тэргүүтнийг номхотгон дарж байгааг билэгдэж ийм арслант тавцан засч өгдгийг гэгцэл Санж сайн мэдэж байв.

“Буянзалбирах хийдийн ширээт ламын сэнтий бас л иймэрхүү билээ. Аргагүй л энэ газраас дэлгэрсэн шажин юм” гэж Санж гэгцэл бодож байлаа.

Дуганд задийн үнэрт хүж унгадаж хөхөмдөг цэнхэр утаа нь тив ламын өмнүүр суунаглаж байлаа. Задийн үнэрээс могой их айдаг болохоор дуганд могой оруулахгүйн тулд задь хольсон хүж хэрэглэдэг юмсанжээ. Хүжинд хольсон задийн үнэр ханхлахад өчигдөр мөргөлөөр явж байхад тохиолдсон явдлыг Санж гэгцэл өөрийн эрхгүй саналаа. Мөргөлчдийн замын хажуухан тал дахь нэгэн том саарал бул чулууны ёроолд могой, гүрвэл хоёр ноцолдож байсан. Гүрвэл нүх рүү гүйн ороход хойноос нь могой хөөж тал бие нь далдарсан. Тэгснээ гэнэт сүүлэн тал нь хий гозолзон ямар нэгэн юманд хазуулан зовох шиг давчдан сандарч их л удаж байж буцаж гарч ирээд чулуун доогуур шургасан.

- Гүрвэл их зальтай амьтан. Нүхэн дотроо дээшээ эгц гарсан хоргодох газар ухдаг юм. Тэр дотроо нуугдаж байгаад өөрийгөө хөөж нүх рүү орж яваа могойг нуруунаас нь хазаж залхаадаг. Могой яаж ч чадахгүй хазуулж, хазуулж аваад буцаж амь тэмцэн гарч зайлдаг юм. Түүнээс биш нүхгүй газар могой, гүрвэл хоёр ноцолдвол урт хайрхан л амтай юм шиг дийлдэг л дээ. Энүүхэн Сэрээ дацан орох замд гүрвэл, могой хоёр их байдаг. Хоорондоо ч их эв түнжингүй амьтад. Гүрвэлийн мах эмэнд ордог болохоор урд цагт багш маань их захидагсан. Тэгээд л би багшдаа гүрвэлийн мах олж өгөх гэж явж л энэ могой, гүрвэл хоёрын чинь таарамжгүйг мэдэж авсан юм. Гүрвэлийн мах тамиржуулахад сайн болохоор могой дурладаг байж болох юм гэж өчигдөр багш Чоймчиг гэлэн нь ярьсныг Санж гэцэл эргэн саналаа. Тэгтэл хөндлөнгийн юм бодож байгаагий нь тааж мэдсэн шиг тив лам нүдээ онийлгон Санж гэцэл рүү муухай харав. Санж харцаа буруулж амжсангүй.

“Их эрдэмт лам гэсэн. Хүний бодож байгаа юмыг хүлээн авч мэддэг юм биш биз. Ер нь алдас болох нь. Өөр юм бодохоо болье” гэж гэцэл Санж бодож биеэ барив. Тэгээд бусдын адил нүдээ хагас аниж уншлагыг үргэлжлүүлээ. Тэр уншлагыг Санж гэцэл аль эрт цээжээр мэдэх тул тийнхүү өөр юм бодох зай чөлөө гарч байжээ. Гэтэл нэг зиндааныхан нь ихэнхдээ тэр уншлаганд муу байгааг Санж чихээрээ мэдэрч, дотроо голох сэтгэл төржээ.

Багш гэлэн Чоймчиг нь зөөлөн сэтгэлтэй хүн боловч Санж гэцэлд ном заахдаа айхтар хатуу, юм л болвол нясалж, торлогдож, шоголдож шийтгэдэг байсан тул сайн цээжилж, дэг журамд сурсан байлаа. Уншлага, тийнхүү өндөрлөх дөхөж байтал гаднаас зэс домбонууд барьсан добдагууд орж ирлээ. Дажаа гэдэг тэнхимийн цай орж ирж байгаа нь энэ. Дажаа өнгөртөл гэлэн Чоймчиг шавиа алсаас харж байгаад гэртээ харихаар явлаа.

Ингэж Буянзалбирах хийдээс ирсэн гэцэл Санж бурхны их хот Лхасын Сэмбэрээгэсум гэдэг гурван их хийдийн нэгэн Бэрээвэн

хийдэд цанидын ном буюу билгэ чанарын ухаан судлахаар ирж Гоман дацангийн намдэлийн хадаг зиндаанд шавилан суулаа. Мэдээ орсон цагаас нь эхлэн энэрэлт эцэг Сайнцогт, элбэрэлт эх Цэндээ нар Санж хүүд эрдэмт сайн лам болохыг мөрөөдөн ямагт сануулан хэлж ятгасаар убаш, банди сахилыг хар багаас нь хүртээлгэж улмаар хийдэд суулган гэцлийн сахил хүртээж билээ. Тийнхүү тэдний санаа амарсангүй. Жагар, Түвдийн оронд хүүгээ явуулж ламын дээд лам болгохыг өдөр, шөнөгүй мөрөөдөж байв. Хөөрхий эцэг, эх хоёр нь өөрсдөө шүтлэггүй, ядуу харцуул боловч лам хүүтэй болох нь нэгэн насны нь ариун дээд хүслэн байжээ. Нээрээ ч лам нар л хүн ардын дотроос эрхэм дээдэс гэгдэж, ламтай төрж, ламтай үхэх нь аз заяа болж байдаг болохоор эцэг эхий нь дээд мөрөөдөл тэр байжээ. Одоо гэцэл Санж эцэг эхийн элбэрэл хайр, ачийг хариулах замд шулуудан орсондоо хязгааргүй баяртай байлаа.

Энэтхэг газраас зээлдэн авчирсан буддагийн сургаалыг Түвдийн лам нар олон үе дамжуулан баяжуулахыг нь баяжуулж, гээхийг нь гээж явсаар өнөөг хүрэхэд олон оны өнгө аяс загасны хайрс мэт давхарлан алагласаар зарим талаар танигдахгүй өөрчлөгдөж, зарим зүйлээрээ чулуужсан амьтны яс шиг болжээ. Сүжигтэн олны сэтгэлийг эзэмдэн барьж байх шинэ шинэ журам, горим тогтож, бурхны номын үг үсгийг ч хүртэл айхтар нарийсган бас ч төөрөлдөхөөс аргагүй тийм бүрхэг юмсаар чихэн дүүргэсэн ажээ. Судлавч барагдахгүй тэр далай их номын ертөнцөд Санж гэцэл сэлэн орлоо.

Долоо. Нас юүлж зуурдаар одов

Оронд орших бэрд хорхой
Биенд орших үхлийн эзэн
Сэтгэлд орших нисваанис

Үй мөрөн бараантан давалгаалж, тайвангүй байлаа. Сарлагийн арьсаар бүрж хийсэн гурван хар завь Үй мөрний хар бараан долгион дээр далбилзан хөвж, дээр нь хоёр хоёроор суусан мөргөлчид зовиуртайгаар ярвайцгаажээ. Давалгаанд завь далбилзан, урсгал сөрөхөд дээр нь суусан мөргөлчдийн толгой эргэж, дотор эвгүйрхэж байлаа. Өлзий, Отгон хоёр нэг завинд суусан тул бие муутай, аймхай нь нэрмээс болж завины хоёр тал руу байн байн бөөлжиж байв. Бөхмагнай хүртэл ярвайчихсан их л тавгүй явав. Их усан дээгүүр завиар явж байгаагүй болохоор тэд аргагүй сандран балмагджээ. Харин Чоймчиг гэлэн, Санж гэцэл хоёр нэг их зовлонгүй аж.

- Ийм юмаар явдгий нь мэдсэнсэн бол Галдан хийдээс Лхас руу зүглэдэггүй л байж. Тоогүй юм боллоо гэж Отгон хүүхэн үглэж явлаа. Өлзий дуугарч чадахгүй элгээ дараад завины ирмэгнээс зуурч сууна. Галдан хийдээс Лхас хүртэл нэгэн сайн өртөө газар тул мөргөлчид голоор явбал дөт гэцгээж ийнхүү тал зоосны хөлстэй арьсан завиар явахаар шийджээ. Өндөр уулнаас буусан Үй мөрөн урсгал дошгин тул бүр ч нэрмээс болжээ.

“Брог- ри галдан намбар жалбийлин” буюу алс уулын амар баясгалант төгс ялгуусан хийд гэгчид мөргөлчид очжээ.

- Сэрдон ченмогийн алтан суварганд мөргөж адис авбал гай зэтгэр чинь нимгэрнэ вий! гэж гэлэн Чоймчиг Өлзийд хэлсэн билээ. Учир нь гэвэл Сэрдон ченмо суварга бол шарын шашныг шинэтгэн бадруулагч Зонхов багшийн шарилт суварга байлаа. Тэрчлэн Зонхов багшийн

ордон Одсэрпуг гэдэг алтан оройтой үзэсгэлэнт сүм байдаг юмсанжээ. Тэрчлэн түүнээс дутуугүй орд харш олон.

Гэлэн Чоймчигийн үгнээс гарахыг Өлзий нүгэл гэж бодсон тул Галдан хийдэд очихоор болжээ. Мөргөлчид Галдан хийдэд хөлсний сарлаг унаж ирээд хоёр хоног өнгөрүүлжээ. Юуны түрүүн Зонхов багшийн шарилт Сэрдон ченмо суварга, түүний Одсэрпуг өргөөнд очив. Галдан хийд бас ид шидтэй маани рилвуу хийдгээрээ алдартай болохоор мөргөлчид хүн бүр баахан маанийн үрэл худалдаж авчээ.

Одсэрпуг ордны нэг өрөөнд Зонхов багштан насан өөд болжээ. Тэр өрөөний ханан дээр Зонхов багшийн зураг байлаа. Өөрөө тодрон гарсан гэдэг домогтой ажээ.

- Бурхан багшийг нас юүлэхэд энэ өрөөнд шавь нар нь гашуудаж “Багштан минь та хаачив аа?” гэж уйлцгаажээ. Тэгтэл энэ ханан дээр Зонхов багшийн дүр өөрөө аяндаа тодрон гарч ирээд “Би энд байнаа” гэж дугарсан юм гэдэг хэмээн Чоймчиг гэлэн тэдэнд тайлбарлаж өгчээ. Өөрөө тодрон гарсан тэрхүү шидэт дүрснээс адис авч байтал Өлзийн бие их муудаж үхэтхийн унажээ. Мөргөлчид цөм сандарч Өлзийг дамжлан хонгилд гаргахад

- Наадахаа гадаа гарга. Маанийн үрлээр ут! Газрын сүрд дарагдаж байх шиг вэ? гэж нэгэн үл таних монгол лам мөргөлчдөд зөвлөжээ. Ингэнэ гэж тэд бас санахаар ч үгүй байв.

- Нээрээ тийм байх. Энэ Галдан хийд их өндөр ууланд байдаг болохоор амьсгаа давхцаад эхэлдэг юм гэж Чоймчиг гэлэн хэлээд тэд цөмөөр гадаа гарчээ. Гадаа хэсэг байлгаад Маанийн үрлээр утсанд Өлзий сэхэн дээрдэж амьсгаа нь давхцахаа больжээ.

Өмнөд оргил буюу Шарце умард оргил буюу Жанце дацанд мөргөлчид очиж үзэв. Зонхов багшийн холбогдолтой бүхнийг орхилгүй үзэж өргөл өргөөд цөмөөрөнгийн сэтгэл ханаж буцах болоход Үй мөрнөөр завь хөлслөн явах санал гарчээ. Тэгээд л ийнхүү

Үй мөрний давалгаан дээр үйлээ үзэж яваа нь энэ. Галдан хийд Зонхов багшийн нутаг, эндхийн хамаг ёсыг Халх Монголд дууриаж байдаг боловч эдний хамба ламаар монгол лам суух хориотой ажээ. Бусад хийдүүдэд монгол хамба нэг бус удаа сууж байлаа. Яагаад Галдан хийдэд монгол хамба хориотой болсон бэ гэвэл урьд цагт Галдан бошигт эцгийгээ хөнөөсөнд хорсож Түвдийг орхиж явсан ажээ. Үүнд дургүйцсэн газрын сүлд монгол хүнийг Галдан хийдийн хамбын ширээнд ойртуулдаггүй гэдэг домогтой болжээ.

Үй мөрний урсгал улам ширүүсч салхи гарав. Завины давалгаанд цохигдох нь нэмэгдлээ. Тэгтэл Өлзийн бие улам муудаж завин дотроо гулдайн хэвтээд амаа ангалзуулан,

- Алтан оройт дацан минь! гэж хэлээд амьсгал хураажээ. Дэргэд нь байсан Отгон айн сандарч,

- Таминь ээ! Яанаа! Өлзий амь тавьчихлаа. Зогсооч ээ! гэж хашгирлаа. Гэвч урсгалын хүчээр явж байгаа завийг зогсоох арга байсангүй. Газарч түвд,

- Гишүү, гишүү! Зогсох аргагүй ээ. Барианы газар зогсоно. Лагсоо, лагсоо! гэж хэлэхээс өөр юу ч хэлсэнгүй.

Өлзий гараараа даллаж, айснаас болж нүдээ томоор бүлтийлгээд үхэж орхилоо. Отгон буруу хараад мэгшин уйлсаар байлаа.

Нөгөө завин дээр суусан Чоймчиг гэлэн хэрэг нэгэнт биш болж Өлзийн бие муудаж амь бие хагацсаныг мэдмэгц аман дотроо “Зуурдын судар” цээжээр уншиж эхлэв. Гэцэл Санж багшийгаа дагалджээ. Нас барагсдад зориулсан уншлага мөн.

Бөхмагнай газарч усч, түвдийн хамт нэгэн завиар түрүүлэн явж байлаа. Гэлэн Чоймчигийн сэтгэл их л гуниг гасланд живжээ. Түүний нутгаасаа дагуулан гарсан мөргөлчний багаас хоёр дахь хүн ийнхүү ертөнцөөс хагацав. Уул нь тэд Бурхны орноо очиж нандин дээд

шүтээнүүдэд мөргөж аврал, буян эрэлхийлж яваа улс юм. Гэтэл ийнхүү зуурдын хагацал үзэв.

Чоймчиг гэлэнг “Зуурдын судрыг” цээжээр уншиж дуусах үед Лхас хотын бараа харагдлаа. Голын эрэгт гармагц Чоймчиг гэлэн, Санж гэцэл хоёр нас барагчийн байгаа завин дээр очив.

“Нүдээ анилгүйгээр, баруун гараар даллан дуудах мэт байдалд нас эцэслэжээ. Бас амаа ихэд ангайжээ. Нэн муу ёрын шинж тэмдэг байна” гэж Чоймчиг гэлэн бодоод асар их цээрлэв. Тэгээд улцан нүдтэй болтлоо уйлсан Отгоноос Чоймчиг гэлэн,

- Амь алдахдаа ямар нэгэн юм хэлсэн үү? Ажиглав уу? гэж асуув. Сүүлчийн үг нь үхэх хүнд их учир утгатай ажээ.

- Мэдэхгүй... гэж Отгон эхэр татсанаа,

- Аа тийм. Алтан оройт дацан минь! гэх шиг болоод амьсгал хураасан гэв. Тэгснээ бас эргэлзлээ.

“Мөн хачин юм даа. Ихээхэн муу ёрын байдлаар өөд болсон байдаг. Гэтэл “Алтан оройтой дацан минь” гэж сүүлчийн үгээ хэлсэн нь сайны ерөөл байдаг” гэж гэлэн эрэгцүүлэн бодсоноо,

- Хүүхээ, Отгоон чи андуу сонсоогүй биз? гэхэд тэр толгойгоо зайлан сэгсэрч,

- Яг л тэгж хэлсэн дээ! гэв.

“Хэрвээ эрдэнийн чимэгтэй орд харш үзвэл тэнгэр нарт дахин төрнө гэж номонд бий. Энэ Өлзий алтан оройт дацан үзсэн бол тэнгэр нарт төрөх биз. Тийм бол ч биднийг хойноосоо далласан байдлаар талийгаач болдог нь муугүй хэрэг. Бас ч учир бий” гэж Чоймчиг гэлэн бодов.

“Эсвэл хар байшин, улаан дацан, цөл газар, хар бартаат лам үзсэнээ андуурч алтан оройт дацан гэсэн юм биш байгаа! Тийм юм үзсэн бол тэнгэр нарын дунд биш харин... тамд төрөх ёстой гэж номд бичээстэй бий. Тэгвэл нүдээ бүлгийлгэж, гараар даллан үхсэн нь үлдсэн бидэнд айхтар муу ёр болно” гэж Чоймчиг гэлэн бас эргэлзэн бодлоо. Буддын ертөнц ийм л уламжлалтай билээ.

“Муу юм бодох хэрэггүй. Сайнаар бодвол зохино. За байз өөр юу гэж төөргийн номонд бий билээ? Аа тийм сайхан хотын бараа үзвэл замбуутивд дахин заяахын дохио гэж байдаг. Энэ талийгаач арай хотын барааг харчихаад алтан оройт дацан минь” гэсэн юм биш байгаа? Тэгвэл үлдсэн бидэндээ ч нэг их халтай юм алга” гэж Чоймчиг бас цааш нь бясалгав.

Бөхмагнай чадал тэнхээтэй, хэнэггүй эр болохоороо амьгүй болсон Өлзийг амьтай юм шиг үүрээд хөлсний шавар сууцныхаа зүг шаламгайлан алхлав. Бусад нь түүний хойноос дуугүйхэн дагалдлаа. “Буянч (яс баригч) олдохгүй байхдаа, хүний нутагт. Одоо тэгэхээр яах билээ. Энэ талийгаач морин жилтэй байх. Тэгэхлээр луутай хүнээр буянч хийлгэлгүй болохгүй. Энэ Бөхмагнай бартай хүн гэдэг. Яавч үүний буянч хийж зохилдохгүй. Яадаг юм билээ?” гэж Чоймчиг гэлэн замын зуур олныг эргэцүүлэн бодов.

Бөхмагнай Өлзийг хүүхэд үүрч яваа юм шиг хоёр гараараа ар нуруундаа шахан наалдуулаад бараг бөхийхгүйгээр хурдан хурдан алхалж Отгон, Чоймчиг гэлэн хоёр түүнийг гүйцэхгүй байлаа. Санж гэцэл Бөхмагнайн хажууд зэрэгцэн явахдаа түүний эрээ цээргүй гүдэс шулуун, бас хачин их тэнхээтэйд нь бахархаж байлаа.

“Талийгаачийг ямар махбодод өгдөг юм билээ? Газар ус, гал, хий, мод тавд л өгөх ёстой доо. Монгол хүн болохоор газраас өөр юманд зохилдохгүй болов уу?” гэж Чоймчиг гэлэн шаналан бодож эхлэв. Газар булах, усанд хийж живүүлэх, хий агаарт дүүжлэн салхиар идүүлэх, эсвэл модны хонгилд хийж орхих ийм таван янзын оршуулга буддын ертөнцөд дэлгэрсэн байлаа. Монголчууд гагцхүү газарт

орхихыг эрхэмлэнэ. Усанд бузар оруулахгүй гэж уснаас бас цэрвэнэ. Хааяа галд хайлуулах нь бий. Агаарт дүүжлэхийг огт үл тэвчинэ. Модгүй тал нутагт модны тухай бас ярьдаггүй байлаа.

- Олзтой өдөр байна! гэж паржигнасан муухай дуутай хүн түвдээр ярихад гэнэт цочиж гүн бодлоосоо хагацаад Чоймчиг гэлэн эргэн тойрныг ажиглавал хар бараан хувцастай гурван донзонпа нар явж байлаа. Тэд Бөхмагнайн үүрч яваа хүнийг хэдий нь үхдэл болжээ гэдгийг хараад л мэджээ. Аргагүй мэргэжсэн нүдээр харжээ. Донзонпа гэдэг бол түвдийн их хотууд, сүм хийдүүдэд элбэг болсон оршуулагч нар юм. Тэд үхсэн хүнийг нохой, шувуунд хувааж өгөх, оршуулах ажилтай улс. Үхэгсдийг нутаглуулах өдрүүдэд тэд бүрэн ажилтай, бусад гаригт ажилгүй тул бүлэглэн явж юм гуйх зэргээр амьдарна. Хэрвээ донзонпа нарт юм өгөхгүй бол тэд ихэд уурлан, өгөөгүй хүнийг үхдэл болоод тэдний гарт очих үед өшөөгөө авна гэж айлган сүрдүүлдэг айхтар хэцүү улс ажээ.

“Донзонпа нар гэж нэг улс байдаг шүү. За ийм аргаар л талийгаачийг оршуулдаг нь зөв. Ербалха дацанд очдог юм уу эсвэл Сэрээд очих нь дээр үү? Сэрээд очих нь дээр. Гэтэл их мөнгө төлнө дөө. Тэнд ямар жирийн харцуулыг хавьтуулах биш. За яахав мөнгө нь ч хамаа алга. Тэртээ тэргүй л буян хийж барахаар шийдсэн хэдэн зоос над бий” гэж Чоймчиг гэлэн дотроо бодлоо.

Тэдний араас гурван донзонпа дагаад эхлэв. Гэцэл Санж, Отгон хүүхэн аль нь ч донзонпа гэдгийг мэдэхгүй тул санаандгүй явж байлаа. Үхэгсдийг тэд хайж олз олдог байв.

- Энийг хэзээ гаргах бол? Маргааш биз дээ! гэж донзонпа нар хоорондоо ярихыг гэлэн Чоймчиг сонсоод сэтгэл нь тавгүй болжээ. Маш хурдан донзонпад мэдэгдсэнд тэр цочжээ.

Удалгүй гэрийн гадаа тэд хүрч ирэв. Гэтэл Донзонпа нар тэднийг мөрдөн дагаж бас л гадаа нь ирэв. Тэгэхээр нь Чоймчиг гэлэн тэдэнд ойртож түвд хэлээр,

- Та нар Ербалхагийнх уу? Сэрээгийнх уу? гэж асуув. Тэд ам булаалдан,

- Сэрээгийнх, сэрээгийн гүшүү минь! гэж монголоор хэлэхэд гэлэн хөмсөг зангидан царайгаа барайлгаж - За тэгвэл та нар маргааш өглөө морин цагаас өмнө ир! Одоо явцгаа гэр мэддэг боллоо гэж тэдэнд хэлэхэд донзонпа нар

- Лагсоо, лагсоо! гэцгээгээд гэдрэг буцав. Тэдний ярилцахыг сонсоод Санж,

- Энэ юун улс вэ, багшаа? гэв.

- Энэ учиртай улс аа. За би орж байгаад чамд ярина гэж багш нь займцуулав. Тайлбарлах цаг биш байлаа.

Тэд байшиндаа орж, дээвэр дээрх тариа хадгалах газар талийгаачийг хонуулахаар шийджээ. Түвд байшин дээвэр дээрээ тариа хадгалах дөрвөлжин хонхорхой зайтай байдаг ажээ. Тэнд талийгаачийг байрлуулахаар бэлтгэж, тэр хэд симхандаа цугларан яаж маргааш түүнийг оршуулах тухай ярьцгаалаа.

- Ийм амархан өөд болчихно гэж санасангүй хэмээн Отгон ихэр татан уйлахад,

- Нэгэнт ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн тул усан нулимс урсгаж зам мөрт нь саад болоод юу хийнэ. Бурхны оронд, тэр тусмаа Зонхов багшийн хөрөгний өмнө нас юүлсэн нь энэ хүний дээд хувь тавилан ч байж мэднэ. “Алтан оройт дацан минь” гэсэн үг сүүлчийнх нь байсан бол тэнгэр нарт ч энэ хүн төрөл арилжин төрж болно. Иймд маргааш ёс төртэй оршуулбал таарна... гэж Чоймчиг гэлэн өөрийн сүжиглэдэг номынхоо үгээр ярихад цөм л чимээгүй. боллоо.

- Бүх юм сайн ёр зөгнөж байна... гэж гэлэн ярьснаа хөмсгөө зангидан

дуугаа нам болгож хэлсэн нь,

- Харин нүдээ нээж талийгаач болсон нь базаахгүй хэрэг. Иймд Отгон чамд хар даавуу, торгоны өөдөс байна уу? Зүү утас байна уу?

Отгон энэ үгэнд цочих шиг болж,,

- Байнаа, багштан минь гэв.

- Тэгвэл нааш нь аваад ир! гэж багш лам тушаангуй хэллээ.

Отгон буйлангаа уудлан хар торгоны өөдөс, мөн утас зүү гаргаж ирэв. Гэлэн түүнийг аваад гурвуул рунханд ханзан дээр байгаа талийгаачийн дэргэд очив. Чоймчиг гэлэн талийгаачийн бүлтийтэл нээлттэй байгаа нүдний анисгыг долоовор хуруугаар доош дарж хоёр зовхийг нийлүүлэхийг оролдов. Хэдэнтээ оролдовч зовхи нь дахиад л нээгдчихээд байлаа. Тэгтэл гэлэн утас зүүг авч талийгаачийн хоёр зовхийг хооронд нь торлон оёж нийлүүлэв. Тэгээд Отгоны өгсөн хар торгоны өөдсөөр нүдийг таглан боожээ.

- Нүдээ нээлттэйгээр, гараа далласан байдлаар юм уу эсвэл амаа ангайж талийгаач болвол муу ёр. Иймд түүнийг өөр байдалд оруулах учиртай. “Бидэргаравын” хорин есдүгээр бүлэгт бий шүү дээ гэж гэлэн Чоймчиг шавь Санждаа түвд хэлээр сурган заасанд юу ярьж байгааг Отгон хүүхэн ойлгосонгүй. Мөн очир зангидан зурсан цаасаар амыг таглан наав.

- Одоо талийгаачийг дээвэрт байрлуулъя! гэж гэлэн хэлэхэд Бөхмагнай талийгаачийг сэвхийтэл өргөөд дээвэрт гаргалаа. Дээврийн хонхорхойд эсгий дэвсээд түүн дээр талийгаачийг хэвтүүлэв.

Гэлэн Чоймчиг, гэцэл Санж хоёр талийгаачийг баруун сүвээгээр нь хэвтүүлж баруун хацар дор гарыг нь оруулж дэрлүүлээд баруун гарын чигчий хуруугаар баруун хамрын нүх рүү таглах маягтай шургуулаад

баруун хөлийг сунгаж, зүүнийг өвдгөөр нь нугалан, зүүн гарыг сунгаж ээрцэг дээр тавьж байрлууллаа. Гэлэн Чоймчиг,

- Эр хүн юм байна. Ингэж оршуулах учиртай. Бурхан Шигээмуни ийм байдлаар өөд болсон юм. Арслан хэвтлэг гэж үүнийг хэлнэ хэмээн түвд хэлээр шавьдаа сурган заажээ.

...Маргааш нь заасан цагт донзонпа нар модон тэрэг түрсээр хүрч ирлээ. Талийгаачийг модон тэргэн дээр эсгий дэвсэн тавьж, өрмөгөөр бүтээгээд Сэрээ хийдийн зүг явцгаалаа.

- Сэрээ хийдийн зүүн урд толгой дээрх ариун чулуунаа аваачиж тас шувуунд түгээхээс биш. Чи тийм оршуулгын тухай мэднэ шүү дээ. Би чамд ярьж байсан гэж Чоймчиг гэлэн шавь Санждаа түвдээр ярив. Санж түүнийг ойлголоо.

- Багш минь тэнд чинь ихэс дээдэс, баячуудыг авдаг. Ядуу хүний хөрөнгө буян хүрдэггүй гэсэн биз дээ. Мөнгө тань хүрэх юм уу? гэж Санж багшаасаа асуув. Тэр хоёр түвдээр ярьж байлаа.

- Мөнгө их төлнө. Гэвч яах вэ? Багш нь тэртээ тэргүй буян хийх гэж л гарсан юм. Энэ талийгаачид зориулаад цаана нь бас ч юм үлдэх бий. Санаа бүү зов. Донзонпа нарт ч төлөх юм юу шалих вэ? гэж багш шавиа тайтгаруулав.

Урьд шөнө багш шавь хоёр тэрхүү талийгаачийн оршуулгатай холбогдсон юмсыг ярилцаж ойлголцжээ.

Болзсон цагаасаа өмнөхөн тэд оршуулгын газар ирлээ. Бяцхан болдог дээр дөрвөн давхар олбог тавьсан мэт үетсэн зузаан хавтгай чулуу байлаа. Өглөө эрт байсан болохоор хүн цөөн бололтой. Донзонпа нар тэргээ түрсээр чулуунд ойртон очлоо. Тэгтэл тэр чулуун дээр нэгэн чармай нүцгэн хүн өөд уруугаа өнхрөн хөрвөж байв. Отгон түүнээс ичиж нүдээ таглав.

- Зүгээр, зүгээр. Энэ ариун чулуун дээр талийгаачийг хэсэглэж тас шувуунд хувааж өгдөг юм. Амьд хүн нүцгэн биеэр энэ дээр хөрвөөвөл нас уртасдаг гэдэг юм. Жирийн хүнд энэ чулуунд амьдаар хөрвөөх нь бүү хэл, үхсэн хойноо ч энэн дээр хэрчүүлэх хувь тавилан олддоггүй юм. Далай лам өөрөө ч энэ чулуун дээр нүцгэн хөрвөөж ирсэн уламжлал бий гэж гэлэн Чоймчиг тайлбарлаж Отгон хүүхнийг тайвшрууллаа. Гэвч тэр нүүрээ тагалсан хэвээр.

Олон түмэн хүний мах, цус хуваасан энэ чулууны дээд тавцан нь гөлийтөл элэгдэж, тос нэвчээд гялтганасан хар хүрэн өнгөтэй болчихжээ. Ёроол хавий нь газар цус, өөхөнд нэвчээд хар хүрэн өнгөтэй хүдэр шиг бамбалзуур болжээ.

- Энэ чулуу Жагарын орноос өөрөө нисэн ирж энд байрласан гэдэг домогтой юм. Энэ хавьд өөр чулуу байхгүйг үзвэл ортой л домог биз. Ербалха дацанд бас ийм чулуу бий. Тэгэхдээ энэнээс бага гэж Чоймчиг гэлэн Отгонд ярив.

Оршуулгын чулуун дээр хөрвөөгч нүцгэн эр хэнэг ч үгүй босоод олны нүдэн дээр хувцаслав. Шүр сувд зүүсэн хЬргой торгон дээлтэйг бодвол их л баян хүн бололтой.

Чулуу тийнхүү чөлөөтэй болоход гэлэн Чоймчиг урьдаас мөнгө төлж, зөвшөөрөл, дугаар авсан ёсоор талийгаачийгаа хуваагч донзонпад тушаах болов. Донзонпа нарын ахлагч нь урт иштэй сүртэй том балиус хутга барьжээ. Түүний ишний унгинаас олон арван хадаг зүүсэн нь хөх сарлагийн сүүл шиг саглагар юм болсон байлаа. Гэлэн Чоймчиг бас нэг хадаг түүнд уяж өгчээ.

Дүртодын орон буюу оршуулгын энэ газар Жагар орноос өөрөө нисэж ирсэн гэдэг домогт чулуун дээр биеэ хэрчүүлэн Цастын орны тасын хоол болохыг хүн бүр хүсдэг тул зав зайгүй байдаг ажээ. Сүүлдээ их зарлага, өндөр үнэ, тусгай дугаартай болсон тул хэр баргийн хүн ч энд замаа төгсгөх бололцоогүйд хүрчээ. Донзонпагийн ахлагч чулуун гамбанзныхаа дэргэд хутгаа барин хоёр хөлөө алцайлган сүртэй

зогсож, туслах донзонпанууд нь талийгаач Өлзийг хөл гараас нь дамжлан чулуун дээр тавив. Бас нэг донзонпа асар их утаа баагиулан сан тавьлаа. Тэр утаанаар тас шувуунууд нисэн ирдэг ажээ. Тас ирмэгц үхдэлийг хувааж өгнө.

Ахлах Донзонпа нүд ирмэх зуур хутгаа гялалзуулан Өлзийн шарилыг тасчиж бөөн бөөнөөр нь тэнгэр өөд шидэлж эхлэв. Том жижиг, бор цагаан өнгөтэй таснууд түүнийг газар унагалгүй шүүрэн авч нисэн одож байлаа. Зарим тас өөр хоорондоо булаацалдан янцгаах мэт дуу гаргана. Үүнд Отгоны бие арзасхийж байлаа. Өөр нэг донзонпа балт сүх барьж талийгаачийн яснуудыг чулуун дээр тар няр хийлгэн няцалж өгнө. Дээш нь шидсэн ясыг ч таснууд шүүрэн авч одож байлаа. Түвд орны Лхас зуугийн тас бол ингэж олон арван жил хүний махаар хооллосоор байгаад гэрийн тэжээмэл шувуу шиг болчихжээ. Чухам юу болж байгааг ухаарч амжаагүй байх хооронд талийгаач Өлзийн биеийг донзонпа нар хуваан түгээж тас шувууны хоол болголоо. Чулуун дээр бараг юу ч үлдсэнгүй. Тэнд бялтсан цусыг ахлах донзонпа хутганыхаа ишний ар унгинаас зүүсэн хадаг яндрын үзүүрээр арчин цэвэрлээд дуусгавар болгож чулуунаас холдож Чоймчиг гэлэн рүү айсуу явлаа. Тэдний орыг өөр нэгэн талийгаач эзэлж, өөр донзонпанууд ажилдаа орлоо. Дуртодын тэр газар дайнд бэлтгэж байгаа юм шиг олон тооны модон тэрэг ярайн эгнэж ээлжээ хүлээцгээж байгаа харагдлаа. “Хэдүйдээ ийм их олон амьтан цугларчихдаг юм бэ? Аймаар солиг оо! “гэж юунд ч хэнэггүй байдаг Бөхмагнай энэ удаа аргагүй сэтгэл гансран боджээ. Донзонпа нарт хөлсөө төлөөд тогтсон заншил ёсоор домбо цай, шар тостой арвайн гурил нэгэн зампар дүүрэнг өгөхөд тэд бараг гараа ч угаасан юмгүй шууд л оршуулгын талбай дээр завилан сууцгааж гурил зууран идэж цайнаас ууцгааж эхлэв.

Чоймчиг гэлэн Отгон хүүхний сэтгэлийг засч,

- Тас бол тэнгэрийн шувуу болохоор одоо манай талийгаач Өлзий тэнгэрт одох нь энэ боллоо. Ум маани бадмихун! гэв.

Отгон хүүхэн урьд өмнө нь ийм хачин оршуулга үзээгүй болохоор сэтгэл их л гансран гуниж юу ч гэж хэлэхээ мэдэхгүй, дуугаа хураасан байлаа. Харин Бөхмагнайд бол ингэж амьтны хоол болон хэрчүүлж дуусах нь аймаар эвгүй мэт санагдлаа. Газар газрын ёс заншил өөр болохоор “Сохрын газар сохор, доголонгийн газар доголон” гэсэн ардын сургаал гарчээ. Тас шувуунд хэрчиж өгөхийг тэнгэрт гарах дөт зам гэж Түвдүүд итгэн биширдгээс ийм заншил дэлгэрчээ. Хятадууд болохоор амыг нь барьж үхүүлбэл сүнс нь амаараа гаран зайлахгүй сайн гэж хүний амыг барьж алах ял бий болгожээ. Гэвч эцсийн дүн нэг гэдгийг Чоймчиг гэлэн сайн мэдэж байлаа.

Найм. Хорин мянгатын ерөөл

Орчлон гаслангаас нөхцөгсдөд алагдана

Зовлон их амгалан сахилд алагдана

Амгалан билэг сэтгэлд алагдана

Лосар буюу шинэ жил ойртож байлаа. Айлууд чимараа хийцгээж, сүм хийдүүд их, бага монламд бэлтгэж байв. Цагаан сар дөхөөд ирэхэд түвд айлууд замбайн гурил, арвайн нэрмэл архи бэлтгэж эхэлдэг заншил түгээмэл билээ. Зэс цар таваг, замбайн гурил товойлгон цац хэлбэртэйгээр овоолж, дээр нь шар тосоор урлаж хийсэн цэцэгтэй дэрс хатгаж бэлтгэсэн идээг чимар гэнэ. Шинэ жилийн идээ юм. Сүм хийдүүд их, бага монлам гэдэг Далай ламын шавдан бататгах ерөөлийн хуралд урьдаас бэлтгэдэг бөгөөд хорин мянган лам оролцоно.

Гэлэн Чоймчиг Лхас монламд оролцож хурахын тулд олон хоног хөөцөлдөж их ч мөнгө заржээ. Түүний нэг том хүсэл тэр байв.

- Энэ жилийн Лхас монламд заавал оролцох ёстой. Далай баламын шавдан бататгах их ерөөлийн хуралд би дахиад оролцож чадахгүй, ямар боловч хорин мянгатын тоонд оролгүй горьгүй гэж Чоймчиг гэлэн шавьдаа захижээ.

Нутгаасаа дагуулж ирсэн мөргөлчдийг намар буцаажээ. Отгон хүүхнийг Бөхмагнайн хамгаалалд өгч өөр нэг хэсэг мөргөлчдийн галтай нийлүүлэн нутаг руу нь цагийн эрт, нарны голтой, ногооны сөлтэйд буцаасан нь сайн болжээ. Түвдэд энэ жил их хүйтэрч байлаа. Мөргөлчид буцсанаас хойш Санж гэцэл Гоман дацангийн намдэл хадаг зиндаандаа номоо үзэж, Чоймчиг гэлэн буяны үйлсийнхээ мөр хөөж, ихэс лам нартай уулзан, бурхны ариун шүтээнүүдээр явж эргэл мөргөл үйлдэж байсаар одоог хүрчээ. Багш лам нь бүх насаараа

цуглуулсан хөрөнгөө алт мөнгө болгоод өвөрлөж ирсэн тул буяны үйлэнд баруун зүүнгүй зарсаар л байлаа. Чоймчиг гэлэн,

- Лхас монламын гэсгүй болоход дөрвөн мянган лан мөнгөөр гар цайлгадаг юм. Би зөвхөн уншлагын ламаар орох тул тийм их мөнгө арай шаардагдахгүй биз гэж нэг өДөр шавьдаа хэлжээ.

- Би шинэ багшаасаа гуйх уу? Манай шинэ багш намайг зиндаандаа ганцхан монгол гээд их л хайрлаж байх шиг санагддаг гэж Санж гэцэл хэлэхэд,

- Өө, юу хийх вэ? Багш нь өөрөө л аргалахыг бодно. Би эндхийн лам, хар, зарц туучий нарыг аль алинг сайн мэддэг юм. Аргы нь олох байлгүй гэж Чоймчиг гэлэн тайвнаар ярив. Түүнээс хэд хоногийн дараа багш лам нь Лхас монламд хурах эрх олж авчээ. Чухам ямар аргаар олсноо шавь гэцэлдээ хэлсэнгүй. Гэцэл ч асуусангүй. Багшийн хэрэг шавьд хамаагүй.

Ло сарын эхний хорь хоногт Лхасын их монлам гэдэг ерөөлийн хурал, хоёр дахь бага монлам нь оны тэргүүн сарын 24- ний өдрөөс арав хоног хурдаг ажээ. Их монлам эзэн хааны шавдан бататгахад, бага монлам Далай ламын нас сүүдрийг уртасгахад зориулагддаг юм.

Их монламыг хуруулах ажлыг удирдан хийлгэхийн тулд Бэрээвэн хийдийн хоёр цогчин шамо, тэдний туслах хоёр шабдэгмаа, нэг аж ахуй түлээ түлшний нярав, түүнд захирагдах хорин нэгэн гээг буюу гэсгүйг сонгож дөрөвт нь төмөр бэрээ олгодог ажээ. Санж гэцлийн шинэ багш нь тэрхүү хорин нэгэн гэсгүйн тоонд оржээ. Тэгээд шавь гэцлийгээ Лхас монламын донгочин болгохоор гуйж бас бүртгүүлж амжжээ. Донгочин гэдэг нь манж, цав зөөдөг нэг ёсны хоол зөөгч юм.

- Буянтай үйл. Зөв. Түүнд оролцвол зохино гэж гэлэн Чоймчиг шавьдаа захилаа. Тэр ёсоор гэцэл Санж Лхас монламын донгочны тоонд орлоо. Багш лам нь ч баяртай байлаа.

Хорин мянган ламд нэгэн зэрэг манз, цав барих тул олон тооны донгоч шаардагддаг байжээ.

Цагаан сарын өдрүүд ойртоход донгоч нарыг дуудан цуглуулж өөр өөрсдий нь тогооны газрыг зааж өгөв. Тэгтэл жамаагийн лам дутсан тул Санжийг жамаа болгов. Жамаа гэдэг нь тогооч юм. Нэг тогоонд дөрвөн жамаа оногдлоо. Асар том хүрэл тогоог асар дотор газарт зоожээ. Нэг тогоо хоёр мянган ламыг хооллох юм гэнэ. Бүгд арван том хүрэл тогоо эгнүүлэн зоосон том модон асар доторхи талбай нь Лхас монламын гал тогооны газар байлаа.

Маргааш битүүний өдөр болно гэж байгаа тул тогооч нар ажилдаа оржээ. Хоёр мянган ламын хоол багтах тийм том тогоог зөвхөн усаар дүүргэхэд л хорь хоног ормоор санагдах тул Санж гэцэл ихээхэн зовинолоо. Гэтэл тогоо бүрийн амсар луу чулуугаар доторлоод асрын хаяагаар нүхлэн оруулсан суваг шуудуу татсан байлаа. Тогоог газрын хөрстэй амсар нь бараг чацуу байхаар газар зууханд зоож шигтгэжээ. Шуудуугаар ус гүйлгэхэд тэр нь хүрэл тогооны амсар руу дуу шуугиантай урсан орж эхлэв. Ус гүйлгэхээс өмнө модон шат тавьж тогоон дотор ороод ёроол дахь шаарыг цэвэрлэв. Тогоонд усыг урсган оруулж заасан хэмжээнд нь хүргээд будаагаа хийлээ. Ишнээс нь урт олс уясан хоёр хүрзийг тэдэнд тавьж олгожээ. Халбаганы оронд хүрзээр тэр будааг хутгах ёстой гэнэ.

“Энэ том тогоотой юм хичнээн хонож байж буцлах бол? Дэмий л тогооч боллоо. Анхнаасаа тэр цай зөөгч нь дээр байжээ. Одоо яаж ийм их хоолыг бэлтгэнэ дээ” гэж Санж гэцэл санааширчээ. Гэвч нөгөөдүүл нь урьд бас жамаагаар ажиллаж байсан туршлагатай залуус байв. Хэд хоног цатгалан байхыг тэд хүсчээ.

- Удахгүй орой тийшээ буцална. Гэхдээ наалдуулахгүйн тул нэг хоёроор хутгаж байлгүй болохгүй гэж ахлах тогооч хэлэв. Яаж хутгадаг юм бол гэж Санж гэцэл гайхаж байсан чинь тогооны гол руу хоёр хүрзээ босоо зоогоод хоёр нь барьж нөгөө хоёр нь хүрзний ишнээс бэхлээтэй олсноос хоёр тийш татаж нааш цааш нь чангааж

хоолоо хутгадаг юм байжээ. Тэрчлэнгээр үе үе хутгахын хамт сарлагийн махыг том том хэрчиж будаанд нэмээд буцлахаас нь өмнөхөн үзэм, элсэн чихэр хольжээ. Тэгээд харуй бүрий болохын үед нөгөөх будаа буцлах шинж оров.

- За одоо л аюултай. Хамгийн их хутган холих цаг ирлээ гэж ахлах тогооч зааварлав.

Хоёр нь хүрзийг тогооны ёроол хүртэл шааж, хоёр нь олсоор нааш цааш татаж сэлүүрдэх мэтээр хутгаж зогсоо зайгүй ажиллав. Хөлсөө цувруулан аахилцгааж тогоотой будаанд зав чөлөө өгөхгүйгээр хутгаж байлаа. Шөнө дүл болж байхад тэд хутгасаар л байлаа. Тэр үед шар тос авч ирэв. Шар тосыг будаанд жигд шингээхийн тулд дахиад л хүрдэн хутгах ажлаа сэргээн зогсоо зайгүй ажиллалаа. Бусад тогооч нар мөн л адилхан байлаа. Харин тэднээс холхон өөр нэг модон гэрт байгаа цайч нарын ажил арай хөнгөн болохыг гэгцэл Санж мэдэж авав. Цай бол будаатай хоол шиг хольж хутгах шаардлагагүй юм байлаа.

Өглөө үүрээр тэдний хоол цай бэлэн боллоо. Хоол, цайны амтыг шалгах ажлаар хоёр шавдэгмаа үүрээр ирээд тогоо бүрээс гурван талаас нэг нэг халбага авахуулж амсан үзэцгээв. Тэд тамшаалан үзэж, ярвалзан маяглаж тогоо бүрийг шалгаад дундах их тогооны хоолыг голж хоёр ч залуухан жамааг тогооны нь дэргэд нэвширтэл зодов. Ашгүй Санж гэгцлийн тогоотой хоол гологдсонгүй. Дөрвүүлээ ихэд баярлаж хоолноосоо нэг нэг аяга идэв.

...Лхас хотынхон гудамжаа цэвэрлэн хог новшноосоо салж, айлууд гэртээ мөн л цэвэрлэгээ хийж Лхас монламын захиргааг хотод морилон ирэхийг хүлээцгээж байлаа. Зарим гудамж асар их хогтой тул цэвэрлэж бараагүй байтал монлам ченмогийн захирагсад хүрэлцэн ирлээ. Алаг эрээн гоёмсог худрага, чимэг унжлагатай морьд унасан цогчин шамо, тэдний туслах шавдэгмаанууд, гээг, гэсгүйн хамтаар морилон ирцгээлээ. Аль байдгаараа гоёсон тэд Будалингийн ордонгоор юуны түрүүн орж Далай ламын амрыг айлтгаж, мөргөл үйлдэв. Дараа нь ордноос гарч хотыг эргэхээр явцгаалаа. Хоёр шамо,

шабдэгмаа нарынхаа хамтаар морин дээр бусад нь урт гэгчийн саваа барьцгааж хойно өмнөө орцгоон явахдаа их л сүртэйгээр,

- Паажуужий! Паажуужий! гэж хашгиралдаж байлаа.

- Замаас зайлцгаа! гэсэн тэр сүртэй тушаалыг сонссон хүмүүс годхийн зугтааж байв. Эд нар Лхас хотод цагаан сарын өдрүүдэд хорь хоног мөн гуравдугаар сарын сүүлчээр арван нэгэн хоногийн турш Лхасын бүрэн эрхт эзэд нь болдог учир эвгүйхэн тохиолдсон хүнд баа шийтгэл тохоож орхидог эрхтэй юмсанжээ. Тэд хот дундуур эргүүл маягтай явж хүмүүст сургаал өгч, жавтий хүртээж, бараг өдөржин яваад орой буцна. Ингэж Лхас монлам гэдэг ерөөлийн их чуулган эхэлдэг ажээ.

Эхний өдөр Будалин ордны орой дээрээс гурван шалмаг ламыг олсоор дамжуулан газар буулгах ёслол болдог тул Санж гэцэл нөхдийнхөө хамт Будалын ордны өмнөд талбайд очив. Тэнд олон зуун хүн цугларчээ. Будалын ордны орой дээрээс доош нь бүдүүн олсыг унжуулан татаж ордны үүдэн тушаа газарт байгаа чулуун багананд нөгөө үзүүрийг бэхэлжээ. Илгэн хормогц өмсч, хөмөн бээлий гартаа хийсэн гурван залуухан эр Будалын оройгоос олсыг даган гэдсээрээ доош гулгаж эхлэв. Хүмүүс амьсгаа даран ширтэж байлаа. Доошлох тусам улам хурдалсаар газар пирхийх чимээ гаргаж хойно хойноосоо тэд бууж ирэв. Элгэдэн гулгасан тул тэдний хормогчноос хиншүү ханхалж байлаа.

- Ингэж буусан хүмүүс нэгэн жилийн алба татвараас чөлөөлөгддөг юм! гэж Санж гэцэлд нөхөд нь тайлбарлав.

- Голдуу зан мужийнхан л үүнийг хийдэг юмдаа гэж бас нэг нь сонирхуулан хэлэв.

...Маргааш өдөр нь хорин мянган лам Их зуугийн сүмд жигдрэн цугларчээ. Бүгд суудлаа эзэлсэн нь улаан долгионтой шар далай шиг ер бусын сонин ажээ. Манз зөөх замаа заалгаж яваад Санж гэцэл

түүнийг харж машид сэтгэл догдолж, хэзээ энэ хорин мянган лам нарын дунд өөрийн суудлыг олж эзлэн суух бол, тийм цаг ирэх болов уу гэж бодлоо.

Журам сахиулагч гэсгүй нар болон шамонууд төв суудлын эгнээний хоорондуур нааш цааш явна.

Нэгэн сүрлэг шамо Лхас монлам хурах жаягийг өндөр дуугаар уншин сонсгов. Жаяг зөрцвөөс хатуу шийтгэх тухай дахин сануулав. Их зуугийн баруун хаалганы тотгон дээр асар хүнд цул төмөр бэрээ тавиастай байдаг. Нүгэл хилэнцтэй юм уу эсвэл жаяг алдагдуулсан ламыг хаалгаар гарах гэж явах үед нь тэр бэрээ гэнэт хөдлөн доош унаж нүгэлт эрийн гавлыг хагалан цээрлүүлдэг гэдгийг ч дахин бас сануулав. Үнэхээр хоёр хүн дамжлан өргөхөөр хүнд цул төмөр тэр бэрээ нь монламын үеэр тотгон дээрээс ойчоод гарах гэж явсан хүний дагзыг хагалсан удаа хэд хэд гарчээ. Бас монлам тарахад хорин мянган лам нар гадагш гарах гэж чихэлдэн явахдаа бие биенээ дарж амь насыг нь дуусгадаг ч хэрэг энд нэг бус удаа гарчээ. Иймд жаяг сахиулахыг их чухалд үздэг байлаа.

Лхас монлам эхэлж хоёр түмэн лам нэгэн зэрэг уншлагаа дүнгэнүүлэхэд их зуугийн хөндий дээвэрт өргөн танхимд тэнгэр аажмаар нүргэлэн дуугарах шиг, эсвэл олон арслан барс цээжиндээ хүржигнэн хүрхрэх мэт сүртэй дуун дэгдлээ. Лам нарыг ян татахад бие доргимоор их дуу гарч байлаа. Энэ сүрлэг үзэгдэл гэгцэл Санжид мартагдашгүй сэтгэгдэл төрүүлэв. Лам нарт манз зөөхөөр гүйж явахдаа хоёр түмэн ламын хоолой нийлүүлсэн ерөөлийн үгэнд газар дэлхий доргиж байх шиг болсныг тэр ажиглан мэдэрчээ. Ийм олон лам нэгэн дор хуран цугларч уншлага үйлдэж байхыг хэзээ ч үзээгүй залуу гэгцэл бурхан шашны зан үйлийн агуу далайцыг мэдрэхдээ гайхан бахархжээ.

Тийнхүү хорь хоногийн уншлага хийж, хорин мянган ламын ерөөл авахуулснаар эзэн хааны болон Далай ламын шавдан батад оршино гэдэгт бас л бүрэн итгэдэггүй байжээ. Иймд мөн сарын хорин

дөрөвний өдөр хоёр дугжив буюу жаран ирмэгт том сор залах ёслол хийдэг ажээ. Хорь хоногийн уншлага нь лам нарыг байтугай цай, хоол зөөгчдийг ядрааж орхижээ. Лам нар болохоор ерөөлийн хаан уншиж залхаад монламын хатуу дэглэмд ядарчээ. Манзач, цайч нар болохоор эгнэн суусан лам нарын хоорондуур домбо, данх барин гүйж, шамо гэсгүй нарт бэрээдүүлчихээс айж тун ядарч байж хорь хоногийн турш нэгэн аялгуут дүнгэнээн дунд дөжирч гүйцжээ.

Ашгүй хурлын өнгө аяс өөрчлөгдөж дүгжив залах ёслол эхлэхэд лам, жамаа, манзач нар цөм л баярлацгаалаа. Гурвалжин өндөр босоо цац хэлбэртэй сорыг бэлтгээд сорч егзөр нар өргөн гадаа гарч дүрэлзэн асч байгаа түүдэг галын дэргэд очиход хойноос нь олон мянган лам нар цувран амандаа сорын уншлага дүнгэнэтэл бувтнацгаан явав. Дүгжив залах ёслол нь шашны элдэв дайсан, буруу номтон, лалнуудыг дарах зан үйл юм. Тос, гурилаар чимэглэж оройн шовх үзүүрт хохимой толгойн дүрс доод талын гурван өнцөгт мөн хохимой дүрсэлсэн тийм сор байлаа. Тэхий дундуур нь хадаг зүүсэн сум хатгажээ. Сумныхаа өдөн залуур тушаа бяцхан хүрдний дүрс бэхэлжээ. Шашны дайсан, лал гэгч буруу номтон, альбин чөтгөрийг төлөөлж ийм сор бэлтгэдэг ажээ.

- Егзөр би сор залсугай! Аймшигт энэхүү сор болбол очирын сумнаас хурц, очирын булцуунаас бат, егүүтгэгч хүч нь цахилгаанаас илүү... гэж егзөр лам гуншин уншиж эхлэв.

Ингэж уншихад нь сорч лам нар сорыг толгой дээрээ өргөн хурайлан эргүүлэв.

- Егзөр би сор залсугай! Дээрх тэнгэр, доорхи лус, газар тэнгэрийн савслага дахь альбинуудад газар усны эздэд энэ сорыг залж байгаа юм бишээ! гэж егзөр лам дахин сүртэйеэ айлдахад сорч лам нар сороо дахин эргүүлцгээлээ.

- Егзөр би сор залсугай! Аймшигт энэхүү сорыг сэтгэл үймүүлэгч буг, гай түйтгэр, хорт лалнуудад зориулан залж байнам! гэж егзөр ламыг

хашгирахад сорч лам нар хэдэнтээ цовхорцгоогоод сорыг эргүүлэн оройгоор нь гал руу чиглүүлэн дошгин ууртайгаар шидлээ.

- Егзөр би аймшигт сорыг залсугай! Аймшигт энэхүү сорыг би залан орхилоо! Хаалгачид үүдээ нээцгээ! Хаалгачид үүдээ нээж лалын хувцас өмссөн бүхнийг оруулан түгжлээ. Хаалгач нар хамаг бүх нүх сүвийг хаагтун! Хаалгач нар хамаг бүх дүрсгүй гай түйтгэрийг түгжин хааж өчүүхэн нүх сүвийг ч бөгөллөө! гэж егзөр лам өндөр дуунаар шүлэглэн хэлснээр сор залах ёслол дууслаа.

Тэгтэл сор залахыг үзэхээр ирж цугларсан олон ядуус, мөргөлчид, бадарчид бужигналдаж сорын шатаж байгаа түүдэг гал руу ухасхийн дайрцгаалаа. Сор шатаасан үнс чандруу, үлдэгдлээс олж авах юм бол амь насанд өлзийтэй, аливаа өвчинд хэрэг болно гэж итгэцгээдэг болохоор атга чимх үнсний төлөө тэгж улайран дайралцдаг ажээ. Чимх үнсний хойноос бөөн хөл хөөрцөг дэгдэж сүүлдээ зодоон үүсэж үнс, цучил бужигнан, ядуус дээр дороо орж учрыг нь олоход бэрх юм дэгдлээ. Сорын гал ч унтарч утаа манаран уугилаа. Дорой ядуу мөргөлчдийн зарим нь олны хөл дор дарагдан гишгэгдэхийг хараад гэцэл Санжийн зүрх өвдөх шиг боллоо. Нэг ядуу мөргөлчин хатингар гартаа чимх үнс атгаад олны хөлөөс зайлах гэтэл өөр нэг хүн түүн рүү дайрч, гараас нь зууралдав. Тэгтэл гуйлгачин атгасан үнсээ ам руугаа хийж хахаж цацан нулимсаа асгаруулахыг Санж гэцэл нүдээр үзэв. Тэрнийг бараг л хахаж үхдэгийн даваан дээр “Пүн пүн” гэсэн асар их дуу чимээ гарч цөмөөрөө цочин тэвдлээ. Үхэр буугаар буудаж байгаа ажээ.

Үй мөрний цаад талд Будалын ордны эсрэг орших хар уулын энгэр дээр сарлагийн хялгасаар нэхсэн өрмөгөөр хийсэн хар майхан дэрвэж байв. Тэр майхныг бай болгон чиглүүлээд Будалын ордны өмнө этгээдээс зэс гунан буугаар буудаж байгаа нь энэ. Тэр ууланд Ландарма хааны булш байдаг юм. Буддын шашныг Түвдээс ул үндэсгүй болгон устгаж арилгахаар оролдсон тэр Ландарма хааныг буддын шашинтангууд үзэн яддаг болжээ. Уул нэр нь Дарма боловч “лан” гэдэг хараалын үгийг нэрний нь урд залгаж Ландарма буюу

Дарма- мал гэсэн утгатай болжээ. Мал гэж хочлогдсон тэр хааныг гүвдүүд хорлож алжээ. Тэгээд шарилыг энэ ууланд оршуулсан юм. Тэгтэл оршуулсан хойно ч Ландарма хаан Буддын шашинд заналхийлсээр байдаг юмсанжээ. Тэгээд л жил бүр тэр Ландармын шарилтай уулыг үхэр буугаар бууддаг болжээ.

- Би чамд ярьдаг байсан. Тэр ууланд байгаа хар майхан дотор цагаан ямаа уяатай байдаг юм. Ямааны хүзүүнд таринадсан сахиус зүүлгээтэй бий. Үхэр буугаар тэр майхныг онох гэж буудаж байгаа хэрэг. Оновол сайн. Онохгүй ч гэсэн муугүй гэдэг юм. Уулыг нь ч гэсэн онох учиртай гэж Санж гэгцэлд багш гэлэн Чоймчиг нь шивнэн ярив. Хачин тэр үйлдэлд гайхсан Санж,

- Багш аа, яагаад уулыг оноход сайн юм бэ? хэмээн асуув.

- Ландармын шарилтай энэ уул Үй мөрөн рүү аажмаар ойртон шахаж байдаг юм гэнэлээ. Голын урсгалыг хөндөлсөн хаахаар тэгж ойртдог уул юм. Хэрвээ Үй мөрний урсгалыг тэр уул хаачихвал гол эргэж Лхас хотыг бурхан шүтээнтэй нь живүүлэн егүүтгэж хөнөөх учиртай юм гэнэлээ. Тэрнээс болж жил бүр Ландармын уулыг үхэр буугаар гурван удаа сумгүй, дөрвөн удаа сумтай буудаж заншсан байна. Сумыг нь ууланд ойчсоны дараа хүн явуулж авчруулдаг юм. Буудуулсны хүчинд Ландармын уул ухарч хуучин байрандаа очдог гэж ярилцдаг учир тийм хэмээн багш ламыгаа ярихад Санж гэгцэл ихэд гайхлаа. Худал гэлтэй биш, хачин л юм.

Газарт булж зоосон нэгэн их хүрэл цутгамал буугаар гурвантаа хий буудаад дараа нь хүрэл бөөрөнцгийг бууны ам руу хийж чихэн дэх дарийг урт иштэй цуцлаар төөнөж нүсэр их дуу гарган буу тавьлаа. Хүрэл бөөрөнцөг исгэрэн нисч Ландармын ууланд тоос манарган туслаа. Сум туссан газар өөд дөрвөн хүн бие биенээсээ өрсөлдөн гүйж харагдлаа.

- Тэр сумыг олж нааш нь авчирсан хүн нэгэн жилийн турш албан гувчуураас чөлөөлөгддөг юм. Уул нь хөнгөн ажилдаа гэж багш

гэлэнгээ ярихад Санж гэцэл сум эрэгчдийг ажиглан сайтар харж авлаа. Тэд бас л сор шатсан газар үнс булаацалдагчдын адил зэс бөөрөнцөг булаалдаж байгаа харагдав.

“Хааяагүй л булаалдаан, хааяагүй л алхилдаан! Яасан ч айхтар хүмүүс юм билээ дээ!” гэж Санж гэцэл бодлоо.

- Эзэн хааны болоод Далай ламын шавданг бататгахын тулд Түвд хүмүүс бүхий л арга ширгээ оны эхэнд ийнхүү хэрэглэдэг боловч олон олон Далай ламд тэр бүхэн нь тус болоогүй ажээ. Гэвч түүнийг хайхардаггүй байлаа.

- Багш аа, оны тэргүүн сарын зан үйл одоо үүгээр төгсч байгаа биз дээ гэж Санж гэцэл багшаасаа асуув.

- Хорин есөнд Далай ламын төлөө золигт гаргах ёслол болдог юм. Тэрийг заавал үзвэл таарна гэж багш хэлэв. “Бас тийм ёслол байдаг юм гэж үү? Их л олон арга, ширэг хэрэглэдэг юм байна даа. Далай ламтангийн лагшин тунгалаг орших нь лавтай юмдаа” гэж Санж гэцэл бодлоо.

Сорын гал дээр ноцолдож байсан олон мөргөлчид саяхан түүдэг гал ноцож, сор шатсан тэр газрыг ямар ч ул мөргүй болтол нь хувхайлан хоослож цэвэрлэж авсан харагдлаа.

Үхэр бууны дуу дөрвөнтөө пэрхийж сонсогдоод чимээгүй боллоо. Түрүүчийн хий буудсантай нийлээд долоон удаа Лхасын тэнгэр, газрыг доргиулан дуугарсан тэр хүрэл гунан буу дахиад бүтэн жилийн турш дуугүй хэвтэх амралтаа авлаа.

Үй мөрнийг боож, үер бус буулгахаар тэмүүлдэг гэгддэг Ландармын ууланд уясан цагаан ямаа, хар өрмөг майхан юунд ч оногдсонгүй эсэн мэнд үлдлээ.

Далай ламын шавдан батад орших байх гэж хүмүүс итгэлээ. Далай

лам л амар мэнд байвал мөргөлчин, сүжигтэн, шавь нар нь бас л амгалан аж төрөх учиртай гэж зон олноороо итгэдэг байлаа.

- Одоо шавь чамд энэхүү бурхны оронд болдог ёслолыг үзүүлж дуусгалаа. Жилийн бусад өдрүүдэд өөр нэг их онцгой юм болохгүй, яг л энэ маягаараа жилээс жилд давтагдан хэдэн арван үе улиран өнгөрсөөр байдаг юм. Хүрд эргүүлэхтэй л ижилхэн санагдана гэж Чоймчиг гэлэн шавьдаа хэллээ. Үүгээр тэр өдрийн шуугиант ёслол ч дуусч, Санж гэцлийн багш ламтайгаа хамт бурхны хотод аливаа зан үйл сониучлах явах цаг нь ч төгссөн болохыг Санж анзаарсангүй. Гэвч багш лам нь бараг л ингэж хэлээд байлаа. Насны залуу, амьдралын нимгэн нь Санжид сэвдээ цохиулсангүй.

Ес. Золиосонд гарсан сүжигтэн

Хуримд хувцасгүй хүүхэн үнэгүй
Хуралд номгүй банди үнэгүй
Худалдаанд шүдгүй тэмээ үнэгүй

Далай ламын шавдан бататгах ёслол Лхас зууд үргэлжилсээр сарынхаа нүүр үзэж оны тэргүүн сарын хорин есний өдөртэй золголоо. Энэ өдөр Далай ламын амины золиосонд өөр нэгэн хүнийг төлөөлүүлэн золигт гаргадаг уламжлалтай аж.

Тэр өглөө гэцэл Санжийг гэлэн багш нь үүр цүүрээр эртлэн босгожээ. Ямар нэгэн юманд яарсан бололтой.

- За өнөөдөр шинийн хорин есөн. Далай ламын насыг уртасгахын билэгдэл болгож сүжигтэн олны дотроос хэн нэгнийг золигт гаргадаг буянтай өдөр. Гол төлөв нүгэлтэй ядуусаас золигт гаргадаг юм. Их буянт үйлс шүү! гэж ярив. Энэ өдрүүдэд гэлэн багш нь нэг л гайхмаар байдалтай болсныг Санж гэцэл хэдий нь ажиж мэдсэн билээ. Багш лам нь шүтээний газруудыг цөмийг тойрон гүйцээж эргэл мөргөл хийж байдаг мөнгөө өргөж гүйцжээ. Тэгээд өчигдөр орой гэцэл Санжид хэдэн лан мөнгө өгч,

- За багшид нь бараг мөнгө үлдсэнгүй. Буяны үйлсэд өгсөөр байгаад шавьдаа юмгүй шахам үлдлээ. Гэхдээ шавь маань хүссэн дацандаа зохих зиндаандаа орж шавилан суусан болохоор өөр юу хүсэх вэ? Багшийнхаа авч өгсөн хашаа байшинд эзэн болж тухтай суугаад номын мөр хөөж эрдмийн туйлд хүрнэ биз! гэжээ.

- Багшаа, та яагаад ийм үг хэлж байгаа юм бэ? Намайг орхиод нутагтаа буцах гэж байгаа юм уу? гэж Санжийг гайхан асуухад гэлэн түгдэрснээ,

- Үгүй л дээ... Нутаг буцахгүй... Гэхдээ шавь чамайгаа бурхны хотод орхиноо!... гэж хэлээд хоолой нь үл мэдэг чичрэгнэсэн боловч биеэ барилаа.

- Би танаас холдмооргүй байна! гэж Санж гэцэл хэлэхэд гэлэн,

- Холдоно ч гэж холддоггүй юм. Хоёр замын эрхээр л холддог юм. Одоо чи хүний зэрэгт хүрчээ. Биеэ даан эрдмийн мөр хөөнө биз. Муу ээж, аав чинь чамайг сайн лам болбол бүхий л санасан санаагаа бүтлээ гэж амьдын жаргал эдэлнэ. Бурхны үнэнч шавь нарын тоог нэгээр нэмэгдүүлбэл ядуу эр эм хоёрын үйлс бүтэх нь тэр ээ. Иймд чи сайн лам болох ёстой. Бурхны оронд ирсэн болохоор бурхны ном суралгүй яахав. Хичээж үз! Чи сайн лам болноо. Эхээс төрөхөд чинь ном нээж үзэхэд сайн лам болох төөрөг тодорсон. Гэхдээ саад барцад бий. Цанидын зод нинба зиндааг дүүргэх үедээ бусдын атаа хорсолд хөнөөгдөхгүйг бодож болгоомжтой байх хэрэгтэй. За өөр би юу захих вэ? Ингээд хоёулаа явж Лу- гон үзье! гэж хэлжээ.

Санж гэцэл түүний яриаг тогтоон сонсоод мөн л гайхан эргэлзсээр байлаа. “Атаа хорлол гэж юу ярив аа?” гэж Санж бодов.

Лугон гэдэг бол аврагч их Далай ламын амь насны золиосонд хэн нэгнийг гаргах ёслол байлаа.

Будалын ордны өмнө талбай дээр лугон үзэхээр олон мянган мөргөлчид лам нар цугларсан байлаа. Лам нар тарнийн ёсны хувцсаар өвч бүрэн өмсгөлтэй байлаа.

Тавцан дээр Лугон буюу золиосонд гарах хүнийг авчрав. Цагаан ямааны арьсан дээлийн үсийг гадагш эргүүлэн өмссөн хүн байлаа. Түүний нүүрийн баруун талыг цагаан, зүүн талыг хар будгаар буджээ. Толгойд нь жижигхэн дуулга өмсгөжээ. Гарт нь сарлагийн хар сүүл бариулжээ. Шодлого хийхээр нэгэн ламыг бас тэрхүү золигт гаргах хүнтэй хамт тавцанд зогсоогоод цагаан нүхтэй тас хар шоог авчирлаа.

Лугон болох хүн шодогч лам хоёр шоог ээлжлэн орхиж эхлэв. Гурав дахин шоо орхиход лугон болох хүнийх цөөн нүхтэй, эсрэг ламынх нь олон нүхтэйгээрээ таарч байлаа.

Гурвантаа орхисон шооны нийлбэр нүхний тоогоор аргагүй л лугон болоххүн ялагдлаа. Тэгэхэд тэрээр уурлах дүр үзүүлж уул шоог ууртайяа дэвсэв. Энэ нь ялагдлаа хүлээсний дохио юм. Шоог уурлан дэвсчихээд лугон болох хүн баруун урагшаа зугтаан гүйлээ. Таринийн ном урьж байсан лам нар тонилгон хөөхийг билэгдсэн бүжиг хийж гар хөлөөрөө элдэв дохио зангаа үзүүлэн цовхчиж эхлэв. Тэдний дүвчигнэж эхлэх үеэр тохой өндөр сор, мөн тиймээр хийсэн Далай ламын дүрс хоёрыг тусгай тавганд тавиад авч иржээ. Цамнан бүжиглэж дууссан лам нар зугтааж яваа золиосонд гарах хүний хойноос хөөж эхлэв. Үй мөрний хөвөө хүртэл тэд хөөцөлдөв. Тэгтэл золиосонд гарах эр гадуур хачин хувцсаа тайлж голын эрэг дээр хаяад завинд сууж гол уруудан тэмүүлэв.

Ингэж бас нэгэн энгийн ламыг Богд эзэн Далай ламын шавдан бататгах золиосонд гаргав. Орны нь хүнийг эрлэгт явуулчихсан болохоор тэдний нас уртдаж, өлмий нь бат оршиж хойтон жилийн өдий хүртэл ямар ч атугай гай зовлон тохиолдохгүй гэж сүжигтэн олон цөм итгэл дүүрэн болоод баяртайгаар тарлаа. Эдгээр хүмүүс өчигдөр сарлагийн хар сүүл барьж “Маргааш золигт гарах тул өгөх ёстой өглөгөө өг” гэж нэхэн явсан тэр эрд тал зоосны дайтай юм цөмөөрөө өгсөн тул бас сэтгэл бардам байлаа. Золигт гарсан эр уугуул нутагтаа бараа нь харагдах ёсгүй байлаа. Тийм болохоор хэдий амь насан нь бүтэн ч гэсэн хүний данснаас хасагдаж алс хол газар цөлөгдөн зайлуулагдсантай ямар ч ялгаагүй хувь тавилантай болж байгаа нь тэр ажээ.

Нэг талаас хүний тооноос хасагдаж золигт гарч байгаа тун ч гунигтай зүйл боловч нөгөө талаас Бурхан багшийн бие төлөөлөгч Далай ламын амь насны золиосонд биеэ өгөх нь буяны дээд буянт үйлс гэж золионы хүн бүрэн итгэдэг тул ийм хувь тавилан олдсонд баярлаж дуртайяа золиг болдог ажээ. Дээр цагт бол амьд ч үлддэггүй байжээ.

Одоо бол амь насыг үлдээж, гагцхүү нутаг орноос нь хөөн зайлуулдаг болжээ.

Өндөр гэгээнтэнг өвчлөхөд тавин өрх айлыг гайд гаргасан юм гэнэ лээ. Онон голын эхнээс хаашаа ч гардаггүй сууцгааж байдаг юм гэдэг. Ганц нэг хүнийг гайд гаргаад барцад нь арилдаггүй тийм том гай түйтгэр ч тохиолддог юмсан. Тавин өрхийг золигт гаргасны хүчинд анхдугаар Богдтон урт насалсан юм гэж ярьдаг үгтэйдээ хэмээн гэв гэнэт гэлэн Чоймчиг багшийгаа ярихад Санж гэцэл цочиж,

- Тийм их олон айлыг уу? Манайд бас энэ золигт гаргах ёс байгаа юм уу? гэж асуухад гэлэн дургүйцэж, - Дуу! Алдас болно. Бурхны шашин дэлгэрсэн газар хаа боловч жаяг ёс мөн нэгэн адил байдаг болно. Хүн нь том байх тусам гайд гаргах юм ихэсч таарна биз дээ гэж гэлэн зам зуур ярилаа. Санж гэцэл

- Тэр золигт гарсан хүн зугтаад явчлаа. Тэгээд цаашаа яадаг юм бэ? гэв.

- Тэр үү? Үй мөрнийг дагаж явсаар Самяй хийдэд очоод өргөл барьц өгч өөрийнхөө хувь заяаг даатгуулж гүрэм хийлгэдэг юм. Тэгээд энэ нутгаас холдож дахин хэзээ ч эргэж ирэхгүйгээр хаа нэгэн газар амьдарна биз дээ гэж Чоймчиг гунигтайяа өгүүлэв.

Тэр хоёрын хажуугаар хулсан хөө хуяг дуулга өмсч, нум сум, бамбай сэлэм агсан зүүсэн торгон цэргүүд пир пүр хийтэл алхлан өнгөрлөө. Араас нь бас хэсэг морин цэрэг явав. Лхас лонлам хурах хөдөө тосгоноос тэднийг цугларуулан ирүүлж дүгжив шатаах, сор залах зэрэг зан үйлэнд оролцуулдаг юм байжээ. Мянган цэргийн дарга нь дабони, зуун цэрэг юм уу мужийн цэргийг дэбаа захирдаг байна. Монлам буюу ерөөлийн их хурлын үеэр дабонид захируулах тийм олон цэрэг цугларч ирдэггүй бололтой.

Шинийн сарын бужигнаантай зан үйл дуусах тийшээ хандаж, өнөөдөр Далай ламынхаа амь насны өмнөөс сүжигтнүүд нь золигт

гарч, их ёслол хийж төгслөө. Хүний өмнөөс хүнийг гаргуунд гаргадаг тэр хачин ёслол гагцхүү энэ газар, хэтэрхий сүжгийн үрээр дэлгэрчээ.

Гэрийн зүг буцаж явахдаа гэлэн Чоймчиг шавьдаа их л элэгсгээр,

- Багш нь ч гэсэн өнөөдөр гарлаганд гарнаа! гэж хэлэв. Үүнд Санж гэцэл маш их гайхан бишүүрхэж,

- Та яалаа гэж гарлаганд гарах юм бэ? гэж сандарсан дуугаар асуулаа. Муу юм зөгнөж сэтгэл нь донсолжээ.

- Би гарлаганд гарах зураг тавилантай юм. Тэр ёсоор өнөөдөр орой явах замаараа багш нь явна гэж гэлэн Чоймчиг санаа амарлингуй тайван ярив.

- Яалаа гэж дээ! Та хаашаа явах юм бэ? гэж Санж хоолой чичрэн асуутал,

- Дуугаа аяд. Гудамжинд ийм юм ярьдаггүй. Гэртээ очоод би чамд хэлнэ гэж гэлэн тэрхүү түгшүүртэй яриаг намжаалаа.

Адак дэнжин заваадан
Жүтбер жайби балдан
Лама дамба намла
Жапсучойвоо!

гэж багш нь амандаа шүлэг маани, номын түлхүүрийг уншихад Санж давтан,

- Би тэргүүтэн: эх болсон хамаг амьтан, арван зүгийн гурван цагийн хамаг хутагтан, хуврагууд, эзэн илэт ачит үндсэн лам нарт итгэмой! гэж дууриан уншлаа. Тэгээд тэд хэсэг дуугүй явахдаа уул номыг цааш нь ам амандаа үргэлжлүүлэн унших учиртай боловч тэгсэнгүй хий л амаа хөдөлгөж өөр өөр юм бодоцгоож байжээ.

“Багштан гарлаганд гарна гэж юу ярьж байгаа юм бэ? Өнөөдрийн золигт гарсан хүний адил гарах гэж үү? Тэгвэл өглөө л тэр хүний хамт гарах ёстой байсан биш үү? Би л багшийн үгийг буруу ойлгох шиг боллоо. Тэгвэл ч нүгэл алдас болно шүү” гэж Санж гэцэл гэнэт бодоод эвгүйрхэхдээ духны нь хөлс чийхрах мэт боллоо.

- Хөөрхий гэцэл гэнэн балчир байна. Намайг амин золиосонд гарна гэдэгт огт итгэхгүй байна. Чухам яаж ч мэдэх юм билээ дээ” гэж Гэлэн дотроо бодлоо.

Тэр хоёр яван явсаар гэртээ ирэв. Багш нь өнөөдөр бахь байдгаараа л гоё хувцаслаж их гамбагар байдалтай байв.

- Багш нь өнөө орой их чухал ажилтай. Түүндээ явахын өмнө сайхан шөл хийж идвэл зүгээр байна гэж гэлэн хэлэв.

Санж гэцэл шалмагхан хөдөлж багшдаа зориулан хар шөл хийлээ. Сарлагийн мах тул их хатуу юм. Багш нь жижигхэн хөшиглөхийг дурладаг ёсоор хичээнгүйлэн хийлээ.

- За багшийгаа хэзээ боловч мартагнавзай. Өнөөдрийн буянт сайхан өдөр багш нь хувь төөрөг ёсоороо бурхны оронд одох болно. Маргаашнаас эхлээд шавь чи ганцаараа амьдарна. Эргэж багш нь ирэхгүй. Ирэвч төрөл арилжин ирнэ гэж багшийгаа ярихад гэцэл Санж юу ч хэлэх учраа олсонгүй. Бүлх үмхсэн мэт гөлрөн, алгаа хавсран зогслоо. Багшийн үг нууц утгаараа аймаар байв.

- Багш нь бүх насаараа бурхны номд сүслэн хичээнгүйлж хоёр зуун тавин гурван сахилаас нэгээс бусдыг цөмийг тавь гаруй жил хатуу сахисаан. Нэгий нь насны эрхээр сахиж чадаагүй. Тэр минь нөхөшгүй их нүгэл. Тэр нүглээ би наманчлан залбирч явах ёстой. Миний тэр нүгэл хоёр зуун тавин хоёр сахилыг ганцаараа бараантуулж чадах нухацтай нэгэн бий. Гэвч буян нүгэл хоёр дүг шаг болно биз дээ. Ингээд багш нь... гэтэл Санж гэцлийн хоёр нүднээс нулимс бөмбөрөн чимээгүйгээр мэлмэрч байхыг гэлэн Чоймчиг харчихаад дуугүй

болов.

- Биеэ барь! Би ямар тамд явах гэж байгаа биш! гэж багш лам нь ууртай шивнэв.

Тэд хоолоо идэж дууслаа. Гэлэн Чоймчиг нүдээ анисхийн хэсэг зуур бодлогоширсноо,

- За ингээд багш нь явна. Чи надтай хамт явах хэрэг байна уу даа гэв.

- Хамт явалгүй яахав. Яавч хамт явна гэж Санж залбиран гуйлаа.

- За яахав. Би чамайг дагуулаад явъя. Харин чи тэр газар очоод айж бишүүрхэж болохгүй. Тэгвэл багшийнхаа явах зам мөрт их хар саад болно. Чи аминд чинь хүрч байвчиг хүлцэж чадах уу? гэж гэцлээс багш нь асуужээ.

- Би чадах амлалт өгье, багшаа! гэв.

- Чи бас аминд чинь хүрэвч үзсэн юмаа нууж чадах уу? гэж багш асуулаа. Харц айхтар төвлөрчээ.

- Чадна. Гагцхүү үүнд итгэж болно. Би өөр хэнд ам тангараг өгөх билээ. Багшийн өмнө өгсөн тангараг андгай биш үү? гэж гэцэл андгайлав.

- Өнөө шөнө багш нь зул өргөх зан үйлд оролцоно. Оролцох ч гэж дээ би өөрөө зулын гол болж жаргана. Миний чамд огт ярьж өгөөгүй үлдсэн зүйл энэ юмдаг. Бурхан Шигмуунийн ариун үйлсэд биеэ өгөх тэр үйлс бол хоёр хөлтэй хүнд ховор тохиолддог заяа. Их арга билгийн хүчинд багш нь ийм эрх олж авлаа. Одоо тэр зол заяанаасаа гээгдэж огт болохгүй. Зулын гол болж миний шатах нь бүх насаа зориулсан бурхан багшийн үйлсэд сүүлчийн өмч хөрөнгөө өргөсний тэмдэг юм. Бие юу ч биш. Гагцхүү сэтгэлийн мөнхжрөл үзэх нь миний дээд тавилан. Хийсээр ирсэн бүх буяны минь титэм тэр болно.

Хийсэн нүгэл над байдаг болж гэм тэрний минь цагаатгал нь бас тэр мөн. Хэрэв би энэ үед л зогсоохгүй бол нүгэл минь улам үргэлжилж нэмэгдэх нь лавтай хэрэг. Тэр бага дээрээ төгсгөл болох учиртай гэж гэлэн Чоймчиг өөртөө ярьж байгаа мэт бөвтнөн хэлэв. Гэцэл Санж сэтгэлийн их хямралаас болж дуугарч чадсангүй.

- Зул өргөхөд гаднын хүн оруулдаггүй юм. Ганц нэг хүн оруулбал тэд болсон явдлыг өөртөө л бясалгах учиртай. Би хорвоо дээр ганц шавьтай хүн. Түүнээ оруулж болно. Харин миний нэгэн зиндааны нөхөрт би чамайг захиж хэлсэн. Тэр чамайг зул өргөлийн газраас гаргаж гэртээ аваачина. Өнөө шөнөдөө тэднийд унтсан нь дээр байх! гэж багш нь ярив. Эцсийн захиа мэт санагдпаа.

Санж гэцэл багшдаа юу гэж хэлэхээ удтал олсонгүй. Тэгтэл багш нь

- Багш нь их зулын гол болж шатах болно. Тэглээ гээд сэтгэлээ битгий зов. Гурван мянга, их мянган ертөнцийн цаана төрөхөөр явж байхад юунд нь зовох билээ. Сэтгэлийн гэм надад байхгүй гэж нэмэн хэлэв. Тэгэхэд л Санж гэцэл сая учрыг олов. “Их нүгэлтэй юмуу, их буянтай хүн зулын гол болон хөвөнгөөр ороолгож хайлан оддог юм” гэж бүүр түүрхэн сонссон нь санаанд оржээ.

...Гадаа дэншиг дуугарах шиг чимээ гарлаа. Гэлэн Чоймчиг цочсоноо,

- За явах цаг боллоо. Хүн ирлээ гарья даа хоёулаа! гэж шавьдаа хэллээ. Тэр хоёр хувцсаа бүрэн өмсөөд гарах болоход,

- За сайн лам болоорой. Би чамд сахиусаа өгье гээд хүзүүнээс сахиусаа багш нь авч Санжийн хүзүүнд зүүж өглөө. Хөлстэй, халуу даасан тэр сахиус нь Санжийн нүцгэн төвөнхийн тушаа, төөнөн нойт оргиулахад Санж золтой л уйлчихсангүй. Гэлэн өврөөсөө бас нэг буйлан шиг юм гаргаж ирээд,

- Чамайг сайн лам болоод нутагтаа эргэж харихын цагт намайг ямар нэгэн хүн сураглаж ирвэл үүнийг өгөөрэй. Өөр юм битгий хэлээрэй!

гэж захив. Санж түүнийг хоёр гардан авахад тэр буйланд жижигхэн хатуулаг жинтэй юм байлаа.

- Хэн гээч хүн бэ, багшаа? гэж Санж дэмий л асуусан нь багшийн сэтгэлд огт нийцсэнгүй. Багш нь унтууцаж,

- Хэн нь хамаагүй. Аяндаа мэдэгдэнэ. Хэрвээ хэн ч намайг сураглахгүй бол яахав чамд байж л байг. За одоо гарцгаая гэв.

Багш шавь хоёр гадаа гарлаа. Хашааны хаалган дээр морин тэрэгтэй хүн ирсэн хүлээж байлаа. Гэлэн Чоймчиг намбатайхан алхалж морин тэргэнд орж суулаа. Сүйх маягаар зассан тэрэг ажээ. Санж багшийнхаа хойноос орж дэргэд нь суув. Тэрэгч аяархан тухирч морио хөдөлгөв. Замын зуур багш лам нь өчүүхэн ч дуугүй, боддогшрон явж байлаа. Таг чимээгүй тэр байдлыг эвдлэх зүрх Санж гэцэлд ч үгүй байлаа. Чухам хаашаа явж байгаа нь ч мэдэгдсэнгүй. Олон цай чанах хугацаа өнгөрчээ. Гэнэт тэрэг зогслоо. Дэлбэгч нь урд талын өндөр суудал дээрээсээ бууж хаалгыг онгойлгож өглөө. Харанхуй дундаас нэгэн авсаархан дуганы сэрийж сарайсан дээвэр нь бүдэг бадаг ялгаран үзэгдлээ. Гэлэн тэрэгнээс дуугүйхэн буугаад дуганы үүдийг чиглэн явлаа.

Араас нь морин тэрэгч, тэгээд Санж гэцэл даган явав. Дуганд орвол бүдэгхэн хэдэн зул тэртээ харанхуйд сүүмэлзэж байв. Баргар гунигтай байдал илэрхий.

Сүмийн голд хүний мөртэй чацуу өндөр амсартай асар том хүрэл цөгц зоолгоотой байх шиг харагдлаа. Саяхан Лхас монламд манз чанаж байсан хүрэл тогоогоо Санж гэцэл дурсан бодлоо. Дуган дотор хоёр гуравхан лам байлаа. Тэдний нүүр царай бараг ялгагдахгүй тийм бүдэг гэрэлтэй байв.

Ямар нэгэн уншлага эхлэв. Тэр уншлагын утгыг Санж гэцэл сайн ойлгохгүй байлаа. Урьд өмнө ч тийм юм сонсоогүйсэн билээ. Нэгэн лам ирж тэр гурвыг дагуулан шатаар дээш гаргалаа. Нэгэн тавцанд

тэд гарч иржээ. Тавцан дээрээс эргэн харахад дуганы гол дунд асар том зулын цөгц байгаа харагдав. Тэр цөгц рүү дүүжин шат шиг олсон шат унжуулжээ. Нэг лам эхлээд тэр шатаар доош бууж зулын ёроолд очив. Хойноос нь гэлэн Чоймчиг орлоо. Мөн араас нь өөр нэгэн лам оров. Хоёр лам гэлэн Чоймчигийн гараас хөтлөн зулын цөгцний гол дахь нүхэнд түүнийг оруулж зогсоолоо. Өвдгөөр нь татаж байв. Гэрийн хаяавч шиг хэлбэртэй урт гэгчийн хөвөнг цөгц рүү бас нэг лам шидэж өглөө. Хоёр лам түүнийг дороос нь тосон аваад гэлэн Чоймчигийн өвдөгнөөс нь дээш ороож эхлэв. Хаяавч адил урт гонжгор тэр хөвөнд тос шингээсэн мэт байлаа. Гэлэн Чоймчиг хоёр гарын алгыг хавсран толгой дээрээ өргөн залбирч байгаа мэт зогсоод амандаа маань уншиж байх шиг харагдлаа. Нүдээ бясалгагчийн дүрээр аньжээ. Хоёр лам гэлэн Чоймчигийг хөвөнгөөр ороон ороосоор мөрөн тушаа нь хүрч очлоо. Тэгээд ямар нэгэн юмыг гэлэнд үнэртүүлэв. Түүнийг үнэртээд гэлэн Чоймчиг огт хөдөлгөөнгүй болов. Гэхдээ толгой дээрээ алгаа хавсран өргөсөн гараа буулгасангүй хэвээр байлаа. Хоёр лам тэр даруй улам шаламгайлан хөдөлж гэлэн Чоймчигийн биеийг гүнжидийн тостой хөвөнгөөр ороон ороосоор толгойг нь далд оруулав. Тэр мөчид Санж гэцэл зулын гол руу харайн орохыг завдахад дэргэдийн лам нь ухасхийн барьж зогсоолоо. Тэр эгшинд хоёр лам гэлэн Чоймчигийн наманчилсан хоёр гарыг үзэгдэхгүй болтол ороожээ. Саяхан хүн зогсож байсан тэр газар одоо хөвөнгөөр ороож хийсэн зулын гол болсон үзэгдэв. Эсгийн бул босгоод тавьчихсан юм шиг харагдахад залуу гэцлийн сэтгэл хачин эвгүй болж муужрах шахав. Түүнийг мэдээд дэргэдэх лам нь навш үнэртүүлсэнд нүд нь бага зэрэг сэргэж, амьсгаа авчээ. Чоймчиг гэлэнг гүнжидийн тостой хөвөнгөөр ороож дууссан хоёр лам олсон шатаар сармагчин адил шаламгайлан авирч зулын дотроос гадагш гараад шатаа татан хурааж авав. Тэр мөчид зулын нэг амсар дээгүүр тавьсан модон цоргоор хайлмаг шар тос урсан цөгц рүү орж эхэллээ. Яагаад ч юм гэлэн Чоймчиг огтхон ч хөдлөхгүй байлаа. Гаднаас нь харахад дотор нь хүн байгаа гэдгийг ч төсөөлөх аргагүй ажээ. Хөвөнгөөр асар том зулын голыг имрэн хийж зоосон юм шиг л амарлингуй, хөдөлгөөнгүй чимээгүй байлаа. Модон цоргоор орж байгаа шар тос ус шиг дуу чимээ гаргасангүй харин зулын хөвөн голыг дэлсэн, илбэн

буцах мэт гулсаж цөгцний ёроолд тунаж байлаа. Тэртээ бүрэг харанхуй өнцөгт хэдэн лам ямар нэгэн уншлага хийж дүнгэр дүнгэр дуугарцгааж байлаа. Удаж төдсөнгүй зулын цөгцний талд хүртэл тос дүүрээд ирлээ. Хажуугийн өрөөнд том зуухан дээр хайлж байгаа тос модон цоргоор урсч дуганы гол дахь цөгц рүү ордог бололтой.

Санж энэхүү хүнд мөчид юу ч хэлж чадахгүй, юу ч бодож санахгүй байлаа. Гэнэт хэнгэрэг хонх дамар дуугарав. Нэгэн лам урт иштэй цучил барьж ирээд зулын голыг асаалаа. Тос шингэсэн хөвөн дүрсхийн аслаа. Дуган дотор гэрэл гэгээтэй болов.

Хажуугаас нь хэн нэгэн хүн татахад Санж эргэн харвал түүнийг багштай нь хамт морин тэргээр хүргэж ирсэн түвд лам ажээ.

- Одоо үйл гүйцлээ. Явъя. Үүнээс цааш энд хүн байж болохгүй гэж тэр хүн түвдээр хэлэхэд Санж гэцэл дүйрэн мангуурч, алмайран гайхсан толгойгоо унжуулсаар трхүү түвдийн араас даган явлаа. Сүүдэр нь их урт, иймаар үзэгдлээ. Цочих шиг болов.

“Бурхны оронд зулын гол болж нас юүлсэн” гэж Буянзалбирах хийдэд байхдаа бүдэг бадаг сонссон нэг хачин ярианы утга юу байсныг Санж одоо л ухааран ойлгожээ. “Багштан сүүлийн үед хачин байдалтай болсон нь ийм учиртай байжээ. Багшид ингэж цагаатгах тийм их нүгэл баймааргүй юм. Тэгвэл буян хийсэн хэрэг үү?” гэж Санж эргэлзэн бодлоо.

Морин тэрэг дэндэлзэн донсолсоор урагшаа хөдлөв. Санжийн хоолой нь зангирч нүднээс нь нулимс гарлаа. Аяархан мэгшин уйлав. Гэнэт багшийнхаа захисныг санаж нулимсаа арчлаа. Хойноос нь нулимс гаргах, гашуудах хэрэггүй гэж багш нь захисан билээ. Нулимсаар саад хийхгүй байхыг тэр их л аминчлан захиж байсан... Санж уйлахаа болив.

Арав. Нүгэл буянгийн ялгаа

Голио үер ирэхийг болгоомжилж өвсөнд авирна
Тогоруу дэлхий цөмрөхийг болгоомжилж сэмхэн алхална
Мэлхий тэнгэр унахыг болгоомжилж дээш харж хэвтэнэ

Шасар малгайгаа духдуулж, жанчаа өмсөж, орхимжоо хөдөрсөн лам
нар Гоман дацангийн үүдэнд ерийн л заншлаараа зэрэг шахам цугларч
тугжээтэй хаалгын өмнө түр саатан зогслоо.

Ганжин хайви жугжэн зонхова

Лувсан дагби шабла солбандив...

гэж олон лам ам амандаа дүнгэнэтэл уншиж мэгзмийн сүүлчийн хоёр
мөрийг чангахнаар хэлж дуусгалаа. Гэцэл Санж тэр үгийг бараг
хэлсэнгүй. Гэвч түүнийг хэн ч ажиглаж мэдсэнгүй.

Гэсгүй дуганы хаалгыг нээхийг завдахад олон лам, хувраг, шасар
малгайгаа авцгааж сүмийн хаалганы зүг гурвантаа бөхөсхийн мөргөв.
Санж гэцэл малгайгаа авахаа мартаж мөргөх гэхэд нэг зиндааны нь
нөхөр шасарыг нь авч өгөв. Гэцэл зулын гол ороолгон төгсгөл болсон
багш ламыгаа мартаж чадахгүй байжээ.

- Бодьсад их нигүүлсэгч эзээн! гэж нийтлам намуухан дуугаар зэрэг
хэлээд түр дээшээ өлийн харцгааж амьсгаа авлаа. Тэгснээ бөхөсхийж,

- Үүдээ нээтүгэй! гэж зэрэг гуйцгаав. Энэ үгийг гурвантаа хэлэхэд
сүмийн үүд цэлсхийн нээгддэг жамтай билээ.

“Бодьсад их нийгүүлсэгч эзний төлөө багш маань одсон... Бас бүх
лам, хувраг цөм бодьсад их эзний төлөө, тэр өөрөө эх болсон зургаан

зүйлийн хамаг амьтны тусын төлөө...” гэж Санж гэцэл бясалган бодлоо.

Лам нар сүмдээ орж юуны түрүүн хүрднүүдийг эргүүлэхээр өдрийнхөө ажлыг эхлэв. Зургаан талтай, тал бүрийг нь цагаан, ногоон, шар, хар, улаан, хөх зургаан өөр өнгөөр будсан хүрднүүд эгнэн ярайж байлаа. Гол дээрээ эргэлддэг тэрхүү зургаан талт хүрдийг хуврагууд нар зөв эргүүлцгээж хойно хойноосоо цувран явж сурчээ... Зургаан тал, зургаан өнгө нь мөн л эх болсон зургаан зүйлийн... хамаг амьтныг төлөөлсөн ажээ. Хүрдний дотор голыг нь зургаан... үсэг маанийг хэдэн түм дахин бичсэн цаасаар ороосон байгаа. Хүрдийг эргүүлэх бүрийд тэрхүү мэгзэм, зургаан үсэгг маанийг уншсантай адил гэж лам нар боддог тул аль болох олон дахин эргүүлбэл маанийг төдий чинээн олон удаа уншсанд тооцогдоно.

Гэвч сүмд шавилан суугчдын хувьд номын үсгийг хүрдээр дамжуулан уншсан болох биш харин амаараа шууд унших ёстой билээ. Өөр хийх ажил сүмд байхгүй. Өглөөнөөс үдшийг хүртэл бурхны номыг дүнгэнэтэл уншиж өнгөрөөнө. Цаг өдрөөр хэмждэг бурхан шашны зан үйлээс бусад үед жавдан дээрээ завилан сууж, тэртээ эрт цагт тогтоосон жаяг ёсоор бурхны номыг ээлж дараалан уншина. Тийнхүү олон өдөр, жилээр уншсаар байгаад цээжилж, бүр сүүлдээ эвшээхтэй адил ерийн хэрэг болж хувираад насны тоо нэмэх тусам улам догьширч, хоолой нь ч бас эвдэрдэг ажээ. Бүх л насаараа жавдан дээрх олбогоо элээж нэгэн төрлийн уншлага үйлдээд бие нь хүндэрч, толгой нь халцарч, хоолой нь паржигнасан хөгшин лам нарын араар мөн л тийм болох? ирээдүй рүү зүглэсэн залуу банди, хуврагууд сууна. Тэд нар ой ухаан нь сэргэлэн үедээ бурхны номыг сайхан цээжлэх боловч сүүлдээ улиг болж, утгы нь ч төдий л сонирхон бясалгалгүйгээр ном судрын үгийг амнаасаа аяндаа урсгадаг болно. Зөвхөн”Жадамба” судар гэхэд л найман мянган шад шүлэг бий. Тэрийг шад шадаар нь цээжиндээ багтаана. Гэхдээ эхнээс нь аваад дэс дараалан уншвал бүгдийг хэлж чадна. Дундаас нь эхлэх гэвэл түгдрэн бажгадах тохиолдол ихэнх ламд учирна. Санж одоогоор оюун

сэргэлэн, юманд сониучийн эрхээр юу л шаардагдана вэ тэрнийг цөмийг цээжилж, бас утгыг нь ойлгохыг эгээрнэ. Номын үг эртний гаралтай тул заримдаа лам багш ч өөрөө тайлбарлаж чадахгүй юм дайралддагийг Санж олон удаа ажиглав. “Бурхны ном гүнзгий тул ёроолд нь хүрэх хүн үгүй” гэж багш нь тийм үед сургана. Эрдэмд оройгүй, далайд ёроолгүй гэдэг билээ.

- Арван хоёр жилийн турш орсон хур бороог тоолж болно. Гэвч зургаан үсэг мааниас нэгнийх нь ч ач тусыг тоолохуйяа бэрх! гэж лам нар шавьдаа заан номлодог болой.

Өглөө босоод унд уух юм уу, хүнтэй уулзаад амрыг асуухын нэгэн адил бат заншил болсон мааниа уншиж, хүрдээ эргүүлмэгц лам нар жавдандаа, ширээт лам ширээндээ залран сууцгаалаа. Тэдний ээлжит суугаа алба эхлэв. Ширээт лам тахилын өмнө бөхөлзөн мөргөөд хоёр сойвонгийн дэмжлэг туслалцаагаар арслант ширээндээ залран суусны хойно лам нар ширээтийн өмнө очиж алга хавсран бөхийн зогслоо. Ширээт лам гурван эрдэнийн ном буюу, гусумтуг гэдэг бяцхан судраар лам бүрийн тэргүүнд хүргэн адис өглөө. Адис авмагц тэд эргэж жавдандаа сууцгаав.

Унзад эхлэн паржигнасан бүдүүн хоолойгоор номын түлхүүр уншиж эхлэхэд бусад нь дуугаа авалцан залгаж үргэлжлүүлээ. Өчигдөр гэцэл Санж багш гэлэнтэйгээ номын түлхүүр хамтран уншсанаа дурсан бодлоо. Сэтгэл нь зовиурлав. Гэвч багш гэлэн нь өөрийнхөө хойноос дэнсэлж болохгүй гэж захисныг саналаа. Эрх догшин бурхдад ёслол үйлдэхээр зиндааны нөхөд хоёр хэсэг болж зарим нь дээд гонхонд, зарим нь хажуугийн дөрвөн үндэсний сүмд орцгоолоо. Санж харангын хуралд хурах тул суугаад үлдэв.

- Өглөгийн эзэн гэлэн Чоймчиг... гэж гэнэт дуган дотор зарлахад Санж хэрдхийн цочиж, бие нь чичрэв.

- Өглөгийн эзэн гэлэн Чоймчиг манз барьж, мөнгө өргөж өглөө, оройн ерөөл гуйсан юм. Тэр ёсоор ерөөл авахуулья гэж гэсгүй лам нийтэд

сонсогдохоор дахин зарлав. “Хөөрхий багш маань ерөөл захиалж дээ. Өөр хэн нь захих билээ” гэж Санж гэцэл гансран бодлоо. Зулын гол болж хорвоог орхисон багш гэлэн нь ихэнх лам нарын нэгэн адил гав ганцаар амьдардаг, садан төрөл гэх юмгүй хүн байлаа. “Жил бүрийн энэ өдөр багштандаа зориулж ерөөлийн хурал захиалж байя” гэж Санж гэцэл дотроо бодоод их чанга дуугаар маань татаж эхэлтэл хажуугийн лам ёворч дуугий нь намсгав.

“Өнөөдрийн бүх хурал зан үйлийг эрхэм багшдаа зориулсугай. Бурхны үйлсийн төлөө тийм баатарлагаар амь биеэ зориулсан нь юутай бишрэлтэй билээ. Надаас л лав тийм их зориг шулуудсан итгэл гарахгүй байх. Бурхны шавийн дээдийн дээд үйл лав тэр мөн. Би хэрвээ эрдэм номоо туйлд нь хүргэж чадвал багшийн насан дээр багшийн замаар ороход нь ч юу нь болохгүй билээ. Бурхны үнэнч шавь тиймээр хорвоог орхидог нь олдошгүй дээд хувь мөн” гэж залуу гэцэл бодлоо. Нэг талаар хорвоог ер бусын байдлаар огоорон орхисон эрхэм багш ламыгаа өрөвдөн үгүйлж, гансран дэнслэх боловч нөгөө талаар түүний эрэлхэг зоримог явдал, бурхны өмнө чин үнэнч сүжигтэйн үлгэр нь түүний шавь залуу гэцлийн зориг сэтгэлийг бадруулж байлаа. “Орчлонгийн далайг багштан баатарлагаар туулан гарч нирваан дүрийг олов. Гэвч түүнд бас ерөөл, уншлага хэрэгтэй юм байжээ. Надад хэлэлгүй өөрөө урьдчилан захижээ, янз нь. Түүнийг тэр зиндааны нөхөр нь ч захисан юм байж мэднэ” гэж гэцэл бодов. Хүний орчлон гүнзгий ажээ.

“...Орчлонгийн далай дөрөв билээ. Эхний далайд хүний өлгий ад чөтгөр, тамын аюулд отуулан хөвж явдаг билээ. Тэнд хүний нэгэн насны явдал эхэлнэ” гэж багш лам нь хэдэн жилийн өмнө гэцэл Санжид зааж байсныг тэр эргэн санаж гэлэнгийн тайван дууг дахин сонсох мэт болов.

“...Хүн эхээс төрөхөд хувь заяаны төөргөөр энэхүү орчлонгийн дөрвөн далайг туулах болно. Эцсийн далайд яргачингаар хүрээлүүлсэн авс хөвж явдаг бий. Тэнд хүний нэгэн насны явдал төгсмой” гэж багш лам нь бүр дэргэд нь дахин хэлж байх шиг

санагдав. Санж гэцэл багшаасаа нөгөө хоёр далай нь юу билээ гэж асууж байснаа санав.

“Дундах хоёр далай бол хэмжээгүй их тачаал, өвчин зовлон оволзон долгилсон, албин буг, лус, ороолон шулмасын сүрэг үй зайгүй бужигналдсан орчлон билээ. Тэнд хүний бүх зовлон багшран хурна. Жаргал гэж үгүй. Тэр далайгаас гэтлэе гэвэл бурхны номд сүжиглэн дагаж явах учиртай” гэж багш лам нь айлдсан билээ. Тийнхүү орчлонгийн дөрвөн далайг туулахад учрах зовлонгоос зайлья гэвэл номын мөр хөөж, бараамид шагшаабадыг бүрэн сахих ёстой гэж гэцэл ойлгож авсан юм. Энэ бүхнийг гэцэл Санж бодсоор байвч нэгэнт цээжлэн хэвшил болсон амны уншлагаа аяндаа уншсаар бусад лам нарын дууллаганаас гажихгүй байлаа.

Удалгүй түй өргөхөөр унзад лам хоёр тахилчийнхаа хамт хүрэл толийг хүрэл бумбын хамтаар барин дуганы төвд гарч ирлээ. Толийг их л хүндэтгэн хоёр гар дээр ирмэгнээс нь хуруугаар дэмнэх төдий өргөж явах ёстойг тахилч нар хатуу сахиж байлаа. Сэлнэн хэнгэрэг хоёр дараа дараагаар дуугарч лам нар тунжурдан хүржигнэн дуугарцгааж, уншлагынхаа түрлэгийг нэмлээ. Тахилч лам бумбатай аршаанаас хүрэл толин дээр дусааж унзад лам өнгө өнгийн хадган багцаар толийг арчин зүлгэж ёслол төгсөв. Толь бол тэнгэрийн билэгдэл тул ийнхүү аршаан дусаан тэнгэр нарыг таацуулан баярлуулж буй ёслол гэдгийг гэцэл Санж аль эртэд багшаараа заалгаж мэдсэн билээ.

Тэнгэр буюу ом бол маанийн зургаан үсэгний тэргүүнд орж эх болсон зургаан зүйлийн амьтан гэгчийн дээд нь гэгддэг ажээ. Сав шимийн ертөнцийн хамгийн дээд амьтан гэгдсэн тэнгэр нар анхандаа биеэс гэрэл цацруулагч ариун дээдсүүд байснаа аршаан, амуу будаа тэргүүтэн газрын идээнд шунаж нүгэл хилэнцэд орж биеийн гэрэл нь үгүй болж, гурван муу заяаны ертөнцөд унахад хүрсэнд Бурхан багш Арьяабал бурхныг илгээсэнд тэрээр тэнгэр нарын явдалд гунин гашуудаж толгой нь арван хэсэг болон хуваагдаж тэнгэр нарын явдлыг өөрнлөх санаа шулуудаж дээргүй дээд бурхан Авидын

тусламжаар Хормуст, Бимилаазэдэр, Шигээмууни, Шагжийн Арслан, Огторгуйн сан, Номунхаан зэрэг зургаан их хүчтэнг төрүүлж тэнгэр нарын орныг хормуст, асар нарыг Бимапазэдэр захирч, шагжийн арслан хэлгүй адгуусуудыг, огторгуйн сан бирдийн орныг, номунхаан тамын орныг тус тус захиран суух болсон гэж Санж гэцэлд багш лам нь заажээ. Шигээмууни бурхан өөрөө хүний орчлонг захиран суух болсон ажээ.

Чухам тэнгэр нар гэж юу болох, ямар дүрс хэлбэртэй, ямар хэлээр ярьдаг болохыг хэн ч мэддэггүй байлаа. Нэг удаа Санж гэцэл багш ламаасаа асуусанд “Эрдэм номд дэвтсэн үедээ учрыг олно” гэж хариулжээ.

Тэнгэр нараас доохно Сүмбэр уулыг эзэгнэгч асурь буюу асар гэдэг дээд амьтан байдаг гэж бас л лам багш нар сургасаар Санж гэцэл үүнд бат итгэсэн билээ. Асар нар гэж мөн л юун учиртай, ямар дүрсийн амьтан болохыг гэцэл төдий л үл ялгана. Осолдохгүй л тэнгэр асар хоёр хүний маягтай гэж ойлгожээ.

“Сүмбэр уулын оргилд Садарваасан балгасанд тэнгэр нарын эзэн Хормуст гучин гурван тэнгэрээр хүрээлэгдэн сууна. Түүнээс доохнуур асар нар аж төрөх бөгөөд тэдний эзэн Бималаазэдэр уулын доорхи агуйд суунам. Тэнгэр, асар хоёр арсалддаг. Асар нар Хормустаас аршаан хулгайлах гэж оролдцог” гэж Санж гэцэлд багш нь заажээ. Үлгэр мэт тэр яриаг Санж тогтоожээ.

Тэнгэр, асар нарын дараа хүний орчлон, дараа нь адгуусны ертөнц, тэгээд бирдийн хорвоо мөн тамын амьтан ийм зургаан зүйл амьтад тус тусын орныг эзэгнэн суудаг гэж Санж гэцэл бат итгэжээ. Гэвч эдгээрээс хамгийн тодорхой ойлгож авсан нь там, бирдийн орны тухай үлгэр шиг зүйл юм. Тэр орны талаар аймаар юмыг лам багш нь мартагдашгүй тод ярьж өгчээ.

Бирдийн оронд уул толгод шиг том гэдэстэй мөртлөө зүүний сүвэгч шиг нарийхан хоолойтой тэгэх атлаа үргэлж идэхийг мөрөөдөж

байдаг тэгээд идэх юм хоолойгоор нь багтаж ордоггүй, оровч тэр нь гал, давирхай болон шатаж амаар буцаж гардаг тийм зовсон амьтас оршино” гэж багш лам ярьжээ.

“Тийм амьтан байдаг л юм байхдаа” гэж Санж гэгцэл их гайхсан юмсан. Гэвч сүм болгонд бирдийн орны зураг дээр баруун гарт халбага, зүүндээ хоолтой бадар аяга барьсан, цүндгэр гэдэс, том нүд, гал мэт дүрэлзсэн улаан үстэй, хар хөх биетэй, яс арьс болсон хүн маягтай амьтдыг дүрсэлсэн байдгийг үзэж бирд гэж тэр хэмээн ухаарчээ.

Тэрчлэн тамын орны тухай багш лам нь бас л гайхмаар хачин юм ярьж өгчээ. Тамын оронд чөтгөр, зэтгэр, шулмас, альбин, буг, ороолон, онгод мэтийн хорлонт амьтад аж төрөх бөгөөд тэнд бас хүний орчлонгоос нүглийн үр нь гүйцэж тамд унасан хүмүүсийг зовоон тарчлаадаг газар гэж Санж гэгцэлд ойлгуулж билээ.

“Тамын арван найман саванд нүгэл ихт хүмс зовон тарчилж байдаг. Хуцын хоншоор мэт хоёр хар уул ойртож холдон дундаа нүгэлтнүүдийг няцалж байдаг. Бас төмөр дөшин дээр няцлагдаж, хангарьдад мах ясаа тоншуулж, хөрөөгөөр нүгэлтний биеийг хөрөөдөж, буцалсан халуун усанд чанаж, гадсаар дөрвөн зүгт биеийг нь тэлээд төөнөн шатааж, төмөр өргөсөн дээр нүцгэн биеэр нь тавиад гөвшдөг, хөлдөөж гэсгээх, хэлэн дээр тариа тарьж зовоодог эсвэл дотор балайрам муухай дуугаар айлган тарчилгаадаг тийм орон болой. Энэ насанд их нүгэл хийвэл арван найман тамын аль нэгэнд орно” гэж гэлэн Чоймчиг шавьдаа байн байн сургадаг байжээ.

Чухам тэр нүгэл гэдэг нь юу болохыг ч багш нь өдөр шөнөгүй давтан давтан хэлж цээжлүүлжээ.

“Таван завсаргүй нүгэл, таван шадар нүгэл, арван хар нүгэл буй. Бурхнуудыг гүтгэх, дайныг дарсныг алах, ирсний биенээс цус гаргах, бурсан хуврагуудын нөхөр салгах, сүм суварга эвдэх, сүжигт эд булаах, дүлбэ хийгээд винайн засаг эвдэх, даяанчийн идээг идэх,

амьтны амь таслах, эс өгснийг авах гэхчилэн цөм их хар нүгэл болно. Тийм явдлыг тэвчих ёстой.

Худал үг, хов үг, олхио үг, ширүүн үг эд бас хэлний нүгэл. Хорт сэтгэл, хомхолзох сэтгэл, буруу үзэл энэ бас сэтгэлийн гэм мөн. Энэчлэн үйлдвээс нүгэл алдас болно” гэж багш нь Санж гэгцэлд цаг үргэлж сурган заадаг байлаа. Тэр бүрийд тохирсон залхаалт тамын оронд бий гэнэ. Хэлний нүгэл хийсэн хүн тамын оронд очиход хэл нь сунан томорч асар том болно. Тэгээд тэр сунаж тал хөндий мэт болчихсон урт өргөн хэлэн дээр нь тамынхан анжсаар хагалж тариа тарина. Тийнхүү өвдөх нь тэсэхүйеэ бэрх болж зовлон эдэлнэ. Иймд олон төрлийн нүглийг тэвчиж бай” гэж багш лам цаг үргэлж сургана. Гэцэл Санж түүнийг хэзээ, хаа ч мартахааргүй цээжилж авчээ. Аймшигт тэр тамуудад орчихгүй юмсан гэж үргэлж хичээнэ. Бусдыг ч мөн тэгж сургах ёстой.

Нүгэлтнийг яаж мэддэг вэ? гэж нэгэн удаа Санж багш ламаасаа асууж билээ. Багш нь инээмсэглэж,

- Тамын орны эзэн Эрлэг Номунхаан Чойжил гэгч бол нэгэн гарт толь, нөгөө гарт чигнүүр бариад хаан ширээндээ заларч байдаг юм. Гэгээн толинд нь тамд очиж байгаа хүний бүхий л явдал хэрэг тодрон харагддаг. Түүний нь хүнд, хөнгөнийг чигнүүрээр дэнслэн тогтоогоод нэг бол халуун, нэг бол хүйтэн тамд түүнийг шууд шиднэ. Ес есөөр там хуваагдана. Есөн халуун, есөн хүйтэн там буй. Тэдгээр өөр хоорондоо ялгаатай. Хар шугамт тамд орсон хүний биед, жишээ нь хар зураас татагдана. Тэр зураасыг дагуулан чөтгөрүүд нүгэлтний бие рүү хадаас шааж зовооно. Эсвэл тэр зураасыг дагуулан хэрчинэ. Хэрчиж дуусмагц нүгэлтний бие дахиад л хэвэндээ орно. Дахиад хадагдах, хэрчигдэх зовлонгоо эдэлнэ. Ер нь тамын хүн үхэх, сэхэхийн хооронд байж тарчлан зовох л ганцхан үйлийг эдэлдэг юм. Хүйтэн тамд жишээ нь “татай, татай” гэдэг там бий. Тэнд цаг үргэлж “татай, татай” хэмээн орилж шүд нь хавжигнан бие нь хөлдөж дахин бас гэсэж байдаг. Нүглийнхээ хэмжээгээр л тамын орон нь оногддог юм гэж багш нь зааж билээ. Бүр банди байхдаа Санж,

- Багшаа, тэр аймшигтай тамын орон чинь хаа байдаг вэ? Үзэж болох уу? гэсэнд багш нь түүнийг өрөвдөж,

- Тамын орныг амьд хүн үзэх ёсгүй, үхэж төрөл арилжихдаа л тэнд очдог юм. Ер нь тамын орныг үзэхсэн гэж боддог хүн хорвоод төрөөгүй. Цөм л диваажин, сухааваадийн орныг хүсдэг юм. Тамын орныг үзье гэхэд нүгэл хийгээгүй хүн бол яагаад ч тэнд очихгүй. Эрлэг номон хаан түүнийг авах ч үгүй гэж сургасан билээ. Түүнээс хойш гэцэл Санж тамын орныг үзэх тухай багшаасаа дахин асуугаагүй. Харин багш нь Буянзалбирах хийдийн бага дуганд байдаг тамын орны зургийг үзүүлэн удтал ярьж өгч билээ.

“Гурван мянга, их мянган ертөнцийн цаана одно гэж багш маань ярьж байсан. Тэр чинь багшийн зааснаар сухааваадийн буюу диваажингийн орон байх учиртай. Хөөрхий багш маань диваажинд очихыг мөрөөдөж байжээ. Тэр нь ёсоор болох болтугай” гэж Санж гэцэл аршаан сүрчимдэж байх зуураа бодлоо.

Аршаан сүрчимдэх буюу таринадах гэгч нь сүмд мөргөлийн уншлага дуусахад хоёр лам гүцтэй цэхэр ус авч ирж бүх лам нарыг тойруулан явуулж таринадуулах зан үйл юм. Үл мэдэг цэхэр өнгөтэй болтол нь сүүтэй хольсон усыг гүцэнд хийж мөн арц гүгэл унгатгасан сангийн хамт лам бүрийн өмнө хоёр лам аваачихад лам нь тэдгээр л үү үлээж таринадана. Тэгж элдэв муу юмнаас ариутгал үйлдэж байгаагийн зан үйл хийнэ.

“Багшийн замд саад тотгор бүү тохиолдог” гэж толгойдоо бясалгаад Санж гэцэл аршаан таринадав.

Зургаан зүйл амьтны тусын тулд Бурхны шавь нар зав зайгүй хурал хурж, уншлага үйлдэж байдаг боловч бирд, тамын орныг юунд гэж маанийн зургаан үсэгт оруулан юм бүхний эхэнд “Ом маа ни бад мэ хум” гэж уншсаар байдгийг гэв гэнэт Санж гэцэл гайхан эргэцүүлэв. Утгыг урд нь боддоггүй байжээ.

“Тэнгэр, асар, хүн, адгуусны төлөө ч мөргөн залбирч болох юм. Гэтэл бирд, тамын орныхны төлөө яагаад сүжиглэдэг билээ? Тийм орон байдаг бол, тэнд очихыг хүсдэггүй бол яагаад тэрний тухайд уншлага хийдэг билээ” гэж гэнэт бодов. Ийм бодол Санжийн толгойд хэзээ ч орж байгаагүй. Учир нь маанийн зургаан үсгийн гүн утгыг ойлгодоггүй хий цээжилсэн байдаг байлаа. Одоо болохоор тавтайгаасаа убаш, долоотойгоосоо банди, арван тавтайгаасаа гэцэл өнөө хориод насны ойд золгох завсар шашны ухаанаас өөр юу ч сонирхолгүйгээр завсаргүй үзэн судалж явдгийн үрээр гэнэт эргэлзээ төрдөг юм болов уу гэмээр. Тэгээд,

- Нүгэл алдас болно. Бүү ийм юм бод! гэж гэцэл Санж өөртөө тушаалаа. Нүгэл, буянгийн ялгал юун болохыг тэрэнд эргэцүүлэн бодох үе олон тохиолдсон билээ. Бодох бүрийдээ бурхан шашны нэгэнт тогтсон ёсноос гажих хандпага гарахад хүрвэл өөрийгөө зогсоон хазаарлаж “Нүгэл, алдас болно!” гэж сэрэмжилдэг байлаа.

Маанийн үсгийг хэдэн сая, живаа дахин уншсанаас орчлон хорвоогийн хувь заяа сайжирдаг юм бол нэгэнт тийм цаг ирэх болсон биш юм уу? Ийм асуулт хожим Пабанхиаг тойрч явах үед гунисан сэтгэлд нь орж л байлаа. Тэр бүхнийг харгалзахгүйгээр маанийн үсгийг бүх насаараа унших хувь тавиланд тэр эргэлтгүй живжээ.

Арван нэг. Есөн мэнгэ голлосон нь

Эгнэгт батгүйн тулд нас хэврэг
Эгүүрт ханилахгүйн тулд амраг хэврэг
Эцэстээ барагдахын тулд эдлэл хэврэг

Мацаг өдөр байлаа. Сар бүрийн найман, арван таван гучинд мацаг өдөр болж лам нар мацаг барина. Энэ нь лам хүний ёс суртахууны журам буюу бараамидийн дөрөвдүгээр дүрэм ёсоор сахих учиртай зүйл. Зургаан гол бараамид байдгийн эхнийх нь өглөг бараамид, дараах нь хүлцэнгүй бараамид, гурав дахь нь хичээнгүй бараамид юм. Өглөгч, хүлцэнгүй, хичээнгүй байхын сургаал мөн. Мацаг барих нь дөрөвдүгээр бараамид буюу шагшаабадын ёс. Өөрөөр хэлбэл тэвчлэгийн ухаан юм. Лам хүн юуны урьд мах цусанд шунахай байж болдоггүй. Иймд мацаг барьж мах идэхийг цээрлэдэг шагшаабад бий болжээ. Шагшаабад сахиж чаддаг лам цаашлаад даян хийж даяанчилж чадна. Даяанчлах нь хүнээс холдож ганцаар суун бясалгал үйлдэхийн нэр юм. Мөн тэрчлэн билэг бараамид буюу ухаанаар бясалгах ёсны номыг лам хүн эзэмших учиртай. Ийм зургаан бараамидын дөрөвдүгээрийг сахих өдрийг мацаг барих ёс гэж лам нараар их л нарийн сахиулдаг болой. Санж гэцэл зиндааны нөхдийн хамт хаврын дунд сарын наймны өдрийн мацаг барихаар маанийн өргөөнд өглөө орцгоолоо. Багш лам нь тэдэнд “Маанийн Чойго” гэдэг судрыг уншууллаа. Тэр сударт мацаг барих буюу нумнэй сахих журмыг нарийвчлан заажээ. Нумнэй сахих нь амаргүй том шалгалт гэдгийг тэдэнд ойлгуулж өглөө.

Тэр шөнөдөө нойргүй, дуу шуугүйгээр маанийн өргөөнд өнгөрөөнө. Маргааш нь зөвхөн ганц удаа махгүй хоол иднэ. Тэр нь жорба буюу хагас мацгийн өдөр. Түүний маргааш хоол идэх ч үгүй, дуугарах ч үгүй, шүлсээ ч залгихгүй өнгөрөх ёстой. Энэ нь жинхэнэ мацгийн өдөр. Гурав дахь өдөр нь хоолонд эргэн орно. Гэхдээ мах идэхгүй.

Дөрөв дэх өдөр нь дахин мацаг барина. Ингэж ээлжлэн үргэлжлүүлсээр арван зургаа хоног мацаг барьж нумнэй сахина. Найман нумнэй тийнхүү өнгөрвөл тэрхүү хуврагийн нүгэл цэвэрлэгдэнэ. Тэгэхдээ хоол идсэний л нүглийн тухайд энэ хамаарна. Ийм дүрмийг Санж гэцэл анх удаа сонсож байгаа нь энэ. Урьд нь тэр мацаг барихад ёсоор нь нэг их оролдож байсангүй. Гагцхүү махгүй хоол, цагаан хоол идэх төдийгөөр хязгаарлагдаж байжээ.

Гоман дацангийн Линсрай гавж Лүндэгжунай гэгч одоо Санж гэцлийн номын багш болжээ. Линсрай гавж бол ном эрдэм, ёс жаяг сайн мэддэг, хатуу гартай, камба хүн юм. Өөрөөр хэлбэл кам нутгийн гаралтай түвд хүн ажээ.

Лүндэгжунай гавж шавь нартаа их хатуу, бас ч сургах ёстой гэсэн бүхнээ заавал сургадаг хүн тул зургаан бараамидыг шавь болгонд өдөр тутмын хэвшил болгохоос нааш санаа амрахгүй нь лавтай. Тэгээд л энэ удаа шагшаабад сахиулан мацаг бариулах ажлыг өөрөө гардан хийж байлаа. Линсрай гавж гэдэг болж Гоман дацангийн хамбаас уул дацанд арван жил ном үзэж байж авсан гавжийн цолтой хүнийг хэлнэ. Линсрай гавж өөрөө бүхий л бараамидыг сахин өнгөрсөн хүн тул шавь нартаа мөн л тэр замыг сонгожээ.

Мацаг барихад бэлтгэх эхний шөнө цөм л суугаагаараа нойргүй, дуу шуугүй хоножээ. Тэр нь асар их тэвчээр шаардсан боловч Санж гэцлийн зиндааныхан тийм шалгалтыг танагтай давжээ.

...Нумнэй сахих зан үйлийн найман мөчлөг өнгөрч сүүлчийн өдөр болж байлаа. Өөрөөр хэлбэл арван зургаа дахь өдөр. Энэ өдрүүдэд Санж нөхдийн хамт хач гүргэм, шанц хольсон усан зутан идэж байлаа. Хоёр нумнэй өнгөрсний дараа Санж гэцлийн бие нэг л эвгүйрхэн сульдсаар, сүүл сүүлдээ ихээхэн зовиуртай болсон ажээ. Долоо дахь нумнэйн үед хар хөлс нь чийхарч муужирч унамаар болж байв. Элгэн дээр нь мушгиран өвдөж, бие нь суларч, тэсч сууж чадахгүй болсон ч гэсэн Санж гэцэл тэссээр л байлаа. Тэгтэл найм дахь нумнэй төгсгөл тийш ойртох үед нүдэнд нь хар ногоон цагираг

эргэлдэн үзэгдэх шиг болж, дотор нь харанхуйлан, элгээр эвхэрч байгаад юу болсныг мэдэлгүй муужран ойчлоо.

Лам нар тэвдэн сандарцгааж Санжийг дамжлан өргөж гадаа гаргав. Тэр даруй морин тэргээр гэцэл Санжийг гэрт нь хүргэж, зиндааны нь нөхөд сувилян сахилаа. Юуны урьд утлага үйлдэв. Утлагын хиншүү утаанаар гэцэл сэхээ орж нүдээ нээжээ. Гэвч бие нь сайжирсангүй. Оройхон тийшээ багш гавж Лүндэгжунай залран иржээ.

- Амны уншлага чинь юу билээ? гэж тэр дөнгөж амь голтой байгаа Санж гэцлээс асуулаа. Гэцэл арай чүү ам нээж,

- Ом на ма шад суухаа! гэж дуугарлаа. Гавж Лүндэгжунай “Зурхайн литээ” нээн үзсэнээ,

- Аа, хаврын эхэн сарын арван таванд Риваади одноо, цэн күлилд тохион төржээ. Эм усан гахай жил. Хаянхирваа шүтэж явах ёстой гэж аман дотроо ганцаар ярилаа. Тэгээд хэсэг зуур бодлогоширсноо,

- Жилийн есөн нүд, үхрийн есөн нүдэнд орсон байна. Уул нь уржнан л орсон баймаар юм. Тэгэхээр есөн нүдний голлолтоос гаргах хэрэгтэй. “Мэнгэний гол” уншихаас аргагүй. Чойгын ус бэлтгэцгээ! гэж Санжийн нэг зиндааныханд шаардлаа.

Мэнгэ голлох нь хүний амьдралд есөн жил тутам нэг удаа тохиолдох гай зовлон юм хэмээн лам нар үздэг ёсоор гэцэл Санжийн хоёр дахь ес нь тохиож гэж гавж Лүндэгжунай бодсон юм байжээ. Тэрчлэн арван хоёр жил тутам хүний жилийн орлого тохионо. Найман махбод буюу кулил, хорин найман одны тохиолыг зурхайн номонд зааснаар тооцоолон аливаа хүний нэр, унах морь, шүтэх бурхан, амины уншлагыг тодорхойлно. Тэр ёсоор гэцэл Санж эм усан гахай жилийн хаврын эхэн сарын арван таванд Риваади од, цэн күлилд тохион төрсөн тул Хаянхирваа бурхан шүтэж, хөх бор морь голчлон унаж, “ом на ма шад суухаа” гэдэг маанийг амны уншлага болгож авах ёстой байлаа.

- Мэнгэ голлосон тул уншлагыг зуун найман бүлэг дүүргэн хийж, золиг гаргахгүй бол яагаад ч тэсэхгүй гэж Лүндэгжунай гавж айлдлаа. Нэгэн зиндааныхан нь багш ламын үгээр даруй хөдөлж уншлагад бэлтгэж эхэллээ. - Золигт гаргах юмыг олоход бэрх. Иймд бэлэн газраас олж ир. Гүрэмч Пагвад очоод хэлбэл тэр ёсоор нь өгнө гэж Гавж даалгав. Санжийн зиндааны нөхөр - Багш аа, юу авчрах юм бэ? гэж гайхлаа.

- Есөн уулнаас авсан шороо, их голын ёроолоос авсан элс, хүн оршуулгын газрын шороо, есөн хар, есөн цагаан чулуу, есөн эрлэгийн зурагтай самбар ийм зүйлс мэнгэн заслаганд ордог юм. Би та нарт аль эртэд заагаа биз дээ? гэж Линсрай гавж ууртайяа тушаалаа.

Нэг шавь нь гарахаар завдахад,

- Хөөе! Пагва гүрэмчид хэлээрэй. Чумар голын ёроолоос авсан элснээсээ өгөөрэй улаан өнгөтэй байдаг юм гэж гавж нэмж хэлэхэд “Чумар гол” гэсэн үгийг Санж бүдэг сонсоод нүдэнд нь улаан цагираг эргэлдэн үзэгдэх шиг болж дахиад л ухаан алдлаа. Зүүд нойр шиг бүдэг юм тархинд нь эргэлдэнэ. Чумар гэдэг нь Улаан мөрөн хэмээх үг юм. Түүнийг монголчууд Хавтгай улаан мөрөн гэж нэрлэнэ. Тэр голоор морьтой гатлах юм уу, унаа мал ойчиход ёроолын улаан элс нь хуйлран босч яг л цусаар эргэлдэх шиг болдог ажээ. Лхас орохоор ирж явах замд Хавтгай улаан мөрний эрэг дээрээс Өлзийн морь хөл алдаж усанд ойччихсон билээ. Тэр голд улаанаар эргэлдэн бужигнасан улбар шар цүнхээл гарч үзэгдэхэд Санж гэцэл цочин айж билээ. Тэр бүхэн өнөөдөр гэцлийн бүрхэг оюунд дахин дүрэлзэн асч улаанаар эргэлдэх шиг болжээ.

- Гэцлийн дүрсийг гурилаар үйлд. Хурцсыг нь дууриалган хийх ёстой. Хар, цагаан хоёр арьс хэрэг болно. Олж ир гэж өөр нэг шавьдаа Гавж ламтан тушаалаа.

Гавж Лүндэгжунай бусад уншлагыг хийхээр суулаа. Нүдээ хагас

аниад,

- Их Махаранз тэнгэр минь ээ. Вирутаки, Вирутакши, вайстраавани тэнгэрүүд минь ээ! гэж тэр уншлагаа эхэллээ.

Ламын уншлага нэлээд удаан үргэлжлэх хооронд Санж гэцлийн нэг зиндааныхан “Мэнгэн засалд” бэлтгэж шаардлагатай бүх юмыг бүрдүүллээ.

- Хар цагаан хоёр арьсыг тэнд тавь. Хар арьсан дээр мэнгэ голлогчийг суулга. Өмнө нь гурилан золигоо тавь гэж гавж Лүндэгжунай шавь нартаа заалаа.

Шавь нар нь тэр ёсоор болгож, гэцэл Санжийг хэдүүлээ өргөж хар ямааны арьсан дээр арайхийн суулгалаа. Хажуу тийшээ ойчих гээд байхад нь хоёр талаас буйдан түшүүлж тогтоов.

Гавж Лүндэгжунай өмнө талдаа жижигхэн цагаан эсгий олбог дэвсээд мэнгэ голлогчийн эсрэг харж суулаа. Цагаан эсгий дээрээ зураас татаж эхлэв.

- Есөн уулчаас авсан шороо хаа байна? гэхэд шавь нь цаасан дээр зурсан зургууд өгөв.

Гавж түүнийг нэг нэгээр нь авч эсгий дээрх зураасныхаа эцэст тус бүр байрлуулав. Бүгд есөн зурвас, есөн зураг эгнүүлэн тавьжээ.

Дараа нь гавж тухлан сууж хүний үхлийн есөн шалтгийн тухай уншлагыг дүнгэнэтэл уншиж гарлаа. Тэгэхдээ үхлийн шалтаг нэгийг уншаад хар өнгөтэй хайргаар гурилан золиг руу ууртайяа шидэж,

- Үхлийн хар сум золигийг онох болтугай! гэж хэлэв. Мөн цагаан чулуун хайргаар Санж гэцэл рүү цацаж,

- Амьдын цагаан гэгээ соёрхоё гэв.

Тэр мөчид өвчтөн босч өнөөх есөн зурвасын нэгийг алхаж гараад,

- Нэг даваа давж, нэг үхлээс гарав! гэж хэлэх ёстой байлаа. Гэвч Санж гэцэл тэгэх тэнхээ байсангүй. Нөхөд нь түүнийг өргөж нэг зураас давуулаад,

- Нэг даваа давж, нэг үхлээс гарлаа! гэж хэлцгээлээ.

Ийнхүү үхлийн шалтаг есыг нэг бүрчлэн дурдаж, өвчтөнг нэг нэг зураас давуулан суулгаж, есөн удаа тэрхүү үйлийг давтан дуусаад,

- Есөн даваа давж есөн үхлээс гарлаа! гэж хэлэхэд эсрэг талд байгаа цагаан арьсан дээр өвчтөнг өргөж суулгалаа.

Гавж Лүндэгжунай золигийг авч мэнгэ голлогчийн толгой дээр нар буруу гурав дахин эргүүлээд таринадмагц,

- Энэ золиг руу нулим! гэж хэлээд золигийг Санж гэцлийн нүүрт ойртуулан барихад гэцэл ядарч туйлдсанаас болоод нулимж чадахгүй байлаа. Ам нь ч хуурайшчихжээ.

- Гурвантаа нулимахтун! гэж гавж чанга сүртэй дуугаар шаардав. Санж гэцэл юу хийлгэх гээд байгааг арайхийн ойлгож, нулимах гээд бас л чадахгүй, дэмий л амаа хөдөлгөв.

- Та нар нөхрийнхөө өмнөөс нулимтугай! гэж багш гавжийгаа тушаахад нэг зиндааныхан нь тэр золиг руу цөм л ууртайяа нулимцгаалаа.

- За одоо гаргаад зүүн хойт зүг хаягтун, энэ золигийг! гэж гавж лам хэлэхэд нэг зиндааныхан нь тэрийг дор нь гүйцэтгэв. Гавж Лүндэгжунай мэнгэн заслыг дуусгаж, өвчтөнг аршаанаар ариутгалаа. Санж үүнийг бүдэг бадаг ойлгов.

Гэцэл Санжийн зиндааны нь нөхөд зутангаар хооллосон болоод оронд оруулан хэвтүүлж хэсэг сууцгаагаад гэр гэрийн зүг тархахаар босов. Тэд итгэл алдсан байдалтай болжээ.

- Одоо гайгүй бий. Өнөө шөнөдөө элдэв муу юмнаас хагацаж маргаашнаас цэвэрлэгдэн ариусаж хуучин байдалдаа дахин орох биз гэж гавж лам Лүндэгжунай айлдсанаар цөм л түүний үгэнд итгэж Санж гэцлийн сайн хувь тавиланд найдаад явцгаажээ. Гэвч Санж гэцэл тэр шөнөжингөө тарчилж өнгөрөв. Маргааш нь нэгэн зиндааныхан ирж Санж гэцлийн бие онц муудсаныг үзээд гавж багшийгаа дуудуулжээ. Лүндэгжунай гавж даруйхан хүрч ирээд,

- Эрхэм сүнс нь хариагүй л байна. Харин үхээрийн сүнс нь хол оджээ! гэж хэлэв.

Энэ үгэнд зиндааныхан их айлаа. Гэвч Санж гэцэл түүнийг хагас дутуу ойлгож байлаа.

- Үхээрийн сүнс нь явчихаар яадаг юм бэ? гэж тэд багшаасаа асуухад,

- Явчихсан тэр сүнсийг дуудах ёслол хийвэл таарна. Та нар хэрэглэгдэх юмыг бэлтгэцгээ гэв.

“Хүнд эрхэм сүнс, үхээрийн сүнс гэж хоёр бий. Хэрвээ үхээрийн сүнс биеийг орхивоос хүн үхмөй. Тийм учраас сүнс дуудлага хийвэл зохино” гэж бурхны номонд заажээ. Тэр ёсоор гавж Лүндэгжунай гэцэл Санжийн үхээрийн сүнсийг эргүүлэн дуудах зан үйл хийж эцсийн удаа шавийнхаа төлөө буг чөтгөртэй үзэлцэхээр шийдлээ. Гавжийн шавь нар,

- Юу бэлдэх вэ? гэж зэрэг зэрэг асуулаа.

- Есөн эрлэгийн яргачны дүрсийг гурилаар үйлд. Ямааны цоохор арьс нэгийг дөнгөж биеэс нь хуулан авч нойтноор нь бэлд. Таван өнгийн даржин ол. Бас ойл, лантуу олж ир! гэж багш лам тушаалаа. Тэдний

хагас нь багшийнхаа даалгасан зүйлийг олохоор явах болоход мөнгөний асуудал дэгдэв. Санж гэгцэлд хэлэхэд тэр арайхийн ойлгоод гэлэн багшийнхаа өгсөн хэдэн лан мөнгийг тэдэнд зааж өгчээ. Лүндэгжунай гавж өөрөө сүнс дуудах уншлагад бэлтгээд орой эргэж ирэхээр явлаа. Учир нь гэвэл сүнс дуудах зан үйлийг шөнө дунд хийдэгэжээ. Эрлэгийн есөн яргачингийн дүрсийг түүхий гурилаар хийхээр зиндааныхан нь өдөржин махран оролдож орой бэлэн болгожээ. Санж гэгцлийн бие гамирдан доройтсон хэвээр байлаа.

Харанхуй болоход Лүндэгжунай гавж ирэв. Тэр сүнс дуудлагын нууц ном Шидил гэдэг бяцхан судар авчирчээ. Олбог дэвсүүлэн тухлан суумагц

- Есөн яргачингийн сүг бэлэн үү? гэж Лүндэгжунай гавж сүртэй асуулаа. Шавь нар нь түүхий гурилаар хийсэн есөн сүг дүрсийг гаргаж ирэв. Лам толгой дохиж,

- Түүхий цоохор арьсан тулам бэлэн үү? гэж дахин асуухад,

- Энэ байна гэгцгээж хуврагууд цоохор ямааны нойтон арьсан тулам өгөв.

- Тэгвэл сүгнүүдийг наад тулман дотроо хий. Тэгээд урт дээсээр амыг нь боож, гадуур нь ес дахин ороогтун! гэж гавж даалгав. Тэр ёсоор болголоо! Лүндэгжунай гавж нууц судар Шидил гэгчээ нээгээд уншлагаа эхэллээ. Сүгтэй тулмыг тойроод есөн хувраг сүх, лантуу, сэлэм тэргүүтэн барьж зогслоо. Нэг нь хаа газраас хуучин цахиур буу олж иржээ. Тэд шалан дээр боодолтой хэвтэж байгаа цоохор ямааны арьсан туламтай гурилан сүгнүүдийг сүртэйеэ бөгөөд заналтайяа хүрээлэн бүсэлж байх нь Лүндэгжунай гавжийн сэтгэлд нийцжээ.

Шидил судрыг уншиж дуусахад есөн хуврагийн нэг нь туламтай сүгнүүдийг авч мөрөн дээрээ хаяад гүйн гарав. Араас нь бусад хуврагууд хөөн гарч гавж багшийнхаа заасан ёсоор зэрлэг муухайгаар хашгиралдан дуу шуугиан дэгдээж, дотор эвгүйрхмээр дэнслүүлэн

орилолдож байшинг гурвантаа тойроод ахин үүдэн дээр ирэхэд өмнөөс нь угтан цахиур буугаар тэнгэр өөд хий буудаж, улангасан хашгиралдав. Сүг үүрч явсан хүн бажгадан айх дүр үзүүлж туламныхаа амыг тайлан дотроос нь есөн аримийг үүдэнд газар асгалаа. Хуврагууд нөгөөх гурилан аримийг түрүүрүүгээ харж унасан бүгдийг нь алх, лантуугаар бяцлан цохих ёстой байсан ажээ. Эхний удаа хоёрхон аримь түрүүгрүүгээ харан ойчжээ. Түүнийг авах юмгүй бяц цохив. Өөдөө хараад ойчсон гурилан сүгнүүдийг дахин цуглуулж тулманд хийгээд мөрөндөө үүрч байшин тойроод гүйцгээж орилоон шуугиан дэгдээлээ. Шөнийн чөтгөрийг цочоон сэрээх гэж тэгж орилолддог ажээ. Хэрвээ аримь түрүүгрүүгээ харалгүй, өөдөө харж унасан бол тэр нь дахиад л авлага шаардаж байгаа хэрэг гэж үздэг байжээ. Байшинг гурав тойрон ирэхэд бас л үүдэн дээр буу тавин угтлаа. Туламнаас сүгнүүдийг дахин асгахад таван аримь уруугаа харан ойчжээ. Тэднийг бас л няц цохилоо. Одоо хоёрхон

аримь өөдөө харсан хэвээр тул дахиад л шуудайлан авч явлаа.

Байшинг дахин гурвантаа тойрч, сүгийг дахин газар хаявал арайхийж цөм уруугаа харжээ. Цөмийг хорсолтойгоор няцлан хог болголоо.

Гурилан сүгэнд л хамаг гай шингэсэн мэт сүйд болцгоов.

- Цуглуулж аваад хол очиж бул! Тэгээд хар чулуугаар дээрээс нь дар! гэж Лүндэгжунай гавж шавь нартаа чандлан тушаалаа. Шавь нар нь хэлсэн ёсоор гурилан сүгнүүдийн хэлтэрхийнүүдийг хамж аваад хол аваачиж булахаар одлоо. Гавж тийнхүү эргэж байшинд орж ирвэл Санж гэцэл өөдтэй сайжирсан юм огтгүй. Харин ч доройтох маягтай харагдлаа. Лүндэгжунай гавж сэтгэл зовж “Сүнс нь эргэж ирээгүй байх нь ээ. Төөрчээ янз нь. Одоо тэхээр яах билээ” гэж бодов.

Бодолдоо дарагдан бүр зовчихлоо.

Лүндэгжунай гавж бол шажоотын ухаанд юмуу лхантовчимбыг ер судалж яваагүй болохоор өвчнийг гагцхүү сэтгэлийн заслаар анагаахыг боддог хүн байжээ. Тэр л ёсоороо гэцэл Санжийг эмчлэхийг хүсчээ. Тэр нь бүтэлтэй юм болмооргүй байв.

Шавь нарыгаа буцаж ирэхэд Лүндэгжунай гавж,

- За хүүхдүүд ээ! Сүнс нь төөрчихсөн бололтой. Тэгэхээр би дахин түлхээс үзүүлж зэтгэрээс салгахаас яах вэ? Та нар таван өнгийн даржин бэлтгэсэн үү? гэв. Таван өнгийн даржин гэдэг туузыг шавь нар бэлджээ.

- Үүний толгойг ороож гадагш хаалгаар гарган даржингаа тэл! гэж багш лам нь зааварлав. Тэр ёсоор өнгийн туузын нэг үзүүрээр Санжийн толгойг ороож, нөгөө үзүүрийг гадагш гаргалаа.

Лүндэгжунай лам дахин уншлага үйлдэж эхлэв. Биеэс дур мэдэн зайлж тэнүүчлэн яваа сүнсийг айлган сүрдүүлэх, чөтгөр шулмасын орныг зүхэн хараах зэргээр гавж асар сүртэй юм уншиж байлаа. Тэр хооронд хэдэн хувраг гадаа гарч шавар тагзыг эргэн гороолж, залбирцгаан,

- Ирээ! Ирээ! Ирээ! гэж гуншигнан чарлацгааж явлаа.

Лүндэгжунайтан уншлага үргэлжлүүлэн дүнгэнүүлж байснаа,

- Ирээ юү! Ирээ юү? Ирээ юү? гэж маш чангаар хашгиран асуужээ. Г адаа байшин тойроод гороолж явсан лам нар түүний хариуд,

- Ирэв ээ? Ирэв ээ Ирэв ээ? гэж гурвантаа чанга хашгиран хариу өчлөө. Тэдний дуу гаслах мэт аягүй сонсдов.

Түүнийг сонсоод Лүндэгжунай гавж өмнөх таваг дээрээ бэлтгэсэн арвайнаас атган авч Санж гэцэл рүү таринадан цацав. Гаднаас хүмүүс орж ирээд таван өнгийн туушийг эвхэж Санж гэцлийн хүзүүнээс зүүж өгөв.

- Долоо хоног даржинг авч болохгүй! гэж Лүндэгжунай гавж зааварлав. Алаг эрээн даржингаас л шалтгаалах юм шиг!

Шөнө их орой болсон тул өвчтөнг мөн л орхиж цөмөөрөө явцгаалаа. “Одоо Санжийн сүнс аргагүй л нэг буцаж ирээ биз дээ. Юу бодож явж сүнс нь зайлан төөрдөг юм бэ дээ” гэж нэг зиндааныхан- нь бараг ижил бодолтой байлаа. Багш ламынхаа хойноос дэнсэлж шаналснаа нөхөддөө хэлсэн бол тэд аргагүй л зайлах байж гэж итгэхэд хүрэх нь лавтай билээ. Нумнэй сахиснаас бие муудаж сүнс зайлсан гэвэл тэд огт итгэхгүй л байхсан. Гэвч үнэн хэрэг дээрээ арван зургаа хоногийн өлсгөлөнгийн гарыг Санж гэцэл даагаагүй ч юм билүү, бүү мэд. Ямар ч гэсэн бие ихээхэн суларч доройтжээ. Лүндэгжунай гавж, шавь нарынхаа хамтаар Санж гэцлийн амийг аврах, сүнсийг нь буцааж дуудах талаар чадах бүхнээ хийжээ. Одоо ганцхан Санжийн өмнөөс хэн нэгнийг золигт гаргах үлджээ. Гэвч нэр алдаргүй, өчүүхэн гэцлийн төлөө хэн ч золигт гарахыг хүсэхгүй нь тодорхой билээ. Гагцхүү заяа мэдсэн хэрэг болжээ.

Арван хоёр. Долоон тамир сульджээ

Хөлгүй могой хурдан явах нь гайхал
Сүхгүй шувуу үүрээ барих нь гайхал
Нүдгүй шоргоолж нүхээ олох нь гайхал

Золигт гаргасан, сүнс дуудсан зан үйлийн хүчинд залуу гэгцлийн бие засран эдгэрнэ гэж гавж Лүндэгжунай шавь нарынхаа хамт итгэсэн боловч тэр бүхэн талаар өнгөрчээ. Санж гэгцлийн бие сайжирсангүй. Хэдэн хоног орноосоо босч чадсангүй. Лүндэгжунай ламтан сүнсийг дахин дуудах гэж шийдсэн боловч гэгцэлд мөнгө байсангүй, ямар нэгэн дур булаамаар хувцас, эдлэл ч байсангүй. Тэгээд ч түүний бие сайжрах найдваргүй мэт санагдсан тул “Сүнсийг дахин дуудаад эгэж ирэхгүй бол нэгэн зиндааныхан ч миний тухай элдэв юм бодож магадгүй. Иймд сэрэмжилбэл таарна. Хол нутгийн хүн учир сүнс нь ар гэртээ одоод төөрсөн хэрэг” гэж боджээ.

- Хэтэрхий хол газраас зорьж ирсний учир сүнс нь нутаг орны зүг эгэн гүйж Монгол газрын уул хаднаа төөрчээ. Ийм хэрэгт дахин сүнс дуудаад ч нэмэргүй болов уу. Гэвч өвчтөний сүжиг мэднэ хэмээн Лүндэгжунай гавж айлдлаа.

“Ирэвээ! Ирэвээ! Ирэвээ!” гэж өчигдөр шөнө хашгиралдаж байсан хуврагуудын сэтгэл гансран донсолжээ. “Ирээгүй юм байж дээ!” гэж тэд гайхан бодов.

- Мамбын дацангийн маарамба Пүрэвдонойд л өгч сүүлчийн горьдлогоо барахаас яахав гэж Лүндэгжунай хэлжээ.

Багш ламынхаа хэлсэн ёсоор шавь нар нь нэг зиндааны нөхрөө эдгээхийн тулд юу ч хийхэд бэлхэн байсан тул Мамбын дацан руу

явцгаажээ.

- Над найдаж л байгаа юм бол аваад л ир! Лүндэгжунай гавж аргалж чадаагүй бол тэртээ тэргүй гайд гарсан амь байх нь л дээ. Горио тасалж, хочоо барая гэж санацгааж байгаа бол аваад л ир. Харин би явж очиж эмнэж чадахгүй шүү. Миний гэрийн илүү гонхонд хэвтэнэ биз гэж Пүрэвдоной маарамба хэлэхэд хуврагууд цөм л зөвшөөрч илжиг хөллөсөн тэрэг олж аваад Санж гэцлийг авахаар иржээ. Тэднийд очих эсэхээ Санж шийдэж ядав.

- Аав, ээж маань юу гэх байсан бол оо! гэж Санж гэцэл арайхийн дуугарав.

- Тэд юу гэх вэ? Хагас жил шахам явж байж хэл хүрнэ шүү дээ. Хэл хүрээд ч тэд эцсийн горьдлого бүхнийг л хий гэнэ биз дээ. Эцсийн горьдлого бол одоо Пүрэвдоной маарамба байна гэж нөхөд нь ятгаад Санж гэцлийг илжгэн тэрэгний хатуу данзан дотор хэвтүүлэн авч одлоо. Замын зуур нөхөд нь Санжид,

- За чи маарамбад сүжиглэвэл зохино. Өөр аврал байхгүй. Ганцхан та л амь насыг минь аварч өгөөч гэж л гуйгаад бай. Өөрт нь итгэсэн хүнийг эдгээгээд л өгдөг маарамба байгаа юм. Юу хий гэсний нь л хийгээд бай. Үгнээс нь гарч болохгүй гэж захицгаалаа.

Пүрэвдоной маарамба шавар тагзныхаа хажуугийн гонхонд Санж гэцлийг хэвтүүллээ. Нөхдөд нь тэр хэлэхдээ,

- Хаяа ирж доройтсон нөхрийгөө хооллож байгаарай. Би хөгшин амьтан, бусдыг байтугай өөрийгөө адгуулж чадахгүй гэв.

- Тэгэлгүй яахав гэж нөхөд нь амлахад,

- Тэгэхдээ өнжөөд ганц ирж бай. Өдөр бүр үүгээр үймэлдээд нэмэргүй шүү гэж Пүрэвдоной маарамбатан хэлэв.

Нөхдийг нь явсны дараа Пүрэвдоной маарамба өвчтөнгийн судсыг барихаар шийдээд Санж гэцлийн өмнө ирж намхан ханз сандайлан суугаад,

- Хэзээ өвдөөв? гэж монголоор асуув.

- Нумнэй сахиж эхний хоёрыг дуусгаад байтал өвдөж эхлээд наймдах нумнэйг дийлсэнгүй ухаан алдсан гэж Санж гэцэл түвд хэлээр хичээнгүйлэн хэлэв.

- Хөөш чи чинь түвдээр сайхан ярьж байх чив? Тэгээд юунд хадаг зиндаанд суудаг билээ. Түвдэд ирээд удаж байна уу? гэж Пүрэвдоной маарамба гайхлаа.

- Хагас жил гаруйхан болж байна гэж Санж гэцэл арай ядан хэлэв. Шаналгаандаа дийлдээд үг ч хэлж чадмааргүй байлаа.

- Тэгвэл чи түвд хэл сайн сурчээ. Овоо дориун сийрэг ухаантай хувраг байх нь ээ! Тэгвэл чамайг эдгээж авбал зохино. Бурханд сайн шавь хэрэгтэй гэж маарамба хэлээд гэцлийн судсыг атган юм чагнах мэт суух зуур Санжийн зүс царайг удтал ажиглав.

- Кайб жунайн даягаар (судар) бол судасны цохилт тавин найман янз. Нэг амьсгааны хугацаанд таван удаа цохилох ёстой гэж гэнэт Пүрэвдоной маарамба ганцаар ярив. Санж гэцэл гайхаж өөрт нь хэлж байгаа юм гэж бодоод тогтоож авлаа.

Пүрэвдоной маарамба бусдыг эмчлэх үедээ анагаах ухааныхаа эрдмийг шалгаж, амандаа юм уу ер нь чанга дуугаар давтан уншиж сурчихсан хүн байжээ. Өөрөө ч тэр заншлаа их хэрэгтэй зөв юм гэж боддог байв. Мартсанаа үргэлж санаж байхад хэрэгтэй. Бас өвчтөнгүүд ч яриаг нь сонсоод түүний их эрдмэнд шүтэн бишрэх учиртай зүйл гэж тэр боддог байжээ.

Пүрэвдоной маарамба Санжийг хэлээ гарга гэж тушаагаад,

- Хэл нь ч зүгээр л байна. Хортой юм идсэн бол хар хөх болсон байх ёстой. Идсэн юмнаасаа болоогүй байна гэв.

- Нүдээ нээж, баруун зүүнээ эргэлдүүлэгтүн гэж маарамба шаардлаа. Санж түүний дурыг дагууллаа.

- Нүд нь ч бас л зүгээр байна. Өнгө нь хэвээрээ. Нэг ч судас улайгаагүй байна гэв.

Дахин бас судсыг нь барьж үзэв.

- Долоон тамир чинь дордон сульджээ. За яахав өнөө шөнөдөө би чамд туршиж нэг юм өгөөд үзнэ. Чи эндээ өөр юу ч бодолгүй хэвтэж бай! гэж хэлээд маарамба гарч оджээ.

“Долоон тамир дордоно гэж юуг хэлээд байгаа юм болоо? Хамаг юм минь муудан доройтсон хэрэг байхдаа!” гэж Санж гэцэл гиюүрэн бодож байлаа. Ходоод нь базлан, бие нь тамирдаж үе үе дуу алдуулж байхад долоон тамир гэдэг доройтсон нь үнэн биз дээ гэж тэр итгэлээ. Оройхон маарамба орж ирээд том багвартай шөл шиг юм өглөө.

- За чи тоолоод балгаад байгаарай. Яг л дөчин хоёр балгаад л болино шүү! Түүнээс илүү балгаж болохгүй гэж маарамба зааварлав. Нялуун амттай шөл шиг юм байлаа. Санж гэцэл тоолон залгилж эхлэв. Бүлээхэн нялуун шөл тул бөөлжис цутгаж байвч тэсээд л балгаад байв. Маарамба бас эрхээр имрэн тооцоолж суух зуур,

- Дөчин хоёр балга юм уухад хүний ходоод гурав хуваасны хоёртоо хүртэл дүүрдэг юм. Нөгөө хоосон зайд нь шингэн холилдон боловсорч чөлөөтэй эргэлдэх учиртай. Тэгээд бие, арьс, цус, яс, тархи, ходоодыг чинь тэжээж өгнө гэж ярьж байлаа. Санж гэцэл түүнийг бүдэгхэн тогтоож авлаа. Юмыг нэг л сонсвол бүрэн тогтоодог тийм сонин ухаантай болохоор гэцэл Санж апиваа юмыг цээжлэх гэж зовдоггүй байлаа.

- Дөчин хоёр боллоо. Одоо боль, Багвараа нааш нь өг гэж маарамба хэлэхэд санж нялуун шөлнөөс салж сая амрав.

- Одоо унт. Маргааш өглөө байдал янз нь мэдэгдэнэ гэж хэлээд маарамба явав.

Маарамбын яриа Санж гэцлийн сониуч занг хөдөлгөв. “Отчийн ухааныг мэдэж авбал сонин юм уу даа. Энэ маарамбад гэрийн шавь орьё байз” гэж гэцэл бодож байгаад өвчин, нойр хоёртоо дийлэгдэн зүүрмэглэж эхлэв.

...Маргааш өглөө гэцлийн бие арай дээрдээд байгаа нь мэдэгдэв. Түүний ухаан нь арай саруул болжээ. Гэвч элгэн талд нь эвхрэн өвдүүлдэг хэвээрээ л байлаа. Санжийн нүд арай дээрдэн сэргэснийг маарамба Пүрэвдоной үзээд сэтгэл нь урамшчээ.

- Арай дээрдээ юу? За алив судсаа өг! гэж маарамба асуух зуур гэцлийн судсыг барьж үзээд духаа үрчийлгэж,

- Бас л төдий сайн бус байна. Ер нь чамтай хамт төрсөн гурван өвчний нэг бололтой. Хүн төрөхдөө гурван өвчин тээж ирдэг юм. Лүнтээ, бадган, сум гэж. Энэ чинь хий, цус, шар ус гурвын өвчин. Хийг бол даруулж эмчлэхэд эдгэнэ. Шар усыг бол барьж эмчилж болно. Цус бол хүний биеийг бүрдүүлсэн үндсэн иш тул тийм амархан үл эдгэрнэ. Ер нь чамд цусны төрөл өвчин ороож буй бололтой. За би хурал номд явж ирээд нэг сайн үзье дээ. Чи тэр нэг хөтөвчинд жавсангаа аваад тавьсан байгаарай. Тэр болтол юм хэлэн дээрээ тавьж болохгүй гэж маарамба захив.

Гэцэл Санж их үд хүртэл ганцаар гиюүрч дэвэн дэлхийн юм бодлоо. Бурхны орон Түвд газарт юм бүхэн учиртай, сүм болгон хутагтай гэж нутгийнхан нь лам нар итгэдэг, тэгж ярьдгийг олон дахин сонсчээ. Одоо тэр учиртай, хутагтай, ариун юмсын хүрээлэл дунд гэцэл Санж аж төрж байна. Гэвч амь насаа алдахуйяа тийм ч хэцүү биш юм шиг

санагдав. Зүв зүгээр байтал гэв гэнэт өвчин хүрсэн. Нэртэй том гавж Лүндэгжунай өөрөө гүрэм буулгаж, мэнгэн засал хийсэн. Дараа нь золиг гаргаж, сүнс дуудсан. Тэгээд тус болоогүй. Одоо энэ маарамба бас л гавьтай сайн үр дүнд хүргэж чадалгүй төрөл арилжвал юутай хэцүү билээ гэхчилэн түмэн бодолд тэр эзлэгджээ.

...Үд дундын үед маарамба ирэв. Тэр зампортой замбайн гурил, бойпортой сангийн арц хоёр авчирчээ. Замбайг идэж, бойпорт арц унгатгах ажээ.

- Замбайн гурил идээд үз. Тэгээд байдлыг чинь харья гэж маарамба зампортой гурил, аягатай дөхүүлж өгөөд өөрөө өвчтөний жавсанг шинжихээр суулаа. Долоон тамир доройтоход юу нөлөөлдгийг маарамба эргэцүүлэн бодлоо.

- Төрөлхийн гурван өвчнөөс өөр нэмүү юм байх шиг вэ дээ. За байз, дөрвөн зуун дөрвөн үндсэн өвчин бий. Мянга хоёр зуун тавин дайвар өвчин бий. Тэдний аль нь байж таарах вэ? гэж маарамба өөртөө ярьж байлаа. Санж гэцэл тэр үгийг мөн л тогтоож авлаа. Сонссон болгон эрдэм гэж тэр боддог юм.

- За байз. Тэр олон өвчин, эмгэг дотроос нэгэн зуун нэгэн өвчин чөтгөр шулмын хорлолоос үүсдэг. Сэтгэлээр тэр засрах ёстой. Гэтэл энэ хуврагт гүрэм уншиж мэнгэн засал, сүнс дуудах хүртэл зан үйл хийсэн гэсэн. Тэр тус болоогүй. Тэгэхлээр чөтгөрийн хорлол биш байжээ. Нэгэн зуун нэгэн өвчинг хоолоор засал хийж эдгээнэ. Энэ хувраг нумнэй сахисан болохоор хоолон засал юуны хэрэг. Нэгэн зуун нэгэн өвчин лхантовчимбын хүчинд эдгэрдэг буй. За тэр л анзаанд оролдвол ямар вэ? гэж маарамба өөрөө өөртөө ярьж байснаа,

- Чиний яг хаахна өвдөөд байна? гэж асуулаа. Санж гэдсэн тушаагаа зааж,

- Энэ хавьд базалдаг гэв.

- Аа тэгж таарна. Гурван хүрдний дундах байж дээ? гэж маарамба нухацтайхан ярьснаа, босч ирээд Санж гэцлийн ходоодон тушаа дарж үзээд,

- Өвдөж байна уу? гэв.

- Үгүй. Дотроо л байх шиг байна.

- Аа тийм үү? Дунд хирд байж мэднэ.

- Гурван хүрд гэж юуг хэлнэ вэ?

- Хүний биед гурван хүрд эргэж байдаг. Эхний хүрд хоолойноос дээш, дунд хүрд гэдэс ходоод хүйс орчим, доод хүрд түүнээс дотогш эргэлдэж байдаг. Гурван зуун жаран хуурай болоод цусан судас энэ гурван хүрдэнд зангилагдсан байдаг юм. Бас гол цур зөөгч арван хоёр судас бий. Тэр гурван хүрдний аль нэг нь зогсвол өвчин хүрнэ. Эдгэхэд бас бэрх. Ер нь хэзээ ч, яавч эдгэршгүй өвчин нэгэн зуун нэг бий гэдэг. Чамд ийм залуу хүнд эдгэршгүй зуун нэрийн аль нэг туссан байж яавч таарахгүй гэж маарамба ярилаа. Тэгээд Санж гэцлийн хүйсэн дээр дарж, алгаа эргүүлэн илж хэсэг чагналаа. Санжид юу ч мэдрэгдсэнгүй.

- За ямар ч байсан дунд хүрдний хавьд гажиг гарчихсан бололтой. Хүчээр идэгчийн төрлийн хэдэн тун эм өгөөд үзье. Тэр хүрд суларсан бол аяндаа хөлс чинь чийхарч бэрх болно. Тэр хүрд ерийн байгаа бол юу ч мэдэгдэхгүй гэж Пүрэвдоной маарамба ятган ярьснаа манхагаа уудалж бор цаасанд боодолтой юм гаргаж ирээд тунгийн халбагаар нэг хоёр хутган аяганд хийж, шөлөөр даруулж уухыг зааварлав.

Маарамба эмээ уулгаж хойноос нь шөлөөр даруулав. Өчигдрийн хоолны шөл тул багахан халааж өгөв.

- Өнөө шөнөдөө байцыг нь харья. Маргааш юу болохыг үзье. Тэртээ тэргүй сүүлчийн найдлага хайж байхад яарах юу байна гэж маарамба

хэлээд босч явав.

Дахиад л Санж гэцэл хувь тавилангийнхаа харанхуй алсыг ширтэн гав ганцаар үлдэв. Алс холын сүрлэг уулс, төрсөн нутаг Хар азаргын нуруу сүндэрлэн цэнхэрлэж дуудан даллах шиг болж нулимас нь бөмбөрлөө.

...Маргааш нь маарамба дахиад л ирж судас барив. Дахиад л

- Кайвжунайн даягт судасны цохилт тавин найман янз гэсэн билээ. Хүний нэгэн амьсгааны хооронд таван удаа судас лугшина гэдэг билээ гэж тэр амандаа ярив. “Цус сэлгэх болон хуурай судас гурван зуун жар билээ. Тэрнээс алинд нь зүтгэр орж вэ” гэж тэр бас дотроо бодлоо.

“Хэрвээ энэ маарамбад нэг сар орчим хугацаагаар анагаалгавал оточийн ухаан сурч болох юм байна. Даанч бие муудаад горьгүй” гэж гэцэл бодлоо.

- За, хөө чиний таван цулын нэгэн нь сульдсан юм болов уу даа. Тийм аваас элгэлж үзэхгүй бол горьгүй байхаа гэж маарамба дахиад л ярив. Таван цул гэж юуг хэлж байгааг гэцэл гадарлаж “муудсан бол элэг л байх даа. Тэр тушаа л эвгүйрхээд байна” гэж бодов.

- Таван цул болбаас зүрх, элэг, уушиг, бөөр, дэлүү энэ хэд билээ. Зүрх тийм ч амар сульдахгүй. Харин бөөр, элэг хоёр хэврэг гайхал юмдаг. Шажоот юмуу Жажоотод үздэг хэрэг гэж маарамба дахин тайлбарлан ярив. Шажоот бол бие эрхтэн шинжих, жажоот бол эмгэг судлах ухаан юм. Мөн манаажот буюу яс барих, чимэйжит буюу эм барих, лхантовчимба буюу дотрын эрхтэн анагаах ийм таван аймагт сав ухаанаар оточийн эрдэм бүрддэг байлаа. Пүрэвдоной маарамба эдгээрийг мэдэх боловч эм барихын ухааныг голчлон дагнажээ. Пүрэвдоной маарамба

- Нэг эм өгөөд явна. Өнөөдөртөө хараад болохгүй бол элэглэнэ. Чамд

ямаа худалдаж авах мөнгө бий юу? гэж Санжаас асуухад гэцэл толгой сэгсрэв.

- Над бас мөнгө юу базаах билээ. Элэглэхэд заавал амьд ямаа юм уу хонь хэрэгтэй. За чи ухаан сийлж байгаарай. Халх Мицаанд чамд танил байхгүй юм уу? гэж маарамба лавлав. Санж,

- Бараг байхгүй. Харин манай зиндааны монгол, торгууд нарт танил байж магадгүй. Тэднийг ирэхээр би гуйаа гэв.

- Лагсоо! Лагсоо! За үүнийг уучих! Нүхнээ оршигчоос залсан эм! гэж Пүрэвдоной хэлээд манхагаа уудлан эм хайх зуур бас л ганцаар ярьсан нь,

- Чамд би өчигдөр хүчээр идэгчдээс авсан эм өгсөн. Эдгэрсэнгүй. Гэвч хоосон биш. Чиний ухаан дээрджээ. Өнөөдөр нүхнээ оршигчдоос залсан эм өгнө гэхэд Санж,

- Нүхнээ оршигчдоос залсан гэж юун эм бэ? гэвэл маарамба,

- Нэг эм найруулахад жараад хольц орно. Орчлонгийн бүхий л бие махбодыг оролцуулахыг хичээнэ. Тэгэхдээ эмийн чанартай юм хорвоод өрдөө 612 янз бий. Тэрнээс, жишээлбэл,

- Чулууны төрөл 34 бий

- Шорооны зүйл 12

- Давс шүү хужрын юм 110

- Өвсөн эм 133

- Жигүүртнээс 17

- Хумст араатнаас 13

- Хүчээр идэгчээс 11

- Хүмүүн эзлэгснээс 12

- Нүхнээ оршигчоос 10

- Нойтны аймгаас 8

- Бусад амьтнаас 100 зүйл эмийн юмс авдаг болно гэж ярив.

- Яасан сонин юм бэ? Та яасан ихийг мэднэ вэ? Хүчээр идэгч, хүмүүн эзлэгсэн, нүхнээ оршигч гэж юуг хэлж байна? хэмээн Санж асуулаа. Пүрэвдоной баярлан,

- Үгүй ер, амь наана, там цаана байж байж бас сониуч эрээ чи. Зөв Бурхан багш маргааш үхэхээ мэдэж байвч өнөө сур гэж айлдсан юм! Чи уул нь эдгэрвэл хэрэгтэй сониуч хүү юм гэж хэлснээ,

- Чи сонс! Хүчээр идэгч гэдэг бол чоно, нохой, цөөвөр мэтс болно. Хүмүүн эзлэгсэн гэдэг чинь гэрийн тэжээвэр амьтдыг хэлнэ. Нүхнээ оршигч нь зурам, тарвага, өт хорхой биш үү. За чамд цөмийг ярих зав алга, би явья даа гэв.

- Багш маарамбаа, та намайг эдгэрэхэд надад энэ отчийн ухааныг зааж өгөх ажаамуу? гэж Санж дорой дуугаар гуйлаа. Пүрэвдоной,

- Амны билэг гэж, чи чинь овоо өөдрөг сэтгэлтэй хүн юм.

Эдгэрвэл би чиний гэрийн багш болно гэж бодье хэмээв.

...Үдээс хойш таван цулыг шинжих элэглэх дом хийхээр болжээ. Санж гэцэл биеэ чагнан хэвтэхдээ ертөнцийн тухай бясалган бодсоор л байлаа. Бурхны ном сурах гэж бурхны оронд ирээд тэр хүсэлдээ хүрэлгүй жанч арилжвал хувраг болсон хэрэг юу билээ гэж дахиад л харамсан бодлоо. Лам хүн насан эцэс болохыг жанч арилжина гэж ярьж байсныг тэр тогтоож авчээ. Өөрийгөө аврах тухай олон юм эргэцүүлэн бодов. Нэгэн зуун нэгэн өвчин огт үл эдгэрдэг гэж хэлсэн, тэрний нь нэг л тусчихаагүй бол бусад нь аргалж болох байх хэмээн горьдож байлаа. Саяхан л нүд ирмэх зуур өдөр өнгөрдөгсөн. Одоо өвчинд шаналсан түүнд өдөр ч өнгөрөхгүй болжээ.

“Тэр таван цул шинжинэ гэдгээ л хийгээсэй. Юу байдаг юм болдоо!” гэж Санж гэцэл хүсэн хүлээж байлаа.

Үдээс хойш маарамбатан аахилсаар орж ирлээ. Цаанаас нь нэгэн зиндааны нөхөд дагажээ. Пүрэвдонойтон,

- Нөхөд чинь мөнгө цуглуулж ганц хар ямаа олжээ. Одоо үүнийг гаргаж чиний таван цулыг шинжилсүгэй гэж хэлээд зиндааныханд нь хандаж,

- За наад ямаагаа цааш харуулаад орхи гэж даалгалаа.

Тэр даруй нөхөд нь хар ямааг нядалж эхлэв. Маарамба өөрөө Санж гэцлийг нүцгэлэн өөд нь харуулан хэвтүүлээ. Тэгээд хуврагуудыг дуудаж,

- Миний дуудсан дэс дараагаар ямааны дотор гэдэснээс таван цулыг халуунаар нь авч ирээрэй. За эхлээд элэг аваад ир, гэв. Цус шүүрсэн халуун элгийг тэд оруулж ирлээ. Маарамба түүнийг авч Санж гэцлийн элгэн тушаа наалдуулан тавилаа.

- Уушиг! гэж маарамба дуудав. Уушиг авч өглөө. Түүнийг бас л Санж гэцлийн уушгин тушаа наалдуулан тавилаа.

- Дэлүү! гэж маарамба хашгирав. Дэлүүг өглөө. Тэр мэтээр таван цулыг халуунаар авч Санж гэцлийн элгэн талд тус бүрийн таарах эрхтэн тушаа наалдуулж тавиад дээгүүр нь ямааны сэмжээр хучаад арьсаар бүтээлээ. Ямааны өвчүүний хэрсэнг арьстай нь хэсэглэн авч өөд нь харуулан шалан дээр тавилаа.

- За энэ хэрсэнтэй арьсыг сайн харж бай. Хэрсэн бол амьтны биеийн хамгийн мэдрэмтгий мах болно. Бас хамгийн шимэрхүү мах мөн. Иймд түүнийг хөрөхөд өвчтөний биед наасан таван цул бас нэгэн зэрэг хөрнө. Хэрсэнг хөрөөгүй байхад дотор махыг авч үзэж болохгүй гэж маарамба зааварлав.

Хэрсэнтэй арьс нь цаг хэмжих баримжаа ажээ. Хэрсэнг хөрөхөд лам,

- Цаг боллоо. Одоо таван цул хөрчээ гэж хэлснээ гуйлан түмпэнтэй халуун усанд таван цулыг авч дэс дэсээр хийв. Элэг, зүрх тэргүүтнийг халуун усанд нааш цааш эргүүлэн маарамба үзэх зуур,

- Өвчтөний таван цулын аль нэг нь гэмтсэн бол дээр нь гавьсан малын таван цулд тэмдэг мэдэгддэг юм гэж амандаа ярьж түмпэнтэйг хутган хөрвүүлж, нухацтай үэсээр байлаа. Удтал шинжпээ. Гэвч тэр гэх тэмдэг олсонгүй.

- Мөн хачин юм даа. Ердөө тэр гэх тэмдэг олдохгүй байна. Таван цулд нь ямарваа гэм суугаагүй бололтой гэж маарамба үглэж суулаа. Элэглэх дом нь тийнхүү үр дүнгүй болох аястайд маарамба бага зэрэг бишүүрхэж,

- Тэгвэл одоо энэ өвчтөний биеийн таван оньс нь гэмтсэн хэрэг байж дээ. Гол оньс мултарвал үхэж ч болно. Маргааш би чиний таван оньсыг шинжиж үзэхээс яахав дээ. Өнөөдөр ч оройтлоо. Зиндааныхан нь ямааны махаар нөхөртөө хоол хийж өг. Тэгэхдээ хурц юм хэрэггүй гэж хэлэв. Нөхөд нь Санж гэцлийн нүцгэн биөнээ бялтсан цусыг арилгаж, хувцсыг нь өмсгөж оронд нь хэвтүүлэв.

Маарамба амандаа бувтнан “ямар золигийн буг шүглэж орхио вэ? Ердөө мэдэх баримжаа алга. Хум, хум, хум” гэж зүхлэг орхив. “Уул нь их л ядарч сульдчихсан юм шиг байх юм. Тамирдсан хүнийг ч хоолоор эмнэвэл дээрсэн. Үүнийг эдгээж чадахгүй бол нэрд муу болно. Хамаг арга ширгээ барлаа гэж үү би. Сэжгээр засрахгүй нээ!” гэж маарамба дотроо бодовч түүнээ ил хэлсэнгүй.

Арван гурав. Жоргүй ламаас зовсон чавганц

Хэнд эрдэм буй болбоос түүнд тус буй
Хэнд эе буй болбоос түүнд нөхөр буй
Хэнд эд буй болбоос түүнд харам буй

Отчийн их эрдэм Санж гэцэлд бас л тус болсонгүй. Залуу гэцлийн бие сайжирсан ч үгүй, харин түүнээсээ дордсон ч үгүй, нэгэн хэвэнд тогтож өөх ч биш, булчирхай ч биш болжээ. Тамирдан ядарч хүйтэн хар хөлс үе үе цувна. Заримдаа ой ухаан нь хурцдаж, заримдаа мохож балайрна. Пүрэвдоной маарамба,

- Миний арга ширэг дууслаа. Чиний сүнс айхтар хол төөрч, бие чинь айхтар сульджээ. Одоо над ганц арга байна. Түүнийг чи хүртэх үү, аль эсвэл гэртээ хүргэгдэж хойтохоо захиалах уу? гэж асуулаа. Санж гэцэлд арай ч юм бүхэн хэрэггүй болж, ертөнцийг огоороогүй байгаа тул маарамбын тэр аргыг хэрэглэхийг зөвшөөрөв.

- Миний энэ арга бол бие сэтгэл хоёрыг хамж хэлээр хууран эвдэх арга юм. Номын хэлээр бол "Хум хум, хум" болно. Чамайг гүрэм, мэнгэн засал, сүнс дуудлагаар эдгээж чадсангүй. Чамайг бас таван цул, таван оньс, гурван хүрдийг чинь шинжиж, хүчээр идэгч, хүн эзлэгсэн, нүхнээ оршигч, давс хужир, өвсөн эм тэргүүтнээр анагааж эс барав. Одоо бодоход чамд дөрвөн хорын язгуур шингэжээ. Тэр юун гэвэл санааны хор, хүрэлцэх хор, амны уурын хор, үзэх хор энэ дөрвүүл чамд хүрчээ. Тэгэхээр эдгээрийг хураан эвдвэл зохино. Би чамд гүртэнба залж ирнэ гэж Пүрэвдонойтон айлдлаа.

Санж дэмий л толгой дохив. Түүнд үнэмшсэн маарамба,

- Чамд мөнгө байхгүй би мэдэж байна. Энэ гүртэнбанууд мөнгө их нэхдэг улс. Би чиний өргөл барьцыг өөрөө даана. Эдгэрдэг юм бол чи

тэр ачийг бодож хариулна биз. Эдгэрдэггүй юм бол чи жанч арилжаж очсон хорвоодоо миний ачийг дуулгана биз. Буян болно гэв.

Удалгүй гүртэнба ирлээ. Баргар хар хөх царайтай, сарлагийн сүүл шиг ширүүн хар үсээ мөрөндөө хүртэл ургуулсан аймаар хүн ажээ. Тэр гүртэн бол догшид буюу номын сахиусан болох догшин дүрт бурхдын тахилга сүлд, ёслолыг гүртэндэхтэй хослон хийдэг эрдэмтэй ажээ. Гүртэнба өвчтөнгийн дэргэд шууд л номт хувцсаа өмсч эхэллээ. Жодов гэдэг титэм малгайг их үст саглагар толгой дээрээ тавилаа. Жодов буюу титэм нь таван талтай, тал бүр дээрээ бурхны зурагтай хоёр хацар руу тохой хэрийн урт хонгорцог үсэн уншлагатай, ар тал руу хөх, цагаан, улаан, шар, ногоон таван өнгийн даржин зүүсэн, тоорцог хэлбэртэй малгай, оройдоо очиртой тул их л сүртэй үзэгдэнэ. Гүртэнгийн саглагар хар үс, жодовын нь торгомсог бараан үс хоёр хослон нийлээд ер бусын сангасваа маягтай болжээ. Таван талд нь эргэн тойрон зурсан бурхад нь Бируузана, Агжаа, Раднаасамбуу, Авид, Амгаасэд эдгээр юм. Бируузаныг монголчууд маш гийгүүлэн зохиогч бурхан гэх бөгөөд мутар нь бүхүмиспара маягтай, хөх өнгөтэй. Агжааг үл хөдлөгч бурхан гэхээс гадна ажаали мутартай, цагаан өнгөтэй. Авид бол цаглашгүй гэрэлт бурхан, мутар нь дихияана маягтай, улаан өнгөтэй. Амгаасад бурхан авхиа мутартай, ногоон өнгөтэй. Ранаасамбуу бол эрдэнийн орол бурхан, вараада мутартай, шар өнгөтэй ажээ. Бүхүмиспара мутар бол газар ёслох маяг, анжаали мутар нь залбирах, авхиа нь аймшиггүйг илтгэх, дихияана нь бясалгал, ваарада бол өглөгийг илэрхийлэх маяг жагжаан гэдгийг Санж Чоймчиг талийгаач багшаараа заалгаж мэдэж авсан байлаа. Эдгээр тав нь титмийг чимэх гэгдэх дээд бурхад мөн. Гагцхүү толгой дээр буюу духнаас дээш залсан байвал зохино. Гүртэн тийнхүү жодов гэдэг бурхант титмээ толгойдоо бат тогтоогоод додиг гээч таван өнгийн эдээр оёсон цээживчээ өмсөв. Дараа нь мадиг гэдэг банзал духлаа, Альбин сэлэм гэдэг нарийхан шулуун сэлмийг агсав.

Таван бурхан зурсан титэмтэй, додогоор цээжин биеийг, мадигаар бөгсөн биеийг ороосон энэхүү сүрлэг гүртэн нь хүний бие сэтгэлд шүгэлсэн 84 мянган нүгэл нисваанисийг арилган тонилгохоор

догшдын ном уншиж гүртэндэх ажээ.

Наян дөрвөн мянган нүгэл алдсын дотроос таван гол хор буй гэж үздэг юм. Тэр нь нэгд мунхгийн хор, түүнийг Бируузана бурхан дарна. Хоёрт хилэнт сэтгэл, түүнийг Агжаа бурхан дарна. Омгийн хорыг Раднаасамбуу дарна. Атааг Амгаасэд дарна. Тачаангуйг Авид дарна. Ийм таван хорыг дарж Санж гэцлийг өвчнөөс аврахаар Гүртэнба бууж гарлаа. Титмийн таван бурхны магтаалыг дүнгэнэтэл уншиж, сэлмээ нэг огшоож нэг буцааж, баруун гараар зүүнийг ташиж ээ, ээ, ээ гэж хашгиран, зүүн гараар барууныг ташиж хум, хум хум гэж орилно. Баруун гараар зүүнийг таших нь “Егүүтгэ!” гэсэн утга бөгөөд ээ, ээ, ээ нь “хүний махыг идэж цэнгэх” хэмээсэн дохио ажээ. Зүүн гараар барууныг таших нь “Бүрмөсөн егүүтгэ, бүрмөсөн егүүтгэ” гэсэн утга бөгөөд хум, хум, хум нь бие, хэл, сэтгэл гурвыг хурааж эвдэх сануулга үг юм.

Пүрэвдоной маарамба гүртэнгийн хажууд сууж түүний гүртэндэхийг ажиглаж байснаа Санж гэцлийн дэргэд ирж дахиад л хувцсыг тайлан нүцгэлэн эхлэв. Гүртэн завьжаараа хөөс сахруулан, нүүр амаа татвагануулан бөөлж байснаа сэлмээ суга татан ил гаргаж Санж гэцлийн өөдөөс ойртон ирэв. Пүрэвдоной маарамба,

- Битгий ай. Хар цагааны завсрыг олно. Өвчин шүгэлснээс чинь ангижруулж өгнө! Битгий ай! гэж ятгав.

Гүртэн нарийхан хар сэлмээрээ Санж гэцлийн элгэнээс холгүй цагаан мөгөөрсний тушаа хатгав. Сэлэм нь нэвтрэн орлоо. Санж гэцэл ухаан алдав. Дахин сэргээд харвал гүртэн ахиад л ойртон ирж баруун гараас нь атган аваад булчин дундуур нь мөнөөхөн сэлмээрээ нэвт хатгав. Далтисхийсэн Санж гэцэл ахиад л ухаан балардав.

Шажоот буюу эрхтэн шинжих сударт заасан ёсоор хүний биеийн хар цагааны завсар цагаан мөгөөрснөөс доохно, бас гарын зөөлөн булчин дундуур байрлах бөгөөд нэвт хатгах, эсвэл огтолж болдог ажээ. Хар цагааны завсрыг олж чадвал биед ямар ч хор хөнөөлгүйгээр цоо

хатгаж болдгийг бөө нар, гүртэнгүүд чадмаг ашигладаг юм гэдгийг хөөрхий Санж гэцэл мэддэггүй байлаа. Санж айн сүрдсэнээс болж арайхийн сэхээ орж, нүдээ нээвэл гүртэн нэгэнт дөвчигнөхөө больж, ажлаа дуусгаад мадигаа тайлж байжээ.

- Зүгээр. Одоо чиний биенээс наян дөрвөн мянган нисваанис чинь зайлаа биз. Цөм зайлдаггүй юмаа гэхэд таван гол хорноосоо салаа биз дээ. Маргааш өглөө эдгэн илааршина! гэж Пүрэвдоной маарамба ятгалаа.

Санж гэцэл дэмий л толгой дохив. “Одоо яадаг бол? Элдэв гай зэтгэрээс салдаг болов уу? Би сая сэлмээр хатгуулаад үхсэнгүй гэж үү? Цус ч гараагүй юм байх даа? Осолдохгүй л өрц рүү сэлэм нь нэвтлэн орсон. Бас гарын булчинг цоо хатгаж байсан. Тэгээд үхсэнгүй үлдсэн юм уу? Энэ үнэн гэж үү? хэмээн Санж бодоод өрцөө илж үзвэл цус гараагүй байлаа.

- Гүртэн ид шидтэй сэлмээрээ чамайг биш харин чамд шүгэлсэн нисваанисыг үхүүлсэн юм. Одоо чи тавтай амраад маргааш гэртээ харь! гэж Пүрэвдоной маарамба Санж гэцэлд ятгалаа. “Нээрээ л ид шидтэй сэлэм байна. Альбин сэлэм гэдэг чинь энэ байжээ. Илдэч хүний гарт үхээгүй болохоор маарамбын хэлдэг үнэн л байж таарна” гэж гэцэл бодлоо.

...Маргааш өглөө нь босоход гэцэл Санжийн бие сайжирсан юмгүй хуучин хэвээрээ байлаа. Босох гэхэд толгой эргэн дотор балартаж, унамаар болно. Суух гэхэд мөн тэрчлэн шанална. Өчигдрийн гүртэнд сэлмээр хатгуулсан өрцөн тушаа нь ч гэсэн булчинд нь ч гэсэн үл ялиг хөндүүр байлаа. Үнэхээр л мэс хүрсэн нь илт ажээ. Гэвч эдгэрч дээрдсэн юм алга байв.

- Өнөөдөр зиндааныхан чинь ирнэ биз. Гэртээ харьж хэвтвэл таарна. Би хэд хоногийн мөргөлөөр Шихаацийн хүрээ орохоор явах боллоо гэж өглөөгүүр Пүрэвдоной маарамба хэлэв.

- Тэгье, тэгье. Харин намайг эдгэрэхээр та надад маналын ном зааж өгнө гэснээрээ биз? гэж Санж дорой дуугаар асуулаа. “Мөдхөн өнгөрөөд өгөхийг санахгүй яасан ч давилуун лам бэ? Ер нь энэ үхэр монголчууд ийм л мангар амьтад шүү” гэж Пүрэвдоной маарамба дургүйцэн бодсон боловч түүнээ ил гаргасангүй.

- За яахав, тэгж л үзье гэж хэлэв.

Санж түүнд баярлаж, “Ашгүй би ер нь үхэхэгүй л юм байна. Маарамбатан надад оточ маналын ухаан зааж өгөхөөр амлаж байхад би яаж үхэх вэ? Эдгэрэх байхаа” гэж горьдлоготойгоор бодлоо. Тэр даруй маарамба гарч явав. Удалгүй нэг зиндааныхан нь ирж зутан авчирч өглөө. Тэр нь амнаас буцаад гарч байв.

- Маарамба намайг харь гэсэн. Та нар гэрт минь хүргээд өгөөч гэж Санж гэцэл гуйлаа. Нөхөд нь,

- Маарамба бидэнд хэлсэн. Тэгээд нэг илжгэн тэрэг олж ирлээ. Одоо явахаас яахав. Маарамба өнөөдөр Шихаац орохоор явах гэнэ гэжээ. Тийм аргаар Санжаас холдохыг хүсчээ.

Санж гэцлийг нөхөд нь илжгэн тэргэнд хэвтүүлж гэрт нь хүргэж очив. Хөх нуурын өөлд Балтаа нутаг ойролцоогоороо Санжид тал өгдөг тул,

- Би Халх Мицанаар (отог) явлаа. Нэг хөгшин шимнанцтай уулзлаа. Тэр чиний биеийг үзэж өгнө гэсэн. Маргааш ирэх байхаа гэж ярилаа. Санж Халх гэсэн үгийг сонсоод сэтгэл нь багахан сэргэж,

- Халх хүн үү? гэхэд Балтаа,

- Халх байх аа! Эсвэл... өөлд ч юм уу? За тэрийг хэн мэдлээ. Харин шимнанцын сахилтай л хүн билээ гэв.

Шимнанцын тухай сонсоход ээжийгээ эргэн санажээ.

Хөөрхий ээж нь ядуу зүдүү бүсгүй байхдаа Буянзалирах хийдийн балин, шалсай түүж идэж явах үед нэг бус удаа шимнанцын сахил хүртэх тухай мөрөөдсөн юм гэдэг. Тэр тухайгаа хожим Санжид ярьж “Шимнанц болчихсон бол хүү чамайгаа төрүүлж чадахгүй л байх байж дээ. Шимнанц болчихоогүй минь яамай. Аав чинь л хориглож аварсан юм даа” гэж хэлэхэд их гайхдагсан.

- Яагаад? гэж Санж асуусан ч удаа бий.

- Яахав дээ, шимнанцын сахил хүртчихсэн хүн хүнтэй суух, хүүхэд гаргахыг тэвчдэг ёстой юм. Тэгээд л тэр гэж ээж нь тайлбарлажээ. Санж тийнхүү ойлгосон.

Хожим нь залуухан зарим гэзэгтэй нар шимнанцын сахил хүртээд өсгий дарсан урт хар гэзгээ хайр найргүй тайруулан, үсээ хусуулаад банди нар шиг мулзан толгойтой болоод шимнанцын сахил хүртэж маани уншиж, махыг цээрлэж, хуврагууд дотор танигдахгүй явцгааж байхыг ч Санж гэцэл нүдээр үзсэн.

- Шимнанц тус болох болов уу? гэж Санж гэцэл Балтаад итгэл муутайхан хэлсэнд, тэрээр гэцлийн чихэнд шивнэж,

- Жор таньдаггүй ламаас зовлон үзсэн чавганц дээр гэдэг биз дээ. Яахав үзэг! гэв.

Ардын дунд хэлцэгддэг тэр үгэнд Санж нэг их итгэдэггүй байлаа. Лам багшийн нэр хүнд, арга билэг юунаас ч эрхэм гэж лавтай ухварласан залуу гэцэл энэ удаа ч тэрхүү шимнанцийн ид шидэд нэг их биширсэнгүй.

...Маргааш нь үнэхээр нэгэн хижээл насны шимнанц ирэв. Санжийг хармагц тэрэнд өрөвдөх сэтгэл төржээ.

- Хөөрхий амьтан. Энэ чинь гуринхалж дотор, гадна хоёроосоо мэрэгдэж байгаа юм байна даа. Энүүнд ямар ч гүрэм ном, өргөл барьц

хэрэггүй гэж тэр шимнанц хэлжээ. Санж тэр үгэнд их л гомдов. Уул учрыг нь ойлгосонгүйгээс тийм болжээ.

- Залуу банди нар явцгаа! Олуулаа сэг дээр овоордог үхэр шиг юу гэж энэ доройтсон өглөгийн эзнийг тойроо вэ? Би үүнийг хүн болговол болгоод болгохгүй бол донзонпа нарт өгье гэж шимнанц гашуун үг хэллээ.

Зиндааныхан нь дургүйцлээ нууж ядан,

- Донзонпад биш бидэнд хэрэгтэй хүн шүү гэцгээлээ. Шимнанц уурлаж,

- Та нар сэг иддэг юм уу? Явцгаа, зайлцгаа гэж түвд хэлээр хашгирлаа. Зиндааныхан нь дуртай дургүй явцгаалаа.

Шимнанц тэр даруй Санжийн тоос шороонд дарагдсан гэр орныг цэвэрлэж эхлэхэд гэцэл дуугүй л ажиглаж байв.

- Чи энд ганцаараа суудаг уу? Чамайг донзонпад тушаачихаад өөрөө энд чинь суудаг хэрэг ээ! гэж шимнанц хэлэв.

- Тэгж болно шүү. Энэ хашаа байшинг багш маань надад авч өгсөн юм. Миний хөрөнгө. Би үхчихвэл хэний ч биш. Тэгэхээр үхээгүй дээрээ эзэнтэй болгочихвол талийгаач багшийн минь авч өгсөн буян улам дэлгэрнэ. Хоосон хонгилд нь буг зэтгэр, ад альбин цугларснаас шимнанц та эзэгнэсэн нь дээр гэж Санж тайвнаар ярив. Энэ гашуун үгэнд шимнанц уурлах ёстой байтал харин баярлаж,

- Ишш чи чинь ухаантай банди юм. Би чамайг тэгвэл донзонпад өгөхгүй ээ гэв.

- Би уул нь банди биш гэцэл юмсан гэж Санж бас нэмж дурдав.

- Хараач хөөе! Ийм залуугаараа гэцэл санваар хүртээ юу? Ар газар л

хүртээ биз дээ. Энэ шоргоолж шиг олон ламтай Түвдэд залуу гэгцэл байдаггүй юмаа гэж шимнанц ярив.

Гэр орныг нь цэвэрлэж, тоос шороог арилган, хогшил хөрөнгийг засаж янзлаад, цэмцгэр сайхан болгосны дараа шимнанц Санжид хандаж,

- Сайхан болоо биз. Өвчнийг эдгээр эхний дом нь гэр орон цэвэр цэмцгэр болгох ажил юм. Одоо чи цэвэрлэн төвхнүүлсэн гэрээ хараад амьд явах юмсан гэж улам илүү хүсч эхэлнэ дээ. Бохир гэрт өвчин их шүглэдэг юм гэв.

- Нээрээ л сайхан боллоо. Би уул нь үхэхийг тун ч хүсэхгүй байгаа юмсан гэж гэгцэл хэлэхэд шимнанц,

- Одоо би чамд хоол цай хийж өгнө. Сайхан хоол цай бол хүний өвчнийг эдгээх дараах дом нь болно гэв.

Төдхөн шимнанц тогоо шанага хангинуулан гал түлж аргал, мод хоёрын холимог утаа үнэртүүлэн хоол хийж эхлэв.

- Утаа үнэртэж ав. Энэ бол миний эхний хоол шүү. Утаатай гэр дулаахан гэдэг юм. Аргалын утаанд монгол хүний сэтгэлийн өвчин засал авдаг болно. Ёстой монгол хүн бол чиний балинд эдгээгүй өвчин аргалын утаанд илаарших аяс орох л байх. За муусайн жанаг, бодпа нар бол ч аргалын утаанд юунд тэгтлээ сайжирна гэж дээ. Нэмэр үгүй биз гэж шимнанц ганцаар ярьж байлаа. Санж түүний үгэнд их л бишрэн сэтгэл хөдлөв.

Үүрч ирсэн манхаг шиг мөртөө дэргэр том үүргэвчнээсээ хэдэн сонгино гаргаж ирээд тэр шимнанц хальсыг авах зуур бас л,

- Зэрлэг сонгинын үнэр бол миний чамд идүүлэх дараагийн хоол мөн. Сонгиныг үнэрлэгтүн! Тэгвэл өвчин чинь хагацан дайжиж ч юу магад! гэж хэлээд арилгаеан сонгиноо Санж гэгцлийн хамарт

ойртуулав. Гэцэл тэр сонгины хурц үнэрт толгой нь мангууран мансуурах шиг болж төрсөн нутаг Хар азаргын нуруугаа санав. Уулын хавцал, голын асга хадаар сонгино түүж явснаа дурсан бодлоо. Хээрийн сонгино хольж янгирын хар махаар эцэг эх нь хоол хийж өгсөн тэр нэгэн намрын явдал санаанд оров. Нутгийн нэгэн анчин тэднийд айлчлан ирээд байсан цаг. Тэднийх Дархинтын хавцгайд нутаглаж байсан. Анчинд цай хийж өгөхөөр ширмэн жалавчаа тулган дээр тавьж ус хийснээ ээж нь дуу алдаж билээ.

- Яав? гэж анчинг асуухад эх нь тогоотой ус руу зааж дуугүй зогссон. Анчин тогоо руу өнгийж хараад,

- Аа дамшваа. Чи надад өөрөө хүрээд ирэв ээ! гэж хэлэхээр нь Санж хөвүүн сониучлан тогоо руу өнгийж харвал тоонон дээгүүр өнгийсөн халил улаан хадны орой дээр хэдэн янгир ямаа зогсож байх дүрс нь тогоотой уснаа тусч дэргэд юм шиг тодхон харагдаж байсан. Тэгэхэд анчин цахиур буугаа шүүрэн авч хот цэнэгийг хойш татангуут,

- Тооноор шагайгаад би нэг буудаад орхиё. Нэг янгир аяндаа тэр улаан байцнаас хийсч хаяанд чинь унаад ирнэ гэж хэлэхэд ээж нь,

- Гараад гадаанаас буудаач дээ. Гэр дотроос эвгүй биш үү? гэв. Анчин гуйсан дуугаар,

- Гарахаар үргээд зугтаачихна. Танайх ямар хоймортоо бурхан байх биш. Би буудаад хоолтой болгоод өгье л дөө. Тоонон дээгүүр олз өнгийж байхад юунд татгалзаа вэ? гэхэд нь,

- Хүүхдүүд айчихна! гэсэн.

- Дүү нар чихээ таглаж бай! Юунд нь айдаг билээ. За буудлаа. Нүдээ ань, чихээ тагла гэмэгц анчин гохоо дарж орхисон нь гэр дотор пүн пан гэсэн аймаар дуу гарч дахь хүхрийн үнэр ханхлан, хүүхдүүд айж уйлалдаж билээ. Анчин харин инээгээд,

- Тэр шүү. Янгир хийсээд айсуй! гэж хашгиран гүйж гарсан юмсан. Үнэхээр гэрийн нь тооноор цухуйм өндөр ханан хадан дээрээс нэг янгир үсрэн доошоо унаж ирээд гэрээс холгүй пүсхийн ойчиж билээ. Тэгээд зэрлэг сонгинотой хольсон сайхан хоол хийж идэцгээсэн юм. Түүнийг Санж хэзээ ч мартдаггүй ажээ. Энэ удаа сонгинын үнэр бага насны нь дуртгалыг сэргээв.

- Үхэхгүй л юмсан! гэж Санж амандаа бувтнав. Шимнанц инээмсэглэж,

- За тэр дээ. Чи сонгины үнэрт өвчнөө байтугай үхлийг мартаж эхлээ биз! гэж асуулаа.

Шимнанц тийнхүү хоол хийх зуур Санж гэцлээс нумнэй сахиж байсан, яаж өвдсөн, одоо ямар байгааг нягтлан асууж авчээ.

- Гайгүй би чамд хоол идүүлж шалгаад дараа нь тавтай унтуулах дом хийнэ. Сайн нойр бол өвчнийг эдгээх хамгийн чухаг домын нэг гэж тэр ярив.

Шимнанцын хийсэн ер бусын амттай хоолыг Санж идэж хар хөлс нь цувран асгарч байлаа. Гэвч тэр хоолноос их идэж чадсангүй. Буцаж гарахыг завдан зовоож байв. Шимнанц түүнийг ажиглан харж байснаа толгой сэгсэрч,

- Аргагүй л туйлджээ. Миний таамаглаж байсан мөн бололтой. Тэгвэл ч би аргалнаа гэж итгэлтэй хэлэв.

- Лүндэгжунай гавжтан гүрэм уншиж, мэнгэн засал, сүнс дуудлага хийлгээд бараагүй. Пүрэвдоной маарамбын бүх арга тус болоогүй. Гүртэн буулгаад ч нэмэр болоогүй. Тийм эрдэмт хүмүүсийн арга ширэг туслаагүй юм чинь номгүй хөгшин шимнанцын арга ч дээ. Их бодохдоо л хоол, цайгаар аргадна биз дээ” гэж Санжийн толгойд бодогдлоо. Шимнанц үүрэг дотроосоо бяцхан буйдан гаргаж ирээд хатсан хөх ногоон өвс, буурцагтай хөхөлбий хонгорцог дотроос нь

авч Санжид үзүүлээд,

- Таньж байна уу? Цахилдаг байгаа биз! Нутгийн чинь цахилдаг. За үүгээр л шархтай ходоодыг чинь эмнэнэ гэв.

- Ходоод минь шархтай гэж үү дээ? хэмээн Санж гайхлаа. Шимнанц,

- Ходоод чинь айхтар шархалжээ. Удахгүй цус алдана. Монгол хүн махсаж энэ түвд газар ходоодны шарх олдог юм. Тэр тусмаа найман нумнэй сахихад ч урьд нь махсаг байсан хүний ходоодны шарх гаарч өгнө. Чи ер нь айлын эрх хүүхэд байсан биз дээ гэв. Санж гэцэл толгой дохив.

.. Тэр өдрөөс эхлэн Санж гэцлийг шимнанц цахилдгийн шүүсээр хоёр долоо хоног эмчлэн, хоол цайгаар сувилав. Шимнанцын онош зөв ч байсан юм уу, эсвэл өөр ч тохиол болсон уу, бүү мэд, ямар ч атугай Санж гэцэл хөл дээрээ босов. Шимнанцыг Бэрээмэг эмгэн гэдэг ажээ. Тэр их аманцар, цайлган сэтгэлтэй, олон газар тэнэж, ихийг үзэж, элдвээр зовсон амьтан байжээ.

- Эмээ минь, би таны ачаар дахин сэхлээ. Их гялайлаа. Та манайхаас битгий яваа! гэж Санж гуйлаа. Бэрээмэг,

- Миний ач юү байхав. Жоргүй ламаас зовлон үзсэн чавганц гэдэг л болж байна гэв.

Арван дөрөв. Номын хүрд эргүүлэгч

Харвахад сум нэг хурдан
Харахад харц нэг хурдан
Санахад санаа нэг хурдан

Номын хүрд эргүүлэх сайн өдөр буюу Чойнхор дүйцэн хурж байлаа.

- Санжэй намшигжүгдэр тамжиджан,
Хорвоо жигдэн сэртэв одсүрэндан,
Шагжаа түв годаам лхаилхо
Санжэй бавоо дүнлаа чигцаалоо!

гэж сүмийн адар доргитол лам нар дүнгэнэлдэн тунжирдаж байлаа.

- Ялж төгс нөгцөгсөн
Түүнчлэн ирэгсэн
Үнэн төгс тухалсан
Бурхан Шигжээмунид мөргөм үү!

гэж яагаад ч юм Санж гэцэл монгол хэлээр уншиж орхиод гэв гэнэт
Түвдэд, Бэрээвэн хийдийн Гомаан дацанд хурал хурж байгаагаа
санаж, царай нь улайв. Чоймчиг гэлэн зарим ерөөл, магтаалыг
монголоор бас заасан тул заншсан ёсоор Санж гэцэл санаандгүй
төрөлх хэлээрээ уншиж орхижээ. Дэргэдийн лам нар мэдээгүй бол ч
бусад нь хэн ч мэдэхээргүй нүсэр их шуугиантай байлаа.

Гэр орноо санасан ч юм уу, юу ч болтугай бурхан багшид мөргөх
магтаалаа монголоор санаандгүй эхэлчихжээ. Чойнхор дүйцэнгийн
хурал дээр монголоор уншлага үйлдсэнийг мэдвэл түвдүүд хатуу
цээрлэл үзүүлнэ гэдгийг мэдэж байгаа тул Санж гэцэл цааш нь
болгоомжтой болж биеэ барив. Гэцэлийн бие одоо маш сайн болоод

байв. Бэрээмэг эмгэний цахилдгийн шүүсний нөлөөнд түүний ходоодны шарх бүрэн эдгэрч, харин ч урьдынхаасаа улам илүү ховдог болсоор хэдэн сар өнгөрлөө. Бэрээмэг эмгэн одоо Санж гэцлийн тогоог барьдаг болсон тул хоол ундаар гачигдахгүй, харин ч мяраалах шинж оржээ. Өвчтэй байхдаа үзэж чадаагүй номоо нөхөн үзэж амжжээ. Бас хажуугаар нь Пүрэвдоной маарамбатай тохирсон ёсоор отчийн ухаан сэмхэн орой үдэш заалгасаар байлаа. Маарамба ч дуртай зааж байв.

- Таны авралаар өвчин зовлонгоос салав. Гялайлаа гэж Санж түүнд хэлжээ. Энэ үгэнд Пүрэвдоной маарамба төдийлөн итгээгүй боловч сүүл сүүлдээ тэрэнтэй санал нийлжээ. Бас тэгээд өөрт нь наалдаж, өөрийн нь эрдэмд бишрэн ном сурах гэж зүтгэдэг тэрхүү монгол лам түүнд аятайхан санагджээ. Бас маарамбын танил гүртэнба ч Санжид эрдмээ заахыг хүсчээ. Нэг өдөр маарамбынд тэр гүртэн дахин тааралдахад нь Санж гэцэл,

- Таны авралаар өвчин эмгэгээс салж, номын мөр дахин хөөлөө. Гялайлаа гээд хэлж орхисонд Гүртэн их баярлаж,

- Чи үхэх заяатай хүн бишээ. Чамд шүгэлсэн муу ёр харин үхэх ёстой байсан. Миний альбин сэлмэнд тэд хиар үсэрсэндээ гэж хар сахлаа имрэхэд нь,

- Тийм сэлэм үнэхээр ад зэтгэрийн амийг авагч их эрдэм, ид шид дүүрэн ажээ. Та над эрдмээсээ хайрлахсан болов уу? гэж гуйв.

- Хэ хэ хэ. Миний сэлэм ид шидтэй бус. Харин титэмлэсэн таван бурхны ид шид шүү дээ гэж маарамба руу нүдээ ирмэснээ гүртэн Санж гэцлийн мөрөн дээр алгадаж,

- Самьяа гүртэнд шавь орох гэж хэн ч гуйгаагүй юм. Чи газрын хаанаас ирсэн, нэг тогжгор монгол гуйв уу? За тэгвэл өөрөө мэд. Би олон удаа зааж чадахгүй. Долоон шөнө долоон үүрээр л уулзамц! гэж хэлжээ. Санж гэцэл тийнхүү Самьяа гүртэнгийн нууц шавь болжээ.

Номын хүрд эргүүлэх сайн энэ өдөр ч Санж гэцэл бурхан Шигээмуунийн төлөө хамаг л итгэлээ зориулан шударга гэгээнээр хурал хурах учиртай гэдгээ дахин санан санасаар байсан боловч магтаалын шүлгийг нь монголоор уншиж орхисныг хажуугийн лам Андуугийн Пагсан сэмхэн сонсчихоод чойнцам завсарлагаа болоосой гэж тэсч ядан хүлээж байсныг Санж гэцэл мэдсэнгүй. Багш лам Лүндэгжунайг л харин мэдчихэж магадгүй гэж имээхдээ Санж гэцэл нүдний булангаар багш гавьж руугаа сэм харав. Гавж Лүндэгжунай зэсэн улаан царайгаа малийлган, гүн атираат духаа үрчийлгэн, юу ч болоогүй мэт амирлангуяа сууж, уншлагаа уншин зузаан уруулаа арай ядан хөдөлгөж байлаа.

“Багштан тэр холоос миний дууг яаж ч ялгаж мэдэх юм билээ дээ. Хий дэмий сэтгэл зовох хэрэггүй” гэж Санж бодов.

Лам нар дахиад л тунжирдан дуугаа өргөн бүдүүрүүлж сүм дүүрэн дүнгэнэлдэв. Санж дууриах зуур: “Багш лам мэдлээ ч гэсэн надад өршөөл үзүүлнэ байх” гэж боджээ. Санжийн багш лам Лүндэгжунай түүнийг өвчнөөс аврах гэж мэнгэн засал, сүнс дуудах, золигт гаргах хүртэл арга хэрэглээд бараагүй боловч Санж эдгэрсэн хойноо,

- Багштан таны ачаар өвчнөөс салав. Гялайлаа гээд хэлчихжээ. Тэгсэн чинь багш лам түүнд баярлаж,

- Их хүнд ёрын муу үйл шүтэлсэн байсан. Гурван давхар нүгэл хор таширласан байсан шиг билээ. Ямар ч гэсэн нэгэн зуун нэгэн өвчнийг миний уншлага хайлуулж өгсөн байлгүй дээ. За тэр ч яахав. Сүнс чинь эргэж ирснээс хойш болоо. Чи ер нь монгол газарт аливаа хүүхэн үлдээж орхисноо санадаг юм биш байгаа биз? Тийм юманд ч сүнс гүйчихээрээ буцаж ирдэггүй зовоогоод байдаг? гэж тулган асуухад Санж гэцэл нүүр нь шатталаа ичиж,

- Үгүй, үгүй. Би чинь сахил санваараа алдвал нүгэл гэдгийг мэднэ багш минь? гэж арайхийн өчиж билээ. Шавийнхаа ичиж зовсон

байдлын хэмжээгээр цаад үйлийг нь тооцоолдог гавжтан үнэхээр Санжийн үгэнд итгэжээ. Санж тийнхүү амьд яваагаа багш лам, маарамба, гүртэн нарын ном эрдмийн нийлбэр ач гэж үзжээ. Гэхдээ эргэлзэж явсан удаа бий. Түүний эргэлзээг багш лам нь уран үгээр тайлж өгчээ. Нүгэл, алдас шүгэлсэн муу ёрын хэтэрхий ихээс болж олон тооны зан үйл хийхээс нааш эдгэхгүй байсан гэж түүнд ойлгуулав. Бас урьд насандаа өнөө насны өдий үед хийсэн үйлийн үр юм гэж багш нь ярьсныг Санж үнэмшиж тогтоожээ. Харин Бэрээмэг эмгэний ачлалыг Санж гэцэл ерийн л нэг тус гэж үзжээ. Хоол ундаар сувилах нь эрдмийн ач биш, харин ердийн асрамж юм гэж боджээ. Ингэж ч бодуулах үгийг багш лам нь олж хэлжээ.

Бурхан Будда буюу Шигээмуунийн мэндэлсэн өдөр, зуны эхэн сарын долооны хурал, мөн сарын найманд Шигээмуунийн үсээ үргээлгэсэн, 15-нд будда болсон, дараа нь мөн тэр өдрийн ойгоор Шигээмууни таалал төгсч нирваан дүрийг олсон ёслолын хурлууд өнгөрч одоо чойнхор дүйцэн буюу номын хүрд эргүүлэх хурал хийж байгаа нь энэ юм. Харанга тахил магтаал, залбирал, ерөөл өөр хоорондоо залган үргэлжилсээр байлаа.

Шигээмуунь бурхан бол хорвоод төрөн, мэндэлж, цагийг эзэлсэн анхны их бурхадын дөрөв дэх гэдгийг Санж аль эртэд мэддэг болсон билээ. Бүр багад нь Чоймчиг гэлэн түүнд зааж өгсөн юм.

- Хорвоод мянган бурхан залрах учиртай. Бурхан бүхний анх түрүүлэгч нь орчлонг эвдэгч хэмээх их Гаргаасундий билээ. Хүн төрөлхтөн бий болоод дөчин мянган жил өнгөрөх үед ес дэх галавт төржээ гэж Чоймчиг гэлэн заасан.

- Хоёр дахь их бурхан Ганагаамууни буюу алтан чадагч болбоос хүн төрөлхтөн гараад гучин мянган жилийн нүүр үзэхэд хорвоод заяажээ. Дараагаар хорин мянган жилийн заагт гэрэл сахигч их Кашив бурхан заяав. Бидний эзэн их Шигээмууни дөрөв дэх их бурхан болон Энэ хорвоод мэндэлжээ гэж Чоймчиг гэлэн уйгагүй давтан заасныг гэцэл Санж үг үсгээр нь хоёр хэлээр эрт урьд цээжилсэн байна. Будда

бурхан Шигээмуунийн наян тэмдэг, гучин хоёр билэг чанарыг Санж гэцэл тугдрэлгүй тоочиж мэднэ.

”Хумс нь зэсийн өнгө мэт,
Хуруу нь бөөрөнхий, нарийн,
Судас нь зангираа үгүй,
Шагай нь илэрхий үгүй,
Арсланы явдлаар ажрагч,
Агуу сайхан биетэй,
Биед мэнгэ хийгээд сэвхи үгүй
Мутар нь модны унгарал мэт,
Чихний хормой зузаан, сувиндуу
Үснир нь рашнар мэт хар”

гэх зэргээр наян тэмдэг, 360 авгайлгатай. Бурхан Шигээмуунийг хүний гуа үзэсгэлэнгийн дээд хэмжүүр болгон зурж, алт, хүрэл гуулиар цутгаж урлан суум бүрд шүтлэгтэн болгонд түгээн шүтүүлсэн Буддын шашны нандин эрдэнэд зориулсан хурал дээр лам бүр их л хичээж ёсыг сахиж, номыг бясалгадаг ажээ.

Саяий бойжи жүгши мэдогдан,
Рирааб линши нида жамбаади,
Санжэй шинду мигдо пүлбэг,
Догун намдаг шинлажот баршог

гэж ширээт лам ганцаар уянгалан уншихыг сонсож суухдаа Санж гэцэл,

- Газар дэлхий болон сүмбэр
Уул тэргүүтнийг бүтээн
Хүжисээр сурчиж,
Огторгуйг наран сарнаар чимэгсэн
Бурханд ач мандал өргөө!

гэж мөн л монголоор толгойдоо дурайтал бодож байлаа.

Дээргүй дээд, тэргүүлэшгүй тэргүүн, үхэшгүй мөнх, үзэгдэх болоод үл үзэгдэх хамгийг бүтээгч гэхчилэн 360 авгайлал чимэгтэй Бурхан Буддагийн үйл, гавьяаны тухай залбиралын энэ хурал дээр Санж гэцэлд мэдэхгүй юм бараг үгүй байжээ. Иймд тэр үе үе өөр юм бодох зав олж байжээ. Сав шим, сансар орчлонгийн ертөнцийг бүтээсэн гэж бурхан багшийг лам нарт бүрнээр итгүүлсэн учир тэд уул номыг ёс болгон үг үсэг алдалгүй цээжилсэн байх нь зүйн хэрэг билээ.

Тэрчлэнгээр өнөөдрийн хурал урьд нь түмэнтээ давтсан танил юмыг уншин, уншсаар байтал ашгүй завсарлагааны манз, цав орж ирлээ. Зутангийн үнэр сэнгэнэн ханхлав.

Санжийн зиндааны нөхөр Андуугийн түвд Пагсан чоймцамын цагийг ашиглан сэмхэн гүйж гавж Лүндэгжунайд нэг юм хэлэхэд тэр нь толгой сэгсрэв. Пагсан цааш гүйж ширээтэд ойртох гэснээ ухарч гэсгүйд очоод баахан юм ярьж Санж гэцэл рүү зааж байлаа. Үүнийг Санж ажиж мэдээд өөрий нь тухай яриа болохыг ойлгов. “Пагсан андууба ямар л сайн юм ярив гэж. Намайг муулж байгаа байлгүй. Гэвч юу гэж муулах билээ? Юу ч гэх шалтаг үгүй. Ер нь энэ Пагсан муухай зантай, хүйтэн царайтай эр шүү” гэж Санж бодлоо. Түүний зиндаанд муухай зантай, яхир хэцүүгээрээ энэхүү Андуу нутгийн түвд залуу Пагсан онцгой билээ. Гэтэл бас Бодьпагийн Чогсон гэж нэг эр бий. Тэр бол түвд хүнд баймааргүй ихээхэн эелдэг налархай зөөлөн зангаараа Санжийн зиндаанд бас л онцгой нэгэн юм.

Гэсгүйд юм ярьж байгаа Пагсангийн цаана нь Чогсон зогсож байхыг Санж харлаа? “Чогсон тэнд байгаа болохоор Пагсанг миний тухай юу ярьсныг сонссон байж магадгүй” гэж Санж боджээ. Манз барьж дуусаад салхинд түр гарах үед Санж гэцэлд Чогсон түвд ойртон ирж, чихэн тушаа нь,

- Чамайг Пагсан гэвхүйд ховлолоо. Чи бурхны магтаал, номын түлхүүрийг монголоор уншсан юм уу? гэж асуув.

Санж гэцлийн дотор палхийжээ. Тэгээд царай нь хувхай цайхыг

Чогсон ажиж мэдээд, тэр асуултын хариуг ойлгож “Битгий шанал, битгий шанал” гэж шивнээд зөрөн өнгөрлөө.

“Пагсан хов хэлжээ. Одоо яадаг бол? Гэвхүйд торлогдуулах цаг болжээ. Торлогдоод өнгөрвөл ч яамай” гэж Санж чичрэн айлаа.

Үдээс өмнийн хурал гадаалах үеэр дуганы үүдэнд шамо гэсгүй туслагч гээгийн хамт гарч ирээд хурлын жаяг эвдсэн банди нар, заримдаа тохитой томоотой ламыг ч хүртэл цээрлэл үзүүлдэг ёстой тул энэ удаа Санжийн ээлж боллоо гэдгийг ч Пагсан, Чогсон, Санж гурав гадарлажээ. “Чухам яаж цээрлүүлэх бол? Торлогддог. Бас шонгоос хүлж ороолгодог. Хар гэрт хийдэг. Өөр яадаг билээ. Энэ хэдээр л өнгөрдөг байх. Аль нь байсан ч өнгөрчээ” гэж Санж бодож гашуун хувиа хүлцэнгүйгээр хүлээхээр шийдлээ.

“Хүний бие эхээс төрмөгц түүний сэтгэлд хоёр мод ургаж эхэлмой. Хоёул зургаа зургаан үндэстэй, арав арван гишүүтэй, дөчин найман мянган навчтай билээ. Сайн үйлсийн модны зургаан үндэс нь зургаан цагаан буян, муу үйлсийн модны зургаан үндэс нь зургаан хар нүгэл. Дөчин найман мянган навчис нь мөн тэрчлэн хоёр туйл буюу номын цогцос, нүглийн нисваанисыг үзүүлж байдаг юм. Аль нэгэн модоо давамгайлүүлчихвал тэр л зүгтээн хувьтавилан чиглэнэ” гэж Чоймчиг гэлэн заасныг Санж гэцэл сайн тогтоож түвд хэлээр мөн цээжлүүлэв.

Ёс суртахууны тэрхүү модыг цагааны буяны навчаар цэцэглүүлэхэд мөн зургаан зам мөр бий гэж Санжид ойлгуулж билээ. Эхний шат нь убаш буюу гэнэн юм. Убашийн мөр хөөсөн хүн ёс суртахууныхаа нүглийг мэдэж засахыг эрмэлзэн, засч, алдаж засаж байдаг тул Санж тийм хагас дутуу бодь мөрийн зэрэгт хүрэхийг хүсээгүй. Багш лам нь ч мөн л тийм бодолтой байсан. Бодь мөрийн хоёр дахь зэрэг нь сартаваан болно. Сартаваан бол сансар хорвоог бүрнээ огоорч хар бор амьдралыг жигшин хөндийрөх хэрэг юм. Санж тийнхүү амьдралаас хөндийрч сартаваан болохыг хүссэнгүй. Багш лам нь ч түүнийг зөвлөсөнгүй. Бодь мөрийн гурав дахь зэрэг нь сагардагамын ёс юм. Энэ нь үнэнч шударга, сэтгэл харамгүй аж төрөгчийн ёс мөн. Нэгэнт

харин ирэгчийн ёс гэж бас нэрлэнэ. Үүнийг Санж гэгцэл сонгон авчээ. Сагардагамын зэрэгт хүрэх нь хүний дээд ёсноо тулан очиж, бурхдын зэргээс холгүй тогтохын мөн чанар юм. Түүнээс цаашлахад анагаманийн ёс буй. Тэр нь өөрт оногдсон бүх үйлийг бүтээж харин үл ирэгчийн зэрэгт хүрэхийн нэр юм. Нэгэнт бүх үйлээ төгсгөсөн тул анагаманийн ёс гүйцээгч бол харин ирэх буюу дахин төрөх хэрэгцээгүй болно. Тийм ид шидтэй болохыг Санж хүссэн ч үгүй. Түүнд хүрнэ гэж өөртөө итгэсэн ч үгүй. Бодь мөрийн тавдугаар зэрэг бол архад буюу дайныг дарсан баатрын явдал мөн. Замд тохиолдох бүх түйтгэр саадыг архадууд даван ялдаг болно. Үүний тухай Санж гэгцэл санасан ч үгүй. Бодь мөрийн хамгийн дээд зэрэг нь бараанди габуут буюу өөрөө бурхан болох ёс болно. Энэ өндөрлөгт гарсан хүн нь өмнөө номын хаалга онгорхой байхыг нүдээр үзмой. Бурхантай ижил, ганц чанарт хүрсэн тул өөрөө бурхан ажээ. Бодь мөрийн ийм зэргийг мөрөөдөж болох боловч хүрч үл чадна. Хүрсэн нь цөөн хүн төрөлтөн үүсээд дөчин мянган жил болоход арайхийж эхний будда Гаргаасундий мэндэлж төрсөн гэдэг билээ. Санжид бараади габуутын зэрэг хэмээх бол санаж үл хүрэх сансар хорвоогийн өндөр алсын үлгэр домог байлаа.

“Сонгож авсан сагардагамын ёсонд минь харшлах юм гэж үү? Миний буруу, эсвэл нүгэл юусан билээ. Бурхны ерөөлийг өөрийнхөө хэлээр л уншиж орхисон хэрэг. Түүнийг нүгэл гэж тооцох юм уу? Бурхны номыг ямарваа хэлээр уншиж болно хэмээдэг биз дээ. Монгол хэлээр байтугай ягчисын хэлээр ч уншиж болно гэдэг биш билүү?” хэмээн Санж бодсоор жавдан дээрээ томоотой сууж, хурлаа үргэлжлүүлэн хурж байлаа. Гэнэт түүний санаанд “Хутагт сайн явдлын ерөөлийн хаан” буюу “Санжид молон” судрын төгсгөлийн үг орж ирлээ.

“Бурхны алтан сургаалыг хэл болгоноор дуудан түгээнэм би. Тэнгэр нарын хэлээр ч, луугийн хэлээр ч, ягчисуудын хэлээр ч, гумбандисын хэлээр ч ялгалгүй айлдан түгээнэм би” гэж тэр сударт гардгийг Санж гэгцэл санаж, зоригжлоо. “Ягчис гэдэг хор өгөгч махчингууд юм уу аймшигт гумбандисын хэлээр ч бурхны номыг түгээж болдог байхад монгол хэлээр уншсан ерөөлийн хэдэн шад шүлгийн төлөө юу л гэж

залхаах билээ” хэмээн Санж гэгцэл дотроо бодлоо.

Тэмээн толгойтой, бугын эвэртэй, могойн хүзүүтэй, загасан хайрстай, үнээний чихтэй, барын ууцтай хачин амьтныг луу гэж бурхны номонд бичжээ. Газар, тэнгэрийн алинаар ч яван амьдрахдаа хүний махаар хүнс хийдэг, хор өгөгч яргачингуудыг ягчис гэнэ. Найман их лус байх ёстой бөгөөд талай, жогвуу давжуу, рэгдэн, норжай, дүнжин, балмаа чинбуу гэнэ. Найман их ягчис, заландорь, бүрнээбадар, маньбадар, гувираа, самбаазана, гүхээндана, банзгаа, бизээгундаалий эдгээр юм. Эднийг цөм нэг бүрчлэн тодорхойлсон судрыг Санж гэлэн, Чоймчиг багшдаа байхыг нэг удаа нүдний булангаар харж билээ. Тэр хуудсан дээр бичсэнийг одоо болтол мартахгүй тогтоож авчээ.

“Лусын хаан малдоо сэжин: Лагшингийн өнгө хар хөх, могойн толгой нь цогнойн дүүлсэн, лагшингийн бөгс могойн сүүл цагирагласан, баруунд сэтгэлчлэн бүтэх чандмань эрдэнэ, зүүнд дэнсэлгээг арилгах үхэлгүй араанаар дүүрэн сангийн сайн хумх барьсан, үзэсгэлэнтэй, харваас гуа, тарган бөгсний халхавч элбэг дэлбэг соёрхсон, үнэлшгүй эрдэнэ шигтгэн чимсэн, ээмэг, хоолойн чимэг, мугар бойвгын бугуйвч, бөгж, сугавчлуур, хоолойвч зэргээр бэдэрлэсэн, яргач, түшмэд, хатан, нөхөд сэлт дагуулсан, завсраар нь баавгай, дигваранз, мэлхий, могой, аалз, гүрвэл тэргүүтэн хамарсан..” гэж бичсэн байж билээ. Хожим малдоо сэжингийн зураг үзжээ. Яг л ийнхүү бичсэнээр зурсан байжээ. Санж гэгцэл тэрхүү агь ёсны номыг нэг л удаа холоос харсан юмсан. Багш лам нь Санжийг бурхны номонд дэс дараа хэрэгтэй, хожим үзэх болно гээд тэр л сонин номоо үзүүлээгүй юм.

“Тийм аймшигт ягчис, мангасын хэлээр ч бурхны номыг номлож болно гэсэн байхад монгол хэлээр нэгэн шад ерөөл татаж болохгүй гэж үү?” хэмээн Санж гэгцэл дахиад л бодлоо.

“Тийм ягчисууд ямар хэлээр ярьдаг юм бол оо? Тийм хачин амьтад байдаг л юм байхдаа? Хэн түүнийг үзэж зурсан хэрэг вэ?” гэж Санж гэгцэл эргэлзэн бодож бодож өөрөө түүнд тайлбар өгч чадсангүй.

“Тийм мангас мэт юмсын хэлээр бурхны ном номлоод ч яах юм билээ. Тэдэнд юун ашиг?” гэж Санж эргэцүүлэн бясалгаж байтал уншлага дуусав.

Лам нар хурал өндөрлөсөнд баярлаж, түргэн түргэн алхацгааж гадаа гараад гороогоо хийхээр галуун цуваагаар явж эхэллээ. Санж гэцэл дунд хавьцаагаар гарч иртэл сүмийн гэсгүй хөмсгөө зангидан, бэрээгээ бариад цээрлүүлгийн баганын дэргэд зогсч байгаатай харц тулгарч сүрдэн айлаа. Гэсгүй түүнийг дуудав. Хүрч очсон нь бүдүүн зэрлэг дуугаар,

- Шигээмуунийн ерөөлийг ямар хэлээр уншсан бэ? гэж асуулаа.

- Нэгэн шадыг монголоор бусдыг түвдээр уншсан гэж Санж өчиг өгөв.

- Тэгвэл үүнийг шонд хүлээд торлогдоё гэж гэсгүй өөрийн туслах мангар бүдүүн гээгтээ тушаалаа. Санж хэрэг биш болж байгааг ойлгомогц,

- “Бурхны алтан сургаалыг хэл болгоноор дуудан түгээнэм би. Тэнгэр нарын хэлээр ч, луугийн хэлээр ч, ягчисуудын хэлээр ч, гүмбандисын хэлээр ч ялгалгүй айлдан түгээнэм би” гэж түвдээр чанга гэгч нь уншлаа. Гэвхүй түүнийг сонсоод гайхан эргэлзсэнээ,

- Хөөе, гээг. Наадахаа орхи. Нааш нь ирүүл! гэж туслахдаа тушаалаа. Түүний царай догшин сүртэй байлаа.

Санж айн чичирсээр гэвхүйд ойртон очвол тэр хөмсөг зангидаж,

- Сэрээ хийдийн пабон- ха ритоодыг тойрч гурван мянга гурван зуун гучин гурван удаа гороо хийж нүглээ наманчлахтүн! гэж тушаалаа. Санж баярлаж,

- Жа! Лагсоо! Лагсоо! гэж алга хавсрав. Гороо хийх нь шонд хүлүүлж

торлогдуулахаас амар гэж тэр боджээ. Гэвч Пабон- хаг 3333 тойроход
15 хоногийн зогсоо зайгүй явдал хэрэгтэй гэдгийг тэр мэдсэнгүй.

Арван тав. Зовлонгийн хүрд эргүүлэгч

Туухад гахай нэг хэцүү
Туулахад тал нэг хэцүү
Тоолоход од нэг хэцүү

Гоман дацанд монголоор бурхны ерөөл уншсаны учир Санж гэцэл гэсгээл цээрлэл үзэж, Сэрээ хийд Пабонха ритоодыг гурван мянга гурван зуун гучин гурав тойрч гороо хийж, бурхны магтаал уншихаар явлаа. Сэрээ хийдийн тэр ритоод нь бүр эртний Соронзонгомбо хааны үед байгуулсан агуйн сүм юм. Ритоод гэдэг бол уулын хяр хэмээх үг боловч одоо өөр утгатай болжээ. Уулын хяр дагаж агуйд ном бясалган суугчдын засч янзалсан, ихэвчлэн нэг хүн хоргодох оронг ритоод гэх болжээ. Пабон- хагийн ритоодыг Далай ламынх гэж үздэг байжээ. Есөн давхар агуй байсан боловч шашны дайсан Ландарма хаан ихэнхийг нь нураан сүйтгэж, одоо хоёрхон давхар үлдсэн гэдэг домогтой ажээ. Сэрээ хийд тийм ритоодоороо Бэрээвэн хийд мэргэн айлдагч ихтэйгээрээ, Галдан хийд гайхам сонин юмтайгаараа Түвд оронд нэр цууд гарчээ. Сэрээ хийдийн ритоодыг тойрон гороо хийх хүн олон учир тоос шороотой тойрог ,зам бий болжээ. Тэр замд л гагцхүү энэ хорвоод бурхны хишиг хүртэж чадаагүй ядуу хувь тавилантан хичнээн олон байдгийг мэдэж авч болохоор билээ. Тангад, түвд, таван хэлийн амьтан энэ тойрог дээр цугларч Пабон- хаагийн ритоодыг тойрон ар араасаа цуван явна. Зарим нь сунаж мөргөнө. Зарим нь зуун найман булцуут эрхээ эмрэн тоолж явна. Зарим нь нэг гартаа жижиг хүрд барьж алхахынхаа тоогоор түүний голыг эргүүлэн маани унших дүр үзүүлэн явна. Зарим нь гурван мянга гурван зуун гучин гурвын тоонд яавал түргэн хүрэх билээ гэж аргаа баран гүйх тооны хурдаар явна. Яс арьс болсон туранхай биетэй, бөөсөндөө баригдаж үзэлд орсон ядуус ч олон үзэгдэнэ. Тэд юунд гороо хийж яваа нь тодорхой. Буян хийж сайн хувь тохиол горилжээ.

Эгээрлийн орон бусдад үгүй болой Нигүүлсэхүйгээр удирдан соёрх,
лам Авид! гэж нэгэн хүн гуншиганаан улих мэт орилон явахтай Санж
гэцэл тааралдав. Тэр хүн монголоор ийнхүү Авид бурхны ерөөл
уншиж явсан учир Санж сониучлан дэргэд нь очоод,

- Та сайн байна уу? гэхэд цаадах нь,

- Сайн, Ламбугай амгалан уу? гэв.

Горооныхон амрах, зогсож саатах дургүйг мэдэх тул Санж түүнтэй
зэрэгцэн алхлах зуур үг өдөж,

- Та халх газраас ирээ юу гэв.

- Халх газраас хэзээ гарснаа мартсаан. Харин ламбугай хэзээ гараав?
Хэрэг зориг юун билээ?

- Ноднин ирсээн!

- Тэгвэл энд анхныхаа гороог хийж байгаа юм уу?

- Тиймээ. Та яаж мэдээ вэ?

- Ноднин ирсэн хүн тэр жилдээ энд гороо хийхээр зав олдоогүй биз.
Тэгээд мөнгөө барж, гуйлгачин болохоор л Пабон- хааг барааддаг
номтой юм газардаа. Бодвол гуйлгачин болоод л энэ газрыг түшээ биз.
Гэвч бас байз. Ламбугайн байдлыг харахад тар|;ан цатгалан байна.
Тэгэхээр хурал номын жаяг, даяг эвдээ биз дээ. Түүний учир гэм, зэмд
унаа юу?

- Таны хэлдэг ч бараг онолоо. Би Бэрээвэнгийн Гоман дацанд хурал
хурж суухдаа монголоор уншлага үйлдсэн гэм, нүгэлтэй хүн л дээ.
Тэгээд л лайгаа эдэлж байна.

- Үгүй тэр юу нь нүгэл байдаг билээ?

- Нүгэл гэж гэсгүй маань шийдээд Пабон- хаад гороо хийлгэхээр явуулсан. Гороогоор шийтгэсэн гэх юм уу даа

- Хэд эргэх вэ?

- Гурван мянга гурван зуун гучин гурав!

- Тэгвэл хагас сарын ажилтай болж дээ. Би залуудаа тэр тоог чинь арав хоногт арайхийн гүйцдэг байлаа. Зэгсэн сайн алхлахад арав хоног арай чүү бардаг билээ. Одоо хөгшрөөд 15 хоног алхаад арай л барахгүй явна.

- Одоо хэд үлдээд байна?

- Долоон тойрог

- Тэгвэл ч та гороогоо өндөрлөхөд ойртжээ. Харин юуны төлөө гороонд гараав? Бас л нүглээ наманчлахын учир уу?

- Миний энэ гороо амьдралд тохиолдсон долоо дох минь юм. Дөчин есөн насан дээрээ Пабон- хааг долоо дахь удаагаа тойрч гурван мянгатын гороо хийж чадвал нас сүүдэр чинь уртсаж, гуравдахь үеэ үзээд, насны эцэст туйлаас жаргана гэж лам багш айлдсан юм. Гурав дахь үеэ хүн бараг үздэггүй юм гэдэг. Хүүгээ, хүүгийнхээ хүүг, түүнийхээ хүүг үзэж байж гуравдахь үетэйгээ золгоно гэсэн үг. Би эхний хоёрыг үзээд байна. Одоо ганцхан үе үлдэв. Түүний барааг харах ид шидийг Пабон- хаагаас олоход ердөө долоохон удаа түүнийг тойрох үлдээд байна. Тэсээд тойрчих санаатай. Гэтэл мэнгэр хөдлөөд үе үе бөглөчих гээд зовоогоод байх юм.

...Энэ үгийг тэр хоёр явдал дундаа ярьж байлаа. “Мэнгэр гэхээс Пүрэвдоной маарамбатан тийм өвчнийг яаж эмчилдэг гэж над заалаа?” гэж Санж бодож явтал тодхон санаанд нь оров.

“Мэнгэртвэл ишигний махыг сүүн дотор битүү чанаад шүүсийг гүүний сүүтэй уулгана. Түүнийг чиндаруулга гэдэг” гэж багш маарамба заасан нь чихэнд тэр чигээрээ сонсогдох шиг боллоо.

Мэнгэртэй тэр хижээл мөргөлчин үе үе бүгшүүлэн ханиалгах боловч биеэ барин тэсвэрлэж гороогоо таслахгүйг хичээж урагшаа алхсаар л байв. Нэг удаа мэнгэрээсээ болж бараг л бүтэж үхэх шахав. Санж түүнийг өрөвдөж далан дээр нь дарж өгөх зэргээр тус болж түүнийг арайхийн тайвшруулав.

- Мэнгэрт ишигний юмуу борлонгийн махыг сүүнд битүү чанаж шүүсийг увал сайн гэдэг юм даа гэж Санжийг ярихад мөргөлчин,

- Тэр үнэн үү? Тэгвэл туршдаг хэргээ гэж инээмсэглэн хэллээ. Тэд цаашаагаа хамтаар үргэлжлэн гороолж явлаа.

- Мэнгэр байгаагүйсэн бол ч би аль хэдий нь гороогоо дуусгах болсон! гэж мөргөлчин амандаа бувтнав.

“Турван үеэ үзэхийг мөрөөддөг нь урт наслахын л хүслэнгээс гарсан хэрэг байх даа. Пабон- хааг тойрон гороолоход ч энэ хүний нас улам л богинодохоос уртсахгүй байлгүй дээ. Ядаж тоосгүй замд бол ч бас учиртай. Гэтэл түмэн хөлийн мөргөлчдийн нунтаглаж тахчиж, цагаан түйрэн болгочихсон энэ замд тоос босохгүй өдөр байтугай хором ч алга. Тэр тусмаа мэнгэртэй хүнд ам хамраар нь өлөн тоос орж уушиг цээж нь давхцаж хэцүү юм байна. Хөөрхий энэ хүнийг багш маарамбын зааснаар эмчилбэл арай дээр биш байгаа?” гэж Санж гэцэл өрөвдөх сэтгэлээр бодож сүжигтнийг үе үе ажиглан явснаа,

- Та ер нь чиндаруулгаар эмчлүүлбэл дээргүй юү? Лхасын халх мицанд очиход эрхбиш нэг ишигний мах, хувин сүү олдох байлгүй. Мэнгэрээ дарахгүй бол танд хэцүү байх шиг санагдлаа гэж хэлэв. Мөргөлчин хялавхийснээ,

- Зүгээр, зүгээр. Сэжгээр өвдөж сүжгээр эдгэрдэг юм. Пабон- хаад

сүжиглэж чадвал эрхбиш насан хутгийг олох байлгүй. Одоо хэдхэн тойрог гороо үйлдлээ. Түүнийгээ дуусгаж сэтгэл амрая гэж хэлээд улам хурдлан алхлав. Тэгтэл түүний мэнгэр нь дахин хүчтэй хөдөлж бүгшүүлэн ханиалгаж, шанааны нь судас гүрэлзэн, цааш явж чадахаа больж зогтусан бөгцийгөөд ээрэх мэт дуугүй болж зөвхөн бөгтөр цээж нь хүгдэгнэн оволзож эхлэв. Санж гүйж хүрээд дал мөрөн дээр нь дарах гэтэл мөргөлчний хамрын хоёр нүхнээс хүрэн цус годхийн гарч мөн тэрхэн мөчид эгц урагшаагаа үхэтхийн ойчлоо.

Санж түүнийг өндийлгөхөөр оролдсон боловч мөргөлчин нэгэнт амь тавьжээ.

Санж гэцэл балмагдан сандарч юү хийхээ мэдэхгүй байтал хаанаас ч гарч ирсэн нь бүү мэд, хоёр донзонпа гэнэт дэргэд нь бий болоод,

- Наадахад чинь сохор зоос, самбай хадаг байна уу? Байвал бид бурхны оронд хүргэе гэж түвдээр асуулаа.

- Мэдэхгүй! гэж Санж хэлснээ санаа зовж, - Би хөлсий нь төлье. Үүний хойтохыг та хоёр дааж өгөгтүн! гэв.

- Лагсоо! Лагсоо! Юу өгөх вэ? гэж тэр хоёр хүйтнээр инээвхийлэн үхдэлийн хоёр гараас нэг нэгээр барьж авлаа.

- Май! гэж Санж товчхон хэлээд хуурцаг дотроосоо хэдэн чох зоос байсныгаа нэг хадагтай гаргаж өглөө.

Хоёр донзонпа баярлан алга тосч түүнийг аваад, үхсэн мөргөлчнийг хоёр гараас нь дамжлан бараг л чирэх тооны авч явахад Санж,

- Хүүе та нар эвтэйхэн өргөөч! гэж шаардав. Тэгтэл Санжийн сэтгэлд “Хөөрхий энэ амьтны ар гэр, төрөл садан гэж байдаг л байх даа. Тэр нь хаа газар суудаг юм бол? Хэнээсээ асуух ч юм билээ дээ?” гэж бодогдов.

- Хүүе, наадахыг чинь халх мицааныханд үзүүлж хэний юун хүн болохыг нь тодруулах юмсан! гэж Санж хэлэв. Тэгтэл тэднийг тойрон ирсэн хэдэн гороочийн нэг нь ам нээж,

- Өө энүүнд садан төрөл гэх юм юу ч байхгүй. Гурван үеийгээ үзнэ гэж л үргэлж ярьдаг юм. Тийм юм юу ч байхгүй. Манай нутгийн юм гэж хэлэв.

- Хоёр үе минь бий гэж тэр саяхан ярьж байсан шүү дээ? гэж Санж эргэлзэн гайхлаа. Нөгөө хүн,

- Худлаа. Тэгж сэтгэлээ зогоож явдаг юм. Мэнгэртэй биенээсээ өөр төрөл садангүй хүн. Одоо нэгэнт нас дуусчээ. Иймд донзонпад тушааж хойт замыг олгохоос өөр арга байхгүй гэв.

- “Хөөрхий! Үхэх цаг ойрхон гэж бодохдоо л түүнийгээ уртасгахын хүслэн болж явсан юм байх даа. Хэн нь түүнд Пабон- хааг гороолон тойрвол нас уртасч гурван үеэ үзнэ гэж хэлсэн юм болдоо. Энэ талийгаачид болохоор Пабон- хааг тойрох нь буян болж байдаг. Надад болохоор шийтгэл болдог байх гэж дээ. Аяа, орчлонгийн явдал ийнхүү дэгэл доголтой ажээ” гэж Санж гэгцэл дотроо бодлоо. Нэгэн үйлийн хоёр талын тухай бодол түүний сэтгэлд гурав дахь удаагаа орж ирж байгаа нь энэ. Өлзийг өөд болоход донзонпа нар Санжид анх ийм юм бодогдуулсан. Дараа нь багш лам зулын гол болж одоход мөн л эргэлзэн гайхах бодолд эзлэгдсэн. Одоо Пабон- хаа гэж хүний нутгийн зэрлэг уулсын хяр дахь хоосон агуйнуудыг тойрон гороолох хувь тавиланг хүртээд нэг нь шийтгэл, нөгөө нь буяны үйлс гэж итгэн яваа хоёр биеийн учралаас ургуулан элдвийг бодохын шалтаг үүсчээ. Дахиад л Санж эргэцүүлэн бодлоо. “Хөөрхий! Тэр талийгаач энэ барзгар уулсыг могойчлон тойроход долоохон гороо дутуу гэж байсан. Тэгэхлээр гурван мянга гурван зуун хорин зургаан удаа нэгэнт тойрчихоод байсан хэрэг ажээ. Түүнд лам багш сайны ерөөл өргөж гороо заажээ. Гэвч надад бол лам багш хэрэг тарьсны торгууль баа болгож горооны тоо тогтоож өгсөн. Нэг үйл мөртлөө сайн, саар хоёрын билэгдэл байх гэж үү? Тэгээд мэнгэртэй өвгөнд хоёр мянга

хэдэн зуун гороо тус болсон ч үгүй. Мөрөөдөл нь биелсэн ч үгүй. Минийх болохоор дөнгөж долоохон тойрдог дээрээ явж байдаг. Хүний нутгийн зэрлэг уулсын энэ хярыг тойрон тойрсоор сайны захад хүрнэ гэж юунд нь бодож явсан эр вэ, тэр мэнгэрт өвгөн?" гэж Санж гэцэл бодож зогстол нь хяхарсан муухай дуугаргаад модон дугуйтай түрдэг тэрэг дээрээ үхдлийг хааш яаш тавьсан донзонпа нар уулын уруу газар руу явж одлоо.

Тослоогүй тэрэгний жихүүдэс хүрэм яхир дуунд эвгүйрхсэн Санж гэцэл буруу хараад гороогоо үргэлжлүүлээ.

Пабон- хааг тойрон гороологчдын дотор нэгээхэн ч баян чинээлэг хүн үгүй ажээ. Цөм л ноорхой дээлтэй, цоорхой гуталтай, тарчиг ядуус, зарим нь өвчин зовлонд нэрвэгдэж, тахир дутуу, эрэмдэг зэрэмдэг болчихсон, зарим нь өөрийн гэх бодолгүй зөвхөн л лам багшийн заасан тоог гүйцээхийн төлөөнөө гөлийтөл гиюүрэн алхлаж, өдрийг өнгөрөөн, шөнийг үдэн яваа улс байлаа. Хаяа нэг бадарчин, шавриачин, банди нар үзэгдэнэ. Тэд бол Санжийн нэгэн адил залхаал үзсэн, эсвэл зүгээр л сониучлан явдаг хүмүүс бололтой.

“Гороог зүгээр нэг хийж болохгүй. Харин сүжиглэн хийвэл зохино. Иймд маани гамбумыг эхнээс эцэс хүртэл давтан давтан уншиж явбаас зохино” гэж багш лам нь Санж гэцэлд хатуу чандалж номлосон билээ.

Санж гэцэл маанигамбум гэдэг ёс суртахууны сургаалийн судрыг аль хэдий нь цээжээр мэдэх тул тэр даалгавар амархан санагджээ. Одоо болохоор нэгэн төрлийн зүйлийг олон дахин унших нь яггүй уйтгартай ажил гэдгийг мэдэж уншлагаа сольж Жадамба судраас юм уу эсвэл Баранзаа Бараамид номноос ээлжлэн уншихад арай сонирхолтой байлаа. Жадамба бол бурхны магтаал найман мянган мөрт шүлэглэл юм. Баранзаа- Бараамид бол бурхан Буддагийн үйл явдлын тухай ном билээ. Эдгээрийг ээлжлэн уншихад өөр хоорондоо адилгүй тул газар хорох нь ч амар, уйтгарлах нь бага байлаа. Мөргөлчид шөнө өдөргүй гороолон явж үүрээр суугаагаараа бага

зэрэг нойр авч явсаар гурван мянгат гороог дуусгахыг ихэвчлэн хичээдэг байжээ. Тийм ч ёс тогтсон ажээ.

Шөнийн цагаар гороолон явахад одноос өөр зугаатай юмгүй. Гэвч одыг тоолох юм уу эсвэл хорин найман одны нэрийг тоочин, заримыг эрэн хайж явбал арай ч зугаатай болохыг Санж мэдэж зурхайн багшийн заасан оддын нэрийг амны уншлага болгожээ.

Тийнхүү өдөр шөнө ээлжлэн солигдсоор байвч горооны тоо гүйцэх яагаа ч үгүй. Явган явахын горыг даахгүй гутал нь хөлнөөс мултарч унах ойртсоор л байлаа. Биеийн тамир ч сулран доройтож байв. Нэг удаа Санж гэцэл горооны албыг орхиж гэртээ харих санаатай уулнаас бууж явахаар шийдэв. Хувцсаа сэлбэх, бас ч багахан хүнс нөөцлөн авахаар тэр далимд түр амсхийхээр санаа шулуудсан хэрэг юм. Санж тэр бодолдоо хөтлөгдөн Пабон- хаагийн хяр руу бууж явтал ойролцоо байх Сэрээ хийдийн борчуулын хашаанаас хоёр банди гарч угтан ирэв.

- Чи хаачих нь вэ? гэж нэг нь түвдээр асуулаа. Санж,

- Гэртээ харьж гутлаа солиод жаахан хүнс сэлбэх гэсэн юм гэхэд хоёрдох банди,

- Чи яагаад багш ламын заасан горооны тоог гүйцээгүй байхад буцаад явж байна! Одоохон эргэж гороогоо үргэлжлүүл! гэв. Санж үнэнээ учирлан,

- Миний гутлыг хараач дээ! Ийм болчихоод явж болохгүй байна. Тэгээд ч идэх юмгүй өлсч байна гэхэд,

- Тэр юу ч биш. Хөл нүцгэн ч, өл хоолгүй ч ялгаагүй гороог таслахгүй явж дуусгах учиртай гэж нэг банди хэлснээ нөгөөдөө хандаж,

- Чи яваад модон ул, хэдэн балин аваад ир! Би үүнийг харж байя гэв. Нөгөө банди Сэрээ хийдийн зүг эргэн гүйлээ. Санж тэр мөчид уур

омог нь хөдөлж “Энэ муусайн түвдүүдэд дээрэлхүүлж байх юм уу” гэж бодоод зам хөндөлдсөн бандийг хажуу тийш түлхээд цаашаа явлаа. Тэгтэл нөгөө банди ухасхийн босч Санжийн араас гүйн ирээд нударгалж эхлэв. Санж түүнтэй ана мана үзэлцэж байтал хоёр дахь банди эргэн ирж эвэршиж хатуурсан гараараа Санжийн элгэнд хоёр гурав хүчтэй буулгаж муужруулав. Нэг мэдэхэд нөгөө хоёр түүний хөл гарыг хүлж байлаа. Нударгын зодооны сургууль хийж өглөө болгон гарын ирмэгээр туйпуу нүдсээр байгаад эвэршиж хатуурсан сарвуугаараа тэр банди Санж гэцлийн эгмийг золтой л хугалчихсангүй. Хэрцгий балмадын сургуультай ажээ.

Удалгүй хоёр банди Сэрээ хийдийн борчуулын хашааны тэндээс хэдэн балин, нэгэн хос модон улавч авчирч Санжийн хуучин гутлыг тайлж хаяад хөлд нь модон улавчийг шидмэсээр янгинатал хүлэн бөхлөж, хавчиг үүргэн дотор нь хатсан хэдэн балингаа хуучин гуталтай нь хамт хийж өгөөд хүлгийг тайлан авмагц,

- Бос! Яв! Гороогоо үргэлжлүүл. Дахин оргох гэвэл муу юм болно шүү. Бид чам шиг юмыг балин болгож орхино. Чи бидний хараанаас хаашаа ч мултрахгүй гэж

тэр хоёр банди заналхийллээ.

Санж арга буюу хүчинд автагдаж тэдний үгийг дагахаас өөр замгүй тул босч Пабон- хаа өөд мацаж эхлэв. Ар талд нь хоёр бандийн доогтой инээд сонсогдсонд Санжийн уур нь дэврэн оволзсон боловч дахин тэдэнтэй үзэлцэх зүрх хүрсэнгүй. “Муухай санаатай улс юмдаа. Намайг энэ хоёр бандиар алсаас харгалзуулж байгаа юм гэж мэдсэнгүй. Тийм муу юм санасан ч үгүй” гэж Санж гэцэл гомдолтойёо бодож явлаа. Түвдүүдийн муу санаа гүнзгий ажээ.

Алсад Сэрээ тэгчилэн буюу их махаяанын орон гэдэг алдарт хийдийн чинхэрдэн, пааландсан орой гялалзан харагдаж байлаа. Ар талд нь түвд банди нарын доогтой инээд замхарч,

- Их зан гаргаад байвал дигваранзанд зоог барина шүү! гэж хашгиралдах нь сонсогдов. Дигваранз гэхийг сонсоод Санжийн дотор арзасхийлээ. Сэрээ хийдийн орчинд дигваранз хорхой элбэг тэр нь хүний биенээс хазвал тэсвэрлэхэд бэрх өвтгөдөг. Гүнжидийн тос гоожуулахаас нааш хатгуур нь биенээс салдаггүй тэр хорхойноос Санж их айдаг байлаа. Гүнжидийн тосонд түүний хатгуур хүний биенээс аяндаа сална. Эс тэгвэл айхтар шаналгааны үүр болдог байлаа. Түүний уурыг хүргэж бие биеийнхээ нүцгэн маханд тавьж хатгуулдаг аягүй муухай шоглоомыг Сэрээ дацангийн банди нар хэрэглэдэг байжээ. Санж ийнхүү Пабон- хааг гурван мянга гурван зуу тойрохоос өөр замгүй болсныгоо бүрэн ухаарчээ.

“Эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд тасралтгүй буян үйлд. Аливаа жижиг ялаа, шумуул тэргүүтэн санамсаргүй тохиолдлоор ам руу чинь орж амь нас нь егүүтгэгдэхгүйн тулд амны хаапт зүүж явагтун!” гэж Гоман дацанд өдөр бүр л сурсан номолдгийг Санж гэцэл энэ мөчид эргэн санах. “Дигваранзаар намайг хатгуулна гэнээ? Тэр чинь юу гэсэн үг вэ гэвэл бас л нүгэл болох үйл мөн. Ялаа шумуулыг залгихаас айдаг бол яагаад бурхны шавь хувраг хүнийг дигваранзаар хатгуулах нь нүгэл биш байдаг билээ? Энэ банди нарыг харахад яавч увашийн болон бандийн сахил хүртсэн тийм л насны улс байна. Гэтэл ийм нүгэлт юм хийхээр санаж бодож байдаг нь юун учир вэ? Багш ламд энэ тухай хэлбэл тэднийг огтхон ч зүгээр өнгөрөөхгүй нь лав” гэж Санж гэцэл боджээ. Таван завсаргүй нүгэл, шадар таван нүгэл, арван хар нүгэл гэж гурав хувааж багш ламын заасан нүглүүдийг Санж гэцэл дэс дараалан тоочиж үзэв. “Хэрвээ намайг дигваранзаар хатгуулах юм бол шадар таван нүглийн гуравдугаарыг үйлдэж байгаа хэрэг. Хэрвээ тос асгаж дигваранзыг үхүүлбэл арван хар нүглийн гуравдугаарыг үйлдэж байгаа хэрэг. Тэгэхлээр энэ хоёр банди аль ч үйлдлээрээ нүгэл алдас хийхэд сийхгүй улс байна. Эдний лам багш нь ямар хүн байдаг бол?” гэж Санж гэцэл бодож явсаар горооныхоо замд оров. Пабон- хааг тойрсон мөргөлчид үг дуугүй цувран явцгааж, ёстой л муу дууг тив гэгчид оччихсон юм шиг уйтгар гунигтай санагдлаа.

Түвд газар Зонховын сургаал дэлгэрч олон зуун жилийг элээж, гурван эр хүний бараг хоёр нь сүмд шавилан суусаар эх болсон зургаан зүйл амьтны тусын тулд нигүүлсэнгүй үйлс бүтээхийг өдөр шөнөгүй номлосоор байвч хүмүүс номын ёсоор болсонгүй. Дээрэм тонуул, аллага, егүүтгэл улам гаарч, муу муухай болгон байсаар ажээ. Үүнийг эргэцүүлэн бодоход Санж гэцэлд хачин санагдав. Зонховын номлол саяхан хүртсэн гэхэд монголчууд илүү дуулгавартай сүслэмтгий юм шиг бодогджээ.

Арван зургаа. Ганлингийн гаслах дуун

Ууланд төрсөн бүргэд даардаггүй
Усанд төрсөн загас даардаггүй
Урцанд төрсөн цаатан даардаггүй

Гоман дацангийн ганлинч лам гэв гэнэт үхэв. Түүнийг орлож ганлин үлээх хүн олдохгүй байлаа. Яг тэр үед Пабон- хааг тойрч гурван мянга гурван зуун гучин гурван гороогоо дуусгаад тас хар царайтай, цонхигор туранхай цээжтэй болчихсон Санж гэцэл дугандаа эргэж иржээ. Дацангийн гэсгүй Санж гэцлийг оногдсон үүргээ үг дуугүй сайн биелүүлж гороог бүрэн дуусгав гэж сайшаагаад шууд л,

- Ганлинч болгоно! гэж айлджээ. Ганлинч гэдэг чөмгөн бүрээг үлээдэг хүн болгох гэж байгааг ч Санж тэр дороо ойлголоо. Ганлингийн гаслах мэт дуунд Санж анхнаасаа төдий л дуртай биш. Аргагүйн эрхэнд л түүнийг бурхан номын хөгжим гэж тэвчдэг байлаа. Бас нэг эвгүй сэтгэгдэл төрсөн шалтгаан бий. Юу гэвэл ганлин бүрээг арван найман насны эмэгтэй хүний чөмөгний ясаар хийдэг гэсэн домогтой болохыг нь багш лам Чоймчигоос сонссон билээ. Ганлингийн дуу нь ажнай сайн хүлэг морины янцгаахыг санагдуулах учиртай. Ажнай морийг унаж ариун сухааваадийн орноо сүжигтэн хүрэлцэн очих ёстой. Тэр л ёсыг дагаж чөмгөн бүрээний салаалсан булцуун дээр морины хамрын нүхийг дууриалгасан хоёр цоорхой гаргаж, түүгээр нь дуугарахаар бодож хийдэг ажээ. Хүний чөмөгний ясаар хийсэн хөгжмийг амаараа үлээж морин янцгаах мэт дуун гаргах нь нэг л жихүүдэс хүрмээр юм шиг Санж гэцэлд санагддаг байжээ. Гэвч хүрээ, хийд болгонд ганлингийн гаслан янцгаах дуу хурал номын үйл болгон дээр сонсогдсоор ижил дасал болжээ. Харин өөрийн биеэр ганлинч болно гэхэд Санж цочирдон бишүүрхлээ.

- Харангач больё л доо, багш минь гэж Санж гуйсанд гэсгүй,

- Хүн нэгэнт эзэгнэж байгаа юманд шунах нүгэл гэв. Үнэхээр харанга цохих хүн дутаагүй нь илэрхий байлаа.

- Тэгвэл дуударамч больё гэж Санж дахин ам нээхэд гэсгүй уурлаж,

- Ганлинчаас өөр юм битгий горьд! Чамайг ганлинч болгохоор хэдий нь томилсон. Үг дуугүй явж Жалсан жинжүгт шавь ор! гэж тушаажээ. Өөр замгүй болсон нь тодорхой.

Санж гарах замгүйд сэтгэлээр багахан гутарсан боловч ганлинч болох далимаар бурхны хөгжмийн зэмсэг эзэмшиж, чихээ онгойлгож авахын горьдлогод автагдлаа. Сүмийн унзадын туслахыг жинжүг (жинжээ) гэдэг бөгөөд хурал номын хөгжмийг тэр эрхлэн гүйцэтгүүлдэг юмсанжээ. Гоман дацангийн жинжүг нь Жалсан гэдэг дэлдгэр хөх түвд байдаг. Тэр хөгжмийн авьяастай бас эелдэг хүн тул Санж түүнээс юм заалгаж авах горьдлоготой байлаа.

- Түр л ганлинч болно шүү! гэж Санж гэсгүйд гуйжээ. Гэсгүй түүнд хариу хэлээгүй боловч царайны байдлаар зөвшөөрснийг Санж гадарлажээ. Ганлин сураад л салахыг Санж хүсчээ.

- Үүнийг ганлин үлээж суртал нь хурлын үеэр би л түр ганлинч хийж байхаас яахав! гэж Жалсан жинжүг ам өгчээ. Гэсгүй лам,

- Түргэн л сургавал түргэн л сална гэж жинжүгт ойлгуулжээ.

Жалсан жинжүг Санж гэцэлд зөвхөн л ганлин үлээж сургахыг завдав. Түүнд Санж дургүйцэж,

- Нэгэнт л намайг хөгжмийн ламаар авсан бол би хурал номын хөгжмийн талаар сайн мэдэж авмаар байна гэв.

- За яахав, залхуурахгүй бол заалгана л биз. Маргаашаас эхэлнэ гэж Жалсан жинжүг болзлоо.

Маргааш нь Жалсан жинжүг хамаг байдаг эрдмээрээ Санж гэгцэлд гайхуулахаар шийджээ. Явцуухан шавар тасалгаанд хурал номын бүхийлэн хөгжмийн зэмсгийг өрчихсөн байлаа. Гэхдээ дөрвөн хананы ёроолд дөрвөн хэсэг болгон хөгжмөө өржээ.

- Бурхны хөгжим дөрвөн янз билээ гэж Жалсан жинжүг яриагаа эхлэв. Сониуч сэтгэлдээ Санж хөтлөгдлөө.

- Хөдөлгөхүй буюу цохивор хөгжмийн төрөл зүйл энэ! гэж баруун хананы ёроолд өрсөн зүйлийг жинжүг хуруугаар зангалаа.

- Хонх, дамар хоёрыг тэнд тавьжээ. Хонхны бариулыг очир хэлбэртэй хийж, ом хом драм хири буюу амирлангуй, дэлгэрэнгүй, эрх, догшин гэсэн утгатай үсгийг дотор талд нь эргэн тойрон бичсэн байдаг. Зүүн гарт хонхыг барина. Баруун гарт очир барьж хонхыг цохино. Хонх, дамрын дуу бол бурхны шавь нарт саад түйтгэр хийх гэж үргэлж бодож байдаг буг чөтгөрийг үлдэн хөөдөг юм гэж ирээд л Жалсан жинжүг айхтар нуршин ярьж эхлэхэд Санж залхуу нь хүрчээ. Түүний мэддэг юмыг нуршихад эвшээмээр болдог байлаа. Тэр байдлыг гадарласан Жалсан зүүн хана руу очиж,

- Энд дэлдэх төрлийн дэлдвэр хөгжим байна гээд хэнгэрэг дохиуртай, поолиосон цан хосоороо, мөн цараан дотроо хос очрын зурагтай сэлнин, зэс харанга, мөнгөлсөн дэншиг, гоёмсог иштэй дуударам ийм таван төрлийн хөгжмийн зэмсгийг жинжүг Жалсан заалаа. Гэхдээ дуугаргах аргыг дараа заана гэнэ.

Хэнгэргийг Санж сайн цохидог байлаа. Бүр багадаа түүнийг сурчээ. Харин эндхийн хэнгэрэгний дохиурууд голдуу матрын толгойг дүрслэн хийсэн хачин хэлбэртэй нь сонин ажээ. Цанг ч Санж бас төдий л сонирхсонгүй.

Ширэм, зэс, мөнгө гурвыг хольж цутгасан тул их царгиа дуутай, дэлбээ нь том тусмаа улам их нүргээнтэй болдог гэж цангийн тухай

багш лам эрт дээр үед хэлсэн нь санаанд оров. Тэрчлэнгээр сэлнин, харанга, дэншиг бол цохин дэлдэхэд өөр өөрийн өвөрмөц дуу гаргадаг боловч үндсэн чанараараа адил төрлийн хөгжмүүд юм. Дэлдэх хөгжмийн хамгийн сонирхолтой нь дуударам юм. Дуударамыг Санж дуугаргаж сураагүй билээ. Харин дуу нь их таалагдах учир тоглож сурахсан гэж боддог байсан юм. Дөрвөлжин модон хүрээн дотор ес юм уу арван хоёр жижигхэн нүд гаргаж нүд бүрд нь зэс таваг бэхлээд өндөр ишин дээр байрлуулсан тийм л жирийн хөгжим боловч дуударам аялгуу сайхантай, уулын тунгалаг горхины чимээг санагдуулдаг дуутай юм. Дуударамд нүдээ бэлчээрлүүлж зогсохыг нь ажиглан мэдээд Жалсан жинжүг дохиур авч дуударамыг жингэнүүлэн дуугаргав.

- Гоё байгаа биз? Гэвч би чамд үүнийг заах гэж бодохгүй байна. Ганлин л үлээж сурвал болоо! гэж Жалсан хэлэв.

- Ганлинг урьдаар сайн сургачихвал дараа нь бусдыг надад зааж өгөөрэй гэж Санж гуйлаа.

- За яахав, харж байж л болно гэж Жалсан хэлснээ өөр нэг хана руу очиж,

- Энд үлээвэр хөгжмүүд байна. За муу дунгарыг ч чи юу эс андав гэж. Харин бишгүүр бол дуударамас илүү сайхан дуутай. Би бол бишгүүрт дуртай. Жу Адиша Энэтхэг газраас Түвдэд ирээд шашны ариун шүтээний зүйлс их л дутууг мэдэж заримыг нөхөж хийхийг санаачилсан юм гэдэг. Галандагаа шувуу гэж гоёхон жиргэдэг амьтан бурхны орон Энэтхэгт байдаг бол манай Түвдэд үгүй юм. Тэгээд Жу Адиша галандага шувууны дууг дууриалгаж бишгүүр зохиосон гэдэг юм даа. Тэр бас Галбаавараас зандан модоо үгүйлж оронд нь улаан хүж хийж бишгүүр үлээх бүрийд улаан хүж асаалгадаг журам тогтоосон гэдэг юм. Чи үүнийг үлээж сурвал дээр гэхэд нь Санж гэцэл толгой дохиж “Лагсоо” гэж түвд маягаар бөхөлзөн шивнэлээ.

Тэнд бас арьсаар бүрсэн чөмгөн бүрээ буюу ганлин зэсээр хийсэн

үхэр бүрээ, миган, лимбэ, тунраа, жүр, шүгэл тэргүүтэн өрөөстэй байлаа. Бүрээгээр огторгуйн зааны хүрхрэх дууг, тунраагаар нохой хуцах чимээг, жүр юм уу шүгэлээр элдэв шувуун дууг дууриалган гаргах зорилготой ашигладгийг Жинжүг Жалсан товч тайлбарлан ярив. Тэр тухайд Санж гэцэл сонссон юм нэлээд тул төдий л сонирхсонгүй.

Эсрэг ханан тушаа чавхдаст хөгжмийн төрөл зүйлийг өрсөн байлаа. Тэнд пипаа, бивлэг, бисаанз тэргүүтэн тавиастан харагдахад жинжүг Жалсан тэр зүг зөвхөн зангах төдий болоод,

- Тэнд чавхдаст хөгжмүүд байна. Хурал номын хэрэгт тэднийг төдий л хэрэглэдэггүй тул чамд одоогоор заах ч юм алга. Манайд ер нь бүх төрлийн хөгжим бий. Харин дэлдвэр хөгжмөөс гандий мод байсныг өчигдөр Жанцэ дацангийнхан гуйж аваад явсан. Тэдний гандий мод цуурчихаж гэнэ. Муу ёрдоо! гэж ярив. Гандий мод нь хоёр алд шахам урт, өнгөлж гөлийлгөсөн адил хүрэн зандан адил цул гулдан мод бөгөөд маш хатуу учир дэлдэхэд зэс харанга шиг сонин дуу гардаг гэдгийг Санж Буянзалбирах хийдийн гандий модоор төсөөлж байлаа. Энэтхэг газар ургадаг тул гандий модтой сүм ховор байдаг ажээ. Санж гэцэл нэгэнт ганлинчаар суух болсныг далимдуулан хурал мөргөлийн хорин дөрвөн төрлийн хөгжмийг сурч авах санаа дотроо агуулсан тул цөмийг нь ихэд сонирхоход Жалсан жинжүг өөрийн эрдэмд хэн нэгэн хүн шүтэн бишрэхэд дуртай байдаг ёсоороо сэтгэл өөг болж,

- За, хө юуны урьд ганлингаа л үлээж сурна биз дээ. Тэрний тулд эхлээд янгийг цээжилж ян татаж сурваас зохино гэж хэлэв.

“Янгийг” гэдэг аялгуу тэмдэглэх аргыг сурахсан хэмээн Санж гэцэл дандаа мөрөөдөж Буянзалбирах хийдийн унзад ламын ян татахыг шохоорхон сонирхдог байлаа. Одоо түүний баргил бүдүүн дуу чихэнд нь сонсогдох шиг болжээ.

Санж гэцэл Гоман дацангийн хурал номын ганлинч хийхээр аргагүй

шийдэж, янгинан гаслах мэт дуутай ганлинг хөгжмийн даамал жинжүг Жалсангийн заавраар үлээдэг ажилтай болоод хагас сар өнгөрлөө. Эхлээд ганцааранг нь суулган ганлин үлээлгэдэг байснаа сүүлдээ нийт хөгжмийнхөнтэй хамт сургуулиуллаа. Бишгүүрч, дунч, хэнгэрэгч, үхэр болоод ямаан бүрээч, цанч, сэлнинч, харангач, дуударамч нар гэхчилэн олон хүнтэй танилцлаа. Тэдний дуугаргах хөгжим нь хэдхэн аялгуутай тул сурахад амархан байлаа. Харин чавхдаст хөгжмийг тоглоход их л амаргүй, бас тэгээд жинжүүг өөрөө ч түүнийг олигтой дуугаргаж чаддаггүй. Хурал номын үед цөөхөн хэрэглэдэг болохыг Санж мэдэж авлаа.

Жинжүг Жалсан түвд хүн гэхэд алив наадамд илүү их дуртай, эрээ цээргүй, ам султай эр байсан тул Санжид зүсэн бүрийн юм ярьж сүүл сүүлдээ их найзлах болжээ. Тэгээд нэгэн өдөр,

- Хоёулаа зууринбочийн захаар явья! гэж гуйжээ. Санж түүнийг дуртай зөвшөөрөв. Учир нь Гоман дацны жинжээ ламтай хамт захаар тэнэж явахад хэн ч халдашгүй бүрэн эрхтэй гэж Санж олзуурхан боджээ.

Сэрүүвтэрхэн нэг өдөр тэд Зуу ринбочейн зах дээр хоёул гарчээ. Балба, хаашмир, Бутаны худалдаачид тэр захын гол эзэд байлаа. Хаашмир хоргой, намбуу гэдэг цэмбэ, тэрэм гэдэг хялгаслаг даавуу, англи паалантай сав суулга, итали шүр, энэтхэгийн элдэв эдлэл тэргүүтнийг эгнүүлэн өрсөн панзчингууд янз бүрийн хэл аялгуугаар ярьж эд бараагаа магтан хашгиралдаж өлөн тоосон дунд үнсэн царайлцгаагаад чих дөжрөм шуугианыг ер хайхрахаа больсон ажээ. Өлсөн тачаадсан илжиг, луус байн байн орилолдож, цоо гэж түвдүүдийн нэрлэдэг өндөр сэрвээтэй, урт эвэртэй хайнагийн шарын нуруун дээгүүр дамнуулаад бөс бараа хөндлөн тохчихсон наймаачид бие биетэйгээ арцалдан хөшилдөж байв.

- Хүүе чи үүнийг хараач! гэж гэнэт Жинжээ лам Жалсан Санж гэцлийн ханцуйнаас татлаа. Юуг хараач гээд байгааг нь гадарлаагүй Санж гайхан ажвал тийм их сонирхмоор юм нүдэнд нь торсонгүй.

- Юуг харах юм бэ? гэж лавлан асуув.

- Түүнийг хараач! гээд Жалсан лам нэгэн худалдаачны араас зангав. Тэр нь ерийн л тохиолддог худалдаачны нэг байв. Баруун гарынхаа ханцуйг сугалдаргалан унжуулж, малгайгаа ар шилэн дээр шидэж сагалдрагаар нь тогтоосон, бүсээ доогуур татаж дээлээ шуусан байдлыг харахад түвд худалдаачин ажээ.

- Тэрэнд сонин юу байгаа юм бэ? гэж Санж гайхан асуувал,

- Сонин юм алга. Гагцхүү гавлыг нь хараач! гэж Жинжээ лам хэлэхэд Санж гайхаж сайтар ажваас түүний заасан худалдаачин эрийн гавал нь ар тийшээгээ цойлсон мэт хэлбэртэй ойлон толгойтой ажээ. Өөр сонирхмоор юм алга байв.

- Юу нь сонин санагдав? гэж Санж улам гайхан лавлав. Жалсан уурлах мэт болж хөмсгөө зангидсанаа,

- За чи ч миний зиндааны хүн болтлоо мөн өдий байна даа. Чи түүний гавлыг сонирхохгүй байна уу? гэв.

- Гавлаар яах юм бэ? гэж Санж хайхрамжгүй хэлсэнд Жалсан,

- Ийм гавалтай хүн ховор байдаг юм. Үүний гавлаар дамар хийхсэн. Тэгвэл ч мөн сайхан дуутай дамар болно доо гэж хэлэв. Санжийн дотор эвгүй боллоо. “Амьд хүний гавлын ясанд шунаж байх гэж дээ. Арай ч хэтэрсэн нүгэлтэй бодол байхаа” гэж тэр бодоод,

- Нүгэл болно, чимээгүй! гэв.

- Юуны чинь нүгэл! Бурхан номын сайн үйлийн тухай бодож байхад нүгэл болдог гэж хэнээс дуулав. Харин ч буян болно. Энэ худалдаачин бол ингэсгээд л насны үйлээ дуусгана. Харин гавлаар нь хийсэн дамар бол бурхан шажны үйлсэд хэдэн үеийг дамжин буян болно гэж

Жалсан ухуулж эхлэхэд нь Санжийн санаа зовж духны хөлс бурзайн гарч, бие нь чичрэх шиг болсон тул панз наймааны хүмүүсийн хоорондуур цаашаа зүтгэж гавлы нь тухай ярьж байгаа наймаачнаас холдон явлаа. Араас нь Жалсан жинжүг амандаа юм үглэн бувтнасаар гүйцэж ирлээ. Тэр амьсгаадаж,

- Дамрыг араараа нийлсэн хоёр хомхоор хийдгийг их учиртай юм гэж бодоорой. Сав ертөнц, шим ертөнц хоёр бөөрөөрөө холбогдон хоёр тийш харж оршноо гэсэн бурхны номлолын билэг тэмдэг мөн. Наргил модны самрын хальсыг тал дундуур нь хувааж хоёр араар нь нийлүүлэн бөхлөөд задгай талыг арьсаар бүрж дамар хийдэг юм. Тийм дамрын дуу зөөлдөөд сөөнгө хоолойтой хүн шиг байдаг. Харин гавлын ясан дамар бол юутай царгиа дуугарна гээч. Тийм дамар дэлдээд сууж байхад амьд хүний толгойгоор дуу гаргаж байгаа мэт сонин санагддаг. За тэгээд их үнэ хүрнэ гээч. Дацанд илүүдвэл Утай Гүмбум за тэгээд л Халх монгол хаа ч үнэ хүрнэ дээ, гавлын дамар! гэж Жалсан жинжүүг зогсоо зайгүй ярихад Санж гэцлийн толгой нь өвдөх шиг болж сэтгэл нь бүрмөсөн хямрав. Нутагтаа байхад түвдүүд хүний гавлаар дамар юмуу бадар аяга хийдэг тухай бүдэг бадаг сонссон байжээ. Одоо энэхүү жинжээ лам Жалсан түүнийг бүр тодруулж ой гуттал нь ярьж өглөө. Санж тэр сэдвийг өөрчилж ондоо юмны тухай ярихын мөрөөдөл болж явтал шүр сувдан унжлагатай алаг хивсэн хормогчтой өндөр гуалиг нуруутай, нүүрэндээ оо энгэсэг буюу цайны хандаар будаг тавиагүй, цайвар ягаан царайтай бүсгүй тэдний замд дайралдав.

- Хүүеэ, энэ бүсгүй лалын шүтлэгтэн юм болов уу? гэж Санж сэмхэн шивнэн Жалсангаас асуулаа.

- Чи юугий нь сонирхоод тэгж асуув? гэж Жалсан байцаахад,

- Бурхан шүтдэг бол тэр нүүрээ цайны хандаар хүрэнтүүлэн будсан байх ёстой. Гэтэл цагаан ягаанаараа байна. Лав лалын шүтлэгтэн байхаа гэж Санж нөгөө хүүхнийг харцаараа үдэх зуур хэлэхэд Жалсан,

- Золиг минь, чамд энэ хүүхний аальгүй цагаан царай сонин байж! Надад бол огт өөр юм нь сонин байна гээд хүүхний хойноос эргэн алхлав.

Цайны хандаар нүүрээ хүрэнтүүлж будаагүй бол түвд хүүхнийг шалиг завхай явдалтан эсвэл лалын шашинтан гэж үздэгийг Санж мэдэх болсон тул тэр хүүхнийг аальгүй цагаан царайтай гэсэнд үг сөрсөнгүй. Харин Жалсан тэр хүүхний юуг сонирхож байгааг таагаагүй тул эргэлзэн гайхаж хойноос нь даган явлаа. Тэгтэл хүүхэн зогтусч пийлэн даавуу зарж байгаа наймаачинтай үнэ хаялцаж эхлэв. Англи улсыг түвдүүд пийлэн гэдэг юм. Пийлэн даавууг чанартай гэж түвд хүүхнүүд үнэлдэг ажээ.

Жалсан жинжүг нөгөөх хүүхний архан талд зогтусаад эргэж Санжийг даллан хүрч очиход нь чихэн дээр нь хушуугаа цорвойж шивэгнэн,

- Хараач чи үүний шилбийг! Би үүнийг л сонирхож байна гэв. Санж гэцэл өөрийн эрхгүй нөгөөх хүүхний чийрэг булчинтай хөлийн шилбэ рүү зэрвэс харлаа. Нарийн гоолиг тэгшхэн шилбэтэй хөлдөө пийлэн шаахай өмсчээ.

- Үүний шилбэ ийм гуалиг тул дунд чөмгөөр нь ганлин хийхсэн, тэгвэл ч мөн... гэж Жалсан Санжийн чихэнд шивэгнэв. Гэнэтийн энэ үгэнд гэцэл золтой л муурч унасангүй. Хүүхэн энэ яриаг сонсчихвий гэхээс яс нь хавтайх мэт болж Санж шалавхан өөр тийшээ эргэн хүмүүстэй чихцэлдэн холдов. Санжийг алдчихаас болгоомжилж Жалсан жинжүг мөн л ухасхийн хүмүүстэй чихцэлдэж, гүйцэн ирээд гараас нь атган авч,

- Чи яачихаваа! Юунд ингэж дальдчиж байдаг юм бэ? гэхэд нь Санж,

- Та дандаа л хүний ясанд шунаж байх юм. Энэ чинь их алдас болно доо гэв.

- Яалаа гэж дээ. Бурхан номын үйл бүтээх тухай л би бодож явна даа. Чи намайг зах дээр наймаа үсэргэхээр гарлаа гэж бодож байна уу? Үгүй шүү! Бурхны үйлийн төлөө л эрэл хайгуул хийж явна... гэж Жалсан хэнэг ч үгүй ярилаа. Санж гэцэл,

- Би тийм нүгэлтэй хайгуулд оролцох дургүй байна. Харихаар буцлаа гэж хэлээд захын төвөөс гарахыг завдав.

Жалсан түүнд өөр юм хэлсэнгүй араас нь дуртай дургүй дагаж явлаа. Тэгтэл нэгэн их шуугиан дэгдэж хүмүүс шавааралдаж, орилуу дуу тавих сонсдов.

- Хулгайч! Хулгайч! гэх дуу Санжид тодхон сонсогдож байлаа.

“Ямар нэгэн хүн хулгай хийхийг завдаад баригдаж дээ. Энэ Түвд газар хулгайч хүнд их хатуу шийтгэл үзүүлдэг болохоор хулгайд баригдсан хүн ч зовно биз дээ” гэж Санж гэцэл дотроо бодож явлаа. Үнэхээр хулгайчийг бариад тууж яваа хүмүүстэй тэд дайралджээ. Үсий нь гөлийтөл хусчихсан ойлон толгойтой залуухан эрийг гар хөлөөр нь дөнгөлөөд тууж яваа үзэгдэв. Түүний хүзүүнээс том хар чулуу дээсээр ороон зүүжээ. Голын усанд живүүлж тонилгох хүнийг ингэж хүзүүнээс нь чулуу зүүж зах дундуур тууж гардгийг Санж урьд нь олонтаа сонссон билээ.

- Нүгэл нь цааш улам зузаарахаас үүнийг аврах гэж байгаа юмсанжээ гэж Жалсан амандаа үгэлснээ,

- Хүүе чи үүний гавлыг хараач! Бэлэн дамар! гэж хэлэхэд нь Санж түүнийг цохиод авмаар санагдав. Үнэхээр тэр хулгайч эрийн гавал ар тийшээ цойлдож орсон сонин хэлбэртэй үзэгдлээ. Жалсан,

- За үүнийг лав л Үйчүү мөрөнд үйлгэж цааш харуулахаар авч яваа байх. Үүнийг дагадаг нь зөв. Хямдхан дамартай болно. Өнөөдөр зах дээр ирсний хэрэг бүтэх биз. Хоёулаа энийг дагая гэхэд Санж нударгаа зангидан дургүйцэж,

- Дэмий чальч! Би л чамтай хамт явахгүй дэг. Нүгэлт хар минь! гээд өөр зүгт зугтаах тооны гүйлээ.

- Би ганцаараа явах минь. Үүнийг нэгэнт тонилгохоор болсон байна. Иймд бурханд өглөгөө өгөөд тонилно биз. Би чамтай чамгүй замаа мэднэ. Хулчгар эр вэ? гэж Жалсан хэлээд нөгөөх хулгайч туусан бөөн хүний араас явлаа.

Санжийн ой гутаж, “Үхэвч ганлинч болохоо больё. Яасан эвгүй бузар юм бэ? Яаж ийгээд л ганлинчийн ажлаас зайлья” гэж дотроо бодож хатуу шийдлээ. Жинжүг Жалсан хонь дагасан нохойн адил ялтны араас дойдогнон алхсаар нүднээс далд оржээ. Хүний ясанд шунасан түүний муухай занд Санж гэцэл үнэхээр дургүй нь хүрч жихүүдэст эзлэгджээ.

Арван долоо. Оюуны сав гэнэт дүүрэв

Урсгал ус нэг муруйна
Ургах мод нэг муруйна
Урт зам нэг муруйна

Тэр шөнө тэргэл сартай байлаа. Санж гэцлийн нойр хүрэхгүй эргэж хөрвөж, хорвоогийн түмэн явдлыг эргэцүүлэн бодож, сэтгэлийн шаналгаанд тарчлан зовж байлаа. Нэгэн үе алс тэртээ Хар азаргын нуруунд Уст Чацрангангийн голоор нутаглах ядуу эцэг эх, дүү нараа санана. Нэгэн үе харь газрын түмэн араншинтай, мянган зовлонтой амьдралын эрээвэр хураавар явдлыг эргэцүүлэн бодно. Бурхны орон гэгдсэн Лхас хотод ирснээс хойш үзсэн харсан, туулж өнгөрүүлсэн бүхэн нь Буянзалбирах хийдэд багш лам Чоймчигоос сонсож, номноос үзэж төсөөлөн бодож байсантай огтхон ч адилгүй байлаа. Бурхны нэрээр хийж байдаг юм бүхэн тийм ч буянтай үйлсийн шинжийг тэр бүрий санагдуулахгүйд үе үе гайхах сэтгэл төрж байлаа. Тэр бодол дээр нь жинжүг Жалсан өчигдөр давс нэмээд өгчээ. “Яахаараа хурал номын хөгжмийг хүний ясаар хийхийг тэр мөрөөддөг юм бэ? Яахаараа тэр хүний сайн сайханд шохоорхохын оронд ясанд нь, тэр тусмаа бүр гавлын ясанд нь шунаж явдаг хүн бэ?” гэж Санж гэцэл гайхан бодоод учрыг олсонгүй. Тэрчлэнгээр лам багш нарынхаа тухай эцэст нь нэгэн зиндааныхныхаа тухай Санж бодлоо. Нэгэн зиндааныхан нь намдэлийн гуравхан аймгийг дуусгажээ. Гэвч тэд нар Санж гэцлийн мэддэгээс илүү мэддэггүй байлаа. Харин Санж бол илэрхий аймаг савын бүх судрыг уншаад парчинг дуусгаж дүлбэ, винайн ёсыг нарийвчлан үзэх хэмжээнд бүр нутагтаа байхад тулж очсон хүн тул нэг зиндааныхныхаа мэдэхгүй зүйлийг ч цээжпэн тогтоосон байжээ. Гэвч түүнийгээ гайхуулж ярьдаггүй юмсанжээ.. Нөхөд нь Санж гэцлийг юмыг зүйрлэшгүй хурдан тогтоодог айхтар ойтой хүн гэж боддог болжээ. Зарим нь түүнд бүр атаархаж үзэн яддаг болсон шиг Санжид бодогддог байв. Ялангуяа Андуу нутгийн

түвд Пагсан онц муухай зантай, ер нь Санжийг үзэн яддаг мэт санагддаг аж. Хурал дээр монголоор уншлага хийсэн тухайд Пагсан л ховолсон шиг сэжиг төрсөн. Бас хааяа юм асуухад Пагсан зөрүүд сарлаг шиг загнадаг. Гэтэл Чогсон бодьпа бол огт өөр. Цаг үргэлж л инээвхийлэн зөөлөн дуугаар ая тал засч Санж гэцэлд долигнож явдаг байлаа. Зөвхөн Санжид ч биш хүн хүнд л тэр наалдаж цавуу шиг юмуу эсвэл нойтон хамуу шиг салдаггүй эр юм. Зиндааны нь өөлд, торгууд нар түвд хэлд сулхан тул хэл сурах гэж Чогсонтой их наалдан үерхдэг байлаа. Нэг зиндааныхан нь “Санж чи ном бясалгаж биеэ зовоож яах нь вэ? Нэг л удаа сонсоод л цээжилчилдэг юм чинь. Ер зовох юм алга. Энэтхэг газар явж их Галигаадаа хотод эрдэм сурвал таарна” гэж хааяа шоглон ярьдаг байлаа.

“Ер нь би урьд сурчихсан юмаа мэдэхгүй хүн болоод л дахин давтаад сууж байх ямар хэрэг байна. Шууд л шалгуулаад гэвш болохыг бодвол яах бол! Манай зиндааныхны байр байцыг харахад одоо дахиад хоёр гурван жил сууж байж винайн аймаг савд хүрч ирэх нь бололтой. Тэгээд ч хөгшин эцэг эх маань миний хойноос шаналж зовж зүдэрч байгаа биз. Энэ газар арваад жил суух хооронд юу ч болж болно” гэж Санж гэцэл хатуу шийдвэрлэв. Яг тэгж бодох үед нойр нь хүрч таг унтчихжээ. Тэгтэл зүүдэлж эхлэв. Хүний гавлаар дамар хийхээр Жалсан жинжүг хоёулаа ярилцаж байсан нүгэлт үйлсийн үр болж Санжийг тамд хүргэхээр шийджээ. Чухам ямар тамд хаяхыг шийдвэрлэхээр эрлэг хаан чигнүүрээ барин дэнслэн нарийвчлан хэмжиж байснаа,

- Хөрөө тамаар оруулж дараа нь төмөр өргөсөн дээр гөвших тамд байлга! Тэгээд тэлүүрдэн төөнөх тамд хая! гэж тушаалаа. Санж үхэтхийн айж “Би гавлаар дамар хийх гэж огт бодоогүй” гэж хэлэх гэсэн боловч дуу нь гарахгүй, хоолой нь боолттой байлаа. Эрлэгийн илч нар Санжийг дөрвөн мөчнөөс нь төмөр бахь мэт сарвуугаараа атган авч хөрөө тамд оруулав. Тэнд олон зуун нүцгэн хүмүүсийг үе мөчөөр нь тас тас хөрөөдөж хаяж байлаа. Санж айж хашгирах гэтэл бас л дуу гарсангүй. Хавтгай вандан дээр Санжийг өөд харуулан тавиад улаан цустай хөрөөгөөр цээжин дундуур нь хөрөөдөж эхлэв.

Яс нь хэрчигнэж, бие нь хуваагдаж тэсэх аргагүй өвдөх шиг болов. Түүний биеийг хэдэн хэсэг хөрөөдөөд дараа нь дахин эвлүүлж хуучин хэвд оруулав. Тэгээд улам ихээр тарчлаан зовоохын тулд дахиад л хөрөөдөж эхлэв. Санж гаслан чарлаж, босон харайхыг оролдсон боловч бүтсэнгүй. Хөлийг нь тайран хаялаа. Гарыг нь хөрөөдөж эхлэв. "Халуун, хүйтэн хоёр тамаар аль алингаар дамжуулж арван зургаан янзын цээрлэл үзвэл зохино" гэж эрлэгийн хөрөөчин хэлж байхыг Санж тодхон сонсчээ. Халуун, хүйтэн нийлсэн арван зургаан тамд нүгэлт хүмүүс хойт насандаа цээрлэл үзэж тарчлан зовдог юм гэдгийг Санж гэцэлд бараг л бурхны ном заахаасаа өмнө лам багш нар нь сурган номлож билээ. Тэр л ёсоор тамын бүхий л оронгууд нүдний нь өмнө ярайж үзэгдэв.

- Төмөр өргөсөн дээр гөвших тамд үүнийг одоо аваач гэж тамлагчдын нэг нь хэлэх шиг болов. Санж гэцэл айн балмагдаж, сарвалзан чаргууцалдлаа. Гэвч тус болсонгүй. Зарааны үс шиг арзайсан төмөр өргөстэй хавтгай вандан дээр түүнийг нүцгэн биеэр нь чулуудав. Хавирга сүврэгээр нь төмөр өргөс нэвт нэвт хатган орлоо. Тэгтэл тамлагч улайдмал төмөр шилбүүрээрээ Санжийг ороолгож эхлэв. Ороолгох тусам төмөр өргөснүүд биенд улам лав орж, тэсэхүйяа бэрх өвтгөж байлаа.

- Өршөөгөөч намайгаа! гэж Санж гуйх гэтэл хоолой таг. Тэгтэл төмөр шилбүүрээр ороолгогч хүн нь нэг зиндааны нөхөр андуугийн Пагсан байхыг Санж нүүрээр нь танилаа. Санж бүр ч айж,

- Пагсан минь, намайгаа өршөөгөөч! Би чамд муу юм хийгээгүй шүү дээ гэж гуйхыг завдав. Тэгтэл Санжийг төмөр өргөст вандангаас угз татан салгаж аваад өөр нэг хавтгай данзан дээр хаяж дөрвөн мөчийг дөрвөн тийш тэлүүрдэн хадлаа. Гарын сарвууг нужганатал нь нэвт хадахад мөн л тэсвэрлэшгүй их өвдөв.

- Одоо төөнүүр аваад ир! Үүнийг тал бүрээс нь төөнөнө гэж Пагсан хашгирахыг Санж сонсоод уйлагнан чарлав. Тэгтэл,

- Хөөрхийг яах нь вэ? Битгий төөнөөч! гэж нэг танил дуутай хүн хэлэх сонсдов. Ажин харвал инээвхийлсэн царайтай Чогсон зогсож байлаа. Санж түүн рүү тэмүүлтэл,

- Сэр,сэр! Зүгээр, зүгээр! гэж Чогсон хэлэх шиг болоод аюулт зүүд нойрноосоо Санж арайхийн салж сэрлээ.

- Яасан их зүүдлэнэ вэ? Рунхаан дотор дуулдаад цочоочихлоо гэж Бэрээмэг эмгэн гал зуухнаас гарч ирээд Санжийг сэрээсэн болохыг сая л ухаарлаа.

- Муухай тамд унаж байна гэж зүүдэллээ шүү! гэж Санж духныхаа хөлсийг арчин хэлэхэд Бэрээмэг эмгэн,

- Захаар юмуу олон хөлийн газраар тэнэсэн хойно зүүдлэлгүй яахав. Элдэв муу юм хараа биз. Тэгээд тэрнийгээ нойрон дундаа үзэж л таарна гэв. Эмгэн голы нь олоод хэлчихжээ.

“Нээрээ л Жалсан жинжүгийг дагаж зах дээгүүр тэнүүлчилснээс л ийм юм зүүдэллээ. Дахиж тийнхүү тэнүүчлэхээ л больё” гэж Санж гэцэл бодоод нүүр гараа угаах зуур шөнө бас өөр нэгэн чухал юм бодож байснаа сэргээн саналаа. Гурван аймаг сав ухааныг шалгуулж шууд гэвш болж цагийг товчлохыг хүсч байснаа эргэн бодож өнөөдөр л өглөөнөөс эхлэн энэ тухай ширээт ламаас гуйхаар шийдээд Санж гэцэл түргэн зуур өглөөний цайгаа уулаа. Чухам ямар ямар шалгалт өгөх билээ гэж эргэцүүлэн бодлоо. “Намдэлийн саваас хадаг, жумбрай (шалтгааны үр) шидавыг өгчихсөн. Парчингийн таван аймаг сав, умын хоёр, зодын хоёр аймаг савын шалгалт өгөх үлдсэн юм байна. Дон- дун- жу Чунсар- ог, Чунсар гон, габдагбо.. за ер нь гайгүй юм шиг вэ дээ. Өнөөдөр зөвшөөрүүлээд авбал маргаашаас эхлээд шалгууль” гэж Санж шийдлээ.

...Ширээт лам Санж гэцлийн гуйлтыг хайхрамжгүй хүйтнээр угтлаа. Тэр анхнаасаа Санж гэцэлд талгүй байсан ёсоороо түүний гуйлтыг дэмий төрхгүйтсэн явдал гэж үзэв.

- Зиндаа алгасаж явдаг ёс байхгүй. Үг дуугүй л явах ёстой замаараа яв гэж ширээт лам хариу айлджээ.

- Тэгвэл намайг ганлинч болохоос чөлөөлж өгөөч! гэж Санж хариу сөргүүлэн гуйлаа. Тэр гуйлтад татгалзахаас ширээт лам нэрлэхсэн бололтой.

- Зиндааныхан дотор чинь ганлинч болох дуртай өөр хүн байвал түүнтэй хоорондоо тохирч болно биз. Гэхдээ жинжүг Жалсан шийднэ байх гэж Ширээт лам хэлжээ.

Жинжээ лам Жалсан дуулгавартай, бас тэгээд сониуч Санжаас салах дургүй байлаа. Гэвч Санж түүнд хамаг байдгаараа учирлан ярьж эцэст нь бүр шалдаа буугаад шөнийнхөө зүүдийг ярив.

- Ха ха ха! гэж Жалсан гурав нугаран удтал хөхөрч дооглож байснаа,

- За за! Үнэхээр чиний сэтгэл муруйсан байна. Зиндааныхнаасаа хэн нэгийг ятгаж орондоо өгвөл би чөлөөлье. Ховог сайрын торгууд Балтыг ятгаад үз! гэж хэлснээр тэд яриа тохиров.

Ховог сайрын торгууд Балтыг Санж гэцэл өөрийн оронд ганлинч болгохоор ятгасанд тэр маш дуртай зөвшөөрөв.

- Ном цээжлэхээр ядраад байх юм. Ганлинч болбол дээр байх! гэж тэр хэлжээ. Энэ үг Санжид бөөн олз байлаа.

Тийнхүү Санж ганлинчийн зовлонт ажлаас салж зөвхөн бясалгах номын мөр хөөх болов. Олон дахин гуйсаар байтал нэг өдөр ширээт ламын сайн дур хөдөлж цанидын (билгэ чанарын) номд цоорон гарсан Гэндэнбалдан Лхаарамбыг Санжийн номын шүүлэг авах ламаар тохоожээ. Цанид Лхаарамба Гэндэнбалдан нас өндөр болсон бүдүүн шалхгар өвгөн лам бөгөөд хоёр хөл дээрээ арайхийж хөдөлдөг ажээ.

Дацанд орж гарахдаа довжооны шатаар өгсөх буух гэж их ядарч, амьсгааддаг байлаа.

- Чи тэр шүүлгээ өгч болно. Гэхдээ надад зав байхгүй. Хурал ном гадаалах, өглөө орой цугларах үеэр намайг шат руу буулгаж өгч бай. Тэр хооронд цээжилсэн номоо уншиж шалгуулах биз! гэж Гэндэнбалдан лхаарамба хэлжээ. Тэр ёсоор Санж өглөө, өдөр, оройн чойнцамын үеэр өвгөн лхаарамбыг сугадан явах болов. Эхний өдөр шат өгсөж явахдаа лхаарамба,

- Чи хадаг, жумбрай хоёрыг шалгуулчихсан гэдэг биз. Одоо шидув эхлэн унш! гэж тушаажээ. Санж шидув буюу шүтээн бүтсэн тухай номнолыг цээжээр уншиж эхлэв. Гэвч тэр номыг ганц нэг өдөр уншиж барахааргүй билээ. Лхаарамба түүн тухай огт бодоогүй бололтой. Санж гэцлийн уншлагыг чихний хажуугаар өнгөрөөж, өөр юм бодож явсаар дуганы хаалгаар орохдоо,

- За болно. Дараа зогссон газраасаа цааш үргэлжлүүлэн уншаарай! гэв. Их ламтан ийм л төрхтэй байлаа.

Энэчлэнгээр өдөр бүр үргэлжилж Санж тэрхүү өвгөн Лхаарамбын бие хамгаалагч нь эсвэл гоцго нь болж хувирчээ. Лхаарамба ч өөрөө сүүлд нь залхуурч унших номын эхэн, дунд, адгаас нь сонсоод л шүүлгэсэнд тооцдог болов. Тийнхүү сар шахуу үргэлжилжээ. Нэгэн өдөр Лхаарамба Гэндэнбалдан Гоман дацангийн гаргачуулыг цуглуулжээ. Хийдийн хамба, цорж, ширээт лам, дэд ширээт буюу лайцан, гэсгүй, унзад, донир эдгээрийг цуглуулан,

- Энэхүү Санж гэгч бурхны шавиас судрын аймаг сав таван зүйл дүлбэ, винайн ёсыг шүүж үзлээ. Цөмийг нэн сайн чээжлэж торохгүй уншлаа. Үүнийг гэвш болгоход дутах юм алга. Гэвш болгоод зиндаа дээшлүүлэх саналтай байна гэж Гэндэнбалдан лхаарамба тэдэнд санал тавилаа. Санжийн зүрх цохилж, биеэ арайхийн барьж байлаа.

- Винайг сайн мэдэж байгаа бол бодисадын болон таринын санваар хүртээгүй байж болохгүй. Иймд энэхэндээ тохироод Винайг дахин нэлээд хугацаанд үзүүлээд сахилыг хүртсэн хойно нь жүд (үндэс) үзүүлбэл таарна гэж ширээт лам айлдав.

- Би санал нэг байна гэж лайцав дугарав.

- Равжамбын мяндаг аваагүй болохоор хэцүү л байна. Манай Гоман дацанд долоон зиндаа дуусгаж байж үүнд хүрдэг. Гэтэл энэхүү Санж болбол дөнгөж хоёр зиндаа дуусгаж байна гэж цорж лам айлдав. Түүний үг үнэд хүрдэг ажээ.

- Тэр ч тийм юм. Тэгэхлээр ум, юм хоёрыг үзэх зиндаанд нэлээн суулгавал таарна гэж Хамба лам айлдсанаар хэрэг явдал бүрэн шийдэгджээ.

Хэдийгээр умаа гэдэг сэжиг сэтгэлийн ухаан, юм гэдэг орчлонгоос ангижрахуйн ухааны номыг Санж цээжээр мэдэж Лхаарамбад сайн шалгуулсан ч гэсэн нэгэнт Хамба лам түүнийг дахин үзэх хэрэгтэйг сануулсан тул үг зөрөх хүн байсангүй. Санж дор хаяад л гурван жил арын жавдан элээх хугацааг товчилсондоо их баярлажээ. Мөн тэр өдрөөс эхлэн Гоман дацанд цуурхал тарав. “Ар монголоос ирсэн Санж гэв гэнэт оюуны нь сав дүүрч, номонд нэвтэрхий болж гэнэ. Пабон- хааг гурван мянга гурван зуун гучин гурав тойрон гороолоод ийм шидийг олж гэнээ” гэж нэг хэсэг ярьжээ. Нөгөө хэсэг нь “Жалсан жинжээ лам хоёулаа Зуу ринбочейн зах дээгүүр тэнэж яваад эрдэнийн гавал олсон юм гэнээ. Тэгээд номд нэвтэрхий болов” гэж ярьцгаав. Түүнд итгэсэн нэг зиндааныхан нь хурал номдоо суухын оронд Пабон- хааг тойрон гороолохыг лам багш нараасаа гуйцгаах болов. Нэг хэсэг нь Жалсан жинжүгийг захаар явья гэж үргэлж гуйж гувшдаг болжээ. Аль алиныг нь хэнд ч зөвшөөрсөнгүй. Ховог сайрын торгууд Балт, Хөх нуурын өөлд Гонсүрэн хоёр Санжийг яагаад Пагон- хааг тойрох болсныг мэддэг байлаа.”Тэд Чогсон түвдээс асууж мэджээ. Гонсүрэн тэр аргыг хэрэглэж шийтгэл хүлээж Пабон- хаад гороо хийх “ял” эдлэхийг хүсчээ. Тэгээд нэгэн өдрийн уншлага дээр монголоор

ярьчихжээ. Гэвч түүнийг хэн ч анхаарсангүй. Дараах өдөр нь бас л монголоор уншлага явуулсанд хэн ч ажигласан ч үгүй, тоосон ч үгүй. Үүнд Гонсүрэн их л гайхан гутжээ.

- Намайг хурлын үеэр монголоор уншлага үйлдэхэд ер хэн ч тоохгүй байна яах вэ? гэж Гонсүрэн маргааш нь Санжаас аминчлан асуув.

- Надад хэлээд нэмэргүй. Харин чи тэр тухайгаа Пагсан юмуу, Чогсонд л санаандгүй ярьж орхи. Тэгээд л хэрэг чинь бүтнэ гэж Санж зөвлөв. Гашуун туршлага хэлсэн нь тэр!

- Тэдэнд ярьж яах юм бэ?

- Хэргээ бүтээе л гэж байгаа бол тэдэнд л ярь. Тэр дороо л хэрэг мандаж чамайг Пабон- хаад явуулаад өгнө гэж Санж ажиг ч үгүй хэлэхэд Гонсүрэн үнэмшлээ. Чухам яаж тэдэнд хэлэхээ мэдэхгүй хэсэг эргэлзсэнээ, өдрийн донго буюу зоог түгээх үеэр Пагсанд Гонсүрэн, Чогсонд Балт нар хэлэхээр шийдэж,

- Түвд хэл дутуу сурсан болохоороо шидув уншихад түгдрээд бардаггүй. Ашгүй монголоор уншиж дууссан чинь олны дүйвээнд хэн ч мэдсэнгүй гэж Гонсүрэн Пагсан түвдэд сонин болгон ярив. Цаадах нь тоосон шинжгүй өнгөрчээ.

- Монголоор уншлага уншчихад манай арын жавдан дээрх гайхлууд юу ч сэжиглэсэнгүй. Монголоор ч гэж дээ ердөө торгуудаар уншсан л даа гэж Балт Чогсомд санаандгүй мэт ярьжээ.

- Өөр хэн ч энийг чинь мэдээгүй юу? гэж Чогсон сониучлав. Балт дуугаа намсгаж,

- Ашгүй хэн ч мэдээгүй. Би бол чамд итгэж ярьж байгаа юм даа гэв. Чогсонд тэр нь эвгүй санагджээ.

- Над итгэхээр эрхий хуруундаа итгэ! гэж Чогсом ууртай хэлээд

өнгөрөн явав. Ховлох шинж бүрэн тодорчээ.

“Одоо л нэг болдогтоо хүрлээ. Энэ Чогсон лав алтан хушуу хүргэнэ дээ. Тэгвэл намайг ч дор нь л Пабон- хаад илгээнэ” гэж Балт дотроо баясан боджээ.

Тэр өдрийн хурал цэглэж лам нар гадагшаа гадааллаа. Хийдийн гэсгүй хамрын тамхиа сороод жаяг эвдэгсдийг залхаах шонгийн дэргэд зогсож байлаа.

- Балт нааш ир! гэж тэр дуудлаа. “Одоо л өнөөх Пабон- хааг руу хөөх биз дээ. Алтан хушуу өргөжээ, гэсгүйд” гэж Балт бодоод гүйн очлоо. Гэсгүй ч уураа барьж ядаж байх харагдлаа.

- Гонсүрэнг олоод ир! гэж гэсгүй тушаав.

Балт Гонсүрэнг тэр дорхноо олж дагуулан авчрав. Гэсгүй тэдэн рүү ярвалзан харснаа,

- Та хоёр долоо хоногийн турш хийдийн хог цэвэрлэнэ. Өнөөдрөөс эхлэнэ гэж зарлиг буулгав. Балт, Гонсүрэн хоёр аянганд цохиулсан мэт цочин гайхаж,

- Бид хоёр яалаа гэж хог цэвэрлэх юм бэ? хэмээн Балт гайхаш тасран асуувал,

- Аа та хоёр яаснаа мэдэхгүй байна уу? гэж гэсгүй чанга хашгираад жугбоо гэдэг төмөр бэрээгээ далайн Балтын мөрөн дээр чанга буулгав. Эгэм нь хугарах шиг болж Балтын толгой эргэв.

- Хөөе, хуврагууд! Нааш ир энэ хоёрыг залхаа! гэж гэсгүй хашгирахад гэв гэнэт дөрвөн мангар хувраг хаа нэгтээгээс гарч ирээд сайртай нудрагаараа Балт, Гонсүрэн хоёрыг толгой түрүүгүй зодож эхлэв. Ийм маягаар гэсгээнэ гэж санасангүй.

- Хаширлаа! Больёо! Өршөөгөөч! гэж тэр хоёр толгойгоо гараар хаацайлган орилолдов. Ном эрдэм сайн сурах авьяасаар тааруухан боловч мангар шавь нараасаа хувраг болгож ойр зуур зардаг Гоман дацанд жаяг сахиулах албатан зодооч хувраг нарын тусгай бүлэг байдаг ажээ. Тэд нар гэсгүй юмуу эсвэл шашны захиргааны даалгавраар лам нарыг залхаан цээрлүүлдэг байлаа. Балт, Гонсүрэн хоёрт тэдний нудрагын амтыг хангалттай үзүүлсний дараа,

- За болно. Хуврагууд явцгаа! Та хоёр хог цэвэрлэх шүүр саваа авцгаа! гэж гэсгүй хэлжээ.

Балт, Гонсүрэн хоёр дэрсЭн шүүр, гуйлан савхан аваад хог цэвэрлэхээр явах зуур хоорондоо хэрэлдэв.

- Чамаас л болсон юм гэж Балт эхлээд ам муруйн үг өдөхөд Гонсүрэн,

- Балай минь, чамаас л үүсээгүй юу? Пабон- хааг тойрч бурхны ном түргэн сурахын тухай чи л эхэлж үг үүсгээ биз дээ гэж ууртай асуухад Балт,

- Чи л дахин дахин үглэж байсаар ийм хэрэг тарихад хүргэв. Ер нь өөлдүүд залхуугаасаа л болно доо! гэчихсэн чинь Гонсүрэнгийн уур хүрч найзыгаа нудрагалаад авлаа. Балт хариуд нь дэрсэн шүүрээрээ толгой дундуур нь савж орхив. Тэгтэл залхаагч хуврагнууд дахин гарч ирээд тэр хоёрыг бүслэн авч бие бие рүүгээ түлхэн зодож, чирч гулдран хийдийн хар гэрт хүргэж босгоор нь оруулмагц гаднаас хаалгыг хааж төмөр цоожоор гажигнатал цоожлов.

Байшин дотор чийглэг харанхуй, бас шалгүй учир дороос хүйт дааж байв.

- Ингээд л буяны үйлс маань өнгөрлөө дөө. Чамаас л болсон юм гэж Балт харамсан дуугэрав.

- Чамаас л болсон юм. Би бол угаасаа Пабон- хааг гойрон гороолоход

нэг их дурлаагүй байсан. Цөм л "Пабон- хаад гурван мянган гороо хийгээд Санжийн оюуны сав дүүрч эрдэм нь цоорч гэнэ" гэгцгээгээд байхаар чиний үгэнд орсон минь гай боллоо гэж Гонсүрэн гонсойн ярихад Балт,

- Тэгвэл ерөөсөө чи бид хоёр аль алинаасаа биш харин тэр муу халхын бадарчин Санжаас болсон хэрэг байна гэж ууртайяа дуугарлаа. Тэр шөнөдөө хоёул нэг их зоволгүй нойроо бартал хурхирч өнгөрчээ. Гэтэл тэднийг маргааш нь, нөгөөдөр нь, нөгөөдрийн маргааш нь хэн ч тоосонгүй. Гурав хоног хоосон суусанд тэр гурынхалж үхэх дөхлөө. Тэднийг мартчихжээ гэж бодоод хоёул хашгиралдан хаалгаа нүдэж өшиглөж гарчээ. Гэвч таг чиг байлаа.

Арван найм. Ертөнц өнгөрсөн ба үл өнгөрсөн зайд

Үхэртэй хүнд газар хол
Үхсэн хүнд дэр хол
Үгүйрсэн хүнд юм хол

Ертөнцийн өвөг эцэг, гурван орны эзэн Лэгдэнванчигчимбуу, махасуваар ван болбоос биеийн өнгө улаан, эх умаадивий улаантай учирсан шампүрэлванжид буюу бусдын хувилсанд баясагч тэнгэрийн оронд оршмой! гэж Лхаарамба Гэндэнбалдан намуухан боловч сүрлэг дуугаар номлов. Санж гэцэл хоёулхнаа байгаа тул лхаарамбад чанга ярих шаардлагагүй ажээ. Санж гэцлийг шалган шүүхдээ Гэндэнбапдан лхаарамба түүний ой сайтай, сэргэлэн ухаантайд биширч өөрийн шавь болгохоор өмчлөн авчээ. “Энэ сайн лам болж магадгүй юм. Би шавиа болгоод ном заагаад үзье” гэж лхаарамба шашны захиргаанаас гуйж зөвшөөрүүлжээ. Тэрнээс хойш Санж Лхаарамбын гэрт бүтээлийн сүм гэж түүний нэрлэсэн бяцхан өрөөнд сууж ганцаарчлан ном заалгах болжээ. Энэ нь гэр орноо санаж, хар бор амьдралын элдэв саад түйтгэрт дайрагдан сэтгэл санаа тогтворгүй болж эхэлж байсан Санж гэцлийг огт өөр ертөнцөд аваачсан мэт болгосон тул түүний байдлыг эргүүлэн ном эрдмийн мөрөө дахин хөөж явах замд нь шулуутгаж өгчээ. Хөл үймээн байхгүй, гагцхүү Лхаарамбын заах зүйлийг анхаарахаас өөр садаарах шалтгаангүй бас ч тэднийх байдал зохистой тохилог тул Санж лхаарамбын дуулгавартай шавь болжээ. Агь ёсны ном гэгдсэн бурхдын намтар, ертөнцийн учир шалтгааны номлолыг Лхаарамба зааж эхэлсэн ажээ.

Амирлангуй дүртэй 42, дошгин дүртэй 58 бүгд нэгэн зуун бурхад мөн тэдэнтэй зөрчилдөн, сүлбэлдэн орших олон арван мангас, шулам, мам, ягчис, дагнис эрлэгүүдийн гарал үүсэл, дүр байдал, зэвсэг хэрэглэл, хот мандап, ид шидийн тухай Лхаарамба үг үсэг дараалан цээжлүүлж байлаа. Нэг санахад сонин үлгэр ч юм шиг, нөгөө санахад

толгой эргэм эмх замбараагүй олон ид шидтэн хорвоо дэлхийг эзэгнэж байгаа юм шиг санагдахаар сэтгэгдлийг Лхаарамба төрүүлж байлаа. Түүний ярих нь сонирхолтой боловч ухаарахад бэрх байлаа. Гэвч бяцхан өрөөнийхөө хананд бас адраас нь олон арван бурхдын хөрөг дүүжилсэн учир тэр зураг дээрээсээ биечлэн зааж өгдөг сайн талтай учраас Лхаарамба Гэндэнбалдан шавьдаа заасан номоо бүрэн ухааруулж салдаг хүн байжээ.

- Саяын миний хэлсэн ертөнцийн эзэн Махасуваар энэ байна! гэж Лхаарамба өрөөнийхөө адрын голоос дүүжлээстэй байгаа хөргийг заалаа. Умаа дивий гэдэг эмийг ярвайн тэвэрсэн улаан өнгийн догшин сүрлэг бурхны зураг байлаа. Тэр Махасуваар ажээ. Түүний эргэн тойронд нь олон бурхдын зураг байрлуулжээ.

- Эргэн тойрны бурхдын учрыг ярьсугай. Сүмбэр уулын дунд оршигч бол нас буян дэлгэрүүлэх жайв бөгөөд биеийн өнгө шар, эх игазадийролжигмаатай учирсан. Сүмбэр уулын зүүн хойно оршигч жайв болбоос биеийн өнгө цагаан, бас цагаан эхнэр чумаагаравтай учирсан. Замбуутивийн дунд оршигч Дагва бурхан бол биеийн өнгө хар, эх Дүйцмаатай учирсан... гэж Лхаарамба тайлбарлав. Тэдгээр догшин дүртэй бурхад тус бүрийг нэг нэгэн эмэгтэй хүнийг тэвэрсэн байдлаар зурсныг “эх чумаагаравтай эсвэл дүйцмаатай учирсан” гэж Лхаарамба тайлбарлахад Санж гайхжээ.

- Номыг үзэхэд эхэнд нь гайхах бус гүн учрыг ойлгон ухаарсны эцэст гайхваас зохино гэж Лхаарамба хэлснээ,

- Огторгуйгаас тэнгэр дөрөв, үнэр идэгч дусаан дөрөв гарч найман их оронг барьсан бөгөөд түүнийг дагинасын орон гэж алдаршууллаа гээд зураг дээрх найман янзын дүрсийг заалаа.

- Ягчим дөрөв, сэрэнбуу мангас дөрөв газар дээрээс гарч найман их оронг эзэлсэнг газар эзлэх орон гэх болжээ гэж цааш нь номлов. Санж цээжлэн дуугүй сууж байлаа. Лхаарамба,

- Дөрвөн их лус ба асар нар дөрөв газар дороос гарч найман их оронг эзэмдсэнийг газар доор эдлэх лусын орон гэж алдаршууллаа хэмээн номлоод лусын орны зургийг заалаа.

- Генирай буюу үүд завсрын дөрөв ба парайман гэх эм мам нийлж дүртэдийн буюу үхээрийн орон барьсан нь энэ гэж Лхаарамба зааснаар ертөнцийн бүхий л хувиарыг Санжид нэгтгэн ойлгууллаа гэж үзэв. Нэг бодоход сонин ч юм шиг, нэг бодоход шал дэмий ажээ.

Бурхдын буюу Тэнгэрийн орон, дагинасын орон, газар эдлэх орон лусын орон, үхээрийн орон гэж байдаг тэр бүхнийг эзэгнэсэн бурхад, дагинас, лус савдагтай хэмээн Санж ерөнхийд нь тодруулан тогтоож авчээ.

Ертөнцийг тэгж ангилан хуваасны дараа Лхаарамба тэдгээрийг эзэгнэсэн бурхад, дагинас, лус савдгийн тус бүрийн шинж төрхийг заахаар шийджээ. Лхаарамба тийнхүү догшин дүрт бурхдын гарт бариастай зүрх, бадар аягатай цус, мөн зураг дээр татсан хэцнээс унжуулан дүрсэлсэн хүний нүд, гар хөл зэрэг эрхтэнгүүдийг ямар учиртайг ярив.

- Өөрийгөө өмөөрөхийг таслахын тулд цул зүрхийг сугалан барьсан,

- Өмчлөх санааг хаахын тулд эрхтэн бүхнийг ил гаргаж татсан;

- Муу үйлийн авьяасыг таслахын тулд үе гишүүнийг хэсэглэн хэрчсэн;

- хүсэл тачаалыг дарахаар цус бүхнийг ууж;

- уурыг дарахаар яс бүхнийг тасалж идсэн учиртай билээ гэж Лхаарамба номлов. Зураг дээр мөн тэр мэт дүрсэлсэн тул Санж гэцэлд ойлгомжтой болжээ. Гагцхүү тэр олон бурхад, дагинас, ягчис мангас тэргүүтэн нь зураг дээр тодорхой байхаас, хүний нүдэнд биеэр үл үзэгдэх нь гайхаш төрүүлэв.

- Бурхад, ягчис, мангас тэргүүтэн эл олныг аливаа хүн нүдээр үздэг буюу? гэж Санж гэнэт асуучихжээ. Лхаарамба цочих шиг болсноо,

- Эдгээрийг үзэх ёстой нь үзэж болно. Үзэх буянгүй нь үл үзмой. Ер нь гаднаас харвал доторхи тодорхой. Дотроос харвал гаднах тодорхой. Зовлонг эдлэлгүй жаргалыг үл мэднэ. Бурханд сүжиглэхгүйгээр бурхныг үл үзнэ. Ертөнц өнгөрсөн болон үл өнгөрсөн зай завсарт оршмой гэж номлов. Санж үүний хариу хэлэх чадвар хүрсэнгүй тул дуугүй боллоо. Лхаарамба цааш нь үргэлжлүүлэн номлохдоо Санжийн ой тойнд дөхүүлэхийг эрмэлзсэн бололтой.

- Мунхагаас эцэг гарна. Тачаалаас эх гарна. Омгоос зэтгэрт үхэр буюу Тэгшламбуу төрнө. Атаанаас инээдэггүй хар буюу погвазүмид төрнө. Уураас илбэт могой буюу бүрэлжтумар гарна гэж багштан номлосон юм гэж айлдаад тэдгээрийг дүрсэлсэн зургийг зааж өгөв.

- Хүний хаан Тисрандизаан, лусын хаан Малдоосэжин хоёр тэмцэлдээд аль алинаа дийлж эс чадсан гэдэг юм. Тэгээд тэр хоёр,

Газар дээр хүний хаан чамаас ихгүй
Газар доор лусын хаан надаас ихгүйгээр нөхөрлөе

гэж Лусын хаан Малдоосэжин гуйж тохирсон юм гэдэг. Лусын хаан Малдоосэжин энэ байна гэж Лхаарамба утаанд идэгдсэн нэгэн хөргийг заалаа. Тэгээд тодорхойлон хэлсэн нь:

- Лусын хаан Малдоосэжинг Лагшингийн өнгө хар хөх, цээж тэнгэрт могойн толгойн цогнойн дүүлсэн, лагшингийн бөгс могойн сүүл цагирагласан хэлбэртэй, баруунд сэтгэлчлэн бүтээх зэндмэнь эрдэнэ, зүүнд дэнсэлгээг арилгах үхэлгүй аршаанаар дүүрсэн сангийн сайн хумх чимсэн, ээмэг, хоолойн чимэг, мутар бойвгын бугуйвч, бөгж, сугавчлуур, хоолойвч зэргээр бэндэрлэсэн, яргач, түшмэд, хатан, нөхөд сэлтээ дагуулсан, завсраар нь баавгай, дигваранз, мэлхий, могой, аалз, гүрвэл тэргүүтэн хамарсан ийм дүртэйгээр зурдаг юм.

Энд тэр бүхэн цөм цогцолжээ. Сайн харж ав гэж айлдав. Санж Лусын хааны тэрхүү аймшигтай эрээн дүр зургийг удтал гайхан ширтэв.

- Догшин дүртэй, гуа бусын янзтай байгаа биз! гэж гэнэт Лхаарамба асуухад Санж санаснаа нуулгүйгээр, - Айж бишүүрхмээр догшин дүртэй юм аа гэж хэлэв. Лхаарамба сэтгэл нийлсэн бололтой толгой дохиж,

- Гуа бусын дуртэй байдаг цөм учиртай. Бурхан шашны дайсан, буруу номтонг сүр хүчээр аюулгаж, зүрхийг үхүүлэхийн учир догшид бий болж, догшдын шүтээн гарчээ. Соёогоо ярзайснаар хортонг номхотгоно. Хөмсөг хөдөлгөн сэрвийлгэснээр цахилгаан эрх гялбуулна. Хилэнгээр бойвгоо дэвсвэл газар дэлхийг хөдөлгөнө. Шашныг өмгөөлөгч эдгээр догшин дүрт бурхдын насны хэмжээ нь галба нэг болно. Нэг галба дөрвөн мянга гурван зуу гаруй жил үргэлжилнэ. Шашин бол галба хагаст оршино гэж номлосон. Одоо дөнгөж хагас галав хүрэхгүй наслаад байна. Тэгэхлээр эдгээр гуа бусын дошгин дүртэй бурхад шашныг үеэ өнгөрөөснөөс хожим төрөл арилжих учиртай болно. Ер нь хилэнт аймгийн ноёд гуч байх боловч дагинас 32, ягчис эх ес, Авидарам гэх мам долоо, бадруулагч эх 8, дөрвөн эгч нарын хамт, Тэнгэр язгуурын элч бүгд 300 бий билээ. Тэд цөм л өөр өөрийн онцгой чанар, тэмдэгтэй, уншлага нарийн байх бөгөөд магадгүй огт давтагдахгүй ч байж болно гэж Лхаарамба номлов. Санж түүнийг идэвхийлэн ойлгохыг хичээж байлаа. Гэвч ойлгохуйяа бэрх юм олон тохиолдлоо.

- Орчлон гаслангаас нөхцөгсдөд алагдана
Зовлон их амгаланд алагдана
Амьтан бүгд сэтгэлд алагдана
Үзэгдэл сансрын номууд сэтгэлд алагдана

гэж Лхаарамба сургамжлав. Үүнийг Санж төдий л ойлгож чадсангүй.

- Орчлон яагаад гаслангаас нөхцөгсдөд алагддаг юм бэ? гэж Санж асуув. Лхаарамба ийм асуултад их дуртай.

- Орчлонг дийлье гэвэл өөрөө нөгцвөөс сэтгэлд тэр орчлон үгүй болж тэр нь орчлон ялагдсан лугаа адил. Тэрчлэн зовлонг мартаж сэтгэлийн их амгаланд орж чадваас зовлон өөрөө алагдан үгүй болсны агаар нэгэн буй! гэж Лхаарамба тайлбарлахад Санж бага зэрэг гадарлав.

- Чи харагтун. Энд зургаан ёсны итгэлт бурхны дүр байна. Үүнд хутагт ёсны итгэлтийг харагтун. Ёзоорийн нүүр хилэнтэй, хар хөх өнгөтэй, баруун нь цагаан зааны нүүртэй, зүүн нь улаан усны үхрийн нүүртэй, арынх нь хар арслан нүүртэй, зургаан мутрын баруунд бөхтөр хутга, бэрээ, сүх, зүүн гуравт гавал, үхрийн шир, цалам барьсан, бойвгоо алцайж оршсон, нууц эхтэй нөхцөлдсөн ийм дүр ёсоор үзүүлжээ гэж Лхаарамба яриад дөрвөн нүүртэй, зургаан гартаа тус бүр бэрээ, сүх зэрэг дээр тоочсоныг барьж хоёр гараар нэгэн жижиг биет эм төрөлтнийг тэвэрсэн догшин дүрт бурхныг заалаа. Тэгээд Лхаарамба,

- Үүний зүс царай, хэв маягийг чи үнэмшихгүй байж болно. Гэвч ийм хутагт ёсны итгэлт бурхан бий хэмээн бат итгэвээс чиний үл итгэхийн мухар моншин сэтгэл алдагдана гэж сургав.

Лхаарамбын заасан зураг дээр “Бясалгах цагийн итгэлт”, “Бүтээлийн цагийн итгэлт”, “Сандуйн итгэлт”, “Адис буулгах итгэлт”, “Дэгжиж хөгжих үйлийн итгэлт”, “Хутагт ёсны итгэлт” гэсэн зургаан бурхдын зураг цөм л олон толгой, олон гартай, гар болгондоо янз бүрийн юм барьснаар дүрслэгджээ.

- Бурхдын барьсан юм болгон учиртай. Гол төлөв хадуур, хорын тулам, бэрээ, дадар, илд, гөвүүр, хэв бүс, хөгнө, чөдөр, хутга, гавал, цалам, толь, гох сүх, хадамгай, төмөр хуурай, үхрийн шир, бадар аяга, жад, дамар хонх, цэцэг, бургас тэргүүтэн байна. Тэр бүхнийг шашны дайсан элдэв муу үйлийг егүүтгэн цэвэрлэхэд хэрэглэдэг болно. Иймд бие биетэй нь андууран хутгавал нүгэл алдас. Тэгээд сайн тогтоохыг хичээгтүн гэж Лхаарамба айлдан номлов.

- Орчлон хорвоод бурхан болоод дошгид эсвэл ягчис болон эрлэг оршоогүй газар байна уу? гэж Санж гэнэт сониучлан багшаасаа асуучихсан чинь Лхаарамба үл ялиг инээмсэглэж,

- Би түрүүн номлоо биз дээ? Ертөнц өнгөрсөн ба үл өнгөрсөн зай завсарт оршино гэж номтой юм. Тэр зуурт эзэнгүй юм гэж үгүй. Бас эзэнтэй юм гэж үгүй. Сайныг үйлдэгч, авран нигүүлсэгч байхад саарыг үйлдэн хөнөөн идэгч бас буй. Үүнд титэмлэсэн таван дээд бурхад байхад зүхлэг хатуу таринын арван бурхад бас бий. Тэдний нэгэн болох дүдгойживарангар шулам бол ямагт зүхлэг орхиж байдаг. Зүхлэгийн үг нь: "Чиний бие хар өнгөтэй болог. Хоолонд хүний мах, морины мах идэг! Чиний хувцаст хүний арьс өмсөгтүн" гэж байдаг юм. За энэ тухайд би чамд дараа тодорхой номлоно. Өнөөдөр гарч жаахан салхи амсая хоёулаа гэв. Санж гарахаар завдах зуур тэсэлгүй бас нэг асуумаар юм гарсныг асуув.

- Багш аа, энэ олон бурхад өөр хоорондоо ялгарахад нэн бэрх бус уу? гэж бараг цөм ижил шахам зурсан бурхдын зургийг заажээ.

- Ерөнхий төрх ойролцоо боловч цөм ялгагдана. Ялгах билгийн нүд хэрэгтэй. Би чамд түрүүн хэлсэн. Мутартаа болгоон барьсан зүйл өөр өөр гэж. Тэрчлэн бас уналгад хэрэглэдэг зүйлээрээ ялгагдана. Жишээ нь энэ их цастангийн эх Доржодвормаа уналгад үймэрсэн хар салхи хөлгөлсөн байна. Цогт тэнгэр уул гэгч Доржямаажан бол халзан морь хөлөглөсөн, өлзийт урт наст огторгуйн эм Доржгүндэгмаа бол луу хөлөглөсөн. Ганманзэрээ мам бол цагаан арслан унасан. Банмандэшрээ бол хулан унасан гэх мэтээр өөр өөр уналга хэрэглэсэн нь хөрөг дээр тодорхой зурагджээ. Үүгээр нь бас танин ялгаж болно. Ер нь догшид гол төлөв уналгад хэрэглэдэг зүйл гэвэл: цоохор барс, цагаан буга, арслан, жороо луус, гарьд, цагаан амт морь, өсгий цагаан хүн гөрөөс буюу махээн, зурвас цагаан халзан галуу, хар гахай, цоохор амтай шар шувуу, зүрх цагаан баавгай, чоно, нохой, цөөвөр, оронго сахлаг, цагаан үүл, хар салхи, есөн толгойт яст мэлхий, эрээн тарлан усны үхэр зэрэг болно. Эдгээрийг давтан гарахад хүрвэл бэлэгдэл сайтай өнгөөр өөр өөрсдөөс нь ялгана гэж Лхаарамба ярих

зуур орхимжоо нөмрөөд,

- Өнөөдөр их бүгчим өдөр байна. Хоёул гадагш гарч түр яваад ирье. Салхи хөлөглөн явна даа гэж Санжид хандан гараа сарвайв. Санж түүний өөхлөг пимбэгэр сарвуунаас атган авч сугадан түшсээр шүтээнийх нь өрөөнөөс гаргалаа.

Гадаа тунгалаг сайхан өдөр байв. Лхаарамба агаар ховдгоор амьсгалж,

- Сайхан өдөр байна. Хоёулаа Лхас зуу хүртэл алхаад буцаж ирье гэв. Санжид тэр тун аятайхан санал санагдлаа.

Гудамжаар буман хүн бужигнаж байлаа. Лхаарамба амныхаа хаалтыг доош унжуулан, салхинд алдахгүйгээр бэхлүүлэв. Ангайсан ам руу нь ялаа шумуул орж нүгэл үүсэхээс тэр мөн л бусдын адил болгоомжилсон ажээ. Лхаарамбын алхаа нь удаан намбалаг тул Санж түүнтэй хөл нийлэхгүй тэвдэж байлаа. Тэгтэл гудамжаар яваа олны дундаас эмэгтэй хүний дуу гарч “Санж, Санжаа!” гэх шиг болов. Санж эхлээд чихэндээ итгэсэнгүй. Гагцхүү “Лхаарамбын алхаанд хөлөө тааруулахыг эрмэлзэж доош харж явлаа. Тэгтэл дахиад л “Санжаа, Санжаа!” гэж эмэгтэй хүн дуудав. Арга буюу толгойгоо өндийлгөн ажвал гудамжны нөгөө талаар цувж яваа мөргөлчин олны дундаас нэгэн халх эмэгтэй гараа гозолзуулан Санжийг даллаж байгаа харагдав. Отгон ажээ. “Отгон байна. Тэр хэзээ эргээд ирээв? Юун хэргээр ирсэн юм брл? Аав, ээжээс сураг авчраа болов уу?” гэж Санж гэнэт бодлоо. Гэвч Лхаарамба тэр байдлыг тоохгүйгээр урагшаа алхсаар бүлгээ. Санж арга олж,

- Манайх хуучиндаа. Тэнд очоод хүлээж бай. Би одоохон эргэж ирнэ! гэж монголоор хашгирлаа. Отгон түүнийг ойлгосон бололтой. Олны дунд зогсон хоцорлоо.

Тэгснээ Санж тэр хоёр руу гүйн очихыг завдахад нь Санж битгий гэсэн дохиог гараараа өгч болиулав. Лхаарамба юу ч болоогүй мэт урагшаа харан зугуун алхаагаар явж байлаа. “Отгон ирдэг нь сайн

боллоо. Аав, ээжийнхээ тухай асууж авдаг хэрэг. Лхаарамбаас яаж түргэн салах билээ. За яахав. Удахгүй ядраад буцах байхаа” гэж Санж догдлон бодлоо.

Лхаарамба хэсэг зуур дуугүй явж байснаа гэнэт ам нээж,

- Сая чи нэг эм хүнтэй үг солив уу? гэж асуулаа. Санж түгдэрснээ,

- Тиймээ. Манай нутгийн нэг ядуу мөргөлчин иржээ. Түүнээс аав ээжийнхээ сургийг гаргахсан гэж бодож байна! гэж үнэнээ хэлэв. Лхаарамба хариу юу ч ярихгүй хэсэг явснаа,

- Билгийн их халуун очоор асар атгагын зөөлөн хур буухыг ална! гэж түрүүн зааж байсан номноосоо айлдав.

Чухам юуны тухай хэлж байгааг Санж дор нь ойлгон авч царай нь час улайж, ичингүйрэв. “Багштан миний тухай буруугаар ухааравзай. Сахил санваарыг эвдэх юм уу тангараг буурагч гэж бодуузай” хэмээн айн болгоомжлов.

- Шагшаабадыг авахад хялбар бөгөөд сахихад бэрх гэдгийг чи сайн тогтоож авсан биз! гэж Лхаарамба мөн л эргэж харалгүй асуулаа. Ёгт утгаар ярьж байгааг нь ойлгов.

- Тиймээ. Багштан минь. Шагшаабадыг хатуу сахих тангарагаас буурахгүйг хичээж явна гэж Санж өчлөг өгчээ.

- Нийгүүлсэхийн балын хур бууснаар сүсгийн их газрыг машид чийглэнэ гэж Лхаарамба шүлэглэн хэлээд дуугүй болжээ. Энэ удаа өршөөн нийгүүлсэе гэсэн далд утга гэж ойлгоод Санж гэцэл сэтгэлээр түр амсхийлээ.

Лхаарамба сэрүүцэн зугаалж хэсэг яваад хөл нь цуцахын үест буцах болов. Санж түүний аяыг дагалдаж хойно өмнө нь орон долгинож явлаа. Гэвч сэтгэлдээ Отгоны тухай бодож байв. “Тэр яасан хурдан

буцаж ирээ вэ? Дахиад л Лхас зууд мөргөл үйлдэхээр ирсэн хэрэг байх даа? Нөгөөх Бөхмагнай хайчсан бол? Ээж, аав, дүү нарын тухайд Отгоноос тодорхой дуулж авна даа!” гэж Санж гэгцэл бодохоос Лхаарамба Гэндэнбалдангаас шалав түргэн салахыг мөрөөдөв. Тэгтэл Лхаарамба огт ярахгүй байлаа.

- Одоо хоёулаа номоо бас жаахан үзнэ. Тэгээд чи надад хоол хийлгэж туслана биз. Оройтвол манайд хоноод өглөө бас номоо өлөн элгэн дээрээ уншина биз! гэж Лхаарамба аажим зугуунаар хэлэхэд нь Санж гэгцлийн дотор харанхуйлах мэт болов. Гэвч лам багшийн үгийг сөрөх нь битгий хэл дургүйцэж бодох нь ч хүртэл нүгэл гэж тэр болгоомжлов.

Гэр орноо, нутгаа их мөрөөдөж байдгаа яг л ийм үед ухаардаг ажээ. Нутгаас нь ирсэн хүний сураг гармагц очиж уулзах, эх эцгээ асуух, ер нь юу болж байгааг мэдэхийг онцгой их хүснэ. Тэр тусмаа ойрхон таних болсон Отгон хүүхэн ирж гэхээр Санж гэгцлийн сэтгэл их л тогтворгүй болж шалавхан уулзахын мөрөөдөлд эзлэгдлээ. Отгон хүүхэн Санж гэгцлийн таних цорын ганц ойролцоо насны бүсгүй хүн байлаа. Алс холын замыг туулах хамтын аяны тэр өдрүүдэд Санж гэгцэл түүнд тус хүргэхийг мэрийн явсан цаг бий. Хөх тооны даваанд түүнийг морин дээрээ дүүрч даваа давуулах хүртэл богинохон хугацаанд уй гашуугаар дүүрэн цээжийг нь тэврэн тайтгаруулж байсан тэр л зураг залуу гэгцлийн санаанаас гардаггүй юм. Гэвч энэ нь номын мөр хөөж, сахилаа сахисан гэгцэл хүний санааг огтхон урвуулаагүй зүгээр л яагаад ч юм бэ үе үе боддог байлаа.

Арван ес. Олон хаалгат суварга

Газар үндсээр баян
Тэнгэр одоор баян
Далай усаар баян

Бурхны шавийн бүрэн өмсгөлтэй Санж гэцэл хувцсандаа үүртэж халууцсаар хашааныхаа гадаа хүрч ирлээ. Дөрвөлжин улаан цэмбээр хийсэн чавирын сав нь хоёр тийш далбалзаж, долоон тохой орхимж нь савсалзан, шар ямбуун банзал нь хөлд орооцолдон, шанам малгай нь данхагнаж ер хурдан явахад төвөгтэй байлаа. Санж нутгийн сониныг сонсохоор тэгж их яарчээ. Тэрнийг амьсгаадаж, хөлс дааварлуулан орж ирэхэд рунханд нь Бэрээмэг эмгэн, Отгон хоёр аль хэдийний тухалж аваад дэвэн дэлхийн юм ярьж, намхан ширээн дээр зампортой замбайн гурил тавьчихсан, зэс домботой хар цайнаас гурил даруулан дуу чимээтэй сорон ууцгааж байлаа.

Цог улайлгах мэпор гэдэг шавар саван дотор хар модны цог улалзан байлаа. Түүн дээр гуулин хогди гэдэг данх тавиастай байв. Отгон хүүхэн өндөсхийж Санжтай мэндлэв.

- Хэзээ буцаад ирчихээ вэ? гэж Санж явуут асуухад,

- Саяхан ирж гэнээ. Бас л дахиад л эргэл мөргөлөөр яваа гэнэ. Үгүй ер нь мөргөл залбирлаар өчнөөн дахин хөл болох хэрэг байна уу? гэж Отгоны өмнөөс Бэрээмэг эмгэн хариулав.

Санж сонссон боловч сонсоогүй мэтээр шууд л симхан руугаа орж, шанам малгай, чавир тэргүүтнээ авч, хувцсаа хөнгөлөөд эргэн гарч ирэв. Нутгийн сонин сонсохыг яарчээ.

- Хэрэг зориг юутай вэ? Манай муу ээж, аав, дүү нар ямаршуу байна

даа? гэж Санж шалгаан асуухад Отгон,

- Ээж, аав, дүү нар чинь сайн. Зүүн ууланд, Шар дэвсэгт байгаа. Чамайг бурхны оронд очиж шавилан суусныг сонсоод амьд явж, үр төрүүлсний хэрэг бүтлээ гэцгээж тун их баярлацгааж байна билээ. Тэгээд улам л сайн хичээж эрдэмтэй сайн лам болоод эргэж ирээрэй гэж дахин дахин захиж байна лээ гэж ярихад Санжийн сэтгэл уужирч,

- Уухай, тэгээд... гэж цааш нь ярихыг шаардав. Отгон,

- Хол газар юугаа ч өгч явуулах юм билээ дээ гэж ээж, аав хоёр чинь ярьж ярьж байгаад хэдэн соном хадаг, нэг мөнгөн ембүү явуулсан. Май энэ байна! гэж хэлээд чисчүүний өөдсөнд боочихсон юмыг Санжид өглөө.

- Тэд нар над юм явуулж яах нь вэ дээ? Өөрснөө ядаж байж! гэж Санж хэлээд эцэг эхээс ирүүлсэн юмыг хүндэтгэн хоёр гардаж авлаа.

- Би өөрөө яахав дээ! Буцаад л ирлээ гээд Отгон дуугүй болов.

- Ямар хэргээр? гэж Санж лавлахад,

- Үрийн хутаг горьдож яваа гэнээ. Тээр жил Лхас зуугийн хамаг л нандин шүтээн бүрийд мөргөөд буцсан. Үр хүүхэд заяана л гэж итгэж. Тэгсэн бас л бүтдэггүй гэнээ. Лам багш нь дахиж Лхас зуу Утай Гүмбум орж ир гэж хэлсэн юм байх. Олон хаалгат суварганд очиж мөргөөд ир. Тэгвэл хүүхэд заяана гэсэн гэнээ. За тэр ч юу л бол гэж Бэрээмэг эмгэн хариу хэлэхэд Отгоны царай улсхийлээ.

- Олон хаалгат суварга гэж хаа байдаг юм болоо? хэмээн Санж гайхав. Тэр мэдэхгүй байдаг нь аргагүй.

- Яагаав дээ. Сахьяагийн хийд орох замд Жанцээ хийдэд Чодэнгоман гэдэг өндөр суварга байдаг. Түүнийг л олон хаалгат суварга гэдэг юм байхчив лээ гэж Бэрээмэг эмгэн тоомсоргүй ярив.

Бэрээмэг эмгэн бага залуудаа мөн л энэхүү Отгоны адил Түвдийн олон хотыг хэсүүчлэн мөргөл хийж, духаа цоортол бурханд мөргөж, улаа элэгдтэл гороо хийсэн болохоор хаана юу байдгийг андахгүй мэддэг байжээ. Тэр бүхнээс ямар үр ашиг гарсныг ч сайн мэдэж байгаа ажээ.

- Ганцаараа ирэв үү? Өөр хүнтэй хамтарсан уу? гэж Санж Отгоноос асуув.

- Өнөөх Бөхмагнай бид хоёр эндээс буцахдаа дэр нийлүүлж өрх гэр болсон юм. Нутагтаа очоод гэр орноо тохижуулж тэрүүхэндээ аятайхан л амьдарч байлаа. Үртэй болохын хүслэн болж жил гаруй хүлээлээ. Хүүхэд олдсонгүй. Дахиад л лам багшаас ном нээлгэж, шоо орхиулж үзлээ. Утай, Лхас орж олон хаалгат суварганд мөргөж тэрнээс өчүүхэн үрдэс ч юмуу хэлтэрхий олж ав гэж лам багш айлдсан. Тэр ёсоор л Бөхмагнай бид хоёр дахин наашаа гарсан юм. Аян зам өлзийтэй сайхан байлаа. Уушийн даваанд газрын сүрд дарагдаж, хамраас цус гарч жаахан ядарсан... гэж Отгоныг ярьж байтал Бэрээмэг эмгэн үгийг нь таслаад,

- Хээ, газрын сүрд дарагдахыг мэдсээр байж, сайн бэлтгэхгүй дээ. Уушийн давааны цаана долоо хоног тухалж, махны төрлийн юм амсалгүй байж бэлтгэхгүй бол газрын сүрд дарагдаж, аягүйдвэл үхэж ч мэднэ. Болчимгүй юм хийж дээ! гэв. Санж,

- Тэгээд Бөхмагнай гуай хайчсан хэрэг вэ? гэж гайхан асуулаа.

- Бөхмагнай юу?... гэснээ Отгоны сэтгэл нь хямралдаж дуугүй хэсэг суугаад,

- Уушийн даваа даваад наашаа явж байтал дээрэмчингүүдтэй тааралдаад манай тэр галынхан юу ч үгүй болтлоо тонуулсан. Бөхмагнай бид хоёроос гадна Цагаан голын хэдэн мөргөлчин хамт явцгааж байсан юм. Дээрэмчингүүд бидний аль олигтойг мулзалж

аваад хоёр гурван хүнээ алуулж, оронд нь Бөхмагнайг Цагаан голынхны галын ахлагч Дарамзагд гуайн хамтаар олзолж аваад уул дамжин алга болсон. Бид хэд ядуу дорой эмэгтэйчүүд, хүүхдүүд зам мөрөөрөө гэлдрэн явсаар арайхийж Лхас зууд орж ирлээ. Бөхмагнай тэр хоёрыг суллагдаад хойноос гүйцэж ирэх байх гэж горьдсоор байлаа. Гэтэл ирсэнгүй. Одоо тэд хаана зовж явдаг бол... гэж Отгон хэлээд мэгшин уйлав.

- Уйлаад яахав вэ? Овсгоотой эр бол хүрээд л ирнэ гэж Бэрээмэг эмгэн Отгоны мөрийг илбэн тайтгаруулах гэж оролдов. Отгон удтал тайтгарсангүй.

- Бурхны орон гэж байх. Тэгээд мөргөлчин ядуусыг зүгээр өнгөрүүлэхгүй тонож дээрэмдэж үргэлж нүгэл хийж байх юм, энэ түвдүүд. Өөдлөхгүй улс байх аа, зайлуул! гэж Бэрээмэг эмгэн сэтгэл гансран өгүүлж, шүүрс алдпаа.

- Эрхбиш нэг арга олж дээрэмчний гараас салаад ирэх байхаа, Бөхмагнай гуай! гэж Санж тэднийг тайвшруулахыг оролдлоо.

“Дахиад л үрийн хутаг олохын мөрөөдөл болж энэ урт хэцүү замыг туулан хүрч иржээ. Одоо тэгээд олон хаалгат Чодэнгомман суварганд мөргөөд нэмэр болох юм болов уу даа! Мөн ч хэцүү юмаа даа” гэж Санж гэцэл тэрний тухай бодож байтал тааж мэдсэн юм шиг санаагий нь Бэрээмэг эмгэн өлгөн аваад,

- Олон газар тэнэж элдэв дээдийн юманд мөргөл залбирч зовж явсан дорвол нутагтаа рашаан ууж хэдэн жил биеэ сувилсан нь дээргүй- юу дээ? Биеийн тамир тэнхээ сайжирвал залуу хүн аяндаа л үрийн хутаг олно шүү дээ. Уст Чацрангийн эхэнд хүртэл сайхан хүйтэн аршаан байдаг юм чинь! гэж ярив. Санж бас л энэ үгийг бодож байсан тул санал нийлжээ.

- Тантун жалбоо гэж нэг хаан эхийнхээ гэдсэнд жаран жил байгаад дараа нь төрсөн юм гэдэг. Тэр нэгэнт жаран жил эхийн гэдсэнд байсан

болохоор буурал үстэй төрсөн юм гэнэлээ. Тэгтэл удаан тээсэн эхийнхээ ачийг хариулах гэж Тантун жалбоо олон тооны гүүр, суварга бариулсан юм байна билээ. Тэгэхээр үр хүүхэдтэй болох ч заяа нь бүрдвэл хэзээ ч болзошгүй юмдаа гэж Санж урьд багшийнхаа ярьж байсан нэгэн домог мэт юмыг хэлэв. Бэрээмэг түүнд дургүй нь хүрсэн бололтой,

- Хээ цэс! Хэзээ жаран жилийн дараа үртэй болно, тэр маань буурал өвгөн төрнө гээд балайран хүлээж суух юм бэ? Дэмий хэрэг. Тэрэн тухай бүү бод. Харин нэгэнт ирсэн юм яая гэх вэ, тэр олон хаалгат суваргандаа очиж мөргөөд буц. Дахин хэний ч үгэнд толгойгоо битгий мэдүүлж бай! Үртэй болно гэдэг ламын хэрэг биш гэж шаардлаа. Бэрээмэг эмгэн хурц гашуун үгтэй боловч хал үзэж, халуун чулуу долоосон болохоор хар ухаантай гэдэгт Санж итгэж байлаа. Санжийн амийг жор мэддэг лам багш нар нь биш харин зовлон үзсэн энэ чавганц л аварсныг яаж мартаж билээ. "Одоо Бөхмагнай гуай ирэхгүй бол би л газарчилж Жанцээ хийдэд хүргэж зорьсон суварганд нь мөргүүлэхээс биш дээ. Өөр яах вэ? гэж Санж бодлоо. Чодэнгамон буюу олон хаалгат суварга байдаг тэрхүү Жанцээ хийдэд Будда бурхны номлолын төрөл бүрийн ёс сахигчид нэгэн дор аж төрж, номлол юугаа дэлгэрүүлж байдгаараа их онцлог газар байлаа. Сахия, гэлэгбаа, нянмаа, каарма гээд л аливаа сүжигтэн алаглан аж төрдөг тэр бяцхан хийдийн Чодэнгамон суварга буддын ертөнцөд их алдаршчээ. Таван давхар тэр суварга олон хаалгатай юм. Давхар бүрд хорин хаалга буй. Бүгд нийлээд зуун хаалгатай боловч маанийн эрхний тоогоор зуун найман хаалгатай гэж шүтлэгтэн олноор итгэжээ. Зуун найман хаалгат тэр суварганд хэрвээ хаалга бүрээр орж гарах гэвэл нэлээн цаг зарах хэрэгтэй байдаг аж. Гэвч ганцхүү түүнд сүжиглэж ирсэн хүнд бол санааны л ажил байлаа. Хаалга бүрээр орж гарч явсаар цаг өнгөрөх, ядарч зүдрэхийг мартдаг байжээ.

- Бөхмагнай гуайг ирэхгүй бол би л таныг газарчилж олон хаалгат суварганд мөргөл хийлгэж ирэхээс дээ! гэж Санж бодож байсан зүйлээ хэлэв. Отгон түүнд баярлах мэт болсон боловч басхүү гуниг төржээ. Бөхмагнайг ирэхгүй бол гэж муу юм зөгнөн хэлсэнд түүний

дургүй хүрчээ. Үнэхээр Бөхмагнайн байдал хүнд болсныг хэн ч мэдсэнгүй. Тэднийг зэрлэг омог голоогууд олзлон авч уулын хавцалд аваачжээ. Уулын дээрэмчид сарлагийн савгаар нэхсэн хар бүрээстэй банагт сууцгаах бөгөөд нүд ирмэх зуур ачаалан хандсан зүгтээ талийж өгдөг заншилтай хээрийн зэрлэг тэнүүлчин отог ажээ. Тэд Түвдийн өндөр уулс дамжин хэсүүчилж их зам тосон дээрэм хийж, гагцхүү тийм аргаар амьдардаг улс байлаа. Хамгийн их олзтой зам нь Халх Монголоос ирдэг мөргөлчдийнх билээ. Гол төлөв гар хоосон, ядуу зүдүү сүжиг бишрэл ихтэй монголчуудыг тэд тоносоор байгаад амтшиж гүйцжээ. Гэхдээ эд хогшлыг нь голчлон дээрэмдэхээс биш. Хүний амь бусниулахыг нэг их хичээдэггүй байжээ. Энэ удаа тэд эд хогшлоос гадна хүн олзолж авах зорилготой байсан нь гай болж Дарамзагд, Бөхмагнай хоёрын галтай тохиолдож тэд олзлогдсон юмсанжээ. Голоогийн тэр дээрэмчдийн зэгц нь хэдэн сарын өмнө баригдаж Лхас зууд хүргэгдсэн байжээ. Тэр дээрэмчин нэгэн удаа шөнийн цагаар андуурч Түвдийн нэгэн их хэргэм ямбатан түшмэлийнхэнд халдаж орхиод баригдсан байжээ. Лхас зуугийн газар шоронд түүнийг хаяжээ. Өчиггүйгэр дигваранзанд идүүлэх ял заахаар яриа гарсан байлаа. Өлсгөлөн дигваранз, хилэнцэт хорхойгоор дүүрэн харанхуй нүх рүү нүцгэлээд шидэж орхивол хэдхэн хормын дараа тэдгээр хорхойд баригдаж үхнэ гэдгийг дээрэмчний ахлагч сайн мэдэж асар их айж байжээ. Өөрийнхөө дээрэмчин хар толгойг аврах арга хайж элдвээр оролдсоор байтал нь золиос авч түүнийг суллах яриа гарчээ. Идэр чийрэг таван эр дайчлан, өөрийнхөө золиосонд тушаавал түүнийг чөлөөлөх болно гэж хэрэг шийтгэгч түшмэл айлджээ.

Лхас хотын захиргаа Ланцыса хүчээр цэрэг элсүүлэх зорилготой байсан учир эхлээд тийм цуу яриа дэгдээжээ. Мөнөөхөн цуурхал нэлээд газар авмагц Ланцысагийн шоронд янз бүрийн аргаар баяжиж хөлжсөн хамжлагын эзэд, чинээлэгхэн түшмэдүүд, дээрэмчин, луйварчны багийн гоцлогч нарыг үл ялих шалтгаанаар баривчлан хийж, тэднийг айлган сүрдүүлэх мэх хэрэглэх болжээ.

Гучин жингийн хүнд чулуун малгайг ялтны толгойд өмсгөөд төмөр

алхаар орой дээр нь тоншиход уул хүний хоёр нүд бүлт үсрэн хацар руу нь унждаг тийм нэг муухай гамлагааг Ланцысагийн яргачид бодож олжээ. Түүнийгээ шоронгийн хоригдлуудад үзүүлж тэдэнд айдас хүйдэс төрүүлж байлаа. Хамжлагын эзэд, чинээлэг түшмэдүүд, луйварчдын толгойлогч нарын өмнө тэр эрүү шүүлтээ үзүүлэн далайлгахын далимд тэднээс золиосны хүн гаргуулах шаардлага тавьсаар байлаа. Уушийн даваа хавиар хөллөдөг голоогийн дээрэмчдийн толгойлогч Дэнзэн тэрнээс муухай юм олныг үзэж өнгөрүүлсэн нүгэлт толгой болохоороо ер тоохгүй байв. Түүнээс бусад хоригдлууд цөм л зүрх үхэж, өөр өөрийн хамжлага, зарц хараат нараас нэг хоёр хүн золиослон гаргаж өгөх ам өчиг алдацгаасаар байжээ. Бараг хамгийн сүүлд өчиг өгөлгүй үлдэхэд нь Дэнзэнд хатуу юм үзүүлэхээр Ланцысагийн яргачид эрс шийджээ. Тэгээд Дэнзэнгийн хамт зүтгэгч нэгэн зөнөг хөгшин дээрэмчнийг өмнө нь туун авчраад мөнөөхөн чулуун малгайг өмсгөж төмөр алхаар орой дээрээс хүчтэй цохиж нүдийг бүлтлээд доош унжсан хоёр нүдийг тус бүрд нь огтлон авч Дэнзэнгийн өмнө тавьжээ. Дэнзэн түүнд цочин гайхах, айх хоёр нь зэрэгцэж ирсэн боловч биеэ барьж бас л өчиг өгсөнгүй. Тэгэхээр нь яргачид нялуунаасаа шулуундаа шилжиж,

- Тэгвэл Дэнзэн чамд бас ийм ял оногооно доо! Хэлэх захих юм байвал энэ сохортоо захих биз! гэж заналхийлжээ.

Дэнзэн үүнээс цочин айж,

- За яахав би өнөө шөнөдөө бодьё! гэжээ.

Тэр шөнөдөө бодоод бодоод бодын шийр дөрөв гэгчээр хоёрхон замаас өөр юм сүвэгчилж чадсангүй. Нэг бол нүдгүй болох, эсвэл золиосонд хүн өгөхөөр өчиг алдах энэ хоёроос өөр арга байсангүй. Өглөө нь тэр өөрийн харьяатаас хоёр хүн золиосонд өгөх ам гарчээ. Тэр тухайгаа харьяат хүмүүстээ мэдээ явуулахдаа “Болж өгвөл мөргөлчдөөс олзлоод Хөх нуурын өөлдүүд гэсэн нэрээр золиосонд гаргаарай” хэмээн сэм захижээ.

- Би ч харьяат хамсаатан ховортой хүн. Гол төлөв Хөх нуурын монголчууд, Ховог сайрын торгуудаас сайн сэтгэлээрээ надтай нийлсэн хэд гурван зарц барлагтай хүн. Түүнээсээ л хоёрыг золиосонд өгөхөөс биш гэж Дэнзэн ам гарчээ.

Ам гарсан тэр хоёр хүний нь тоог бөглөхөөр Дэнзэнгийн дээрэмчид Уушийн даваагаар хэрэн хэсэн явж байгаад Халх газраас ирж буй Дарамзагдын гал руу дайрч хоёр хүн олзолж авчирсаны нэг нь Бөхмагнай байлаа.

Дэнзэнг гавлаж сарлагийн нуруунд хүлж дагуулан явсаар Данцысагийн зандалчид Уушийн давааны сархиагт очиж золиосны хүнээ авахаар шаарджээ. Золионы хүн болгож Дарамзагд, Бөхмагнай хоёрын толгойг хар таараар битүүлэн боогоод зандалчдад тушаажээ.

- Харваас нас бие тэнцэх улс байна. Авч явахаас даа! гэж тэд зөвшөөрөөд Дэнзэнг суллажээ. Замын зуур золиосны хүмүүсийг цагдаа нар огт хайрлахгүйгээр барахгүй, хоол унд ч өгөхгүй, нүүрийг бүтээсэн таарыг ч авахгүй, сарлагийн хурдаар шилбүүрдэн хөөсөөр явахад Бөхмагнайн уур хүрч,

- Та нар ер нь юу гээд алчих шахаад байгаа юм бэ? Биднийг хааш нь авч явна вэ? гэж хашгирав.

- Үгүй энэ чинь Түвд хүн биш байна аа янз нь! Юу гээд хашгираад байгаа юм бэ? гэж цагдаагийн нэг нь тэвдэн асуулаа. Тэгтэл нөгөө нь тайвнаар,

- Битгий гайх! Дэнзэнгийн хань хамсаатан дотор янз бүрийн амьтас байдаг юм гэсэн. Эд нар бодвол хасаг, монгол, балба, чантуугийн л нэг биз. Дуугай л хөөж аваачаад Ланцысад тушаая. Бүү эргэлз гэж сургамжлав. Нөгөө нь,

- Аа, за тэгвэл яахав. Нээрээ ч дээрэмчдийн бүлэгт юу эс нийлэх вэ гэжээ.

Бөхмагнай, Дарамзагд хоёр түвд хэл мэдэхгүй болохоор тэдний яриаг ойлгосонгүй, хий дэмий л бачимдан уурлаж,

- Тавиачээ, та нар биднийг! Тавиач! Цусаар урсмаруудаа! гэж Бөхмагнай хашгирч байлаа. Түүний үгийг хэн ч тросонгүй.

Ланцысад Бөхмагнай, Дарамзагд хоёрыг тушаажээ. Толгойн боолтыг аваад түвд хүн биш гэдгийг нь Ланцысагийн түшмэдүүд даруй мэдсэн боловч,

- Дэнзэнгийн дээрэмчдэд Хөх нуурын монголчууд байдаг гэсэн биз дээ. Тэднээсээ л золиосонд өгч орхиж л дээ! гэж нэг түшмэл сануулсанд цөм үнэмшив.

- Одоо эднийг шоронд хий. Тэнд хэд хоног өлсгөж омгий нь номхотгохгүй бол эд нар цэрэгт явахгүй нь лав. Өлсөөд ирэхээрээ аргагүй л омог, уураа барж цэрэгт явахаар өөрөө гуйна гэж ахлах түшмэл зарлиг буулгажээ.

Бөхмагнай, Дарамзагд хоёрыг харанхуй хар шоронд хаяжээ. Тэгээд хэд хоног таг мартаж орхисон билээ. Бөхмагнай галзуурсан илжиг мэт орилон хашгирч шоронгийн хаалгыг өшигчихөд цагдаа нар сая л тэднийг хорьсноо санаж байцаахаар болжээ. Гэвч түвд хүн биш байх тул Халх мицанаас хэлмэрч олохоос нааш байцаахгүй гэж дахин шоронд нь буцаажээ.

Бөхмагнай байдал иймд хүрсэн гэдгийг Отгон яаж мэдэх билээ. Хэд хоног дэмий л хүлээж шаналсны эцэст зорьж ирсэн олон хаалгат суваргын зүг явахаар шулуудлаа. Нутаг буцах цаг оройтвол өвлийн хүйтэн улирал ирж, цаст Уушийн давааг гэтлэн давж чадахгүй. Түвд газар өвөлжихөөс аргагүйд хүрэх тул Отгон тийнхүү яарчээ. Яардаг нь аргагүй учиртай байжээ.

Амласан ёсоороо Санж түүнд газарчилж Чодэнгамон буюу олон

хаалгат суварга руу явахаар шийджээ.

“Замдаа хэзээний алдарт Нартан хийдээр ороод гарах юм шүү. Гаанжуур, Даанжуурыг барладаг номын тэр ариун өргөөгөөр шагайлгүй өнгөрвөл алдас болно* гэж Санж бодож байлаа.

- Санаагаа л зогооно уу гэхээс өөр ямар ашиг байв гэж дээ. Олон хаалгатайгаас л биш өөр сонин гажууд юм тэнд байхгүй. Олон хаалгаар орж гарсан хүн л үрийн хутагтай байдаг юм бол би лав л хориос наашгүй хүүхэдтэй байхсан даа. Гэвч тэр санаанд хүрэмгүй хэрэг! гэж Бэрээмэг- эмгэн сүүлийн удаа хориглосон боловч Отгон үгэнд нь орсонгүй.

- Багш ламын айлдсан ёсоор л үзээд алдъя. Үгнээс нь зөрвөл алдас нүгэл болох биз гэж Отгон эрс хэлжээ.

Тэд аянд гарав. Тэдний зорьсон Чодэнгомман буюу олон хаалгат суварга бол орой дээрээ сампин зангидсан мэт хэлбэртэй алтадмал догтой, таван давхар, давхар бүртээ хорь бүгд зуу гаруй хаалгатай бөгөөд тэрхүү цагаан суварганы хаалганаас хаалга дамжин хөлхөн явсаар бүтэн өдрийг бардаг ажээ. Тэр аяллын дараа үрийн хутаг олно гэдэгт Отгон итгэж, Санж болохоор төдий л сайн итгэхгүй байлаа. “Ертөнц басхүү олон хаалгат суварга мэт билээ. Түүний хаалга бүрээр амьтан орж, гарч төгсгөлгүй хөлхөж, ирэх буцахын тавилан дуусварыг хэзээ ч үл үзмой” гэж багш лам айлдсаныг Санж гэнэт дурсан санаж олон хаалгат суварга орохоор гэрээс гарлаа. Гарахдаа гагцхүү сэтгэлийн зовлонд ойчсон Отгон хүүхнийг өрөвдөж түүний тусын тулд ийнхүү шийдэн замчлагч нь болжээ. Давхар давхар зовлон үзсэн тэр бүсгүйн сэтгэлийг засч нэг ч билээ хүссэн зүйлийг нь гүйцэлдүүлэхэд тус хүргэвэл тэр бас л буяны үйлс гэж Санж тооцож байв. Багш лам нь ч ингэж л ярьж байсан. Нөгөө талаар сүжгийн хүч хичнээн их болохыг тэр ухаарч байлаа. Гэвч бурхны ариун шүтээний хүч хэр зэрэг мэргэн болохыг Отгон хүүхний цаашдын хувь тавилан залуу гэцэлд зааж өгөх нь магад. Ингэж их сүслээд үр дүнгүй өнгөрөх учиргүй гэж тэр одоогоор бодож байв.

Хорь. Сэтгэлийг биеэр илчилнэ

Шар тосыг шарж болдоггүй
Хар усыг өрөмтүүлж болдоггүй
Хайр элсийг нүхэлж болдоггүй

Багш ламтан Гэндэнбалдан зузаан олбог дээрээ завилан сууж байлаа. Хоёр хөлөө зөрүүлэн завилахдаа тус бүрийн тавхайг нь дээш, өлмийг нь уруу харуулсан байх учиртай бөгөөд түүнийг алмазан хэв маяг буюу важрапариянка суудал гэнэ. Ийнхүү ихэмсгээр завилан залрах нь бурхад, дээдсийн ёс билээ. Хоёр мутраа элгэн тушаа дээш нь өргөөд эрхий хурууг долоовортой уулзуулан бусад хурууг тэнийлгэн дармачакра мудра буюу эрдмийн хүрд эргүүлмөй гэсэн дохиог үзүүлжээ. Яагаад багш лам өнөөдөр ийнхүү ёс ямбыг үзүүлэн сууж байгаа нь Санжид тов тодорхой. Багш лам дохионы ёсыг шавьдаа зааж эхэлжээ. Бурхад янз бүрийн хэв төрхтэйгээр дүрслэгдсэн байдаг бөгөөд дор бүрийдээ утга учиртай ажээ. Босоо бурхан үл ялиг бөхийсхийж, баруун гарыг унжуулан алгыг урагш харуулан тэнийлгэж, зүүн гарыг доош тохойгоор нугалан алгыг дээш нь дэрвийлгэн ямарваа юм түлхэн зайлуулах мэтээр зогсож байваас түүнийг саманпада гэж самгаридар нэрлэнэ. Үүнээс бурхдын лагшингийн хэв маягийн цагаан толгой эхэлнэ. Гурвантаа бөхийсөн буюу тривханга зогсолт гэж дараа нь ордог. Тэр бол цээж, баруун зүүн гар цөм үл мэдэг бөхийн нугарсан байдалтай байна. Үүнийг түрүүнийн номлолоороо Гэндэнбалдан багш нь Санжид бүрэн зааж, биеэр үзүүлж өгсөн билээ. Өнөөдөр тэр хичээл үргэлжилнэ. Отгон хүүхнийг газарчилж Жанцэ хийд орсныг нь Гэндэн лам ах мэдчихжээ. Түүнээс болж багш лам гурав хоног дараалан үлгэр ярив. Бүх үлгэр нэгэн утгатай байлаа. Гагцхүү үйл явдал нь өөр өөр юм. Бурхны ном үзэхээр шулуудсан хүн жирийн хүний амьдралаас хагацан салах учиртайг тэдгээр үлгэрт сэнхэртэл номложээ. Багш ламын ариун үүрэг бол шавь нараа элдэв алдас нүглээс болгоомжилж, тэднийхээ

хожим ойчиж болзошгүй нүгэл тамын ам, үүдийг урьдчилан хааж, торлон бөхөлж байх ёстой билээ. Тэгж чадвал сая багш шавийн ариун барилдлагаа тогтоно. Гэндэнбалдан ламтан сайн шавьтай байхыг үргэлж хүсдэг боловч тэр бүрий хүсэл ханасан явдал үгүй ажээ. Иймд шинэ шавь Санжийгаа мөн тэр замаар оруулчихгүйг хичээжээ.

- Бурхдын суух ёсныг эхнээс нь аваад дараа дараагаар үзүүл! гэж багш ламын тушаасан ёсоор өчүүхэн шавь Санж важрапариянкаас эхлэв. Яагаад ч юм багш нь самгарьдаар голдуу зааж байв.

- Зөв. Одоо ардхапариянкаар суу! гэж багш тушаав.

Зүүн хөлийг завилан баруун хөлийг өвдгөөр нь доош нугалан унжуулж түүн дээр баруун гарын алгыг дээш харуулан тавих маягаар сууж үзүүлэхэд сая ардхапариянка суудал болно. Үүнийг Санж мөн л ёсоор нь хийлээ. Саттваарпариянкаар суухыг багш лам шаардав. Тэр нь ердийн завилан суухыг хэлнэ

- Важрапариянка болчихоод байна даа, наадах чинь гэж багш нь уурлан толгой сэгсрэв. Важрапариянка, саттваарпариянка хоёр бараг ялгах юмгүй гагцхүү сүүлчийнх нь хоёр хөлийг дөнгөж авцалдах төдий мөчигхөн завилан суухыг хэлж байгаа юм. Санж үүнийг мэдэх боловч морин дээр хар багаас явж эв хавгүй болсон хөл нь мөчиг завилан суухад төдий л аялаг биш байлаа. Багш лам дургүйцэж,

- Буянт суудлаар сууж сурах буян дутаад байна уу? Эсвэл нүгэл бузар хөлд чинь ороо юу? гэж байцаав.

- Угаасаа яс нь зохицоогүй юм уу өвдөөд байна гэж Санж хэлсэнд багш нь

- Мөчид завилах төдийн суудлаар сууж чадахгүй бол олигтой лам болж яаж барах юм бэ? Бясалгал хийж сар, жилээр суухын цагт яах хүн бэ? Удахгүй би чамд ёогын ухаан заана. Тэр бол үүний дэргэд үнэхээр яс янгинаж, шөрмөс сунахаар болгох зүйл. Ёогын ухаан

сурахгүй гэж бас л уураа барьж ядан өгүүлснээ ядарсан бололтой баруун хөлийг өвдгөөр нугалан зүүн хөлөө газар тулан хагас нугалан унжуулж баруун өвдөг дээр баруун гарын алгаар дарж зүүн гараар зүүн хөлийн тушаа газар тулж суулаа.

- Одоо би ямар суудлаар суув? гэж багш нь асуув. Санж түүнийг сайн мэдэж байсан тул түгдрэлгүйгээр,

- Махараажалиилаасанаа буюу эзний амгалант суудлаар багштан та заларч байна гэв. Багш лам түүнийг сонсоод маш гайхаж,

- Би чамд үүнийг заагаагүй байтал яаж мэдэв? гэж асуужээ.

- Хөрөг дээрээс санамсаргүй үзээд Лүндэгжунай багштангаас асууж тогтоож авсан юм гэж Санж хариулахад Гэндэнбалдан хөмсгөө зангидаж,

- Олон багштай байх хэцүү. Юмыг дэс дараалалтай зааж, нэг хэв жаягт оруулж чаддаггүй юм. Шарыг үзэж шарваж, цагааныг үзэж царваж байх муухай. Иймд чи одоо энэхүү Махараажалиилаасанаа суудлаар өөрөө сууж сур, саттваарпариянкийн дараах суудал шүү. Лам хүн иймээр суухуйяа ховор. Энэ бол ноёд ихсийн суудал. Гэвч шашны түшмэл эрдэнэ үүгээр сууж болмой гэж ярив.

Санж уул заасныг ёсоор нь хийж үзүүлэв. Багш ламтан түүнд сэтгэл өег болж толгойгоо дохиж түр амсхийн сууснаа,

- Ёзоорын нүүр хар хөх, хоёр давхар, баруун зүүн нь ногоон, хар мутрын анхны хоёрт хутга, гавал дойд хоёрт илд, гавал эрх, баруун бойвгоо хумиж зүүнээ сунгасан... энэ юуны хөрөг вэ? гэж асуув. Тэрэнд цочмоор өөр хариу хэрэгтэй.

Багш лам нь юм зааж байснаа гэнэт ном судраас иш татаж шалгадаг зантай учир Санж энэ асуултад цочсонгүй, “Бясалгах цагийн итгэл” гэдэг бурхны зургийн тухай асууж байгааг ойлгожээ. Тэр нь хоёр

давхар толгойтой, дөрвөн гартай, баруун хөлөө өвдгөөр нугаласхийж зүүнээ сунган зогссон тийм бурхан ажээ.

- Бясалгах цагийн итгэлт бурхны дүр байна гэж Санж хариулахад багш нь,

- Номыг хоосон цээжлэх бус нүдээр үзэж, гараар барихаар бясалгах нь их сайн хэрэг. Тэгвэл чи баруун бойвгоо хумьж, зүүнээ сунгасан зогсолтыг над үзүүлээд орхи гэв. Санж тэр даруй зүүн хөлөө тэнийлгэн, баруунаа өвдгөөр хагас нугалан хоёр гараа дээш сарвайн зогсож үзүүлэв. Багш нь,

- Мөндөө мөн! Ийм зогсолтыг параатияалидхаа буюу баруунаа бөхийсөн маяг гэдэг юм. Одоо наадах шигээ зүүнээ бөхийн үзүүлсүгэй! гэв. Санж баруун хөлийг сунган жийж, зүүнийг өвдгөөр нь тахийлган зогсов. Арай ядан тогтож байлаа.

- За үүнийг зүүнээ бөхийх маяг буюу алиндхаа зогслого гэдэг юм. Одоо чи баруун хөлийг өвдгөөр нугалж, дээш нь аарцагтаа наалдуулж зүүн хөлийг үл мэдэг нугалсхийн зогс гэв. Үүнийг Санж хийж чадахгүй их л зүдэрлээ. Удтал дахин дахин хийлгэсний эцэст багш лам сая зөвшөөрөн сайшааж,

- Баруун бойвого бүрэн нугарч зүүн бойвого хагас нугарсан байдлаар зогсохыг ардхапариянка буюу бүжиглэх маяг гэнэ. Сайн тогтоож ав! Одоо яг тэр адил зүүн тал руугаа уул маягийг үзүүл! гэв. Зүүнээ бөхийсөн ардхапариянка гэдэг нь биеэр үйлдэхэд улам ч төвөгтэй байжээ.

- Ардхапариянка амархаан. Харин Акалапариянкаг хийхэд төвөгтэй байдаг юм. Гэвч залуу хүнд юухан байх вэ? гэж багш лам айлдлаа.

Санж хичээн зүтгэсээр бурхдын тэрхүү хэв маяг, зангаа дохиог багш ламынхаа санаанд таарах хүртэл нь уйгагүй хийж байлаа. Багш лам түүнд их урамшиж, - Бурхны хайр хүлээхэд холгүй байна. Ийм хичээл

зүтгэлтэй шавь л бурханд хэрэгтэй гэж сайшааснаа, - За одоо хамгийн төвөгтэй Акалапариянка зогслогыг сурна. Хоёр янз буй. Баруун бойвгыг өвдгөөр хагас нугалан зүүн бойвгыг ар тийш нугалан тавхайг дээш харуулан өсгийгөө өгзөгтэй үл мэдэг хүргэсхийн зогс. Тэгж чадвал акапапариянка маяг мөн! гэв. Тэр ёсоор зогсох гэтэл чадахгүй байсан тул Санжийг түр амсхийхийг багш нь зөвшөөрөв. Акалын хэв маягаар зогсох нөгөө нэг хувилбар нь ганцхан хөлөө өөрчлөхөөс өөр зүйлгүй боловч түүнийг биеэр хийхэд төвөгтэй ажээ. Гагцхүү зураг дээр тиймээр дүрслэж болох юм. Гэвч ёогын дасгал хийсээр сурсан хүнд бол иймэрхүү хэв маягаар суух, зогсох гэгч санааны дурын хэрэг болно. Бурхдын хэв маяг, зангаа дохионы хэл нь хүний жирийн амьдралд тохиолдохооргүй тийм өвөрмөц байх ёстой гэж эртнээс уламжлагдан тогтжээ.

- Хэцүүгий нь эхлээд сурчихвал хөнгөнийг яаж ч байсан чаддаг болно гэж лам багш нь сургамжлахад Санж “Нээрээ үнэн үг дээ. Эхлээд хэцүүгээс нь л барьж авбал таарна” гэж бодлоо. Багш лам,

- Хоёр гарын арван хурууг хослуулан үзүүлэх зангаа дохио арван хэдэн янз буй. Тэрнийг чи бол амархан хийж чадах учир би зөвхөн хэлэх, үзүүлэх төдийгөөр хичээлээ дуусгавар болгоно гэв.

Санж тийнхүү бурхдын хэв маяг, суух, зогсохын ёс, дохио зангааны учрыг заалган өөрийн биеэр үйлдэн сурахын хамт багш ламынхаа бүтээлийн өрөөнд өлгөөстэй байдаг хөрөгнүүд, баримал, шуумлуудаас үлгэр авч нэлээд сайн төсөөлөлтэй болжээ. Гэвч багш лам Гэндэнбалдан хэр баргийн юмыг тоож сэтгэл нь ханадаггүй тул Санжийн хичээл зүтгэлийг төдий л сайшаахаасаа урьдаар өөлөхийг л эрмэлзэнэ. Тэр нь ч Санжид хэрэг болж байлаа. Багш лам цаг үргэлж

- Хичээх хэрэгтэй. Залуу байхад юм сурвал зохино гэж сургамжилна. Хэв маяг, дохио зангаа бол бас нэг ёсны хэл юм гэнэ. Санжийг хааяа магтах дур нь хүрвэл баруун гарын алгыг тэнийлгэж дээш өргөнө. Түүнд нь Санж их урамшдаг.

- Энэ бол авхиамутар мөн. Аюулгүй тайван амгалан, сайн сайхныг билэгдсэн дохио чагжаан гэж ламтан заажээ.

Санжийг олигтой дүнд хүрэхгүй байвал багш лам нь үрчгэр царайгаа улам барайлгаж, баруун гарын долоовор хурууг гозойлгоод бусад хуруугаа нугалан чанга атгаж дохио өгнө. Тэр нь тархаанимутар буюу заналхийлэх зангаа дохио юм. Тархаанимутар үзүүлсэн цагт багш нь тун сэтгэл дундуураар барахгүй заналтай болсны дохио өгч буй нь тэр билээ. Тэр дохионы дараа духан дээрээ шугамдуулахаас эхлээд элдэв цээрлэл үзэж болно.

Багш ламын хамгийн дуртай үзүүлдэг нэг дохио бол баруун гараа дээш өргөж эрхий долоовор хоёрыгоо үзүүрээр нь нийлүүлэн бусад хуруунуудыг шулуун чигт нь бие биеэс салгахгүйгээр гозойлгодог байна. Тэр бол ватаркамутар буюу нотолгоо хэмээх дохио болой. Гэндэнбалдан лам тэрхүү нотолгооны дохиог алив үнэн үг хэллээ гэж бодох бүрийдээ үзүүлнэ. Мутрын нэрийг заавал самгарьдаар цээжлүүлнэ.

- Аливаа мангас төрөн гарахуй дор бурхантай заавал мөчөөрхөн тэмцэх агаад эрхбиш ялагдах ёсон буй бөгөөд чингэмэгц зүрхээ өргөө, шашныг харуулдан сахия гэж андгайлан шинэ сахигч буй болмой! хэмээн ярихдаа мөн л витарамутрыг үзүүлэхэд нь Санж гайхаж,

- Бурхантай мөчөөрхөн тэмцэхээс өөр үйлтэй мангис хорвоод төрдөггүй юм уу? гээд асууж орхижээ. Багш нь,

- Цагаанд хар, сайнд муу байдгийн адил их буянт бурхдад их нүгэлт буруу номтон заяаж эсрэг тэмцэлдэх жам буй. Тэр жамыг дагаж аливаа буг чөтгөр, лус савдаг, рудраа буюу шашны дайсан гардаг болно. Иймд нэгэнт тогтсон ёсонд эргэлзэх нүгэл! гэж сануулав.

- Миний хэлснийг газар гэрчилнэ! гэж багш лам нь дахин номлоод завилан суусан байдлаа өөрчлөлгүйгээр баруун гарын алгыг тэнийлгэн хурууны үзүүр нь газар бараг шүргэх төдий дүр үзүүлж

зүүн гарын алгыг дээш харуулан завилсан хөл дээрээ тавив.

- Бхүүмиспарсаамутар гэгч энэ! Газар ёслох дохио. Гэрчээр газрыг татах тэмдэг. Үүнийг сайн тогтоож авагтун! хэмээн багш нь номлов. Санж түүнийг дууриан үйлдэхэд багш нь толгой дохин таашааж зүүн гарын долоовор хурууг гозойлгон бусад хурууг эвхэж баруун гараар мөнхүү долоовор хурууг атган дохио өгөхөд Санж ойлгосонгүй.

- Бодахьяагримутар энэ. Гүйцэтгэхийг илэрхийлсэн дохио! гэж багш нь тайлбарлав. “Хичнээн ч олон янзын дохио зангаа байдаг юм бэ? Чоймчиг багштан залбирах, хүндэтгэх мутар, номын хүрд эргүүлэх мутар, очир дүрслэх мутар төдийхнийг зааж билээ. Тэр хэдээр л хязгаарлагддаг мэтээр ухаарсан минь мөчид болжээ” гэж бодоод тэрхүү бодьяагримутрын сургуулийг даруй хэдэнтээ давтан хийлээ.

- Болно. Одоо ядуу зүдүү олны дунд орвол ямар мутар үзүүлэх вэ? гэж багш ламыгаа асуухад Санж өглөгийн дохио үзүүлэх юм байх гэж бодоод баруун гарыг доош унжуулан тохойгоор үл мэдэг нугалаад алгыг тэнийлгэв.

- Зөв. Вараадамутар гэгч энэ. Өглөгийн дохио. Ядуу олонд өглөг түгээх үед мутар иймэрхүү байх ёстой гэж багш нь магтав.

- Багш аа, ийм олон янзаар зогсох болоод суухын гадна дохио зангааны янз бүрийн ёсыг дагах төдийгөөр их буян бүтэх буюу? гэж Санж асууж орхисонд багш лам таашаасангүй.

- Бурхан болбоос ганцхан хэв маяг, дохио зангааны явдалтан биш. Тэр нь гагцхүү хэлбэр. Аугаа их сургаал, номлол нь сэтгэлийн лут рид шидийг хадгалан оршихдоо бусдад биеэр илрэн харагдах шинж бүхий билээ. Сэтгэлийг биеэр илэрхийлэн номнохын учир эдгээр ёс тогтсон юм гэснээ хоёр гарыг элгэн тушаагаа зөрүүлээд тус тусын чигчий хурууг хооронд нь гохдуулан долоовор хуруунуудыг дээш гозойлгон дунд хурууг эрхий хуруутай учруулан, ядам хурууг түүнийг дагалдуулан нугаласхийж,

- Одоо би юуг үзүүлж байна? гэж асуулаа. Санж хариулж чадсангүй.

- Энэ бол очир зангидах дохио. Важрахимкара мутар гэдэг энэ. Ийм дохио үзүүлбэр очроор огтлохын гүн ухаан бясалгаж буй төдийгүй тэр тухайн санаж гүйцэшгүй олон сэжүүрт иш онолыг хүн ухаандаа үүсгэн бодож болно. Иймд энэ дохиог гүн ухаантан л гагцхүү үзүүлж зүрхэлнэ. Бурхдын хөрөг дээрээс түүнийг харж болно. Ерийн нүгэлтэн үүнийг дууриан үйлдвээс алдас болно. Басхүү элэг доогтой ч явдал болно. Энд бол өөр хүний нүд үл үзэх тул шавь чи очир зангидан үзүүл! гэж багш нь шаардав. Санж түрүүчийн заасныг дууриан элгэн тушаа гараа зөрүүлэн, хуруугаа этийлгэж үзүүлбэл багш нь улсхийж уураа барьж ядан дүнхэлзээд,

- Мунхаг шавийн багш зовуур гэгчээр би ч зовох нь ээ! Наадах чинь важраахимкарамулар биш харин пражналингаанавхийнъяа мутар болон хувирав. Тэврэхийг үзүүлсэн дохио. Үүнийг ариун бурхад үл хиймой. Гагцхүү хилэнт аймгийн бурхад шашныг хамгаалахад дохио болгон хийнэ. Нүгэлт эмсийг тэврэн авч ариун явдалтанд хоргүй болгож байгаагийн дохио юм. Тэр зүүн хананд байгааг хар. Махасуваар тэрээр эрх хураах байдлаар биеийн өнгө улаан, эх Умаадивий улаантай учирсан, шампүрэлванжид буюу бусдын хувилсанд баясагч тэнгэрийн орноо оршдоогоор дүрсэлсэн байгаа биз! гэж асуугаад зүүн ханан зүг заав. Тэнд Махасуваарын улаан дүр мөн өөртэй адил улаан өнгөт Умаадивий гэдэг эмийг тэвэрсэн байдлаар зурсан нь Санжийн нүднээ туслаа. Мутрыг нь Умаадивийгийн бүсэлхийгээр тэврэх мэтээр ороосноор зуржээ.

- Эмс лугаа учран тэвэрсний дохиог чи хаанаас сурсан бэ? Би түүнийг заагаагүй байхад! гэж багш нь дахин асуулаа. Санж ичингүйрэн айж,

- Багштан өршөө! Би хэнээр ч заалгасангүй билээ. Гагцхүү таны заасныг дууриан үйлдэх гэтэл ийм юм боллоо. Багштан өршөө! гэв.

- Өршөөхөөс урьдаар сургах учиртай. Бурхны ёс нарийн. Иймд

өчүүхэн төдий анзааргагүй шавь бол юунд ч хүрч болно. Аюуш тамд орохоор нүгэл, алдсыг нэгэн эгшнээ нүд ирмэх зуур хийж мэднэ. Ийм учирт чи миний үгийг үгэнд тооцож анхааралтай сонсох учиртай. Болгоомжгүйгээс их аюулд орж болно гэж Г эндэнбалдан ламтан сурган айлдав. Тэр их л сэжиглэсэн шинжтэй байлаа.

Тийнхүү бурхдын завилах, зогсох, зангах хэв маягийг ихэнхийг зааж өгсөндөө лам багш нь сэтгэл цадаж,

- За өнөөдөртөө ингэсгээд болно гэтэл гадаа хашааны олсноос хэн нэг хүн татсан тул ламын гэр дэх жижигхэн хонхны хэл татагдаж жингэнэн дуугарав.

- Хүн ирэх шиг боллоо. Очоод хэн болохыг мэдээд ир. Хамаагүй нээвзэй! гэж багш нь Санжид тушаалаа.

Санж гүйн гарч хаалган дээр очоод оньсыг тайлалгүйгээр,

- Хэн бэ? гэж асуухад,

- Би Чогсон бодьпа байна Чамайг сураглаж ирлээ. Чи Санж мөн биз дээ? гэхэд Санж,

- Тийм. Юу гэж намайг сураглаа вэ?

- Ланцысагийн газраа нэгэн монгол хүн баригдаад байгаа гэнээ Тэрийг асууж байцаахад чамайг хэлмэрчээр аваачих гэж дуудуулсан юм. Тэр хүн чиний нэрийг хэлсэн гэнэ.

- Миний нэртэй ижил нэртэн манай нутагт хэдэн арваараа бий шүү дээ

- Чамайг яг зүсээр нь танина. Нэг нутгийн хүүхэд! гэж тэр хүн хэлүүлсэн гэнээ. Тэгэхээр одоо хоёулаа Ланцысаагийн газар очье.

- За тэгвэл би багштанд очиж гуйгаад ирье. Чи хаалган дээр байж бай!
Би одоохон эргээд ирье.

Ингэж тэр хоёр ярилцаад Санж эргэж гүйв. Багш ламдаа учрыг хэлж
Ланцысагийн газар очих зөвшөөрөл гуйсан Санжийн үгэнд
Гэндэнбалдан итгэсэнгүй,

- Ланцысагийн босгоор эгэл ядуус алхан орвол шууд барьж аваад
арван дөрөв ташуурдаж залхаагаад дараа нь хэрэг зоригийг асуудаг
ёстой юм. Чам шиг хүнд түүгээр орох хэрэг байхгүй гэв.

- Чогсон бодьпа ирээд тэгж хэллээ. Тэр лав үнэн байх. Би нэг
хэрэгтэнд хэлмэрчлэх юм гэнээ. Манай нутгийн хүн гэнэ. Очихгүй
байх муухай бизээ гэх мэтээр Санж багшийгаа ятгаж сүүлд нь Чогсон
бодьпатай хамтарч гуйсаар арай гэж зөвшөөрүүлэв.

Чогсон хоёулаа Ланцысагийн газар очиход шоронгоос мөнөөхөн
хоригдлыг байцаахаар гаргаж ирэхэд нь Санж ажин харвал Бөхмагнай
байлаа. “Ашгүй Бөхмагнай гуай амьд мэнд байгаа ажээ. Яагаад
шоронд орчихсон юм бол доо? Хөөрхий Отгон эгчийн сэтгэлийг нь
онгойлгох юм байна даа. Шоронгоос аргалж гарвал л болоо биз” гэж
Санж бодлоо.

Хорин нэг. Бурхны орон дахь там

Цасанд мөр хар
Цаасанд бичиг хар
Зарганд үг хар

Гартаа гавтай, хөлдөө гинжтэй, хүзүүндээ дөнгөтэй Бөхмагнай арай ядан зогтуссанаа Санжийг хармагц нүд нь сэргэх шиг болон гялалзаж нуруугаа тэнийлгэн эгц зогслоо. Нутгийнхаа хүнийг хараад сэтгэл сэргэсэн юм уу, эсвэл нэрэлхсэн ч байж болно. Ямар ч гэсэн Бөхмагнайд нэгэн бодол төржээ.

- Ашгүй чи ирэв үү? гэж тэр дуугарлаа.

- Дуугүй бай! гэж түвд цагдаа зандрав.

Чулуун шалан дээр Бөхмагнайг сөгтгөн суулгалаа. Хөл, гарын гав гинж нь гаслан ёолох мэт тарчигнан хяхралдав. Хэрэг шийтгэгч түшмэл суудалдаа очиж тухалмагц, хахир чанга дуугаар,

- Ялтан чи үг өчгөө үнэнээр хэлбэл зохино. Худал юм дуугарваас нүгэл чинь улам хүндэрч муу заяа улам ойртоно гэж хэлэв.

- Хэлмэрчил! гэж Санжид өөр нэг хүн ууртайяа тушаалаа. Санж түр зуур түгдэрснээ түшмэлийн яриаг дамжуулав. Бөхмагнай,

- Санж минь би эдэнд баригдаад байна, шоронд нь суулаа. Амьд гарах аргагүй тамын орон байна. Тэгэхээр манайханд хэлж намайг суллуулах арга хай. Би үүнийг л хэлэх гэж чамайг дуудуулсан юм. Эдний үгэнд хариулах завсар би чамд ярьсныг битгий хэлмэрчлээрэй гэв. Санж толгой дохиж,

- Үнэнээ хэлнээ гэж энэ хүн өчиж байна хэмээн орчуулав.
- Энэ их олон үг хэлсэн. Чи яасан цөөхөн үгээр хэлэв. гэж түшмэл сэжиглэн муухай харлаа.
- Би бүрэн хэллээ. Монгол үг их урт шүү дээ. Гүшүүтээн! гэж Санж өчлөө. Гүшүү буюу дээд гаралтан гэдэг үгээр хүндэтгэн хэлэхгүй бол Түвд түшмэлд тун таалагдахгүй болохыг Санж ухаарч байлаа.
- Тэгвэл чи энэ ландрамыг удахгүй тонилгоно гэдгийг нь ойлгох нь ортол хэлээд өг гэж түшмэл тушаав.
- Эд нар намайг золиосонд өгсөн бололтой. Үнэхээр л толгой авах байх. Хөөрхий Дарамзагд гуайг байхгүй болгосон, чи мэдсэн үү? гэж Бөхмагнай хэлэхэд Санж царай барсхийж,
- Яасан бэ? гэж дуу алдаж орхив.
- Ялтангай нэгч үг битгий ярь. Эс тэгвэл чамайг мөн адил үгүй хийнэ шүү? гэж түшмэл зандрав.
- Энэ юу гээд байна? гэж дараа нь асуув.
- Амьд явмаар байна. Би ямар ч гэм зэмгүй хүн гэж ярилаа, гишүүтээн? хэмээн Санж “хэлмэрчлэв”.
- Амьд явахыг хүсдэг чинь сайн байна. Тэгвэл чи Шамбалын цэрэгт явах ёстой. Тэнд л амьд явах ёстой эсэх чинь мэдэгдэнэ. Амьд явах ёсгүй байсан бол анхны буун дуугаар л талийна. Амьд явах ёстой байсан бол шамбалын дайныг эсэн мэнд туулах биз гэж түшмэл нухацтай хэлэв. Санж түүнийг монголчлоход Бөхмагнай хөх инээд үзүүлээд,
- Шамбал байтугай шулмасын цэрэгт явсан ч хамаагүй, эдний өмхий шоронгоос л гармаар байна. Хөөрхий Дарамзагд гуай шазруун үг

хэлчихсэнээс болоод эдний гарт өнгөрсөн. Эдний гарт ч гэж дээ, үхэр хулгананд бариулж үхсэн. Би тэгж үхэх дургүй байна гэж хэлэв.

Санжийн сэтгэл харанхуйлах шиг боллоо. Хэрэгтэнгүүдийг нүцгэлээд харанхуй нүх рүү хаячихдаг. Тэнд нь мөн хориотой байсан өлсгөлөн хилэнцэт хорхойнууд эсвэл үхэр хулганууд шавж аваад ямар ч хүнийг нэг шөнийн дотор барьж идээд зөвхөн араг ясыг нь үлдээдэг аюумшигтай муухай тамлалын тухай Санж сонссон болохоор Дарамзагд гуайг тийм үхлээр өнгөрчээ гэж ойлгоод сэтгэл нь харанхуйлжээ. Түүнийг нь тааж мэдсэн юм шиг Бөхмагнай,

- Бурхны орон гэгдсэн энэ Лхас зууд бугийн орон, бирдийн орон байдаг л юм байна гэж нэмж хэлэв.

- Юу гээд байна түргэн хэлмэрчил! гэж түшмэд тачигнан зандрав. Санж бөхөсхийн алга хавсарч,

- Лагсоо хэмээн тэр цочирдон дуугарснаа энэ хүн үхэх дургүй гэнээ. Шамбалын цэрэгт явъя гэж байна, гишүү! гэв.

- Түшмэдийн баргар царай өөрчлөгдөх шиг болсноо,

- Тэгвэл чамайг шоронгоос гаргаж, цэрэгт өгнө. Дэнзэнгийн ланшен (боол) биз дээ чи! гэхэд Санж орчуулав.

- Дэнзэнгийн боол гэж юу хэлээд байгаа юм бэ? гэж Бөхмагнай асуулаа. Тэр ойлгохгүй гайхан эргэлзжээ.

- Аа чи бас мэдэхгүй царай гаргах уу? Дэнзэн чамайг цэрэгт өгсөн. Чи түүний ланшен мөн. Одоо булзааруулах гэвэл толгойгүй л болохоо бодвол таарна. Шоронд сууж тэжээлгэсний чинь зардал одоо чиний толгойноос үнэтэй болчихоод байна гэж түшмэл хилэгнэв.

Бөхмагнай тэр үгийг сонсоод хэрэг бишидвэл аягүй юм болж магадгүй гэдгийг ухаарчээ.

- Дэнзэн ч байна уу, мэнзэн ч байна уу, ялгаа алга цэрэггээ л авна биз. Цэрэг болж байгаад учраа ольё гэж тэр хэлэв.

- Тэр нь дээрдээ. Одоо тэгвэл чи энэ бичигт гарынхаа мөр үлдээ! гэж түшмэл зандрах маягаар хэлээд тайлиан цаасан дээр бичсэн хэдэн үсэг рүү заалаа. Тэр даруй өөр нэгэн хүн бэхтэй янтайнд Бөхмагнайн эрхий хурууг наалдуулав. Цаасан дээр эрхий хурууны мөрийг палийтал гаргамагц Бөхмагнайн хөлийн гинж, хүзүүний дөнгийг авч хаяад зөвхөн гарын гавыг үлдээлээ.

- Цэргийн ноён хаа байна, дууд! Энэ хүнийг тушаа! гэж түшмэл туслах руугаа зангалаа. Туслах нь “Лагсоо” гээд годхийн гарснаа удалгүй эргэн орж ирээд,

- Цэргийн ноён хараахан ирээгүй байна гэв. Түшмэл ярвалзан босоод дал мөрөө хавчисхийн суниснаа,

- За тэгвэл, энд түр хүлээж бай! Үүнд замбай өгүүл! гэж хэлээд гарч явахаар завдан үүд рүү яаран алхлав.

Хоёр хуяг “лагсоо” гэж бөхөлзөв. Тэгээд алгаа хавсран ташихад гаднаас зарц орж ирээд бөхөсхийлөө.

- Үүнд усаар зуурсан замбай авчирч өг! гэв. Тэрхэн мөчийг ашиглаад Бөхмагнай Санжтай үг солихыг боджээ.

- Отгоны сураг байна уу? гэж тэр яаран асуулаа.

- Отгон эгч мэнд байгаа. Таныг олзлогдсоны дараа санд мэнд явж Лхасд ирсэн. Тэгээд Бэрээмэг эмгэнийд байж таны сургийг гаргаж ядаад Олон хаалгат сүм рүү явсан. Би газарчилж өгсөн. Тэнд очиж мөргөл хийгээд ирсэн. Одоо Бэрээмэг эмгэнийд байгаа. Удахгүй нутаг буцах санаатай юм гэнээ гэж Санж ярихад,

- Ашгүй юун сайн юм бэ? Олон хаалгат сүм орсон уу, бас. За болж дээ. Би эдний гарт ороод Лхасын шоронд тамаа үзлээ. Одоо эдний цэрэгт дайчлагдлаа. За гайгүй цэргийн хуарангаас оргоно. Хойноос чинь гүйцээд очно. Нутаг руугаа зүглээд аянчин дагаад буцаж бай гэж Отгонд хэлээрэй хэмээн Бөхмагнай яаран ярьж байтал гаднаас зарц орж ирээд усанд зуурсан замбайн жонхуу өгөв.

- Наадхаа идэж бай! гэж хуяг тушаав.

- Жонхуу ч яахав. Чамтай уулзсан минь аз боллоо. Ер нь Лхас гэдэг чинь буг чөтгөрийн орон юм даа. Шоронд нь түмэн муухай юм үзлээ. Дарамзагд гуай хэд гурван хараалын үгийг түвдээр сурсан юм байж. Түүнийгээ эдэнд хэлчихсэнээс болж амь насаа алдлаа. Өлсгөлөн хилэнцэт хорхой, үхэр хулгананд амьдаар нь хаяж өгсөн. Тэгэхийнхээ өмнө зөндөө тарчилгасан.

Давстай усанд дүрсэн саваагаар хичнээн ч олон удаа савав. Миний арьс ч нэлээн тэссэн. Харин Дарам гуайнх шархалж их зовсон. Хумсны завсраар хулс шааж тамалсан. Дарам гуай хараал хэлэх бүрийдээ улам айхтар зовлонд учирч авах юмгүй болтлоо зэрэмдэглүүлсэн. Махир хутгаар хамры нь үзүүрийг авч хаясан. Дараа нь хоёр хүн дамжлан даадаг тийм том чулуун малгай шиг юм өмсүүлж байгаад алхаар орой руу нь цохиход хоёр нүд нь бүлтэрсэн, түүнийг халбага шиг хутгаар огтлон авч элээний хоол болгон шидсэн, энэ бүхнийг би харсан. Гэвч гав дөнгөтэйдээ яаж ч чадсангүй. Хоёр нүдээ авахуулснаас хойш Дарам гуай тун их хилэгнэж эднийг элдвээр хараан зүхсэн. Би ч бас тэр мэт харааж байлаа. Даанч хэл мэдэхгүй болохоор ойлгоогүй биз. Харин Дарам гуай ойр зуурын юм түвдээр ярьдгийнхаа гайгаар л эднийг галзууруулж байж хайран амиа алдлаа. Эдний гараас яаж ийгээд гарвал Дарам гуайн өшөөг заавал авна. Түвдийн ууланд гарч дээрэмчин болно гэж Бөхмагнай уур хилэнгээ нууж ядан Санжид хэллээ. Тэрний нүд эрс шийдэмгийг илтгэнэ.

Тэр мөчид хаалга нээгдэн цэргийн ноён орж ирлээ. Хуягнууд бөхөлзөж Бөхмагнайн зүг зэрэг зэрэг зааж,

- Авах хүн чинь тэр байна, гүшүү! гэж Бөхмагнайг заалаа.

- Аваад яв! гэж цэргийн ноён өөрийгөө дагаж ирсэн хоёр хүнд тушаалаа. Тэр хоёр салбаганан ярууллаа.

- Дүү минь, ахыгаа ингээд явлаа гэж Отгонд хэлээрэй гээд Бөхмагнай нөгөөх хүмүүсийн хүчинд автагдан гадагш гарлаа. Санж дагалдан гарав. Бөөн гашуудалд эзлэгджээ.

Уранхай, салбархай хувцастай хир даг болсон, хатингар туранхай хэдэн хүнийг хуягууд хүрээлэн зогсож байсантай Бөхмагнайг нийлүүлээд тууж одлоо. Бөхмагнай Санжид хандаж,

- За дүү минь, энэ бурхны орон гэгдсэн Лхасад чинь бирд, тамын орон байдаг юм байна шүү. Сайн санаж яваарай! гэж хашгирлаа.

Гартаа гавтай, зарим нь хүзүүндээ дөнгөтэй, сагсайсан үс, сахалтай тэр хэдэн хүн Лхасын чулуун дэвсгэрт гудамжаар төмөр гаваа хангинуулсаар явж байхад хүмүүс тэднийг өчүүхэн ч тоож анхаарсангүй. Учир нь тийм явдал бараг л өдөр бүр тохиож байдаг тул дөжрөн дасчээ.

Санж тэдний хойноос гунигтайяа гэлдэрч явлаа. Элдвийн юм сэтгэлд нь орж хямралджээ. “Яалаа гэж Дарам гуай энэ хоёрыг барьж тамлаад бүр амь насанд нь хүрсэн хэрэг вэ? Харийн энэ нутагт тэднийг хэн өрөвдөж, өмөөрөх ч юм билээ дээ? Одоо тэгээд Бөхмагнай гуайг юун цэрэгт авч яваа юм бол? Шамбалын цэрэгт авна гэсэн байхаа” гэж Санж эргэцүүлэн бодлоо.

“Шамбалын дайн болно. Тэр цаг ойртсоор буй. Баруун хойт зүг наян багцад газарт Шамбалын орон буй. Тэр орноос Шамбалын дайн үүсч галав галаар юүйлмой. Тэгээд Майдарын галав тогтмой” гэж Буянзалбирах хийдэд шавилан суух тэр цагт лам багш нь сургаж байсныг гэнэт эргэн санах.

- Одоо тэр Шамбалын дайн эхлэх гэж байгаа юм болов уу? Тийм ойрхон болсон юм байх даа?” гэж Санж дотроо тээнэгэлзэн бодож явтал дал мөрөн дээр нь хүн давхийтэл алгадахад цочин эргэж харвал Чогсон байлаа. Тэр налиганан инээмсэгэлж, нүдээ ирмээд,

- Чи нөгөө хэрэгтэндээ сайн хэлмэрчлэв үү? Намайг оруулахгүй хөөсөн. Тэгээд би захаар тэнэж яваад ирлээ гэж Чогсон ярихад Санж гунигт бодлоосоо хагацаж чадахгүй хэвээр,

- Чогсон чи мэдэж байна уу? Шамбалын дайн болох юм уу? гэж асуув. Чогсон бас л худлаа инээсэн хэвээр,

- Ха ха ха. Шамбалын дайн уу? Тэр ч өдий хол байна. Бидний л үед болдоггүй байх. Чи юунд ингэж бодоо вэ? гэж Чогсон их л дооглонгуй асуулаа. Санж гунигтай дуугаар,

- Шамбалын цэрэгт татагдаж байгаа хүмүүс л тэгж ярих юм байна. Саяын хэрэгтэнг мөн л тэр цэрэгт авлаа.

- Аа тэрнийг сонсоо юу? Сонор чихтэй эр юм.

- Цэрэгт хүмүүсийг олноор татаж байгаа юм гэнээ. Тэрнээс болоод л Шамбалын дайны тухай саналаа л даа.

- Цэрэгт татаж байгаа гэнэ лээ. Гэхдээ бурхны шавь нарыг цэрэгт аваагүй байгаа. Шамбалын дайн болбол бурхны шавь нар явж л таарна. Одоохондоо бол Пийлэн улсын цэрэг урд Энэтхэг газраар дамжин манайд ойртож байгаагаас болж цэрэгт татаж эхэлсэн шиг дуулдах юм. Гэвч цуу үг шүү! гэж Чогсон болгоомжлон ярив.

Санж энэхүү Чогсон гэгчийн нэгэн зиндааныхан дотроосоо илүү ойр дотнод үздэг байлаа. Чогсон ямагт зөөлөн ааш гаргаж, Санжид наалдах гэж оролддог болоод ч тэр юм уу, эсвэл хүний газар, гүний нутагт өөр рүү аятайхан харсан хүнд тал өгөх сэтгэл төрдгөөс тэр юм

уу, ямар ч гэсэн Чогсонтой арай ойр дотно болжээ. Пагсан бол үүнээс эсрэг зантай, дуу цөөнтэй хүн тул чухам юу бодож байгааг нь мэдэхүйеэ бэрх. Санжид бол бүр ч муу юм шиг байдаг. Бурхны номын нэгэн шад шүлгийг нутгаа санахын эрхэнд монголоор уншчихсан тэр нэгэн явдлыг Пагсан л мэдэж ховлосон шиг санагддаг байлаа. Түүнээс хойш хэд хэдэн удаа эвгүй явдал тохиолдох бүрийд Пагсан ямагт холбогдож дандаа л Санжийн эсрэг зогсож байх мэт болсон билээ.

- Чиний тэр хэлмэрчилсэн хэрэгтэн танай танил байсан юм уу? гэж Чогсон гэнэт асуулаа. Өөр юм бодож явсан Санж дуулсангүй. Чогсон дахиад л асуув. Санж болгоомжилсон ч үгүй,

- Аа тэр үү? Манай нутгийн хүн байна. Мөргөлөөр ирж явах замд нь дээрэмчин түйвээж баривчлан засагт тушаасан юм байна. Хоёулаа баригджээ. Хөөрхий Дарамзагд гуай өнгөрсөн юм байх аа! гэж Санж сүүрс алдав.

- Яалаа гэж тэднийг барьж авдаг юм бэ? юунд тэр хоёрын нэг нь нас барсан хэрэг вэ? гэж Чогсон шалгаалаа.

Чогсон угаасаа нойтон хамуу шиг- салдаггүй хүн гэдгийг Санж мэдэх тул нэг их гайхсан ч үгүй. Гэвч гайхах хэрэгтэйг тэр яахин гадарлах билээ. Түвдэд өөр орноос ном үзэхээр ирсэн хүн бүрд нэг түвд “найз” сэмхэн тохоон томилдог ёс хэдий нь тогтжээ. Тэр "ёсоор" Санжид анх нэгэн зиндаанд ороход нь “заяасан” найз нь энэхүү бодьпа гаралтай Чогсон түвд байсныг ганцхан хүн л мэддэг билээ. Тэр нь лам багш болно.

- Би тэр хүнтэй удаан ярьж чадсангүй. Цэргийн ноёныг хүлээх зуур л хоёр гурван үг солилоо. Уушийн даваанаас наахна л буугаад байхад нь дээрэмчин дайрч буудалцаад хоёул баригдаж энд хүргэгдэн шоронд оржээ. Дарамзагд гуай гэж манай нутгийн өвгөн байдаг юм. Тэр нь түвдээр хараал зүхэл хэлж орхисноос тамлагдаад энэ Лхасын шоронд өлсгөлөн үхэр хулганын дунд хаягдаад бариулж өнгөрсөн гэнээ. Ямар ч гэм зэмгүй явсан хүмүүс бололтой... гэж Санж ярихад

Чогсон цаашлуулж,

- Уухайс, одоо тэгээд тэр үлдсэн хүн нь хэн гэгч юун учиртай юм бэ, хө. Найздаа хэлээч! гэж шамдуулав.

- Өө тэр нь ч яахав зүгээр л нэг жирийн сайн сэтгэлт хүн юм. Бас л манай нутгийнх. Аян жинд явж л амьдардаг хүн. Нэр нь... гэснээ Санж эргэлзэж Магнай гэдэг юм. Түүнийг Хөх нуурын монгол гэж бодоод цэрэгт авч байгаа бололтой гэхэд Чогсон,

- Шамбалын дайнд хаанахын хэн боловч дайчлагдах үүрэгтэй юм гэж ярьдаг. Тэр болж дээ гэхэд нь Санж,

- Саяхан чи Шамбалын дайн бидний үед болохгүй гээгүй билүү? гэв. Чогсон Санжийн мөрийг алгадан аяглаж,

- Тэр ч тийм л дээ. Би зүгээр л зүйрлээд ярьж орхилоо. Тэр хүн тэгээд түвдэд анх ирж байгаа юм уу? Чамайг яаж таньдаг юм бэ? Өөр таних хүнгүй юм уу? Зайлуул, хөөрхий, тус болохсон гэж Чогсон хэлэв. Тэр их өрөвч дүр үзүүлж байлаа.

- Анх ирж байгаа байлгүй дээ. Манай нутгийн хүн болохоороо л намайг таньж байгаа биз! гэж Санж болгоомжтой хариу өгөв. “Отгоны тухай ярих уу, байх уу? Тус болохсон гэдэг нь юу бол? Түүнийг хааш нь аваачиж байгааг урьдаар мэдвэл таарна” гэж Санж боджээ.

- Цэрэгт явсан тэр хүмүүсийг чухам хааш нь явуулж байгааг мэдэж чадсангүй. Тэрийг нь мэдвэл ч туслахад амар дөт болно доо гэж Санж хэлэхэд Чогсон,

- Би мэдэхийг оролдьё. Мэдвэл чамд хэлнэ. Ер нь тэгээд юугаар туслах билээ гэхэд нь Санж,

- Цэргээс нь л чөлөөлүүлбэл гол тус тэр болох биз. Өөр юу байх вэ?

ГЭВ.

Нутгийнхантайгаа холбогдсон аливаа хэргийг Халх Мицанаас асууж зөвлөлгөө авч байж хийх хэрэгтэй гэдгийг гэнэт санаад Санж ийнхүү болгоомжлов. Чогсон хоосноор инээмсэглэж,

- Замбайн гурил ч бас хэрэгтэй шүү! Тэрний тус бас их! гэв.

Тэр хоёр дуугүй хэсэг явцгаалаа. Дацангийн зүг ойртож, ирсэн замаа даган алхлав. Тэд тус бүрдээ өөр өөрийн бодлыг толгойдоо бясалган, утаа, тоостой холилдсон бүгчим агаараар амьсгалан, хүний хөлд элэгдэж гялтайтлаа зүлгэгдсэн чулуун дэвсгэрт гудмаар яаран явцгаалаа. Зул, хүжийн үнэр салхи даган хамар дэлдэнэ. Хоногт хоёр гурван мянган жин шар тос шатаачихдаг хоёр мянган зултай жокоон дацангаас эхлээд Лхас зууд тос, хүжний үнэр түгээдэг газар тоолошгүй олон. Тэр бүхэн цөм л эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын төлөө хийж байгаа буяны үйл мөн гэдэгт сүжигтэн олон гүнээ итгэнэ. Хамгийн ядуу сүмд дор хаяад л зуун найман зул өдөр шөнө өглөө үдэшгүй асаатай байна. Хэдэн түмэн жин шар тос зул болгон өдөр бүр шатаадаг бурхны энэ оронд зул асаадаггүй нэгэн газар бий нь шорон юм. Ийнхүү бурхны орон, там хоёр нэгэн дор оршино. Бурхад гэдэг нь юу билээ? Элдэв хачин дохио зангаа, билэгдлийн гайхмаар шинж тэмдэг агуулсан тэр бүхний дүрийг Санж цээжлэн тогтоожээ. Янз бүрийн мутар, чагжаан, хувцас, чимэгтэй, тэр нь хүний орчлонд байхгүй тийм дошгидын дүрийг хэн нэг нь бодож олоод түүндээ үнэмшүүлэх бүхий л аргыг хэрэглэн үе дамжин сургуулилж ирсэн ажээ. Олон янзын суудал, зогсолт, зангаа дохио нь юунд ч тус болдгийг төсөөлөхөд бэрх үнэхээр л бурхны орон, там хоёр нэг дор сүлэлдчихсэн мэт ажээ.

Хорин хоёр. Зургаан зүйл хамаг амьтан

Хүн залуугаараа байдаггүй
Хүлээс чангаараа байдаггүй
Хөвд ногооноороо байдаггүй

Лхас зуугийн их хүрдийг Санж хэдэн нөхдийнхөө хамт саваагүйтэн эргүүлж явлаа. Зургаан талтай асар том тэр хүрдний тал бүрд нь хэд хэдэн модон бариул хийжээ. Бариул бүр нь түмэн хүний гар дамжсаар элэгдэн гөлийж хатсан бяслал шиг тос даасан шар юм болжээ. Зүй нь тэд хүрд эргүүлэн хялбарчилж унших бус харин амны байнгын уншлагаар номын мөр хөөх ёстой улс. Гэвч хүрд эргүүлэн, ажлаа хөнгөвчилж байлаа. Нэг ёсондоо дэггүйтэж байгаа хэрэг. Хүрдэн нэг удаа эргэхдээ хэдэн мянган маани мэгзэм уншсантай тэнцэх алба залгуулдаг гэж тооцогддог юм. Зургаан талтай тэр том булны дотор голыг нь мааний зургаан үсгийг, мэгзэмийн таван шад шүлгийг хэдэн мянга давтан бичсэн цаасаар ороожээ. Нар зөв эргэх нь уншсантай тэнцэх ёстой тул үсгийг вргэлт эхлэх талаас бичих ёстой. Зургаан тал нь тус бүр өөр өнгөтэй, гол дээрээ нар зөв эргэдэг энэхүү бул нь шашны зүтгэлтнүүдийн бодож олсон санаачилга, "хөдөлмөр хөнгөлөх" арга байлаа. Уул нь ном мэддэггүй хүмүүст зориулсан боловч одоо хэн бүхний эргүүлж зугаацах зүйл болон хувирчээ.

- Надад яагаад мэ буюу бирд таарчихдаг байнаа! Би эргүүлэхээс татгалзаж байна! гэж гэнэт хүрдний өнгөөр нь ялгасныг ажихдаа Чогсон уурлав. Тэр санаандгүй үүнийг ажжээ.

Үнэхээр түүнд хүрдний улаан өнгөтэй тал нь таарчихжээ. Улаан өнгөтэй талд "мэ" үсэг буюу бирдийг томъёолсон үсэг бичигдсэн байх ёстой билээ. Хэдэн түм дахин" бирд бирд" гэж бичсэн байгаа гэж төсөөлөөд Чогсон дотор эвгүй болжээ. Тэр эгшинд нэгэн зиндааныхан

нь цөм л хүрдний аль талд санамсаргүй таарснаа ажиглав.

- Надад асар таарчээ! гэж Пагсан дуу алдан баярлав. Ногоон өнгөтэй бөгөөд “ма” үсэгтэй тал юм.

- Надад хүн таарчээ! гэж Санж тун их олзуурхав. Хүрдний шар будагтай, “ни” үсэгтэй тал тохиосон байлаа.

- Хеек! Надад там таарчээ. Хеек! Хеек! гэж хэн нэг нь бухимдах сонсогдов? Тэрнээ цээрлээд “хеек!” (сөнөтүгэй) гэж хашгирсан хэрэг билээ. Түүнд хүрдний хөх өнгөтэй “хум” үсэгтэй тал оногдсон болой. Цээрлэж, гутмаар үг нь аргагүй мөн.

- Ом хэнд ноогдож вэ? гэж нэг нь сонирхон асуув. Аз нь дутсан ч юмуу, эсвэл санамсаргүй ч тийнхүү таарсан юм уу, бүү мэд. Ямар ч гэсэн тэдний хэнд нь ч хүрдний “ом” үсэгтэй цагаан будагтай тал таарсангүй, харин эрүү өвдөг болсон эмгэн өвгөн хоёр тэр талд нь орчихсон явж байлаа. Энэ хүрд асар том учраас хүн босоо зогсоод элгэн тушаагаа тааруулсан бариулыг атган турж эргүүлдэг байжээ. Ом үсэгтэй цагаан тал нь тэнгэр гэдгийг билэгдсэн хамгийн дээд хүндэтгэлтэй хэсэг байжээ.

- За биднээс ч юуны нь “ом” буюу тэнгэр нар гарах вэ дээ гэж Пагсан амандаа бөвтнөв. “Нээрээ ч тийм дээ. Бидэн шиг юм яаж тэнгэртэй дүйх билээ” гэж Санж бодлоо.

Эх болсон зургаан зүйл амьтны оройн дээд нь тэнгэр нар бөгөөд тэднийг “ом” гэж томъёолно. Түүний дараах нь асар нар бөгөөд “ма” гэж тодорхойлно. Гурав дахь нь “ни” буюу хүн. Дөрөв дэх нь “бад” буюу адгуус, тав дахь нь “мэ” буюу бирд, зургаа дахь нь “хум” буюу там юм. Цөмөөрөө нийлээд “ом маа ни бад мэ хум” гэсэн маанийн зургаан үсэг болно. Энэ зургийг буддагийн бүхийлэн шавь нар амны уншлага болгоно. Жирийн үгээр хэлбэл “тэнгэр, асар хүн, адгуус, бирд там” гэсэн уншлага юм. Ийм үгийг хэдэн зуун мянган лам нар өдөр бүрий амны уншлага болгож байдгийг эргэцүүлэн бодоод

Санжийн инээд хүрэх шиг болов. Бурхны номын тухайд анх удаа л инээд нь хүрсэнд тэр өөрөө ч гайхлаа.

“Харь хэлээр л хэлдэг болохоор эгэл монгол хүмүүс ойлгож ухаардаггүй байх. Түүнээс биш “тэнгэр, асар, хүн, адгуус, бирд, там” гээд л аман дотроо уншаад суугаад байхыг чагнахад гажигтай ч юм шиг санагдах биш үү? гэж Санжид бодогдлоо.

“Тэнгэр нарны оронд тэнгэрүүд сууна. Асрын оронд асар, хүний оронд хүн, адгуусны оронд адгуус, бирдийн оронд бирд, тамын оронд эрлэг чөтгөрүүд сууна. Энэ бол эх болсон зургаан зүйл амьтас мөн. Тэдгээрийн тусын тулд лам хүн мөргөл бясалгал үйлдмой!” гэж лам багш нь үргэлж сурган заасаар цээжлүүлснийг Санж ямагт санаж явдаг билээ.

Хүрдийг аажмаар эргүүлэхэд гол нь үл мэдэг чихран гунигтай дуугарч, зиндааныхан нь нэг үе дуугүй болцгоож өөр өөрийн талд оногдсон маанийн үсэгний тухай эргэцүүлэн бодож байх шиг дүнсгэр байлаа.

“Эх болсон зургаан зүйл амьтан л гээд яриад байдаг. Гэтэл тал хувь нь огт байхгүй юм шиг вэ дээ? Бирдийн орон гэж ер нь бирд гэж ямар амьтан байдаг билээ. За тэнгэр, асар нар гэдэг нь бас ямар билээ?” гэж гэв гэнэт Санж эргэцүүлэн бодлоо. Энэ тухай нутагтаа байхдаа лам багшаасаа асууснаа санах Ийм юм бодох нь хүртэл нүгэл. Асуусан нь бүр их алдас!” гэж багш нь сургажээ. Тэр цагт гэмшиж өнгөрсөн.

Сүүлд бас тамын орон гэгчийн тухай лам багшаасаа зориглон асууснаа санах. “Үхэж төрөл арилжсан хойноо муу заяатай хүн тамд унадаг юм. Тэгэхээр тэр орныг амьд сэрүүн үедээ үзсэн хүн нэг ч үгүй. Буянтай зарим нь үхсэн хойноо ч үздэггүй зүйл. Ийм юмыг хэтэрхий сониучилж хэрэггүй. Ер нь бурхны номонд юу л бичсэн байна вэ, түүнийг үг дуугүй, эргэлзэн бодох юмгүй шууд л сүслэн дагах учиртай. Өчүүхэн төдий эргэлзэн өөр юм бодож эхэлбэл буруу даваагаар орж, буруу номтны сүрэгт нийлнэ. Илүү дутуу юм битгий

асууж бай. Нүгэл, алдас” гэж багш нь тэгэхэд сурган заасан билээ. Түүнээс хойш илүү дутуу юм багшаасаа асуухаа бүр больж билээ.

Өнөөдрийн энэ нэгэн нарлаг өглөө яагаад ч юм бэ, Санжийн сониуч сэтгэл дахин сэргэж, элдвийг эргэцүүлэн боджээ. Ер нь Лхасад эрдэм сурахаар ирснээс хойш үе үе ийм явдал түүнд тохиолдож байлаа. Тэр болгонд асуулт буй болж, асуултаа тавих бүрийд буруудаж байлаа. “Одоо бодохноо нь дандаа л лам багш нартаа асуулт тавьж буруудаж явжээ. Ер нь зиндааныхандаа тавьж болдоггүй юм уу?” гэж Санж бодов. Ном, амьдрал хоёр зөрөөтэйд гайхжээ.

- Пагсан андуу чамд асрын орны уншлага таарчээ. Тэгээд чи хэзээ асар нарт очих юм бэ? гэж Санж тохуурхах маягтай асуулаа. Пагсан гэдэг андуу нутгийн тэр түвд залуу Санжийн үгэнд асар их уурлан дургүйцэх шиг боллоо. Угаасаа ч тэд бие биендээ тал өгч сураагүй болохоор ийм хүйтэн үгнээс юунд ч хүрч болно гэдгийг тооцоолсонгүй бие биеийг өдсөн ажээ. Чогсон тэр өдөлтийг нь ашиглан,

- Азтай л өдөр болоод Пагсан андууд асар нарын билэгдэл таарчихжээ. Түүнээс биш, түүнд минийх солигдоод оччихсон хэрэг байлгүй гэж ёжлов. Санжийн инээд хүрлээ. Санж Пагсанд асар нарын уншлага, Чогсонд бирд нарынх буюу “мэ” таарчихсанд эгдүүцсэн байлаа.

- Миний мөн чанар асар юм чинь аргагүй энэ уншлага таарлаа. Харин Санж чамд хүн төдийгөөс цааш юм таарсангүй. Чогсонд бол бүр бирдийн уншлага тохиож яг л сав, савандаа байгаа юм биш үү? гэж Пагсан гашуунаар ёжлон хэлэв. Энэ үг тэр нэгэн зиндааны хэдэн залуугийн дунд дарь авалцуулах мэт нөлөө үзүүлжээ. Хүрдэн дотор тэд зодолдож эхлэв. Тэдний зодооны хөлд чирэгдэхээс болгоомжилж хоёр гурван өвгөд эмгэд арайхийн гадагш гарлаа.

Тавуулаа байсан бөгөөд Санж, Чогсон хоёр нэг тал, нөгөөд бусад нь орж нударгалцаж эхлэв. Хүрдэн дотор явцуу зайгүй тул биесээ

онохоос өмнө хүрдний модон кина руу цохиж гараа шалбалах нь илүүтэй байлаа. Түвд газар нударгын зодоон их дэлгэрсэн болохоор тэд ном оурахын хажуугаар түүнийг ч бас сураад авчээ. Санж хүрдний бариулнаас атган автал тэр нь мултран ирэхэд түүгээрээ Пагсангийн шанаа руу гөвшиж орхив. Тэгтэл Пагсан шалхасхийн муужирч уналаа. Энэ мөчид л тэд ямар хэрэг тарьснаа ухаарч цөмийнх нь дотор палхийж, хөсөр ойчсон Пагсанг өргөн өндийлгөөд зайгүй шахам хүрднээс чирэх тооны гаргаж ирэв. Тэгтэл цөмийн нь толгойд шуудай углагдаж юу ч үзэхээ болив. Гарыг нь хүмүүс хүлж ууц нуруу руу нь хайр найргүй цохилж нэгэн тийш түрж эхлэв. Тэднийг зодолдож эхлэхийг мэдээд номхотгогчид ирсэн нь тэр ажээ. Толгойд нь шуудай өмсгөөд юу ч үзэхгүй болгомгоц гары нь хүлж хүнийг биригчлэхдаа түвдүүд гарамгай билээ.

- Гяндан руу аваач! Бурхны шавь нар байж, бурхны шүтээн дотор зодолддог яасан муу ёрын нүгэлтэнгүүд вэ? гэж хэн нэгэн хүн загнаж байхыг Санж сонслоо. “Пагсан юу болсон бол. Арай чангадуулчихлаа” гэж Санж дотроо харамсан бодлоо.

- Үхдэлийг аваад яв! гэж нөгөөх хүн тушааж байхыг сонсоод Санжийн дотор палхийжээ. Пагсанг үхэж гэж бодоход туйлын ихээр харамсан гэмшлээ. Нүгэл хийснээ ухаарлаа.

Тэднийг Лхасын гянданд тэр даруй хүргэв. Толгойд нөмөргөсөн тааран уутыг авахад нь эргэн тойрныг ажиглавал чийг ханхалсан бүгчим харанхуй чулуун нүх шиг юманд тэднийг хийчихжээ.

Эргэн тойронд юу ч байсангүй. Дэвсгэр ч үгүй хонгил байжээ. Харин тэднийг цөмий нь нэг дор оруулсан нь зол байлаа. Тэд хэсэг чимээгүй байснаа,

- Пагсан андуу яасан бол? гэж Санж санаа зовохын эрхээр асуулаа.

- Бүү мэд! гэж бараг л цөмөөрөө гайхан эргэлзлээ.

- Үхсэн байх аа! Үхдэлийг аваач! гэж байхыг би сонссон! гэж Чогсон хэлэв. Цөмөөрөө харамсан хямарлаа.
- Үхсэн бол Санж чи л алсандаа. Намайг харсаар байтал шанаа руу нь чи хүрдний бариул модоор гөвшчихсэн шүү дээ! гэв.
- Тэгэх нь ч тэгсэн. Гэхдээ аяархан л цохих шиг болсон доо. Арай үхчихмээргүй юм гэж Санж гайхазнав.
- Андуугийн Пагсан байхгүй болсон бол Санж чи л Түвдэд ясаа тавина даа гэж Чогсон хэлэв.
- Нээрээ л тэгнэ дээ! гэж Санж сүүрс алдан гунигтайяа өгүүллээ.
- За ийм муу юм зөгнөхөө больё. Өөр юм ярьцгаая гэж нэг нөхөр нь тэдний сэтгэлийг засах үг хэлэхэд цөмөөрөө сэхээ авч хэсэг зуур дуугүй сууцгаалаа. Хажуугийн шоронд хэн нэгийг тарчлаан зовоож байгаа бололтой муухай чарлах дуун сонсогдлоо. Тэд цочирдон гайхлаа. Урьд өмнө нь гянданд сууж байгаагүй болохоор тэдэнд энэ шинэ орчин их л аягүй байлаа. Хажуугийн шоронгоос чарлах дуун нэг үе чангарч, нэг үе суларч сонсогдсоор байлаа.
- Биднийг бас л ингэх байхдаа гэж хэн нэг нь хэлэв.
- Лав л давстай саваагаар далан тав савуулах тийм дайллаганд орох бийвий гэж нэг нь шоглов.
- Тохуурхалтгүй үнэн дээ. Зөвхөн Лацысагийн хаалгаар гэм буруугүй мөртөө шагайсан хүнийг л арван дөрвөөс доошгүй саваадаад дараа нь хэрэг зоригийг асуудаг шүү дээ. Гэтэл бид яасан бэ? Хүрдэнд зодолдсон. Бас аягүй бол нэгийгээ алсан...
- Дэмий юмнаас маргалдсандаа. Хэнд ямар маань ноогдсон юм падгүй юм байсан л даа.

- Пагсан андуу үхчихсан бол яанаа!

- Тэр уул нь гүжирмэг монгол маягийн эр юмсан.

- Сэхэж л үзээсэй билээ. Ямар сайн байх вэ?

- Өлсч эхэллээ гэхчилэн тэд хоорондоо завсар зайгүй ярьцгаалаа. Өөр хийх ажилгүй юм болохоор ярих тэнхээгээ тасрах хүртэл үг солицгоох бололцоотой байлаа.

- Үгүй ерөө. Энд чинь бас нэг хүрд байж байдаг юмаа гэж Чогсон гэнэт хэлэв. Тэд гайхан ажиглавал шоронгийн харанхуй мухар хананд хонхорхой гаргаад дээр нь бяцхан зэс хүрд тавьсан байхыг үзэцгээж тэд гайхлаа.

- Гянданд хүртэл хүрд байхад ч бурхны номыг бид яаж мартаж вэ? Энд бас л хүрд эргүүлж болдог байжээ.

- Одоо үүнийг чинь эргүүлж л зугаагаа гаргацгаая даа!

- Дахиад зодоон үүсэхийн нэмэр. Больёо таминь! гэж тэд ярьцгаалаа.

Түвд газар хамгийн элбэг юмны нэг нь хүрд болно. Өчүүхэн жижгээс эхлээд асар томыг хүртэл модноос эхлээд зэс, гууль, мөнгө алтан хүртэл хүрд бий билээ. Тэднийг гараар эмрэн эргүүлж, маань мэгзэм унших хүнд ажлыг хөнгөлдөг болно. Уншлагыг түргэтгэн хөнгөвчилсөн хэрэг. Гэвч бас усан хүрд, салхин хүрд зохиожээ. Урсгал усны хүчээр тээрэм адил эргэж байнга хөдөлгөөнд орших хүрд, бас хавтгай даавуун дээр олон зуун маани бичээд дарцаг адил салхинд хийсгэж байдаг салхины хүрд бий. Түвдийн түргэн урсгалт голууд дээр, салхин зам болсон уулын хөндий, шавар, тагз, сарлагийн савган банагийн орой дээр тэрхүү хүрднүүдтэй олонтаа тохиолдож болно. Тэр бүхэн дээрээс “Ом ма ни бод мэ хум” буюу “Тэнгэр, асар, хүн, адгуус, бирд, там” гэсэн үгсийг л уншиж болно.

- Энэ гянданд ах маань бие барсан юмдаа, хөөрхий! гэж түрүүнээс хойш дуугүй суусан Пагва дуу алдав. Энэ үг цөмийнх нь сэтгэлийг хөнджээ. Цочирдон гайхсан найз нар нь зовнив.

- Яагаад энд нас барсан юм бэ? гэж Чогсон гайхан асуулаа. Пагва санаа алдан,

- Бирдэнд баригдаж үхсэн юм гэнэлээ гэж хэлэхэд цөмөөрөө цочлоо. Энд бирд байгаа юм гэж санасангүй.

- Яагаад?

- Яахав? Тэр л хүрдний цаахна өнцгөөс хэдэн түмэн дигваранз, хилэнцэт хорхой гарч ирсэн юм гэнэ лээ. Ахыг маань чармай нүцгэлээд ганцаарангий нь энэ гянданд хаячихсан юм гэдэг. Тэгээд тэр олон өлсгөлөн дигваранз, хилэнцэт хорхойнууд ахыг минь амьдаар нь сорж дуусгасан юм гэнэлээ.

- Яагаад тийм олон хорхой шавьж гарч ирсэн юм бол?

- Яахав дээ! Тийм хорхойнуудыг тусгай газар хорьж өлсгөж байгаад ялтан руу тавьдаг гэж ярьдаг, тэр үнэн байх.

- Бас өлсгөлөн үхэр хулганыг тавьдаг гэсэн үг байдаг.

- Яагаад амьд амьтныг өөр хооронд ч егүүтгэлцүүлдэг юм бэ?

- Эх болсон зургаан зүйл амьтны тусын тулд гэдэггүй билүү!

- Тэр ч маанийн үг болохоос амьдралын үг биш байхаа!

- Ах чинь тэгвэл их нүгэл хийсэн хүн байж л дээ?

- Ах юун нүгэлтэй байх вэ? Лам багшийн зулын шар тосыг өлсөхдөө уучихсан юм гэнэлээ. Асаастай зулыг үлээчихээд л хайлмаг тосы нь

уучихсан гэдэг юм. Түүнийг их том нүгэл гээд л ахыг маань энэ шоронд хаячихсан гэж эгч ярьж байсан. Тэгээд л удалгүй энд хилэнцэт хорхойнд бариулсан юм. Эгч надад энэ шоронд гэж тэр жил зааж өгсөн... гэж Пагва хэлснээ мэгшин уйллаа. Цөмөөрөө сэтгэл хямралдаж дуугүй болцгоолоо.

Саяхан гяндангаас гарч цэрэгт татагдсан Бөхмагнайн тухай Санж бодлоо. Тэр одоо хаана яваа бол гэж гунигтайяа дурсав...

Харанхуй болж эхлэв. Тэд хүрдтэй булангаас зэвүүрхэж, бие биендээ наалдан нөгөө буланд шавааралдан сууцгаав. Тэр өнцгөөс ихэд бишүүрхэцгээж байлаа.

Гэвч тэр шөнө амгалан өнгөрлөө. Маргааш нь зодолдсон лам нарыг шоронгоос хөөн гаргаж,

- Дахиад нүгэл хийж энд ирвэл хохь чинь шүү. Багш лам нар чинь өмөөрөөгүй бол та нар үзээгүйгээ үзэж үхэр цамаа харайх байсан... гэж хуяг заналхийлжээ.

Пагсангийн толгойд модоор гөвшсөндөө Санж бишүүрхэн зовж, түүнийг ямар байдалтай байгааг мэдэхийг юуны урьд хүслээ. Пагсан духандаа шарх олжээ. Гэвч амь нас нь бүрэн бүтэн байлаа. Санж сарлагийн махаар бууз хийж хайруулдсан цай бэлтгээд Пагсанг шавар тагзанд нь очиж эргэхээр шийджээ. Пагсан түүнд их баярлав. Тэр Санжийн хоол, хүнсийг амтархан идэх зуур,

- Хүний сайныг ханилж мэддэг юм. Гэхдээ чи намайг нөхөр гэж боддоггүй л биз. Би зөөлөн найланхай байж чаддаггүй, өндөр уулын зэрлэг омгийн хүн шүү! гэв. Санж түүнийг үнэнээ хэллээ гэж боджээ. Ингэж нэгэн зиндааныхан хоорондоо эцсийн удаа нүдрага аөрүүлэлцээд дахин эвлэрэв. Түүнээс хойш тэд зодолдох, гадуур тэнэхийгээ бараг бүрэн хязгаарлав. Ном хичээл нь ч хүндэрч, жавдан дээрээсээ ч салахгүй шахам сууцгаадаг болжээ.

Өдрүүд хойно хойноосоо цуван өнгөрч, судрууд лам нарын гар дамжин ээлжилсээр байлаа. Кайб жүмнейн даягаас эхлээд бараамидууд, мадьяамагам, абидармын ёс, винай, тарина, вишнугийн ялгал ёсыг судлан өнгөрлөө. Алтангэрэл, Бадамхатан, Жадамба судруудыг цээжлэн дуусгаж, гүрмийн номыг үзэв. Дээр нь бас бодь зүгийн гучин хоёр номыг ч зав зайндаа үзлээ. Самгарьд, бамгаал, сингаал, түвд хэлийг оролдон номын дуудлагаар сурав. Түвд хэлийг бол өөрийн төрөлх монгол хэлнээс дутахгүй эзэмшлээ. Сүм хийдийн нэгэн жигдийн сонирхолгүй амьдрал өдөр сар, жилээр ээлжлэн чимээгүйхэн урсан өнгөрч байлаа. Ноднин болсон явдал энэ жил давтагдсаар... .

Сүргийн дотор сэтэр зүүж амиа дархлуулсан сэрх ямаа шиг Санж зиндааныхан дотроо их юм мэддэг, ухаалаг, төлөв хүн гэгдэж төвийн магтагдах боллоо.

Нутгаас нь хүмүүс Алашад гарсан хуйхуйгийн бослогоос болж ирэхээ больжээ. Бөхмагнай төвдийн цэргээс оргож уулын дээрэмчин болсон сураг гарчээ. Отгон хүүхний дүр Санжид үе үе харагдах боловч дахин мөргөл хийхээр ирсэнгүй. Сонирхолгүй нэгэн хэвийн зургаан жил дахиад өнгөрөв. Нутаг орноосоо бүрэн тасарч түвд амьдралд дасаад бараг л монгол төрхөө гээлээ.

Хорин гурав. Ном хаялцан цоорсон нь

Айраг цагаан ч архи нь хар

Цас цагаан ч ус нь хар

Цаас цагаан ч бичиг нь хар

Лхас зуугийн Бэрээвэн хийдийн үүдэнд Лхаарамбын ном хаялцах тэр онцгой өдөртэйгээ нэг л мэдсэн Санж золгох болчихжээ. Маргааш лхаарамбын ном хаялцана гэхээс үнэмшигдэхгүй байлаа. Хэзээ энэ оронд ирснээ эргэн санавал яахын зуургүй л нэгэн аравжингийн нэг мөчлөг хэдий нь өнгөрчихсөн байлаа. Хорь эргэм настай банди ар газраас ирсэн тэр өдөр санааны үзүүрт алслан бүдгэрчээ. Алтадмал үйсэн малгай өмсөх эрхийг олж, арван бэрхэт буюу гавж цолтой нэгэн болоод төрсөн нутгийн барааг харах ойртож байлаа. Одоо тэр Лхас зуугийн их дуганы үүдэн дээрх дэвжээн дээр гарч Түвд орны мэргэд лам нарын өмнө ном хаялцахыг завдан байна. Ном хаялцан цоорч чадвал лхаарамба цолыг олж, бурхны энэхүү оронд зорьж ирсэн хэргээ бүтээнэ. Алс тэртээ зүүн хойт зүгт хэдэн мянганы цаана баруунаас өмнийг чиглэн цэнхэрлэх Хар азрагын нурууны Чачран голоор нутаглах эдүгээ их л насжиж ядарсан хайрт эцэг Сайнцогт, энэрэлт эх Цэндээгийн бүх л насны мөрөөдөл, итгэл найдварыг тийнхүү гүйцээгээд нутаг юугаа зорин буцахад болно. Юу олж аваад буцах тухай бодож байгаа билээ гэж гэнэт Санж гавж өөрөөсөө асуулаа. Өөрийнхөө асуултад тэр өөрөө хариулахдаа их л ядардаг заншилтай болжээ. Өөрөөсөө өөрөө хариулж чадахааргүй тийм асуулт асуудаг болж эхэлсэн нь гавжийн дамжаа барьснаас хойш юм.

Гавжийн дамжааг сайн барьснаас хойш илэрхий аймаг сав, судрын аймаг сав, винайн аймаг савыг үзэн дуусгаад зурхай таринын номыг гүйцээжээ. Оточ маналын ухаан, орон хийдийг босгох ёсон хоёр Санж гавжийн илүү сонирхдог ном болсныг зиндааныхнаас Чогсон найз нь илүү сайн мэдэж байлаа. “Чээжийг минь бүрэн бэтгэртэл дүүрсэн хоосон чанарын номоор хөөрхий эцэг, эх хоёр юугаа хийнэ дээ. Харин

билэг чанарын ном үзэж, мэс засал, инжаан, тунжааны талын юмаар эв дүйтэй болвол арай дээргүй юу?! гэж Бэрээмэг эмгэн амьсгаадсан сөөнгө дуунаар хэлээд гар дээр нь насан хутаг болсныг энэ мөчид дахиад л Санж эргэн саналаа. Хэдхэн жилийн өмнө тэр эмгэн ертөнцийг орхисон. Түүнээс хойш Санж их л өнчирснөө байнга мэдэрч байлаа. “Аниг Гомбоодоо очиж босгоор нь алхаад л нүд аних юмсандаа!” гэж Бэрээмэг эмгэн хичнээн ч олон удаа санаашран хэлж байвдаа. Тэр бүхнийг нь гүйцэлдүүлж амжилгүй түүнийг насаа юүлэхийг нь харсандаа Санж ихэд гэмшдэг байлаа. Хэдэн жилийн өмнө анх удаа Бэрээмэг эмгэнийг тэгж хэлэхэд нь Санж их гайхаж билээ. “Аниг Гомбоо гэж өвгөн нь л юм байх даа. Хаана байдаг юм бол?” хэмээн удтал эргэлзэж билээ. Тэгээд нэг удаа тэсч чадсангүй “Эмээ, Аниг Гомбоо гуай хаана суудаг юм бэ? гэж асуучихсан чинь Бэрээмэг эмгэн элгээ хөштөл инээж билээ. “Их хол бий!” гэсэн хариугаар Бэрээмэг эмгэн инээдээ барьсан юмсан. Түүнээс хойш Санж тэрхүү Бэрээмэг эмгэний өвгөн нь Аниг Гомбоо гэдэг хүн байдаг гэж бүрэн итгэчихжээ. “Яаж энэ хөөрхий эмгэнийг алс хол байгаа өвгөнтэй нь уулзуулдаг юм билээ дээ?” гэж үе үе бодох боллоо. Тэгтэл нэг их удсангүй Бэрээмэг эмгэн хэвтэрт оров. Өдөр хоногоор бие нь муудаж эхлэв. Санж аргаа барахдаа Пүрэвдоной маарамбыг нэг өдөр залж гэртээ аваачсан чинь Бэрээмэг эмгэн чиндээ тултал уурлаж, маарамбыг хөөн гаргажээ. Бэрээмэг эмгэн,

- Жор мэддэг ламаас зовлон үзсэн чавганц дээр гэж үгтэй юм. Энэ өл халзан маарамбаар юугаа хийнэ? гэж уурлав.

- Сайн маарамба гэдэг болохоор л таныг эдгэрүүлэхээр залсан юмдаа гэж Санж хэлтэл Бэрээмэг эмгэн бүүр ч уурлаж,

- Маарамба, дооромбод би сүжиг буурсан хүн. Хоосон чанарын номоор бэтгэрчихсэн амьтад байдаг юм. Маарамба залсанд орвол чи надад ээгий мөөг нэг ширхэгийг олоод өг! гэж шаарджээ. Санж тэр мөөгийг олохыг завдан зах руу явах болсонд эмгэн,

- Ээгий мөөгийг Энэтхэг газраас авчирдаг юм. Пибүүнэрээс хай! гэж

захив. Санж тэр дороо зах орж цагаан орхимж нөмөрсөн пөбүү нар буюу индүүсүүдийг хайж олоод ээгий мөөг гэгчийг сурагласаар байж хоёр гурван ширхэг мөөг олж авчирсан юмсан.

- Ашгүй энэ мөөг чинь л надад тус болно. Түүнээс биш түмэн маарамба байгаад нэмэргүй гэж Бэрээмэг эмгэн баярлаж билээ. Тэр мөөгийг усанд угаагаад нэг аяга сүүн дотор хийж хэдэн цаг өнгөрөхөд сүү нь аяндаа тараг болон бүрэлдэж орхидог ажээ. Бүрэлдсэн таргийг уугаад дахиад л сүүнд хийж тавихад тэр сүү мөн л тараг болон бүрэлдэнэ. Ийнхүү Бэрээмэг эмгэн хэдэн сарын турш гагцхүү ээгий мөөгөөр бүрсэн таргаар хооллож бие нь нэлээд хөнгөрч ухаан санаа нь саруул болж билээ. Бэрээмэг эмгэн,

- Намайг жижигхэн хөхөл сонжуутай охин байх тэр эртийн цагт юмсан. Хөөрхий эх минь нас эцэслэхийнхээ даваан дээр надад захиж билээ. “Одоо эх чинь тэсэшгүй нь бололтой. Охин чамд минь хань түшиг болох хүн байхгүй. Эцэг чинь бурхны орон хүрэхээр гурван жилийн өмнө Түвд рүү яваад сураггүй болсон. Мөргөлчин дагаж Түвд орвол эцэгтэйгээ уулзаж юун магад. Эцэгтэйгээ уулзвал Утай, Гүмбум, Лхасын их бурхан шүтээнд мөргөж, эхийнхээ төлөө буян үйлд” гэж хэлээд зэс гуутай сахиусаа эх минь надад хүзүүнээсээ авч өгсөн юмсан. Тэгээд л хөөрхий эх минь өнгөрсөн. Би гэдэгамьтан эхийн захиснаар мөргөлчин дагаж, түмэн газрыг туулан бурхны орон гэгдсэн энэ Түвд газар ирж билээ. Түүнээс хойш яг жаран жил, нэг равжун өнгөрлөө. Эцгээ ч олсонгүй. Буян ч үйлдэж чадсангүй. Нэг биеэ элээж дууслаа. Сүүлд Халх мицааныхнаас эцгийнхээ сургийг гаргасан. Эцэг минь ойлон толгойтой хүн байжээ. Түүнд нь түвдүүд шунаад хөөрхий эцгийг минь бүрэлгэж орхисон юм гэнэлээ. Эцгийн гавлын ясаар аяга хийж Лавран хийдийн хамбад оргөх гэж тийм муухай хэрэг хийснийг мэдээд надад Түвд газар ариун нандин юм байхгүй болж, гутрахын эрхэнд шимнанцын сахил хүртээд Аниг Гомбоод суусан юм даа” гэж ярьсан үг болгон нь Санж гавжийн чихэнд одоо ч тодхон сонсогдох шиг болж байлаа. Гашуун хувь тавиланг эдэлсэн тэр эмгэн санамсаргүй тохиолдлоор Санжтай уулзаж, түүнийг үхлээс авраад, дараагаар нь олон жил тогоогий нь

барьж төрүүлсэн эх шиг нь ижилдсэн юмсан. Ядуу, эгэл тэр эмгэний хал үзэж, хашир таньсан ухаалаг сэтгэлийг Санж биширч явдаг байв. Бас оровдөн хүндэлдэгсэн.

Ээгий мөөгөөр бүрсэн тарагны хүчээр Бэрээмэг эмгэн хэдэн сарын турш биеэ эзэмдэж байлаа. Тэгээд нэгэн өдөр Санжийг дуудаж, Би ч тэсэхгүй нь шиг байна. Чамд сүүлчийн үгээ хэлье. Чиний багш Чоймчиг гэлэн гэж байсан биз? гэж асуухад нь Санж гэнэт цочирдон хамаг бие нь чичрэх шиг болов. Олон жилийн тэртээ зулын гал болон “хайлсан” багш ламынхаа нэрийг гэнэт тэрхүү эмгэнээс сонсоно гэж огт санаагүй явжээ. Бэрээмэг эмгэн цааш нь,

- Багшийн чинь тухай би сонссоон. Тэгээд чамайг эрж олсон юм. Ашгүй чи багш шигээ сайн хүн болжээ... гээд чимээгүй хэсэг зуур бодпогоширсноо,

- Багш чинь чамд юу ч захиагүй юу? гэв. Санжийн сэтгэлд сая л бүдэг бадаг юм орж ирлээ. Тэр нэгэн түгшүүртэй харанхуй шөнө лам багшийн захиж байсан үг нэг нэгээрээ сэргэн тодрох шиг болон, “Багшийг чинь хэн нэгэн хүн сураглавал үүнийг өгөөрэй” гэж захисан нь сая л санаанд орлоо. Санж сэтгэлээ барьж ядан,

- Багш лам минь буян үйлдэхийнхээ өмнөхөн надад нэг жижигхэн боодолтой юм өгөөд “намайг сураглаж асуусан хүнд өгөөрэй” гэж захисан юм. Тэр нь та юм уу” гэж асуулаа. Бэрээмэг эмгэний царайд ер бусын гэрэл гэгээ тусах шиг болж, өнгө орон туяарахыг Санж ажиж мэдэв. Эмгэн өвчнөө таг мартан өөрчлөгдөв.

- Тэр нь би мөөн! Багш ламтай чинь уулзаж чадаагуйдээ би гомдолтой байна. Бид хоёр уул нь Аниг Гомбоод уулзах учиртай байсан юм. Чадсангүй. Хувь тавилан тийм байж л дээ. За яая гэх вэ? Багш ламынхаа өгсөн юмыг чи надад үзүүлээч! гэж Бэрээмэг эмгэн үгээ зөөн хэлэхэд Санж ухасхийн босч гүнгэрваан дотроос жижигхэн боодолтой юмыг олж авчирлаа. Гар нь чичрэхийг өөрөө мэдэж, багш ламыгаа дурсан бодлоо. Тэгээд Бэрээмэг эмгэнд түүнийг хоёр гардан

барилаа. Эмгэн түүнийг мөн л хоёр гардан авахдаа мойног хуруунууд нь хоорондоо эвлэхгүй чичирч байхыг Санж ажиглав. Эмгэн нөгөөх зүйлийг духандаа хүргэн адис аваад хоёр нүдээ анин хэсэг зуур бодлогоширлоо. Холын юмыг дурсан бодож, огт өөр ертөнцөөр тэр аялж байх шиг, өвчинд нэрвэгдсэн биеэ мартчихсан мэт болжээ. Тэгснээ хоёр нүднээс нь нулимс мэлмэрэн гарч үрчлээт хацар дээгүүр нь мэлрэн урсав. “Та намайгаа өршөөн соёрхоорой” гэж эмгэн аман дотроо бараг дуулдахгүйгээр шивнэн хэлэв. Лам багш Чоймчиг гэлэнд нь хандан хэлж байгааг Санж ойлголоо. Эмгэн тийнхүү нэлээд удсанаа,

- За хүү минь энэний баримтийг тайлаад харуулаадхаач! гэж гуйлаа. Санж тэр боодолтой юмыг хичээнгүйлэн нээж эмгэнд харуулав. Хааш хаашаа хоёр цүнгийн хэмжээтэй дөрвөлжин алт ажээ. Дээд талын хавтгай дээр очир шиг юм зуржээ. Эмгэн түүнийг илж үзсэнээ дахин бас духандаа хүргэн адис аваад,

- За үүнийг очир зураастай талаас нь тэг дундуур нь хуваагаад нэг хэсгийг нь Аниг Гомбод өргөөрэй! Нөгөө хэсгийг баринтагт нь боогоод нутагтаа авч хариарай. Ямар нэгэн хүн үүнийг сураглаж ирвэл өгөөрэй! гэж захилаа.

- Аниг Гомбоо гэж хэн юм бэ? хэмээн Санж гайхан асуулаа. Сүүлийн үед Бэрээмэг эмгэн Аниг Гомбоо гэж их ярих болсон нь түүний гайхшийг төрүүлжээ. Аниг Гомбоо гэж нэг хүн байгаа юмаадаа хэмээн таамаглаж ядавч асууж зүрхэлсэнгүй билээ.

- Аниг Гомбоо гэж хүн бишээ. Амдоогийн оронд, манай нутаг орох замд Аниг Гомбоо гэдэг шимнанцын хийд байдаг юм. Тэнд миний хамаг залуу нас өнгөрчээ. Айдаа, шүүрс алдмаар юм! гэж Бэрээмэг эмгэн хэлснээ санаа алдаж, дахин бодлогоширлоо. Санж түүний сэтгэлийн зовлонг дэврээхгүйн тулд дуугүй сууж байв.

- Аниг Гомбоод эр хүн оруулдаггүй юм. Гэхдээ өргөл барьц өгөх гэсэн хүнийг хөөдөггүй. Санж гавж чи удахгүй ном хаялцаад лхаарамба цол

хүртэнэ. Тэгээд нутаг буцах биз. Тэр замдаа л Аниг Гомбоог дайрч өнгөрөөд миний захисныг гүйцээнэ биз. Зовлон үзсэн бүсгүй хүн Аниг Гомбоод сэтгэлээ тайтгаруулдаг юм. Ер нь тэр хийдийг үзээд орхиход илүүдэх юм байхгүй. Бурхны ухаанаас хүний ухаан илүүг би тэнд ухаарсан юм даа гэж Бэрээмэг эмгэн хэлээд нүд аньжээ. Энэ бүхнийг яагаад ч юм бэ ном хаялцаж, дамжаа барихын өмнөх өдрүүдэд Санж гавж дурсан санажээ. Бурхны гүн ухааны далайд гүнзгийрэн живэх тусам тэр далайн ус нь хөөс мэт хөнгөн юм шиг түүнд үе үе бодогдох боловч тийм бодлын сэжүүр гарах бүрийд "нүгэл, алдас болно" гэж цээрлэн өөрийн сэтгэл санааны гүнд хачин гайхмаар шимнус амилан төрөхөөс болгоомжилдог байлаа. Дамжаа барихын сүүлчийн бэлтгэл хийж байгаа энэ өдрүүдэд дахиад л сэтгэлийн шулмас босох аятай болсон нь түүнд эвгүй санагдлаа. Заримдаа нэг талаас линсрай гавж Лүндэгжунай, нөгөө талаас номгүй эмгэн Бэрээмэг хоёр ном хаялцаж, гэрчээр нь Санж гавж зогсож байх шиг ч санагдана. Өнөөдөр мөн тийм сэтгэгдэл төрснөөс уламжлан талийгаач Бэрээмэг эмгэнийг дурсан санав. Тэр эмгэн хар ухаанаараа их л гайхмаар юм бодож, ярьдаг байснаас Санжийн чихэнд хоногшиж, уламжлаад бодол санаанд нь нэвчсэн юм биш бизээ?

“Ийм юм бодож байснаас маргааш ном хаялцахад юу асуухаа билүүдсэн нь дээргүй юу?” гэж Санж өөртөө дахин шаардлаа.

Маргааш нь... Лхас зуугийн Бэрээвэний их дуганы өмнө олон лам нар цугларлаа. Ном хаялцаж, дамжаа барихад оролцохоор ирцгээжээ. Ном хаядаг дэвжээг засч бэлтгэсэн байв. Арван бэрхт гэдэг гавж цолтонгоос мигримба, жидримба, зогримба, егзөр, манрамбаас эхлээд маш хэтэрсэн буюу равжамба, лавран хийдэд ном хаялцаж ялсан доорамба, таринын номонд цайрсан аграмба, Лхас зууд ном хаяж ялсан төгсгөлгүй эрдэмт гэгдэх лхаарамба цолтонгуудыг хүртэл олон тооны эрдэмт лам нар цугларсныг хараад Санжийн зүрх үхэх шиг болж, гэрэвшин бишүүрхсэн байдалтайгаар чулуун дэвжээнд гарч очлоо. Алтадсан үйсээр хийсэн өргөн хүрээт цан малгайгаа, жанчтайгаа авч тавиад Санж эргэн тойрныг ажиглав. Олны дунд шивэр авир яриа дэгдлээ. Санж баруун гарт эрхээ барьж түр

зогссоноо зүүн, баруун алгыг хавсран ташихад хүмүүс таг чимээгүй боллоо. Тэр даруй зүүн гарын алгыг доош харуулан, барууныхыг дээш нь чиглүүлэн “дис” гэж чанга дуугарлаа. Зүүн гарыг доош унжуулан, алгыг газар чиглүүлсэн нь аливаа нүгэлтэн үржүүлэхгүйн тул тамын хаалгыг тагаллаа гэсэн дохио болно. Баруун гарын алгыг дээш харуулан өргөх нь урьд нүгэл хийснээр дахин төрөл арилжихдаа үүрэн гарсан гайт бүхнийг татан гаргахыг зөгнөжээ. “Дис!” хэмээн сануулах нь Манзширийн зүрхний таринийг урих эхлэл дуун юм. Ийнхүү үйлдэх нь ном хаялцахын хатуу тогтоосон жаяг ёс билээ. Ийм үйлдлийг хиймэгц ном хаялцахаар цугларсан лам нар таг чимээгүй болж Санжийн зүг гөлрөн ширтэцгээлээ. Сорин сонжих байдал илэрхий бүлгээ. Анхны асуултыг хэн бүхэн тайлж чадах хөнгөн юмаар гаргахаар Санж бодож байсан ёсоороо урагш нэг алхаж өмнө эгнээнд суугаа лам нарын нэгний өмнө очиж,

- Сансрын юм бүхэн угаас юунд бүтдэг вэ? Төрөн түгэхийн ёсноос гажуу нь юу вэ? гэж түвдээр асуулаа. Тэр лам залуухан хүн байлаа. Тийм л хүнд анхны асуултаа тавих зорилготой байснаа Санж биелүүлэв. Анхны асуулт амархан мөртөө хэн ч хариулж чадахгүй бол их учиртай байдгийг тэр туршлагаас мэджээ. Лам нар залуу тусмаа гүн ухааны номлол цээжилдэггүй, ухаардаг ч үгүйг Санж зиндааныхнаараа баримжаалан мэднэ. Асуулт авсан лам хий л ангалзан царай нь улайхыг Санж ажиглав. Тэрнийг хариулж чадахгүйг мэдмэгц алгаа дахин нэг удаа чанга ташаад уул асуултаа давтаж самгарьд хэлээр тавилаа. Самгарьдаар тэр бүр ч шонгүй нь тодорхой байлаа. “Хэрвээ энэ асуултыг тэр залуугийн хажууд сууж байгаа шүрэн улаан царайт равжанбаас асуусан бол ч дор нь л хариулах байсандаа” гэж Санж дотроо бодлоо. Ном хаядаг хүний нэг ашиг нь асуух хүнээ өөрөө сонгодогт байлаа. Царай зүсээр нь хэн болохыг таамаглаж, асуултаа тааруулахад боломжтой юм. Санж үүнд бас их олзуурхаж байв. Нөгөө лам самгарьдаар асуусныг самгарьдаар хариулах ёстой боловч юу ч хэлж чадахгүй нь илэрхий боллоо. Санж түүнийг хариулж чадахгүй байна гэдгийг олонд мэдэгдэхийн тулд баруун гарын алгаар зүүн алгаа нэг удаа чанга ташиж дохио өглөө. Тэгээд уул асуултыг түүнд гурав дахь удаагаа тавих ёстой тул сингал

хэлээр дахин асуулаа. Сингалаар ярихад нь ном хаялцахаар ирсэн лам нар дуу алдан гайхацгаалаа. Санж сингал хэлийг дөнгөж л гадарлаж байгаа тул олон юм ярьж чадахгүйгээ мэднэ. Гэвч ном хаялцахаар ирэгсдийн дотор шашны бурхны эрдэмд өндөр цол хүртсэн айхтар амьтангууд олон байгаа тул тэдний довтлох зоригийг бууруулах зорилгоор сингал хэлээр хоёр гурван асуулт бэлджээ.

Сингал буюу арслан тивийн тухай бурхны номд их гардаг боловч лам нар голдуу түвд, самгарьд хоёр л хэлээр эрдмээ зузаалдаг ажээ. Сингал хэлийг тэд төдий л ойшоодоггүй байв. Харин ч сангасваа нарын орон гэж их л дорд үздэг ч удаа байлаа.

Сингалаар байтугай түвдээрээ нөгөөх асуултыг хариулж чадаагүй залуу лам ялагдлаа хүлээлээ. Санж түүний ялагдлыг хүлээлгэсний дохио болгож баруун мөрөн дээр нь гараа хүргэв. Ингээд дараагийн хүний өмнө очиж асуултаа дахин тавилаа. Тэр нь нөгөөх шүрэн улаан царайт равжамба ажээ.

- Сансрын юм бүхэн угаас бурхны их хот мандалд бүтмой. Төрөн түгэхүйн ёсноос гажууд юм орчлонд үгүй боловч үзэгдэл сансрын юмс сэтгэлд алагдмой! гэж тэр лам түвд хэлээр ноттой хариуллаа. Лам нар цөм л дүнгэнэлдэн сайшааж байлаа. Нэгэнт асуулт нь хариулагдсан болохоор Санж түүнийг өөрчилж түүнээс ургуулсан шинэ асуулт гаргах ёстой болов. Равжамбатангийн хажууд бас нэгэн залуувтар лам байх тул түүнд хандаж,

- Бурхны чуулган хуран үйлдэх нь өндрийн язгуур олох буй. Буян түүний үр нь орчлонд эргэх мөн буюу. Хоосон чанарын ухаан бясалган үйлдэх нь нисванис бүхнийг барах, бурхны хутаг олох мөн буюу эсвээс биш буюу? гэж түвдээр асуулаа. Ламтан түүнд хариулж чадахгүй байлаа. Гурван хэлээр гурав давтан асуухад тэр үг хэлж эс чадав. Бусдын өмнөөс хариулах ёсгүй тул мэддэг нь халаглаж байлаа. Үүнийг ялагдсанд тооцож баруун мөрөнд нь гараа хүргээд дараах хүн дээр очив. Манримба цолтой нэгэн ажээ. Нэгэнт манримба болохоор эмчлэх эрдэм төгс гэсэн үг болно. Иймд түүнд мөн л таарах асуулт

өгвөл зохино. “Лхантавчимбаас асуудаг юм уу, эсвэл чимейжитээс уу?” гэж Санж дотроо эргэлзэн бодлоо. Отчийн таван ухаан буюу шажоот (эрхтэн шинжих), жажоот (эмгэг судлах), манаажот (яс барих) чимейжит (эм барих) лхантавчимба (дотрын эмнэлэг) эдгээрийг Санж их сонирхон судалж, сайн мэддэг болсон байлаа. Мянга мөч, таван цул, гурван хүрд, арван хоёр судас, таван оньсын тухайд мэдэхгүй юмгүй болжээ. Харин эмгэг судлах, ялангуяа долоон тамир доройтохыг эмнэхдээ арай дутмаг, яс барих буюу манаажотын ухаанд тааруу байв.

- Хүчээр идэгчийн арван нэгэн чадалтнаас лүнтэбадгасүмд юу хэрэг болох билээ? гэж Санж хамгийн энгийн шахам зүйлийг сингал хэлээр асууж орхисон чинь нөгөөх маарамба тэр хэлд тааруу байсны улмаас ч юм уу хариулж чадсангүй. Лам нар дургүйцэх мэт дүнгэнэлдэх нь сонсогдлоо. Манримба тэрээр олонд их алдаршсан хүн байлаа. Гэвч сингаал хэлээр асуулт ирнэ гэж бодоогүй явжээ. Юу ч ойлгоогүй тул гурвантаа давтахад хариу хэлсэнгүй. Тэгэхээс тэгэх гэж сингаалаар л асуугаад байжээ. Хэд хэдэн лам ном хаялцахаас татгалзан гарч явлаа. Тэд дургүйцлээ ингэж илэрхийлжээ.

Асуултын дараах тохиол нь жинжээ лам Жалсанд дайралдсанд Санж их гайхлаа. Гэвч алгаа хавсран чанга дохио өгмөгц өндөр дуунаар,

- Кшатрий ба брахмаан, вайшья ба шудра мөн Васеттха тэргүүтэн долоон жаяг дотор бие, сэтгэл, явдлаа барьж чадвал энэхүү амьдралдаа юу болохсон бол? гэж асуув. Жалсан жинжээ хэнгэрэг цан, бүрээ бишгүүр, дамар тунраагаас өөр юм мэдэхгүй мөртөө ном хаялцахаар ирсэнд нь Санж гайхжээ. Гэвч хүнийг бүү бас гэдэг эртний сургаал ёсоор биеэ барин “Лхаарамбад тавих асуултыг жинжээд тавих ч гэж дээ” хэмээн бодлоо. Жинжээ лам хариулж чадсангүй. Хариу нь хоёрхон л үг хэрэгтэй гэдгийг ч ихэнх лам мэдэж байжээ. Ийнхүү ном хаялцах нь талцам, зэнцам гэдэг нотлох, няцаах хоёр ээлжлэн түүнийг нэгтгэн цогломдох тэргүүтэн хосолж үдээс өмнийн турш үргэлжиллээ. Ихэнх асуудал нь хариугүй үлдсэнд Санжийн сэтгэл өег байлаа. Ном хаях ажлыг төдий л анзаарч

бэлтгээгүйдээ Бэрээвэн хийдийн том толгой лам нар таа муутайхан байлаа. Юунд тэрийг Санж мэдсэнгүй.

- Ном хаялцаж цоорон гарсанд баяр хүргэе! гэж аль хэдийний долиггор зантай Чогсон нялуухан дуугаар баяр хүргэлээ.

- Төгсгөлгүй эрдэмт буюу лхаарамба цол өгөхөд боломжтой хүн ойрдоо гараагүй. Энэ монгол яагаад ийм сүрхий болов? гэж Бэрээвэн хийдийн гяргачуул хоорондоо ярьж байхыг Санж бас чихнийхээ үзүүрээр сонсоод авлаа.

- Билгийн их халуун очоор асар атгагын зөөлөн хур буухыг ерөндөглөнө! гэж нэг хүн чихэнд нь шивнэв. Эргэн харвал Пагсан байлаа. Тэр ер баярласан шинжгүй, харин ч уурлан дургүйцсэн мэт царайтай харагдлаа. “Энэ Пагсан яасан атаархуу амьтан бэ? Зиндааныхан маань цөм л баяр хөөр болж байхад энэ л ганцаараа пад хар царайлчихаад бас юу гээд байгаа юм бэ? Бурхны номноос авсан үгээрээ над гайхуулах гэсэн юм болов уу?” гэж Санж дотроо бодлоо.

... Монголын нэг лам ном хаялцаж Бэрээвэн хийдийнхнийг паг суулгасан тухай модон улаатай цуу үг нь Лхас даяар тархав. Тэр үгийн цаана янз бүрийн юм нуугдаж байсныг Санж тэр өдөртөө ер гадарласангүй, харин ч нэр цуутай амьтадтай ном хаялцаж дийлсэндээ бахархах сэтгэл төрж, олон жил хүний газар ном шагайж суусныхаа хэргийг бүтээв гэж додигорхон бодолтойгоор шавар тагзандаа буцаж ирэв.

Хорин дөрөв. Туламтай гурилаар биеэ солив

Өвчин бага ч үхэхийн шалтаг

Үг бага ч хэрүүлийн шалтаг

Өө бага ч гажихын шалтаг

Тэр шөнө Санжийн нойр хүрсэнгүй. Ном хаялцсаны улмаас сэтгэл нь их л хөдлөн догдолж, зүрх нь хөөрөн, нойр хульжжээ. Өдрийн болсон явдал дэс дэсээрээ нүдний нь өмнө үе үе амилан харагдах шиг болж нойрыг нь үргээж байлаа. Хэдэн тийшээ харан хөлбөрсөөр байтал шөнө их орой болчихжээ. Хоймор байгаа шүтээний өмнөх зулын голд ассан гэрэл огт хөдөлгөөнгүй зүмбэрлэн тогтсон юм шиг харагдана. Ном хаялцаж билгэ чанарын эрдэм сурсны дээд цол хэргэм олж авмагцаа нутаг буцахаар Санж андгайлсан билээ. Одоо тэр санаагаа гүйцээлээ. Иймд тун ч удалгүй нутаг орноо зүглэн буцах болно. Нэгэн үе мултартал урт хугацаанд бараагий нь хараагүй нутаг ус, хөгшин эцэг эхдээ золгоно гэхээс түүний зүрх догдолж бөөн баяр хөөр дэгдэж байлаа. Эх, эцгээ ямархуу байгааг мөргөлчингүүдээс сонсдог боловч өөрийн биеэр учран уулзахын хүслэн хязгааргүй их аж. Арван хэдэн жилийн дараагаар эргэж очиход хүмүүс намайг бараг л танихгүй биз дээ гэж бодогдлоо. Эх, эцэг нь бол таних ёстой. Эх эцгээ ч хүү нь таних учиртай. Жижигхэн бор банди Лхас хотод анх орж ирсэн билээ. Одоо тэр банди үгүй болжээ. Харин түүнээс урган өссөн ханхар том биетэй, халзандуу толгойтой, намбатай намуун алхаатай лут нэгэн лхаарамба нутагтаа эргэж очих болно. Тэр бүрийг эргэцүүлэн бодож хэвтгэл гадаа хашаа дээгүүр хэн нэгэн хүм сэмхэн давж газарт типхийтэл буух чимэг сонсогдов. Санж цочин өндийж чимээ чагналаа. Зөөлөн алхаатай нэгэн хүн осолдохгүй л хашаа даваад үүд рүү нь чиглэн ирж явах шиг санагдлаа. Тэгтэл зулын гэрэл тун үл мэдэг нахисхийлээ. Үүд сэм нээгдэхийг тэрүүгээр мэдээд Санж өндийв. Рунхаанаар дамжаад нэгэн хүн орж ирлээ. Зулын гэрэлд пад хар царайтай бүлтгэр нүдтэй, ширүүн харцтай царайгаар нь симхааны

үүдээр шагайnguут Санж түүнийг танив. Дотор нь эвгүй болох шиг тэвдлээ. Пагсан ажээ. Эрт урьд хүрдэнд зодолдож байгаад духан дээр нь цохиж Санжийн үлдээсэн үл мэдэг сорив зулын гэрэлд гялсхийн тодрох шиг боллоо. “Энэ одоо юу хийж яваа юм бэ? Өдөр атгагын хурны тухай хачин үг шивнээд байсан биш үү?” гэж Санж бодоод ухасхийн бослоо. Пагсан гараараа затаж,

- Битгий ай! Хэвт, хэвт! Би энүүхэнд суугаад хэлэх гэсэн юмаа хэлээд гарна гэж сөөнгөдүү бэрсүүтэй хоолойгоор хэлэв. Санжийн сэтгэл бага зэрэг тайвширлаа.

- Би өдөр чамд юу гэж хэлсэн билээ? гэж Пагсан асууснаа хариулах зав өгөлгүйгээр цааш үргэлжлүүлэн,

- Билгийн их халуун очоор асар атгагын зөөлөн хур буухыг ерөндөглөнө! гэж би чамд хэлсэн дээ. Тэрийг ч ойлгосон байх. За тэгэхлээр одоо тэр атааны зөөлөн хур чам дээр буух гэж байна гэхэд нь Санж цочиж, ихэд болгоомжлон ийш тийш харав.

- Ийш тийш бүү хар! Өнөөдөр тэр хур буухгүй. Хэрвээ чамайг нутаг буцах сураг л гарвал тэр шөнөдөө л бууна! гэж Пагсан хэлэв. Түүнийг Санж сайн ойлгосонгүй.

- Ямар хур вэ? гэж өөрийн эрхгүй асуухад,

- Өнөөдөр ном хаялцсаны дараа гяргачуудын хоорондоо ярьсан юмыг би чамд хэлэхээр ирлээ. Тэд линсрай гавьжийн өрөөнд зөвлөлдөж байхыг би сэмхэн сонссон юм. Чамд хэтэрхий их юм зааж сургажээ гэж тэд Линсрай гавьж Лүндэгжунайг зэмлэж байна билээ. Бурхан шажны хамаг нууцыг мэдсэн хүнийг Түвд орноос гаргаж болохгүй нууц хуультайг чи яаж мэдэх вэ дээ. Оройгүй эрдэм сурсан гаднын хүнд хоёр зам байдаг. Нэг бол бүх насаараа Лхасд сууж эрдмээ эргээд Түвд хүнд зааж байсаар ясаа тавих, нэг бол нутаг буцахынхаа өмнөхөн түвд хүний гарт ясаа тавих, ийм л хоёрхон тавилантай юм. Чи алийг нь сонгож авахаа өөрөө мэд. Бүх насаараа Түвдэд суухаар

шийдвэл чамд айх юм байхгүй. Харин монгол газраа буцахаар завдвал чамайг явахын чинь урьд шөнө яг л өнөөдөр миний орж ирсэн шиг гэрт чинь орж ирээд оронд чинь дуусгана. Үүнийг л би чамд хэлэх гэсэн юм. Нэгэн зиндаанд нэгэн үеийг элээснийхээ учир үүнийг би хэлэхгүй байж чадсангүй. Чи намайг муу хүн гэж боддог байх. Тэгвэл би өөрийгөө чамд цагаатгах учиртай. Болгоомжтой бай! гэж Пагсан хэлээд шуудхан босч гадагшаа гарлаа. Санж яах ч учраа олсонгүй. “Хүүе Пагсан” гэж дуудсан чинь тэр аль хэдий нь хашаа даваад харанхуй гудамж руу живэн үзэгдэхгүй болов.

Сэтгэлийг нь бүрмөсөн хямруулсан тэр ярианаас болоод Санж шөнөжин элдвийг бодлоо. “Номонд их сайжирсан харийн хүнийг нутагт нь буцаах дургүй” гэсэн дам үгийг Санж аль хэдийнэ сонсож мэдсэн байлаа. Түүгээр ч барахгүй яаж, ямар аргаар тийм хүнийг үгүй хийдэг тухай ч зарим нэг хачин яриаг тэр урьд нь сонссон байжээ. Гэвч тэрэнд итгэдэггүй явжээ. Одоо болохоор шууд л өөрт нь холбогдох хэрэг мандаж байгаа нь энэ юм болов уу гэж эргэлзэхээс өөргүйд хүрчээ. Ямар аргаар Санжийг үгүй хийх бол гэдгийг өчнөөн олон хувилбараар төлөвлөн бодов.

- “Юуны урьд намайг нутаг буцах эсэхийг тагнаж мэдэх байх. Хэн анх тийм уг асуухыг сайн ажиж болгоомжлох нь зөв” гэж Санж бодлоо. “Нутаг явахыг мэдсэнийхээ дараа яаж үгүй хийх бол! Шөнө унтаж байхад өнөөдрийн Пагсан шиг орж ирээд шулуухан цааш харуулах байх. Тэгвэл яах вэ?” гэж Санж бодлоо. “Үүдэндээ түгжээ хийх үү? Түгжээг суга татаад л орж ирнэ. Тиймдээ тулсан хүмүүс юу ч хийхээс буцахгүй. Тэгвэл яах вэ? Сэмхэн оргохуу? Дор нь гүйцээд барьж авах байлгүй. Халх мицанд очиж нуугдах уу? Бас л дороо илрэх байлгүй” гэж Санж тал бүрээс эргэцүүлэн бодоход гарах газаргүй мэт байлаа.

“Намайг өөр ямар аргаар үгүй хийх бол? Гудамжинд явж байтал дээрэмчний дүрээр дайран егүүтгэх үү? Тэгж мэдэх л юм. Эсвэл гурим чойрын үеэр хортой тараг идүүлэх болов уу? Тэр ч бас болох л юм. Гэхдээ хордон үхсэнийг хэн хүнгүй мэдэж бөөн яриа дэгдэх биз. Түүнээс сэвдээгүй өөр нарийн арга бодох олох байлгүйдээ” гэж бас

бодлоо. Егүүтгэн үгүй болгож болох бүх аргыг цөмийг жагсаан үзээд цөмийнх нь эсрэг арга ширэг төлөвлөхөөр шийдэв. Хамгийн эхлээд шөнө унтаж байх үеэр гэрт нь нэвтрэн орж хөнөөх болзошгүй аюулын эсрэг нарийвчилсан арга ширэг бодож зохиохоор оролдлоо. Хоёр гурван арга олсноос нэгийг нь шилж авлаа. Тийнхүү шаналсаар байгаад бараг үүр нүүрээр багахан дугхийж унтахдаа ядаж хар дарж зүүдлэн сэржээ.

Маргааш нь нутаг буцахад хэрэгтэй юмаа зэхэж базаахаар бусдад ажиглагдахгүйгээр хэрдээ нэлээд ажил амжуулжээ. Тэр өдөр хурал номгүй байсныг далимдуулан жаал зугаа хэргээ бүтээлээ.

Нөгөөдөр нь Санж хурал номдоо очихоор явж байтал Бэрээвэн хийдийн гориломд орохын өмнөхөн Чогсон угтан ирж нялуунаар инээмсэглэн мэндийг мэдэж, - Лхаарамба Санждолбийчойжамц таны амгаланг айлтгая! хэмээн бөхөлзлөө.

- Лхаарамба гээд байх ч болоогүй юм биш үү? гэж Санж дургуйцэхэд Чогсон худлаа инээж,

- Бололгүй яах вэ? Лхас зуугаар л нэг ярьж байхад зиндааны чинь нөхөр яагаад хэлж болдоггүй юм бэ? гэв. Тэр хоёр хийдэд ойртож явтал Чогсон,

- Лхаарамба цолыг хүртэж Санждолбийчойжамц нэр өргөмжлөгдсөн та одоо бурхны орон Түвд газар үргэлжлэн сууж түвд, тангад, таван хэлийн амьтад ном заан соёрхох биз дээ гэж нэгэн зиндааныхан чинь итгэн горьдож байгааг хэлэх юун? гэв. Санж түүний үгэнд сэжиг төрж,

- Төрсөн нутаг, төрүүлсэн эцэг эхээ харсангүй бүхэл бүтэн үе өнгөрлөө. Эрдмийн мөр хөөж суусаар их чиллээ. Нутаг орон төрөл төрөгсдийнхөө барааг нэгэн удаадаа эргэж хараад буцаж ирдэг юм билүү дээ гэж бодох юм хэмээхэд,

- Нутаг явах гэдэг чинь буруугүй. Гэхдээ эргэж ирнэ биз дээ. Тэгэхгүй бол зиндааныхан бид чинь өнчирнө шүү дээ гэж Чогсон ярилаа. Тэгээд сүмийн үүд хүртэл гэд дуугүй явцгаалаа. Сүмд орохын өмнө Чогсон,

- Үнэхээр чи нутаг явахаар шийдээ юү? Хэзээ? гэж тулган асуужээ. Тэр ч аргагүй л сэжиг төрүүлсэн асуулт байв.

- Удахгүй явна. Гэхдээ би эргэж ирнэ шүү дээ! гэж Санж хаяагаа манасан үг хэлэв. “Пагсангийн хэлдэг үнэн боллоо. Энэ Чогсон намайг нутаг буцах эсэхийг тагнаж явна” гэж Санж сэжиглэн бодлоо.

Тэр шөнөөс эхлэн болгоомжтой байхаар Санж шийдлээ. Шөнөжин зултай унтдаг болов. Тугалын арьсаар хийсэн туламтай замбайн гурилаа дүүргэж амы нь боолоо. Тэгээд хөнжил дотроо хийж хучив. Зулын гэрэлд яг л хүн унтаж байгаа юм шиг харагдахаар заслаа. Өөрөө шүтээний ширээн доогуур орж суугаагаараа унтах байр засч, гүнгэрваатай ширээний урд руу унжуулсан цэмбэн хөшигний баруун өнцөгт нь үл мэдэгдэх жижигхэн нүх гаргалаа. Анхны шөнө юу ч болсонгүй. Санж шүтээнийхээ өндөр ширээн доогуур орж суугаагаараа хонолоо. Доргимын дээрх зулын бүдэг гэрэлд симхан доторхи юм бүхэн ялгагдах төдий гэрэлтэй харагдана. Цэмбэн унжлаганы баруун дээд өнцөг дэх үл ялгагдах жижиг нүхээр харахад симхан доторхи юмс цөм багтан үзэгдэж байлаа.

Тэрчлэнгээр гурван шөнө өнгөрлөө. Ямар нэгэн аюултай юм тохиолдсонгүй. Санж гадуур гарахдаа ганцаараа явахгүйг хичээж байлаа. Бас шогаа чойр гэдэг оглөөний уншлага, гүнциг чойр гэдэг өдрийн уншлага, гүрим чойр гэдэг оройн уншлагын дараа манз, гонзын алиныг ч амандаа хүргэхгүй байлаа. Тэр хооронд нутаг буцах бүх бэлтгэлийг хийж Халх мицаны нэг найзтайгаа хамтран явахаар бэлджээ.

...Дөрөв дэх шөнө дундаа орж байлаа. Санжийн нойр их амархан хульждаг болоод байсан үе билээ. Хэн нэгэн хүн хашаагийг нь давах

шиг болоход Санж сэрж чимээ чагнав. Дахиад нэг хүн хашаа давах шиг боллоо. Жаахан байж байснаа гурав дахь хүн хашаа даван орж ирэх шиг боллоо. Санж шүтээн доогуураа завилан суусан чигтээ чимээ чагнаж, баруун гартаа гурван үзүүртэй зэсүм бариад хүлээж суулаа. Хашаа давсан хүмүүс сэмээрхэн гэтэх маягаар явцгааж байхыг Санж их л тод сонсож, айдас нь хүрэх шиг боллоо. Хаалга нь тун аяархан нээгдэхийг бас мэдрэв. Цэмбэн унжуулганы баруун дээд хэсэг дэх жижигхэн нүхээр Санж ажиглаж байлаа. Өнчин зулын гэрэлд симхан доторхи бүдэгхэн харагдаж байв. Гурван хүн цуван орж ирлээ. Санж золтой л дуу алдчихсангүй. Учир нь хамгийн түрүүнд найрсаг найз Чогсон нь орж иржээ. Түүний үргэлж инээвхийлж явдаг шарман царай нь аймшигтай дошгин байдалтай болсон харагдав. Хачин бараан хувцас өмсөөд нүүр рүүгээ хар хялгасан сангасваа унжуулжээ. Тэр толгойгоо гэдрэг савж сангасваагаа духан дээгүүрээ хойш нь сөхөж нүүрээ ил гаргаагүй бол Санж танихгүй өнгөрч болох ажээ. Урт гэгчийн сэлэм бүснээсээ зүүжээ. Түүнийхээ ишнээс баруун гараараа атгасан байлаа. Хойноос нь дагаж ирсэн хоёр хүн нь огт танихгүй улс байлаа. Тэр гурав эгнэн зогслоо. Тэгмэгц гурвуулаа аман дотроо маань шивнэн уншив. Дараа нь Чогсон сэлмээ гэрнээс нь сугалан авахыг Санж зулын бүдэг гэрэлд тод харлаа. Болд төмөр илд нь гялсхийн харагдах тэр мөчид Санжийн дотор палхийх шиг боллоо. Чогсон сэлмээ баруун гартаа өргөж, Санжийн орон тийш хулганад гэтсэн муур шиг сэм сэм алхан ойртож очоод гурван удаа дохих шиг болов. Сүүлчийнхэд нь битүү түнших мэт чимээ гарлаа. Чогсон тэр гурав дахин маани уншиж, гурвантаа залбирал үйлдээд сэм сэм алхлан гарч явцгаалаа. Бүх биенээс нь хүйтэн хөлс гарч байхыг Санж мэдэж, айж тэвдэн, биеэ барьсан хүлээснээсээ сая л мултрах шиг болжээ. “Хамгийн сайн найз шиг минь наалдаж байсан өнөөх Чогсон гайхал л намайгаа хөнөөхөөр ирдэг байна шүү!

Гэтэл хамгийн муу найз шиг байсан Пагсан болохоор намайгаа аврах гэж бодож явдаг байна шүү! Орчлон гэдэг ийм ажээ. Эргэж хөрвөж байдаг байжээ!” гэж Санж бодоод шүтээний ширээн доогуураас гарч чимээ чагнав. Ирсэн хүмүүс хашаа даваад чимээ сураггүй алга

болцгоолоо.

Санж болгоомжтой алхлан орныхоо дэргэд очоод хөнжлөө сөхөн үзвэл туламтай замбай гурван газраар хагас зүсэгдээд доторхи гурил нь гоожиж байхыг олж хараад “Би энд байсан бол ингээд л гурван хүрдээрээ тас цавчигдаад өнгөрөх байжээ” гэж бодоод Санж айн жихүүдэс хүрэх шиг боллоо.

Тэр даруй түламтай гурилаа орон дотроосоо гарсан шуудайд далд хийлээ. “Маргааш өглөө л эд нар үүгээр ирж шинжлэн шалгана. Тэгээд намайг амьд үлдсэнийг мэдвэл мөрдөн хөөж эхэлнэ. Иймд ул мөрийг сайтар баллах нь зөв” гэж Санж бодоод шаламгайлан хөдөлж бүх юмыг санасан ёсоороо янзлав. Тэгээд Бэрээмэг эмгэний захиж байсан үгийг дагахаар шийдэв. Талийгаач эмгэний үлдээсэн ширэн авдар дотроос түүний залуу цагтаа өмсч байсан шимнанцын хувцсыг гаргаж авлаа. Тэрхүү шимнанцын хувцсыг өмсөж гэлэнмаа болон хувирахаар тэр урьдаас бодож олсон байлаа. Зэхэж бэлтгэсэн бусад юмаа аваад байшин, хашаа хоёроо аль алийг гаднаас нь том цоожоор цоожлоод нэг гудамжны цаана шавар тагзандаа хүлээж байсан нөхрийндөө Санж хүрч очлоо. Нөхөр нь дулдуйтай бадарчин болж, өөрөө түүнийг дагасан шимнанцын дүрээр Санж оргон зайлахаар шийджээ.

- Хүний анхаарал татахгүйгээр хурдан холдож, хэн ч санаагүй замаар явбал дээр байх гэж бодоод Үйчүү мөрнөөр уруудаж хэсэг холдоод дараа нь аажмаар зүүн хойш зүглэе гэж бодлоо. Үйчүү мөрний нэг нугаланд ширэн завь тавиастай байгаа. Одоо түргэлэхгүй бол үүр хаяарчихна. Үүр хаяарахаас өмнө Лхасаас нэлээд холдоод авмаар байна хэмээн найз нь угтан уулзмагц Санжид хэлэхэд тэр ч зөв юм гэж зөвшөөрчээ. Үнэхээр санасан ёсоороо болж тэд Үйчүү мөрний намуухан усан дээгүүр сарлагийн арьсан завиар хэнд ч мэдэгдэхгүйгээр шөнийн түнэр харанхуйд хучигдан хөвж одлоо. Урсгалын дагуу болохоор завь нь аяндаа хөвөн уруудаж байлаа. Лхас хот харанхуй дунд нэвсийн бараантаж, хааяа нэг дуган, дацангийн бүдэг зулын гэрэл үл мэдэг ёлтойсоор хоцорлоо.

Тэртээ олон жилийн өмнө анх удаа энэ мөрөн дээгүүр мөн ийм нэгэн завиар хөвж явсан нь Санжийн санаанд орлоо. Түвдийн ариун шүтээн болсон газруудаар Отгон хүүхнийг мөргүүлж, үрийн хутаг олгоход тус хүргэхээр явж байсан тэр цагийн явдал одоо ч мартагдаагүй хэвээр байлаа. Отгон хүүхэнд харь газрын элдэв шүтээний аль нь ч тус болсонгүй. Тэрэнд үр заяасангүй. Түүгээр ч барсангүй заяасан нөхрөөсөө хоёр дахь удаа энэ газар хагацан салжээ. Нэг нь мөнх бусыг үзүүлсэн. Нөгөө нь Түвдийн шоронд орж, цэрэгт дайчлагдаад дараа нь уулын дээрэмчний сүрэгт нийлж сураггүй алга болсон. Одоо тэр зовлонт эмэгтэй хаахан газар юухан хийж явдгийг Санж мэдэхээ болиод нэлээн хэдэн жил өнгөрчээ.

“Үрийн хутаг заяасангүйд их л гомдож явдаг тэр бүсгүй одоо хаа явдаг болдоо. Уул нь Лхантавчамбын ухаан судалсан хойно минь, өдий үедсэн бол ч би түүнд тус болохыг оролдоод үзвэл хоосон юм болохгүй ч байж мэдэхсэн билээ. За тэр ч өнгөрчдээ” гэж Санж гэв гэнэт санаанд нь орсон тэр нэгэн бүсгүйн тухай бодлоо. Гэвч одоо тэр өөрөө Бэрээмэг эмгэний шимнанц хувцас өмсөөд эр мөртлөө эмийн дүрийг үзүүлэн явж байна. Бурхны сайн шавь болж, их эрдэм сурахаар сүсэглэн зорьж ирсэн газраасаа одоо зүс буруулан зугатаж явна. Үйчүү мөрний хар бараан ус үе үе долгилохоос өөр юу ч сонсогдохгүй дүнсгэр шөнийн дүлий чимээгүйд оргодол хоёр өчүүхэн ч дуу чимээ гаргахгүйг хичээж суулаа. Түнэр харанхуй шөнийн нам гүмд түмэн зүйлийн дуртгал амилан сэрж, элдвийг эргэцүүлэхээс өөр хийх юмгүй тул Санж бодолд дарагдлаа. Өөр хоорондоо ярих ч бололцоогүй тэр аян Санжийн туулж өнгөрүүлсэн хамаг амьдралын замыг нь эргэн сануулах гэсэн юм шиг ер бусын мөртлөө ерийн ажээ. Шавилан суухаар анх энэ газар ирсэн цагийн юм цөм л санааны дотор илхэн. Лүндэгжунай гавж, Пүрэвдоной маарамбаас эхлээд нэгэн зиндааныхан нь ялангуяа Чогсон, Пагсан хоёрын ааш араншин, хүний ясанд шунаж явдаг жинжээ лам Жалсан, Лхас хотын аймшигт шорон цөм л дараа дараагаар санаанд орлоо. Долоон тамир сульдсаныг эдгээнэ гэж түмэн зүйлийн арга ширэг хийгээд дийлээгүй лам багш нарын байдлыг одоо ч тэр мартаагүй байна. Эрдэмт лам нарын гүн

ухаанаас гараагүй юм эрдэмгүй шимнанц Бэрээмэг эмгэн хэрхэн сийлж Санжийг дор нь эдгээн тэнхрүүлж авсан тухайг ч тэр сайн санаж байлаа. Төгсгөлгүй эрдэмт маш хэтэрсэн, арван бэхт гэхчилэн сүртэй лут цол хэргэмтэй олон лам нарын орогнох газар болсон Лхас зууд нүгэлт үйлс огтхон ч гармааргүй атал өдөр бүрий хүний санаанд оромгүй юмс болж байдгийг одоо Санж сайн мэдэж байлаа. “Эрдэм ном их сурлаа” гэсэн шалтгаар харь газрын хүнийг хяхан хөнөөдөг бусармаг бурангуй заншил бичигдээгүй хууль болон энэ газар ноёлж байдгийг Санж одоо өөрийн биеэр үзэж амслаа.

Юм л бол малгайгаа авч хэлээ гарган хоёр эрхийгээ гозойлгож, шилээ маажин “гүшүү, гүшүү” (дээдэс, дээдэс) гэж бусдын өмнө бөхөлзөн бялдуучилж үргэлж долигонон явдаг түвд хүмүүсийн дотроо юу бодож байдгийг Чогсон бодьпагийн төрөхөөр Санж төсөөлөн бодоод гайхаш төрж байлаа. Тэр бүхий л маяг нь заримдаа айхтар өнгөц юм байсан ажээ. Одоо тэдний гарт өртөлгүйгээр эх нутгийнхаа барааг харах ёстой. Харийн хүнээс харамлаж байгаа тэр эрдэм номынхоо үр шимийг нутгийнхандаа хүргэж өгөх учиртай. Тэгэхгүй бол олон жилийн турш зовон зүдэрч номын мөр хөөсний хэрэг юухан билээ? Санж энэ бүхнийг эргэцүүлэн бодож шөнийн жихүүнд голын уснаас чийг авахыг мэдэрч жихүүдэс нь хүрэхийг анзаарсангүй. Бэрээмэг эмгэний хувцас түүнд давчдан нимгэдэж байлаа. Одоогоор хувцас биш харин цаг хожих нь юунаас ч онцгой чухал байлаа. Хоёр оргодол яарахын туйлд хүрч байв.

Хорин тав. Төрөл арилжсан мөргөлчид

Өсөхөд өрөвдөхийн тус

Өтлөхөд өргөхийн тус

Үхэхэд яс барихын тус

Тэнүүлчин хоёр загзгасхийн цочлоо. Газар шагайн бөгтгөнөж явсаар сая л нэг толгойгоо өндийлгөн эргэн тойрныг ажин харж, түр амсхийн зогслоо. Гэтэл хэдхэн мөчийн өмнө огт өөр байсан орчлон хорвоогийн өнгө гэнэт хувирчихсан юм шиг санагджээ. Юм бүхний өнгө гагцхүү цусан улаанаар гэнэт будагдчихсан юм шиг санагдсан нь тэр хоёр тэнүүлчдийн айдсыг төрүүлжээ. Марсанлха хийдийн шавар тагзнууд час улаан харагдлаа. Өмнөхөн талд нь яваа хэдэн хонь бас л улаан өнгөтэй байв. Тэд гайхан айж нүдээ аницгаалаа. Хэсэг зуур чимээ чагнах мэт зогсоод нүдээ нээцгээлээ. Юм бүгд улаанаар эргэлдсэн хэвээрээ ажээ. Марсанлха хийдийн гол дуганы алтан ганжир хүртэл улайчихсан юм шиг харагдав. “Бид хоёр олон хоног айж тэвдэж, цочиж бусгаж, мөрдөгдөхөөс болгоомжлон явсаар байгаад эцэст нь ухаан балайртаж гажуу солиу юм үзэхэд хүрсэн биш байгаа” гэж Санж гайхан бодоод биеэ базалж үзэв. Мэдээтэй ажээ. Дээшээ өлийж огторгуйг ажин харваас тэр л гагцхүү рашиар мэт номин хөх өнгөтэй хэвээрээ байлаа. Марсанлха хийдийг хүрээлэн орших ханан хаднууд болохоор шунхан улаан өнгөөр гэрэлтэх мэт хачин харагдлаа.

- Яасан аймаар цусан улаан өнгөтэй газар вэ? гэж Санж аман дотроо шивнэн асуухад дагуул нөхөр нь,

- Энд ер нь ийм юм тохиолддог газар. Тун удахгүй огт өөр өнгөтэй болно. Битгий зов! гэж сургамжлав.

- Аймаар юм! гэж Санж шивэгнэв.

- Энд чинь зүсээ хувилгасан Балдорж лхаг оршуулсан газар шүү дээ!
гэж нөхөр нь санууллаа.

Тэр нэрийг сонсмогц Санжийн санаанд эртний нэгэн аймшигт домог орж ирлээ. Түвд оронд бурхны шажин дэлгэрч эхлэх цагт Дарма хаан төр барьж, шашныг дэлгэрүүлэхийг цааргалж байжээ. Лам нар Дарма ханыг ландарма буюу Дарма мал гэсэн хоч өгч хараал зүхэл заналхийллээр түүнийг мохоохыг оролджээ. Гэвч Дарма хаан шашныг эсэргүүцсэн хэвээр байжээ. Түүнийг мэдээд даян хийж суусан Балдорж гэгч лам шашны дайсан ландармыг үгүй хийж буян үйлдэх санаа агуулж олон хоног эргэцүүлэн бодсоор нарийн арга олжээ. Балдорж тийнхүү цагаан морио хөөгөөр будаж хар болгоод, цагаан дотортой хар дээл хийлгэн өмсөөд хааныхаа амь насанд халдахаар явжээ. Тийнхүү хааныг хорлоод зугтаажээ. Нэгэн гүвээ давмагц морио усанд унагаж угаагаад цагаан зүсийг гаргаж, өөрөө дээлээ эргүүлж өмссөн ажээ. Тийнхүү хар морьтой хар дээлтэй явснаа гэнэт цагаан морьтой, цагаан дээлтэй болон хувирсан нь түүнийг мөрдөн хөөж явсан хүмүүсийг төөрөгдүүлж энэ мэхээрээ амь гарч чаджээ. Бурхан шажинд тус хүргэсэн гэж үзээд Балдоржийг энэхүү марсанлха хийдэд ёс төртэй бунхалсан гэдэг домогтой юмсанжээ.

Гашуун сургамжтай домогт энэ түүхийг эргэн санах зуур Санжийн сэтгэл бага зэрэг төөрөгдөж, юм бүхний өнгө улайран хувирсан сүрт үзэгдлээс бишүүрхсэнээ бага боловч саринаалаа.

Нэлээд яваад дахин амсхийж эргэн тойрныг ажвал нөгөөх аймшигтай цусан улаан өнгө нэгэнт алга болон өөрчлөгдөж юм бүхэн хэвийн байдлаараа харагдах болчихсон байлаа. “Үгүй энэ юутай жигтэй билээ? Надад ямар нэгэн муу ёр танигдав уу?” гэж Санж дотроо бодоод эргэн тойрныг дахин сайтар ажваас Марсанлха хийдийг хүрээлсэн элгэн улаан хаднуудын энгэр дээрээс оройн улаан нарны сүүлчийн туяа гялавхийн үгүй болж байх харагдлаа.

- Ай хөөрхий! Айсан хүн адуу хөөнө гэгчээр оройн улаан нарны шаргал туяанд энэ элгэн хад час улаан өнгөтэй харагдаж айлгасан

байж шүү! гэж Санж амандаа үглэн сэтгэл тавирсан янзтай хэлэхэд,

- Мансарлха гэдэг чинь түвдээр улаан лха гэсэн үгийг мартав уу? Эргэн тойрон байгаа хаднууд нь шороо нь ч гэсэн зосон улаан өнгөтэй газар байгаа юм. Час улаан хадтай болохоор нь Марсанлха гэж нэрлээ биз. Оройн жаргах нарны туяатай нийлээд бүх юм улаанаар эргэн хувирсан мэт ийм аймаар өнгө хаяа гардаг газар даа энэ. Ийм юманд зовох хэрэггүй. Бидэнд үүнээс ч аймаар юм тохиолдохгүй гэх газаргүй. Иймд сэтгэлээ барь! Орон хийдэд суусаар байгаад чи их аймтгай болсон хүн байна гэж нөхөр нь ярив.

Тэнүүлчин хоёрыг гаднаас нь харахад өрөвдөлтэй байлаа. Нэг нь яс арьс болсон туранхай биетэй, хавчиг үүрэг үүрч, дулдуй барьсан хатингар туранхай хижээл насны эр, нөгөө нь шимнанцын хувцас өмссөн бөгөөд газар шагайж бөгтийсөн амьтан ажээ. Нуруугаар дунд зэрэг болохоор Санжийг хэн ч хараад шимнанц л гэж бодохоор байлаа. Харин царайгий нь сайн ажиглах юм бол эр хүн гэдгийг мэдэхэд хялбархан юмсанж.

- Үгүй чиний наад уруул дээгүүр чинь ганц нэг сахал шиг юм сөрвийгөөд гараад ирж! Одоо л хэрэг биш болно шүү! Энэ түвдүүдийн хартайг хэлэх үү? гэж гэнэт найзыгаа сануулахад Санж ондгосхийн цочлоо.

- Нээрээ юу? гэж гайхан асуухад найз нь:

- Шөрвийгөөд их тод байна. Чамд чимхүүр бий юу? Зулгааж хаявал таарна. Ер нь тэгээд хүний өөдөөс эгцлэн хараад байх хэрэггүй. Танигдана шүү! гэж сануулав. Санж үнэхээр тийм болох магад гэдэгт итгэсэн тул,

- Чимхүүр надад бий бий! Энүүхэнд суугаад зулгаалгах уу гэсэнд найз нь,

- Болохгүй. Шимнанцын сахал зулгааж суугаа дулдуйчинг харвал

бөхтэй морь үзсэн юм шиг гайхацгааж сүйд болно. Шөнө болохоор юм уу эсвэл хүнгүй зэлүүд газар очиж байгаад наадах хэдийг чинь зулгаая. Ямар ч байсан Марсанлхад л хоноглохоо больёо. Би урд нь чиний наад хэдэн сөөвгөрийг ажиглах минь яалаа гэж болгоомжлон ярив.

Тэд ийнхүү Марсанлха хийдээр орохгүй өнгөрөн явахаар шийдлээ. Шөнийн харанхуй нөмрөх хүртэл тэд явцгаалаа. Тэгээд нэгэн их сүрлэг хадны нөмөрт орж тэд хээр хоноглохоор шийджээ. Цаг дулаан тул хээр хоноход тохиромжтой байлаа. Шөнийн цагаар ууланд гал гарах аюултай тул тэд хуурай юм идэж голоо зогоолоо. Ууланд өчүүхэн төдий гал харагдвал дээрэмчингүүд баримжаа авч шиншлэн ирдэг нь Түвд газрын бараг нийтлэг болсон заншил юм.

- За чавганц минь хажуугаар хэвт! гэж найз нь шоглоход Санж хи хи инээж,

- Чавганц болж даанч сурахгүй нь ээ! гэв.

Сураад ч яах юм билээ. Нутаг орны бараа харах хүртэл чавганцын дүрийг үзүүлж явбал болоо. Ер нь тэгээд хүн амьтан ойр үзэгдэж байх цагт юм ярих хэрэггүй. Дуу чинь чавганцынхаас огт өөр юм. Дуугаараа танигдчих гээд байх юм гэж найз нь сануулав. Санж түүнийг зөвшөөрч байлаа. Үнэхээр чавганцын дуу гаргах гэж хичээгээд хичээгээд нэмэргүй байгааг тэр хэд хэдэн удаа ажигласан юм.

- Инээдтэй хэрэг шүү! Лхаарамбын дамжаа барьчихаад шимнанц болоод ингэж явах гэдэг! гэж Санж гайхах аяс гаргахад,

- Тэр байдаг л ёс. Эр хүн долоо дордож, найм сэхдэг юм. Түвд, тангадын гарт л баригдахгүй энэ нутгаас гарч чадвал болоо. Гэр орондоо эргэж очиход чинь чамайг сайхан цагаан сэтгэлтэй монгол ах дүүс угтаж аваад цагаан эсгий дээрээ тосч буулгаад Буянзалбирах хийдэд хамба ламаар зална даа! Тэр цагт хөгшин муу ахыгаа

балинчаар аваарай даа. Ах нь балин, шалсай хийхдээ гарын дүйтэй юм гэж найз нь Санжийн бараг чихэн дээр нь шивнэн ярихад сэтгэл нь өөрийн эрхгүй хайлан уярав.

“Хөөрхий энэ ядарсан эрд би тус хүргэх ёстой. Ядарсан цагт ядарсан хүн л тус болдог юм байна” гэж Санж дотроо бодож байлаа. Санжийн дагуулан гарсан тэр найз нь Хар азаргын нуруу, Бурхан буудай уулаар нутагтай эгэл нэгэн эр байжээ. Хийдэд шавилан сууж лам багш нь түүнийг дагуулан Утай, Гүмбум, Лхас зуугаар мөргөл хийхээр явжээ. Гэвч Түвдийн өндөр ууланд дээрэмчингүүдтэй дайралдаад багш лам нь тэднийг эсэргүүцсэний учир голоог омгийнхонд баригдаж тамлагдаад эцэстээ уулын голын гүн цүнхэлд шидүүлчихжээ. Түүнээс болж хүний газар, гүний нутагт гав ганцаар хаягдсан бяцхан хувраг Өлзийт хувь заяагаа өөрөө шийдэхээс аргагүйд хүрсэн юмсанжээ. Түвд орноор олон жил тэнүүчлэн, дулдуйтай бадарчийн дүрээр өчнөөн хугацааг өнгөрөөжээ. Төрсөн нутгаас үнэтэй юмгүйг энэ завсар яс махаараа мэдэрчээ. Тэгээд Санжийн хань бараа болж нутаг бараадах замд гарсан нь энэ. Санж тэр хоёр яаж танилцсан бэ гэвэл Лхас хотын гудамжинд билээ.

Дүгжүв залах ёслол болж байсан юм. Жил бүрийн эхэн сарын хорин дөрвөнд дүгжүв зална гэж хоёр том сор бэлтгэн шатааж дараа нь Ландарма хааныг оршуулсан уулын зүг үхэр буугаар бууддаг тэр ёслолын үед нэг хэсэг мөргөлчид сорын үнс олж авахын төлөө нөгөө зарим нь үхэр бууны сумыг туссан газраас нь олж эргүүлэн авчирч өгөх, тэгснээрээ бүтэн жилийн турш алба гувцуурааас чөлөөлөгдөхийн төлөө зүтгэдэг ажээ. Өлзийт тийм хэргээр сорын үлдэгдэл булаалдан зодолдож байжээ. Хамаг мэхээ шавхан зодолджээ.

Гэвч түүнд юу ч олдсонгүй. Сорын хувцасны бяцхан тасархай олж авсныг нь өөр нэг мөргөлчин булаан авч Өлзийтийг нармийтал нь дэлссэнд тэр сорын гал байсан үнсэн дээр нүүрээрээ хатган ойччихоод хорсон бачимдсанаас болж уйлж суух үед нь Санж түүнийг өрөвдөж татан босгоход Өлзийт,

- Муусайн зэрлэг тангадуудтай нэгийгээ үзэх минь гэж монголоор заналхийлэхэд Санж түүнийг сая л монгол хүн юм байна гэж мэдээд гараас нь хөтлөн явж олны хөлөөс зайлуулаад,

- Сорын үлдэгдлээр юугаа хийх нь вэ дээ? гэж монголоор асуужээ. Тэр Санжийг монгол хүн гэж мэдмэгц улам ч сэтгэлээр унан эхэр татан уйлж,

- Халх мицаны Бапдан лам гуйсан юм. Сорын үлдэгдэл олж ирвэл их шан өгнө гэсэн юм... гэж үгээ таслан цувуулан ярив. Санж түүнийг өрөвдөж,

- За яахав, нутгийн хүн юм байна. Би чамд олзоо өгье! гэж хэлээд орхимжныхоо доогуур нуусан түлэнхий дүгжүвийн нэг хэлтэрхийг гаргаж ирээд түүнд өгчээ.

- Дүгжүв залахад лам багшдаа тусалж байх зуур олж авсан юм. За яахав, нутгийн хүн байна. Танд өгчихье гэж Санж түүнд хэлэхэд Өлзийт асар их баярлаж, хүүхэд мэт инээмсэглэн, түлэнхий дүгжүвийн тасархайг нандигнан хоёр гардан тосч авахад нь Санжид хөөрхий тэр сүсэгтэнг өрөвдөх сэтгэл төрж билээ. Сүжиг гэдэг ямар их хүчээр хүнийг атгаж байдаг нь энэ мэт өчүүхэн зүйл дээр ч илэрхий харагдана. Дүгжүв гэдэг нь ерийн л нэгэн сор бөгөөд шашны дайсанг дарахын билэгдэл болгож хэдхэн хоногийн өмнө гарын дүйтэй лам нар цаас, гурил, шар тос тэргүүтнээр бүтээн үйлдэж хувцас зэргийг нь элдэв даавуу шаавууны өөдсөөр орлуулан хийсэн сүг дүрс билээ. Түүнийг зүхлэг таринны номоор баахан таринадаж байгаад гал руу хаян шатаасан хэрэг. Шатсан үнс, хогийг нь мөргөлчид булаалдан авахдаа элдэв муу юмнаас, гай зэтгэрээс биеэ хамгаалах увдис зай болно гэж итгэдэг байлаа. Хоосон чанарын зүйл боловч сэтгэлийн нисваанисыг үлдэн хөөхөд хэрэг болно гэдгээр ийнхүү сүсэгтэнд үе залгамжлан итгэгдсэн тухайг Санж сайн мэдэж байлаа. Гэвч өөрөө яагаад түүний үлдэгдлээс сэмхэн авч орхимжиндоо нуусан билээ? Сүжгээс үүдсэн хэрэгцээ их болохоор хэн нэгэн этгээдийн хүсэлд хариу өргөх гэснээс гарцаагүй. Сүжигтэн

хүний хэрэгцээ, төөрөгдөл нь заримдаа утгагүй дэмий юмыг ч ариун шүтээний дээдэд аваачин дэвшүүлж чадна. Сэжгээр өвдөж, сүжгээр эдгэнэ гэдэг яриа ийм л учиртай болно. Энэ бүхнийг Санж шөнө дүлийн харанхуйд сүжигт дулдуйчтай зэрэгцээд эзгүй хээр хадны нөмөр хоргодон хэвтэж байхдаа эргэцүүлэн дурсчээ. Бурхны номын тухайд “а” үсэг ч үгүй энэхүү сүжигтэн, тэр номыг бүхий л насаараа үзэж орой нь цоороод лхаарамбын цолд хүрсэн Санж хоёрын тухайд бол яг энэ үед ямар ч ялгаа алга бөгөөд гагцхүү амьд явахын агаар нь л нэгэн адил байгааг Санж ухаарч байлаа. Лхасаас оргож гарснаас хойших хэцүү түгшүүртэй өдрүүдэд Санжийн их эрдмээс хэрэг болсон юм нэгээхэн ч байсангүй. Харин харанхуй цээжтэй, сүжигтэн Өлзийтийн амьдралын аугаа их ухаан, туршлага нь түүнд нэн ч хэрэг болж байлаа. Найман мянган мөрт “Жадамба” судрыг цээжээр уншивч хээрийн түүдэг гал өөрөө асахгүй болох нь тодорхой аж.

- Үд дунд яг жин үдийн халуунд галаа асааж цайгаа ууж байя. Тэгвэл утаа нь алсаас огт харагддаггүй юм.

- Улаан шалын хөндийгөөр туулахдаа гутлаа эргүүлж өмсөөд явья. Тэгвэл ирсэн нь явсан, явсан нь ирсэн болж мөр маань мөрдөгчийг аяндаа төөрүүлнэ.

- Хөх нуурын өөлдүүдээс хүүхэд тоглодог шагай олж авья. Хоолгүй өлсөхөд хүрвэл өдөр бүр нэг шагай хүлхээд явахад чи амь авч гарна. Дээрэмчинд тоногдлоо ч гэсэн шагайг тоож авах хүн байхгүй. Хүүхдийн тоглоом л гэж бодно! хэмээн Өлзийт Санжид амьдралын ухаан зааж байлаа. Үнэхээр ийм юмыг Санж хэдэн түмэн номноос альнаас ч олж уншаагүй билээ. Үнэхээр үд дундын халуунд хээр гал түлэхэд алсаас утаа нь огт харагддаггүй нь үнэн байлаа. Цэнхэр униар татсан жин үдийн халуунд ,гал түлэхэд утаа ч бараг гардаггүй болохыг тэгж мэдэв. Амьдрал, номын зөрөөг ч ухаарав.

- Орон хийдэд шавилан суусаар байгаад бээрэг болчихжээ.

- Орон хийдэд шавилан суусаар байгаад аймтгай болчихжээ.

- Орон хийдэд шавилан суусаар байгаад хараа чинь муудаж, хамар чинь битүүрч, бие чинь хөшчихжээ! гэхчилэн Өлзийт бадарчин үе үе Санжид сануулж явав. Үнэхээр л тийм байлаа. Үг гашуун ч гэсэн үйл хэрэгт тустай гэгчийг санаж Санж түүнтэй эвлэрэн зөвшөөрч явлаа. Шөнийн цагаар Санж чичрэн жиндэж байхад Өлзийт хэнхдэгээ ярж, толгойноосоо уур савсуулан унтаж байхыг олонтаа ажиглав. Эргэн тойронд торойх бараа үзэгдэхгүй байхад Өлзийт “энүүхэнд нэг хийд байх бололтой. Утаа нь үнэртэж, нохойн дуу гарч байна” гэдэг байлаа. Санж тэрхүү утааны үнэрийг мэдрэх байтугай, нохойн дууг ч сонсдоггүй байлаа. Гэвч гүвээ давмагц өмнө нь ямар нэгэн хийд байж л таардагсан. Энэ бүхэн амьдралын хар ухаан юм. Гэвч Санжид бол өчүүхэн ч гадарлахааргүй харь холын зүйл ажээ.

...Өглөө үүр хаяармагц Өлзийт сэрэн өндийлөө. Тунгалаг сайхан өглөө байв. Гэвч Өлзийтэд тэр сайхан өглөө нэг их таашаагдсангүй.

- Оройхон дуу цахилгаантай бороо асгах нь бололтой. Хоёулаа юунд очиж хоргоддог юм билээ дээ. Хадны ёроолоос гаралгүй болохгүй гээд суниахад нь,

- Агуй юм уу, модны ёроолд очиж хоргодсон нь дээр байхаа! гэж Санж хэлтэл Өлзийт тачигнатал инээж, - Хоргодох юмаа мөн олж ядав аа? Дуу цахилгаантай борооны үед хад бараадвал ниргүүлэхийн л цондон. Мод ч гэсэндээ цахилгаан гэдэг ч тийм юмыг анддаггүй эд! гэж сануулав.

- Тэр хоёр босч хувцас хунараа засав.

- Аль вэ, наашаа! Гэрлийн эсрэг энэ хад налаад сууж бай! гэж Өлзийтийг хэлэхэд Санж гайхаж,

- Яах юм бэ? гэж дургүйцсэн чинь,

- Яах юу байх вэ? Наад хэдэн шөрөвгөр сахлыг чинь сугалж хаяхгүй

бол чамайг шимнанцын хувцас өмссөн эр хүн! гэдгийг наад захын чавганц л мэдээд авна! гэж Өлзийт дооглоод чимхүүр авч уруул дээрх хэдэн сөрөвгөр үсийг нь зулгаан хаялаа. Өвдөж нүднээс нь нулимс гарахад Өлзийт тайтгаруулж,

- Тангадуудад баригдаж тарчилснаас ганц нэг час час хийлгэн өвдөх төдий өнгөрсөн нь дээр байлгүй! гэв.

Ингээд тэд цааших замдаа орлоо. Өлзийт энэ хавиар нааш цааш олонтаа хэрэн явсан хүн болохоороо газар мэдэхгүйн зовлон алга байлаа. Бас ч түвд хэлээр нэлээдгүй сайн ярина. Санж түүнээс илүү ярих боловч дууны өнгөө таниулахаас айж, дугарч чаддаггүй байлаа. Өлзийт болохоор Санжийг заримдаа эмгэнээ болгож, заримдаа дүүгээ болгож янз бүрээр ярина. Зүсээ хувирган, бараг төрөл арилжсан мэтээр энэ хоёр тэнүүлчин уул нутгийнхаа зүг тэмүүлэн өдрөөс өдөрт ойртож явлаа. Бүхний нүднээс буруулан яваа аяны энэ түгшүүртэй зам нь Лхаарамба Санжийн хувьд амьдралын их сургууль болж, бурхны ном, хүний хувь тавилангийн хоорондын ялгааг айхтар тодорхой ойлгуулж өглөө.

“Яахаараа тэд намайг үгүй хийх гэж шийддэг байнаа? Бурхны ном сайн сурсан гэж үү. Тэгвэл өөрсдөө бурхны номыг сайн сурахыг яагаад өдөр бүр шаарддаг билээ. Бурхны номыг сайн сураад алс газар аваачиж түгээх нь тэднийхээр буян хийж байгаа хэрэг биш гэж үү? Харь орны хүнд халдааж л байвал бурхныхаа шавийг олшруулж, номыг нь хол түгээж тийнхүү буян үйлдэж байгаа хэрэг биш юм уу? Аль апы нь биш болж таарлаа. Тэгээгүй бол эдэн намайг яагаад егүүтгэн үгүй хийх болов. Миний олон жил сүсэглэн ном сурсан минь ийм дэмий төгсгөлд хүргэх байсан юм уу?! гэсэн бодол Санжийн толгойд эргэлдэж салахгүй дагалдаж байлаа. Хариулах хариу нь олдож өгөхгүй зовооно. Гэвч ийм явдал нэгэнт бодитойгоор болж байгааг бүрэн ойлгов.

Хорин зургаа. Амь наана, там цаана

Тостойгоос тогоо хар
Билэгтэйгээс бэх хар
Амттайгаас архи хар

Баянсүмбэр уулын бараа их л алсад харагдаж байлаа. Хоёр тэнүүлчин тэртээд цэнхэрлэн бүрэлзэх их уулсаар чигээ барьж зүүн хойш зүглэн явсаар л байлаа. Одоогоор аливаа аюулгүй, амь насанд харшилсан юмгүй, бүрэн бүтэн явцгааж байв. Санжийн бие аян замын гар даахгүй нэлээд суларчээ. Өлзийт бадарчин болохоор явах тусмаа бие нь хөнгөрч, сэтгэл нь сэргэж баяр хөөртэй болно.

Буман оройтын ууланд явж байхад Санж газрын сүрт дарагдаж толгой нь эргэн, бөөлжис цутгаж, ядран доройтжээ. Өлзийт болохоор юу ч болоогүй мэт алхалж байлаа.

- За ламбугай минь! Гүрэм номоо уншиж сурсан эрдмээ гаргаж үз! Бусдыг биш гэхэд өөрийгөө аврах, эрдэм сураа биз дээ гэж Өлзийт өгөөдөх, асуух хоёрын хооронд хэллээ. Санж ямар ч ном уншаад нэмэргүйг өөрөө мэдэж байлаа. Өлзийтийн үг гашуун бөгөөд үнэн.

- Ийм юманд хэрэг болдог ном сураагүй гэж үнэнээ хэлсэн чинь Өлзийтөд их таалагджээ. Зальхай нүдээр инээвхийлснээ,

- За тийм л байгаа юм шүү дээ. Амьдрал ахуйд хэрэг болохгүй эрдмээр юугаа хийнэ. Би ингэж л боддог болсон хүн Бага залуудаа ч лам багш, бурхан шүтээнд сүсэглэж л явлаа. Бурхны ариун орон гэгдсэн Утай, Гүмбум, Лхас зуугаар хэрэн тэнүүчилж өнгөрөөсөн энэ жилүүдэд ганцхан л юм ухаарсан. Тэр минь юу вэ гэвэл “Бурхны гүн ухаанаас ардын хар ухаан дээр” юм байна гэдгийг л мэдсэн. Хичнээн олон аавын хүү сүм дуганд шавилан сууж, хичнээн олон жин шар

тосоор зул барьж, хичнээн олон олбог элээж байгааг харах бүрийд л дотор аягүй болох юм. Гэхдээ ийм юмыг би хэнд ч ярьдаггүй. Алдас нүгэл болно гэлцээд ад үзэх нь төвөгтэй. Харин Санж лхаарамба чамд бол олон хоног өвөр түрийдээ орж ижил дасал болчихсондоо л илэн далангүй ярьж байна. Энийг минь чи ямар ад шоо үзэх юм уу, бусдад тархаах биш гэж Өлзийт хэлээд хавчиг үүрэг дотроосоо жижигхэн буйлан гаргаж ирэв. Тэр дотроосоо жижигхэн хануур олж аваад,

- Аль вэ, баруун гарынхаа тохойг ил гаргаад ир! гэж шаардав. Санж тохойгоо ил гаргавал Өлзийт гарынх нь тохойн хацар тушаа нэгэн судсыг часхийтэл ханав. Цус олгойдон гарлаа. Өлзийт аман дотроо тоолж байснаа нөгөөх ханасан газрыг ганцхан дарж цусыг тогтоов.

- Одоо зүгээр болно. Балгахан хар архи хойноос нь уучихвал ч бүр сайн болно. Даанч бид хоёр шиг тэнүүлчинд хэн архи сөгнөх билээ дээ гэж Өлзийт үглэж билээ. Цусыг тийнхүү ханаснаас хойш уулын сүрд дарагдан зовох нь багасч Санжийн зовлон намдаж билээ. Амьдралын нарийн арга ухаантай Өлзийт бадарчинг бишрэн хүндлэх сэтгэл Санжид аяндаа бий болов.

“Бэрээмэг эмгэнтэй их төстэй хүн юмдаа. Бадарчлан явсаар байгаад л ийм бэрх хүн болоо биз дээ. Гашуун мөртлөө яг л үнэн юм яриад байна” гэж Санж түүний тухай эргэцүүлэн бодож байв.

Хоёр тэнүүлчин нэгэн шандны хөвөөнд ирж түр тухлан суухаар үүргээ авч, тогоо шанагаа бэлтгэж эхэлтэл,

- Энүүхэн зүүн талд Аниг Гомбоо гэдэг эмэгтэйчүүдийн сүм байдаг юм. Мөн ч хөгийн газар даа! гэж гэнэт Өлзийт ярив. Тэр үгийг сонсмогц Санж цочих шиг болж Бэрээмэг эмгэний захиасыг гэнэт саналаа. Тэгмэгц үүргээ дахин боож эхлэхэд нь Өлзийт гайхаж,

- Өвчин тусав уу? Дөнгөж буудаллахаар зэхэж байснаа болиод унах чинь! Эмэгтэйчүүдийн сүм гэхээр айв уу? Тэдний үнэр ч хүрэхээргүй хол байхад юунд нь ламбугайд алдас нүгэл болох вэ дээ! гэж шоглох

маягтай хэлэхэд Санж,

- Аниг Гомбоод очиж мөргөл үйлдье! гэв. Өлзийт тачигнатал инээж,

- Юу гэсэн үг вэ? Нүгэл алдас гэж байдаг юм бол тэр чинь болно биз дээ. Тэгээд ч толгой хагалчих гээд байдаг хэцүү газар! гэв.

- Яагаад толгой хагалчих гэдэг юм бэ?

- Яах юу байх вэ? Дандаа хүүхнүүд шавилан суудаг болохоор эр хүн харагдвал чулуугаар нүүлгээд нүүр нүдгүй болгочих гээд байдаг юм. Өвгөн чинь залуудаа саваагүйрхэж үүгээр хөллөх гээд үзсэн хүн. Баллуулах шахсан юмдаг. Залуудаа бараагүй юмыг одоо өтөлсөн хойноо юу хийх вэ? Тарагныхаа савнаас салчихаж магадгүй! гэж Өлзийт нэлээд залхсан байртай ярихыг сонсч Санжийн инээд хүрсэн боловч тэр хийдэд очихоор бослоо.

- Үгүй чи хайчих нь вэ? Хүн учры нь хэлээд байхад тоохгүй явж байж тархиа хага цохиулчихвал ямар сайн бэ? гэж Өлзийт хориглов. Санж шулуудсан хүний ёсоор толгой зайлж,

- Үгүй, үгүй. Аниг Гомбоо гэдэгт би заавал очих учиртай. Өргөл барьц өргөнө гэсэнд,

- Өргөх юм чамд юу байв гэж дээ? гэж Өлзийт эргэлзлээ. Санж түүнийг ятгаж,

- Өргөх юм бага нь үнэн. Гэхдээ Бэрээмэг эмгэн гэж бараг л миний эмэг ээж болсон ачтай хүн байсан юм. Тэр энэ Аниг Гомбоо гэдэгт шавилан сууж залуу насаа өнгөрөөсөн гэдэг. Насан хутаг болохынхоо өмнө надад ганцхан юм захисан. Түүнийг нь би биелүүлэхгүй бол ёстой нүгэл гэдэг тэр болно. Явъя. Та надад тэр хийдийг заагаад өгөөч! гэж шаардав.

- Аа Бэрээмэг эмгэн үү? Мэднээ мэднэ. Тийм хүн байсан. Улаан

галзуу авгай байсан юм даа. Хэл нь тонгорог шиг л хурц болохоор түүнийг үздэггүй байлаа. За тэрний захиас байгаа юм бол одоо очихоос биш дээ. Түүнээс ах нь энэ рүү зүглэхээс ч хаширсан хүн гэж Өлзийт яриад мөн л явахаар болж юмаа хумхив.

- Энүүхэн зүүн гүвээний цаана уулын энгэрт, өгсүү газар байдаг шиг санагдана. Шимнанцын сахил хүртсэн хүүхнүүдээр дүүрэн газар. Нэг ч эр хүн байхгүй. Эр хүнийг хийдийнхээ горилонд ч оруулах дургүй, хэцүү амьтад даа! гэж Өлзийт үглэсээр явлаа.

- Нэлээд явж нэгэн их гүвээг давмагц уулын энгэрт бүргэдийн үүр шиг юм харагдлаа. Өлзийт түүнийг зааж,

- Аниг Гомбоо гэдэг чинь тэр байна. Чамайг ч яахав, шимнанц байна гээд л оруулж орхино. Намайг ч үүдэн дээрээсээ л үлдэн хөөнө биз дээ. Аягүй бол дээр үед хөглөж явсныг минь мэддэг чавганц дайрагдаад таньж орхивол намайгаа юм үлдээхгүй дээ! гэж Өлзийт санаа зовоход нь,

- Зовоод юугаа хийх вэ? Би таныг өмөөрнө. Зөвхөн өргөл барьц төдийхнийг өгөөд гарах төдийд гайгүй биз дээ! гэж Санж аргадав.

- Аа амаргүй шүү! Өргөл барьц өгөөд гарах хооронд юу болно гэж санана. Тэгээд ч чи бол шимнанц гэдгээ сайн нууж байх учиртай. Олон үг ярьвал дуугаараа танигдчихна шүү. Байнга шивнэн ярьж бай. Хоолой чинь бэрсүүтэж, таг болсон юм гэдгийг битгий март! гэж Өлзийт хариу сургамжиллаа. Тэр хоёр хэсэг зуур дуугүй явцгаалаа. Тэгтэл нэгэн хуурай жалга дайралдав. Өлзийт,

- За хэрвээ намайг эд нар ад шоо үзээд хөөн зайлуулбал би чамайг энэ жалганд хоргодож суугаад хүлээнэ. Чи хэргээ бүтээгээд наашаа ирээрэй! гэж захилаа.

Санж түүнийг дотроо өрөвдөж, хоолой нь зангирч йрснээ,

- Гайгүй биз дээ, ах минь! гэж арайхийн хэлэв.

- Өргөл өгнө! гэж л хэлээрэй. Тэгвэл л гайгүй байдаг юм. Өргөл барьцыг авмагц л хөөнө шүү! гэж сануулаад Өлзийт түрүүлэн явлаа.

..Хийдэд ойртон очих үед үсээ хусч, шар хувцас өмссөн хөгшин, залуу янз бүрийн гэлэнмаанууд тэр хоёрыг гайхсан нүдээр ширтэж, болгоомжлон хүрээлэх маягтай болж эхлэв. Шар хувцас өмсч, үсээ хусуулж, элдэв ээмэг бөгжөөсөө салсан тэднийг харахад эм хүмүүс гэж ялгахад бэрх байлаа. “Үсээ л хусчихвал эрэгтэй эмэгтэй хүн чинь ялгагддаггүй юм уу даа?! гэж Санж дотроо гайхасхийн бодлоо. Хийдийн горилонд орж нэлээд явтал гурав дөрвөн гэлэнмаа чийрэг бүдүүн биеэ гайхуулах мэт хөндөлдөн зогсож замыг таглаад,

- Хаачих нь вэ? Буц! гэж түвдээр чанга чанга, зэрэг зэрэг шаардлаа. Дуугий нь сонсоход л сая тэднийг эмэгтэйчүүд гэж танихаар байлаа. Уянгалаг шингэн дуу нь содон ажээ.

- Энэ шимнанцад би газарчилж явна. Аниг Гомбоод өргөл барьц өргөхөөр зорьж ирлээ. Хоолой нь бэрсүүтэж, дуу нь гарахгүй болсон хөөрхий зовлонтон! Үүнд би газарчилж, бас хэлний нь оронд хэл болж явна. Оруулаач дээ, биднийгээ! гэж Өлзийт тайлбарлан гуйлаа.

- Ямар өргөл барьцтай вэ? гэж байцаав.

- Бага шиг... гэснээ Өлзийт Санжид хандан монголоор "юу өгөх гээд байгаа юм бэ?" гэж шивнэн асуухад нөгөөтөх нь "алт!" гэж хэлж орхилоо. "Алт гэнэ үү? Би буруу дуулав уу? Хол замд өлбөрч үхэх гэж яваа мөртлөө энэ муусайн хүүхнүүдэд алт өргөөд байхдаа яадаг золиг вэ?" гэж Өлзийт харамсан бодлоо.

- Юу өгөх юм бэ? гэж хүүхнүүд шаардав.

- Алт! гээд л сандрахдаа Өлзийт хэлж орхив. Тэгтэл шимнанц нар хоорондоо шивэр авир ярилцаж байснаа,

- Хоёулаа алт өргөх юм уу? гэв.

- Энэ л алт өргөнө. Над юм байхгүй! гэж Өлзийт үнэнээ хэллээ. Тэгсэн чинь хоёр гурван булиа эмэгтэй Өлзийтийг Санжаас тусгаарлаад замын хажуу дахь чулуу зааж,

- Энд суугаад хүлээж бай! гэв. Санжийг болохоор тэр газар нь зогсоогоод “Ширээтээс асууна” гэж хэлээд нэг нь яваад өгөв.

Сохор, доголон, тахир дутуу янз бүрийн зовлонд идэгдсэн хүүхнүүд сүмийн хашаанд энд тэндгүй гуниглан явцгааж байгааг Санж харлаа. Зарим нь хүрд эргүүлэн найган явна. Зарим нь суварга налан сүүна. Зарим нь сүмийн үүдэн дэх банзан дэвцэн дээр тоо томшгүй удаа сунаж мөргөсөөр байна. “Ерийн хийдийг бодвол, арай цэвэрхэн үзэмжтэй юм уу даа! Эмэгтэйчүүд болохоор аргагүй биз дээ!” гэж Санж бодож зогслоо.

Нэлээн удсаны дараа нэг гэлэнмаа ирж “Ширээт зөвшөөрөхгүй байна”. Өчигдрөөс эхлээд 49 хоногийн турш манай гориломд эр хүн оруулахыг хориглосон!” гэж хэлэв. “Бэрээмэг эмгэний захиасыг биелүүлэхгүй явах гэж үү дээ. Яаж болох вэ? Гуйх хэрэгтэй” гэж Санж өөртөө тушаав.

- Ширээт ламд хэлж өгөөч! гэж хэлэх гэснээ хоолой нь бэрсүүтсэн гэгчээ гэнэт санаад Санж Өлзийтөд очиж,

- Бэрээмэг эмгэнийг санаж байна уу? Тэр өөд болсон. Түүний захиасаар би ирлээ. Би Ширээт ламтай уулзмаар байна. Намайг оруулаач! гэж хэлэхийг шивнэн гуйхад Өлзийт өндөр дуунаар түүнийг дамжуулав.

- Бэрээмэг гэнээ? гэж хүүхнүүд лавлав.

- Тийм ээ. Бэрээмэг. Хэдэн жилийн өмнө танай хийдэд шавилан сууж

байсан!

Энэ үгийг дамжуулан хэлэхээр нэг залуухан шимнанц гүйж одлоо.
Тун их удалгүй тэр эргэж ирээд,

- Оруул! гэж байна! гэв.

Санж, Өлзийт хоёул ухасхийсэн чинь Өлзийтийг хүүхнүүд хориглож
нөгөөх чулуун дээр нь буцаан суулгалаа.

Санж тийнхүү зөвшөөрсөн ёсоор дуганд орж ширээт дамын өмнө
очив. Махлаг бүдүүн биетэй бадриун эмэгтэй ажээ. Гэвч шар хувцас
хусмал толгойгоороо эр хүнээс ялгагдахгүй байлаа. Яг л лам мэт
завилан суужээ. Эм хүн гэж бодоход инээдтэй аж.

- Өглөгийн эзэн ямар хэргээр явна? гэж огт санамсаргүй асуулт
Ширээт гэлэн лам тавихад нь Санж цочиж тэвдэж,

- Ом маани бад ми хум! Талийгаач Бэрээмэг эмгэний г эрээс ёсоор
Аниг Гомбоо хийдэд өчүүхэн алт өргөхөөр ирлээ! гэж шивнэн хэлсэн
чинь Ширээт гэлэнмаа,

- Юу яриад байнаа. Би сонссонгүй гэв.

- Энэ шимнанцын хоолой сөөжээ. Тэгээд шивэгнэж ярьдаг юм байна
гэж гэвхүй бололтой бэрээ барьсан өөр нэг гэлэнмаа тайлбарлаад
Санжийн хэлснийг давтав.

- Бэрээмэг шимнанцыг мэднээ. Хөөрхий сайхан сэтгэлтэй шимнанц
байсан юм гэж Ширээт хэлэв. Тэрхэн эгшинд Санж Ширээтийн өмнө
сөгдөж хоёр гар дээрээ хадаг өргөн барив. Хадаг дээр цун алтны тал
гялтганаж байхыг хараад ширээт үл мэдэг бөхийж түүнийг хоёр
гардан авмагц хажуу талын ширээн дээр тавилаа. Тэгээд Санжийн
духанд адислаж, модны үр хэлхэж хийсэн эрх нэгийг өгөв. Санж адис
аван тэр эрхийг өвөртлөөд босоход ширээт гэлэнмаа гарга гэсэн

дохиог гэвхүй гэлэнмаад өглөө.

“Эм хүнээс анх удаа адис авбаа, хөөрхий. Ийм юм тохиолдоно гэж Лхаарамба болтлоо бодож явсангүй дээ. Хийморьт муу болно гэж лам багш байнга айлдаж, эм сүвтнээс цээрлүүлсээр өдийг хүрсэн биш билүү?” гэж Санж бодлоо.

“Энэ цун алтны тал алга байна. Шуналт энэхүү шимнанц өөрөө авсан байж таарна. Бас тэгээд алхаа гишгээ нь нэг л биш! Дагуулыг нь шалга!” гэх үгсийг Ширээт гэлэнмаа гэвхүйдээ хэлэхийг Санж чихний үзүүрээр бүдэг сонслоо.

Хэрэг биш болж байгааг Санж мэдрээд түрэгхэн шиг гарлаа. Тэгтэл баахан гэлэнмаа цугларч Өлзийтийг хүрээлж байгаа харагдав. Санж яаран алхалж Өлзийт рүү хүрч очсон чинь нэг бүдүүн тарган гэлэнмаа Өлзийтийн захнаас бадриун гараараа атгаж аваад,

- Энэ гайхал мөн байна. Долоон жилийн өмнө намайг шимнанцын сахилы минь золтой л эвдүүлчихээгүй, түмний шившиг болгосон гайхал энэ явж байна! Одоо чамаас өшөө авна даа! гэж хашгираад Өлзийтийн дал мөр лүү цохиод авлаа.

- Хек, хек хек! гэж хүүхнүүд хашгиралдлаа. Тэгээд Өлзийтийг бүслэн авч цохих нь цохиж, өшиглөх нь өшиглөж бөөн зодоон үүслээ. Санж Өлзийтийг өмөөрөх санаатай хашгирах гэсэн боловч дуу гаргаж болохгүйгээ гэнэт санаж амаа бариад дэмий л гүйн хүрч улайрсан гэлэнмаануудыг хойш нь болгохыг оролдов. “Шимнанц чи юу ч вэ? Хойшоо бол! Бид энэ нүгэлтэнг гэсгээнэ!” гэж тэд улайран хашгиралдаж Өлзийтийг гөвшихөө үргэлжлүүлэв. Хөөрхий Өлзийт олон хүний хөл, гарын нүдүүр болж толгойгоо барин нааш цааш бөгтөгнөж байлаа. Тэгтэл анх түүнийг зодохыг уриалсан тарган эхнэр Өлзийтийн дулдыг булаан авч толгой дундуур нь янхийтэл цохив. Өлзийт ухаан балардан газар ойчихыг хараад Санж тэсч чадсангүй, нөгөөх зодооч гэлэнмаануудын дундуур хамаг хүчээ гарган хага зүсч ороод Өлзийтийг өндийлгөн өвдөг дээрээ толгойг нь түшүүлээ.

Тэрний нүд нь хачин эвгүйгээр эргэлдэн амь нь гарлаа. Санж биеэ барьж чадсангүй,

- Алчихлаа шүүдээ, шуламнууд минь! гээд байдаг бүх хоолойгоороо хашгирчихлаа.

Улангассан гэлэнмаанууд тэр үгийг сонсоод алмайрах мэт түр чимээгүй болов. Тэгтэл түрүүчийн тарган эм лам,

- "Хараач! Эр хүн байна шүү дээ! Шимнанцын хувцас угласан эр хүн байна!" гэж хашгирлаа. Бусад нь

- Тийм байна. Үүнийг бас алцгаая! гэжхашгиралдаад Санж руу дайран орж ирэв. Санж тэднийг Өлзийтийн дулдуй, өөрийнхөө таяг хоёроор хослуулан эргүүлэн хөөхөөр эсэргүүцэж гарлаа. Таяг нь хугарав. Дараа нь дулдуй нь бас хугарлаа. Тэгмэгц улангассан эхнэрүүд Санж руу дайран орж ирлээ. Нүдэх нь нүдэж, зулгаах нь зулгааж, өшиглөх нь өшиглөж байлаа. Санж үзэлцсээр байв. Тэгтэл,

- Больцгоо та нар! Яагаад хүн зодоод байгаа юм бэ? гэж хэн нэгэн эрэгтэй хүн бүдүүн дуугаар зандрах сонсогдов. Хүүхнүүд түүнийг анзаарахгүй гагцхүү Санжийг л нүдэхээр улайрч байлаа. Гэтэл буун дуу гарахад нь эхнэрүүд сая цочиж зодооныхоо шуналаас түр саллаа. Шийртэй буу үүрсэн хэдэн морьтой хүн тэднийг бүсэлжээ. Санж өндийн харвал тэдний дотор хүүрамчаар инээвхийлсэн Чогсон зогсож байхтай харц нь тулгарлаа. Цочихдоо дальдгас хийлээ.

- Тэр зогсож байгаа нь мөн байна! гэж Чогсон ташуураараа Санж руу зааснаа,

- Лхаарамба Санждолбийчойжамц амгалан морилж явна уу? гэж доогтойгоор мэндпэв. Тэгснээ тачигнатал инээлдэж,

- Ха ха ха. Түүнийг хараач таминь! Лхаарамба хүн шимнанц хувцастай явж байхыг харна гэж санасангүй гэж Чогсон дооглож

байхыг сонсоод Санжийн уур нь хүрлээ. Тэгтэл нөгөөх буугай хүмүүс ухасхийн бууж ирээд Санжийг барин авч хүлэв. Тэгээд хөтөлгөө морин дээрээ суулгаж морины гэдсэн доогуур Санжийн хоёр хөлийг холбон хүллээ. Баригдаж сүйрэлд орсон нь ил боллоо.

- Таминь ээ, би энэ эмст алагдсан нөхрөө оршуулаад явах юмсан! гэж Санж гуйлаа.

- Битгий чальч! Тэрний үхдлийг гэлэнмаа нар шувуунд хаяад өгчихнө. Харин чамайг бол бид Лхас зуугийн таснуудад хүргэж өгнө! гэж цагдаа нар заналтайяа хэлээд цааш хөдөлцгөөлөө.

Хөөрхий Өлзийтийн бие Аниг Гомбоо хийдийн шар шороон дээр бараантсаар хоцроход Санж сүүрс алдаж,

- Чогсоон, чи нэг зиндааны минь хүн байна. Хөөрхий тэр бадарчныг хүн ёсоор оршуулахад туслаач! гэж гуйсан чинь,

- Нэг зиндаанд байсан нь үнэн. Гэвч чамаас болж би өөрийн хар толгойг алдахад хүрээд байна. Чамайг Ланцысад бүрэн тушааж байж сая яс амарна. Одоо чи бол миний нөхөр ч биш, зиндааных ч биш. Харин дайсан! гэж Чогсон хэлээд мориндоо ташуур өглөө.

Тэд морины хар хурдаар Аниг Г омбоо хийдээс холдон одлоо. Санжийн морины цулбуурыг цагдаа нар барьжээ. Хорвоогийн энэрэлгүй гашуун явдлыг ийнхүү Санж анх удаа биеэрээ мэдэрч маш их гутлаа. Ийм юм болсны дараагаар амьд явах ч сонирхолгүй шиг санагджээ.

Тэд зогсоо зайгүй давхиулсаар байгаад шөнийн харанхуй нөмрөх хүртэл их л холдлоо. Нэгэн их хавцалд орж очлоо.

- За энд түр хоноглож, нүднийхээ хорыг гаргаад явъя! гэцгээлээ. Санжийг морин дээр нь хүлээтэй чигээр нь байлгалаа. Цагдаа нар гурван чулуу тулж цай чанацгааж байлаа. Яг цайгаа болгоод аягалан

уухаар тэд сууцгаалаа. Тэгтэл энд тэндээс буун дуун гарч баахан дээрэмчид довтлон орж ирлээ.

- Буунуудыг нь хураагаад ав! гэж хэн нэгэн хүн дээрэмчингүүдэд тушаах нь сонсогдов. Санжийн чихний хажуугаар сум шунгинан өнгөрч байлаа. Зэрлэг суманд алагдчихвий гэж Санж дотроо их л эмээж байв. Дээрэмчид цагдаа нар өөр хоорондоо буудалцаж морьд янцгаалдан, эмээлийн дөрөө харшилдаж, хүмүүс хараал зүхэл орхиж айхтар шуугиан дэгдлээ. Хүмүүс ёолох сонсогдлоо. Тэр дотор Чогсонгийн дуу гарч байлаа. Суманд оногдчихгүйн тулд Санж морины дэл рүү бөхийж байлаа. Тэгтэл морь нь суманд хайруулсан боллолтой цочин цовхчиж зэсрэн зугтлаа.

- Нэг морьтой хүн зугтлаа. Хөөгөөд бариад ав! гэж дээрэмчид хашгиралдлаа. Санжийн араас өөр нэг морьтой хүн нэхэн хөөж дор нь гүйцэн ирлээ. Аюулаас цочин сүрдээд,

- Амь авраарай! гэж Санж айсандаа монголоор хашгирч орхилоо.

- Хүүе энэ чинь монгол хүн үү дээ? гэж харанхуй дундаас айхтар танил дуу сонсогдов. “Яасан танил дуу вэ? Энэ чинь хэн юм болоо” гэсэн бодол Санжийн санаанд эгшин зуур гялсхийн орж ирээд тэрхэн мөчид хариу нь олдож,

- Бөхмагнай гуай юу? гэж Санж хашгирав.

- Хөөе тийм байнаа. Чи хэн бэ? гэж хариу хашгирах нь Бөхмагнайгийн дуу яг мөн байлаа. Санж амь наана, там цаана явахад Бөхмагнайтай ингэж уулзсандаа асар их гайхах, баярлах хослов. Тэрхэн эгшинд Санжийн морийг хэн нэг хүн цулбуурдан авч зогсоогоод чанга дуугаар,

- Чи хэн бэ? гэж монголоор асуулаа.

- Би Санж байнаа. Бэрээвэн хийдийн шавь. Та Бөхмагнай гуай юу?

гэж Санж асуулаа.

- Өө Санж юм уу? Яасан хачин тохиолдол вэ? Би Бөхмагнай байна гээд тэр хүн Санжийг морин дээрээс нь тэврэхийг завдсанаа,

- Үгүй чи чинь хүлэгтэй юм уу? гэв.

- Би морин дээрээ хүлэгдээд явж байна. Лхас зуугаас оргож яваад эдэнд баригдлаа. Намайг буцааж Ланцысад тушаахаар явж байна! гэж Санж учирлав. Тэр үгэнд тэд итгэсэнгүй бололтой,

- Ланцысаа гэнээ? Тэр тамын оронд юу гэж чамайг аваачих нь вэ? Мөн горьдов оо, энэ муу үхэр тангадууд! гэж Бөхмагнай шүд зуун хэлээд Санжийн хүлгийг хутгаараа тас татан хаялаа. Бөхмагнай,

- Бид энэ хэдийн буунд нь шунаж байлаа. Тэгээд энд отож суусан юм. Сайн буутай юм билээ. Ах чинь түвдийн цэргээс оргож уулын дээрэмчин болсоор олон жил өнгөрлөө. Түвд эхнэр авсан гэж ярихад Санж гайхаж, - Отгон эгч яасан бэ? гэвэл Бөхмагнай,

- За тэр яахав. Үргүй амьтан. Нутаг буцаа биз. Харин чи яагаад оргоод баригдаад явж байдаг билээ? гэхэд нь Санж өөрийн бүхий л учрыг түүнд ярив. Тэр хооронд дээрэмчин нөхөд нь олзны буугаа цуглуулан ирэв. Бах нь ханасан дуугаар хэн нэг нь баясав.

- Хэдэн сайн буутай боллоо. Эзэд нь цөмөөрөө шамбалд явчихлаа. Өөрсний нь л хохь гэж нэг дээрэмчин бахдах мэт ярилаа.

...Бөхмагнай дээрэмчин нөхдийнхөө хамт Санжийг нутаг руу нь нэлээд дөхүүлж өгөх, ядахдаа Харлаг тагийн нуруу хүргэхээр амлав. Ийнхүү Санж нутгийн бараа харах болсондоо амьдралын замд үзсэн хамгийн том зол баярыг эдлэв. Тэр шөнөдөө тэд зам буруулан зогсоо зайгүй явцгааж үүр цайх хүртэл нэлээн холджээ. Мөр мөшгөн хөөхөд огтхон ч сэжиглэгдэхгүй зам болоод аргыг гагцхүү дээрэмчингүүд л мэддэг ёсоороо тэд шөнийн харанхуйд ч өдөр юм шиг баримжаагаа

олж явлаа. Бөхмагнай эмээлийнхээ тохмон доороос бараг түүхий
шахам мах гаргаж Санжид морины явдал дунд өглөө. Адууны хөлс
ханхлан бөөлжис цутгамаар боловч өлссөний эрхэнд Санж түүнийг
морин гүйдэл дунд хэд хэд зулгаан зажлалгүй залгилаа.

Хорин долоо. Хамбын ширээнээ өргөмжлөв

Хад нь хар ч хагд нь ногоон
Элэг нь хар ч цөс нь ногоон
Ус нь хар ч замаг нь ногоон

Хаянхярваа буюу морин толгойт гэдэг бурхны алтадмал хөрөг хамгийн түрүүнд Хамбын нүдэнд туслаа. Гурван тийш харсан гурван тэргүүнтэй агаад тэдгээр нь хортонг номхотгохын учир соёогоо ярзайлгаж, цахилгаан гялбах мэт хилэнгээр хөмсгөө дөрвийлгөсөн, гурвалсан мэлмийтэй, титмийн дээгүүр таван хохимой чимэгтэй, зургаан мутрын баруунд очир, хадамгай, илд, зүүнд нь гал, хатгуур, бугалга барьж, зүүн бойвгуудыг сунган жийж, барууныг хагас жийн хумьж газар дэвсэх мэт зогсоод хоорондоо сүлжилдэн толгойг цогнойлгосон найман могойг гишгэн оршсон, лагшиндаа гахайн арьсыг годоор нь зангидан нөмөрч, дотор эрхтэнгээр холбож хийсэн эрхийг зүүсэн, тэргүүн дээгүүр нь дадарласан таван улаан галын дөлөн дээрээс гурван морин толгой өмнө зүгийгхаран цухуйсан, үнэлэшгүй эрдэнэ шигтгэн чимсэн ээмэг, хоолойн чимэг, мутар, бойвгын бугуйвч, бөгж, сугавчлууур, хоолойвч зэргээр бэндэрлэсэн ийм нэгэн хөргийг Хаянхирваа бурхан гэдэг ажээ. Малчдын шүтэх дуртай тэр бурхныг Хамба лам Санждолбийчойжамц хамбынхаа ширээнд залрахын өмнөх мөчид харсандаа сэтгэл нь хачин өөрчлөгдлөө. Түвдийн өндөр уулс, Хөх нуурын өргөн хөндий, Алашаагийн элсэн цөл, Ховог сайрын хужирт цайдмыг туулан эх нутаг юугаа зорин явахын завсар орон хийдийн суугаа амьдралаас дайжиж, морин дэл дээгүүр явахын амт авсан болохоор Хамбын сэтгэлд морин толгойт бурхан хямрал төрүүлжээ. “Ингээд л бүх насаараа энэ ширээн дээр нэгэн хэвээр завилан сууж, урьд нэгэнт цээжилсэн номоо өдөр бүрий давтан давтан унших ажлаар хорвоог элээх болно доо” гэж Санждолбийчойжамц лхаарамба Буянзалбирах хийдийн хамбын суудалд суухдаа бодлоо. Түүний иймэрхүү юм

бодож байгааг хэн ч тааж мэдэхгүй нь лавтай юм. Төрсөн нутагтаа эргэж ирснийг нь мэдмэгц Буянзалбирах хийдийн том толгой лам нар түүнийг хүрээлэн авч Хамбынхаа албанд өргөмжлөн залахаар ятган зөвшөөрүүлжээ. Түвдийн Лхас зуугийн газраа олон жил сууж бурхны номонд цоорон лхаарамбын зэрэгт хүрсэн тийм хүн тэр нутагт өөр байсангүй болохоор Буянзалбирах хийдийн лам нар Санжийг ирсэнд их олзуурхжээ. Одоо түүний номын нэр нь Санждолбийчойжамц болой. Номын далай болсон эрдэмт тэр хүнийг өргөмжлөн залснаараа уулын бөглүү аманд шигдэн суурьшсан бяцхан Буянзалбирах хийдийн нэр алдар ч олон түмэнд улам сайнаар хэлэгдэх учиртай байлаа.

Сүмээр пиг дүүрэн хүн цугларчээ. Увш хуврагнуудаас эхлээд гэцэл гэлэн, ширээт, шавранг хүртэл бурхны шавь нар, тэрчлэн өглөгийн эзэд мөргөлчид багшран цугларч сүмийн дотор төө зай ч үлдээлгүй бүрхэн зогсоцгоожээ. Дуганд албан хаах ёстой хэргэмтнүүд бүрэн өмсгөлөө агсаад зогсож байлаа. Ширээт лам цорж, шинзав, засаг лам, да лам, нансоо лам, гэвхүй, унзад, нярав нар дэс дэсээр байраа эзлэв. Улаан, шар хадаг, долоон алд орхимжоо савсуулан, жинжээ ламаа дагуулсан гэцэл, улаан эмжээрт шар догоого нөмөрч гяраг бүс бүслэн, шамтав, орхимжоо мөрлөсөн гэлэнгүүд эгнээгээрээ ярайна. Тэрчлэн ширээт ламын туслах лаацав, житбүү хоёр тахилч, гүүрэмбэ, дуганч, мигрэмбэ, жимаа лам, сойвон, гээг, жинжээ лам нар үүгээр түүгээр үзэгдэнэ.

Цөмөөрөө л Санждолбийчойжамц Хамбын зүг бишрэл, итгэл сониучлал дүүрэн нүдээр харцгааж байлаа.

Харангын хурлаар өглөөний уншлага эхэлнэ гэдгийг санахад Санжид олон олон жил давтсаар байгаад өнгөгүй болчихсон босгоны мод юм уу эсвэл жажилсаар байтал амтгүй болчихсон шөрмөстэй борц шиг сонингүй санагдлаа. Харангын хурлын дараа түй өргөнө, аршаан таринадана, манз зооглоно. Өдөр дунд магтаалын хурал хийнэ. Бурхдын үйл явдлыг магтан унших тэр хурлын дараа оройн ээлжинд үхсэн амьтдын ерөөлийн хурал хийнэ. Ийм л ажлаар өдөр хоног, жил сар, за тэгээд бүтэн амьдрал өнгөрнө. Хурал нэгэн аялгуугаар бөвтнөн

хурна. Маани татах, унзадын тунжирдах дуунаас өөр нэг их содон дуу авиа гарахгүй. Хэнгэрэг, дэншиг, ганлин, сэлнин, цан, мигаан, лимбэ, жүрүү, шүгэл, тунраа, бишгүүр, дун бүрээ, үхэр бүрээний дуу янз бүрийн хурал, ёслолын үеэр дуулдах боловч тэр бүхэн цөм л мигримбийн заалтаас гажих ёсгүй. Бас л нэгэн хэвэнд мөнхөд тогтоосон жаяг ёсыг дагана. Тэгэхээрээ лам нарын нэгэн аялгуугаар бөвтнөн унших маягаас ялгаа юун байх вэ? Нохой хуцахыг тунраагаар, шувуу жиргэхийг жүрүүгээр, луу хүрхрэхийг үхэр бүрээгээр дууриалгана. Гэвч тэр бүхэн нэг л өнгө аястай байх учиртай. Үүнийг лхаарамба цөмийг цээжээр мэдэж байлаа. Жинжээ ламын туслах хийж байхдаа Бэрээвэн хийдэд үүнийг мэдэхийн цаана мэдэж, сурахын цаана сурчээ.

Банди байхдаа шавилан сууж байсан энэхүү дацангийн доторхи юмсыг Санж лхаарамба эргэн тойрон ажин харлаа. “Бүгдээрээ л хуучин янзандаа байх шиг вэ дээ? Нэмэгдсэн юм алга. Харин утаа тоос нь нэлээд зузаарчээ. Нэг сайхан сүм барих цаг болсон юм байна даа” гэж Санждолбийчойжамцтан дотроо эргэцүүлэн бодлоо. Тэгтэл өөрийнх нь багадаа шавилан сууж байсан жавдан нүдний буланд харагдлаа. Цочих шиг болж жавдангаа ажиглав. Хэвээрээ байлаа. Дээр нь суугаа бяцхан бор банди нүдээ бүлтэгнүүлэн зогсож байхыг харав. Сэтгэл нь уярч хоолой нь зангирлаа. Тэр л жавдан дээрээс алс газар сурахаар одож билээ. Одоо түүнийг залгамжлахаар бас л нэг амьтны үр шар баринтаг өмсөөд зогсож байгаа ажээ. Хорвоо гэдэг их урсгал ажээ. Нэг нь нөгөөг залган урсана. Нэг нь нөгөөг халан үргэлжилнэ. Түүний тавцанд сав ертөнц мөнхийн манцуй болон нэгийг үдэж, нөгөөг тосно.

Хамба ламд энэ бас л мэдээжийн зүйл. Номын үгийг хздэн түмэн удаа давтан давтсаар нэгэн ламын бие гүйцэхгүй болоход түүний шавь үргэлжлүүлэн мөнөөх номыг нь үг үсэг алдалгүй давтан айлдсаар мөн л насны туйлыг үзэж биеийг барна. Бурхны айлдсан бүхэн хэн ч халдашгүй, хэн ч засашгүй дархан тул хоёр мянгаад оны тэртээ уншиж байсан уншлага өнөөдөр ч хэвээр ажээ.

Багынхаа жавдангаас харцаа зайлуулах гэтэл бондгор бандийн цаад талд төрсөн эцэг Сайнцогтын бишрэн сүсэглэх царайг олж хараад хамба лам Санждолбийчойжамц хэрдхийн цочих шиг боллоо. Хөөрхий нь баяр бахархал, итгэл сүшиг хоёр хосолсон нүдээр үр болсон Санжийгаа бишрэн ширтээд баруун гартаа хир даг болсон малгайгаа базлан бөгцийн зогсож байгаа харагдав. “Зайлуул даа! Муу эцэг минь үр намайгаа өдий өндөр тавцанд гарч нутгийнхаа цорын ганц хийдийн хамба лам болоод байгаа энэ мөчийг үзнэ гэж бодоогүй л явсан биз дээ. Одоо тэгээд хүүгээ Буянзалбирах хийдийн тэргүүн хамбын суудалд сууж байгаа энэхэн үед юу бодож зогсдог бол доо? Сүшиг бишрэл дүүрэн цээжинд нь баяр хөөр оволзож байдаг болов уу? Эсвэл айн бишүүрхэж зогсоо юм уу? Ихэс дээдсийн сэнтийд заларсан хүүдээ ойр ч очихоос болгоомжилж байгаа юм уу?” гэж Санж эргэцүүлэн бодлоо. Тэггэл ээж нь санаанд орлоо “Төрүүлсэн хүүгийнхээ ид шидийг үзэж чадалгүй ёртөнцийн мөнх бусыг үзүүлчихсэн нь хичнээн халаг билээ! Хөөрхий ээж минь энэ мөчийг үзсэн бол хүү төрүүлж зовсоноо мартагнан сэтгэл нь дэвтэх байсан болов уу? Намайгаа эрдэмтэй лам болоосой гэсэн ганц хүслээр л эх, эцэг минь аж төрж байлаа. Одоо тэгээд би гэдэг хүн эрдмийн оройд ойртлоо. Гэвч ядуу эцэг эхэд минь тэрнээс юу халдах билээ. Эх минь юуны ч ид шидийг үзэж чадсангүй. Эцэгт минь миний хамбын суудал юу өгөхсөн билээ. Түлээгий нь бэлтгээд, аргалы нь түүгээд өгөх үү? Малы нь адгуулаад, гэрий нь бариад өгөх үү? Үгүй шүү дээ. Хамбын ширээндээ суусаар л шар жанчиндаа хулгасаар л энэ хорвоог дуусгана. Баймгай том сүмийн хамба ламыг тэд нар тийм амархан дураар нь тавих уу даа?” гэж Санж бодоод эхний жавдан дагуу цувран зогсож байгаа том толгой лам нарыг ажиглан харлаа. Гууль, зэсээр цутгаж хийсэн мэт гялтгар халзан толгойтой, бүдүүн нугалаа, гүн үрчлээнд хэрэгдсэн шарман өнгөтэй шалхгар хацартай гэлэн, гэцэл, гавж, унзад, гэвхүй нарын царайд амирлангуй, тоомсоргүйн шинж бүрэн төгөлдөр хуралджээ.

Санж лхаарамбыг хүн бүр ажин харж байгааг санамагц тэр хамбынхаа суудалд аяархан шигдэн доошлов. Түүнд хоёр сойвон туслах мэт дүр үзүүллээ. Хамбыг суумагц лам нар дор бүрийн

жавданд боривоо бохирон завилцгаалаа. Сүсэгтэнгүүд шалан дээр хоёр өвдгөөрөө түгхийн сөхөрцгөөлөө. Сүмд таг чимээгүй боллоо. Гэв гэнэт төөрсөн зөгий орж ирээд сүмд дүнгэнэн нисч эхлэв. Лам нар сэжиглэв. Гагцхүү эцэг Сайнцогт тэрхүү зөгийд их л тал өгч баярлах мэт болохыг Санж ажиглан харлаа. Зөгий гэрт орвол зуншлага сайн гэдэг.

...Эрт урьд цагт Хангарьд шувуу дэлхий дээр ямар амьтны мах хамгийн амттай болохыг мэдүүлэхээр хараацай, зөгий хоёрыг явуулжээ. Зөгий амьтан болгоныг хатгаж амталсаар яваад хүний мах хамгийн амттайг мэджээ. Хараацай зөгийтэй дайралдаад,

- Хэний мах амттай гэж хэлэхээр явна? гэж зөгийнөөс хараацай асуухад,

- Хүнийх! гэж хариулжээ. Хараацай хүнийг аврахын тулд заль хэрэглэн,

- Худлаа байлгүй. Үнэнсэн бол чи хэлээ харуул гэхэд зөгий хэлээ урт сунган харуулахад нь хараацай тэр хэлийг сугалан хаяжээ. Тэгээд хэлгүйн эрхээр зөгий хий дэмий л бүвтнэн дүнгэнэдэг болжээ. Хараацай, зөгий хоёр Хангарьдад очиход зөгий юу ч ойлгогдохгүй дүнгэнэн эргэлдсээр байж. Хангарьд учрыг ухаарахгүй байхад нь хараацай,

- Хүний мах хамгийн муухай, могойн мах хамгийн амттай байна гэнээ! гэж зуучлан хэлжээ. Хангарьд түүнээс хойш могойн мах иддэг болжээ. Хараацай болохоор хүнийг хангарьдаас аварсныхаа ачийг санаж хүний урдуур өмнүүр хэрэн нисдэг болжээ.

Үлгэрт ингэж гардаг юм. Хангарьд шувууг эрээн могой зууснаар зурдаг ёсон тийнхүү гарчээ. Үүнийг санаж лам нар дуганд орсон зөгийн дүнгэнэн нисэхээс цээрлэж байсан хэрэг ажээ. “Хамбыг шинээр залахад сүмд зөгий орж ирдэг нь юу билээ” гэж Дэмчиг гавж, Дэчин унзад, Дэмбэрэл гэсгүй гурав нэгэн зэрэг сэжиглэн боджээ.

“Хүүгий маань хамбын ширээнд өргөмжлөгдөхөд зөгий орж ирдэг нь буян зөгнөсөн сайхан зөн боллоо” гэж Санжийн эцэг Сайнцогт баярлав. Үнэхээр малчин хүн зөгийг өгөөмөр зун болж, балын хур буухын дохио гэж баярлан билэгшээдэг байлаа. Тэр л заншлаас Сайнцогт гажсангүй. Тэр л ёсоороо бодож байлаа.

Санждолбийчойжамц лхаарамбын гарт гүсүмтүг судар бариулав. Түүгээрээ лам нар болоод сүсэгтэнд адис өгөх учиртай. Эхлээд лам нар адис авлаа. Дараа нь сүсэгтэнгүүдийн урт цуваа өнгөрлөө. Тэгтэл эцэг Сайнцогт буурал толгойгоо хүүгийнхээ өмнө бөхийн адис горьлон ирлээ. “Эцэгтээ адис өгөх гэж үү дээ?” гэсэн бодол Санжийн оюунд цахилгаан адил харван орж ирлээ. “Би хэдийгээр хамба лам ч гэсэн төрсөн эцгээ яаж адислах юм билээ!” гэж тэр эргэлзэн бодлоо. Ийм тохиолдол болно гэж урьд өмнө огтхон ч тэр бодож явсангүй. Эцэг нь бөндгөр буурал толгойгоо бөхийлгөн хүүгийнхээ адис хайрлахыг хүлээсээр байлаа. Аргаа барсан Санж сэмхэн,

- Аав минь өнгөрч хайрла! Би яаж эцэг тандаа адис өгөх билээ гэж Санж шивнэн хэлэв. Түүнийг сонсмогц эцэг нь гайхсан нүдээр хүүгийнхээ өөдөөс өлийн харлаа. “Аав та яах нь вэ? Өнгөрөөч. Би танд адис өгч яаж болох вэ?” гэж Санж дахин шивэгнэлээ.

- Юу гэнээ? Надад яагаад адис өгөхгүй гэж? Чи одоо миний хүү биш Буянзалбирах хийдийн хамба лам шүү дээ! Би хүүгээсээ биш хамба ламаас адис гуйж байна! гэж эцэг нь бараг л ихэнх хүмүүс дуулдахаар хэлж шаардахад түүний дуунд эрс шийдэмгий өнгө илэрхий байлаа. Олон мөргөлчид гайхан хүлээцгээж байлаа. Эцэг нь хүүгээсээ адис горьдон толгой нь бөнжигнөн үл мэдэг салганан чичрэхийг Санж ажиглаад, тэсч чадсангүй, өрөвдөх сэтгэл нь дийлж, нүдээ анин гүсэмтэг судраар аавынхаа тэргүүн дээр гурвантаа адислав. Эцэг нь сэтгэл ханаж, хязгааргүй баярлан хөөрч, инээмсэглэл, нулимс хоёр хослон дүүрсэн нүдээрээ хүүгээ талархан харснаа бөгтөр нуруу нь эгцлэн улам ч гоолиг болох шиг харагдлаа. Тэгээд орь залуу хүн шиг шалмаг золбоотой болж, буурал толгойгоо өндөрт өргөн, шүтээний

болон хүүгийнхээ өмнүүр жавхаалаг алхан өнгөрлөө.

“Би биш энэ л хийдийн хамба лам л эцэг танд адис өглөө. Та ч үүнийг хүссэн. Тэр л ёсоор тань болголоо, Алдсыг нийгүүлстүгэй!” гэж Санж дотроо бодлоо.

Хожим энэ тухай эцгээсээ ийм үг сонсож билээ. “Эцэгтээ хүү нь адис өгөх нүгэл алдас болно гэж их зовсон юм” гэж Санжийн хэлсэнд аав нь “Адис өгөөгүй бол би айхтар их гомдох байсан. Миний мах ясны тасархай хүү минь бурхны хутгийг олж хамбын ширээнд залраад байхад эцэг үрийн ёс хамаагүй хэрэг. Лхас зуугаас ирсэн лхаарамбаас адис авсан минь хувь заяа. Хүүгээсээ адис авсан эцэг байгаагүй бол ядуу тэнэг Сайнцогт хүүгээсээ адис авсан анхны эцэг болог гэж бодоод аав нь тун их баярлаж билээ” хэмээн ярьжээ. Эцэг өөрийнхөөрөө бодож, түүнийгээ л зөв гэж тооцдог ажээ. Хүү бас л өөрийнхөөрөө бодно. Очиж очиж төрсөн эцэгтээ адис тавьсан нь түүнд ичгэвтэртэй, бас алдас болмоор эвгүй зүйл мэт санагджээ. “Эцгийгээ адислаад байх тийм өндөр дээдэс гэж хаана төрсөн билээ. Санждолбийчойжамц гээч нэгэн шинэхэн өргөмжлөгдсөн хамба ламд ид шидтэй, ер бусын юм юухан байх билээ? Юу ч байхгүй. Байгаа юм нь гэвэл цээжээ бэтгэртэл үсэгчлэн тогтоосон баахан ном, бараамидаас эхлээд мадьяамагама, абидарма, винай, гаринын ёс, вишнейн ялгалыг хүртэл мэднэ. Хайв жумнейн даяг гэдэг орчлонгийн явдлаас эхлээд найман мянган мөрт бурхдын магтаал жадамба судар, аравсал гэдэг гурван цагийн мянган бурхдын зан үйл, хар цагаан гүрмийн ном, хараал зүхлийн сундуй судрыг хүртэл Санждолбийчойжамц гэгдсэн хамба миний бие цөмийг цээжээр мэднэ. Гэвч тэр бүхэн хөөрхий эхийг минь дахин амилуулж, хөгшин эцгийг минь баян чинээлэг болгож чадах уу даа? Яагаад ч үгүй дээ” гэж Санж лхаарамба бодож суулаа. Түүний бодол холын юманд бэлчиж, харц нь өөрчлөгдсөнийг тэргүүн ширээт лам ажиж мэдээд гүн ухааны далайд живжээ гэж ойлгов.

Саяий бойжи жүгши медогдан,
рирааб линши нида жамбаади

Санжей шинду мигло пулбег,
Догун намдаг шинлажот баршог!

гэж сүм дүүрэн суусан лам, хуврагууд дүнгэнэлдэн нэгэн дуугаар уншлаа. “Газар дэлхий болон сүмбэр уул тэргүүтнийг бүтээн хүжсээр сүрчиж, огторгуйг наран сарнаар чимсэн Бурханд ач мандал өргөөе!” гэж энэхүү шад шүлгээр мөргөл эхэлжээ. Гэвч ийм юм хэлж байна гэдгийг сүсэгтэнгүүд байтугай лам нарын ихэнх нь ухаарч мэдэхгүй. Гагцхүү том толгой лам нар л мэднэ. Түвдээр юмуу самгарьдаар үйлдэх бурхны номын уншлагыг монголоор орчуулж тайлбарладаг лам багш бараг үгүй. Үл ойлгогдох харь орны хэлээр уншсан номын гүн утга байтугай эгэл үгсийн нь санааг ч гадарлахгүй болохоор гагцхүү мухраар сүсэглэн биширнэ. Ийнхүү байдпаар олон үеийг элээн мөргөл үйлдсээр өнөөг хүрчээ.

Магтаалын хурал өглөөгүүр хурж ийнхүү дуусахын үед түй өргөхөөр унзад Дэчин, хоёр тахилчийн хамтаар тольт бумба барьсаар сүмийн гол дунд хүрч ирэв. Олон жил зүлгэгдсэн хүрэл толийн өнгө нь шилнээс ялгагдахгүй гялалзаж байв. Толийг хүндэтгэлтэйгээр дээдлэн барьж, лам нар тэнгэрийн магтаал уншиж, сэлнин, хэнгэргээ цохин тэнгэр эзэгнэсэн бурхдад магтаал өргөв. Хоёр тахилч бумбатай аршаанаас толь руу дусаахад унзад өнгө өнгийн хадаг холбосон алчуураар толийг арчлаа. Ийм үйлдлээр түй өргөн дуусав. Хормустын эрх барьсан гучин гурван тэнгэр гэгчид магтаал өргөж байгаа нь энэ юм. Толь нь тэнгэрийг билэгдсэн утгатай ажээ. Гэвч гэгээн толь гэж бас иймэрхүү толийг эрлэг номон хаан буюу тамын орны эзэн гартаа барьж хүн толгойтны хийсэн нүгэл буянг тэрүүндээ харж үнэн худлыг ялгаруулдаг гэж шашны сургаал байдаг билээ. Тэнгэрийн толь, тамын толь хоёрын хооронд ертөнц, тэнгэр, бурхад, хүн хийгээд хэлгүй адгуус, бирд, тамын амьтад оршин суудаг мэтээр Бурхан номложээ.

Хорин найм. Орон хийдийн суурь тавив

Эрхтнээс чих хэлтгий
Эдлэлээс домбо хэлтгий
Эрдэнээс дун хэлтгий

Буянзалбирах хийдэд ерөөлийн хурал эхлэх дөхөж байлаа. Хамба лам Санжлолбийчойжамц жаран нугалааст шар лагойгоо нөмрөн бөгтийн суужээ. Түүний царайд гунигийн хөх сүүдэр тодорхой.

- Өглөгийн эзэн Сайнцогт эхнэр Цэндээгийнхээ хойноос манз барьж ерөөл гуйжээ! гэж өндөр дуунаар зарлахад Санждолбийчойжамц лхаарамба бөгдгөсхийн цочлоо. Эцэг Сайнцогт нь талийгаач эх Цэндээгийн хойноос ерөөл авахуулахаар хийдийн нийт лам нарт манз оруулан уншлага гуйсан ажээ. Эцгийнхээ хүсэлтээр эхийнхээ дурсгалд ерөөл уншина гэж бас л Санжийн бодож яваагүй юм тохиолдлоо. Ерөөл гуйсны өргөл барьцанд манз оруулахаар эцэг нь амлажээ. Ингэхээр ядуу муу эцгийнхээ бэлдсэн цайг ууж идээд оронд нь талийгаач эхийнхээ төлөө ерөөл унших явдал болжээ. “Эцэг яасан зовлонтой хүн бэ? Заавал энд манз өргөж ерөөл гуйдаг нь юу билээ. Тэрүүнд орвол намайг гуйж гэртээ уншуулсан нь дээргүй байсан юм болов уу? Ээжийн хойноос ерөөл авахуулахад манз цай шаардаад байхааргүйсэндээ би” гэж Санж лхаарамба ичингүйрэн бодлоо. Тэгтэл нүдний буланд буурал толгойт хөгшин эцэг нь сүмийн үүдэн тушаа бөгтгөнөж зогсох нь харагдав. Хүүгийнхээ толгойлсон энэ хийдэд ерөөл хуруулах болж байгаадаа тэр их л хөөрөн бахархаж, бөөн баяр яваа бололтой. Манз, зэд мөнгө, эдлэл тэргүүтэнд мөргөлчид өргөн барьж ерөөл уншуулдаг, үхсэн амьдын ерөөл гэдэг хурал бараг өдөр бүр хурдаг билээ.

Аливаа хүн, хүний биеийг олон төрмөгц орчлонгийн дөрвөн далайг туулах ёстой бөгөөд тэрхүү далай тус бүр ёроолгүй гүн их өвчин,

тачаал, зовлон, гунигийн үр шингээстэй, альбин, буг, лус, ороолон, шулмас, яргачид дүүрэн хүрээлсэн байдаг жамтай. Тэр бүхийг туулан гэтэлж явсаар нирваан дүрийг олно гэж бурхны номлолд сурган заажээ. Хүлцэнгүй, хичээнгүй ёсыг баримталж, өглөгийн эзэн байж, шагшаабадыг сахин чадвал орчлонгийн далайг туулахад эрхбиш амар замыг олж, таван завсаргүй нүгэл, шадар таван нүгэл, нийтдээ арван хар нүглийг тэвчээрлэх учиртай. Сэтгэлийн гурван гэм буюу хорт сэтгэл, хомхолзох сэтгэл, буруу үзлийг тэвчиж, олхиогүй үг, ширүүн үг, худал үг, хов үгийг манаж чадвал хэлний гэмээс гэтэлж сартаван, сагардагам, анагааманийн аль нэгний үрийг олно. Номонд ингэж сургажээ. Гэвч хүний сайн сайхан мөрөөдөл нь ямар нэгэн хоосон чанарын нирваан дүрд хүрэхийн төлөө нэг олдсон насаа элдвээр хязгаарлан, мухраар сүсэглэн, идэвхгүй, хүлцэнгүй явахын нэр юм гэж үү гэдэгт Санж одоо хариу өгч чадахаар өндөрлөгт байлаа. Орчлонгийн дөрвөн далай гэгч гагцхүү сэтгэлд оршиж байгааг тэр мэднэ. “Үзэгдэл сансрын юмс сэтгэлд алагдана. Орчлон гаслангаас нөгцөгсдөд ялагдана” гэж номонд сургажээ. Нөгцөгсдөд бол орчлон үгүйтэй адил эсвэл алагдсантай адил нь үнэн болохоор нэгэнт талийн одогчийн хойноос ерөөл авахуулах нь мөн л хоосон чанар, сэтгэлийн л хэрэг юм. Эцгийн сэтгэлийг бодож тэрхүү гуйсан ерөөлийг уншиж суухдаа Санж лхаарамба энэ бүхнийг эрэгцүүлэн бодож байлаа. Хөөрхий эх нь лам багшийн юу гэж л заасан тэр бүгдийг ёсоор нь биелүүлдэг дуулгавартай сүсэгтэй, хүлцэнгүй нэгэн байлаа. Нүгэл, алдас болно гэгдсэн болгоныг эх, эцэг хоёр тэвчин цээрлэдэг байлаа.

Буянтай, хэрэгтэй гэсэн болгоныг хийж гүйцээхийг эрмэлздэг байлаа. “Сүсэгт эд булааж болохгүй, сүм суварга эвдэж болохгүй. Эс өгснийг авч болохгүй. Бурсан хуврагууд доромжлох юм уу тэдний нөхрийг салгаж болохгүй. Даянчийн идээг идэж болохгүй!” гэхчилэн түмэн хориг цээрээс нэгээхэн ч зөрж байсангүй боловч хөөрхий эцэг, эхийн амьдрал аз жаргалтай, буянтай сайхан болсонгүй. Нас нь ч уртассангүй. Эх Цэндээ бие баржээ. Эцэг Сайнцогтын цээж нь хүржигнэж, амьсгаа нь давхцан бас ч сайнгүй. Нэгэнт эрүүл саруулдаа сайныг үзэлгүй өнгөрсөн хойноо одоо ерөөлийн ном хичнээн уншивч юун тус байх билээ. Гагцхүү эцгийн сүсэг сэтгэл л

цадах юмдаа. Үүнийг лхаарамба Санждолбийчойжамц дотроо бодож суувч өнгөн дээрээ тогтсон жаяг ёсоор гүн итгэлтэйгээр бурхан номынхоо үйлсийг үргэлжлүүлж байлаа. Эхийн төлөө юм гэж хичээнгүйлж ч байлаа.

Удалгүй ерөөл авах хурал дуусч чойнцам буюу завсарлагааны цаг боллоо. Эцгийн оруулсан манзыг түгээж эхлэв. Шар тос орхиж, хонины сүүл хөшиглөн хөөрцөгдөж хайруулдсан амттай сайхан цай байлаа. Эхийн хааяа нэг хийдэг тэр л цай яг мөн ажээ. Санждолбийчойжамц эхлээд тэр манэнаас амсахгүй гэж бодсоноо больжээ. Амсахгүй гэдэг нь эх, эцгээсээ өргөл барьц авч оронд нь ерөөл унших, тэгэхдээ бүр талийгч эхийнхээ хойноос унших утгатай үйл явдал тохиолдсоноос бишүүрхжээ. Ямарваа өргөл барьц, манз цай, зэд поггүйгээр л хэдэн түмэн удаа ерөөл унших эх үрийн элбэрэл ёс байх учиртай гэж сагардагамын мөр хөөсний хувьд Санж бодож байлаа. Гэтэл бас эхийнх нь төлөө эцэг нь түүнд биш бүхэл бүтэн хийдэд зориулсан манз бэлтгэн барьж ерөөл гуйсан болохоор ганцхан Санжид хамаатай хэрэг биш байлаа. Тэгээд ч эхийн өмнөөс эцэг бэлтгэж ирсэн идээнээс амсахгүй байх нь эвгүй санагдана. Амтархан хоёр аяга уужээ.

Манзын дараа лам нар салхинд гарлаа. Сүмийн үүдээр сүсэгтнүүд хөлхөлдөн байв. Тэдний дотор эцгээ олж хараад Санжид түүнийг өрөвдөх сэтгэл төрөв. Тэгтэл эцэг нь амьсгаадан бөгтгөнөсөөр хүрч ирээд Санждолбийчойжамцын өмнө түгхийн сөгдөн сууж, номт дээлий нь хормойноос адис авлаа. Ийм юм болно гэж бас л санаагүй явсан Санж асар их бишүүрхэн эвгүйрхэж, яах ч учраа олсонгүй, дэмий л бөхийж эцэг юүгээ өргөн босгох зуур,

- Аав минь та яаж байгаа нь энэ вэ? Надад сөхөрч яах нь вэ? Өөр тух тохьтой ламд мөргөхгүй дээ гэж шивэgnэв. Тэгтэл эцэг нь гомдох шиг болж,

- Би Буянзалбирах хийдийн хамбад мөргөж байна. Хүүдээ мөргөж байгаа юм биш гэж ууртай шивэgnэв. Олны нүдэн дээр ийнхүү зогсох

нь эвгүй мэт санагдаж Санж эцгээ сугадан хүмүүсээс холдуулж,

- Аав минь та яах гэж манз өргөж ерөөл гуйв даа. Манзтай манзгүй би ерөөлийн хурал хэдэн ч удаа хийлгэх л байсандаа! гэж Санж учирласан чинь эцэг,

- Өргөл барьцаа өргөж байж л ерөөл гуйдаг нийтийн ёс. Эцэгт нь хүүгээ Хамба нь болсныг далимдуулж олны ёсыг эвдэх санаа алга. Нүгэл алдас болно. Хамба гээд хамгийн ёсыг эвдэж болохгүй. Өргөлгүйгээр хуруулаад олигтой юм яаж бүтэх вэ? Одоо чи миний хүү гэдэг өчүүхэн явддаас аль хэдий нь ангижирч бурхан шүтээний дээд ариун орноо одсон тул эцэг, үрийн ёс хамаагүй! гэв. Эцгийн үг үнэн тул Санж юу ч гэж няцаахаа ч ухаарч ядлаа. Үнэхээр Санжийг эцэг нь одоо хүүгийнхээ хувьд биш харин Буянзалбирах хийдийн хамба лам лхаарамба Санждолбийчойжамцын хувьд хүндэтгэн шүтэж байгаа хэрэг.

- Хамбынхаа ёсоор бай хүү минь. Надад чамайгаа хүү гэснээс Буянзалбирах хийдийн хамба лам Санждолбийчойжамцтан гэж бодох минь илүү эрхэм байна. Өгсөн манзыг амссанд их гялайлаа, эцэг нь талийгаач эхийн чинь хийдэг тэр л хэмжээнд сайн цай бэлдэх гэж оролдсон юм. Одоо аавд чинь манзнаас цааш өргөл өргөх бинчин байх биш. Гэхдээ дор хаяад дөчин есийг гүйцэлдүүлэх тооны манз барих юм байнаа, аавд чинь. Одоо дахин ерөөл авахуулахгүй бол муу эхийн чинь төөрөг сайнгүй гарсаан гэж аав нь хоолой зангируулан ярив. Санж энэ үгэнд цочих шиг болж,

- Төөрөг нь сайнгүй гэж аав та юу ярив аа? гэж шивнэн асуулаа.

- Хэлэн дээр нь тариа тарьж зовоох тамд орохоос болгоомжлох бүхнийг хийлгэвэл зохино гэж лам багш айлдсан юм гэж эцэг нь зовууртайяа хэлэв.

- Хэнбугай тэгж айлдсан бэ? гэсэнд

- Талийгаачийг гаргахад зайлуул Дэмчиг гавж их тус болсон. Ном, гүрэм хийж өгсөн. Төөрөг судры нь үзсэн. Тэгээд л айлдсан үгийг нь дагуулаад Буянзалбирах хийдэд долоо хоног бүр манз өргөж ерөөл гуйдаг болоод байна. Хүү чиний үед хорин нэг дэх нь тохиосонд билэгшээн баярлаж байна даа гэж эцэг ярьснаа,

- За хурал номондоо орж үз! Лам нар ороод дууслаа! гэв.
Санждолбийчойжамцын сэтгэл асар их хямралдаж донсоллоо. Гэвч түүнээ ил гаргалгүйгээр явж суудалдаа суулаа.

“Хэлэн дээр нь тариа тарьж зовоох тамд орохоос болгоомжил гэсэн гэнээ. Хи! Мөн дураараа айлдаж байгаа хэрэг шүү. Сүсэгтэнээр тоглож байгаа нь тэр дээ” гэж Санжаадолбийчойжамц ууртайяа бодож суулаа. Хүний хэлийг тариан талбай шиг том болтол нь татан сунгаад дээр нь газар хагалахын нэгэн адил анжсаар хагалж шан татаад тариа ургуулж зовоодог тийм тамыг дүрслэн зурж сүсэгтнийг айлгадаг зураг Буянзалбирах хийдэд бусад хэдэн зуун сүм дуганыхтай ижил байдаг билээ. Хүний хэлийг тийнхүү зүсэн зовоовол яана гэдгийг төсөөлөн бодоод сүсэгтэн хүн айн зовинодог нь ч мэдээжийн хэрэг. Тийм там гэгч байхгүйг одоо Санждолбийчойжамц сайн мэдэх болжээ. Гэвч байдаг гэж сүсэгтэн олонд номлон итгүүлэх үүрэгтэйгээ ч бас л ойлгож байлаа. Харанхуй цээжтэй сүжигтэнд бурхны шавь гэгдсэн лам нар ийм юм ярихад хүүхэд мэт итгэн биширч, хөдөлбөргүй үнэ болгон хүлээн авдаг болохоор Санжийн эцэг Сайнцогт мөн адил тэр үгэнд бат итгэжээ. Өөрөөр бодох ч сэхээ сүжигтэнд байхгүй.

"Хөөрхий муу ээж маань энэ дэлхийд хамгийн шүтлэгтэй, хамгийн дуулгавартай ядуусын нэгэн болохоороо нүгэл, алдас гэж хийсэн юм түүнд юухан байх билээ. Нийтээр дагаж тогтсон ёс гуримыг л үг дуугүй баримталсаар насны туйлд хүрсэн амьтан даа. Гэтэл түүнийг хэлээ зүсүүлэн зовох хэмжээний тамд унах нүгэл үйлдсэн мэтээр өөд болсон хойно нь гүтгэн хэлж яаж зүрхлэх билээ? Тэгээд хоосон таамаг тэр “нүгэл” гэгчийг нь эцэг маань наманчлан ерөөл хуруулах гэж сүүлчийн ганц ямаагаа зориулж байдаг. Ай хуурамч орчлон!” гэж

Санждолбийчойжамц аграмба бодож суухдаа гартаа барьсан
Гүсүмтүг судрыг хорчийтол базаж орхисноо өөрөө мэдсэнгүй. Хэдэн
зууны турш хэдэн түмэн лам нар сүжигтэн олны зовлон зүдгүүрийг
хичнээн уран аргаар далимдуулан завшиж байсныг ийнхүү
эргэцүүлэн бодоход толгой эргэмээр ажээ. Эхийг нь хэлээ зүсүүлэн
тарчлах тамд унахвий гэж айлдсан гавж Дэмчиг сүмийн
жавдангуудын баруун мөрний эхнээсээ хоёрдоход сууж байгааг
Санждолбийчойжамц гэнэт хараад цочих шиг болов. Халцарч бараг
үсгүй болсон бөгөөд данхгар гуйлан шанага шиг том толгойтой,
махан чихтэй, нугалуур мэт атираат бүдүүн хүзүүтэй, шүрэн улаан
хамартай тэр гавж юу ч болоогүй мэт амарлингуй ихэмсэг дүрээр
жавдан дээрээ лаглайн сууж байв.

“Хэнэггүй сууж байна шүү! Энэ гавж насан туршдаа хичнээн хүний
зовлонд зоолсон болоо!” гэж Санж бодлоо. Шашны ёсыг сахин дагаж,
үг дуугүй шүтэж байх тийм сүжигтэнгүүд бий болгохын төлөө арван
найман там гэгч юм байдаг тухай үлгэрлэн зохиож, түүнээ үргэлж
номносоор ирсэн нь лам нарын аж амьдрахын гол нэг болзол болон
хувирчээ. Төмөр дөшин дээр няцлуулаад дахин амь орон бүтэж дахин
бас няцлуулах юм уу, улайдсан төмөр тогоонд тариа мэт хууруулах,
бие махбодоо хөрөөгөөр хөрөөдүүлэн салгуулахад дахин нийлж
амилаад дахин хөрөөдүүлэх зэрэг санаанд оромгүй тарчилгаадаг там
байдаг гэдгийг хар багаас нь өвгөн буурал болтол нь сүжигтнүүдэд
номлон ойлгуулсны хүчинд “бурхдыг гүтгэхгүй, бурсан хуврагуудыг
доромжлохгүй, сүм дуган эвдэхгүй, даяанчийн идээг идэхгүй”
гэхчилэн горим дэглэмд сүжигтнүүд баттай баригдаж шашныг
хамгаалан хүндэтгэдэг болжээ. Зөвхөн тамын аюулаас шүтлэгтнийг
айлгаад зогсохгүй бурхдыг хамгаалах дошгидын дүрийг олноор
бодож олжээ. Дошгидын дүрийг хүн айж, адуу сүрдмээр юм болгон
зохион гаргаж нийтэд ухуулан түгээжээ. Тийнхүү хий санаанаас
зохиосон хуурамч бурхдын дүр нь сүм, дуган бүрийн үүднээс аваад
гонхонд хүртэл өчнөөн байр эзэлж орхино.

“Хадны улаан альбин сорогзонмарав толгойн үс нь улбар шар, хөмсөг
нь гох улайлгасан мэт, нитны ёзоор улаан, торгон улаан нөмрөг

өмссөн, баруун мутартаа альбингийн гэдсэн цалам хийсгэсэн, зүүндээ муу ёрын шар шувуу барьсан, мянган хар могойгоор баглаж чимсэн, богино түрүүт төмөр гутал өмссөн нэгэн зэс улаан цусан өндөгнөөс мэндлэн төрөвөө" гэж сударт бичигдсэн ёсоор тийм нэгэн аймшигт зургийг сүм болгонд зурж сүжигтний үзэх харах газарт байрлуулна. Ийм догшин бурхдын дүрс даруй тавин найм агаад тэд цөм л арван найман тамыг дүрсэлсний нэгэн адил бурхан шашинд сүжигтнийг итгүүлэн дагуулахын үүднээс бий болсон зохиомол юмс ажээ. Хадны улаан альбин сорогзонмарав гэгч юм хаа ч байхгүй боловч байдаг хэмээн итгүүлэн номлосоор сүжигтэн битгий хэл лам нар ч өөрснөө итгэдэг болжээ. Гэвч Санждолбийчойжамц бурхны номыг төгс судалж лхаарамба болохдоо номлол, сургаалынхаа мөн чанарын цаадах, наадах талыг нэгэнт ойлгодог болжээ.

Хүүхдийг элдвээс болгоомжлохдоо “битгий тогло хадны мангаа ирнэ!” гэж сүрдүүлэн сургадгийн адилаар шүтлэгтэнг мөн л “битгий тэг, нүгэл алдас болно, тамд унана” гэхчилэн номлож байгаа хэрэг юм. “Байхгүй юмыг байдаг гэж итгүүлж болдог болохоор хүний сэтгэл санаа гэдэг ч хачин юм даа” гэж Санжийг бодож суух завсар лам нар хурлаа үргэлжлүүлэн хурсаар байлаа. Санжийн амнаас цээжилж уншиж сурсан уншлага нь аяндаа урсан гарч бүлгээ.

“Хөөрхий эхийн минь хойноос ч ерөөл уншаад ямар ашиг байх вэ? Эцгийн сэтгэлийг л хуурах төдий юм. Харин биетэй бодитой юм бүтээвэл тэр хэрэг болох вий? Юу бүтээх вэ? Суварга? Бурхны хөрөг? Ном? Аль аль нь боломжтой л зүйл. Суварга бүтээгээд олонд тустай юм болж чадах уу даа? Бурхны хөрөг гэхээр бас л нэг сүмийн мухарт тавиастай өнгөрнө. Ном гэхээр лам нарын өмч төдий л болоод байх биз дээ?” гэж Санждолбийчойжамц бясалган бодсоор байлаа. Нэг санал нь нөгөөгөө үгүйсгэсээр л байлаа. Тэгтэл хамгийн сүүлд “Чойрын дуган босгуулбал ямар? Манай энэ дацан их хуучирчээ. Манай нутагт ч сүм хийд бариулчих мэргэжсэн хүн ойр хавьд үгүй болж. Чойрын дуган байгуулчихвал олны орж гарах газар болж, эхийн дурсгалыг үлдээсэн гэж сэтгэл тэнүүн явах биш үү?” гэж Санждолбийчойжамц лхаарамба нэгэн үзүүрт бодолд бүрэн эзлэгдлээ.

...Тэр бодлоо шөнө дүл болтол бясалгаж бараг нойргүй унтлаа. Маргааш нь сүмийнхээ гяргачуудыг цуглуулан санаж бодсоноо тэдэнд ярив. Тэд ч их л сониучлан сонсож, дэм үзүүлээ.

- Манай Буянзалбирах хийдийн гол дуган их хуучирчээ. Лхас зууд ном үзэж таван ухааны эрдэм сурахдаа даган бүтээхүйн ёсыг би илүү сонирхож зүгээргүй мэдлэг суугаад ирсэн. Үүнийгээ дулдуйдаж байгаад чойрын дуган бариулмаар санагдлаа. Та бүхэн үүнийг юу гэж болгоох бол? гэж Санждолбийчойжамц лхаарамба асуулаа. Буянзалбирах хийдийн том толгой лам нарт энэ санал таалагджээ.

- Манай хийдийн гол дуган байтугай ихэнх дуган үжирч муудаад салхи, борооны гар даахаа больсон нь үнээн. Лхаарамбатангийн ярьдаг тун аргагүй юм. Чойрын дуган бариулуштай байна. Өглөгийн эздийн буянгаар манай хийдэд овоо хөрөнгө хуримтлагджээ. Түүнийг хэрэглэх юм одоогоор гарахгүй л байна. Тэгэхээр тэр хөрөнгөөр чойрын дуган босговол лам хувраг бидэндээ ч, сүжигтэн олон түмэндээ ч аль алинд нь хэрэг болно. Буяны үйлс бүтэх нь тэр гэж ширээт лам Чойбсон ярилаа. Тэр үнэхээр ийм юм бодсон нь илэрхий.

Ширээт лам Чойбсонгийн үгнээс гажих хүн гарсангүй. Цөмөөрөө зөвшөөрөн санаа нэгджээ. Тэд сүм барих газраа сонгож олох гэж бүтэн өдрийн явдал боллоо.

Сонгож олмогц газрын эзнээс тэр хэсгийг гуйх бслол хийх ёстой болжээ. Газрын альбин өсгий цагаан хар хайнаг унасан, лусын модны бэрээ барьсан цоохор лэгдэннагва гэгчийг аргадах уншлага үйлдэж, оронгын эврээр газар дээгүүр зурж сүм барих тэмдэг тавьцаалаа. Дөрвөн өнцөг, төв дунд нь нүх ухаж, вааран савнаа будаг, мөнгө, зоос, цай хадаг хийж булаад цагаан эсгий дэвсэв, дуган барихаар татсан тэгэн дээр цагаан гүү, тэмээний сүү дусаан мялаалаа. Лам нар шар, улаан орхимжоо сагсуулан хонх, дамраа дуугарган уншлага уншиж, сүртэй ёслол болов.

Санждолбийчойжамц лхаарамбын заавар ёсоор чойрын дуган барих суурь тавих ажил нэгэнт эхэлсэн нь тэр хавийн лам хувраг, сүжигтэн олонд ойр хавьд сонсож, үзээгүй том үйл явдал болжээ. Хүн бүр л ямар нэгэн хувь хандив нэмэрлэхээр шийдэж, ямаа хонь хөтлөн ирэх, хадаг яндар авчрахаас эхлээд өдөр бүр өргөл барьц нэмэгдсээр байлаа. Санждолбийчойжамц хамбатан өөрийн гараар сүмийн зургийг сууринаас нь эхлэн зурж, зааварлаж байв. Гэвч орон байшин тэрлүүлэх дадлагатай хүн байхгүйн харгайгаар ажил төдий л хурдан явахгүй удаашралтайд хамба лам их л халаглана. Болдогсон бол хурал номоо зогсоож хамаг ламаа хөөж гаргаж байгаад л тэр сүмийг босгомоор санагдана. Дуган босгох журам ёс их нарийн тул түүнийг баримтлах учиртай. Ойр хавийн газар орноос сүмд хэрэглэх будаг, шавар, чулуу, мод зөөхөд их цаг орж байлаа. Ашгүй хонд, шунх, зосны төрлийн юм, хар мод, яргай, чаргайн зүйл нутгаас олдох төлөвтэй байлаа. Харин түүнийг эдэлж юм бүтээх хүнээр дутмаг байж таарах шинжтэй болжээ. Гэвч Санждолбийчойжамц Хамбатан нэгэнт шийдэж зорьсон юмныхаа төлөө хамаг ухаан чадлаа шавхан зориулахаар чармайж, өдөр шөнийг ялгахгүйгээр оролдон хийх боллоо. Тэр нь сүжигтнүүдийг байтугай лам нарыг ч хоморгондоо хумин татжээ. Тийнхүү бөөн ажил дэгдлээ.

Хорин ес. Нүгэл нүглээс чиг айсангүй

Харьд очдогоороо хүүхэн гадна
Хал үздэгээрээ гар гадна
Хар нүднээс хөмсөг гадна

Гэнэт тэнгэр муудаж бөөн хар үүл нүүж дуу цахилгаантай бороо орж эхэллээ. Ойрхон байгаа хөдөө гэртээ очихоор ганцаараа мориор гарсан хамба лам Санждолбийчойжамц тэрхүү ширүүн бороонд тохиолдож зүг чигээ алдлаа. Залуувтар лхаарамбын эрэмгий зан нь түүнийг ийнхүү ганцаараа замд гаргахад хүргэжээ. Морь нь ч хуйсганан, өөрөө ч жихрүүдэс нь хүрч аадар бороог түргэн өнгөрөөсэй гэж хүсэмжлэн нөмөр газар бараадахыг оролдсон боловч бүтсэнгүй. Жалгад морь нь тогтохгүй байлаа. Тийнхүү жалга уруудан явсаар нэлээд хугацаа өнгөрлөө. Аадар бороо аажмаар зүсэрч шөнөжин орох төлөвтэй болов. Тэгтэл ашгүй жалгын амруух нэгэн тохойд хоёр гэр байхтай тааралдав. Нэгий нь гадаа жолоо татан зогсоод хамба лам мориноос бууж, гэрийн баруун бүснээс цулбуураар нь уяад чөдөрлөж, эмээлээ шуугаад үүдийг аяархан сөхөж тэр айлд орлоо. Гэрийн хойморт гүнгэрвааны өмнө ганц зул голойтол асаастай байв. Хүнгүй айл юмуу даа гэж хамба лам эхлээд гайхан зогтуслаа. Тэгтэл гэрийн зүүн хаяанд эргэнэгийн өмнө нэг хүн бөгтгөнөн юм хийж байгааг олж харлаа.

- Сайн байна уу? гэж Хамба лам тэр хүний амрыг эрсэн чинь цочих мэт дуу алдахад нь бүсгүй хүн гэж танилаа.

- Сайн, та сайн уу? Өөдөө суу! гэж гэрийн эзэгтэй хэлээд баруун хаяа руугаа заалаа. “Яасан танил дуу вэ?” гэж хамба лам эргэлзэн гайхаад баруун хоймор өөд явах зуур юүдэнгээ сөхөв. Гэрийн эзэгтэй хайч, шилээврээ дуугарган галдаа аргал зэргэлж эхлэв. Хамба лам баруун хоймор гарч ямааны арьсан дэвсгэр дээр суух зуур гэрийн эзнийг

ажиглан харлаа. Зулын бүдэг гэрэлд гэр доторхи юм олигтой харагдахгүй байв. Эзэгтэй галдаа аргал зэргэлэн голд нь хомоол үнгээд модон үлээгүүрээр үлээж эхлэв. Төдхөн гал нь дүрэлзэн асч гэрт гэрэл гэгээтэй боллоо. Дүрэлзсэн галын гэрэлд гэрийн эзэгтэйн царай зүс нь тодрон үзэгдэхэд Хамба лам түүнийг таниад цочисхийлээ.

- Отгон уу даа? гэж лам дуу алдлаа.

- Тиймээ. Та хэн бэ? гэж Отгон хүүхэн асуухдаа ламын зүг биш харин гал руугаа ширтэж байлаа. Түүний царай нь шаналгаантай мэт боловч бараг л хуучин хэвээрээ байлаа. Хамба лам ийм санамсаргүй тохиолдлоор уулзсандаа гайхах боловч басхүү олзуурхаж,

- Би Санж байна. Эцгийн хөдөө гэрт очих гэж яваад бороонд төөрчихлөө гэв. Отгон түүнийг сонсоод сэргэн баярлах мэт болж,

- Өө та байсан юм уу? Би таньсангүй. Таныг эргэж ирээд Буянзалбирах хийдийн хамбатан болсон гэж дуулж байлаа. Тэгээд хийдээр очиж уулздаг юм билүү гэж бодож л байлаа. Ядуу муу гэрт минь таныг ингээд ороод ирэх юм гэж оггхон ч санасангүй. Та бороонд норчихсон бол хувцсаа хатааж үз! Би гал өрдөөд орхиё гэж хэлээд галдаа аргал улам нэмж, тогоогоо тулган дээр тавьж ус хийлээ. Санж,

- Цувтай болохоор нэг их норсонгүй. Цуваа л хатаая даа! гэв. Отгон хүүхэн бөөн баяр болж цай хоол хийхээр шийджээ.

- Танд цай хийгээд өгье! гэж тэр хэлээд ухасхийн хөдөлж аяга саваа цэвэрлэж эхлэв. Санж тэр хооронд цуваа тайлан баруун ханан дахь цахнаас өлгөлөө.

- Тантай хамт олон хаалгат сүмд очиж мөргөөд ирснээс хойш олон жил өнгөрлөө. Энэ хооронд Бөхмагнайгийн сураг гарсангүй. Түвдүүдэд баригдаад л амь үрэгдсэн юм шиг байна лээ гэж Отгон

хоолой нь зангиран ярьлаа. Санж түүнийг сонсоод,

- Бөхмагнай гуайтай би дайралдсаан... гэсэн чинь Отгон дуу алдаж,

- Өө тийм үү? Хаана дайралдав. Амьд явна уу, ашгүй? гэхэд Санж,

- Амьдаар барах уу? Түвдийн цэргээс оргоод ууланд гарч голоог омгийнхонтой нийлж сайн эр болсон байна билээ. Намайг нааш нь нутгийн бараа харуулж өгөөд буцсан л даа гэж санаандгүй ярихад Отгон,

- Тэгээд тантай хамт наашаа ирэхгүй яасан юм бол? Миний тухай ярихгүй байна уу? гэж асуув. Санж бас л юм бодсонгүй,

- Ирэхгүй юм шиг байна лээ. Түвд эхнэр авсан гэнээ! гэв. Отгон хүүхэн санаа алдаж,

- Намайг үргүй гээд л түвд эхнэр аваа биз дээ! гэж аяархан хэлэхэд нь Санж сая л эвгүй сэдвээр ярьснаа ойлгож,

- Яасан айхтар ширүүн бороо ордог байнаа? Усан галав юүлэх шиг л боллоо шүү! гэв. Отгон бөөн хөл хөөрцөг болж,

- Би танд одоохон хоол хийгээд өгье. Одоо их орой болжээ. Тэгээд энэ хар усан борооноор хаашаа явах вэ? Та өнжөөд өглөө эрт явсан нь дээр байлгүй дээ! гэв. Санж “нээрээ л тэгэхээс биш дээ! Харанхуй шөнөөр хаа гэж явах уу?” гэж дотроо бодлоо.

- Шинэ мах шөл байхгүй. Жаахан борц л байна. Та борцтой хоол голохгүй биз? гэж Отгон хүүхэн зовингуйрхан асуулаа.

- Зүгээр, зүгээр. Харин ч сонин байх гэж Санж түүний сэтгэлийг заслаа. Отгон уур нүдүүрээ аяархан тогшиж байв.

Гэрийн дотор их л ядуу тавилгатай байлаа. Хойморт ганц авдар, зүүн

талд бараг газар шахам зассан ор, түүний цаана бас нэг авдар, эргэнэг ийм л хогшилтой айл ажээ.

- Олон хаалгат сүмд мөргөж ирснээс хойш амьдрал ахуй ч дээрдсэнгүй, үр хүүхэд ч заяасангүй. Эр нөхөр ч эргэж ирсэнгүй. Ядуу зүдүү л амьдарч байна. Баруун талд байгаа гэрт Балжин эмгэн суудаг юм. Хүү нь хааяа эргэж ирдэг. Манай хоёр долоон ямаа нэг үнээтэй. Түүгээрээ л амь зууж байна. Аянчин дагаж урагшаа явах санаатай! гэж Отгон сонин болгон ярилаа. Түүнд нь гайхаш төрөв.

- Одоо бас явж яах нь вэ? гэж Санж гайхан лавлав. Отгон хүүхэн ичингүйрснээ,

- Нэгэнт л үрийн хутаг заяагаагүй нь гарцаагүй болсноос цааш Бэрээмэг эмгэний ярьдаг байсан Аниг Гомбоо гэдэг шимнанцын хийдэд очиж бүх насаа өнгөрөөдөг юм уу гэж бодож байна гэснээ, мартсан нөгөө Бэрээмэг эмгэн амьд сэрүүн үү, зайлуул! гэв. Санж санаа алдаж,

- Эмгэн өөд болсоон! Мааний бад ми хун! Аниг Гомбоод өргөл өгүүлсний нь хүргэж өгч явж амь алдах шахсан... Тэнд очиж сууж яах нь вэ дээ? гэж асуулаа. Отгон,

- Яахав дээ! Өөр жаргал гэмээр юм алга. Бэрээмэг эмгэн залуу насаа тэнд өнгөрөөсөн л гэж ярьдаг байсан... Тэгээд л очдог юм уу гэж бодсон хэрэг. Бас Бөхмагнайн сураг гарч ч магадгүй гэж горьдсон юм. Тэр ч тэгвэл өнгөрч л дээ.. гэхэд Санжийн сэтгэл нь хямарч дуугүй суулаа. Отгон хүүхнийг өрөвдлөө.

Борцтой шар будаа нь ч удалгүй боллоо. Санж аяганыхаа уутнаас багвараа гаргаж хоол тосон авч дуу чимээгүйхэн идэж эхлэх зуур Отгон хүүхнийг өрөвдөн ажиглаж байлаа. Санжаас долоо найм эгч тэр бүсгүй сүлжмэл хар үстэй, мяраалаг дүгрэг царайтай, дунд зэргийн нуруутай, яралзсан цагаан шүдтэй ажээ. Үсээ яагаад ч юм бэ найман салаа сүлжээд зэс боолтоор нэгтгэн боож, духан тушаа бага

зэрэг мөнгө орсон хагас даруулгаар дарж хавчаараар тогтоожээ. Хүзүүндээ хуван холовч зүүжээ. “Үрийн хүслэн болсон энэ амьтан одоо бас дахиж хол зам туулж Аниг Гомбоо хийдийг зорихоор шийдэж байгаа юм гэж үү дээ? Мөн лайтайя?” гэж Санж дотроо бодож суулаа. Түүний дэмий хүсэл санааг өөрчилмөөр байлаа.

Хоол идэж дуусахад Отгон,

- Таны морийг яах вэ? гэж асуулаа.

- Яахав. Цатгалан морь л доо. Тэгсгээд эмээл нь шуулттай хоног уудаа гэж Санж тээнэгэлзлээ. Отгон, - За яахав. Би нэг аргалаад ирье. Энүүхэнд гадастай аргамжаа бий. Тэрнээс аргамжаад орхисон нь дээр байхаа гээд гарч одлоо.

“Үгүй эднийд хоноглодог чинь зөв болж байна уу, буруу болж байна уу? Ганц бие бүсгүйнхээр Буянзалбирахын хамба лам хоног төөрүүлж яваа тухай яриа гарч хөг болохгүй байгаа?” гэж Санж гэв гэнэт ухааран бодохдоо айх шиг болов.

- Таны морийг аргамжчихлаа. Яасан их устай бороо орж байнаа? Хувингаар цутгах шиг л болж байна. Шөнөжин юүлэх байхаа! гэсээр Отгон хүүхэн орж ирлээ. “За явдаг маань ч өнгөрлөө. Өглөө айтар эрт л явж үзье” гэж Санж дотроо бодлоо. Отгон гэрийнхээ зүүн талд байгаа газар ороо янзалж засаад,

- За та энд унтаж амар! гэж хэллээ.

Санж босч тэр зассан газар нь очлоо. Тэр мөчид гэрийн дотор энд тэнд дусаал гоожиж байгааг ажиглаж мэдлээ.

Отгоны зассан орон дээр хажуулдав. Зузаан сэгсүүргэн дээл ганцыг Санжид хучлага болгон өглөө. Түүгээр хучаад ламбугай тонон өөд ширтэн хэвтлээ. Отгон хүүхэн гал хөсөө засч янзаад эрэгнэгийнхээ өмнө цомцойн суусаар байхад нь,

- Өөрөө унтахгүй яагаав? гэж Санж аяархан асуулаа. Отгон түр дуугүй байснаа,

- Одоохон! гэж хэлэв. Гадаа бороо шаагин орсоор байлаа. Бас хэдэн мөч өнгөрлөө. “Аа энэ чинь ороо над өгчихөөд унтах газаргүй болоод сууж байгаа хүн юмсанжээ. Түрүүний ажихгүй дээ” гэж Санж гэнэт бодоод яаж энэ байдлаас гарахыг сүвэгчлэв. Гэвч арга байсангүй. Хаана ч тэр унтах юм билээ дээ.

- Миний энүүхэн хажуугаар хэвтээд өг л дөө гэж Санж арай ядан дуугарлаа. Отгон хүүхэн гагцхүү үүнийг л хүлээж байсан юм шиг ухасхийн босч Хамба ламын урд талаар тулганаасаа холгүй газарт хуучин тэрлэг нөмрөөд бас нэг тийм ноолонхой цэгдэг дэрлээд хажуулдан хэвтлээ. Насан туршдаа эмэгтэй хүнтэй ийнхүү зэрэгцэн хэвтэж байгаагүй болохоор хамбын сэтгэл тав муутай байлаа. Хүүхний зөөлөн амьсгаа бараг л хамар дээр нь сонсогдох шиг болж, элдвийн юм бодогдож нойр нь хульжив. Тэгтэл Санжийн мөр рүү хойт оргин тусаал туслаа. Түүнээс биеэ зайлуулах санаатай баруун тийшээ жаахан хөдлөөд орхисон чинь гарт нь Отгон хүүхний шахмал бяслаг шиг төвгөр хөх нь дайралдаж, Санжийн хамаг биеэр гүйдэл гүйх шиг хачин боллоо. Эмзэг газар нь ламбугайн гар санамсаргүй хүрснийг Отгон хүүхэн ойлгохдоо санаатай хүрлээ гээд бодчихжээ.

- Миний эндээс дусаал гоожоод байна. Тан руу жаахан шахаад хэвтэж болох уу? гэж Отгон шивэгнэв. Санж түүнд юу гэж хэлэхээ мэдэхгүй алмайрчээ. Дуугүй л байлаа. Дуугүй байгаагий нь Отгон хүүхэн мөн л өөрийнхөөрөө ойлгож бараг л өвөрт нь ороод иржээ. Санж улам хүнд байдалд орж хаашаа ч хөдөлж чадахгүй байлаа. Гадаа бороо улам ширүүсэн орж, үе үе тэнгэр дуугарсаар л ажээ. Отгон хүүхний зөөлөн амьсгаа одоо Санжийн бүр хацар дээр нь мэдрэгдэж байлаа. Санж түүнийг мэдээгүй хүн болох гэж нэг хэсэгтээ элдвээр чармайж байлаа. Гэвч эхлээд гэрийн бүрээсэн дээр шаагих борооны чимээг, хажуу талаар дуслах дусаалын дууг Санж сонсохоо больж, дараа нь тэнгэр дуугарахыг мэдрэхээ байжээ. Орчлон хорвоо тийнхүү байхгүй юм

шиг болж, гагцхүү Отгон хүүхнийг л хажууд нь байгааг Санж осолдохгүй мэдэрч, сэтгэлийн хямралд донслон, гэрэвшиж байтал уруул дээр нь Отгоны улаа бутарсан зөөлхөн хацар аяархан наалдлаа...

...Бороо гэнэт зогсчээ. Бороо зогсмогц үүр цайжээ. Отгон хүүхэн аль хэдий нь босоод цай чанаж байв. Үүрийн өмнөхөн хэсэг зуур таг унтчихсанаа Санж мэдэж сэрмэгцээ өндийн хувцаслаж эхлэв. Гэр дотор борооны чийг, утаа хоёр холилдон үнэртэж, дөнгөж чанасан шар цайны аагтай давхцан байлаа. Отгон хүүхэн тулганыхаа дэргэд нөмгөн суугаад цайгаа самарч байв. Түүний махлагдуухан бөөрөнхий биеийн эвлэг аятайг Санж одоо сая л олж харах шиг болов. Дөнгөж одоо л харлаа гэж үү? Цэнхэр тоонын даваанд арваад жилийн тэртээ хээр унтаад босдог тэр өглөө Отгон хүүхнийг горхийн усанд нүүрээ угааж байхыг Санж сэмхэн хараагүй гэж үү? Хармагц нүд буруулан өөрийгөө зэмлэсэн. Тэгэхэд Отгон нөхөртэй, Санж бол сахил санваар сахисан банди явжээ. Дараа нь хэдэн жил өнгөрөхөд Үйчүү мөрнөөр үхрийн ширэн завиар явж байхад усны долгионд бие нь эвгүйрхэж Санж түүний бүсэлхийгээр тэврэн, ус руу ойчихоос нь болгоомжилж яваагүй гэж үү? Тийм юм болж л байсан. Тэгэхэд Санж сахил санваараа бат сахисан гавж байсан л даа. Элдвийг боддог ч үгүй явжээ. Гэхдээ Отгон хүүхэн Санжийн бүхий л амьдралын нь бодь мөрийг хөөсөн зам дээр нь мөр солбилцон тохиолдсон ойролцоо насны цорын ганц бүсгүй хүн байсныг Санж одоо л эргэцүүлэн бодлоо. Банди байхдаа бүсгүй хүнд ойртох байтугай түүн рүү шуналтайгаар харах л юм бол завсаргүй хар нүглийн нэгийг үйлдэж алдас хийж байгаа нь тэр гэдгийг лам багшаасаа, ер нь лам толгойтой бүрээс бат сонсож бүрэн итгэсэн билээ. Гавж байхдаа мөн тэр сургаалыг бусдад айлддаг, өөрөө бол бүсгүй хүний тухай мөрөөдөх цагаа бурхны номонд шавхан өгсөөр байгаад сүүл сүүлдээ архи дарс ууж угаасаа сураагүй хүн түүнийг огтхон ч тоодоггүйн адилаар эмс, охидын тухайд бодох санах ч юмгүй болж, байгалиас заяагдсан сэрэл нь аажмаар унтарчээ.

Хамба ламын зэрэгт хүрч ном бүхний наад цаад учрыг гүнээ ухаарсан

энэ үедээ Санжийн бодох санах нь их л өөрчлөгдөж бүсгүй хүн байхгүй бол хүний орчлон дуусвар болно, лам бүхэн бүсгүй хүнээс төрсөн юм гэдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж байлаа. Эхнэр авахгүйн сахил санваарыг гагцхүү Зунхавын сургаал баримтлагчид тэр дотроо монгол лам нар л хатуу сахиж байдаг болохоос биш Энэтхэг, Балба, Хачээ, Хаст, Сангас, Лангаа, Бамгаалын ихэнх лам нар ийм сүжгийн хүлээснээс чөлөөтэй байдгийг ч Санждолбийчойжамцтан мэдэж байлаа. Тэд нүглээс айхгүй гэрлэдэг биш үү?

Үрийн хутаг олох гэж Отгон хүүхний өчнөөн зовлон туулж, хичнээн сүжиг бишрэл гаргасныг Санжаас өөр сайн мэдэх хүн одоо үгүй билээ. Үр төрүүлэх л үүрэгтэйгээр хорвоод заяасан болохоор бүсгүй хүн түүнээ бодож явдаг нь юун нүгэл, алдаст холбогдох билээ?

Отгон хүүхний царай өнгөлөг сайхан харагдаж байлаа. Гэвч тэр хамбын өөдөөс эгцлэн харж чадахгүй ичингүйрэн суух шиг санагдлаа. Санж, хүүхнийг ч зэмлэсэнгүй, өөрийгөө ч зөвтгөсөнгүй. Тиймэрхүү юм бодох аргагүй байлаа. Харин нэг их айхтар юмны саварнаас мултран гарсан юм шиг, өөрийнхөө толгойг өөрөө мэддэг болчихсон юм шиг эсвэл хий агаарт гандирсан балгасанд олон жил сууж байснаа торгон ногоон зүлгэн дээр, бүүр нусгай жаал явахдаа хурга хариулж хөл нүцгэн гүйж явсан Дунд хайлаастайн голын зөөлхөн ширэг дээр буугаад ирчихсэн юм шиг хөнгөн хөгжөөнтэй сэтгэгдэлд л Санж бүрэн автагджээ. Мөрөн дээгүүр нь хэд ороон боож байдаг жаран хуяг орхимжоо аваад тавьчихсан юм шиг, ээтэн гутлаа тайлаад хөл нүцгэн явж байх шиг хачин санагдсанд Санж хүүхний өгсөн цайг шалмагхан сорж уулаа. Өчигдөрхөн л өндөр настай буурьтай суурьтай, лам бүрийн ах зах, шүтлэгтэн бүрийн багш мэтээр өөрт нь санагдаж ихэмсэг, хөдөлгөөнгүй, сүр ихтэй байдал үзүүлэхийг хичээж явсан Санжид өнөөдөр агсам хурдан морь унаад хээр талаар давхиулмаар, найрын сөн түшээд уртын дуу аялж суумаар хүсэл төрж байлаа. Бурхны номонд гардгаар “Арын уул нь зандангийн ой цэцэрлэгт сүмбэр, өврийн уул нь ногоон дадар хийсэх адил, баруун уул нь хар хөх торгон хөшиг сунгасан адил, зүүн уул нь цагаан арслан

огторгуйд дүүлэх адил, урсгал ус нь хар могой газрын уруу гүйх адил дээдсийн жаргал хэмээх оронд шал довжоо нь төмөр, дөрвөн туурга нь алт, хашаа нь оюу, лавай үүдтэй, чон эрдэнэ ба шүрэн шаттай, дог нь улаан аранжин зэсээр барьсан, зүүнд нь төмөр бич улаан нүүрт зуун тоть олноор наадсан, урд нь улаан хүн улаан морьдыг уралдуулсан орд харшийн” гадуур нь үргэлж явсаар байгаад өнөө шөнө анх удаа л түүний дотор орж үзсэн мэт санагдахад Санждолбийчойжамц лхаарамбатан сэтгэлийн хямралд дахин живж, царай нь нэг улайж, нэг цайж суусаар хэдэн ч аяга цай ууснаа мэдсэнгүй. Отгонтой харц тулгарахаас айж байв.

- Цай маань дуусчихлаа. Та уумаар байвал дахиад чанах уу? гэж Отгон хүүхнийг асуухад Санждолбийчойжамцтан сая л хүний орчлонд Отгон хүүхний утаат хар гэрт сэтгэлээрээ эргэн ирлээ.

- За би ч явах уу даа! гээд Санж босохыг завдлаа. Отгон хүүхэн,

- Жалга өгсөөд хөтлөөр даваад зүүн тийш эргэж нэлээд яваад модгүй нүцгэн уулыг даваад цаад хөндийд нь аавынх чинь бий шүү! гэж газар шагайн суусан хэвээрээ хэлэхэд ингэж явахыг заасанд тооцоод,

- Тэгье тэгье! гэж Санж хэлээд бослоо.

- Би таныг гаргаж өгье! гээд Отгон мөн л бослоо. Санж түүнийг хэрэггүй гэж хориглох гэсэн боловч чадсангүй. Отгон ойлгож,

- Баруун айлын эмээ гэрээсээ бараг гарч чаддаггүй юм. Энэ хавьд өөр хэн ч байхгүй. Ламбугайг моринд нь мордуулж өгөх хүн би л байна шүү дээ гээд тэр хоёул гэрээс гарлаа. Санжийн морийг аль хэдий нь авчирч эмээллээд өчигдөр орой байсан байдлаар нь бэлтгэчихжээ. Санж түүнд гайхан баярлав.

- Ядуу муу гэрээр минь та соёрхон орж тааллаа хайрласанд өнчин зүрх минь жарган гялайлаа! гэж Отгон хүүхэн шивнэх төдий хэллээ. Санж энэ үгэнд уяран барьц алдаж,

- Хувь тавилангийн минь төөрөг ийм байсан юм байлгүй дээ! гэснээ цааш нь юу ч хэлж чадсангүй мориндоо мордон давирах аядсанаа жолоогоо татаж Отгон хүүхэн рүү их хүч гарган эгцлэн харлаа. Түүний дүгрэг цайвар царай, гялбалзсан бор нүд, дун цагаан шүд, нимгэвтэр улаан уруул, хянгадуу шулуун хамар нь ертөнцийн өвөг эцэг гэгддэг махсуваар лэгдэнванчигчимбуу бурхны дөрвөн эхнэр буюу югваагийн Чинжидмаа хүлэгч эхтэй ав адилхан юм шиг санагдлаа.

- Аниг Гомбоо руу хэзээ явах вэ? Түүнийгээ надад дуулгаарай! гэж Санж гуйлаа. Шоглосон юм шиг болов гэж бас тэвдэв.

- Одоо би Аниг Гомбоо руу явахгүй... Яваад ч яах юм билээ... гэж Отгон эрс тод хэллээ. Энэ үгэнд Санж цочихын хамт баярлах шиг боллоо. Өөрийн эрхгүй инээмсэглэж орхилоо. Отгон бас инээмсэглэв. Бие биенээ инээмсэглэлээр үдлээ. Санждолбийчойжамц лхаарамбатан морио давиран, жалга өгсөн одлоо. “Махсуварын югваа Чинжидмаа минь, бурхны номын хүлээсийг сэтгэлээс минь чи тайлж, ахуй нисваанисын шинэ хүлээсээр биеийг минь хүлэх юм гэж үү дээ!” хэмээн бодож явлаа. Санж тийнхүү өөр юм бодох чадваргүй болчихсон мэт ганцхан сэдвээр элдвийг бясалгасаар гурав хоног өнгөрлөө.

Эцгийн гэрт тав тохьгүй юм шиг санагдаж сэтгэл нь дэнсэлж, тогтож сууж чадахгүй байлаа. Нэг их юм дутаад байх шиг санагдана. Гэтэл дутсан юмаа юу болохыг үл тоймлоно. Нэг бодоход их хар нүглийн эзэн ч юм шиг. Нөгөө бодоход сүжгийн хүлээснээс чөлөөлөгдсөн мэт ажээ. Яван явсаар сүжгийн хүлээснээс чөлөөлөгдсөн гэх бодолдоо дийлэгдлээ. Үээж цээжилсэн ном судраасаа өөрийгөө зөвтгөх юм юу билээ гэж удтал бодлогоширлоо. Тийм номлолыг бараг үзээгүй билээ. “Гэвч байз. Хаа нэгтэй л бий дээ. Сайн санахгүй юм уу?” гэж Санж бодсоор байж гэнэт оллоо. “Аа тийм! Лонсал сударт бий шүү дээ” гэж Санж гэнэт духаа алгадан баярлав. Ертөнцийн эхлэл бол упаяа (эр) пражна (эм) хоёрын нийлбэр гэж Лонсал сударт бий. “Юм бүхний

гарахын орон ямагт умайн нууц тарина бүхний орон их амгалангийн билэг билгүүнээс гардаг буй. Үүнийг шүтэхээс өөр аргагүй” гэж Лонсал номлодог биш үү? Тэр номлолоос гажуу, би?” гэж Санж өөрийгөө зөвтгөн судар номноос гэрч татаж бодсоор байж өдөр хоног арайхийн барлаа.

Буцах замдаа Санж аглаг уулын шилд удтал сууж, өнгөрүүлсэн амьдралынхаа тухай удтал цэгнэн бодлоо. Харамсах мэт болж байв. Тэгээд харанхуй болоход мориндоо мордож зам буруулан явсаар Отгон хүүхний гадаа ирж буув...

Гуч. Буруу даваагаар орсон хүн

Баян хүн ноён хүний дүү
Худалч хүн хулгайч хүний дүү
Унтсан хүн үхсэн хүний дүү

Буянзалбирах хийдэд чойрын шинэ дуган барих ажил ид оволзож байв. Сүжигтэнгүүд Ар жаргалангийн нуруу, Нум дэлээчийн модноос гуалин зөөж, сарлагийн шараар зогсоо зайгүй нааш цааш тээж байлаа. Өдөр бүр шинэ дуган бүтээхэд зориулсан өргөл барьц цугларч, Дэмбэрэл гэсгүй, Дэмчиг гавжаас эхлээд ширээт Чойбзэнг хүртэл бөөн их ажилтай боллоо. Хамба лам Санждолбийчойжамц өөрөө сүм бүтээх ажлыг заан зааварлаж, зурахы нь зурж, будахы нь хүртэл будалцаж хурал номын ажлаас ч хааяа хөндийрөх шинж оржээ. Шинэ дуган бүтээж байгаа сургаар хавь ойрын шүтлэгтэнгүүд мод чулуунаас эхлээд ээмэг бөгжөө хүртэл өргөл барьц болгож байгаа нь Санж хамбын сэтгэлийг догдлуулжээ. Номын гунигийг нь тэр ажилд мартуулав.

Амар жимэр орших шалтгаан бүрдүүлэх, лам хуврагийн сонсох, санах, сэрэх тэргүүтнийг нэмэгдүүлэх, өглөгийн эзэд цаглашгүй буян хуралдуулах, олон хүн хуран мөргөхийн орон болгох хэрэгцээг дүүрэн бүрдүүлэхийг Санж юуны өмнө эрхэмлэж байв. Ийм шаардлагыг хангах нь сүм, хийд барих ёсны наад захын хэрэг ажээ.

“Элбэрэлт эхийн хойч дурсгалыг бодож нэгэн дуган бариулахаар оролдож байна” гэж эцэгтээ Санж хамба хэлэхэд тэрний баярлан хөөрснийг дүрслэх аргагүй болжээ. Одоо тэгээд эцэг Сайнцогт нь дуганд хэрэглэгдэх мод, гуалин, чулуу хайргыг сарлагийн шараар зөөх ажилд оржээ. Эцгийн сэтгэл нэгмөсөн сэргэн хөөрөв.

“Эхийн дурсгалд тэр сүмийг бүтээх тул та ерөөл гуйж сүмд манз

оруулдгаа больмоор байна” гэж эцэгтээ Санж хэлэхэд тэр бүрэн санал нийлж, манз оруулахаа зогсоожээ.

Дүндан буюу нуруу хийх мод, шүн буюу нум, шин буюу бэрээ, бэрээний дэвсгэр хийх модны хэмжээг эцэгтээ дээсэнд зангилгаа гарган баримжаалж өгөхөд Сайнцогт танилуудтайгаа хамтран хавь ойрын уулаар явж, модтой энгэр болгоныг самнан хайж эрж олох ажил хийж байлаа. Сүжиг, хүсэл хоёр нийцсэн байжээ.

Дуганы суурийн газрыг малтуулж дуусаад найман давхар болсон хөх туйпуугаар суурь тавцанг хийлгүүлээд ханыг өрүүлж тулгуур суурь чулуу бэлтгүүлэн баганыг босгож сүмийн эхний давхарлагт хүрээд байлаа. Нуруу, нум бэрээний мод ихээхэн хэрэгтэй болж ирлээ. Эцэг Сайнцогт нутгийн хашруудтай хэдэн сараар эрэн бэдэрч явсаар нэлээд гуалин олж ирсэн боловч хоёр гурван дүндан, бэрээний мод дудтаж байлаа. Ойр хавьд гагцхүү хар мод ургадаг болохоор сүмийн багана тулгуур, нуруу хиймээр мод ховор ажээ. Хэдэн өртөө хол байгаа Жон харгайтын нуруунд цөөн сайхан хар мод ургаж байгаа тухай олж сонсоод эцэгтээ хэлсэнд тэр явахаар болов. Эцэг нь явахынхаа өмнө хүүгээ эзгуй газар тосч уулзаад,

- За аав нь Жон Харгайт руу явж захисан модыг чинь заавал олж ирнээ... гэж хэлснээ түр тээнэгэлзэж түгдрэн дуугүй боллоо. Санж гайхаж,

- Аав та өөр юу хэлэх гээ вэ? гэж асуувал,

- Хүү минь болгоомжтой байгаарай. Чиний тухай элдвийн муухай цуу үг тараадаг улс гарчээ. Тэд хүү чамд минь атаархаад л тэгж байгаа биз дээ. Миний хүү шиг ариун санваартанг юу ч гутааж чадахгүй.. л дээ гэж эцэг нь шивнэн хэлэв. Санж түүнд цочиж,

- Аав та юу ярьж байна? Юун цуу үг? гэвэл - Би тэр үгийг шал худлаа зүйл гэдгийг мэдэж байна. Харин хэн тийм юм ярьж явдгийг нь хүүдээ хэлж санаа амрах гэсэн юм. Танай хийдийн Дэмчиг гавж л элдэв яриа

тараадаг бололтой. Одоо би тэрний хамаг муу санааг ухаарлаа. Мунхаг болохоор насан туршдаа ухаарсангүй явжээ. Саяхан болтол Дэмчиг гавжийг би шүтэж л явлаа. Одоо бол надад шүтэж явах хүү минь байна. Гэхдээ чамаас болоод би тэр гавжийг муулж байгаа юм биш. Түүний тараасан цуурхлаас болоод их олон юм эргэцүүлэн бодлоо. Залуудаа Дэмчиг гавж хөөрхий муу талийгаач ээжийг чинь гомдоосон юм гэнэлээ. Тэрний нь хөгийг ээж чинь ам хэлтэй хүн болохоороо багшид нь ярьчихсанаас болж эвгүйхэн л болцгоосон. Тэр ч их урьдын юм л даа. Тэгээд сая эхийг чинь талийгаач болоход тус хүргэсэн нэртэй үлдэхээр хичээсний нь тэнэг толгой би гадарласангүй. “Хэлээ зүсүүлэх зовлонт тамаас болгоомжлох бүхнийг хий” гэж айлдсаныг нь цаагуур бодож үзсэнгүй. Наагуур бодоод л хүүхэд шиг итгээд явсан. Тэгэхнээ нь лам багшийгаа муулдаг хэлний нүгэл хийсэн хүн гэж эрт залуугийнхаа өсийг санаж, өөрийгөө цагаатгаж, түүнийг маань муулж хэлсэн учиртай үг байж. Талийгаач болчихсон хойно нь ч тийм нэр зүүлгээд яана вэ дээ тэр! гэж эцэг нь цухалдан хэлж шанааныхаа судсыг гүрэлзүүлэн түр дуугүй болсноо,

- Тэгээд зогссон бол ч яахав. Хүүгий минь бас гутаах санаа агуулж явдаг бололтой. За ийм хүнээс болгоомжилж яваарай хүү минь гэж хэлээд эцэг нь холдон одохыг завдав. Түүний ярианд бухимдан донсолсон Санж, - Намайг юу гэж яриа юм бол? гэж асуув.

- Тийм үгийг эцэг нь давтан хэлэх арга алга. Нүгэл алдас болно. Би төрсөн эцэг нь болохоор хүүгээ тийм юм хийгээгүй гэдэгт ясандаа итгэж байна. Өөр хүмүүс, хар элэгтэнд бол тийм үг юм бодогдуулж мэдэх л байх. Би бол яагаад ч итгэхгүй. За хүү минь санаж яваарай. Аав нь тэр захисан модыг чинь заавал олж ирнээ гаж хэлээд эцэг нь мориндоо мордон шогшууллаа.

“Юу гэж цуурхдаг юм болоо?” гаж Санждолбийчойжамцтан эргэцүүлэн бодлоо. Гэвч тоймтой хариу олсонгүй. “Эхийнхээ дурсгалд зориулж дуган бариулж байна гэж цуурхсан юм биш байгаа. Би тийм юм бодож байсан ч гэсэн хэлж үзээгүй шиг билээ. Эцэгг бол яахав дурссан. Тэгэхдээ бусдад битгий дуулгаарай гэж сайн захисан.

Эцэг тийм үг алдахаар хүн биш. Хоосон ерөөл хэдэн түм уншуулаад ч нэмэргүй. Харин нэг сайхан сүм бариулчихвал эхээ дурсах юм тэр болно гэж л эцэгт ярьсан. Ингэж байна гэж цуурхдаг юм гэлээ гэхэд эцэгт тэр муухай санагдах ёсгүй биз дээ. Өөр юу цуурхах билээ?..." гэж Санж бодсоор гэртээ харихаар явлаа. Шургааган хашаатай модон байшинтай, жижиг гэртэй болж Буянзалбирах хийдийн баруун хороонд тэр амьдардаг байлаа. Гэрийнх нь хашааны үүдэнд модон сандал дээр нэг хүн сууж байхыг тэр холоос хараад гайхлаа. Морио хашааны шургаагнаас уяжээ. Хэн ирээд хүлээж байгаагий нь эхлээд гадарласангүй. Ойртон ирмэгц таньж, зүрх нь түг түг цохилон. Отгон хүүхэн ирээд хүлээж байжээ. "Манайд илэрхийгээр ирж яах гэсэн юм болоо? Олны нүдэнд өртөх нь дээ!" гэж Санж бодмогц эцгийн шууд ярьж чадахгүй битүү сануулаад байсан хэл ам, цуу үгний сэдэв нь Отгон хүүхэн болсон юм уу гэж сэжиглэх санаа гэнэт төрлөө. Хэнд ч сэвдээ авахуулахгүйгээр Отгон хүүхнийд дөрөв таван удаа очсоноо саналаа. Мэдэж, сэжиглэсэн хүн нэг ч гарах учиргүй гэдэгт Санж бүрэн итгэлтэй байлаа. Отгон хүүхэн баяр баясгалангаар дүүрэн огт өөр хүн болчихсон юм шиг онцгой царайгаар Санжийг угтан тосч зогсохыг харахдаа залуухан хамбын царай улсхийж, эвгүйрхлээ.

- Сайн байна уу, та. Би танаас эм тан залах гэж ирлээ гэж Отгон хэлэхэд нь Санж хариу мэндлээд хашааныхаа хаалгыг нээж, Отгоныг дагуулан гэртээ орлоо. Үүдээр дөнгөж алхан ормогц Отгон баяр хөөрөө барьж чадсангүй ухасхийн Санжийг хүзүүдэн тэвэрч авахад нь тэр нэлээд ичингүйрч гэрийнхээ хаалгыг дотроос нь оньслоо.

- Би чамдаа гялайлаа, гялайлаа! гэж Отгон шивэгнээд яахын зуургүй Санжийн хацар дээр хэд хэд үнсээд авлаа. Санж гайхан догдолж,

- Юу болсон бэ? Яаж байнаа! гэж асуув.

- Би чамаас хүүхэд олжээ! гэж Отгон уухайлах мэт бардам баяртайгаар хэлэхэд аянганд цохиулсан юм шиг дайваганан цочирдсон Санж дуугарч чадахгүй ангайн зогслоо. Ийм юм сонсоно гэж тэр зүүдлээ ч үгүй явжээ. Дэмий алмайрахдаа,

- Худлаа байлгүй! гэчихлээ.

- Үнэн, үнэний цаад үнэн! гэж Отгон нотлов. Түүний үг бүрд нь хөдөлгөөн бүрд нь баярлан хөөрсний шинж илэрхий байлаа.

- Миний биш байлгүй! гэсэн дэмий үгийг Санж амнаасаа унагачихаад тэр дороо харамслаа. Тэгтэл Отгон,

- Хэнийхий нь би мэдэж байна. Чамаас өмнө надтай дайралдсан харчуул эр хүн биш байж! За би үүнийг л хэлэх гэж зүрх гаргаж ирсэн юм. Одоо дахиж үүгээр бараагаа харагдахгүй. Хэл амны нэмэр. Чинийхээ хүүхдийг тээж, төрүүлж өсгөнө. Чи ч манайхаар явах хэрэггүй. Хамбын чинь нэрд муу. Хүүгээ гарсан хойно л очоорой. Тэр хооронд биеэ барьж, сахилаа сахиарай. За би явлаа! гээд Отгон хүүхэн гарахаар завдахад Санж биеэ захирч чадсангүй түүнийг чанга тэврэн авч хацарт нь хушуугаа наалдуулж түр зуур зогслоо.

- Намайг хаалгаараа гаргаж, хойноос харж зогсуузай. Би одоо шууд гэр руугээ явлаа гэж Отгон хэлээд ухасхийн гадагш гарлаа. Мөчийн дараа морин төвөргөөн хашааны гаднаас холдон замхрах сонсогдлоо. Хүүхнийг тэгж холдон одсонд харамсах шиг болов.

Санждолбийчойжамцын бүх бие нь сулрах шиг болж давхар давхар зузаан олбогт суудалдаа лагхийн ойчлоо. Толгой нь эргэх шиг, судсаар гүйх цус нь буцлах шиг хачин санагдлаа.

“Хоёр ч нөхөр солиод Утай, Гүмбум, Лхас зуугийн хамаг шүтээнээр явж үрийн хутаг гуйсан нь бүтээгүй тэр хүүхэн тэгээд насан туршдаа эхнэр хүнээс дөлж явсан над шиг амьтнаас хүүхэд олчихлоо гэж үү дээ? Мөн хачин гайхмаар орчлон юм даа. Би тэгээд одоо яах болж байнм. Хамба байх уу, эцэг байх уу? Алийг нь сонгох юм билээ?” гэж Санждолбийчойжамц гиюүрэн боддоо.

“Хамба байх гэж л хар нялхаасаа өдий хижээл насаа хүртэл сүм

хийдийн газар шавилан сууж, бурхны ном үзэж, хамаг амьдралаа өгсөн биз дээ? Хэн нэгэн хүүхний хормойноос зууралдаад сууж байхсан бол орь залуугаасаа хар хүн болж үр хүүхдээ өсгөж, үрээ малаа адгуулж явахгүй яагаав? Хийсэн нүглээ наминчлаад үүгээр төгсгөл болго! Цааш нь битгий даамжруул" гэж хойморт тахисан Хаянхирваа бурхан нь хэлэх шиг болов.

“Үгүй ээ, яалаа гэж! Нэгэнт чамаас болж бүсгүй хүн хүүхэд олсон бол түүнийхээ эцэг байх учиртай. Эцэг үрийн элбэрэл журмыг эвдвэл харин тэр чинь завсаргүй их нүгэл болно. Хамаг сайхан залуу насаа шоголтой ном тэврэн, маани мэгзэм уншиж өнгөрөөсөн чинь багадаа юу? Хүний жаргал гэж түүнийг тооцох юм уу? Хоосон чанарын номлол чинь юунд хэрэг болдог вэ? Сүжигтэн олныг л хуурч авах идэхийн шалтаг болдгоос өөр ид шид байна уу? Тэр чинь сүжигтэн биднийг байтугай бүх насаараа уншиж, сахил санваараа сахисан лам та нарыг мөнхрүүлдэг үү? Та нарыг үхэшгүй мөнхийн шид, үгүйрэшгүй баяны шидтэй болгодог уу? Үгүй шүү дээ” гэж Отгон хүүхэн Санжаас асуух шиг болов. Үнэн хэрэгтээ Санждолбийчойжамц лхаарамба өөрөө өөртэйгээ үг сөргөлдөж байгаа нь энэ. Түүний зүрх сэтгэлд хоёр ухаан сөргөлдөж байгаа нь энэ. Нэг нь насан туршид судалсан бурхны гүн ухаан. Нөгөө нь ардын хар ухаан. Тэр ухааныг эцэг эхээс, Бэрээмэг эмгэн, Өлзийт бадарчнаас, Отгон хүүхэн, сүжигтэн олноос заалгажээ. Амьдралын хар ухаан түүний нүдийг нээсэн.

Санждолбийчойжамц хамба сэтгэлийн шаналгаанаас чөлөөлөгдөх нь байтугай түүнд улам бүр эзэмдүүлж өдрийн бодол, шөнийн зүүд нь хоёрхон сэдэвт дулдуйддаг боллоо.

“Буянзалбирах хийдийн хамба лам Санждол бийчойжамц лхаарамба хөдөөлөх нэрийдлээр ганц бие бүсгүйчүүдээр орж гардаг болж гэнэ. Нутгийнхан бэлэвсэн эхнэр Отгоныд хоног төөрүүлээд өглөө эрт явж байхыг нь анчин Довдон уулан дээрээс дурандаж суугаад олж харсан гэнэ. Самуун явдалтай хамбатай болжээ, манай хийд!” гэсэн цуу яриа нутаг усныхны дунд түгэн тарж байгаа нь Санжид өөрт нь их

оройтож дуулджээ. Дуулдах хүртэл тэр огтхон ч сэжиглэхгүй явлаа. Буянзалбирах хийдийн ширээт лам Чойбзэн түүний эрдэм номд оройгуйд нь атаархаж, мөн хийдийн Дэчин унзад, Дэмбэрэл гэсгүй, Дэмчиг гавж нар нас залуудаа их өндөрт гарчихсанд нь өөмтгөлж тэрхүү цуурхлыг өдөр бүр давсыг нь чангалан уулзсан болгондоо ярьж байх болсныг ч Санждолбийчойжамц лхаарамба гадарлаж таамагласан ч үгүй. Хурал номынхоо албыг залгуулж, Чойрын дуганыхаа барилгыг үргэлжлүүлж байлаа. Өдөр хоног их л хурдан өнгөрч байв.

...Намар болохын дохио орж, өвсөн толгой халиурч эхэллээ. Жон Харгайтад модонд явсан хүмүүсээс сураг чимээгүй байхад Санждолбийчойжамц хамбын сэтгэл төвдөхгүй болж сураглуулахаар шийдэв. Намрын цас ууланд унахаас өмнө дуганы дүндан бэлтгэх хэрэгтэй байлаа. Тэдний хойноос хүн явуулахаар зэхэж байтал эцэгтэй нь хамт мод бэлтгэхээр одсон Нандий өвгөн уруу царайлсаар эргэж ирлээ. Санж хамба түүнээс,

- Юу болоов? Яасан удав? Та нар модоо олж чадав уу? гэж асуусан чинь тэр өвгөн хэсэг зуур хулгаж байснаа,

- Тун муу юм боллоо. Багана хийж болмоор хэсэг мод олоод байтал нэг нь ойчихдоо эцгийг тань дайрчихлаа... гэж хэлээд дуугүй боллоо. Хайрт эцгээ харамсан Санжийн сэтгэл харанхуйлж цээж нь давчдан гунилаа. Хорвоо хөмрөх шиг болжээ.

- Эцэг нь том модонд няц цохиулан насан эцэслэжээ. Хол газар тээж явах аргагүй болохоор тэр хавьд нь хөдөөлүүлээд Нандий өвгөн эргэж иржээ. Уй гашуунд бүрэн эзлэгдсэн Санж хэдэн хоногийн турш сүмийн барилга дээр очиж чадсангүй. Өөрийн нь сэдсэн юманд тус болох гэж чармайж яваад эцэг нь зуурдаар нас барсанд Санж харамсавч барахгүй, сэтгэлийн зовлонд унажээ. Модонд явахдаа эцгийн захиж хэлсэн үгийг санах бүрийд нүд нь харанхуйлна. “Элбэрэлт эх, эцэг хоёр минь та нарыгаа үр болсон би чинь жаргуулах нь байтугай баярлуулж ч чадсангүй. Санасан санаа байна. Чойрын

дуганыг барьж заавал дуусгуулах юмсандаа. Тэгж гэмээж нь та хоёрынхоо дурсгалыг үлдээлээ хэмээн сэтгэлээ зогоох юм” гэж Санждолбийчойжамц баттай бодож, сүм барих ажлаа түргэвчлэхээр шийдэв. Намрын эхэн сарын турш тэр ажлаар хөөцөлдөж овоо юм амжуулж авчээ. Харин дугандаа хурах ажлаас нэлээд хөндийрлөө. Хамбын ширээнээ завилж хоосон уншлага хийж цагийг элээн барж суухыг ч тэр нэг их дурлахгүй байлаа. Хамбын ширээнээс уйдан дайжлаа.

Нэг өдөр Буянзалбирах хийдийн том лам нар бонсооханбад цугларцгаалаа. Бонсоохамба бол лам нарын цугларч зөвлөдөг байр юм. Байгуулж байгаа сүмийн дотоод чимэглэлийг яаж хийлгэхийг тэд зөвлөлдөхөөр цугларчээ.

- Үүдний байшингийн хаалганд ягчис, лагнаадорж тэргүүнийг зурах, ер нь номын ёсоор бол зэс улаан гарьд хөлөглөж лагшинд улаан торгон нөмрөг соёрхсон барс хэрэглэл баруунд, ирвэс хэрэгсэл зүүндээ барьсан, ардаа чулуун бүрхүүл овойсон, баруун мутартаа торгот жадыг дайсанд тавьсан, зүүнд дайсны зүрх, гэдсэнд цалам барьсан, хуяг дуулга яралзсан байддаар зурах номтой биз дээ гэж Дэмчиг гавж эхлээд ярив.

- Заавал тийм ягчисыг зурах хэрэг юун билээ. Харин сэтгэлд өег гушаанаа цэцэг зурмаар байна гэж Санждолбийчойжамц зөрүүлэн хэлэхэд хэзээ ч өөрийгөө шүүмжлүүлж яваагүй Дэмчиг гавж,

- Бурхны шавь бид бурхны номыг л дагана шүү дээ. Эс тэгвэл буруу даваагаар орж лал болох биш үү? гэхэд нь Санждолбийчойжамц зэвүү нь хүрч,

- Гавжтан Чойрын сүмийн хаалганд их ягчис зурна гэж нэлээд андуурав. Тийм заалттай ном байхгүй. Ер нь тэгээд сүжигтэн олныг сүмийн үүдэнд ирэхэд нь айлгаад сүр дараад байхаар юу болох вэ? Энэ улигт аргаасаа салмаар биш үү? гэтэл Гавж,

- Сүжигтнийг сүжиглүүлж л байх учиртай. Түүний үрээр ч сүжигтнээ алдалгүй будаа тариа мэт олшруулсаар Зонховын ном дэлгэрсээр байна. Харин ч их ягчис зөөлдөх биш үү? Уналгад улаан хоншоор шувуу эдэлсэн, лагшинд улаан хуяг өмссөн, тэргүүндээ гэрэлт дуулга сэлт, мутарт хаш улаан жад, цусан дадар долгилсон, хүний зүрх сэгсэрч сорсноор дүр бүтээн зурууштай гэж маргалаа.

- Байхгүй болгоныг байдаг мэтээр номлон бүх нийтээрээ мэхэлсээр бид олон он элээжээ. Сүжигтний сүсэг буурах цөвийн цаг ойртжээ. Гавжтангийн хэлдэг улаан хоншоорт шувуу хөлөглөж, цусан дадар долгилуулан, хүний зүрх сэгсэрч сорсон тийм амьтан хаа хэзээ ч байдаггүйг мэдэх тийм хүмүүс олсрох тусам бидний номлолд байтугай сүм хийдэд маань ч бишрэхгүйд хүрнэ шүүдээ. Ядаж орон хийдээ хүний ахуй, хорвоогийн явдалд ойртуулмаар биш үү! Тэгээгүй цагт дан зохиомол хуурмаг юмаар чимсэн сүм хийдийг тоохоо болих үе тохиох бизээ. Далан худалчийг хүн тоодоггүй шиг хаалга хачивцнаасаа аваад хаа ч байхгүй зохиомол юмаар эрээлж будсан сүмийг яг л худалч хүнээс дорд үзэх тийм цаг ирвэл яана. Сүм хийд бол урт настай, үеийг элээн орших учиртай. Түүнийг бясалгахад энэ сүмийг өөр маягаар чимэхсэн гэж санаж байна хэмээн Санждолбийчойжамц ярьсан чинь ширээт лам хүртэл дургүйцэн уурлаж,

- Хэдэн мянган оныг элээн хэвшиж тогтсон жаяг ёс маань далан худалчийн үгтэй адил болж байна уу? Нүгэл алдас бизээ. Буруу даваагаар орж байгаа юм биш үү, хамбаа? гэв.

- Омгоос зэтгэрт үхэр тэгшламбуу төрдөг гэж бид номлодог биз дээ? Ширээт лам таны омгоос тэгш ламбуу төрөх үү? Үнэндээ үгүй шүү дээ. Бид яг л ингэж хуурдаг улс даа! гэж Санж түүний үгийг таглав. Тэгтэл айсан унзад Дэчин,

- Таминь ээ, тарцгаая. Бурхны орон байранд алдас нүгэлтэй үг ярихаа зогсоцгооё! Хэн зөв, хэн бурууг мартацгаая гэв. Тэд тарлаа.

- Манай хамба ер нь буруу даваагаар орсон бололтой. Эмсийн хойноос гүйдэг гэдгийг дээрхэн л та дуулаа биз. Одоо болохоор сүмийн үүдэнд зурдаг уламжлалтай зургийг зурахгүй гэхийг сонсов уу гэж Дэчин унзад ширээт ламаас асууж сонсдов.

Гучин нэг. Шар шувтлахаар шийдсэн нь

Илжигтэй лам шалбаагийн голд
Энэрэлтэй лам ширээний голд
Эхнэртэй лам тамын голд

“Буянзалбирах хийдийн хамба лам Санждолбийчойжамц лхаарамбатан буруу даваагаар оржээ” гэсэн цуу үг түгэн тарж, Засагт хааны хүрээнд хүрч тун удалгүй Богд эзний сонорт дуулджээ.

Тэр хооронд Ширээт Чойбзэн, Дэчин унзад, Дэмбэрэл гэсгүй, Дэмчиг гавж нараас өгсүүлээд хамба лам Санждолбийчойжамцтай таарахгүй лам нарын тоо өдөр ирэх бүрий нэмэгдсээр байв.

Буянзалбирах хийдэд барьж байгаа чойрын дуган ч өөрөө ахисаар оройдоо ойртсоор бүлгээ. Санждолбийчойжамц хамбын хийдэг ганц ажил нь тэр сүмийн барилга болжээ. “Энэ сүмийг л бариад дуусгачихвал хийдээс дайжиж нэг бол даяанчлан суух, эсвэл яадаг юм бэ, Отгон хүүхэнтэй айл гэр болон амьдрах минь. Эх эцгийн дурсгал буян болгож сүмийг заавал дуусгах ёстой” гэж тэр дотроо бат шийджээ. Түүний энэ санааг одоогоор хэн ч мэдээгүй байлаа. Тэгтэл,

- Отгон хүүхэн давхар биетэй болж гэнээ. Санждолбийчойжамц лхаарамбатаны хүүхэд болохоос гарцаагүй. Анчин Довдонгийн дурандаж харсан цагаас хойш тоолоход хугацаа нь таараад байна гэсэн яриа түгэн тарж сая л хамба ламтангийн өөрий нь сонорт хүрлээ. Түүнийг Дэмчиг гавж өөрөө хүрч ирж Санж хамбад хэлэв.

- Лхаарамба таны тухай нүгэл, чивэлтэй яриа хааяагүй таржээ. Бурхны номын тухайд таны ярьдаг тангараг буурсан үгсийг ч лам нар бид энүүхэндээ дараад байж болохсон. Гэтэл та хамбын мяндаг, лхаарамбын цолоо умартаж, эмс охидтой зууралдаж, манай

Буянзалбирах хийдийг тулгын чулуу тулснаас нь хойш өнөөг хүртэл дуулдаж байгаагүй муу ярианд оруулжээ дээ гэж Дэмчиг гавж чамханба буюу ламын нарын амралтын өрөөнд сууж байхдаа Санж хамбад бараг л тулгах шахам хэлэв. Тэр энэ ярианд урдаас бэлджээ.

- Бидэн шиг мах цусанд төрсөн жижигхэн лам нар байтугай ертөнцийн өвөг Махсувар хүртэл биеийн өнгө улаан, эх Умаадивийтэй учирсан байдлаар шампүрэл ванжид буюу бусдын хувилсанд баясагч тэнгэрийн оронд оршдог шүү дээ! гэж Санждолбийчойжамц егөөдөн хэлэв. Ийм хариуг урьдаас бодож байжээ.

- Чивэлт шуламтай учран тэвэрсэн бурхад догшдын дүр бишгүй л бий. Тэр бол тийм байхыг цээрлүүлсэн зүйл болохыг лхаарамба та надаар хэлүүлэлтгүй мэднэ. Муу үйлийн авьяасыг таслахын тулд үе гишүүнийг хэрчин хэсэглэсэн, мунхгийг дарахаар мах бүхнийг идэж, хүсэл тачаалыг дарахаар цус бүхнийг ууж, уурыг дарахаар яс бүхнийг тасалж идсэн байдлаар бурхад, догшдын дүрийг бүтээдгийг лхаарамба та андахгүй байлгүй дээ. Тэр бүхэн ийм нүглийг жигшүүлэх гэсэн хэрэг биз дээ гэж Дэмчиг гавж нухацтайяа хэлэхэд,

- Бурхны сургаалыг бид үлгэр болгочихоод л байгаа шүү дээ. Үлгэрийг маань сүжигтэнгүүд тоохгүй улиг болохоор нь дахин үлгэр зохиож түүндээ итгүүлэх гэж тайлбарладаг болсон биз дээ? “Долоон сар одох цагт эм лусын умайнаас төмөр өндөг ам, нүд нь өс нэгэн төрлөө. Төрсөн даруйдаа огторгуйд дүүлэн харайлаа” гэж номонд бичээстэй байдаг биз дээ? Энэ үлгэрээс ялгаа юу байна? Зохиомол сонин үлгэр шүү дээ гэж Санждолбийчойжамц няцаан ярив.

- Номын мөрийг номоор нь үлдээе. Хүний мөрийг хүн дээр нь ярьж байна. Хэрвээ эмс охидоор хөөцөлдөж явсан хамба таны явдал үнэн бол... та нэг бол шар шувтлах, нэг бол жанч арилжих тухай л бодож байх болж дээ гэж Дэмчиг гавж сануулаад цааш нь олон юм ярихаас болгоомжилж босч явлаа.

- Тиймдээ хүрвэл та ч гэсэн залуудаа манай ээжийг гомдоосон гэдэг биз дээ? Тэр явдалдаа хорсч анасаар талийгаач болсон хойно нь юу гэсэн муухай үгээр ном буулгасан байлаа? Энэ чинь л ёстой та бидний үнэн нүүр царай болж шүү дээ. Бид цаанаа ийм, наанаа бол буяны ном айлдсан бурхны үнэнч шавь нар даа. Тийм биз! гэж Санждолбийчойжамц тэрхүү гавж Дэмчигийн хорыг маажих үгийг зориуд хэлж орхиод уур хэлэнгий нь дүрэлзүүлчихжээ.

Чамханбад болсон энэхүү бяцхан маргаан нь Буянзалбирах хийдийн лам нарыг Санждолбийчойжамц хамбын эсрэг хандуулах сүүлчийн шалтаг болжээ. “Буруу даваагаар оржээ!” гэж цөм л ам амандаа бувтнацгаах болжээ. Дэмчиг гавж бол бүүр холын бодолтой хортой явуулга дэгдээж байлаа.

“Явуулга, гүтгэлэг элдэв юмсаа хийж л бкйг. Сүмээ бариулж дуусгая. Дуусгаж аравнайлмагц би хөдөө гарч үс тавьж, хар болоод Отгонтой суух минь. Хайран өнгөрсөн өмнөх насаа нөхөж чадахаар сайхан амьдрах юмсан” гэж Санж бодож байлаа.

Түүний үзэж өнгөрүүлсэн амьдрал нь хоосон дэмий урссан ус шиг санагдаж байлаа. Хийдэд нялхаараа шавилан сууж бандиас хувраг, уваш, гэцэл болсон. Түвд газар явж Лхас хотын Бэрээвэн дуганд арын жавдангаас эхлээд өврийн жавдангийн эхэн хүртэл хэдхэн алхам газарт урагш ахихын тул бүхэл бүтэн үе мултартал оныг элээсэн тэр бүрийд үзэж өнгөрүүлсээзүйл юухан билээ? Өнгөөр засдаг хуурам ч болгоныг тооловч баршгүй. Шүтээний ширээнээс л тэр хуурмаг юм эхэлдэг. Тэнд тахил болгон өрсөн болгон цөмөөрөө билэгдлийн төдий шинжтэйг Санж одоо сайн мэдэж байлаа. Молор эрдэнэ гэдэг цац нь сүмбэр уулыг, алтан загас сернядан гэдэг хоёр загас дэлхийг хашиж байдгийн тэмдэг, дарчин бумба гэдэг амтай устай бумба нь тэнгэр нарын ундаа, бадамлянхуан цэцэг сухаавадийн орны билэгдал, дунгаряйчил нь бурхдын алдар түгээгч гэхчилэн цөмөөрөө үлгэр домог томьёоны шинжтэй билээ.

Санжийг ядаргаанд орж доройтох үед Пүрэвдоной маарамба яаж

үйлийг үзсэнийг бас мартаагүй байна. Сүнс дуудах, мэнгэн засал хийх, амин золиг гаргах гэхчилэн одоо бодоход инээд хүрмээр хүүхдийн тоглоом шиг зан үйлийг хичнээн итгэлтэйгээр үнэн сэтгэлээсээ хийж байлаа? Тэгээд тэгээд тус болсон билүү? Тэр бүхэн үлгэр мэт хоосон, үргүй өнгөрч гагцхүү Бэрээмэг эмгэний хар ухаан л Санжийн долоон тамирыг сэргээж өгсөн билээ.

Отгон хүүхнийг үрийн хутагтай болгох гэж хичнээн сүр бадруулж, үйлийг нь үзлээ? Тэгээд тэгээд тус болсон билүү? Цөм л талаар өнгөрсөн.. Гэвч тэр үрийн заяатай л байж дээ!

Багш лам Чоймчиг гэлэн маань яасан билээ. Өөрийгөө нүгэлтэй гэж бодсоор яваад зулын гол болж өнгөрсөн. Түүнийгээ нүглээ наманчлан цагаатгах дээд арга гэж бодож байсан. Бас л үлгэр домог шиг билэгдлийн төдий зан үйл юм.

Энэ бүхнийг Санждолбийчойжамц нэг биш удаа эргэцүүлэн бодсон шигээ чамханбад болсон маргалдааны дараа дахиад л сэргээн бодлоо. Багш лам Чоймчиг гэлэнгийн захиж үлдээсэн цун алтны талыг сураглах хүн Санждолбийчойжамцыг хамбын ширээнд суусны маргааш л гараад ирсэн юм. Хурлын завсарлагаар салхинд явж байхад нь өндөр сайхан залуу хүрч ирээд Санжид хандан,

- Амрыг айлтгая! Та Чоймчиг гэлэн агсны шавь мөн үү? гэж асууж билээ.

- Тийм ээ. Багш минь байсан юм. Юу гэв? гэж Санжийг асуухад тэр залуу,

- Таныг нутагтаа эргэж ирэхэд хүүгээ явуулж сураглуулж уулзаарай! гэж тэр хүн ээжид минь захисан юм гэнэлээ. Тэр ёсоор л би тан дээр ирлээ гэжээ.

- Ээж чинь хэн юм бэ? гэвэл,

- Ээж маань уржнан өөд болсоон! гэж залуу хариулсан. Тэр залуутай Санж танилцаж, Чоймчиг багш гэлэнгийнхээ өгсөн алтны хэлтэрхийг гардуулж санаа амарч билээ. Багш лам нь мөн л Санж шиг нууцхан амрагтай байж, хүүхэдтэй болсондоо гэмшиж, нүгэл алдас болов хэмээн шаналж явжээ. Тийнхүү зулын гол болон насан хутаг олжээ. Гэвч Санж тэр замаар явахгүй. Санж шашны үлгэрийн шар ертөнцөөс ахуй амьдралын ногоон зүлгэнд шилжих ёстой. Амьдралд нь тохиолдож байсан юм бүхэн энэ шилжилтийг бэлтгэхэд тусалсан. Пабанхаг тойрон гороо хийхдээ ч, Лхасын шоронд сууж байхдаа ч, Бэрээмэг эмгэний асрамжинд амьдрахдаа ч, Өлзийт бадарчингийн үглээ яриаг сонсохдоо ч, ном эрдэм илүү сурчихлаа гээд сэлэмдэн хороохоор шөнө дөлөөр гэрт нь орж ирсэн Чогсонгийн заналт царайг хөшигний цоорхойгоор ажиж суухдаа ч, Аниг Гомбын гэлэнмаануудад нүдүүлж амь алдсан бадарчин нөхрөөсөө хагацах үедээ ч нүгэл буянгийн мөн чанарыг сайн ухаарчээ. Бурхан шажны сургаал номлол, түүний зан үйл нь үнэн хэрэгтээ сонирхолтой бодож зохиосон үлгэр юм гэдгийг Санждолбийчойжамц одоо нэгэнт ухаарчээ. Тэр үлгэрт үнэмшилтэй байлгахын тулд хэдэн түмэн лам нар үе залгамжлан өдий төдий чамин сонин арга ширгийг бодож олоод амьдралд нэвтрүүлжээ.

Санждолбийчойжамц одоо тэрхүү улиг болсон үлгэрийн орныг тойрон гарч бодитойгоор оршин байдаг хүн ёсны амьдралд нэвтрэн орохыг хүсч байв.

Одоо түүний сэтгэлд титэмлэсэн дээргүй дээд бурхан хамгийг айлдагч, буяныг цацруулагч, бүхнийг эрхэндээ хураагч гэгдсэн бурхдын үр биш харин үртэй болохын мөрөөдөлд автагдсан ядуу буурай мөртлөө зөөлөн хурын дусал шиг элэг дэвтээм зантай Отгон хүүхний дүр өдөр, цаг бүрд нүдний өмнө бодитой тодорхой харагдсаар байх болжээ. Тэр л түүний сэтгэлийн бурхан болжээ.

Буянзалбирах хийдэд бий болсон дүнсгэр байдал гэв гэнэт өөрчлөгдлөө. Намрын дулаахан нэг өдөр Богд эзний зарж илгээсэн Бандид хамба бараа бологсдын хамтаар Засагт хааны хүрээний засаг

ламыг дагуулам хүрэлцэн ирлээ. Буянзалбирах хийдийн хамба ламын буруу даваагаар орсон хэрэг явдлын хар цагааныг ялгаруулахаар иржээ.

Тэд Буянзалбирах хийдийн том лам нарын цугларан зөвлөх Бонсооханба өрөөнд орцгоожээ. Санждолбийчойжамцыг хүлээх өргөө буюу Чагсааханбад ганцааранг суулгалаа. Бусад багтаагүй хэргэмтэнгүүд Чамханба өрөөнд орцгоолоо.

Бандид Хамбад Буянзалбирах хийдийн ширээтээс эхлээд гэлэн, гэцап, гавж, гэвхүй нар Санждолбийчойжамц хамбын тангараг буурч, буруу даваагаар орсон тухайг тал бүрээр нотлон ярьж удаан хугацаагаар сууцгаалаа. Тэдний хооронд маргаан үүсчээ. Зарим хүн Санждолбийчойжамцыг өмөөрөх төлөв гарснаас маргаан дэгджээ. Номын цаад утгат нэвтэрсэн зарим хүний хэлдэг л үгийг Санждолбийчойжамц хэлжээ. Гэхдээ сүжигтний өмнө биш гавжаас доошгүй хэмжээний лам нарын дунд ярьжээ гэж хөнгөлөх тал гарав. Харин эхнэрт тачаасан нүглийг өмөөрөх хүн гарсангүй.

- Хар, цагаандаа хүрвэл зохино гэж Бандид хамба шийджээ. Тэр даруй тогоотой буцлам ус авч ирцгээлээ. Дотор нь хар цагаан хоёр адилхан чулуу хийлээ. Тэгээд Санждолбийчойжамц хамбыг дуудан оруулаад ханцуйгий нь шамлуулсны дараа,

- Ав! гэж Бандид хамба тушаалаа. Санж буцлам халуун устай тогоо руу гараа дүрж ёроолд нь тохиолдсон нэг чулууг атган гаргаж ирлээ. Хар чулуу байлаа! Түүнийг хармагцаа Дэмчиг гавж Дэчин умзад хоёр баярлан инээмсэглэх нь илт байлаа. Бүх юм үүгээр шийдэгдлээ. Хар нүглээ тэр чулуугаар илчилсэнд тооцов.

- Буянзалбирах хийдийн хамба лам Санждолбийчойжамц таны тангараг буурч буруу даваагаар орсон нь илэрхий болоод байна. Олон даяар яригдах болжээ. Сая хар цагаандаа хүрч та өөрийн гараар хар чулуу атган гаргалаа. Одоо тэгэхээр хоёрхон зам байна! гэж Бандид хамба сануулан хэлснээ түр дуугүй болж Санжийг царайг ажиглаад,

- Нэг бол жанч арилжих, нөгөө бол шар шувтлах, энэ хоёроос өөр зам алга. Нүглээ сайтар наманчлан жанч арилжваас илүү сайн төрөлд дахин төрж болно. Шар шувтлах бол дахиад орон хийдийн бараа харах эрхгүйгээр шар шувтална. Алийг нь болгоохсон бол? гэв.

Санждолбийчойжамц энэ хоёр замын юун утгатай болохыг сайн мэдэж байлаа. Жанч арилжина гэдэг нь төрөл арилжих гэсэнтэй ижил юм. Ямар нэг хэлбэрээр амь насаа хороохын нэр. Хамгийн хүндтэй дээд хэлбэрээр нь Санжийн багш Чоймчиг гэлэн Лхас зууд очиж жанч арилжсан билээ. Санждолбийчойжамц төрөл арилжихыг хүсэхгүй байлаа. Тэр амьдрахыг, хүний ёсоор амьдрахыг мөрөөдөж байлаа. Гэтэл Буянзалбирахын гяргачууд яг л жанч арилжих замаар Санжийг явуулах хүсэлтэй байжээ. Амьд явахаас нь айж байжээ.

- Шар шувтлах уу даа? гэж Санждолбийчойжамц шийдэмгийхэн хэллээ.

- Тэгвэл болно. Гэвч орон хийдийн бараа дахин харахгүйгээр шар шувтлах учиртай шүү дээ! гэж засаг лам сануулахад Санж дуугуй байлаа. Тэр нь хол газар, лам хувраг, сүм дугангүй газар цөлнө гэсэн утгатайг ч ойлгож байлаа. “Яахав. Отгоныг аваад явна. Отгонтой байсан цагт хаа ч цөлөгдсөн хамаагүй” гэж Санж дотроо бодож байлаа. Санждолбийчойжамц энэ талаар элдэв муу санаагүй, сагардгамын ёс баримталж үнэний мөр хөөж явсны улмаас их л дутуу бодсоноо хожим ухаарчээ. Хэрвээ жанч арилжвал нэгэнт үгүй болох тул түүгээр нь орхих, хэрвээ шар шувталбал хол газар цөлөөд зогсохгүй бурхан шажин, сүм хийдийг дахин харах аргагүйгээр тухайлбал хоёр нүдийг хараагүй болгон орхих ёстой байжээ. Түүгээр ч барахгүй харж хандах, туслах тэтгэх бүхий л холбооноос тасалж, ганцаардуулах ёстой байжээ. Үүнийг Санждолбийчойжамц эргэцүүлэн бодсонгүй.

- Маргааш гахай цагт шар шувтална! гэж зарлав.

Санждолбийчойжамц гэртээ харив. Тэр оройдоо явж Отгоныг эргэмээр санагджээ. Гэвч унаа морь бэлэнгүй. Бас нэгэнт шар шувтлах юм бол нэгмөсөн очихоор шийдлээ. Анх удаа Санж олон жил хийж дадсан уншлага, шашны элдэв зан үйлээ цагт нь хийлгүй эртхэн унтаж амрахаар хэвтжээ. Нойр нь ч амархан хүрлээ.

Гэвч Буянзалбирах хийдийн том лам нар, түүний дотор Дэмбэрэл гэсгүй, Дэмчиг гавж хоёр их ажилтай байлаа. Тэд Санждолбийчойжамцын элдэв холбоог таслах хуйвалдаан хийж байлаа. Одоо Санжид эцэг, эх, төрөл төрөгсөд байхгүй, гагцхүү Отгон хүүхэн байгааг лам нар мэдэх билээ. Нэг охин эгч нь хүнтэй суугаад харь газар явчихсан юм. Цөллөгөнд байхад нь харж үзэх эргэж очих хүнгүй болгохын тулд Отгон хүүхний учрыг олохоор тэд хуйвалджээ.

- Тэрний хүүхэд найм, есөн сартай болов уу? Иймд түүнд чи очиж хэл. Санж хамбатан шар шувтлах хэрэгт холбогдоод байна. Яаралтай ирж уулз! гэж хэлүүллээ хэмээн ятга, тэгэхээр тэр хоёрын явдал үнэн бол Отгон хүүхэн яаран нааш гарна. Нааш гараад замын дунд орж явахад нь сүгийн хувцас өмсөн тосч нуугдаж байгаад морийг үргээн туйлуулах ажлыг чи хий. Мориноос ойчоод дор хаяад л бэртэх биз. Ингээд хэнд ч мэдэгдэлгүй эргэж ир! гэж Дэмчиг гавж хоёр хүнд зааварлаж тэр шөнөдөө тэднийг илгээлээ. Ийм юм болж байгааг Санж ердөө ч гадарласангүй.

Маргааш нь гахай цаг боллоо. Санж энгийн хувцас өмсч хийддээ очлоо. Очих замдаа шинээр бариулж буй Чойрын дуганаа нар зөв тойрон гарав. Оройн гонх нь баригдаагүй дээвэр нь дутуу байлаа. “Энийгээ дуусгаж чаддаггүй минь л хайран боллоо” гэж Санж харамсан бодлоо.

Сүмд бүх лам нар толгой дараалан цугларчээ. Санжийн зүг хүн бүр л үзээгүй юмаа үзсэн мэт харцаар ширтэцгээж байлаа. Хоймор байх шүтээнтэй занхан өөд харуулж сүмийн голд Санжийг зогсоолоо. Төдхөн “Билгийн зүрх” гэдэг уншлагыг лам нар өндөр дуугаар уншиж эхэллээ. Богинохон уншлага тул удахгүй дууслаа. Ширээтээс

эхлээд том лам нар баруун гараар зүүнээ ташлаа. “Орон газар бүрийн хэрэггүй бүхнийг тонилго!” гэсэн дохио гэдгийг Санж мэдэж байв. Дараа нь зүүн гараар барууныг ташицгаав. “Түйтгэрийг бүрмөсөн номхотгон тонилго!” гэсэн утгатай юм. Муу ёрын ууль шувууны дууг дууриалган бүрээ, тунраа үлээлээ. Тэгмэгц Дэмбэрал гэсгуй урагш гарч нэг гартаа сантай бойпор, нөгөөдөө хүрэн занда бэрээ барьж хүрч ирлээ. Бэрээгээрээ Санжийн баруун мөр рүү түлхэн түүний биеийг нар буруу эргүүлэв. Эргэмэгц ар дал руу нь бэрээгээрээ хатган үүд рүү түрэн хөөлөө. Санж хоргодсон ч үгүй, шууд л үүд чиглэн явлаа. Санжийн гишгэсэн алхам тутамд гэсгүй лам сангийн бойпортой утаагаар тэр газрыг нь ариуггах дур үзүүлсээр яваад сүмийн үүдэнд хүрлээ. Үүдээр дөнгөж гадагш алхахад цаанаас нь хэн нэг хүн (сүгийн хувцастай мэт харагджээ) Санжийн нүд рүү нунтаг шар ногоон юм цацав. Санаандгүй явсан тул тэнгэрийн дүлийний нунтаг шиг тэр зүйл Санжийн хоёр нүд рүү бөөнөөрөө пургин орж байж ядмаар хорсуулан нулимс нь цувран юу ч харж чадахгүй болов. Санж нүдтэйгээ ноцолдон бөхийтөл хоёр хажуугаас нь бахим хүчтэй хүмүүс барин авч гарыг нь ард нь хүллээ.

- За та хоёр наад тангараг буурагчийгаа моринд суулгаад ойчихгүйгээр сайн бөхлөөд цулбуураас нь хөтлөөд авч од. Нөгөөх заасан газар хүргээд эргэж ир! гэж ширээт ламын хэлэхийг Санж сонслоо. Нүд нь хорсч нулимс асгаруулан юу ч харахгүй байлаа. Нүдийг нь хараагүй болгох бодис цацжээ гэдгийг Санж мэдлээ. Нүдэнд орсон юмыг хуруугаар шүлсдэн арчиж арилгахыг хүсэв. Гэвч гар хүлээтэй суганаас нь хүмүүс өргөж моринд мордуулаад хөлийг нь морины гэдсэн доогуур холбон хүлжээ. Хоёр гуяыг эмээлийн бүүрэг дээгүүр татсан олсоор мөн даруулан боолоо. Санжийн нүд харанхуйлсан хэвээр юу ч үзэхгүй байлаа.

Гэнэт лам нар алга ташицгааж, хек хек хум, хум, хум! гэж хашгиралдах сонсдов. Түүнтэй зэрэг морь нь ухасхийн урагшаа давхлаа. Хаашаа зүглэснийг баримжаалсангүй.

- Та нар намайг хааш нь аваачих нь вэ? гэж Санж хашгирсан чинь,

- Цөл гэсэн газар нь цөлөхөөр явлаа! гэж хариу өглөө.

Морин давхиагаар тэд үл мэдэх зүгт одлоо. Санжийн нүд хараа орохгүй байлаа. Тэгэхээр нь,

- Ус дайралдвал над нэг балга ус өгөөдхөөч! Би нүдээ угаамаар байна гэв.

- Тийм заавар байхгүй ээ! гэж сөөнгө бүдүүн дуутай хүн хариуллаа.

- Нэлээд яваад байтал хэн нэг хүн морины хар хурдаар дахин ирэх шиг сонсогдоход нь Санж чих тавин чагнавал,

- Санж ахаа, таныг хааш нь авч яваа юм бэ? Би танд хэл дуулгахаар ирлээ! гэх сонсогдов. Дууны нь өнгөөр таавал Чоймчиг багштангийн нь нөгөөх хүүгийн дуу байв.

- Юу гээ вэ, дүү минь! гэж Санж асуулаа.

- Тун базаахгүй муу юм боллоо, ах минь. Таныг эргэхээр хүрээ орох гэж явтал нь морь нь үргэж Отгон эгч мориноосоо ойчиж чирэгдээд нас барчихлаа! гэж тэр залуу хэлэх сонсдов.

- Юу гэнээ! юу гэнээ! гэж Санж ухаан гартлаа айж, учир зүггүй хашгиран асуув. Царай нь пад хар болжээ.

- Отгон эгч таныг эргэх гэж хүрээ рүү явж байгаад морь нь туйлж бусгаад нас барчихжээ. Хүүхэд нь дутуу гарчихсан юм шиг байна гэж нөгөө залуу лавлан хэлэв.

- Ай халаг минь! Ай халаг минь! гэж Санж боож үхэх мэт давчдан хашгираад хоёр гараа хүлэгнээс салгах гэж тарчлав. Дагуулууд түүний хоёр талд ойртож ирж тулан явцгаав. Санж орь дуу тавьж, энгэнэн уйллаа. Тийнхүү амьд, үхсэний хооронд ихэр татаж хэсэг

зуур багтарч явлаа. Тэгээд багахан сэхээ орж,

- Миний дүү Отгон эгчийгээ Шар дэвсэгт оршуулаарай! гэж гуйлаа. Түүнд өөр юу ч бодогдсонгүй.

- Тэгье, ах минь! гэж тэр залуу хоолой чичирсэн дуугаар хариулаад тэднээс арга буюу хоцрон үлдэх шиг боллоо.

“Отгон минь дээ, хөөрхий минь! Чи биеэ гамнан хайрлаж байхгүй юу гэж нүгэлт толгой над руу явсан юм бэ, чааваас минь. Ядаж үрээ аварч чадсангүй дээ, чааваас!” гэж Санж уй гашуундаа багтран, аман дотроо үглэж явлаа. Нүд нь хараа орохгүй байлаа.

Сэтгэлийн түмэн зовлонд орсон Санжийг тэртээ хол газар, эзгүй зэлүүд говьд аваачиж цөлөхөөр тийнхүү авч явааг ч тэр өөрөө мэдэвч чухам хаа хүргэхийг төсөөлөхгүй байлаа.

Хорвоо дэлхий одоо түүнд тас харанхуй гүн хар нүх шиг болжээ.

Оройгүй сүм буюу төгсгөл

Дээвэр хоолойгоороо татуу
Дээл захаараа татуу
Уул оройгоор татуу

Хаврын усан цэнхэр зэрэглээ талд уналаа. Цагийн толгой наашаа эргэж цас хайлан ханзарч дуусаад агь нүдэллээ. Буянзалбирах хийдийн лам нар чийгтэв гэж өдөр бүр сүмээсээ холдож эрүүл газар очиж сууцгааж нарладаг боллоо. Нэгэн удаагийн нарлалтын үеэр тэд дуусаагүй сүмийн тухай ярив.

- Чойрын сүмийг бариулж дуусгах юмсан гэж ширээт лам сүүрс алджээ. Үнэхээр гунигтай байлаа.

- Харин ээ, хариугүй дуусах дөхсөн юмыг гүйцээчихвэл хэрэг байнасанж гэж Дэчин унзад үгээ зөөж ядан ярилаа.

- Сүм бүтээх ёсыг мэддэг хүн манай хийдэд байхгүй л болоод байна даа! гэж бас нэг нь хэлэв.

- Дэмчиг гавж орон хийд бариулахад огт хоосонгүй биш үү?

- Аа Дэмчиг гавж юу шалих вэ? Цацар, суварга мэтийн юмыг бол дөнгөх биз. Харин Чойрын дуганд ч шонгүй байхаа.

- Одоо тэгээд яана! Олны буян хөрөнгө их орсон энэ дуганыг дуусгахсан гэж! Нүдний булай болж зовоогоод байх юм.

- Чухам аа, чухам! гэж тэд ярьцгаав.

Санжийн зураг, санаагаар эхлүүлэн бариулж байсан чойрын сүм оройдоо хүрэлгүй дутуу хэвээр үлджээ. Санж хамбыг шар шувтлан Буянзалбирах хийдээс хөөн цөлсөн тэр өдрөөс эхлэн чойрын дуганы зүг хэн ч очсонгүй байсаар намар орой болж удалгүй цас дарж тэгээд бүтэн өвөл өнгөрчээ. Одоо хавар болж цагийн дулаантай золгоход тэр

сүмийг барьж дуусгах тухай бодоцгоож эхэллээ. Гэвч дуусгах хүн байсангүй. Сүм барих ёсыг сайн мэдэх лам тэр хийдэд байтугай ойр хавьд алга байлаа.

Сүмийг барьж дуусгах тухай Буянзалбирах хийдийн бонсооханбад хэд хэдэн удаа яриа боллоо. Үргэлжлүүлэн гүйцээх хүн олдсонгүй. Тэгэхээр нь хийдийн шинэ хамба Чойбзэн хатуу гар хэрэглэхээр шийдэж,

- Дэмчиг гавж Дэмбэрэл гэсгүй та хоёр энэ сүмийг бариулж дуусгасугай! гэж тушаалаа. Дэмчиг гавж ухаан алдталаа айж, чадахгүй гэж хэдэнтээ няцаан тонгочсон боловч хамба халирсангүй.

Дэмчиг гавж тийнхүү чойрын дуганг барьж дуусгах ажлыг үргэлжлүүлэн оролдохоор тохоогджээ.

Сүжигтнүүдээс хүч туслалцаа авах гэтэл тэд яагаад ч юм нэг л идэвхтэй муутай болчихжээ. Гэвч Дэмчиг гавж элдвээр оролдож, мод чулуу, шавар тоосго цуглуулж сүмийг дээш нь үргэлжлүүлж бариулж эхлэв. Долоо хоног дээрээ явж байтал Дэмчиг гавжийн зааж тавиулсан

дүндан нуруу мултран унаж хоёр лам айхтар хүндээр бэртлээ. Буруу бариулснаас нурсан нь илэрхий байлаа.

Бзртсэн хоёр ламыг эдгэрч илаарь болтол нь сүмийн барилга дээрх ажлыг зогсоолоо.

Хаврын дунд сар гарлаа. Дэмчиг гавж сүмийн барилгыг цааш нь үргэлжлүүлэхээр хоёр дахь удаагаа оролдлоо. Шөнө гэртээ хоёр гурван зул асааж байгаад л Санжийн зурж үлдээсэн зургийг нүдээ хөхөртөл хардаг болсон ч гэсэн Дэмчиг гавж түүний нарийн учрыг олж чадсангүй. Гэвч нэрэлхүү өвчин нь түүнээс тийм ч амархан салахгүй байлаа. Хичээж оролдсоор нэгэн тулгуур нумтай багана босгуулсан нь ачаагаа даалгүй гурав дахь хоног дээрээ жайжийн хазайж эхлэв. Бас л нурах бололтой. Түүнийг мэдээд Дэмчиг гавж хэдэн хоног бодол болон гиюүрч явлаа. Олон өдрийн гиюүрэл нь түүнд нэг мулгуу санаа төрүүлжээ. Тийм юм бодож олохдоо тэр чадмаг ажээ.

- Дэмчиг гавж нутгийн хоёр сайн бичээчийг дуудуулжээ. Тэднийг хүрээнд хүрэлцэн ирэхээр нь Дэмчиг гавж гэртээ урьж аваачаад нарийн хоол хийж дайлахын зуур их л нууц чухал юм найдаж байгаагаа хэдэнтээ сануулж тэдний ам өчгийг авлаа. Тэгээд шөнө болтол дэвэн дэлхийн юм хамж ярин их л дотночилж байгаа мэтээр ойлгуулжээ. Хоёр бичээчийг тэгж ятган уяруулж талдаа татсан дараа,

- За та хоёрт манай Буянзалбирах хийдийн хамба лам бид бүгдээр нэг их нууц чухал юм найдаж даалгана. Үүний утгыг хэнд ч задруулан алдас хийж үл болно. Хэлээ шүдээрээ хашиж байж та хоёр чадах юм байгаа биз дээ? гэж асуув.

- Чадалгүй яахав дээ гэгцгээв.

- За тэгвэл сайн сонсоцгоо! Ноднин буруу даваагаар ороод манай хийдээс цөлөгдсөн Санж гэгчийг та нар мэддэг биэ? За тэгвэл тэр Санж одоо манай хийдээс хагас сарын аяны хол газар ингэнэ усны говьд байгаа! гэж Дэмчиг гавж ярихад,

- Зайлуул, амьд байгаа юм уу? гэж бичээч нар сониучлав. Дэмчиг гавж түүнд нь дургүй нь хүрэвч биеэ барьж,

- Тангараг буурсан, тэрнийхээ нүглийг эдэлж дуусахаас нааш тийм ч амархан төрөл арилжчихдаггүй юм. За тэр ч яахав. Та хоёр сангаас унаа, зардал аваад тэр Санжтай очиж уулзаж ирвэл зохино. Та нарт нэг итгэлтэй хүн газарчилна. Үүнийг биелүүлбэл та нёрыг Буянзалбирах хийд гомдоохгүй шан хүртээнэ! гэв. Хоёр бичээч татгалзсангүй. Найдаж байгаа юм бол бүгээх болов.

- За тэгвэл сайн сонс! Тэр Санжтай эвтэйхэн найрсгаар уулзаад бие тэнхээгий нь асууж, ядарч зовж байгаа эсэхийг нь мэдэх зэргээр сэтгэлд нь нийцтэй үгээр ярилцвал таарна. Тэгэхээр тэр нугаг орны сонинг асууж эхэлнэ. Та хоёр Буянзалбирах хийдэд шинэ чойрын дуган боссон тухай яриарай.

- Босоогүй байгаа биз дээ?

- За юун түрүүн үгтэй юм бэ? Та нарыг тэнд хүрэх гэсээр байтал чинь бид тэр сүмийг дуусгаж орхино. Тэгээд сум бариулж дууссаныг сонсоод тэр Санж гайхах биз. Тэр үнэмшихгүй байж мэднэ. Тэгээд л

тэрийг тэгж барьж уу, энийг ингэж хийж үү? гэж асуух бий. Тэр л хэлэх үг болгоныг нь бичиж аваад ир! Оройг нь тэгж ингэж барьж уу гэж асуувал нэгд нэгэнгүй бичиж авна биз.

- Асуухаар нь юу гэж хариулах вэ?

- Тийм тийм л гээд байвал таарна. Та нар өөрснөө биш. Тэр л яаж барьсныг нь ярих ёстой. Ярихгүй бол яаж баривал зохих байсныг лавлан асуувал зөв.

- Бид тэр сүмийг яаж барьсныг нь мэдэхгүй юм чинь юу ярих вэ дээ. Тэр дороо л зэс маань цухуйна даа.

- Харин тийм ээ! Та нар юу ярих вэ. Түүгээр л яриулж авбал таарна. Ярьсан болгоныг бичиж авч ир!

- Бичүүлэхгүй бол яах вэ? Юмыг яаж мэдэх вэ?

- Тэр юм харахаа байсан. Тэгэхээр та нарыг бичиж авч байгааг үзэх ч үгүй л дээ. Мэдэгдэхгүй л бичвэл таарна.

- Өөр яах юм бэ? Хачин л ажил байна.

- Өөр юм хэрэггүй. Ингэж, тэгж барьж уу? гэдэг л үгийг нь сонсоод ир. Бичиж авахдаа юм орхивзай!

Ийм даалгаврыг Дэмчиг гавжаас аваад хоёр бичээч аянд гарчээ. Тэдэнд Санжийг анх цөлөхөөр авч явсан хоёр яргачны нэг нь газарчилжээ. Хүний бараагүй зэлүүд холхи газар хүрэв.

...Аагим халуун нэг өдөр гурван морьтой хүн Ингэнэ усны говьд орж ирлээ. “Тэр хэрвээ амьд байдаг бол лав л ус бараадах ёстой. Ингэнэ усны булгийн дэргэд шахам л бид орхиод явсан юмдаг” гэж замчлагч сөөнгө хоолойгоор хэлэхэд “Ийм эзгүй цөлд хүнийг ганц биеэр нь орхиод явах гэгч мөн бөх зүрхээ. Яаж өвлийг тэсч өнгөрөөнө, юугаа идэж ууна гэж бодоо юм бол?” гэж хоёр бичээчийн нэг нь гайхлаа. “Өрөвдөөд үстэй дээл, туламтай ааруул, дулаан малгай, гутал өгөх нь өгсөн. Хууль хатуу болохоор яах билээ дээ бид. Цөлөх биш бараг л амьдаар нь хээр хаяад өөрөө үхэж далд орог гэсэн санаагаар л цөлдөг шүү” гэж нөгөөх газарч хэнэггүй ярилаа.

- Тэрүүхэн бутан дотор нэг юм шоволзоод байна. Тэр мөн шиг вэ дээ. Аль вэ, дурангаа! гэж нэг бичээч хэлээд нөгөөгийнхөө дуранг авч их говь руу хараагий нь сунган ажиглав. Тэгснээ,

- Хүн байна. Зайлуул, амьд л байгаа юм байна. За тийшээ очихоос доо! гэв. Тэд өрөвдөн гутсан байдалтай болжээ.

- Би очоод яах вэ? Ойролцоо газар та нарын морийг бариад сууж байя. Дуу хоолойгоор минь намайг таньчихаад сэтгэл нь бухимдаж мэднэ! гэж газарч болгоомжлов. Тэр нь ч тийм байж мэдэх тул хоёр бичээч зөвшөөрчээ.

Санж ч тэдний айсуй явааг удалгүй таамаглаад хармагны бут сандайлан суугаад хүлээж байлаа.

- Амар амгаланг айлтгая! гэж хоёр бичээч Санжийн өмнө очиж мэндэллээ. Цочин бэлбүүрдэцгээж байлаа.

- Амархаан. Та нар амар сайн байна уу? Хаанаас хаа хүрч явна? гэж Санж асуулаа. Түүний нүд аль хэдий нь хараагүй пэлдэн шар юм болчихсон нь аймаар дүрлийн харагдаж байлаа.

- Аа бид нар Засагтхааны Буянзалбирах хийдийн хавиар нутагладаг улс байна. Нутагтаа буцаж явна гэж бичээчийн нэг нь хэлмэгц баруун өвдгөө босгон суугаад хулсан үзгээ, цаас янтайтай гаргаж, Санжийн хэлэх үгийг бичихэд бэлтгэлээ. Санж түүнийг үзээгүй боловч ямар нэгэн юм бэлтгэж байхыг нь мэдрэв.

- Юун сайн юм бэ? Манай нутгийнхан шиг вэ дээ? За тэгээд нутгаар сонин юутай вэ? гэж Санж асуулаа. Зөвхөн ийм асуулт хүлээж байсан хоёр бичээч,

- Сонин юм ихээ. Юуны урьд Буянзалбирах хийдийн шинэ чойрын дуган дуусч аравнайлаад хурал хурж эхэлсэн нэг сонинтой гэж хоёр бичээч ам булаалдан ярилаа.

- Өө тийм үү? Яасан түргэн бариа вэ? Оройгий нь яаж барьж вэ? гэж Санж сэтгэл догдлон асуулаа.

- Ноднин ч зогсоо зайгүй хөдөлсөн. Энэ жил ч мөн адил. Олон хүний хүчээр дор нь дуусгалаа ддаа. Оройгий нь яаж барьсан юм бүү мэд! Осолдохгүй л дуусгасан байсан гэж нэг бичээч хэлэхэд,

- Та нар тэр дуганд орж үзсэн үү? гэж Санж баярлах дуунаар асуулаа. Энэ асуулт тэр хоёрт тус боллоо.

- Орох нь орсон л доо. Сайхан л эд билээ.

- Яаж барьж уу? Ямархуу будаг түлхэцтэй байна?

- Сайхан гэж ярихгүй. Будаг түрхэц ч нүд гялбам сайхан. Зүгээр бид хоёр ингэж тэгж барьжээ гэж яаж хэлж мэдэх вэ? Орон сум бариулах эрдэм байх биш дээ.

- Нээрээ ч аргагүй. Дотор нь ном өгүүлэгчийг байлгах арслант дөрвөлжин ширээг засаж уу?

- Засжээ, засаж. Хоймор талд нь байна билээ.

Түүний дөрвөн хөлд нь арслангийн хоншоор мэтийг үйлдэж дөрвөн төмөр гархи зүүж үү? Дээд сууринд олон нэхмэл татаасаар нүд гарган сүжлэн зүүх ёстой. Дээр нь лавар татаж, торгон унжлага хийгээд суухад хөл унжихааргүй чулуун түшүүр хөлд хийх өгөх учиртай. Тэр мэт хийж үү? гэж Санж асуухад нөгөө хоёр ам булаалдан,

- Яг тиймээр хийсэн байсан. Одоо л санаж, нүдэнд харагдах шиг болж байна гэцгээхийн хамт түүний хэлснийг цаасанд таталган бичиж авч байлаа. Үг үсэг гээхгүйг хичээжээ.

- Түүнээс цааш хоймор талд шүтээний зарлигийн, тайлгын гурван занханыг байрлуулж уу? Баганын суурь, багана, шингийн дэвсгэрийг яаж хийгээ болдоо? Шин, нум, нурууны суурь нуруу, нурууны бүрхэвчийг тахил давхрага, бүрхэвч вадчод тэргүүтэнг номын ёсоор тавиа болов уу? Яагаа бол?

- Мэдэх юм алга! Яаж тэднийг тавих ёстой юм бол?

- Дашлхүмбийн дацан бүтээсний хэв маягаар хоёр гурав дахин багасгаж үйлдэх ёстой. Тэрийг ч бараг хийчихсэн байлгүй дээ. Би

эхлээд овоо явуулчихсан байсан юм даа.

- Тэр ёсоор барьсан шиг байна лээ!

- За тэгж үү? Та нар будаг түрхэц нүд гялбам гэж ярив уу? Уул нь тийм нүд гялбам баймааргүй дээ. Хөх, шар, улаан дөрвөн зүйл өнгөнөөс гажих учиргүй юм. Алаг эрээн юм уу гүн өнгөөр үйлдэх ёсонгүй. Тийм алаг эрээн болгочихож уу?

- Үгүй ер нь анх орсон болоод л нүд гялбаад байсан байх. Түүнээс биш тийм ч их алаг эрээн болсныг харсангүй л дээ. Харин хаалга нь л их эрээн харагдав уу даа?

- Аа тэгж үү? Тэд нар хаалганд ягчис, лагнаадорж тэргүүтний биеийн зураг бүтээх гээд зүтгээд байсан юмдаг. Ер нь хаалгыг яаж хийж вэ? Уул модон барм хөндлөн тавьж, хацар мод зангидан бүслүүр хийж их замын хаалгын дээд давхарлагийг тогтоосон байгаа биз? Эсвэл давхар хаалгыг хойш нь налуулчихсан юм болов уу?

- Мэдэхгүй юм даа. Ямар ч гэсэн их л сүртэй сэргэр сайхан хаалгатай байсан... Их ч өндөр сүм болж билээ!

- Өндөр өргөний ялгамж нь ямар болоо болдоо! Таван давхарлаг болгож чадсан болов уу, үгүй болов уу? Сэрүүн байшинг сүмээс хоёроор өндөр үйлдэж үү, үгүй юу?

- Мэдэхгүй юм даа. Их л өндөр байсан. Нээрээ нэг гонх нь их л ялгаран дээшээ цоройсон мэт байлуу даа?

- Тэгж таарна. Түүнийг уул нь босгоход их төвөгтэй л юмсан. Жамъяншадавынхаар үйлдвэл ч амархан босгож болно л доо. За тийм байж! гээд Санжийг цааш юм асуухаа болих шинжтэй болж эхлэхэд нь хоёр бичээч их сандарч, ам булаалдан,

- Орой нь мөн сайн болжээ. Ганцхан зовох юм бий. "Сайн хүний нэрийг муу хүн, сайхан сүмийн нурууг шаазгай шувуу баасдана" гэх шиг тэр сайхан оройд нь шувуу нэлээд үүрлэдэг бололтой гэв.

- Өө тэр яаж болох вэ? Хэрээ, бялзуухай, хэгүүрзгэнэ шувуунд үл хөнөөгдөхийн тулд шувууны тор хийх учиртай. Цахилдаг, хөвөн, өвс

дэрс, ноос, даавуугаар сайхан тор үйлдэж, нэхэж бололгүй яахав. Төмөр утсаар үйлдэх боловч зэвэрч муудах ёсон бий гэж Санж чин сэтгэлээсээ ярив. Хоёр бичээч үг үсэг алдахгүй бичиж байлаа. Нэг нь бийрээр, нөгөө нь хулсан үзгээр бичиж суулаа.

- Орой нь сайхан болж гэж та нар ярив уу? Юу нь тийм санагдав? гэж Санж тэсч чадалгүй асуулаа. Оройг нь дуусган барьсан гэхэд тэр сэжиглэж байсан тул ийнхүү тодотгон асуужээ. Бичээч хоёр ч үүнийг бас ойлгоод авчээ.

"Оройгий нь барих аргыг яаж хэлүүлж авах билээ? Гол нь оройгий нь хэрхэн бүтээх тухай мэдэж ирэхийг даалгасан биз дээ? Одоо болтол хэлүүлж авсан юм маань үнэндээ бараг хийгдээд бүтчихсэн л зүйл болно. Хэлүүлж авсан зүйл тэгээд хангалттай ч юм уу, үгүй ч юм уу, бас мэдэхэд бэрх. Буцаад очсон чинь хэрэгтэй юм олж ирээгүй байна гээд эргүүлээд хөөвөл яана. Тэгвэл ч энэ хол газар дахин эргэж ирэх гэж турж үхэх хэрэг гарна байх даа. Хүрээд ирсэн чинь энэ хүн өөд болчихсон байхыг үгүй гэх ч аргагүй. Тэгвэл ч Дэмчиг гавж, Дэмбэрэл гэсгүйн гараас амьд гарахгүй дээ" гэж бичээчийн ахимаг настай нь тэр хооронд бодоод айдас нь хүрлээ. Тэгтэл Санж өөрөө ам өрсөж шал өөр юм асуув.

- Худаг гаргах ёстой байсан. Тэрийг гаргаа болов уу? гэж Санж сонирхлоо. Сүмийн хажууд худаг гаргахаас болж бас л аанайхан Дэмчиг гавжтай ам муруйснаа Санж эргэн боджээ.

"Худгаас ус авах цагт эхнэр хүн ус авахаар ирэх үе түүнд тачаах сэтгэл төрөх аваас бие биеийг харагдуулахгүйн тулд халхавч хий. Гары нь алган дотор ус цутган дүүргэж эхнэрийг даган дэгтрээд усыг үргэлжлүүлэн цутгаж магад. Тийн бүү үйлд" гэж Будиг гэдэг сударт бичээстэй байдгийг яагаад ч олж цээжилсэн юм бүү мэд. Дэмчиг гавж мэддэг байжээ. Санжийн төслөөр худгийг хаалтгүй хийсэнд тэр гавж ихэд хилэгнэн уурлаж, завхай сэтгэлийн үрээр ийм юм боллоо гэж зэмлэн хаалт гаргахыг шаардсан билээ. Гэвч хаалтыг Санж хийлгэсэнгүй. Үүнд гавж айхтар хорсон уурлаж байлаа.

- Худгийн тухай юу ч мэдсэнгүй дээ! гэж бичээчийн нэг нь харамссан маягтай хариулжээ. "Яагаад худгийн тухай асууж байгаа юм болдоо, зайлуул! Энд усгүй цөлд цангаж зовж байдаг юм байх даа. Эрдэм төгссөн сайхан лам ирж билээ. Тэгээд хараа мэлмийгий нь хөнөөгөөд

энэ хол газар юуны учир цөлчихдөг байнаа? Хүн гэдэг хэцүү амьтан юм даа. Нэг нэгэндээ ингэж дайсагнаад юу хийнэ? гэж бичээчийн ахимаг насны нэг нь гансран бодож дуугүй суутал залуу бичээч түүнд нүдээрээ дохио өгч “асуугаач!” гэж шаардлаа.

- Сүмийн орой дээр нэг хачин урт нарийхан жанцан шиг юм босгочихсон харагдана билээ. Тэр юун учиртай юм болоо? гэж өвгөн бичээч хашраараа худлаа юм зохион ярилаа. Тэгээд тэр үг нь оносон бололтой. Санж ярвайн дургүйцэж,

- Юун жанцан бэ? Сүмийн орой дээр үү дээ одоо! Тийм юм хийх учиргүй. Аягүй бол Дэмчиг гавж цэцэрхээд л хачин юм хийлгэсэн байж таарна. Хайран сүмийг гутаасан байхаа даа? гэж асуулаа.

- Мэдэхгүй юм даа! Осолдохгүй л тиймэрхүү юм үзсэн.. гэж бичээч хэлэв.

- Тулуурын нумуудын дээгүүр гол дундах занхан тэргүүтний нурууг олон нүд гарган тавьж, асар тэргүүтэнд зүг тус бүрд нуруу зохицуулан тавих учиртай. Түүний дээр унийн толгой бөгсийг солин тавьж унины бүрхүүл сэлтийг тохоод дээр нь шарамдаг мод тавих ёстой. Тийм маягаар хийж үү, үгүй юу? гэж Санж асуулаа.

- Мэдэхгүй юм даа. Тиймэрхүү байсан л байхаа даа! гэж бичээч хэлэхэд Санж эргэлзэн гайхаж,

- Шарамдаг модны дээр... гэж хэлтэл тэр үгийг бичиж байсан залуу бичээчийн хулсан үзэг цаасан дээр гэнэт чихран дуугарлаа. Үгий нь бичиж авч байсныг тэр дороо ойлгосон Санжийн царай барсхийн хувирч огцом босоод,

- Аа таануус тэгнэ вий! гэж хашгираад таягаараа бичээч нарыг цохиж хөөхөөр оролдон ухасхийтэл хармагны бутанд тээглэж ойчлоо...

ТӨГСӨВ

1982-1983 он